

Миний бие, үеэл ах Жон Хэрнкастлийг нөхөрсгөөр гар барих гэхэд нь татгалзсаны учрыг Англид суугаа төрөл садандаа тайлбарлах зорилгоор үүнийг Энэтхэгээс бичиж байна. Энэ тухай өдий болтол дуугүй явсныг минь тэд буруу ойлгосон ба төрөл төрөгсдийнхөө сэтгэлд сэв суулгахыг би хүсэхгүй байна. Миний захидлыг уншихаасаа өмнө яаран хийсэн дүгнэлтээсээ тэднийг түр ангижрахыг би гуйж байна. Би зөвхөн хатуу, маргаангүй үнэнийг өгүүлнэ гэж нэр төрөө барин тангараглая.

Үеэл ах бид хоёрын битүүлэг зөрөлдөөн 1799 оны тавдугаар сарын дөрөвний өдөр генерал Бэрдийн удирдлага доор Серингапатамыг дайрах үед эхэлсэн юм. Эл агуу их үйл явдалд бид хоёул оролцсон билээ.

Нөхцөл байдлыг бүрэн ойлгомжтой харуулахын тулд бүслэлт эхлэхийн өмнөх үеийг, тухайлбал Серингапатамын ордонд өчнөөн төчнөөн алт, эрдэнийн чулуу хадгалсан байдаг тухай манай хуаран даяар ярилцаж байсныг эргэн дурсах нь зүйтэй юм.

## II

Тэр яриа хөөрөөний дотор, Энэтхэгийн он дарааллын бичигт тэмдэглэсэн нэгэн алдарт зүйл болох Шар алмазын түүх хамгийн санаанд багтамгүй ярианы нэг байлаа.

Өнө эртний сайхь домогт чулуу Энэтхэгийн дөрвөн мутарт Сарны бурхны магнайг чимж байсан гэжээ. Ер бусын өнгөөрөө ч юмуу, эсвэл чимж буй бурхныхаа аяст захирагддагаас сар тэргэлтэх буюу хавиргалахад гэрэлтэн гялалзах өнгө нь тодорч, бүдгэрэн хувирч байдаг хэмээн сохроор итгэдгээс ч тэр үү, эл эрдэнийн чулууг Энэтхэгт эдүгээ хүртэл САРАН ЧУЛУУ гэж нэрлэдэг ажээ. Иймэрхүү итгэл эртний Грек, Ромд ч байсныг би сонссон юм. Гэхдээ аль нэг бурхан чимсэн очир алмазыг бус, харин чанар чансаа муу боловч сарны нөлөөгөөр өнгө нь хувирдаг учраас мөн л саран чулуу гэж нэрлэсэн байх ба манай үеийг хүртэл чулуу цуглуулагчдын дунд тийнхүү нэршсээр иржээ.

Энэтхэгийн шар алмазтай холбоотой элдэв адал явдал манай тооллын **XI** зуунаас эхэлсэн байна.

Тэр үед лалын шажинтан, байлдан дагуулагч Газнийн Махмуд Энэтхэгт халдан орж, Сомнатх хэмээх ариун хотыг эзлэн, хинди мөргөлтнүүд хэдэн зууны турш шүтэж ирсэн, дорно дахины гайхамшиг болсон алдарт сүмийн эрдэнэсийг тонон дээрэмджээ.

Сүмийн бурхдаас Сарны бурхан л хомхой сувьдаг байлдан дагуулагчдын саварт ороогүй байна. Магнайдаа шар алмаз чимэгтэй тэрхүү онгон ариун шүтээнийг хамгаалдаг гурван бярман түүнийг шөнө сэм авч гараад Энэтхэгийн ариунаараа удаах хот Бенарст аваачсан ажээ.

Шинэ сүмд, эрдэнийн чулуугаар чимэглэсэн танхимийн алтан багана тулсан хүнхэр дээвэр доор Сарны бурхныг залаад дахин шүтэж тахих болов. Уг сүмийг барьж дууссан шөнө Вишну бурхан нөгөө гурван бярманы зүүднээ залран үзэгдээд, ариун тахилын магнайг чимэгч алмазыг үлдээжээ. Гурван бярман нүүрээ хувцсаараа даран сөхрөн унахад нь Саран чулууг үеийн үед өдөр шөнөгүй сахин хамгаалж байгтүн хэмээн лүндэн буулгаж, нөгөө гурван тайлгач ч Бурхны зарлигийг дуулгавартайяа бишрэн сонсчээ. Эл чулууг зүй бусаар эзэмшихийг зүрхэлсэн этгээд болон чулууг өвлөн авсан үр садад нь золгүй тавилан учирна хэмээн Вишну айлджээ. Гурван бярман Вишнугийн айлдсан үгийг тахилын сүмийн хаалган дээр алтан үсгээр бичиж үлдээ гэж зарлигдсан байна.

Зуу зуун жил улиран өнгөрч, нөгөө гурван бярманы үр ач ариун чулууг үе дамжин өдөр шөнөгүй сахин хамгаалсаар Их Моголын хаадын удмын Аранзэвийн халдан орсон XVIII зууны эхийг хүргэжээ. Аранзэвийн тушаалаар Бярманы мөргөлийн хийдийг тонон дээрэмдэж, эвдэж сүйтгэсэн бөгөөд ариун адгууснуудыг хороон дөрвөн мутарт Сарны бурхны сүмийг бузарлан ариун нандин тахилыг нь хэдэн хэсэг хагачин хаяж, харин Саран чулууг Аранзэвийн нэг цэргийн дарга тонон авсан аж.

Алдсан эрдэнээ хүчээр эгүүлэн авах чадал мөхөстсөн гурван бярман хувцсаа сольж өмсөөд нөгөө этгээдийг мөшгин дагажээ. Нэг үе нөгөөгөөр солигдсоор, шүтээнийг бузарлаж ариун чулууг зүй бусаар эзэмшсэн дайчин аймшигт үхлээр нас нөгчив. Саран чулуу хууль бус эзэмшигчдээ элдэв гай зовлон тарьсаар буруу номтны гар дамжин явлаа. Элдэв хувьсал өөрчлөлт гаравч гурван бярманы үр сад Саран чулууг даган сахиж, Вишну бурхан ариун шүтээнийг нь эгүүлэн хайрлах цагийг тэвчээртэй хүлээнэ. Ийм маягаар XVIII зууны эцэс хүрсэн ба хожим нь Серингапатамын султан Типпугийн гарт орж, мань хүн түүгээр чинжаалынхаа бариулыг чимээд хамгийн үнэт эрдэнэстэйгээ хамт зэвсгийн өрөөндөө хадгалжээ. Тэр үед ч, бүр султаны ордонд, гурван бярман ариун чулуугаа нууцхан манасаар байжээ. Типпугийн бараа бологсдын дунд лалын шашинд сүсгээрээ ч юм уу, эсвэл хуурмагаар дагаар орсон гурван харийн хүн байсан нь зүсээ буруулсан нөгөө гурван тайлгач байсан гэлцдэг билээ.

Манай хуаранд Саран чулууны ер бусын түүхийг ийн ярилцах бөлгөө. Эл түүх бидний хэнд ч нэг их сүрхий юм бодуулаагүй байтал хачин жигтэй зүйлд дурладаг зангаараа манай үеэл итгэж орхижээ. Серингапатам руу дайрдаг шөнө үүнийг үлгэр гэлээ хэмээн бидэнд учир утгагүй уурласнаас үүдэн зүйрлэшгүй тэнэг маргаан дэгдэж, Хэрнкастль галзууртлаа хилэгнэсэн билээ. Английн цэрэг Серингапатамыг авдаг юм бол тэр алмаз миний хуруунд гялалзаж байхыг нь та нар харна даа гайгүй хэмээн сагсуурдгаараа сайрхаж, бид ч хариуд нь тачигнатал хөхрөлдөв. Уг хэрэг тэгсгээд дууслаа гэж бид бүгдээрээ тэр шөнө бодсон билээ.

Одоо дайралт болсон өдрийн тухай дурсахыг зөвшөөрнө үү. Довтолгоон эхлэхэд л үеэл бид хоёр салсан юм. Гол гатлах үеэр ч, анхны цохилт өгөөд Английн далбаа мандуулж байхад ч, суваг гаталж, сөөм газар бүрийг байлдан авсаар хотод орж байхдаа ч би түүний барааг харсангүй. Хотыг манайхан хэдийн эзлэн авч, султан Типпугийн цогцсыг баахан алагдсан улсын дундаас генерал Бэрд өөрийн биеэр олсны хойно, үдшийн бүрэнхий нөмрөх үеэр л би Хэрнкастльтай нүүр учирсан билээ.

Манай ялалтын дараа гарсан дээрэм тонуулыг зогсоохын тулд генералын тушаалаар илгээсэн бүлэгт бид хоёул багтсан байв. Цэргүүд аймаар овилгогүй авирлаж, хамгаалалтгүй болсон ордны эрдэнэсийн санд нэвтрэн ороод алт, эрдэнийн чулууг нь цөлмөн тоночихсон байлаа. Цэргүүдийн дунд эмх журам тогтоохоор зорьж ирсэн, эрдэнэсийн сангийн үүдэн дээр би үеэлтэйгээ тааралдав. Цочмог зантай Хэрнкастль алаан хядаан хараад жигтэйхэн улангасчихсан байхыг би даруй ажигласан юм. Өөрт хүлээлгэсэн үүрэгт ажлыг гүйцэтгэх чадвараа лав алдсан байсан гэж би боддог юм.

Эрдэнэсийн санд зэгсэн хөл үймээн болж байсан ч хүч хэрэглэсний шинж би олж үзээгүй. Цэргүүд тэр булай ажлаа эв найртай (ингэж хэлж болдог бол) хийж байлаа. Тэд есөн шидийн овилгогүй шог яриа, этгээд үг хэлэлцэх бөгөөд Саран чулууны түүхийг гэнэт сөхөн төрхгүйтэж марзганана. Дээрэм тонуул нэг газар нь арай намдтал ↔Саран чулууг хэн олов оо?≈ гэж хашгирах дуунаар өөр нэг хэсэгт бужигнах ажээ. Миний бие эмх журам тогтоох гэж дэмий л оролдож байтал ордны нөгөө жигүүрээс аймшигтай дуу хадсанд бас нэг замбараагүй явдал гарлаа хэмээн эмээсээр тэр зүг даруй гүйлээ.

Нэг нээлттэй хаалганд дөхөж очвол босгон дээр нь алагдсан хоёр энэтхэг хүн (хувцсыг нь үзвэл ордны цэргийн дарга бололтой) хэвтэж байлаа.

Дахин хүн хашгирсан учраас зэвсгийн тасалгаа байсан тэр өрөөнд алгуурлалгүй орох хэрэгтэй болсон юм. Үхлүүт шархадсан гурав дахь энэтхэг хүн цаашаа хараад зогсож буй нэг хүний хөлд татганан тийчилж байлаа. Намайг өрөөнд оронгуут зогсож байсан хүн эргэж харав. Нэг гартаа бамбар, нөгөө гартаа цусанд бялдсан хутга барьсан Жон Хэрнкастль зогсож байх нь тэр. Наашаа эргэхэд нь чинжаалын бариулд шигтгэсэн чулуу галын оч мэт гялсхийж билээ. Нөгөө энэтхэг амьсгал хураахын өмнө өвдөглөн өндийж Хэрнкастлийн барьсан чинжаал өөд чичлэн ↔Саран чулууны хараал чамд болон үр садад чинь хүрэг!≈ хэмээн төрөлх хэлээрээ сөөнгөтөн зүхээд нам ойчив.

Намайг юу ч хийж амжаагүй байтал дагаж явсан цэргүүд маань гүйлдэн орж ирлээ. Үеэл маань яг л солирсон юм шиг тэднийг угтан харайж очоод,

□ Энэ өрөөг цэвэрлэж, үүдэнд нь манаа тавь! гэж надад хашгирав.

Хэрнкастль бамбар, чинжаал барьсан чигээр цэргүүд рүү гүйж очсон тул нөгөөдүүл нь зайлж ухарлаа. Миний бие, итгэлтэй хоёр цэргийг манаанд гаргав.

Тэр шөнөдөө үеэлийнхээ барааг дахиад харсангүй.

Өглөө болтол дээрэм тонуул үргэлжилсэн тул генерал Бэрд, аливаа хулгай дээрэм үйлдэж байгаад баригдсан этгээдийг хэн ч байсан ялгаагүй дүүжлэх болно гэж нийтэд зарласан юм. Цэргийн цагдаагийн дарга ирсэн явдал генерал Бэрдийн тоглоогүй гэдгийг нотолжээ. Эл тушаалыг сонсгож байх үеэр, би Хэрнкастльтай олны дунд тааралдлаа.

Амар мэндээ мэдэлцэнгээ Хэрнкастль заншлаараа гараа сарвайсанд би гараа өгөхөөс түдгэлзэж,

□ Юуны түрүүнд, зэвсгийн тасалгаанд тэр энэтхэгийг хэн алсан, тэр хүн үхэхийнхээ өмнө таны барьсан чинжаалыг заагаад хэлсэн үг нь ямар учиртай болохыг хэлж өгөөч гэлээ.

□ Тэр энэтхэг, үхлүүт шархадсанаас болж нас барсан гэж бодож байна. Харин сүүлчийн үгний нь учрыг би таны адил мэдэхгүй байна гэж Хэрнкастль хариу өчив.

Би Хэрнкастлийг анхааралтай ажиглалаа. Урьд түүнийг эзэмдэн байсан уур цухал бүр намджээ. Буруугаа хүлээх боломж олгоё гэж бодоод,

□ Танд өөр хэлэх юм алга уу? Гэж асуусанд ,

□ Юу ч алга гэв.

Тэгэхэд нь би эргэж холдон явсан ба тэр цагаас хойш нэг ч үг солилцсонгүй билээ.

Үеэлийн тухай бичсэн энэ зүйл (эл нөхцөл байдлыг нийтэд мэдэгдэх шаардлага гарахгүй л бол) зөвхөн манай гэр бүлийн гишүүдэд зориулагдсан юм гэдгийг ойлгоно уу, Хорооныхоо даргад илтгэчихэж болохоор үг Хэрнкастль надад цухуйлгаагүй юм. Дайралтын өмнө сүрхий их догдолж байсныг нь мартаагүй улс Хэрнкастльд нөгөө очир алмазыг сануулж даажигнах боловч мань хүн хариу үл дуугарна. Зэвсгийн өрөөнд намайг ороход ямаршуу байснаа мартаагүй буй заа. Түүнийг өөр хооронд шилжих нь гэж дам хэлэлцэх болов. Мэдээжийн хэрэг, надаас л холдохын түүс болсон биз.

Энэ бүхэн үнэн худал ямар ч бай би түүнийг буруушааж чадашгүй зэгсэн үндэстэй шалтгаан байгаа юм. Дээр дурдсан бүхнээ нийтэд мэдэгдье гэтэл хоосон таамаглалаас өөр бодит баримт надад үгүй. Босгон дээр хэвтэж байсан хоёр энэтхэгийг Хэрнкастль алсан гэдгийг бүү хэл зэвсгийн өрөөнд гурав дахийг нь алсан гэдгийг ч нүдээрээ хараагүй учраас нотолж чадахгүй байлаа.

Нөгөө энэтхэг хүний амьсгаа хураахаасаа өмнө хэлсэн үгийг сонссон минь үнэн боловч амь нь тэмцэхдээ дэмийрч байсан гэвэл би өөрийн зөвийг хэрхэн нотолж чадах билээ? Дээр дурдсан бүхнийг тал бүрээс нь эргэцүүлэн үзээд, миний эдүгээ хүртэл энэ хүнд дургүйцэж явдгийн зөв буруу алин болохыг хэрхэн болгоохоо төрөл садангууд минь өөрсдөө шийдтүгэй. Очир алмазын тухай энэтхэгийн үлгэр домогт хэдийгээр итгэдэггүй боловч би гэдэг хүн сүсэг бишрэлээс бүрэн ангижраагүй гэдгээ хүлээх ёстой. Ямар ч атугай аливаа гэмт хэрэг хожим хойно зохих шийтгэлээ хүртдэг гэж би бодох бөлгөө. Хэрнкастлийн буруутай гэдэгт би итгэдгээр барахгүй тэрхүү очир алмазыг биедээ хадгалж яваа бол хэзээ нэгэн цагт харамсах цаг ирэх ба мөн тэр алмазыг өөр бусдад өгдөг юм гэхэд авсан хүмүүс ч харамсах болно гэдэгт эргэлзэхээргүй сүсэгтэй билээ.

## I бүлэг

↔Робинзон Крузо≈ зохиолыг нээгээд, нэгдүгээр бүлгийн зуун хорин есдүгээр талыг гаргаж харвал уншигч та, аливаа ажлыг хийхийн өмнө хөлс, хүч хүрэх эсэхийг бодолцож үзэлгүй эхэлбэл даанч тэнэг явдал болно гэдгийн хэдий дэндүү хожуу боловч би ойлгосон юм≈ гэсэн өгүүлдэр олж уншина.

Өчигдөрхөн би ↔Робинзон Крузогоо≈ сөхөхөд яг энэ хэсэг таарсан билээ. Харин өнөө өглөө, өөрөөр хэлбэл 1850 оны тавдугаар сарын хорин нэгний өглөө манай хатагтайн зээ, мистер Фрэнклин Блэйк ирж, доорх зүйлийг товчхон ярилцав.

□ Бэттереж гуай, би гэр бүлийн зарим асуудлаар хуульчтайгаа зөвлөх дашрамд, Йоркшир дэх нагац эгчийн гэрээс хоёр жилийн өмнө энэтхэгийн очир алмаз алдагдсан тухай ярилцсан юм. Энэ бүх түүхийг шудрага үнэний тусын тулд бичиж тэмдэглэвэл зохих ба хэчнээн түргэн тусмаа төчнөөн сайн байх болно гэж надтай санал нэг байна билээ гэв.

Хуульчийн цаадах санааг хараахан ойлгоогүй авч амар тайван байхын тулд үргэлж хуульчийн талд байвал зохино гэж үздэг болохоор минийбие түүний үгийг зөвшөөрч, би ч яг тийм бодолтой байна гэдгээ хэллээ.

Мистер Фрэнклин яриагаа үргэлжлүүлэн,

□ Очир алмаз алдагдсан хэрэгт гэм зэмгүй хүмүүсийг сэжиглэн нэр төрд нь хал учруулж байгааг та сайн мэднэ. Хожим бидний хойч үе сонирхож болох зарим бичиг баримт дутагдсаны улмаас гэмгүй улсын дурсгалд сэв сууж магадгүй юм. Манай гэр бүлийн энэ жигтэй түүхийг өгүүлэх нь маргаангүй зөв бөгөөд, Бэттереж гуай, хуульч бид хоёр энэ тухай өгүүлэх их л зөв арга олсон юм шиг надад санагдана гэв.

Тэр хоёр сайхан юм бодож олсон нь эргэлзээгүй боловч энэ нь надад чухам ямар хамаатай болохыг би хараахан ухаараагүй л байлаа.

□ Бид үнэн хэрэг явдлыг өгүүлэх хэрэгтэй бөгөөд үүнийг хийчихээр чадвартай нэлээд хүн энэ хэрэгт биеэр оролцсон билээ. Ийм ч учраас, Саран чулууны түүхийг хүн бүр мэдэж буй зүйлээсээ хадуурахгүй ээлж дараатай бичих хэрэгтэй гэж үзэж байгаа юм. Эл очир алмаз таван жилийн өмнө энэтхэгт алба хааж байсан манай нагац ах Хэрнкастлийн гарт хэрхэн орсноос эхэлбэл зохино. Тийм оршил өгүүлэл ч байна. Тэр бол гэрчийн үзсэн бүхнээ тодорхой бичсэн гэр бүлийн хуучин гар бичмэл юм. Дараа нь одоогоос хоёр жилийн өмнө Йоркшир дэх нагац эгчийн байранд Саран чулуу хэрхэн орж ирсэн болон арван хоёр цагийн дараа хэрхэн алга болсныг өгүүлвэл зохино. Тэр үед тэднийд юу юу болсныг сайн мэдэх хүн Бэттереж танаас өөр байхгүй. Тэгэхээр та л хамийн түрүүнд үзгээ барьж, өгүүллэгээ эхлэх хэрэгтэй боллоо доо гэж Фрэнклин хэллээ.

Очир алмазын явдлыг өгүүлэхэд миний бие ямар үүрэг гүйцэтгэх ёстойг надад ингэж мэдэгдсэн юм. Тэгээд ийм байдалд орчихоод миний хэрхэнийг уншигч та сонирхвол, иймэрхүү даалгавар миний хэрээс хэтэрнэ гэж даруухан татгалзсан боловч авьяас чадвараа дайчлаад үзвэл барах л юм гэж бодож байлаа. Миний оронд хэн ч байсан тэгэх л байсан биз гэж хэлэхийг зөвшөөрнө үү. Фрэнклин царай руу хараад далд санааг минь ойлгосон бололтой. Миний даруу занд итгэхийг үл хүсэн, зохих ёсоор авьяас чадвараа дайчлахыг шаардав.

Мистер Фрэнклин намайг орхиод явснаас хойш хоёр цаг өнгөрлөө. Түүнийг явмагц л би өгүүллэгээ эхлэхээр бичгийн ширээ рүүгээ очиж билээ. Тэгээд би, авьяас чадвараа дайчилсан хэдий ч арга барагдан суухдаа, аливаа ажлыг хийхийн өмнө хөлс, хүч хүрэх эсэхийг бодолцож үзэлгүй эхлэбэл даанч тэнэг явдал болно гэж Робинзон Крузогийн ойлгосон зүйлийг өөрийн биеэр ухаарч билээ.

Энэ ажлыг хийх гэж хөнгөмсгөөр зөвшөөрөхийн урьд өдөр “Робинзон Крузо” номыг санаандгүй нээтэл яг тэр хэсэг тааралдсан гэдгийг уншигч та бүү мартаарай. Урьдаас зөгнөн хэлсэн байна бус уу? Би бол мухар сүсэгтэн хүн биш, энэ насандаа тун олон ном уншсан, нэг ёсны эрдэмтэй хүн дээ. Миний нас дал гарсан хэдий боловч ухаан минь сайн, хөл минь ч бат чийрэг гишгэдэг хэвээр билээ. Тэгэхээр, “Робинзон Крузотой” эн зэрэгцэх ном ер байхгүй, хойшид ч бий болохгүй гэж санаж явдгаа илэрхийлбэл мунхаг хүний үг байна гэж та битгий бодоорой. Өчнөөн жил би гансаа нэрэн тухлан суугаад энэ номыг сөхөж үзэхдээ, энэ хорвоогийн хатуу бэрх амьдралыг туулахад түших нөхөр, зөвлөгч минь болдгийг ямагт мэдэрч ирсэн юм. Сэтгэл тавгүйтвэл, мөн хүний зөвлөмж тусламж хэрэгтэй бол “Робинзон Крузог” үзнэ. Урьд бас эхнэр минь залхтал яншсан үед, одоо бол дарс хэтрүүлж уусан үедээ “Робинзон Крузог” навсартал гэж үзсэн билээ. Хатагтай маань саяхан төрсөн өдрөөрөө надад цэнхэр хавтастай, бас зурагтай дөрвөн шиллинг зургаан пеннийн үнэтэй долоо дахь “Робинзон Крузо” бэлэглэв. Тэр өдөр би хэтрүүлж балгачихаад байсан бөгөөд “Робинзон Крузо” намайг дахиад хэвийн байдалд оруулсан юм.

Энэ бүхэн очир алмазын түүхийн эхлэл гэмээргүй санагдаж байгаа биз? Миний бие, юу болохыг нь хаана байгааг нь Бурхан мэднэ хэмээн эрэд бидэрч яваа мэт байна. Уншигч таныг зөвшөөрвөл бид нэг хуудас цаас аваад дахиад шинээр эхлэн бичихийн ялдамд гүн хүндэтгэлийг минь хүлээн авч соёрхоно.

## II бүлэг

Би ахайтныхаа тухай дээр хэдэн мөр дурдсан билээ. Манай ахайтны охин тэр очир алмазыг бэлгэнд аваагүй бол манайд хэзээ ч үзэгдэхгүй байхсан, бас хэрэв манай ахайтан зовж шаналан байж энэ хорвоод охин төрүүлээгүй бол тэр бэлгийг хүлээж авахгүйсэн. Нэгэнт ахайтнаасаа эхлэхэд хүрвэл уг түүхийг нэлээд эртнээс өгүүлэх хэрэгтэй болно. Та хэрэв минийх шиг иймэрхүү ажил барихад хүрвэл энэ бол үнэхээр зугаатай эхлэл болно гэдгийг хэлье.

Дээдсийн хүрээлэнгийн талаар та бага боловч төсөөлөлтэй бол Хэрнкастлийн гоо үзэсгэлэнт гурван охин, Эделиад, Каролина, Жулиа авхай нарын тухай дуулсан биз. Эгч дүү гурвын хамгийн отгоныг би хамгийн сайн нь гэж боддог. Олон зүйлээс ийн дүгнэснийг минь та мөдхөн үзнэ. Миний бие, тэдний эцэг, өвгөн лордынд (Тэнгэрийн ивээлээр очир алмазын энэ хэрэг мандахад өвгөн ноён байсангүй. Дээд, доод аль ч давхаргад түүнээс илүү хэлтэй, тэвчээр багатай хүнтэй би учирч яваагүй билээ) арван таван настай байхдаа гурван сурвалжилт охиных нь зарцаар орсон юм. Мисс Жулиа талийгаач Жон Вериндертэй гэрлэх хүртэл би өвгөн лордынд сууж байлаа. Талийгаач тун сайн хүн байв. Харин хүнээр удирдуулах хэрэгтэй байсан, энүүхэндээ гэхэд тийм хүн олоод авчихсан байлаа. Нэмж хэлэхэд, манай ахайтан гэрлэх ёслол хийхээр сүмд дагуулан очсон өдрөөс эхлэн тарган цатгалан, жаргалтай амьдарсаар гар дээр нь сэтгэл амгалан амьсгал хураахад ахайтан ч нүдийг нь аниулсан билээ.

Миний бие залуу хостой хамт, хүргэний эдлэнд очиж суух болсноо хэлэхийг мартжээ. “Ноёнтон, би Габриэл Бэттережгүйгээр байж чадахгүй” гэж манай ахайтан хэлсэнд “Ахайтан минь, би ч бас чадахгүй” гэж Жон ноён хариулж билээ. Ер нь талийгаач түүнтэй үргэлж иймэрхүү маягаар харьцдаг байлаа. Би ч ийнхүү тэднийд ажлах болсон юм. Миний хувьд бол эзэгтэйнхээ дэргэд л байвал хаашаа ч явсан ялгаагүй байв.

Ахайтан маань аж ахуй, фермийн сонирхож эхлэхэд нь би ч бас жижиг фермийн эзний долдугаар хүү байсныхаа хувьд тэр ажлыг сонирхох болов. Намайг хэрэг хөтлөгчийн туслахаар тавихад нь би байдаг чадлаараа хичнээн ажиллаж, төдөлгүй тушаал дэвшлээ. Хэдэн жилийн хойно даваа гариг байсан шиг санагдана, хатагтай маань нэг өдөр, “Ноёнтон танай хэрэг хөтлөгч тэнэг өвгөн байна.

Чамлахааргүй тэтгэвэр олгоод Габриэл Бэттережийг оронд нь тавимаар юм” гэлээ. Мягмар гаригт “Ахайтан минь, хэрэг хөтлөгчид тэтгэвэр олгож чөлөөлсөн. Габриэл Бэттережийг түүний оронд томилсон” гэж Жон ноён хэлжээ. Та бүхэн аз жаргалгүй амьдардаг гэр бүлийн тухай хангалттай олон юм дуулсан биз. Тэгвэл тэс өөр жишээ нь энэ билээ. Энэ жишээ зарим хүнд дохио болж, заримыг нь урамшуулах болтугай. Тэр дашрамд би эл түүхээ цааш үргэлжлүүлье.

Намайг их жаргалтай байсан гэж та хэлнээ дээ.

Миний бие хариуцлага хүндэтгэлтэй байр суурь эзэлж, өөрийн гэсэн товхийсэн бяцхан байшинтай, өглөөгүүр эдлэн газрыг эргэж тойроод, өдөр тооцоо хөтөлж, оройн цагаар гаансаа нэрэн ↔Робинзон Крузог≈ бариад сууна. Миний жаргалд үүнээс өөр юу дутаж болох вэ? Диваажингийн цэцэрлэгт ганцаараа байхдаа Адам юу хүсэж байсныг санагтун. Та Адамыг зэмлэдэггүй бол намайг бүү зэмлээрэй.

Манайд гэр ахуйн ажил эрхэлдэг байсан Селина Гоби гэгч бүсгүй миний анхаарлыг татсан юм. Би эхнэр шилж сонгох талаар талийгаач Вильям Коббеттай санал нийлдэг. Сонгосон эмэгтэй чинь хоолоо сайн зажилж иддэг, бат чанга гишгэдэг бол та алзахгүй. Селина Гобид энэ чанар хоёул байсан нь түүнтэй гэрлэх нэг шалтгаан болсон билээ. Үүнээс гадна өөрөө нээж олсон гэмээр нэг шалтгаан байлаа. Юу гэвэл, Селина ганц бие байвал долоо хоног тутмынх нь ажлын хөлсөнд их мөнгө төлөх хэрэг надад гарна, хэрэв миний эхнэр болчихвол би хөлс өгөхгүй, надад үнэ өртөггүй үйлчилнэ шүү дээ. Би уг хэргийг авч үзэхдээ, ийнхүү дэийн засаг, хайр сэтгэлийн асуудлыг хамтруулсан юм. Энэ шийдвэрээ ахайтандаа “Ахайтан минь би Селина Гобийн талаар эргэцүүлж бодоод түүнтэй гэрлэвэл гэртээ хөлсөөр ажиллуулснаас бага зарлага гарна гэж үзлээ” хэмээн албан ёсоор илэн далангүй мэдэгдэв.

Ахайтан инээд алдаад миний үг яриа, чиг болгосон зарчмын чухам алинд нь илүү дургүйцвэл зохихоо мэдэхгүй байна гэлээ. Язгууртан хүн биш бол ойлгох аргагүй шалтгааны улмаас баахан инээдэмтэй санагдсан гэж боддог юм. Селинад гэрлэе гэж хэлэхийг зөвшөөрлөө гэдгээс өөр юу ч эс ухаарсан миний бие явж, Селинад учраа хэлэв. Селина “Тэгье” гэж зөвшөөрсөн нь мэдээж хэрэг.

Хурим ойртож, надад ёслолын шинэ хувцас хийх тухай яриа гарахад би хулчийж эхлэв. Ийм байдалд орчихоод юу бодож явсныг танил эрчүүдээсээ асууж сонирхвол, барагцаалбал гэрлэх ёслолын долоо хоногийн өмнөөс татгалзаад үзэх юмсан гэж учиргүй хүссэн хэмээн бүгдээрээ чин сэтгэлээсээ хүлээсэн билээ. Харин би арай цаашилж, үнэндээ ч даварч, гэрлэхээс татгалзах гэж оролдоод үзлээ. Гэхдээ мэдээж, хов хоосон биш л дээ! Би, Селинаг зөв зүгээр надаас яваад өгөхгүй гэдгийг даанч мэдэхгүй яахав. Эрэгтэй нь гэрлэхээ боливол эмэгтэйдээ шагнал өгөх хууль Англид байдаг юм. Уг хуульд захирагдаж, мөн удтал эргэцүүлж бодсоны эцэст би Селина Гобид нэг өдөн дэвсгэр, тавин шиллингийн шагнал өгье гэлээ. Гэтэл Селина миний хэлсэн шагналыг авахаас татгалзахаар зэгсэн тэнэг хүн байжээ. Итгэхэд бэрх боловч аргагүй л үнэн юм шүү.

Тэгээд л миний хамаг найдлага тасрах нь тэр. Би хамгийн хямд хувцас оёулж, ер нь бусад зүйлийг ч чадах хэрээрээ хямдхан өнгөрөөв. Бид жаргалгүй ч гэсэн бас золгүй хос биш, аль аль нь тэнцүү байлаа. Чухам яагаад тийм болсныг бүү мэд, бид хоёр бие биедээ ямагт саад болдог байв. Би шатаар өгсөх гэхэд эхнэр маань уруудна, харин эхнэр маань өгсөнө гэвэл би уруудах жишээтэй. Ер нь гэр бүлийн амьдрал иймэрхүү байдгийг би туршлагаасаа мэдсэн юм.

Шатны талаар учраа олж зохицолгүй таван жил өнгөрсний эцэст төгс мэргэн Тэнгэрийн бошиго бид хоёрыг салгаж амраахаар болгоож, эхнэрийг минь дуудлаа. Би тийнхүү газар дээрх ганц охин Пенилоптойгоо үлдэв. Удсан ч үгүй Жон ноён нас нөгчиж, ахайтан бас ганц охинтойгоо үлдсэн билээ. Охины нь Рэчел авхай гэнэ. Би хатагтайнхаа тухай тун бүдэг бичиж байна. танд тайлбарлах хэрэгтэй бол миний бяцхан Пенилопыг манай ахайтан ивээлдээ аван сургуульд явуулж, эрдэм ном заалгаад сүрхий цовоо охин болгосныг түүнчлэн насанд хүрэхээр нь мисс Рэчелийн шивэгчин болгоно гэснийг өгүүлсүгэй.

Миний бие 1847 оны Христосын мэндэлсэн өдрийг хүртэл буюу миний амьдралд тэр нэг өөрчлөлт гарахаас өмнө хэрэг хөтлөгчийн ажил эрхэлж байлаа. Тэр өдөр Жулиа ахай надтай цай уухаар манай гэрт морилон ирээд, өвгөн лордын амьд сэрүүнд тэднийд зарцаар орж, тавь гаруй жил өөрт нь үйлчилснийг тэмдэглээд өвлийн хүйтэнд өмсөхөд дулаан гэж өөрийн гараар нэхсэн сайхан ноосон хантааз өгч билээ.

Тэр гайхамшигт бэлгийг хүлээн аваад ийнхүү хүндэтгэл үзүүлсний хариуд талархах үгээ олж ядав. Гэтэл тэр ноосон хантааз бол хүндэтгэлийн илрэл биш, харин хахууль байсныг мэдмэгц би тун их гайхаж билээ. Өөрөө анзаарахаас минь өмнө ахайтан миний хөгширч буйг мэдэж, намайг гадуур дотуур явдаг хэрэг хөтлөгчийн хэцүү ажлаа орхин насныхаа эцэст даамлын хялбар ажил хийгээч гэж ятгахаар (ингэж хэлж болдог бол) ирсэн юмсанж.

Хялбар ажилд шилжүүлэх тухай тэрхүү гомдмоор саналыг би чадах хэрээрээ эсэргүүцсэн боловч ахайтан миний сул талыг анддаггүй болохоор эрх сонирхолдоо нийцүүлж чадлаа. Би гэдэг хөгшин

тэнэг шинэ ноосон хантаазаараа нулимсаа арчин байж энэ тухай бодъё гэж хэлснээр бидний маргаан дуусав.

Ахайтныг явсны дараа, сэтгэл үнэхээр аймшигтай хямарч эхэлсэн тул, мухардаж тэвдэхэд минь хэзээд түших нөхөр болдог зүйл рүүгээ тэмүүлэв. Гансаа нэрж, ↔Робинзон Крузогоо≈ авлаа. Энэхүү гайхамшигт номын хуудсыг эргүүлээд удалгүй ↔Маргааш нь үзэн ядах зүйлээ бид өнөөдөр хайрлаж байдаг≈ (158 дугаар тал) гэсэн сэтгэл тайвшруулам өгүүлбэр олж уншив. Би ч хэрхвэл зохихыг шууд ойлголоо. Өнөөдөр би хэрэг хөтлөгч хэвээр үлдэх гэж байдгаараа зүтгэж, харин маргааш болоход ↔Робинзон Крузод≈ өгүүлснээр, огт өөр юм хүсэж таарах нь. Маргаашийн өдөр, маргаашийн зан ааль минь ямар байх ёстойг санаандаа дүрслэх л үлдэж, хэрэг нэг тийш болов. Энэ хэргийн талаар сэтгэл нэгэнт амарч, ахайтны хэрэг хөтлөгч миний бие унтахаар явсан бөгөөд, харин маргааш өглөө нь Вериндер ахайн гэрийн даамал болчихоод сэрлээ. Бүх юм ↔Робинзон Крузод≈ өгүүлсний дагуу аятайхан болов!

Миний охин Пенилоп хэр их бичсэнийг минь сонирхон мөрөн дээгүүр өнгийж хараад сайхан, үнэн зөв бичжээ гэлээ. Гэхдээ зохих зүйлийг бичээгүй байна, очир алмазын түүх бичээч гэж гуйсан, гэтэл та өөрийнхөө тухай л өгүүлсэн байна шүү дээ гэж анхааруулав. Яагаад ийм болсныг тайлбарлаж чадахгүй нь хачирхалтай. Ном бичдэг ажил эрхэлж амь зуудаг эрхмүүд бүтээлдээ над шиг амьдралаасаа бас бус зүйл оруулдаг болов уу? Хэрэв тийм бол би тэднийг өрөвдөж байна. Ингэхэд бас л буруу эхэлж, баахан цаас үрэх нь ээ. Тэгэхээр одоо яах вэ? Та жаахан тэвчиж, би эл түүхийг эхлэх гэж гурав дахь удаагаа оролдоод үзэх болжээ гэдгээс өөр хэлэх юм алга.

### III бүлэг

Эл түүхийг эхлэх гэж хоёр янзаар оролдлоо. Эхлээд толгойгоо маажиж баахан суугаад тусыг эс олов. Дараа нь Пенилоптойгоо зөвлөсөнд цоо шинэ санаа хэлж өглөө.

Фрэнклин Блэйк ахайтныд морилон ирэх тухай мэдээ хүлээж авсан өдрөөс эхлэн тохиолдсон явдлыг дэс дараатай өгүүлэх хэрэгтэй гэж Пенилоп зөвлөсөн юм. Энэ маягаар дурсамжаа сар өдөртэй нь тодруулж чадвал чухал явдлууд ой тойнд дурайн тодрох нь гайхмаар болно. Гэтэл юуны түрүүнд сар өдөр тогтооход бэрхшээл тулгарав. Тэгэхэд охин маань сургуульд сурч байх үеэсээ одоо хүртэл хөтөлж ирсэн өдрийн тэмдэглэлээ надад үзүүлэхээр болов. Охиныхоо саналыг дэмжиж, боловсронгуй болгохын тулд ↔Тэмдэглэлийн дэвтрээ ашиглан очир алмазын түүхийг миний оронд бич л дээ гэсэнд Пенилоп царайгаа улайлган ууртай харж, дэвтэрт нь юу бичсэнийг өөрөөс нь өөр нэг ч амьд амьтан мэдэх ёсгүй хэмээв. Ямар учиртайг асуувал ↔Зүгээр ээ, дэмий юм≈ гэв. Хайр сэтгэлийн явдал тэмдэглэсэн биз гэж би хэлэх байна.

Тэгээд Пенилопын төлөвлөснөөр бичихдээ, миний бие 1848 оны тавдугаар сарын хорин дөрөвний лхагва гаригт эзэгтэйнхээ өрөөнд дуудагдан орсноо эхлээд тэмдэглэхийг зөвшөөрнө үү.

□Габриэл, танд мэл гайхмаар нэг сонин дуулгая. Фрэнклин Блэйк гадаадаас ирсэн, одоо Лондонд эцгийн дээ буусан гэнэ. Маргааш манайд ирж, зургадугаар сар гартал байгаад мисс Рэчелийн төрсөн өдрийн баярт оролцоно гэж ахайтан маань хэлсэн юм.

Хэрэв би малгайтай явсан бол энэ мэдээг дуулаад баярласандаа малгайгаа дээш нь чулуулах байснаас зайлахгүй. Фрэнклиний барааг харалгүй их уджээ. Багадаа энэ байшинд бидэнтэй хамт байсан юм. Одоо санахад мистер Фрэнклин хэзээний л эрчигнүүр эргүүлж, эсвэл цонх хагалчихсан явдаг ч гэсэн ер нь тун сайн хүү байж билээ. Энэ тухай мисс Рэчелд хэлтэл, Фрэнклин бол ямар ч хүүхэлдэйг элдвээр зовоодог хэрцгий тамлагч, Англид үйлдвэрлэдэг есөн шидийн уяа ногтоор жаахан охидыг хөллөн давхидаг догшин хөтөч болдог байсныг санаж байна хэмээн хариу өгүүлээд

□ Фрэнклин Блэйкийг бодохоор зэвүү хүрч, жигтэйхэн ядаргаатай санагддаг юм гэж үгээ дуусгав.

Одоо миний хэлэх зүйлийг сонсоод уншигч та мистер Фрэнклин эрийн цээнд хүртлээ өдий олон жилийг яагаад эх орноосоо алсад өнгөрөөх болсны учрыг асууж сонирхох нь лавтай. Үүнд хариулсугай. Яагаад гэвэл, түүний эцгийн аз дутахад нэгэн вангийн ойрын угсаа залгамжлагч байсан бөгөөд тэрхүү эрхээ хууль ёсоор баталж чадаагүй юмсанж.

Товчоор өгүүлбэл: Манай ахайтны ууган эгч нь мистер Блэйк хэмээх учиргүй баян, хөрөнгө баялгаараа ч, шүүхээр оруулсан дуулиантай заргаараа ч нэрд гарсан алдартай эрхэмтэй гэрлэсэн юм. Нөгөө ванг зайлуулж, хэргэм цолыг өөрөө авах ёстой гэж хэчнээн ч жил английн шүүхээр гүйж залхтал нь шаардаж, хэчнээн ч олон шүүгчдийн түрийвчийг дүүргэж, зөв бурууг нь шийдэх гэсэн хэчнээн ч олон гэмгүй улсыг хооронд нь хэрэлдүүлэв дээ, ер нь тоочих аргагүй их хэрэг мандаж билээ. Шүүх эцэстээ, хэргийг нь үл хэрэгсэж, мөнгө авахаа зогсоох шийд гаргахаас өмнө мистер

Блэйкийн эхнэр, гурван хүүхдийнх нь хоёр нас баржээ. Хамаг хэрэг шувтарч нөгөө ван хэргэм зэрэгтэйгээ үлджээ. Тэгэхэд мистер Блэйк хохирсныхоо хариуг авах ганц зөв арга олсон байна. Юу гэвэл хүүг нь хүмүүжүүлэх үүргээ биелүүлэх боломж эх орондоо олгохгүй байх явдал мөн гэж үзжээ. Тэгээд ↔Манай орны албан байгууллагууд надтай ямаршуу харьцав даа. Мэдсээр байж тэдэнд найдах хэрэг үү≈ гэсэн маягийн юм хэлжээ. Түүнээс гадна мистер Блэйк ер нь бүх хөвгүүдэд, хүүдээ ч гэсэн дургүй учраас зүтгэснээрээ л дуусна гэдгийг та зөвшөөрөх биз. Тийнхүү эцэг нь Фрэнклин хөвгүүнийг биднээс салган төгс хөгжсөн хэмээн итгэж байсан Герман улсад сургуульд явуулсан юм. Харин мистер Блэйк Парламентад сонгуультай нутаг нэгтнүүддээ тус хүргэх хөдөлмөр хийх, мөн нөгөө вангийн тухай өдий хүртэл дуусгаагүй байгаа мэтгэл зохиол бичих санаатай Англид тухтайхан үлджээ.

За, Тэнгэрийн ивээлээр, энэ талаар өгүүлэх юм дууслаа! Эрхэм минь та бид хойшид мистер Блэйкийн тухай ярьж биеэ чилээх хэрэггүй. Түүнийг ванлигтай нь орхиж, очир алмазын тухай өгүүлсүгэй.

Очир алмаз биднийг муу ёрын энэ чулууг манайд авчирч өөрийн мэдэлгүй гэмтэн болсон Фрэнклин рүү дахин хөтлөн аваачна.

Манай хонгор хөвгүүн гадаадад суухдаа биднийг марталгүй, байсгээд л заримдаа манай хатагтайд, заримдаа мисс Рэчелд бас надад ч бичнэ. Гадаадад явахаас нь өмнө бид хоёр өгөө аваатай байлаа. Надаас нэг бөөрөнхийлсөн олс, дөрвөн иртэй тонгорог, мэдээж барааг нь дахин харах хөг өнгөрсөн зургаа долоон пенс зээлсэн юм. Ер нь мөнгө зээлүүлээч гэсэн захиа надад бичдэг байлаа. Гэвч хилийн чанадад түүнийг хэрхэн эрийн цээнд хүрч байгаа тухай ахайтнаасаа үргэлж сонсдог байв. Германы их сургуулийн өгч чадах бүх эрдмийг сурчихаад Францад, дараа нь Италид очин суралцаж, мөхөс миний ойлгосноор, тэдгээр орны их сургууль түүнийг өргөн мэдлэгтэй, суу билэгтэн болгон гаргажээ. Фрэнклин жаахан бичихнэ, зурна, бас жаахан дуулна, хөгжим зохионо, тоглоно, ер нь надаас юм зээлдэг шигээ энэ бүхнээс бага сага юм зээлдсэн болов уу гэж би хувьдаа сэжиглэдэг юм. Насанд хүрч, жилийн орлого нь долоон зуун хүрдэг хөрөнгө эхээсээ өвлөн авсан боловч шүүрэн шанагаар ус гоожих мэт үрэн таран хийжээ. Хэчнээн их мөнгөтэй байх тусмаа төчнөөн их үрнэ. Мистер Фрэнклиний халаасанд яагаад ч нөхөж болдоггүй цоорхой байдаг мэт ажээ. Хаана ч явсан цовоо нийцтэй байх тул хүн бүхэн эелдэг угтан авна. Энд тэнд хэсүүчлэн явах бөгөөд шуудангийн хаяг гэвэл өөрийн нь хэлснээр, ↔Европ, шуудан, өөрөө хүлээн авах≈ байна. Хоёр ч удаа Англидаа буцаж бидэнтэй уулзахаар шийдсэн боловч тухай бүрд (ингэж хэлсэнд уучлаарай) ямар нэг бүсгүй саатуулаад байж. Харин гурав дахь оролдлого нь бүтсэнийг манай хатагтайн надад дуулгасан үгнээс та хэдийн олж мэдсэн билээ. Тавдугаар сарын хорин тавны мягмар гаригт манай хонгор хөвгүүн ямаршуу эр болсныг бид анх удаагаа харах учиртай байжээ. Фрэнклин бол язгуур гарал сайн, зүрх зориг их, бидний тооцоогоор бол хорин тав хүрсэн залуу. Фрэнклин Блэйкийг манайд морилж ирэхээс нь өмнө та түүний тухай одоо миний мэдэж байгаагийн дайтай мэддэг боллоо.

Тэрхүү мягмар гариг бол зуны найртай дэлгэр өдөр байлаа. Ахайтан, мисс Рэчел хоёр мистер Фрэнклинийг үдээс өмнө ирнэ гэж бодоогүй учир хөрш нэг найзындаа өглөөний унд уухаар явцгаав.

Тэднийг явсан хойно, миний бие зочинд зориулан бэлтгэсэн өрөөг очиж үзвэл бүх зүйлийг ёсоор засчээ. Дараа нь бойдаагийн зэрэгцээ даамал болох тул би (хэрэв талийгаач Жон ноёны зоорины түлхүүрийг өөр хүн баривал би тун ч аягүйцэх байсан учраас миний аминчлан гуйсан ёсоор намайг даамал болгосон гэдгийг тэмдэглэе). Латорын алдарт улаан дарснаас хэдэн лонх авчирч хоолны өмнө бүлээсгэх санаатай зуны халуун наранд гадаа тавив. Хуучин улаан дарсанд хэрэгтэй зүйл өвгөн настанд ч нэгэн адил ашигтай гэж үзээд зуны урин дулаан агаарт жаахан суусугай хэмээн арын хашаанд очихоор сүрлэн сандлаа авч гартал ахайтны байрны өмнөх дэвсэг дээрээс бөмбөрийн зөөлөн дуу сонсогдсонд зогтусав.

Байшин тойрон дэвсэг дээр очвол цагаан маалинган цамц, өмдтэй, хүрэн бор царайтай гурван энэтхэг манай байшинг харан зогсож байна.

Тэдэнд ойр очоод хүзүүнээсээ жижиг бөмбөр зүүснийг нь ажиглав. Ард нь уут барьсан цайвар үстэй, жижиг турьхан биетэй англи жаал байна. Тэд бол хэрмэл илбэчид юм, харин жаалхүү тэдний тоглолтод хэрэглэдэг зэмсгийг авч явдаг байх гэж би бодлоо. Гурван энэтхэгийн англиар ярьсан, хамгийн найрсаг (үүнийг би хүлээн зөвшөөрөх ёстой) байдалтай нэг нь биесээ танилцуулсан тул миний таамаглал ч нотлогдлоо. Манай эзэгтэйд илбэ жилбээ үзүүлэх зөвшөөрөл эрлээ.

Би муухай ааштай өвгөн биш, ер нь аливаа зугаа хөгжилд дуртай бөгөөд өөрөөс нь бараан царайтай учраас л хүнд итгэхгүй байна гэдэг олиггүй зан гэдгийг мэднэ. Гэвч хүний сайн ч сул талтай байдаг. Миний сул тал гэвэл надаас илүү намбатай тэр хэрмэл илбэчнийг хармагц Вериндер ахайнд үе улиран ирсэн алт, мөнгөн халбага сэрээ хийсэн сагс хоолны ширээн дээр гаргаж тавьснаа

даруй санасан явдал юм. Тиймээс тэр энэтхэг гэрийн эзэгтэй эзгүй тул нөхдийн хамт эндээс явсан нь дээр гэлээ. Үүний хариуд дэгжин гэгч мэхийгээд манайхаас холдоцгоов. Харин би сүрлэн сандал руугаа очоод наран талд гарч тухлан суугаад яг унтчихаагүй юмаа гэхэд ямар ч байсан таатайхан зүүрмэглэв.

Миний охин Пенилоп, байшинд түймэр гарчихсан мэт давхиж ирээд намайг сэрээчихлээ. Яах гэсэн гэж та бодно? Пенилоп, нөгөө гурван илбэчинг даруй баривчлуулах гэжээ. Учир нь гэвэл, тэд Лондонгоос наашаа хэн гарсныг мэдэж байна, бас Фрэнклинг Блэйкийг хорлох санаа агуулж байна гэнэ.

Мистер Фрэнклиний нэрийг сонсоод би нойроос сэрж, нүдээ нээн чухам юу болсныг тайлбарлахыг шаардав.

Пенилон Хаалгачийн охинтой баахан дэмий ярьж суугаад манааны шовгороос гарч явтал нөгөө миний буцаадаг гурван энэтхэг, бяцхан хөвгүүнийг дагуулан одохыг харжээ. Миний бие, хөөрхөн, турьхан хүү юм гэдгээс өөр юу ч олж хараагүй атал, яагаад ч юм бүү мэд, харийн хүмүүс тэр хөвгүүнийг муу хэрэгт ашиглаж байгаагаас зайлахгүй гэсэн бодол манай хоёр охины толгойд орж, зам хажсан бургасны араар нуугдан тэд хашаанаас гараад хэрхэхийг ажиглаж эхэлсэн байна. Тэгтэл санаанд оромгүй жигтэй зүйл үйлджээ.

Эхлээд тэд эргэн тойрноо сайтар нягтлан ажиглаад зам дээр өөр хүн амьтан үгүйд итгэж авчээ. Дараа нь гурвуул манай байшингийн зүг харан зогсоод сүрхий анхааралтай ширтэн, өөрийнхөө хэлээр хурдан хурдан шулганалдан нэгийг хэлэлцэж, бие биеэ эргэлзэж тээнэгэлзсэн янзтай харсан гэнэ. Тэгснээ тусламж эрэх мэт нөгөө хүүг эргэн хараад, англиар ярьдаг ахлагч нь ↔Гараа сарвай≈ гэж хэлжээ.

Тэр аймшигт үгийг сонсоод зүрх минь амаар гарчихалгүй яаж тэссэнийг мэдэхгүй гэж охин минь ярихад, ↔Тэгвэл бэлхэвч чинь саад болно шүү дээ≈ гэж би бодсон хэдий боловч ↔Пээ, нуруугаар хүйт оргичихлоо≈ гэж л хэлэв (Жич тэмдэглэхэд, эмэгтэйчүүд яльгүй тааламжтай үгэнд дуртай байдаг юм).

За, цааш өгүүлсүгэй. Энэтхэг хүн, ↔Гараа сарвай≈ гэхэд хөвгүүн цочин ухарч, толгой сэгсрэн дургүй байгаагаа хэлжээ.

Нөгөө энэтхэг, огт уурласан шинжгүй, тэгвэл Лондон руу буцаж, навсархай хувцастай, ад үзэгдэн зах дээр хоосон сагсанд өлөн зэлмүүр унтаж байхад чинь олсон тэр газраа эргэж очмоор байна уу гэж асууснаар, гарсан бэрхшээл эцэс болов бололтой гэнэ. Жаалхүү гараа дурамжхан сарвайсанд энэтхэг хүн өврөөсөө бэх шиг хар шингэн бүхий шил гарган ирж, алган дээр нь асгаад хүүгийн толгойд гар хүрч, агаарт хий дүрс зурснаа, ↔Харагтүн≈ гэж хэлжээ. Хөвгүүн алган дээрх бэх шиг шингэнийг ширтэн хөшөө мэт хөдөлгөөнгүй нам зогсов (Өдий болтол Пенилопын яриа бэх дэмий үрсэн жирийн нэг илбийн тухай мэт санагдаж, дахин нойр хүрч, зүүрмэглэж эхэлтэл Пенилопын цааш өгүүлсэн зүйл нойр хулжаасан юм).

Гурван энэтхэг эр хавь ойрыг дахин нэг хараад ахлагч нь

Гадаадаас ирсэн нөгөө англи эрхмийг харагтун гэж хөвгүүнд өгүүлсэнд,

Би харж байна гэв.

Өнөөдөр тэр англи эрхэм яг энэ замаар тэр байшин руу ирэх нь үү? Гэж асуувал хүү,

Өнөөдөр тэр англи эрхэм өөр замаар биш яг энэ замаар энэ байшинд ирнэ гэж хариулав.

Энэтхэг хүн нэлээд азнаад дараагийн асуултаа тавьсан нь:

Англи эрхэм нөгөө зүйлээ авч явна уу?

Хүү мөн л азнаж байгаад,

Тийм гэв.

Англи эрхэм өнөө орой хэлсэн ёсоороо ирэх нь уу? Гэж гурав дахиа буюу сүүлчийн удаа асуухад,

Хэлж чадахгүй нь гэж жаалхүү хэлсэнд,

Яагаад? Гэж энэтхэг хүн асуув.

Би ядарч байна, нүд бүрэлзээд харж болохгүй нь. Өнөөдөр дахиад өөр юм үзэж чадахгүй гэж хөвгүүн өчлөө. Тийнхүү асууж лавлах ажил дуусчээ. Энэтхэгүүдийн ахлагч хөвгүүнийг нэг зааж, буудалласан (хожим бид олж мэдсэн юм) хотынхоо зүг нэг заагаад эх хэлээрээ нөгөө хоёр нөхөртөө нэгийг ярьжээ. Дараа нь, жаалхүүгийн толгой дээр элдэв янзын дүрс агаарт зураад магнай руу нь үлээсэнд хүү алмай байдлаас татавхийн сэргэжээ.

Тэгээд дөрвүүл хот орох замаар одож, хоёр найз бүсгүй тэдний барааг дахин харсангүй. Эргэцүүлж тунгаан, эрж сурвалжилбал аливаа зүйлийн учир шалтгаан заавал олдоно гэлцдэг билээ.

Пенилопоос сонссон зүйлд ямар учир байна вэ?

Би нэгдүгээрт, ахлах илбэчин, хашааны хаалган дээр зарц нарын хэлэлцэх үгээс мистер Фрэнклин морилон ирнэ гэдгийг голж мэдээд бага сага мөнгө салгаж болох юм гэж шийдсэн хэрэг. Хоёрдугаарт, тэр гурван энэтхэг хүн хөвгүүний хамт, хатагтайн ирэхийг хүлээн үүгээр түүгээр холхиж эргэн ирж, мистер Фрэнклиний айлчлах тухайд ид шидээр мэдсэн мэт (мөнгө олохын тулд) өгүүлэх гэсэн биз. Гуравдугаарт, тэд жүжигчдийн нэгэн тоглолтдоо бэлтгэж, хүний анхаарал сарниулж мэхлэх үгээ давтаж байхад нь Пенилоп харсан ажээ. Дөрөвдүгээрт, өнөө орой алт, мөнгөн халбага сэрээг анхаарч байхад илүүдэхгүй юм байна. Тавдугаарт, Пенилоп баахан тайвширч, эцэг намайгаа наранд дахиад жаахан дугхийх боломж олгон зөнд минь орхивол сайнсан гэж бодлоо.

Энэ бодол маань хамгийн ухаалаг, зөв мэт санагдаж билээ. Ер нь та залуу бүсгүйн занг мэддэг бол Пенилоп миний бодлыг огт зөвшөөрөхгүй байсанд лав гайхахгүй буй заа. Миний охины бодлоор бол, тэр харсан зүйл нь их учир холбогдолтой юмсанж. Ялангуяа энэтхэг хүний англи эрхэм нөгөө зүйлээ авч явна уу гэсэн хоёрдугаар асуултыг онцлон анхааруулна.

Пэ, аав минь! Үүнийг тоглоом шоглоомд бүү бод! ↔Нөгөө зүйл≈ гэж юу гэсэн үг вэ? Хэмээн Пенилоп хоёр гараа базлан байж өгүүлэв.

Иртэл нь тэсч чадвал чинь мистер Фрэнклинээс асууя л даа, үр минь гээд тохуурхан буйгаа мэдэгдэх гэж нүдээ анивчлаа. Харин Пенилоп хэлснийг минь үнэнд боджээ. Охины сандарч, түгшсэн нь намайг хөгжөөж,

Мистер Фрэнклин энэ тухай хаанаас олж мэдэх билээ? Гэж асуусанд,

Асуу л даа. Тэгээд үүнийг инээдэмтэй юм гэж бодох эсэхийг нь хараарай гэлээ. Тийн хэлээд охин минь намайг орхин одов.

Пенилопыг явсан хойно ядаж охиныхоо санааг амраахын үүднээс мистер Фрэнклинээс асууя гэж шийдлээ. Фрэнклинээс тэр тухай асуухад бидний хооронд чухам ямар яриа үүссэнийг уншигч та зохих цагт бүрэн мэдэх болно. Харин би одоо, таны сонинч занг өдөөчихөөд хожим нь бууруулахгүйн тулд, цааш өгүүлэхийн өмнө, илбэчдийн тухай бидний ярианаас өчүүхэн төдий ч наргиантай зүйл олж үзэхгүй гэдгийг анхааруулахыг зөвшөөрнө үү. Мистер Фрэнклин, Пенилопын нэгэн адил тэр явдлыг сүрхий ноцтой хэрэг гэж үзсэнд миний бие үлэмж гайхсан билээ. Фрэнклиний бодлоор бол ↔Нөгөө зүйл≈ хэмээсэн нь Саран чулууг хэлжээ гэвэл та энэ явдал хэчнээн ноцтой болохыг лав гадарлах буй заа.

## IV бүлэг

Өөрийн бие, сүрлэн сандлынхаа тухай өгүүлсээр таныг баахан чилээж орхисондоо үнэхээр харамсана. Зуны нар ээсэн хашаанд нэгэн нойрмог өвгөн үүрэглэн суух нь огт сонирхолгүй гэдгийг би сайн ойлгож байна. Гэвч яриа маань зохих ёсоороо үргэлжлэх нь мэдээж агаад мистер Фрэнклин Блэйкийг иртэл нь та надтай хамт нэг жаахан байх хэрэгтэй болж дээ.

Пенилоп намайг орхин явсны дараа дугхийж амжаагүй байтал хоол бэлэн болсныг илтгэсэн аяга таваг тар няр хийх чимээ зарц нарын өрөөнөөс гарч намайг амраасангүй. Өрөөндөө хооллодог болохоор зарц нарын хоол надад огт хамаагүй, зөвхөн тавтай хооллохыг тэдэнд ерөөгөөд дахин тухалж авахаас өөр хийх зүйлгүй тул хөлөө жийн, гэдрэг налан суутал дахиад л нэг эмэгтэй гүйж айсуу. Энэ удаад охин минь бус, харин сав угаагч Нэнси ажээ. Би босож замыг нь хаав. Явуулаач гэж гуйхад нь ажиглавал их л дурамжхан царайтай байсанд миний бие зарц нарын даамлын хувьд, зарчим ёсоор учир явдлыг асууж лавлалгүйгээр түүнийг явуулчихаж огт болохгүй байлаа.

Яагаад хоолноосоо зугтаж байгаа юм бэ? Юу нь болохоо байчихаа вэ, Нэнси? Гэж асуув.

Нэнси хариу дуугаралгүй мултрахыг оролдсон хэдий боловч би амжин чихдээд авав. Би иймэрхүү маягаар залуу бүсгүйчүүдэд эелдэг харилцаагаа илэрхийлдэг бөгөөд Нэнси бол хөөрхөн, махлаг бүсгүй билээ.

Юу болоо вэ? Гэж дахиад асуув.

Розанна бас л хоолноос хожимдчихлоо. Тэгээд намайг олж ир гэж явууллаа. Энэ айлын хамаг хүнд ажлыг би л үүрч байх юм. Бэттереж гуай, намайг явуулаач дээ! Гэж Нэнси өчив.

Розанна гэгч бол манай бага шивэгчин байлаа. Розаннаг өрөвдөж (учрыг нь та мөдхөн мэднэ), эл бүсгүй цаадахаа элдэв бусын хатуу үгээр загнан байж авчрах төлөвтэйг царайгаар нь гадарлаад одоогоор тодорхой хийсэн юмгүй тул очиж Розаннаг авчирья гэсэн бодол төрөв. Үүнээс хойш дэг журам сахиж бай гэж зэмлэсэн сануулгыг минь дуулгавартай хүлээж авна гэдгийг би мэдэж байсан юм.

Розанна хаана байгаа вэ? Гэж асуув.

Мэдээжээр, нөгөө элсэн дээрээ л байгаа биз? Хэмээн Нэнси толгой сэжин өгүүлээд, өнөө өглөө бас дотор нь эвгүйцээд цэнгэг агаарт гарья гэж гуйгаад явсан юм. Би ч тэрнээс болж амар заяа үзэхгүй нь дээ! гэв.

□ Охин минь, хоолондоо ор. Би учрыг нь олж, Розаннаг дагуулж ирье гэж хэллээ. Хоолонд зэгсэн дуртай Нэнсигийн тэнийжээ. Тийнхүү сэтгэл ханамжтай байгаа үедээ хөөрхөн харагддаг юм. Хөөрхөн харагдахад нь би өхөөрдөж, эрүүнээс нь угзардаг, энэ бол зохисгүй явдал бус, зүгээр л сурчихсан юм.

Ингээд би ч тулуураа барьсаар элсний зүг алхлаа.

Үгүй, ийм маягаар цааш өгүүлж болохгүй нь таныг дахиад саатуулах болсныг минь уучлаарай. Гэвч тэр элст эргийн тухай, Розаннагийн тухай та заавал сонсох хэрэгтэй, яагаад гэвэл очир алмазын хэрэгт тун ойр холбогдсон юм. Дашрамын зүйлд сатааралгүй өгүүллэгээ үргэлжлүүлэх гэж хэдий их чармайвч бүтэх юм алга! Гэвч яая гэх вэ! Хүн, юмс энэ амьдралд ийнхүү харамсмаар бусдын анхаарлыг татаж байдаг юм. Үүнийг хялбарчилан товчхоноор өгүүлсүгэй. Бид мөдхөн хэргийн гол нууцад нэвтэрнэ гэж амлая!

Нийтээр хүлээсэн ёсонд эд юмсаас өмнө хүнийг тавьдаг учраас Розаннагаас эхэлье. Розанна ирээд удаагүй, шинэ зарц билээ. Миний бие эл түүхийг бичихээс дөрөв таван сарын өмнө манай эзэгтэй Лондонд байхдаа шоронгоос суллагдсан ялтан эмэгтэйчүүдийг буруу замд дахин орохоос сэрэмжлэх үүрэг бүхий засан хүмүүжүүлэх газраар оржээ. Уг байгууллагын ажлыг нэлээд сонирхож буйг нь ажиглаж амжсан захирал авгай ахайтанд Розанна Спирман гэгч нэг бүсгүйг зааж, түүний тухай тун гунигтай түүх өгүүлснийг энд давтан дурсах зүрх хүрэхгүй байна. Би ер нь савхийвэл сэтгэлээ чилээхэд дургүй, та ч бас адилхан буй заа. Товчхон өгүүлбэл Розанна Спирман хулгайч байжээ. Аргагүйн эрхэнд ганц удаа хулгай хийхийн оронд, өчнөөн мянган хүнийг тонодог, хотын нэгдлүүдийн ивээлд багтаагүй байсан учраас цагдаад баригдаж, шоронд суугаад, дараа нь засан хүмүүжүүлэх газар шилжсэн байна. Засан хүмүүжүүлэх газрын захирал өмнө үйлдсэн хэргийг нь үл харгалзан, Розаннаг христосын мөргөлтөн бүсгүйд байвал зохих сайн сайхан чанар бүрдсэн бөгөөд боломж таармагц тэр чанараа харуулж чадах цөөн хүүхний нэг гэж үздэг ажээ. Ахайтан христос шажинтны хувьд мөн ховор сайхан сэтгэлтэй хүн учраас ↔Розанна манайд ажиллаж тийм боломж олж аваг≈ гэж захирал авгайд хэлсний дараа нэг долоо хоног болоод манайд шивэгчнээр ажиллах болсон билээ.

Розаннагийн намтрыг мисс Рэчел бид хоёроос өөр нэг ч хүн мэдэхгүй. Ахайтан намайг тоож аливаа чухал асуудлыг зөвшин хэлэлцдэг зангаараа Розаннагийн талаар ч зөвшин ярилцахад нь сүүлийн үед талийгаач Жон ноёны адил ахайтныхаа амыг үргэлж дагуулах болсон миний бие саналыг нь чин сэтгэлээсээ дэмжиж дуртайяа зөвшөөрсөн юм.

Хөөрхий бүсгүйд заяасан шиг аз завшаан ховор тохиолдох буй заа. Розаннагийн урьдын амьдралыг нэг ч зарц мэдэхгүй учраас өнгөрсний нь сөхөж, нүүрий нь улайлгах хүн байсангүй. Бусдын нэгэн адил хөлс авч, тэнцүү эрх эдлэхээс гадна манай хатагтай бүсгүйг зоригжуулж үе үе найрсаг үг хэлнэ. Розанна ч тийм эелдэг харьцдагт нь талархан, сайн ажиллаж, дуулгавартай байсныг хэлбэл зохино. Сул биетэй, хааяа муужирч унадгийг дээр нэгэнт өгүүлсэн билээ. Хэдий дорой биетэй боловч ажлаа өө сэвгүй, нягт нямбай, олон таван үггүй гүйцэтгэнэ. Үргэлж талтай байдаг ч гэсэн, нэг их дотночилж сүйд болдоггүй Пенилопоос өөр хүнтэй яагаад ч юм үерхдэггүй байв.

Бусад зарц шивэгчин Розаннад нэг л тааруухан байдгийн учрыг би даанч мэдэхгүй юм. Бусдын атаа жөтөөг төрүүлээд байх гоо үзэсгэлэн үгүй, харин ч манай төрүүлээд байх гоо үзэсгэлэн үгүй, харин ч манай хүүхнүүдээс зүс царайгаар хамгийн муу нь байсны дээр далиу мөртэй билээ. Үг дуу цөөтэй, зожиг зантай учраас л тэдний дургүйг хүргэдэг болов уу гэж би санана. Чөлөө гарвал авгай хүүхнүүд дэмий чалчиж байхад Розанна ном уншина, эсвэл ямар нэг юм хийж оролдоно. Хашаанаас гадагш гарах ээлж ирвэл арваас есөн удаад нь малгайгаа тайван өмсөөд ганцаархнаа зугаалахаар одно. Хүнтэй ам мурийсан удаагүй, гоморхож туньдаг ч үгүй, бусадтай эелдэг боловсон харьцах боловч ямагт хөндий байна. Нэмж хэлэхэд, царай муутай ч гэсэн шивэгчин гэхээсээ язгууртан хатагтай гэмээр төрхтэй билээ. Розанна Спирманыг анх манай байшингийн босго алхахад нь л хүүхнүүд энэ байдлыг ажиглачихсан бөгөөд ихэмсэглэн хамраа сөхдөг гэлцдэг нь оргүй гүтгэлэг юм.

Энэ сонин бүсгүйн бас нэг этгээд занг одоо дурдах юм бол элсний тухай ярианд шууд орно.

Манай байшин Йоркширийн эрэг дээр, тэнгисийн хөвөөнд байдаг. Бид хавь ойрынхоо газраар тааваараа зугаалдаг боловч нэг л тийшээ огт зүглэдэггүй бөгөөд очихын ч хэрэггүй зэвүүн муухай газар гэж би үздэг юм. Сэтгэлд гуниг төрүүлэм нарсан ой бээрийн хугас хэртэй үргэлжлэх бөгөөд тэрхүү ойн цаана гарч, намхан намхан хад асгат газрыг өнгөрвөл та эрэг хавийн хамгийн үзэмжгүй, зэлүүд мухарт хүрч очно.

Энд элсэн манхны хормой далайд тулж, уснаас цухуйсан хоёр шовх хадаар шувтрах бөлгөө. Энэ хоёр хадыг Өмнөд, Умард цохио гэнэ. Хоёр цохионы хооронд жилийн дөрвөн улиралд нааш, цааш займчин нүүдэг, Йоркширийн эрэг хавийн хамгийн осолтой газар гэлцдэг бамбалзуур элс бий. Далайн түрлэгийн үед хөлгүй гүнд нь ямар нэг юм болж, бамбалзуур элсний гадарга тэр чигээрээ

хачин жигтэйгээр намалзан донслох тул нутгийнхан Нуранги Элс хэмээн нэршсэн билээ. Тохойн амны ойролцоо хагас бээр хэртэй үргэлжлэх их харгиа далайгаас цутган түрэх их усыг тогтоон барьдаг ажээ. Өвөл, зуны улиралд далайн ус нуранги элс дээгүүр түрэн халих үеэр усны давалгаа тэндээ үлдээд жигд эргэлдэн долгиж, элсийг бүхэлд нь дуу шуугүй нөмрөн авах мэт үзэгдэнэ. Мөн ч зэвүүн, тун ч буйд газар даа! Энэ тохойд нэг ч завь орж зүрхэлсэн удаа үгүй. Коббс Хол хэмээх загасчдын суурингийн хүүхдээс энд тоглохоор ирэх нь үгүй. Жигүүртэн шувууд хүртэл Нуранги Элснээс дөлөн тойрч гарах мэт санагдана.

Зугаалахад таатай өчнөөн олон газраас нэгийг сонгоод ↔Явах уу?≈ гэж ам ангаймагц нь дуртайяа хань болон дагалдах хархүү дуртай цагтаа олчих залуу бүсгүй энэ элсийг шилж аван очиж амрах юмуу, эсвэл цор, ганцаараа салхинд сууж, ном уншиж болно гэвэл хүн үнэмшихгүй гэдгийг би баттай хэлж чадна. Гэтэл Нуранги Элс бол (та юу л гэж бодно, дураараа бологтүн) манай хөрш, Коббс Хол тосгоны ганц үерхдэг бүсгүүндээ хоёр, гурван удаа очсоныг нь эс тооцвол Розанна Спирманы үргэлж очдог, зугаалах дуртай газар нь билээ. Тэр найзынх нь тухай хожим өгүүлнэ. Одоо би Розанна Спирманыг хоолонд нь авчрах гэж чухамхүү тийм зорьсон минь үнэн бөгөөд ингэснээрээ бид хүүрнэлээ эхэлсэн газар эсэн мэнд буцаж, элс рүү дахин зүглэх болно.

Розанна нарсан ойд байсангүй. Элсэн манхнуудыг өнгөрөөд эрэг дээр гартал далиу мөрөө нуух гэдэг бололтой, байнга өмсдөг саарал цуваа нөмөрч, жижиг сийрсэн малгай тавьсан Розанна далайн ус, нуранги элсийг ширтэн цор ганцаараа сууж байлаа.

Намайг дөхөж очиход давхийн цочсоноо нүүр бууруулав. Миний өөдөөс эгцэлж харахгүй байгаа учрыг зарц нарын ахлагчийн хувьд, зарчмын үүднээс ч лавлахгүй өнгөрөөж би хэрхэвч чадахгүй. Розаннаг өөр рүүгээ татан эргүүлбэл уйлж байна. Хатагтайн бэлэглэсэн зургаан сайхан торгон алчуурын нэг миний халаасанд байсныг гаргаж өгөнгөө,

□ Хонгор минь, нааш ир, энд суу. Эхлээд нулимсыг чинь арчихъя, дараа нь яагаад уйлсны чинь учрыг зүрхлээд асууя даа гэж хэллээ.

Далайн хөвөөнө сууна гэгч одоо таны төсөөлж буйгаас хавьгүй их цаг ордог ажил гэдгийг уншигч та миний насан дээр очихоороо ойлгоно биз ээ. Намайг суух зуур Розанна минийхээс долоон доор, хямдхан давуун алчуураараа нүдээ арчив. Розанна тун их гутарч, гиюүрсэн харагдах боловч дуулгавартай охин шиг миний үгийг дагаж хажууд суув. Эмэгтэй хүнийг аргадаж, түргэн тайвшруулъя гэвэл өвөр дээрээ суулгах хэрэгтэй л дээ. би ч энэ хосгүй аргыг санаж л байсан. Гэвч Розанна бол Нэнси биш! Тэр аргыг хэрэглээгүйн учир чухамдаа энд байлаа!

□ За, одоо яагаад уйлснаа хэл дээ, хонгор минь гэж шалгаасанд,

□ Өнгөрснийг дурсаад л... Заримдаа хуучин амьдрал минь санагдаад байх юм хэмээн дорой дуугаар өгүүлэв.

□ За хэрэггүй, хэрэггүй, охин минь. Хуучин амьдрал чинь нэгэнт өнгөрсөн, яагаад өдий болтол мартаж чадахгүй байна вэ?

Розанна миний пижакны нэг энгэрээс барилаа. Би бол хувцас хунартаа баахан хааш яаш ханддаг өвгөн тул идэж уухдаа элдэв юм дуусах нь бий. Шивэгчид миний хувцасны тосон толбыг ээлжээр арилгаж цэвэрлэнэ. Өчигдөр Розанна миний пижакны энгэр дээр байсан нэг тосон толбыг юм бүхнийг арилгадаг хэмээсэн шинэ бодисоор цэвэрлэсэн юм. Толбо арилсан хэдий боловч бүдэг хар мөр үлдсэн байж. Розанна түүнийг заагаад толгой сэгсрэн,

□ Толбо арилсан ч гэсэн мөр нь үлджээ. Мистер Беттереж мөр нь үлдсэн байна! гэж хэлэв.

Хувцсыг нь заагаад тэгж палхийтэл тулган хэлбэл хүн хариу өчих гэж багагүй гэвдэх вий. Яг тэр үед би яагаад ч юм түүнийг хараад жигтэйхэн их өрөвдлөө. Розанна царай муутай хэдий ч сайхан хүрэн нүдтэй ажээ. Өөрт нь хүртэмгүй санагдаж буй бололтой миний өндөр нас, сайн нэр төрийг хүндэтгэсэн харцаар намайг ширтэхэд нь шивэгчнээ өрөвдөн зүрх шимширч билээ. Розаннаг тайвшруулж чадахгүй нэгэнт мухардсан тул хоолонд нь даруй авч очихоос өөр арга байсангүй.

Алив босъё, туслаач. Розанна, чи хоолноос хоцорлоо, би чамайг аваачих гэж ирсэн юм гэж хэлсэнд Мистер Беттереж та юу?! Гэж дуу алдав.

Уг нь чиний хойноос Нэнсийг явуулсан юм билээ.

Тэгэхээр нь миний амнаас зэмлэл сонссон нь чамд дээр байх гэж би бодсон юм л даа, хонгор минь.

Намайг түшиж босгохын оронд хөөрхий бүсгүй миний гарыг аяархан атгаад, дахиад уйлчихгүйг хичээн арайхийн нулимсаа барьж чадахад нь би ихэд тоосон билээ.

□ Мистер Беттереж та их сайн хүн шүү. Би өнөөдөр хоол идмээргүй байна. Би энд дахиад жаахан сууя.

□ Чи энд байх гэж юунд дурлана вэ? Яагаад энэ баргар муухай газар дандаа ирдэг юм бэ? гэж би асуулаа.

Розанна элсний зүг хуруугаараа зааж,

□ Би энд нэг л татагдаад байдаг юм. Ийшээ зүглэхгүй гэж оролдоод дийлээгүй гээд бодлоосоо эмээсэн мэт дуугаа намсган, □ Заримдаа миний булш намайг энд хүлээж байгаа юм шиг санагдах юм гэлээ.

□ Розанна, цаана чинь чамайг хонины шарсан мах, өөхтэй чунз хүлээж байна! Хоолондоо шууд оч. Гэдэс хоосон байхаар элдэв юм боддог юм! Хэмээн хорин дөрөв, тавтай залуу бүсгүйн амнаас үхэж үрэгдэх тухай яриа сонсоод настай хүний хувьд үнэхээр эгдүүцсэн миний бие ширүүхэн зандрал.

Гэтэл Розанна миний үгийг сонсоогүй бололтой, босголгүй мөрөн дээр гараа тавин,

□ Энэ газар намайг илбэдчихсэн байх аа. Шөнө дандаа зүүдэнд орж, юм оёж хатгаад сууж байсан ч санаанаас гарахгүй юм мистер Бэттереж би та нарт баярлаж явдгийг та мэднэ. Таны сайхан сэтгэл, эзэгтэйн итгэлийг хөсөрдүүлэхгүйг хичээдгийг минь ч та мэднэ. Ийм амьдрал туулсан миний мэтийн эмэгтэйд эндхийн амьдрал дэндүү амгалан, хэтэрхий жаргалтай байгаа юм биш үү гэж би заримдаа гайхдаг. Эндхийн бусад зарц, шивэгчнээс тэс ондоо гэдгээ ойлгож байгаа учраас би тэдний дунд улам л ганцаардаад байна. Манай хатагтай, засан хүмүүжүүлэх газрын эрхлэгч авгай хоёр, шударга хүмүүсийн сайн үйл над шиг эмэгтэйд ямар аймшигтай цээрлэл болдгийг огт төсөөлөхгүй. Сайхан сэтгэлт мистер Бэттереж минь, намайг битгий загнаарай. Би ажил үүргээ овоо гүйцэтгэдэг биз дээ? Намайг сэтгэл дундуур байна гэж хатагтайд хэлж болохгүй, би тийм байгаа юм биш. Заримдаа санаа сэтгэлийн тав алдагдах юм, үүнээс өөр юмгүй, гэж өгүүлээд миний мөрөн дээрээс гараа авч, нуранги элс рүү гэнэт зааж, □ Хараач! Гайхалтай, аймшигтай байгаа биз? Би энэ элсийг хэдэн арван удаа харсан мөртлөө тэр бүр анх удаа үзэж байгаа юм шиг санагддаг юм! гэв.

Розаннагийн гарыг дагуулан харвал далайн түрлэг эхэлж, аймшигт элс чичрэн донсолж байв. Элсний бараан гадарга зугуухан дээшилснээ хотойж, тэр аяараа доргино.

□ Энэ элс надад юу санагдуулдаг гэж та бодно? Гээд Розанна миний мөрнөөс дахин барьж,

□ Энэ элсэн доор амьсгал нь давхцан бачимдсан хэдэн зуун хүн дээш гарах гэж хэчнээн тэмцэвч улам доошоо, аймшигтай гүн ёроол руу нь живэн одож байх шиг санагддаг юм! Мистер Бэттереж, та чулуу шидээд үздээ! Шидсэн чулууг элс яаж залгихыг харъя! гэв.

Ёстой л солиорсон хүний үг байна даа! Хоосон ходоод, тав алдсан сэтгэлийг ингэж л дэврээдэг юм! Яг ийм үг (хэдийгээр зэгсэн хатуу боловч хөөрхий бүсгүйд тус болох байсан гэж би итгэл төгс хэлнэ) аман дээр гарч иртэл элсэн манхны дундаас гэнэт:

□ Мистер Бэттереж! Та хаана байна? гэх дуу саад болов.

Хэн дуудсаныг мэдсэн ч үгүй,

□ Энд байна хэмээн хариу хашгирлаа.

Розанна ухасхийн босож, дуу гарсан зүг харав. Би ч өндийхөөр завдсанаа бүсгүйн царай ер бус хувирсныг хараад хэрдхийн балмагдав.

Царайд нь урьд өмнө үзэгдээгүй сайхан ягаан туяа татаж, амьсгаа даран, үг дуугарах ч сөхөөгүй, баярлан гийх шиг болов.

□ Хэн бэ? гэж намайг асуухад Розанна,

□ Ай, хэн бэ? гэж өөдөөс намуухан дуугарах нь өөртөө хэлэх мэт.

Эргээд харсанд элсэн манхны зүгээс гялалзсан сэргэлэн нүдтэй цайвар бор дэгжин костюмтай, мөн тийм өнгийн бүрх малгай, бээлий өмссөн ба товчныхоо нүхэнд нэг сарнай хатгасан залуу эрхэм, нуранги элсийг ч уяраам ялдамхан инээмсэглэсээр айсуу. Намайг босох гэж мунгинасаар байтал хажуугийн элсэн дээр харайн бууж, намайг хүзүүдэн авч, харийн маягаар чанга тэвэрсэнд амьсгал арай л бүтчихсэнгүй.

□ Хонгор Бэттереж өвөө минь! Би танд зургаан шиллинг долоон пэнсийн өртэй шүү дээ. Одоо намайг танив уу? гэх нь тэр.

Бурхан минь биднийгээ өршөөж хайрлаач! Бидний хүлээж байснаас бүтэн дөрвөн цагийн өмнө Фрэнклин Блэйк ирчихсэн байлаа!

Намайг ам нээж амжаагүй байтал Фрэнклин Блэйк, Розаннаг баахан гайхсан янзтай харж байхыг ажиглаад би ч бас бүсгүйг харав. Мистер фрэнклиний харцыг мэдээд ч тэр үү, улам ч их улайснаа огцом эргэн залуу эрхэмд мэхийн ёсолсон ч үгүй, надад ганц ч үг хэлэлгүй биднийг гэнэт орхиод явсанд би мэл гайхан цэл хөхөрч билээ. Уг нь Розанна шиг журамтай, ялдамхан шивэгчин манайд үгүй сэн.

□ Ямар сонин бүсгүй вэ? Намайг гайхаад байх юу байсан юм бол? Гэж мистер Фрэнклин хэлэв.

□ Таны гял цал буусан гадаад хийцийн хувцас л гайхлыг нь төрүүлсэн байх гэж би залуу эрхмийн эх газрын маягийг тохуурхав.

Ухаалаг хүмүүс заримдаа өөрсдөөс нь дутуугүй мунхаг загнадгийг билиг авьяас хомс улс мэдчихээрээ жигтэйхэн хөөрч баярладгийг би олонтаа ажигласан учраас тэнэгүүдийг тайвшруулж,

зоригжуулахын тулд Фрэнклин Блэйкийн хайнга асуулт, өөрийнхөө мулгуу хариуг энд бичсэн юм. Гадаадад гялалзсан сайхан боловсрол эзэмшсэн мистер Фрэнклин ч, өчнөөн олон оймс элээсэн, амьдралын хар ухаан ихтэй, хашир өвгөн миний бие ч, Розаннагийн хачин авирласны үнэн учрыг огт гадарласангүй. Саарал цувны нь хормой салхинд дэrvэсээр элсэн манхны цаагуур орж бараа нь ч тасраагүй байхад бид хоёр хөөрхий бүсгүйг хэдийн мартчихсан байлаа. Ямар учиртай байсан юм бэ гэж уншигч та асуух нь зүйн хэрэг. Эрхэм найз минь, цааш нь тэвчээртэй уншигтун. Тэгвэл үнэн учрыг нь мэдээд ирэхээр та Розанна Спирманыг миний нэгэн адил өрөвдөх биз ээ.

## V бүлэг

Бид хоёул үлдээд би босох гэж гурав дахь удаагаа оролдтол мистер Фрэнклин намайг болиулав.

□ Энэ эвгүй газар тэр чигээрээ бидний мэдэлд байгаа нэг давуу талтай юм. Бэттереж гуай эндээ сууж л бай. Танд хэлэх юм байна.

Фрэнклиний ярьж байх зуур, би өмнөө зогсох эрээс санаанд минь үлдсэн бяцхан хөвгүүний ямар нэг танил төрхийг харчих санаатай ширтэж байлаа. Сайхь эр намайг бүр самууруулчихав. Харах тусам балчир хүүгийн ягаан хацар, хүүхдийн жижиг цамцных нь адил үгүй болсныг мэдэрч байлаа. Одоо мистер Фрэнклиний царай цайвар болжээ. Эрүү нь буржгар хүрэн сахал, хуузаар хучигдсаныг хараад би учиргүй гайхаж, ихэд урам хугарч билээ. Ихэд нүүрэмгий загнах нь тун зохисон, аятайхан байсныг хүлээх хэрэгтэй боловч урьдын шалмаг, хөнгөн хөдөлгөөнтэй жиших юм байсангүй. Их санасан газар ес хоног хоосон гэгчээр Фрэнклин багадаа өндөр хүн болох төлөвтэй байснаа тэгсэнгүй. Хэдийгээр чийрэг, тэгш гоолиг ч гэсэн дунд зэргийн нуруутай хүнээс нэг, хоёр ямх намхан ажээ. Товчоор хэлбэл, би бүр будилж гүйцэв. Улиран өнгөрсөн он жил түүний гялалзсан нүдний шулуун харцыг л өөр чилсэнгүй. Чухам тэр харцнаас нь би хонгорхон хөвгүүнээ дахин олж хараад судалгаагаа орхисон юм.

□ Төрж, өссөн газартаа тавтай морилогтун, мистер Фрэнклин. Бидний хүлээж байснаас хэдэн цагийн өмнө ирсэнд бүр ч их баярлаж байна.

□ Ингэж эрт ирэх шалтгаан байлаа л даа Бэттереж гуай, сүүлийн гурав, дөрөв хоног Лондонд намайг дагаж мөшгөөд байна уу гэсэн сэжиг төрөөд, нүдэнд хүйтэн царайтай нэг гадаадын хүнээс мөр буруулахын тулд оройн галт тэргээр гарахын оронд өглөөнийхөөр гарсан юм гэж хариу өгүүлэв.

Энэ үгийг сонсоод би хачин их гайхаж, нөгөө гурван илбэчин, мөн Фрэнклин Блэйкт хортой юм хийж магадгүй гэж Пенилопын сануулж байсан үг санаанд минь харван орж ирлээ.

□ Таныг хэн, яагаад мөрдөж байгаа юм бэ, эрхэм ээ? Гэж би асуулаа. Гэтэл мистер Фрэнклин миний асуултыг үл анзааран,

□ Өнөөдөр танайд ирсэн гурван энэтхэг хүний тухай яриач. Тэр гурван илбэчин, нөгөө гадаадын хүний хамсаатнууд байж магадгүй юм шүү. Бэттереж гуай минь гэв.

□ Гурван илбэчний тухай та хаанаас мэдээ вэ? Хэмээн асуусны нь хаиулахын оронд муу зуршлаараа эргүүлээд асуучихав. Гэвч уншигч та, хөөрхий хүн төрөлтнөөс их юм хүлээдэггүй биз дээ, тэгвэл надаас ч бас их юм хүлээх хэрэггүй.

□ Байшинд Пенилоптой тараалдаж, Пенилоп энэ тухай хэлсэн юм. Таны охин хөөрхөн бүсгүй болох төлөвтэй байсан, үнэхээр ч сайхан болжээ. Пенилоп хөөрхөн чихтэй, бяцхан хөлтэй юмаа. Талийгаач Бэттереж авгайд энэ үнэлж барамгүй давуу зүйл байсан билүү? Гэж мистер Фрэнклин асуув.

□ Талийгаач Бэттереж авгайд зэгсэн их дутагдал байсны нэг бол (үүнийг дурдахыг зөвшөөрвөл) тун тогтворгүй хүн байлаа. Эмэгтэй хүн гэхээсээ ялаатай илүү адилхан, ер нэг байрандаа тогтож сууж чаддаггүй сэн.

□ Надад л таарах байж дээ гээд

□ Би ер нь нэг байрандаа удаан тогтдоггүй хүн. Бэттереж гуай, та урьдынхаасаа улам ч ухаалаг болжээ. Би илбэчингүүдийн тухай асууж лавлахад охин тань энэ талаар дурссан юм. ↔Танд манай аав ярина байх, эрхэм ээ. Өндөр настай боловч гайхалтай хүн шүү, хэнээс ч дутахгүй сайхан ярьчихна гэж Пенилоп хэлээд тун ч хөөрхөн улайсан. Таныг хэдий их гүн хүндэтгэдэг ч гэсэн би тэсэж чадалгүй... Ер нь би Пенилопыг хар багаас нь таньдаг байсан учраас тэглээ гээд муу юм болохгүй л дээ. За, тэр ч яахав, ажил хэрэгтээ орье. Тэр илбэчид юу хийж байсан бэ? гэв.

Би охиндоо баахан сэтгэл дундуур байлаа. Мистер Фрэнклинд үнсүүлсэнд нь биш, Фрэнклин үнсэх эрхтэй юм, харин нөгөө тэнэг түүхийг заавал надаар яриулах гэсэнд нь дургүйлхсэн билээ. Гэвч тэр тухай ярихаас өөр зам байсангүй. Намайг ярих тусам Фрэнклиний хөөр баяр алга болж

байлаа. Хөмсгөө зангидан сахлаа чимхлэн сууна. Ярьж дуусахад минь сайн тогтоож авах гэсэн бололтой нөгөө хөвгүүнээс илбэчдийн ахлагч юу гэж асуусныг дахин лавлав.

□ ↔Өнөөдөр тэр англи эрхэм яг энэ замаар энэ байшин руу ирэх нь үү?≈, ↔Англи эрхэм нөгөө зүйлээ авч явна уу?≈ гэсэн гэнэ ээ? Тэгээд халааснаасаа битүүмжилсэн жижиг цаасан хайрцаг гарган, □ Нөгөө ↔Зүйл≈ гэж үүнийг хэлсэн болов уу гэж би сэжиглэж байна. Энэ бол миний авга ах Хэрнкастлийн алдарт очир алмаз юм шүү дээ, Бэттереж гуай гэв.

□ Ивээлт тэнгэр минь! Эрхэм ээ, тэр нүнжиггүй хурандаагийн очир алмаз яаж таны гарт орчихоо вэ?! Хэмээн би дуу алдлаа.

□ Тэр хүний мөсгүй хурандаа очир алмазаа миний үеэл дүү Рэчелд төрсөн өдрөөр нь бэлэг болгон өгөөрэй гэж гэрээсэлсэн юм. Харин гэрээсийг нь биелүүлэх үүрэг хүлээсний хувьд эцэг маань үүнийг хүргэж өгөхийг надад тушаасан юм.

Нуранги элсэн дээгүүр чимээгүй бялхан долгилох далай намайг харсаар байтал хуурай газар болон хувирвал миний бие Фрэнклиний яриаг сонсоод гайхсан шигээ тэгтэл балмагдахгүй байсан гэдэгт би үл эргэлзэнэ.

□ Хурандаагийн очир алмаз мисс Рэчелд үлдсэн хэрэг үү! Таны эцэг хурандаагийн гэрээсийг гүйцэтгэгч болсон гэнэ ээ! Мистер Фрэнклин таны эцэг хурандаад хурууныхаа үзүүрийг ч хүргэхээс цээрлэнэ гэдэгт би мөрий тавихад бэлэн байна!

□ Сүрхий хэллээ, Бэттереж гуай! Хурандаагийн тухай үүнээс илүү муу үг олох уу даа? Тэр хүн миний үеийнх биш, таны үеийн хүн. Тэгэхээр та надад хурандаагийн талаар юу мэддэгээ ярьж өгөөч. Дараа нь би танд миний эцэг яагаад хурандаагийн гэрээс гүйцэтгэгч болсныг бас бус өөр юм дуулгая. Лондонд байхдаа, авга ах Хэрнкастль болон түүний очир алмазын талаар их л олиггүй санагдсан хэдэн зүйл олж мэдсэн. Үүнийг та нотлох эсэхийг би мэдэх гэсэн юм. Та саяхан авга ахыг ↔нүнжиггүй хурандаа≈ гэж нэрлэлээ. Өвгөн найз минь, өнгөрснийг эргэн санаж, учрыг нь яригтүн.

Тоглоом шоглоомгүй үнэн сэтгэлээсээ хэлж байгааг үзээд би яриагаа эхлэв.

Энд зөвхөн уншигч танд л зориулсан гол гол зүйлийг түүвэрлэн өгүүлсүгэй. Анхааралтай уншаарай, эс тэгвэл манай туужийн үйл явдал гүнзгийрэх тусам та бүр будилж орхино шүү. Бодол санаагаа, хүүхэд шуухад, хоол унд, эсвэл шинэ бүрх малгай ч юмуу бас бусэлдэв зүйлээс хөндийрүүлэгтүн. Улс төр, морь, худалдаа санхүүгийн газар хэлэлцэх үнэ цэнэ, клубдээ гарсан зохисгүй будлианыг мартахыг хичээгтүн. Миний бие ийнхүү илэн далангүй байгаад дургүйцэхгүй байх гэж найдаж байна. Эелдэг уншигч таны анхаарлыг татах л гэж энэ шүү дээ. Тэнгэр минь! Та бүхнийг агуу их зохиолчдын бүтээлийг уншин сууж байхад анхаараач гэж хүн биш ном гуйсан үед анхаарал тань хичнээн хялбар сарнидгийг би ямар мэдэхгүй биш дээ.

Манай эзэгтэйн эцэг өвгөн ноён тэвчээр багатай, сул амтай хүн байсныг би нэлээд дээр дурдсан билээ. Тэднийх таван хүүхэдтэй байв. Анх хоёр хүү төрж, олон жилийн дараа эхнэр нь дахин хөл хүндтэй болж гурван охин ойрхон зайтай төржээ. Манай эзэгтэй отгон нь, бас хамгийн сайн охин нь байсныг дээр нэгэнт өгүүлсэн билээ. Ууган хүү Артур эцгийнхээ хэргэм зэрэг, өв хөрөнгийг үе залгамжлан авч, удаах хүү, дээд төрөлт Жон нэг хамаатнаасаа подхийсэн хөрөнгө өвлөн аваад цэрэгт алба хаахаар явжээ.

Ишиг эврээ ургахаар эхийгээ мөргөнө гэсэн үг байдаг. Хэрнкастлийн сурвалжит гэр бүлийг би төрсөн гэр шигээ бодож явдаг бөгөөд дээд төрөлт Жоны тухай тодорхой өгүүлэх үүргээс чөлөөлөгдөх ахул надад их л ивээл болохсон. Тэр хүн бол хорвоогийн тоосыг хөдөлгөж явсан хамгийн өөдгүй этгээд байсан гэдэгт би өчүүхэн ч эргэлзэхгүй. Түүний тухайд үүнээс өөр хэлэх үг даанч үгүй. Цэргийн албаа торгон цэргийн хорооноос эхэлсэн ба хорин хоёр ч хүрээгүй байхдаа тэндээс халагджээ. Халагдсных нь шалтгааныг дурсахаа больё. Цэргийн хатуу дэглэм дээд төрөлт Жонын сэтгэлд нийцсэнгүй. Тэгээд Энэтхэгт цэргийн дэглэм журам адилхан хатуу чанд эсэхийг үзэх, бас ч дарь үнэртэх санаатай явжээ. Зүрх зоригийн хувьд гэвэл, бух нохой зодооч азарган тахиа, зэрлэгүүдийн дайчин эрэмгий чанар хосолсон байсныг шударгаар хэлбэл зохино. Серингапатамыг авсан тулалдааны дараа Жон Хэрнкастль өөр хороонд шилжиж, төдөлгүй дахиад тэндээсээ шилжжээ. Тэнд хурандаа цол хүртэн дэвшиж яваад наранд цохиулж Англи нутагтаа буцаж ирсэн юм.

Энэтхэгээс нэр алдраа хугалчихаад ирсэн тул ах дүү нар нь нүүр буруулцагааж, хадамд гараад удаагүй байсан манай эзэгтэй (мэдээжээр нөхөртэйгөө зөвлөөд) ахыгаа босго алхуулахгүй гэж хамгийн түрүүнд мэдэгдсэн ажээ. Хурандаагийн нэр төрд суусан өчнөөн олон толбыг орхиод зөвхөн Саран чулуутай холбоо бүхий болчимгүй явдлыг нь энд өгүүлсүгэй.

Хурандаа Жон хэдийгээр бөх зүрхтэй эр боловч Энэтхэгийн тэр эрдэнийн чулууг ямар замаар, хэрхэн олж авснаа хүнд мэдэгдэхийг огт хүсдэггүй байжээ. Мөнгөөр гачигддаггүйн дээр мөн

шударгаар хэлэхэд, мөнгөнд шуналгүй байсан тул зарж борлуулах ч гэсэнгүй. Тэр чулуугаа хэнд ч бэлэглээгүйгээр үл барам нэг ч амьд амьтанд харуулдаггүй байж. Зарим хүн үүний учир бол, дарга нарынхаа дургүйг хүргэж болзошгүй гэж болгоомжилсных гэлцэх ба энэ хүний зан төрхийг сайн мэддэггүй зарим нь алмаз эрдэнэ харуулчихвал амь насаа алдана гэж айсных гэлцэж байв.

Хурандаа айсан гэвэл хилсдэх боловч эл таамаглал ортой байж болох юм. Үнэндээ хурандааг Энэтхэгт байхад нь хоёр ч удаа аминд нь халдсан бөгөөд шалтгаан нь Саран чулуу байсан гэдэгт хэн ч эргэлзэхгүй байв. Хурандааг Англидаа эргэж ирэхэд Саран чулуу бас л гай болж, хурандаагаас хүмүүс дөлж зайлан ганцаардуулжээ. Хурандаагийн амьдралын нууц юм бүхэн дээр саад тотгор болж, нутгийнхнаас нь хөндийрүүлжээ. Эрчүүд клубтээ хүлээж авахгүй нэг бус эмэгтэй гэрлэе гуйхад нь татгалзаж, найз нөхөд, хамаатан садан нь гудамжинд тааралдаад олж харахгүй харалган болцгоожээ.

Өөр хүн иймэрхүү тааламжгүй байдалд орсон бол хүмүүстэй эвлэрэх гэж чадлаараа л мэрийх буй заа. Хэдийгээр өөрөө гэмтэй ч, хүн бүхэн нүүр буруулсан ч гэсэн дээд төрөлт Жон бууж өгөх хүн огт биш байв. Энэтхэгт байхдаа амь алдаж болзошгүй байсныг ч эс тоомсорлон очир алмазыг биедээ хадгалсаар ирсэн бөгөөд Англид ч олон нийтийн санаа бодлыг үл хэрэгсэж буйгаа харуулан нөгөө алмазаа үрсэнгүй. Юм бүхнээс тэрслэн зөрдөг гэжүүн зантай, цэвэрхэн царайтай боловч чөтгөр шүглэсэн мэт хар санаа илэрсэн хүний хөргийг дүрсэлбэл энэ байна.

Хурандаагийн тухай есөн шидийн үг байсгээд л дуулддаг байв. Заримдаа хар тамхинд орсон л гэнэ, бас хуучин ном цуглуулдаг болжээ л гэнэ. Нэг үе хувилахуй ухаанаар оролдон хачин хачин туршилт хийж байна гэлцэж, мөн Лондоны ядуусын хороололд тун сэжиг бүхий этгээдүүдтэй нөхөрлөн явж байна гэлцэх бөлгөө. Ер нь ямар боловч зожиг, завхай, битүүлэг амьдралтай байжээ. Хурандаагийн Англид ирснээс нь хойш би нэг удаа, ердөө ганцхан удаа нүүр учирч билээ.

Энэ хүүрнэлийг бичихээс хоёр жилийн өмнө буюу хурандаа нас нөхчихөөсөө барагцаалбал жил хагасын өмнө манай хатагтайн Лондонгийн байранд гэнэт ирсэн юм. Тэр өдөр мисс Рэчелийн төрсөн өдрийн баярыг уламжлал ёсоор тэмдэглэж байсан зургадугаар сарын хорин нэгний өдөр байв. Надтай уулзахаар нэг эрхэм ирээд байна гэж зарц дуулгасанд доошоо үүдний танхимд бууж очвол турж эцсэн, өвгөрч доройтсон боловч бахь байдгаараа догшин шазруун дүртэй хурандаа зогсож байлаа.

□ Дүүд минь очоод, зээ охиныхоо төрсөн өдрийг тохиолдуулан сайн сайхныг хүсэх гэж ирснийг минь уламжлаадах гэж хурандаа хэлэв.

Хурандаа хэд хэдэн удаа манай ахайтантай эвлэрэх гэж захиа ирүүлсэн нь гай уршиг л тарих гэснээс өөр бодолгүй байсан гэдэгт би огтхон ч эргэлзэхгүй. Харин анх удаа ийнхүү өөрийн биеэр хүрэлцэн ирсэн байлаа. Эхлээд ахайтанг зочидтой байгаа гэж хэлье, үү гэтэл хурандаагийн зэвүүн харцнаас баахан сүрдэж үүдний танхимд хүлээж байя гэсэн ёсоор нь үлдээгээд хэлсний нь уламжлахаар дээшээ гарав. Зару нар зайдуухан зогсоод дарь, үрлэн сумаар цэнэглэсэн, хэзээ хэзээгүй дэлбэрч мэдэх устгагч хөдөлгүүр харж байна уу гэлтэй хурандааг бүлтийтэл ширтэцгээнэ.

Ахайтан маань эцэг өвгөдийнхөө ааг омгийг бага зэрэг өвлөж авсан хүн л дээ. Миний бие ахынх нь үгийг дамжуулсанд,

□ Хурандаа Хэрнкастльд, мисс Вериндер завгүй байна, харин надад бараагий чинь ч харах хүсэл алга гэж хэлэгтүн гэлээ.

Ёсорхог эрчүүдийн дагадаг биеэ барих ёсыг хурандаа төдий л ойшоодоггүйг мэдэх мэдэх тул үүнээс арай өөр хариу өгөөч гэж би ахайтнаасягтах гэж үзлээ.

Гэвч ямар ч тус болсонгүй. Удмынхаа нөгөө ааг омгийг надад гаргаж,

□ Зөвлөгөө авахыг хүссэн цагтаа би өөрөө танаас асуудгийг та бэлээхэн мэднэ. Харин одоо танаас зөвлөгөө эрээгүй байна гэж айлдав.

Миний бие ахайтны үгийг хурандаад уламжлахаар доошоо бууж, түүнийг нь арай зөөлрүүлж,

□ Хурандаа, ахайтан, мисс Рэчел хоёр завгүй байгаадаа харамсаж, уучлал гуйж байна хэмээн уламжиллаа.

Ахайтны хариуг хэдийгээр эвэргүүгээр дамжуулавч хурандаа уурсан хилэгнэнэ дээ гэж бодож байтал ер уурласангүйд би баахан гайхлаа. Харин түүнийер бусын тайван байгаа нь миний айдсыг төрүүлсэн юм. Хурандаа гялалзсан бор нүдээр намайг ширтэн бусад хүнтэй адил чанга бус, харин тэрүүхэндээ хорсолтойгоор аяархан инээд алдаад,

□ Баярлалаа, Бэттереж ээ. Би зээ охиныхоо төрсөн өдрийг мартажгүй санаж явья гэж өгүүлээд өсгий дээрээ огцом эргэн гарч одов.

Хойтон жил нь мисс Рэчелийн төрсөн өдөр болоход хурандаагийн бие нь муу, хэвтэрт байна гэж дуулдсан юм. Түүнээс хагас жилийн хойно буюу миний бие энэ түүхийг бичихээс зургаан сарын өмнө нэгэн хүндэт ламтан, манай ахайтанд захиа ирүүлэв. Захиандаа гайхалтай хоёр зүйлийг өгүүлсэн нь: нэгдүгээрт, хурандаа хоногоо хүлээгээд хэвтэхдээ дүүгээ уучилсан гэнэ. Хоёрдугаарт, бүх хүнийг уучилж, ер нь тун их үлгэр дууриалтайгаар нас эцэслэсэн гэнэ.

Би бол хамба, санваартнуудыг үл харгалзан сүм хийдийг нэгэн сэтгэл барин хүндэтгэдэг хүн. Гэвч дээд төрөлт Жонд ад чөтгөр шүглэсэн, тиймээс ч тэрхүү увайгүй эр, амьсгал хураахаасаа өмнө эцсийн удаа өөдгүй авирлаж (уучлах ажаамуу), ламтныг мэхэлсэн гэдэгт би итгэлтэй байлаа.

Мистер Фрэнклинд миний өгүүлсэ зүйлийн гол тойм ийм байна. Миний яриаг улам улам анхааран сонирхож байхыг би ажиглав. Зээ охиныхоо төрсөн өдрөөр ирчихээд үүднээс нь буцсан тухай сонсоод Фрэнклин могойд хатгуулсан мэт давхийн цочив. Тийнхүү балмагдсанаа өөрөө хэлээгүй хэдий боловч хувхай даасан царайнаас нь андашгүй харагдсан юм.

□ Бэттереж гуай, та мэдэх бүхнээ ярилаа. Одоо миний ээлж болов. Гэвч Лондонд олж мэдсэн зүйлийг, мөн миний бие очир алмазын эл хэрэгт яаж яваад орооцолдсоноо ярихын өмнө нэг зүйлийг тодруулмаар байна. Та манай зөвлөгөөний зорилгыг төдий л сайн ойлгохгүй янзтай харагдах чинь. Эсвэл худлаа юу?

□ Үгүй ээ, эрхэм ээ. Энэ удаад үнэхээр тийм байна гэж би хариу өчив.

□ Тэгвэл цааш үргэлжлүүлэхийн өмнө санал бодлоо тантай хуваалцах гээд үзье. Миний үеэл дүү Рэчелийн төрсөн өдрөөр хурандаагийн өгч байгаа бэлэгтэй холбогдож тун ноцтой гурван асуудал гарч байна. Намайг анхааралтай сонсогтун Бэттереж гуай. Хэрэв хэрэгтэй гэж үзвэл хуруу даран тоолоорой хэмээн ухаалаг хэрсүү чанараа харуулахдаа нэлээд додигор болдог зангаараа өгүүлсэн нь бага хөвгүүн байсан үеэ тодхон санагдуулж билээ. Тэгээд цааш өгүүлрүүн:

□ Нэгдүгээр асуудал. Хурандаагийн алмаз Энэтхэгт ямар нэг хуйвалдааны бай болж байсан эсэх? Хоёрдугаар асуудал. Тэр хуйвалдаан үүсгэсэн хүмүүс Хурандаагийн алмазыг даган Англид ирсэн эсэх? Гуравдугаар асуудал. Уг хуйвалдааныг хурандаа мэдэж байсан эсэх? Мөн дүүгийнхээ гэмгүй хүүхдээр дамжуулан дүүдээ гай зовлон тарих гэж тэр алмазыг зориуд гэрээслэн үлдээсэн юм биш биз? Би үүнийг л мэдэх гэсэн юм даа, Бэттереж гуай минь. Та айсны хэрэггүй.

Сүнс зайлтал айлгаж орхичихоод ингэж сануулдаг мөн таарч дээ!

Мистер Фрэнклиний таамаглал үнэн л бол үхсэн хүний өс хонзонгийн зэвсэг, амьд луйварчдын хуйвалдааны бай, ад чөтгөр шүглэсэн очир алмаз манай нам тайван англи гэр оронд гэнэт нэвтрэн орж дээ. Мистер Фрэнклиний үгээр бол бидний байдал яг л байна! Арван есдүгээр зуунд, хөгжил дэвшлийн энэ үед, Британий үндсэн хуулийн шим хүртсэн энэ оронд иймэрхүү юм сонссон хүн бий гэж үү? Ийм юм сонссон хүн байхгүй учраас итгэж үнэмших хүн ч гарахгүй буй заа. Гэвч үүнээс эс харгалзан би өгүүлэхээр завдан буй түүхээ үргэлжлүүлсүгэй.

Та миний нэгэн адил тэгж цочмог айж мэгдвэл арван тохиолдлын есөн удаад нь айдас хүйдсийг ходоодондоо хүртэл мэдрэх вий. Айдсыг ходоодондоо мэдрэсэн үед анхаарал чинь сарниж, дэмий л уймарч эргэлдэж эхэлнэ дээ. Би тэрүүхэн дороо элсэн дээр эргэлдэн байж ядаж байлаа. Миний бие тийнхүү хямарсан ходоодоо, эсвэл таны таалалд нийцүүлбэл (уг нь чанартай нэг юм) хямарсан сэтгэлээ тогтоон дарахаар тэмцэж байхыг минь мистер Фрэнклин ажиглачихаад яриагаа үргэлжлүүлэхээр завдсанаа зогсож,

□ Та яав аа? Гэж огцом асуув.

Яав гэнэ ээ? Би түүнд учраа хэлсэнгүй. Харин танд итгээд хэлчихье. Би гансаа нэрж, ↔Робинзон Крузогоо≈ үзэхсэн гэж хүсэж байлаа.

## VI бүлэг

Юу хүссэнээ эс өгүүлэн мистер Фрэнклинээс яриагаа үргэлжлүүлэхийг хүндэтгэлтэйгээр гуйсанд, ↔Бүү самгард, Бэттереж гуай≈ гэхихээд цааш ярьсан юм.

Манай залуу эрхэм нааш ирэхийн өмнө Хампстидэд очиж, гэрийнхээ хуульчтай уулзах үес, нүнжиггүй хурандаа болон алмазтай холбоотой бүхий зүйлсийг илрүүлэх ажлаа эхэлсэн гэдгээ юуны түрүүнд мэдэгдлээ. Нэг удаа хоолны дараа хоёулхнаа сууж байгаад, мисс Рэчелд төрсөн өдрийнх нь бэлгийг хүргэж өгөх үүрэг эцгээсээ авсан гэж санамсаргүй ярьжээ. Элдвийг хүүрнэлдэнгээ тэр бэлэг гээч чухам юу болохыг, талийгаач хурандаа, Блэйк-эцэг хоёрын найсаг харьцаа хэрхэн үүссэнийг хуульч өгүүлжээ. Тэдгээр нь үнэхээр жирийн бус байсан тул үгээр илэрхийлэхэд ч бэрх санагдана. Мистер Фрэнклиний мэдсэн зүйлийг өөрийнх нь үгээр толилуулбал дээр болов уу. Фрэнклин өгүүлрүүн:

□ Бэттереж гуай, эцэг маань нөгөө золгүй ванлингийг захирах эрхээ тогтоох санаатай хөөцөлдөж байсан үеийг та санаж байгаа биз дээ? За сайн байна! Яг тэр үед манай нагац Хэрнкастль Энэтхэгээс эргэж ирээд байжээ. Хөөцөлдөж байгаа заргад нь хэрэг болох хэдэн бичиг түүнд байгааг манай эцэг мэдсэн юмсанж. Тэгээд хурандааг Англидаа эсэн мэнд буцаж ирсэнд нь баяр хүргэх нэрийдлээр

очсон байна. Гэтэл хурандаа Хэрнкастль хялбар хууртах хүн биш байж. ↔Та нэг юм гуйх гэж иржээ дээ. Тийм биш бол надтай уулзаж нэр төрөө золихгүй сонг гэж хурандаа хэлсэнд эцэг маань илэн далангүй байхаас өөр замгүй болсныг ухаарч, нөгөө бичиг цаас хэрэгтэй гэдэг үнэнээ даруй хэлсэн байна. Хурандаа хэд хоног бодоод хариу өгье гэжээ. Хариугаа тун жигтэй захиадлаар өгснийг манай хуульч надад үзүүлсэн юм. Хурандаа өөрийн эцгээс маань хүсэх зүйл байна гээд бие биедээ нөхөрсөгөөр тусалъя хэмээн захидлаа эхэлсэн байв. Дайнд за дайрч (яг ингэж бичсэн байлаа!) орчлонгийн хамгийн том очир алмазын нэгийг эзэмших болсон, тэр алмазыг биедээ авч яваа цагт дэлхийн аль ч өнцөгт, ямар ч байшинд орогновч түүний бие болон эрдэнийн чулуу огт амар заяа үзэхгүй гэж үзэх үндэс түүнд бий гэнэ. Ийм осолтой байдлын улмаас уг алмазыг өөр хүнд хадгалуулахаас өөр аргагүйд хүрч байгаа ажээ. Харин тэр хадгалах хүнд бол ямар ч аюул заналхийлэхгүй. Тэр хүн эрдэнийн чулууг хамгаалалт бүхий газар, их үнэ цэнэтэй зүйлс хадгалдаг тусгай агуулах сав бүхий банкны эзэнд ч юмуу, инжаанд өгвөл болох ажээ. Тэгээд л өөрөө санаа амар суух боломжтой ажээ. Өөрөө ч юмуу, эсвэл итгэмжлэгдсэн хүнээрээ дамжуулан урьдаас тогтсон хаягаар, товлосон өдрүүдэд хурандаагаас зөвхөн амьд мэнд гэсэн зурвас авах болно. Хэрэв товлосон цагт зурвас ирэхгүй бол мэдээ чимээ тасарсныг хурандаа хүний гарт амь үрэгдсэний тэмдэг гэж үзэх гэнэ. Тийм тохиолдолд эл алмазыг цаашид хэрхэх тухай тодорхой заасан, битүүмжилсэн гэрээслэлийг задалж, чандлан биелүүлэх ёстой. Эцэг маань энэ хачин хүсэлтийг нь зөвшөөрөх аваас хурандаа нөгөө баримт бичгүүдийг өгөх юмсанж. Ийм л агуулагтай захидал байсан юм.

□ Тэгээд таны эцэг яасан бэ? гэж би асуув.

□ Эцэг үү? Одоо би ярья. Эцэг маань саруул ухаан гэгч хосгүй чадвараар хурандаагийн захидалд хандсан юм. Бичсэн бүхнийг нь шал утгагүй, дэмий зүйл гэж үзжээ. Хурандаа Энэтхэг орноор хөндлөн гулд хэсэж явахдаа олсон нэг муу шилийг алмаз гэж бодсон хэрэг. Амь насанд нь заналхийлсан аюул болон амь нас, хэлтэрхий шилээ хамгаалах урьдчилсан арга хэмжээний хувьд гэвэл, эрүүл ухаантай хэн боловч зөвхөн цагдаагийн газар хандах ёстой. Одоо арван есдүгээр зуун шүү дээ. Хурандаа хар тамхинд орсоор олон жил болсныг хэн ч андахгүй, нөгөө үнэт баримт бичгийг салгаж авах цорын ганц зам бол хар тамхинд мансуурсан хурандаагийн солиорлыг үнэмших явдал байвал эцэг маань тэрхүү хөгийн үүргийг хожим төвөг удахгүй гэснээс удахгүй гэснээс ч илүү дуртайгаар хүлээн авахад бэлэн байсан юм. Нөгөө алмаз, битүүмжилсэн гэрээслэлийг банкинд, найдвартай газар хадгалуулахаар өгч, хурандаа амьд мэнд буйгаа мэдэгдэж тогтмол ирүүлдэг захидлыг эцгийн итгэмжилсэн хүний хувьд манай гэр бүлийн хуульч мистер Брафф авч, задалж үздэг байв. Тиймэрхүү байдалд орсон алив эрүүл ухаантай хүн эл явдлыг үүнээс өөрөөр үзэхгүй буй заа. Бэттереж гуай минь, бид амьдралынхаа туршлагаас өөр нэг ч юманд итгэдэггүй, ер бусын, нууцлаг зүйлд сониноос уншихаараа л үнэмшдэг билээ.

Хурандаагийн талаар эцгийн бодлоор мистер Фрэнклиний хуумгай, ташаа гэж үзэж буйг нь би тэгэхэд ойлгосон юм.

□ Энэ хэргийн талаар өөрөө ямар бодолтой байна вэ. Эрхэм ээ? Гэж би асуулаа.

Тэгтэл мистер Фрэнклиний,

□ Эхлээд хурандаагийн тухай яриад дуусгачихъя. Бэттереж гуай, англи сэтгэхүйд дэс дараалал байдаггүй онцлогтой бөгөөд өвгөн найз минь, таны энэ асуулт үүний нэг жишээ юм. Манайхан машин хийхээ болчихвол орчлон ертөнцөд оюун ухааны хамгийн арчаагүй улс болох вий гэлээ. Үүнийг сонсоод ↔За гадаадын боловсрол гэгч энэ дээ! Англичуудаа ингэж дооглохыг Францад л сурсан байх даа гэж бодож билээ.

Мистер Фрэнклин тасарсан яриагаа үргэлжлүүлэн:

□ Эцэг маань хүссэн баримт бичгээ авч, түүнээс хойш хүргэн ахтайгаа нэг ч удаа уулзсангүй. Он жил улиран өнгөрч, товлосон өдрүүдэд хурандаагаас захиа ирэхэд нь мистер Брафф задалж үзнэ. ↔Эрхэм ээ, амьд сэрүүн яваагаа мэдэгдье. Нөгөө алмазыг хадгалж л бай. Жон Хэрнкастль гэсэн албаны товчхон үгтэй баахан үгтэй захиаг нь би уншсан. Ийм үгтэй зурвасууд товлосон өдрөө тогтмол ирдэг байснаа долоо, найман сарын өмнө анх удаа өөр үгтэй захиа ирсэн нь ↔Эрхэм ээ, би үхэх гэж байна. Нааш ирж гэрээслэлээ бичихэд минь туслаач гэжээ. Манай хуульч мистер Брафф явж, Энэтхэгээс ирснээсээ хойш ганцаархнаа суудаг болсон, хотын ойролцоох эзэмшил газар нь байдаг зуны байрандаа байхад нь хурандаатай уулзжээ. Хурандаад хэдэн нохой, муур, шувуу хань болох ба тэднийд өдөр бүр ирж, гэр зуурынх ажлыг хийдэг нэг хүн, нэг эмчээс өөр хүн байсангүй. Гэрээслэл нь их энгийн байв. Хурандаа мөнгө хөрөнгөнийхөө ихэнхийг хувилахуй ухааны элдэв туршилт сорилтод үржээ. Гэрээслэл гурван зүйлээс бүрдэх ба хурандаа хэвтэрт орсон боловч ухаан саруул үедээ дуудаж бичүүлсэн аж. Нэгдүгээр зүйлдээ, гэрийн тэжээвэр амьтадыг арчилж, тэжээж байх тухай дурджээ. Хоёрдугаар зүйлдээ, умард нутгийн нэг их сургуульд хувилахуй ухааны тэнхим байгуулахаар гэрээслэжээ. Гуравдугаар зүйлдээ, манай эцгээр гэрээслэл гүйцэтгэх болзолтойгоор

Саран чулууг зээ охиндоо төрсөн өдрийн бэлэг болгон үлдээжээ. Эцэг маань эхлээд эл үүргээс татгалзсан боловч эргэцүүлж үзээд сүүлдээ зөвшөөрсөн юм. Нэг талаар, гэрээслэл гүйцэтгэлээ гээд өөрт нь төвөг чирэгдэл учрахгүй гэж итгэсэн, нөгөөтэйгүүр, хуульч Брафф мисс Рэчелийн ашиг сонирхолын үүднээс, уг алмазыг ямар боловч үнэ цэнэтэй эд биз гэж сануулсан учраас зөвшөөрчээ.

Тэр алмазыг ямар учраас мисс Рэчелд үлдээснээ хурандаа хэлсэн үү? Гэж би асуув.

Учрыг хэлснээр барахгүй, гэрээслэлдээ тайлбарласан байна билээ гэж мистер Фрэнклин өгүүлээд,

Би нэг хуулбарыг нь авчирсан, танд одоохон үзүүлэмз. Бэттереж гуай минь, жаахан тэсэж үз! Цагийн юм цагтаа гэдэг. Та хурандааг нас барсны дараа юу болсныг сонсогтүн. Хурандаагийн гэрээслэлийг биелүүлэхийн өмнө ёс журмын дагуу нөгөө алмазыг үнийг тогтоох хэрэгтэй боллоо. Энэ талаар асууж зөвлөсөн инжаан бүхэн дэлхийн хамгийн том очир алмазыг нэгийг эзэмшсэн хэмээн баталж байсан хурандаагийн үгийг нотолцгоов. Гэтэл үнийг яв цав тогтооход нэг бэрхшээл тулгарав. Овор хэмжээгээр ер бусын том агаад өнгө нь нэн өвөрмөц. Эдгээр онцлог шинжээс гадна, нэг сэв байсан нь чулуу яг голдоо толботой байв. Тийм сэвтэй хэдий боловч хамгийн доогуур үнэллээ нэхэд л хорин мянган фунт хүрч байна. Эцэг яаж гайхсан гэж санана! Гэрээслэл гүйцэтгэгчийн үүргээс арай л татгалзаж, тэр гайхамшигт эрдэнийг манай гэр бүлээс золтой л алчихаагүй шүү! Харин сүүлдээ сониуч зан нь дийлж, алмазтай хамт хадгалуулсан битүүмжилсэн зааврыг нь задалжээ. Тэдгээрээс хурандаагийн амь насанд заналхийлж байсан хуйвалдааны нууцыг тайлах түлхүүрийг олж болно гэж би бодож байна гэв.

Тэгээд хуйвалдаан үнэхээр байсан гэж бодож таараа биз дээ?

Эцгийнхээ онцгой ↔эрүүл ухааныг~ өвлөж аваагүй миний бие амь насанд нь аюул заналхийлж байсан гэдэг хурандаагийн үгэнд итгэж байна. Орондоо мөрөөрөө нас нөгчсөн хэдий боловч үхлийнхээ шалтгааныг миний таамаглаж байсанчлан битүүмжилсэн заавартаа тайлбарлажээ. Хүчинд автан алагдсан тохиолдолд (товлосон өдөр тогтмол ирдэг захидал нь тасрвал тэгж үзнэ гэсэн билээ) Саран чулууг манай эцэг Амстердам руу нууцаар явуулах хэрэгтэй ажээ. Тэр хотын алдарт алмаз зүсэгчид өгч, дөрвөөс зургаан хэсэг хуваалгаад ямар ч хамаагүй үнээр борлуулаад, мөнгийг хурандаа гэрээслэлдээ дурдсан нөгөө хувилахуй ухааны тэнхимийг байгуулахад нэмэр болгон өнөх байв. За, Бэттереж гуай минь, сэргэлэн ухаанаа хурцалж, хурандаагийн заавраас ямар дүгнэлт хийж болохыг бод доо!

Би ч тэр даруй ухаанаа дайчиллаа. Гэтэл английн болхи удаан шинж бүрдсэн миний ухаан мистер Фрэнклин чиг гаргаж өгөхөөс өмнө бүр будилж орхилоо.

Алмаз бүхлээрээ байх явдал, хурандаагийн эсэн мэнд явахтай сүрхий овжин холбогдсон байгааг хар л даа. ↔Намайг албал ал. Тэглээ та нар алмазанд ойртож чадахгүй. Алмаз, та нарын нэвтэрч дөнгөхгүй банкны бат хамгаалалттай агуулахад байгаа шүү дээ!~ гэж дайснууддаа хэлэхийн оронд ↔Намайг ал л даа. Тэгвэл алмаз чинь хуучнаараа биш болж устана~ гэжээ. Энэ юү гэсэн үг вэ?

Энэ удаад миний бие харь орны гайхалтай саруул ухааныг биширч билээ.

Ойлгомжтой. Тэгж жижиглэсэнээрээ үнийг нь бууруулж, муусайн луйварчдыг амаар нь шороо үмхүүлэх хэрэг байх нь гэж би өгүүлэв.

Огт тийм биш. Би тэр тухай асууж лавласан.

Тэр ялимгүй согогтой алмазыг хэдэн хэсэг хуваасан ч үнэ цэнээ алдахгүйгээр барахгүй харин ч бүтэн байснаасаа илүү үнэд хүрнэ гэсэн. Энэ ч тодорхой хэрэг, юу гэвэл, тав, зургаан өөгүй сайхан алмаз сэвтэй нэг том чулуунаас хавьгүй их үнэ хүрнэ шүү дээ. Хуйвалдагч нар олзонд шунаж хулгайлахаар завдаж байсан бол хурандаагийн заавар тэдний сэтгэлийг бүр их гижигдэх ёстой. Алмазнаас үлэмж их мөнгө олж болох бөгөөд нэгэнт Амстердамын мастеруудын гараар орсон бол худалдаж борлуулахад их л хялбар болох билээ.

Тэнгэр биднийг тэтгэх болтугай эрхэм ээ! Хэмээн би уулга алдаад,

Тэгвэл ямар учиртай хуйвалдаан юм бол? гэж асуув.

Уг чулууг урьд нь эзэмшиж байсан энэтхэгчүүдийн хуйвалдаан нь эртний хийдийн нэг шашны заншил дээр үндэслэн үүссэн байна. Одоо надад байгаа гэр бүлийн нэг бичиг миний бодлыг зөвийг нотолсон юм гэж мистер Фрэнклин хариуллаа.

Манайд гурван энэтхэг илбэчин ирснийг Фрэнклин их л учиртай хэрэг гэж үзэж байсны учрыг би сая л ухаарлаа.

Мистер Фрэнклин цааш өгүүллүүн:

Би өөрийнхөө саналыг танд тулгахгүй. Аливаа бэрхшээл зовлон, аюул ослыг эсхайхран ариун нандин шүтээнээ олж авах аятай боломж эрж хайх хэрэгт амь биеэ зориулсан бөгөөд нандин шүтээнээ бэрхшээл, зүтгүүрийг гэтлэн туулахаас шантрахгүй гартаа оруулах аятай боломжийг хүлээн бүхий л хэдэн шилдэг лам явж байгаа болов уу гэсэн миний таамаглал дорно зүгийн хүний тэвчээр,

дорно дахины шашны нөлөөний талаар та бидний гадарладаг зүйлстэй яв цав тохирч байх шиг санагдана. Би номыг их хийсвэрлэж боддог, махны худалдаачин, боовчин, татварын байцаагч ч хөдөлбөргүй бодит зүйл биш шиг санагддаг юм. Миний таамаглалыг юу ч гэж үзсэн хамаагүй харин одоо бидэнд хамаатай бодит асуудалд оръё. Саран чулууг авах гэсэн хуйвалдаан хурандааг нас барсан ч гэсэн хэвээрээ үргэлжлэх үү? Зээ охиндоо төрсөн өдрийнх бэлэг болгон үлдээхдээ хурандаа энэ тухай мэдэж байв уу?

Энэ бүхэн манай ахайтан мисс Рэчел хоёрт шууд холбогдолтойг би сая ойлгож, мистер Фрэнклиний үг бүрийг алдалгүй анхааран сонсов.

□ Саран чулууны түүхийг мэдчихээд би тэр алмазыг нааш нь авчрахаас дургүйцсэн юм. Гэвч хэн нэг хүн нагац ахын өвийг үеэл дүүд заавал гардуулж өгөх ёстой агаад энэ ажлыг миний бие хэнээс ч дутахгүй гүйцэтгэж чадна гэдгийг мистер Брафф сануулсан юм. Банкнаас нөгөө алмазыг аваад явж байхад нэг навсайсан ноорхой хувцастай, бараан царайтай хүн намайг дагаад байх шиг санагдсан. Тэгээд ачаа бараагаа авахаар эцгийнхээрээ иртэл нэг захиа байсан нь гэнэт нэг ажил гарч, Лондонд хэд хоног саатахад хүрлээ. Алмазыг банканд буцааж хадгалуулахаар өгөх үед нөгөө ноорхой хувцастай этгээд ба л явж байх шиг санагдсан. Өнөө өглөө алмазыг банкнаас авахад нөгөө ноорхой дахиад үзэгдлээ. Тэгэхээр нь би зам буруулж, мөрөөр орохоос нь өрсөн, оройн галт тэргээр гарахын оронд өглөөнийхөөр гарчихлаа. Алмазаа аваад энд эсэн мэнд иртэл юу сонсов оо? Гурван хэрмэл энэтхэг ирж, хөндлөнгийн хүн ойр хавьд нь байхгүй хэмээн итгээд намайг Лондонгоос ирэх нь үү, авчрах юм нь биед нь яваа эсэх онцгой чухал хоёр зүйлийг тодруулсан байна. Алсад яваа хүн, мөн халаасанд нь байгаа зүйлийг харуулах гэж хөвгүүний алган дээр бэх асгасан тухай ярьж цаг үрэхээ больё. Дорно зүгийн орнуудад олонтаа харж явсан энэ явдлыг би жирийн нэг илбэ гэж таны адил үзэж байгаа юм. Одоо та бид хоёр жирийн нэг явдлыг өсгөж дэгсдүүлээд байна уу, эсвэл саран чулууг банкнаас авсан тэр мөчөөс эхлэн энэтхэгчүүд үнэхээр халуун мөрөөр нь орчихов уу гэдэг асуудлыг шийдвэрлэх ёстой.

Гэтэл бидний хэн маань ч үүнийг шийдвэрлэж дөнгөхгүй бололтой. Бид хоёр өөд өөдөөсөө харснаа Нуранги элсийг зугуухан нөмөрсөөр дөхөн айсуу далайн түрлэгийг харцгаав.

□ Та одоо юу бодож байна? гэж мистер Фрэнклин гэнэт асуув.

□ Эрхэм ээ, тэр алмазыг энэ элс рүү хаячихвал асуудлыг нэг тийш болгож гэж бодож байна.

□ Тэр чулууны үнэтэй тэнцэх бэлэн мөнгө халаасандаа авч яваа бол ингэж хэлээрэй Бэттереж гуай, тэгвэл би шидчихье!

Сэтгэлийн тав алдсан үед өчүүхэн хошигнол ч хүний дотрыг тэгтлээ уужруулдаг нь үнэхээр сонин. Мисс Рэчелийн хууль ёсны өмчийг үгүй хийж, бас гэрээслэл гүйцэтгэгчийнх нь хувьд Фрэнклин Блэйкийг өгүүлшгүй бэрхшээлд учруулна гэхээс, хэдийгээр юунд тийм хөгийн санагдсангүй одоо хэр нь ойлгохгүй боловч бид хоёрт учиргүй инээдэмтэй санагдаж билээ.

Фрэнклин эхлээд сэхээ авч нөгөө яриандаа буцаж орлоо. Халааснаасаа дугтуй гарган задалж, дотроос нь нэг цаас аваад надад сарвайнгаа,

□ Бэттереж гуай, хурандаа ямар учраас зээ охиндоо ийм зүйл өвлөн үлдээснийг бид нагац эгчийн тусын тулд мэдэх ёстой. Хурандааг Англид ирсэн өдрөөс эхлэн зээгийнхээ төрсөн өдрийг мартахгүй гэж танд хэлсэн тэр өдрийг хүртэл Вериндер ахай ахтайгаа ямаршуу харьцаж байсныг саначих. Май, үүнийг унш гээд хурандаагийн гэрээслэлийн хуулбарыг өгөв.

Тэр нь одоо ч надад байгаа бөгөөд уншигч танд толилуулъя.

↔... Гуравдугаарт буюу эцэст нь хэлэхэд, намайг нас нөгчсөний хойно мисс Рэчелийн төрсөн өдрөөр эх нь болох Вериндер ахай сэрүүн тунгалаг байвал, Дорно дахинаа Саран чулуу хэмээн алдаршсан алмазыг өөрийн дүү бэлбэсэн хатагтай Жулиа Вериндерийн ганц хүүхэд, миний зээ охин мисс Рэчелд гэрээслэн үлдээж байна. Тэгэхдээ тэр өдөр түүний эх, дээр дурдсан Жулиа Вериндер ахай амьд сэрүүн байх тохиолдолд л энэ л заалт хүчинтэй юм. Миний гэрээслэл гүйцэтгэгч өөрийн биеэр буюу итгэмжилсэн хүнээрээ намайг нас эцэслэсний дараа миний зээ мисс Рэчелийн төрсөн өдрийн ойгоор, бололцоотой бол миний дүү Жулиа Вериндерийн дэргэд алмазыг гардуулахыг хүсэж байна. Амьд ахуйд минь нэр хүндэд минь ихээхэн хөнөөл учруулсан зохисгүй зан авир гаргасныг нь уучилж, ялангуяа охиныхоо төрсөн өдөр зарцдаа тушааж намайг гэрийнхээ босго алхуулалгүй, цэргийн дарга, эр хүний минь хувьд доромжилсон нүглийг нь амьсгал хураахын өмнө бүрмөсөн уучлан хэлтрүүлэж байгаагаа үзүүлэн охинд нь алмаз эрдэнээ бэлэг болгож байгаа гэрээслэлийн минь сүүлчийн хэсгийн үнэн хуулбарыг миний дүүд мэдэгдэхийг хүсэж байна.

Тэгээд цааш нь гэрээслэлийг гүйцэтгэх үеэр манай ахайтан мисс Рэчел хоёрын аль нэг нь нас барсан байх юм бол алмазыг битүүмжилсэн зааврын дагуу Голланд руу явуулах хэрэгтэй. Дараа нь алмаз борлуулаад олсон мөнгийг нөгөө умард нутгийн их сургуульд хувилахуй ухааны тэнхим

байгуулах хэрэгтэй нэгэнт гэрээслэн үлдээсэн мөнгөн дээр нэмж, тийш нь хүргүүл ≈ гэсэн заалт байлаа.

Би мистер Фрэнклинд бичгийг нь буцааж өгөхдөө хэлэх үгээ ч ойлгохгүй бүр мэгдэж орхив. Хурандааг амьдарч байсан шигээ өөдгүй хэвээр нас нөгчжээ гэж би бодож явсан бөгөөд түүний гэрээслэлийн хуулбар ч энэ бодлоос ангижруулсан нь үгүй. Харин ч баахан эргэлзээ төрүүлсэн юм.

□ За, та хурандаагийн гэрээслэлийг уншчихлаа, одоо юу хэлмээр байна аа? Саранчулууг нагац эгчийндээ авчирснаараа би санаандгүй байтлаа өс хонзонгийн зэвсэг болж байна уу, эсвэл жинхэнэ Христос сүсэгтний нүгэлээ наманчилсныг нотолж байна уу? гэж Фрэнклин Блэйк асуулаа.

□ Хурандааг жигшүүртэй хонзон өвөрлөж, ичгүүргүй худал хэлсээр нас нөгцсөн гэж хэлэхэд хэцүү л байна, эрхэм ээ. Бурхан тэнгэр л мэдэж байгаа би, надаас асуусны хэрэггүй гэж би хариулав.

Фрэнклин гэрээслэлийн хуулбарыг гартаа эргүүлж тойруулах нь базаж мушгиж байгаад үнэнийг гаргах гэсэн мэт. Тэгэхийн хамт гайхмаар хувирч, гялалзсан цовоо залуу байснаа одоо буурьтай, дөлгөөн, бодлогоширсон хүн боллоо.

□ Уг асуудал бодит, хийсвэр хоёр талтай юм. Хаанаас нь эхэлбэл зохих вэ?

Манай залуу эрхэм франц төдийгүй бас герман боловсролтой болсон билээ. Өдий хүртэл миний бодлоор бол франц хүмүүжил нь давамгайлж байснаа одоо герман хүмүүжил нь илэрч байх шиг санагдав. Ойлгоогүй зүйлээ хайхрахгүй орхих явдал бол миний баримталдаг нэг зарчим билээ. Би ч асуудлын бодит, хийсвэр талын дунджийг сонгож авлаа. Шуудхан хэлэхэд, би мистер Фрэнклинийг бүлтийтэл ширтээд юу ч эс хэлэв.

□ За, энэ бүгдийн далд санааг мэдь. Манай нагац ах Саран чулууг яагаад Рэчелд үлдээх болов? Яагаад нагац эгчид үлдээгээгүй юм бэ? гэж Фрэнклин өгүүлсэнд,

□ Доор хаяад тааж ядах юм алга, эрхэм ээ. Хурандаагаас манай хатагтай аливаа нэг хөрөнгө өвлөн авахаас татгалзана гэдгийг хурандаа Хэрнкастль мэдэж байсан биз гэж би хэллээ.

□ Рэчел татгалзахгүй гэдгийг яаж мэдсэн юм бол?

□ Эрхэм минь, төрсөн өдрөөрөө Саран чулуу шиг ийм үнэтэй бэлэг авахаас татгалзах залуу бүсгүй байдаг юм гэж үү?

□ Энэ бол асуудлын хийсвэр тал юм. Бэттереж гуай, та юмыг хийсвэр талаас нь дүгнэж чаддаг их завшаантай хэрэг. Хурандаагийн гэрээслэлд хараахан тайлагдаагүй бас нэг нууц байна. Рэчелийн төрсөн өдрийн бэлгийг зөвхөн эхийг нь амьд байх тохиолдолд гардуулна гэснийг ямар учиртай гэж үзэх вэ? Гэж мистер Фрэнклин өгүүлэв.

□ Би талийгаачийн ясыг өндөлзүүлье гэсэн юм биш. Гэвч хүүхдээр нь дамжуулан дүүдээ гай уршиг учруулъя гэсэн зорилгоор өв үлдээсэн юм бол тэрхүү зовлон зүдгүүрийг нь амсахын тулд дүү нь амьд байх шаардлагатай байна л даа.

□ Пэ! Та хурандаагийн санааг ийм гэж үзэж байна уу? Дахиад л хийсвэр талаас нь тайлбарлалаа! Бэттереж гуай, та ер нь Германд очиж байсан уу?

Үгүй, эрхэм ээ. Харин таны юу гэж үзэж байгааг мэдэж болох уу?

Хурандаа бараагийг нь ч хараагүй зээ охиныхоо тусын тулд бус,

харин амьсгал хураахынхаа өмнө дүүгээ уучилснаа их л эелдгээр баталж түүнээ охинд нь үлдээсэн бэлгээрээ харуулсан байж тун болзолшгүй юм. Бэттереж гуай, энэ бол таны тайлбараас тэс өөр бөгөөд асуудлыг бодит талаас нь авч үзсэн хэрэг. Тэгэхээр нэг тайлбар нөгөөгийнхөө адил үнэн зөв байж магадгүйеэ.

**Мистер Фрэнклин байдлыг тийнхүү нааштай, амарлингуй дүгнэхчээд**

өөрийн зүгээс шаардлагатай бүхнийг хийлээ гэж бодов бололтой. Элсэн дээр гэдрэг харан хэвтээд, цаашид хэрхвэл зохихыг надаас асуулаа.

Гадаадын элдэв утгагүй үг хэрэглэхээсээ өмнө тун ухаалаг, холын хараатай байж, ийм хэрэгт намайг дагуулахгүй байснаа даанч санаанд оромгүй түргэн хувирч, одоо бүр шалдаа буугаад надаас өмөг түшиг эрэх нь энэ. Тийнхүү хачин хувирч өөрчлөгддөг нь гадаадад олсон хүмүүжлийнх нь уршиг болохыг үүний нь анх олж мэдсэн мисс Рэчелийн тусламжтайгаар хожим мэдсэн юм. Та бид цөмөөрөө л өөрийн өнгө ялгааг бусад хүний өнгө ялгааны тусгал мэтээр хүлээж авдаг насан дээр нь мистер Фрэнклинийг хилийн чанадад явуулсан бөгөөд нэг өнгө баттай тогтож амжаагүй байхад нөгөө улс гүрэнд очдог байжээ. Үүний улмаас сэтгэлийн байнгын зовууртай амьдарч ирсэн мэт их, бага хэмжээгээр хоорондоо эрс тэс олон янзын зан араншинтай болжээ. Фрэнклин ажилсаг, атлаа залхуу дүйнгэ мөртлөө ухаалаг, шийдэмгий байтлаа арчаагүй байж нэгэн зэрэг чадна. Франц, итали, герман зан холилдсон агаад төрөлхийн англи зан нь үе үе цухалзах нь ↔Хөөрхийлөлтэй өөрчлөгдсөн боловч надад миний гэсэн юм үлдсэн юм шүү≈ гэж өгүүлэх мэт. Түүний гэнэт буун өгч, өөрийнхөө үүрэг хариуцлагыг танд тохье гэж эелдэг наалинхай зангаараа гуйх үед нь итали авир нь давамгайлдаг юм

хэмээн мисс Рэчел ярьдагсан. Тэгэхээр одоо манай залуу эрхмийн итали авир дийлчихээд байна гэж үзвэл та эндүүрэхгүй болов уу.

Цаашид юу хийхээ шийдэх нь таны хэрэг бус уу, эрхэм ээ? Миний ажил биш нь мэдээж гэж би асуулаа.

Мистер Фрэнклин дээр нь мэлтийх тэнгэрээс өөрийг үзэх боломжгүй гэдрэг харан хэвтэх тул миний үгийн хүчийг анзаараагүй боллолтой.

□ Би нагац эгчийгээ учир шалтгаангүй айлгая гэж хүсэхгүй байна. Гэхдээ сонор сэрэмжтэй байвал илүүдэхгүй гэж бодож байна. Бэттереж гуай, та миний оронд байсан бол яах байснаа ганцхан үгээр хэлээд орхиоч.

Хүлээнэ гэж би ганц үгээр хариулав.

Бүрэн зөвшөөрч байна. Хэр удаан хүлээх бол? Би ч санаж бодсоноо тайлбарлаж эхэллээ.

□ Эрхэм ээ, миний ойлгосноор бол, энэ балагтай алмазыг мисс Рэчелд төрсөн өдрөөр нь хэн нэгэн хүн заавал гардуулжогөх ёстой бөгөөд та эл үүргийг хэнээс ч дутахгүй гүйцэтгэж чадна. Маш сайн. Өнөөдөр тавдугаар сарын хорин таван, мисс Рэчелийн төрсөн өдөр зургадугаар сарын хорин нэгэнд болно. Тэгэхээр бидний мэдэлд дөрвөн долоо хоног байна. Энэ хугацаанд юу болохыг хүлээж, харзная. Ахайтанд анхааруулах эсэхийг нөхцөл байдал хэлээд өгнө.

□ Ёстой доги, Бэттереж гуай! Гэвч төрсөн өдөр хүртэл энэ алмазыг хэрхэх билээ?

□ Эрхэм ээ, таны эцгийн жишээг дагая! Эцэг тань алмазыг Лондонгийн банканд хадгалуулсан. Та харин Фризинхоллын банканд өгч хадгалуулагчдын (Фризинхолл манайд хамгийн ойрын хот бөгөөд Английн банк ч түүнээс найдвартай байж чадахгүй буй заа). Хэрэв би таны оронд байсан бол ахайтан нарыг эргэж ирэхээс өмнө шууд Фризинхолл руу давхих байсан даа.

Хийж хөдлөх юмтай болсондоо, тэр тусмаа мориор давхих болсонд Фрэнклин Блэйк ухасхийн өндийж, намайг ёсорхолгүйгээр угз татан босгоод,

□ Бэттереж гуай, та ёстой алт шиг хүн юм. Явья, жүчээнээс морины сайныг барьж даруй эмээллэгтүн! гэв.

Эцсийн эцэст, Тэнгэрийн ивээлээр мистер Фрэнклиний бүхий л гадаад өнгөний цаанаас жинхэнэ англи зан нь тодордог байна шүү! Ингэхэд нь морь унахдаа баясан сэргэдэг урьдын Фрэнклин санагдаж өнгөрсөн сайхан цагийг эргэн дурсаж билээ! Мистер Фрэнклинд морь эмээллэж өгнө гэнэ ээ? Бүгдийг нэг зэрэг унаж чаддагсан бол би арван хоёрыг эмээллэхээс төвөгшөөхгүй сэн!

Бид хоёр гэдрэг сандран буцаж, морины сайныг яаран эмээллэж мистер Фрэнклин балагт алмазыг банкны бат бэх саванд даатган өгөхөөр довтолгон одов. Мистер Фрэнклиний унасан морины төвөргөөн холдон замхраад, миний бие хашаандаа ганцаар хоцорсон хойно зүүдлээд сэрэв үү гэж бодохоор байлаа.

## VII бүлэг

Миний бие тийнхүү гайхаж мунгинаад, ухаан санаагаа цэгцлэхийн тулд түр ч болох ганцаархнаа байх хэрэгтэй байтал, миний охин Пенилоп, талийгаач эх нь шатан дээр тээглэдэг байсан шиг садаа болж, мистер Фрэнклин бид хоёр чухам юу юу ярилцсаныг даруй шалгааж гарав. Тухай нөхцөлд Пенилопыг аргалж, сониуч занг нь л дарах чухал байсан учраас, Фрэнклин бид хоёр гадаад улсын төрийн бодлогын талаар шүүн хэлэлцсээр сүүлдээ халуун наранд таг унтацгаачихжээ гэж хариулав. Таны эхнэр юмуу, охин тохирмжгүй үед зохисгүй юм асууж, төвөг төвөг удвал иймэрхүү хариу өгөхийг бодоорой. Тэгэхээр бүсгүй хүний наалинхай аашаар таныг үнсчихээд хожим эвийг нь таарахаар шалгааж гарах вий.

Үд хэвийж, ахайтан, мисс Рэчел хоёр эргэж ирэв. Фрэнклин Блэйк ирчихээд буцаж давхисныг сонсоод тэд хэчнээн их гайхсаныг хэлэх юун. Шууд л элдэв зохисгүй асуултаар булсныг болон ↔гадаадын улс төрийн байдлын талаар ярилцсан≈, ↔халуун наранд унтчихсан≈ гээд тэднийг аргалж дөнгөхгүй байсаныг хэлээд илүүдэх биз ээ. Хлэх үг олдохгүй болохоор нь өглөөний галт тэргээр ирсэн нь мистер Фрэнклин этгээд зангийн нэг илрэл байх гэлээ. Буцаад давхисан нь ч бас нэг этгээд зан гаргасных уу гэж асуухад нь ↔Тийм, яг тийм≈ гэлээ. Ийнхүү тэдний асууж шадгаахаас тун овжин мултарч чадсан мэт санагдав.

Хатагтай нарыг аргалчихаад өрөөндөө ортол намайг яггүй хэцүү юм хүлээж байжээ. Пенилоп орж ирээд бүсгүй хүний наалинхай зангаар намайг дахин дахин үнсэж, мөн л бүсгүй хүний сониуч зангаар юм асуув. Харин удаад шивэгчин Розанна Спирман юу болсныг л зөвхөн яриач гэж гуйв.

Фрэнклин бид хоёрыг Нуранги элсэнд орхиод харихдаа Розанна Спирман тун ч ойлгомжгүй ааштай байсан гэнэ. Пенилопын үг үнэн бол, царай нь солонгын өнгөөр гийн гэрэлтэж байжээ. Ямар ч шалтгаангүй баярлаж, яагаа ч үгүй байхад гуньхарч байжээ. Фрэнклин Блэйкийн тухай нэг амьсгаагаар өчнөөн төчнөөн юм асууснаа, тэр үл таних эрхмийг сонирхоод байна гэж бодов уу хэмээн Пенилопт уурласан гэнэ. Мистер Фрэнклиний нэрийг ажлынхаа хайрцгийн дотор талд инээмсэглэн бичиж байхыг нь харцгаажээ. Мөн далиу мөрөө толинд харчихаад уйлж байхыг нь үзжээ. Урьд өмнө мистер Фрэнклин Розанна хоёр бие биеэ мэддэг байсан болов уу? Огт боломжгүй юм! Бие биеэнийхээ тухай юм дуулсан юм болов уу? Бас л боломжгүй юм! Розаннагийн учиргүй ширтэхэд нь мистер Фрэнклин хэрхэн үнэн голоосоо гайхаж байхыг би нүдээрээ харсан. Мистер Фрэнклиний тухай асуухдаа Розанна үнэн сэтгэлээсээ сонирхож байсныг Пенилоп хэлж чадах байв. Иймэрхүү ярианаас би ихэд залхан байтал охин маань, энэ насандаа ч сонсоогүй утгагүй тайлбар хэлж яриагаа дуусгав.

□ Аав аа! Энд ганцхан тайлбар байна. Розанна мистер Фрэнклинийг харангуутаа л дурлачихжээ! гэж Пенилоп тун нухацтай өгүүлж билээ.

Үзэсгэлэн гоо авхай нар л анхны харцаар хүнд сэтгэлтэй болсон тухай та сонссон бөгөөд үүнийг ч бүрэн боломжтой гэж зөвшөөрдөг биз ээ. Гэтэл засан хүмүүжүүлэх газраас ирсэн, царай зүс муутай, далиу мөртэй шивэгчин эзэгтэйд нь айлчлан ирсэн эрхмийг хараангуут л сэтгэлээ өгнө гэж ер байх уу даа?! Ийм тэнэг явдлыг аль нэг зохиолоос олоод та надад үзүүл л дээ! Би нулимсаа гоожтол хөхрөв. Пенилоп миний тийнхүү баясаж хөхөрсөнд яагаад ч юм уурсаж,

□ Аав аа, таныг ийм хэрцгий авирлаж байхыг би ер үзээгүй юм байна гэж их л эелдэг хэлчихээд гарч одов.

Охины маань үг нүүр өөд хүйтэн ус цацсантай адил сонсогдов. Пенилопын үгэнд барьц алдсандаа өөртөө зэвүүцэх боловч үнэндээ ч мэгдэж орхисон билээ. Таныг зөвшөөрвөл ярианыхаа сэдвийг өөрчилье. Ийм зүйл өгүүлж, элдвийг нуршсаныг минь уучилна уу. Гэвч бид жаахан цаашлахаар үүнийг учир шалтгаангүйгээр өгүүлээгүй юм гэдгийг уншигч та ойлгох болно.

Үдэш болж мистер Фрэнклинийг Фризинхоллоос ирэхэд хувцаслаж, хоолондоо орохыг мэдэгдсэн хонх хэдийнээ дуугарчихсан байлаа. Жигтэйхэн удаан саатаж ирсэн болохоор нь ямар нэгэн юм тохиолджээ. гэж бодоод явсан сонинг нь дуулгах санаатай халуун ус барьсаар өрөөнд нь оров. Гэтэл юу ч тохиолдоогүй гэсэнд хачин их урам хугарлаа (та ч бас ялгаагүй биз). Фризинхолл орох замдаа ч нааш буцахдаа ч нөгөө энэтхэг хүмүүстэй тааралдсангүй. Саран чулууг банкинд өгөхдөө лут үнэтэй эд гэдгийг нь л хэлээд баримт бичгийг халаасандаа хийж, эсэн мэнд авчирчээ. Би шатаар буухдаа өглөөжингөө алмазаас болж тэгтэл үймэрч сандарсны дараа дэндүү энгийн төгсгөл байна даа гэж бодож явлаа.

Фрэнклин нагац эгч, үеэл дүү хоёртойгоо хэрхэн уулзсаныг би хэлж чадахгүй.

Тэр өдөр ширээнд үйлчлэхийн тулд би их л юм өгөх байлаа. Гэвч миний зэрэгтэй хүн (гэр бүлийн том том найрыг эс тооцвол) ширээнд үйлчилбэл бусад зарц, шивэгчний нүдэнд нэр төрөө унагах бөгөө ахайтан намайг тэртээ тэргүй ийм хандлагатай гэж үздэг болохоор ямраар ч горьдох байсангүй. Тэр орой, Пенилоп болон бусад зарц, шивэгчнээс дээд ↔зиндааны≈ сонинг сонсож мэдлээ. Мисс Рэчел хувцас хунар, үс гэзгээ тэгж онцгой анхаарч байхыг нь урьд ер үзээгүй, мистер Фрэнклинтэй уулзахаар зургийн өрөө рүү бууж явсан шигээ тийм баярлаж гийсэн, сайхан царайтай байхыг нь огт хараагүй гэж Пенилоп ярив. Дээдсийн дэргэд тайван байдлаа хадгалах, Фрэнклин Блэйкт үйлчлэх хоёр бол даанч нийцэхгүй зүйл байлаа гэж зарц мэдэгдэв. Орой тийшээ хөгжимдөж, хоршин дуулах сонсогдов. Фрэнклин дээрээс авахад мисс Рэчел бүр ч дээрээс аван дуулах ба ахайтан төгөлдөр хуур дээр наадан тэр хоёрыг дагаж дуулахдаа, ан хөөцөлдөн хашаа гуу жалга дээгүүр харайх шиг бэрхшээлтэй үед нь эвтэйхэн дэмнэж туслах бөгөөд шөнө дэвсэг дээрээс тэдний дуу онгорхой цонхоор аятайхан сонсогдох ажээ. Нэлээд орой би мистер Фрэнклинд өгөхөөр соодтой ус, дарс авч тамхины өрөөнд орохдоо Рэчел түүний толгойноос алмазны тухай бодлыг арчиж хаясныг ойлгосон юм.

Би Фрэнклинийг арай ноцтой ярианд оруулах гэж чармайсан боловч,

□ Рэчел бол миний бие Англид буцаж ирснээсээ хойш үзсэн хамгийн дур булаам сайхан бүсгүй! Гэхээс өөр үг сонсож чадсангүй.

Шөнө дундын үес би заншлаараа үүд хаалга түгжихээр Сэмуэл хэмээх туслах зарцаа дагуулан байшингаа тойров. Зам руу гардаг хажуугийн хаалгаас бусад бүх үүд хаалгыг түгжиж, Сэмуэлийг унт гэж явуулчихаад, би цэвэр агаар амьсгалсугай хэмээн гадагш гарлаа.

Тэргэл сар мэлтийсэн дулаахан бүгчим шөнө байв. Тэнгисийн давалгаа манай багахан тохойн амны элсэн эргийг дуулах төдий цохилох нь үе үе сонсогдсон нам гүм ажээ. Дэвсэг байшингийн сүүдэр талд байх боловч дэвсгийн нөгөө зах хүртэл хана дагуу зурагтай элсэн жимийг сарны туяа

тодхон гэрэлтүүлнэ. Эхлээд би тэнгэр өөд харж байснаа жим рүү хартал байшин тойрон гарч ирэх нг хүний сүүдэр үзэгдэв.

Олон оймс элээж, хашир суусан хүн болохоороо би түүнийг дуудсангүй гэвч хөгширч, алхаа хүндэрсний харгайгаар хөл доор элс шажигнан намайг мэдэгдчихэв. Би сэмхэн булан тойрч очье гэтэл надаас хөнгөн алхаатай хэдэн хүний яаран одох чимээ дуулав. Намайг булан тойрох үеэр зугтаагчид замын хажуугийн бут сөөг рүү гүйлдэн хүрээд цэцэрлэгийн өтгөн мод, бутанд нуугджээ. Тэгээд цааш явж манай хашааг даваад зам дээр гарч, эсэн мэнд арилахаас амаргүй юмгүй. Би дөчин насаар залуу байсан бол тэднийг цэцэрлэгээс гарахаас нь өмнө бариад авчих горьдлоготой байхсан. Харин одоо залуу чийрэг, хөлтэй хүн илгээх санаатай гэртээ орлоо. Хэнийг ч үймүүлж сандраагүй, Сэмуэлийг дагуулан нэг нэг буу барьсаар гарч байшингаа тойрч, бут сөөгийг нэгжлээ. Манай эзэмшилд гаднын хүн орогноогүй болохыг лавтай мэдээд бид хоёр буцаж, хүний сүүдэр зэрвэс харагдсан нөгөө жимээр явж байтал сарны гэрэлд гялалзах нэгэн бяцхан зүйл элсэн дээр хэвтэхийг олж үзлээ. Түүнийг авч харвал анхилуун үнэртэй, бэх шиг өтгөн хар зүйл агуулсан жижиг лонх байв. Би Сэмуэл д юу ч хэлсэнгүй. Харин илбэчдийн тухай, тэд нэг хөвгүүний алган дээр жаахан бэх асгаж байсан тухай Пенилопын ярьсныг санаж, энэ шөнө алмаз хаана байгааг тэрсүүд аргаараа мэдэх санаатай манай байшинг тандан эргэлдэж байхад нь би тэр гурван энэтхэгийг үргээжээ гэсэн сэжиг даруй төрсөн билээ.

## VIII бүлэг

Энд түр саатах хэрэгтэй байна.

Миний дурсамж болон Пенилопын тэмдэглэлийн дэвтрээс үзэхэд Фрэнклин Блэйкийн ирсэн өдрөөс мисс Рэчелийн төрсөн өдрийг хүртэлх хугацааг орхиж болно гэж бодож байна. Ихэнх өдрүүд нь онц юмгүй өнгөрсөн юм. Хожим манай гэрийнхнийг бүгдийг хамарсан, хөл үймээн дэгдээсэн Саран чулууны хэргийг өдөр өдрөөр нь нарийвчлан тоочно гээд одоогоор Пенилопын тусламжтайгаар хэдхэн явдлыг энд дурдахыг зөвшөөрнө үү.

Ингэхээр одоо шөнө зам дээрээс олсон анхилуун үнэрт бэхтэй лонхноос эхлэх нь зүйтэй.

Маргааш өглөө нь буюу хорин зугаанд би тэр илбэ жатгын хэрэгслийг мистер Фрэнклин үзүүлж, дээр нэгэнт өгүүлсэн таамаглалаа хэлэв. Фрэнклиний бодлоор бол тэр энэтхэгүүд алмазны хойноос мөшгөн хөөцөлдөж байгаа төдийгүй илбэ жатгадаа итгэдэг зэгсэн тэнэг улс ажээ. Жаал хүүгийн алган дээр бэх асгаад толгой дээгүүр нь хий дүрс тэмдэг зуран нүднээс далд буй хүн, юмсыг харуулна гэж итгэдэг ажээ. Дорно дахинд байдаг шиг энэ хачин илбийг гэхдээ бэхгүйгээр үйлддэг хүмүүс манай оронд ч бий, тэднийг ↔зөн билэгтэн≈ гэсэн маягийн утгатай франц үгээр нэрлэдэг □ Биднийг алмазаа энд хадгаллаа гэж итгэсэн учраас хэрэв урьд шөнө байшинд нэвтэрч чадвал зам заалгах гэж далдыг хардаг хөвгүүнийг дагуулж ирсэн нь лавтай гэж Фрэнклин өгүүлэв.

□ Тэднийг дахиад оролдоно гэж та бодож байна уу, эрхэм ээ? Гэж би асуулаа.

□ Тэр хөвгүүн үнэхээр юу хийж чаддагаас л шалтгаална. Хэрэв Фризинхоллын банкны төмөр шүүгээг нэвтлэн очир алмазыг харж чаддаг юм бол нөгөө гурван энэтхэг цаг нь болохоос нааш биднийг дахиж үймүүлэхгүй. Хэрэв харж чадахгүй бол нэг их олон хонолгүй тэднийг бутанд байхад нь дахин харах хэрэг гарах вий.

Би ийм хэрэг гарна хэмээн үнэхээр итгэж байтал гайхалтай нь тийм юм огт тохиолдохгүй.

Илбэчид хотод очоод мистер Фрэнклин банкинд орж байхыг хүнээс дуулж мэдсэн, эсвэл нөгөө хөвгүүн алмазыг үнэхээр харж, одоо алмаз чухал хаана байгааг мэдсэн (үүнд би ер итгэхгүй байна), үгүй бол зүгээр л учир байдал давхацсан биз. Ямар боловч мисс Рэчелийн төрсөн өдөр хүртэл хэдэн долоо хоног өнгөрөхөд энэтхэг хүмүүсийн бараа сүүдэр үзэгдээгүй билээ. Илбэчид илбэ жатгаа үзүүлэн хотод юмуу, хот орчимд үлджээ. Мистер Фрэнклин бид хоёр цаашид юу болохыг хүлээж, луйварчдад хэтэрхий эрт хар авахуулчихалгүй байя гэж тогтлоо. Ийнхүү хоёр тал хэрхэн шийдсэнийг дурдаад, одоохондоо гурван энэтхэг эрийн талаар миний хэлэх зүйл ч дууслаа.

Хорин есний өдөр мисс Рэчел мистер Фрэнклин хоёр өнгөрч өгөхгүй байсан цагийг нөгцөөх шинэ арга сэджээ. Тэдний хөөрч хөгжилдөн хийж байсан зүйлийг онцлон тэмдэглэх шалтгаан бий юм. Хожмын явдалд холбоотой болохыг та үзнэ.

Ер нь, дээдэс язгууртнуудын амьдралд тун ч ёозгүй бул хар чулуу буюу юмгүй дэмий сууна гэгч айхавтар бэрхшээл байдаг юм. Тэд ихэнх амьдралаа ямар нэг хийх юм хайж өнгөрөөх ба ялангуяа, оюуны хөдөлмөр гэгчийг шохоорохн дурлах үедээ ой гутам зүйл рүү хэрхэн сохор мухраар дайрахыг нь харахад сонин байдаг юм. Арван тохиолдлын есөд нь тэд ямар нэг амьтныг тамалж, эсвэл нэгийг эвдэж сүйтгэдэг бөгөөд ингэхдээ ухаан санаагаа хөгжүүлж байна хэмээн итгэцгээх боловч үнэндээ

гэр орондоо л хөл үймээн үүсгэхээс цаашгүй билээ. Харамсалтай нь хатагтай нар ч эрчүүдийн нэгэн адил, өдөр бүр эмний хоосон шил авч гараад гүрвэл, цох, аалз, мэлхий барьж хийгээд гэртээ харьж, тэр золгүй амьтдыг сүлбээр зүүгээр нэвт хатгах буюу эсвэл хумсын чинээ ч өрөвдөх сэтгэлгүйгээр жижиг жижиг хэрчиж байхыг нь би олонтой харсан. Танай залуу эзэн юмуу залуу авхай барьж ирсэн аалзныхаа гэдэс дотрыг томруулагч шилээр тун анхааралтай ажиглаж байхыг та харах буюу эсвэл толгойгүй болсон мэлхийшатан дээгүүр үсэрч явахтай тааралдах ба энэ хэрцгий балмад явдал ямар учиртайг гайхан асуувал, танай залуу эзэн юмуу, залуу авхай байгалийн шинжлэл сонирхож байгаа юм гэсэн хариу сонсох вий. Заримдаа бас дээр дурдсан багаж зэвсгээ ашиглан цэцэг юунаас бүтсэнийг нь мэдэх гэсэн тэнэг сониуч зандаа хөтлөгдөн үзэсгэлэнт сайхан цэцэгсийг гэмтээн хэдэн цагаар суухыг нь харж болно. Чухам юунаас бүтсэнийг нь мэдлээ гээд цэцэг улам үзэсгэлэнтэй, улам анхилуун болно гэж үү? Гэвч хөөрхийсүүд цаг нөгцөөх хэрэгтэй гэдгийг та ойлгоно биз. Та хүүхэд байхдаа шавар шороонд хутгалдаж, үймээн шуугиан дэгдээж явснаа өсөж том болоод шинжлэх ухаан оромдоглож, аалз тамлан, цэцэг сүйдэлж эхэлнэ. Аль алиных нь нууц бол та хоосон толгойдоо бодох юм үгүй, болхи гараараа хийх зүйл юу ч үгүйд л байгаа юм. Мөн зотон даавуу сүйдлэн будаг нялж, байшингаар нэг будаг ханхлуулна, эсвэл бохир устай шилэн саванд шанаган хорхой дүүргэн гэрт байгаа улсын бөөлжсийг хүргэх юмуу, энд тэндгүй, ер газар сайгүй чулуу хагалж бутлан хэлтэрхий нь хамаг хоол хүнсэнд хутгалдан холилдсон байх ба үгүй бол гэрэл зураг оролдож байгаа нь энэ гэж гар хуруугаа завааруулж, гэрийнхнийхээ царай зүсийг элдэв янзаар гажуудуулсан зураг гаргана. Энэ бүхэн мөн л бүтэлгүй төгсөх бөлгөө. Мөр бүтэн хувцас, толгой хоргодох байр гол зогсоох хоол олж, амь зуулгатайгаа залгахын тулд хөдөлмөрлөх ёстой байдаг хүмүүс нэлээд хүнд амьдралтай гэдэг нь эргэлзээгүй юм. Гэвч та хамгийн хэцүү ажилтай байсан өдрөө, ажилгүй дэмий сууж арга ядахдаа цэцэг сүйдэж, аалзны гэдэс дотор гаргахтай зэрэгцүүлээд үзээрэй л дээ. Тэгвэл толгойдоо бодож санах юмтай, гараараа хийх ажилтай азтай одонд төрсөндөө баярлах буй заа.

Мистер Фрэнклин, мисс Рэчел хоёрын тухайд гэвэл, тэд ямар ч амьтан ургамал тамлаагүй гэдгийг би баяртайяа хэлэх байна. Тэд жаахан үймээн дэгдээснээс илүү хэрэг тарьсангүй. Шударгаар өгүүлэхэд, ганцхан хаалга л эрээчиж сараачсан юм.

Мистер Фрэнклин юм бүхнээр өнгөц оролддог олон талын суу ухаанд ↔чимэглэлийн зураг≈ гэгч ордог ажээ. Фрэнклин будаг найруулах шинэ маягийн шигэлэгчийг нээж олсон гэж бидэнд мэдэгдэв. Чухам юугаар хийснийг минь бүү мэд харин ямаршуу юм байсныг ↔өмхий шингэн≈ гэсэн хоёрхон үгээр илэрхийлэхэд л хангалттай юм. Рэчел шинэ ажлаа эхлэхсэн хэмээн тэсэж ядан байсан ба Фрэнклин шинэ бодисоо найруулахад хэрэглэх зүйлс авчруулахаар Лондон руу хүн явуулав. Тэднийгээ хольж найруулсны эцэст өрөөгөөр нь орсон нохой хүртэл найтаахаар юм болгожээ. Мисс Рэчел хормогц зүүлгээд, английн ↔boudoir≈ гэдэг үгээс өөр сайн оносон нэргүй бяцхан өрөөг нь чимэглэх ажилд оруулжээ. Манай хоёр залуу хаалганы дотор талаас чимэглэлийн ажлаа эхлэв. Фрэнклин хаалганы сайхан чийг уушгин чулуугаар хусаж арилгаад, өөрийнх нь хэлснээр ажлын гадаргуу гэгчээр бэлтгэв. Дараа нь Рэчел тэр гадаргууг хээ угалз хангарди, цэцэг, шувуу, янагийн тэнгэр зэрэг янз бүрийн дүрсээр дүүргэжээ. Тэр бүхнийг (би нэрийг нь санахгүй банья) өчнөөн төчнөөн эх дагина зурсан бөгөөд талхчин бүсгүйд сэтгэлээ өгч байсан италийн алдарт зураачийн бүтээлээс хуулжээ. Эл чимэглэл нь их цаг идсэн, тун ч бохир ажил байсан хэдий боловч манай авхай, залуу эрхэм хоёр ядарч, залхсан шинж ер үгүй байв. Тэд мориор зугаалж, зочид хүлээж авч эсвэл хоолонд орж дуу дуулахаасаа бусад үедээ ажилсаг зөгийнүүд шиг толгой нийлүүлэн нөгөө хаалгаа завааруулах бөлгөө. Шуламс, хийх юмгүй хүнд хүртэл хорлон сүйтгэх юм олж өгдөг хэмээсэн яруу найрагч хэнсэн билээ? Энэ айлд миний оронд тэр яруу найрагч байгаад бийр барьсан мистер Фрэнклинийг харсансан бол түүнээс илүү үнэмшилтэй бичиж чадахгүй буй заа.

Дурдвал зохих бас нэг өдөр бол зургадугаар сарын ням гариг байлаа.

Хожмын явдалд хаалганы чимэглэлийн нэгэн адил нөлөөлсөн гэр орны нэг асуудлыг тэр орой бид зарц нарын өрөөнд анх удаагаа ярилцсан юм.

Мистер Фрэнклин мисс Рэчел хоёр хамт байхдаа тун дуртайг хараад мөн аль талаараа өхөөрдөм хос болж чадахыг ажиглаад хаалга чимэглэхээс өөр бусад зүйлд ч санаа нийлнэ хэмээн бид нэлээд ортой тааварлан хэлэлцэв. Зарим нь намраас өмнө энд хурим болох вий гэлцэнэ. Бусад нь (миний бие тэргүүлэн) Рэчел хадамд гарах нь гэдгийг зөвшөөрөх боловч одоо дурдах шалтгааны улмаас гэрлэх хархүү нь Фрэнклин Блэйк байна гэдэгт эргэлзэж байв.

Фрэнклин хайр сэтгэлд автагдсаныг түүнийг харж, яриаг нь сонссон хүн ер эргэлзэхгүй. Харин мисс Рэчелийг ойлгоход л хамаг бэрхшээл оршиж байгаа юм. Таныг мисс Рэчелтэй танилцуулахыг зөвшөөрнө үү. Дараа нь, хэрэв чадвал түүнийг ойлгох гээд үзээрэй хэмээн танд даатгаж орхиё.

Манай залуу авхай энд өгүүлэн буй зугадугаар сарын хорин нэгэнд арван найм хүрч байгаа юм. Та бараан үстэй бүсгүйд дуртай бол (сүүлийн үед дээдсийн хүрээлэнгийн маягаас гарсан гэж би дуулсан), бас нуруу турууны талаар тийм ийм байвал сайхан гэсэн баттай бодол танд үгүй бол хэлэх

байна. Мисс Рэчел бол толгойноосоо хөлөө хүртэл тун сайхан зохицсон жижигхэн гунхсан гоолиг биетэй билээ. Түүний сууж, зогсож байгааг ялангуяа алхаж гишгэхийг харсан ямар ч эрүүл ухаантай хүн, хувцасны ачаар биш, харин бие цогцос нь өөрөө (ийм үг хэрэглэхэд та дургүйцэхгүй бол) хэчнээн гоолиг болохыг үзэж бахдан шагших биз. Тийм хар үс би ер үзээгүй, нүд нь үснээсээ дутахгүй хар өнгөтэй. Хамар нь томгүй гэдгийг хэлэх хэрэгтэй. Ам, эрүү нь (Фрэнклиний үгийг иш татвал) ёстой л тэнгэр бурхдынх гэлтэй. Царай зүс нь нөгөө л маргашгүй том мэргэжилтний үгээр нар мэт гялбам бөгөөд харахад үргэлж сайхан байдгаараа нарнаас давуу чанартай билээ. Нэмж хэлбэл, сум шиг цэх шулуун, бардам зоримог, сурвалжит язгууртны дэгжин намба төрхтэй агаад цангинасан цээлхэн дуутай, инээхдээ эхлээд нүдээрээ тун хөөрхөн инээмсэглэдэг. Миний бие чадах хэрээрээ л мисс Рэчелийг дүрсэлбэл ийм байна!

Ямар зан араншинтай вэ? Энэ сэтгэл булаам бүсгүй ер дутагдалгүй гэж үү? Хатагтай минь, Рэчел илүү ч үгүй, дутуу ч үгүй, яг л таны нэгэн адил дутагдалтай билээ.

Тоглоомгүй хэлэхэд, өгүүлж барамгүй гоо үзэсгэлэнтэй, хонгорхон мисс Рэчел маань нэг дутагдалтай гэдгийг миний бат шударга зан хэлэх хэрэгтэй гэж шаардаж байна. Мисс Рэчел бол толгой даасан бодолтой, мөн хувцасны маяг сэтгэлд нь таарахгүй бол бүр этгээд хувцасладаг зэргээрээ үе тэнгийнхээ охидоос ялгаатай. Энэхүү бие даасан байдлыг нь жижиг сажиг зүйл дээр тэвчиж болохоор авч чухал зүйл дээр бүр дэнддэг билээ. (Ахайтан бид хоёрын санаа энэ талаар таардаг юм). Аливаа асуудлыг шийдэхдээ өөрөөсөө хоёр дахин ахмад хүний бууриар бодож шийднэ. Хүнээс зөвлөгөө ер авахгүй, юу хийх санаатайгаа ч цухуйлгахгүй, хэнд ч, эхдээ хүртэл нууцаа итгэж ярих нь үгүй. Их, бага аливаа зүйлд ч, хайрладаг болон жигшдэг хүмүүстээ ч хандахдаа ямагт өөрийн бодлоор харьцах ба баяр, гунигаа хэнтэй ч үл хуваалцана. ↔Рэчелийн шилмэл анд, заналт дайсан бол Рэчел өөрөө юм≈ гэж ахайтан олон удаа хэлж билээ.

Үүн дээр нэг зүйлийг нэмж өгүүлээд энэ тухай дуусгая. Мисс Рэчел битүүлэг дураараа зантай хэдий боловч худал хуурмаг зангийн сүүдэр ч үгүй хүн. Ам ажил нь зөрж байсан удаагүй. Дотроо зөвшөөрсөн атлаа ↔үгүй≈ хэмээн хэлж байхы нь би санахгүй байна. Багадаа энэ сайхан сэтгэлт охин хайртай найзынхаа өмнөөс нэг биш удаа буруу хүлээж, шийтгүүлж байж билээ. Хийсэн хэргий нь мэдчихээд асууж байцаавч ер үг алдаагүй байлаа. Гэвч хэнд ч, хэзээ ч худал хэлж байсангүй, харин таны нүдийг эгцлэн ширтэж, зөрүүд бяцхан толгойгоо сэгсэрч, ↔Би юу ч хэлэхгүй≈ хэмээн зүгээр л хэлдэгсэн. Ингэснийхээ төлөө дахиад шийтгүүлээд ↔Юу ч хэлэхгүй≈ гэсэн үгэндээ уучлал гуйх боловч зөвхөн талх, үс өгч шийтгэхийг ч үл харгалзан буруутныг илчилдэггүй байв. Дур зоргоороо, заримдаа айхавтар дур зоргоороо ашилдагийг нь би үгүйсгэхгүй. Гэвч ийм сайхан хүн энэ ертөнцөд байгаагүй бизээ. Та энд зөрчил байна гэж бодож магадгүй. Тийм бол таны чихэнд нэг үг хэлье. Та эхнэрээ хорин дөрвөн цагийн турш ажиглагтун. Хэрэв сайн хатагтай чинь энэ хугацаанд ямар ч зөрчил гаргахгүй бол бурхан таныг өршөө! Та жинхэнэ шуламтай суучихсан байна.

Би сая таныг мисс Рэчелтэй танилцууллаа. Үүнээс үүдэн энэ залуу авхай хадамд гарах талаар ямар бодолтой байдаг юм бол гэсэн асуулт гарна.

Зургадугаар сарын арван хоёронд манай эзэгтэй Лондонд байдаг нэг эрхмийг хүрэлцэн ирж, Рэчелийн төрсөн өдрийн баярт оролцоно уу хэмээн урилга явуулав. Энэ азтай эрд мисс Рэчел сэтгэлээ өгсөн байх гэж би итгэсэн юм! Тэр эрхэм бол мистер Фрэнклиний нэгэн адил Рэчелийн үеэл ах, нэрийг нь Годфри Эблвайт гэдэг билээ. Ахайтны бага эгч (бүү ай, би энэ удаа гэр бүлийн түүхэнд нэг их гүн орохгүй) дурлалд мэхлэгдэж цөхрөөд ямар ч байсан хадамд гарахын тулд ↔тэнцвэргүй≈ гэрлэжээ. Сурвалжит Каролина авхай, Фризинхоллын банкны эзэн Эблвайттай суух гэж зүтгэхэд нь гэрийнхэн нь бүгдээрээ их л балмагдаж билээ. Одоогоор сайшаалтай талыг нь өгүүлбэл, банкны эзэн бол маш баян, хүндтэй хүн байсан бөгөөд олон хүүхдийн эцэг болжээ. Доголтой тал нь гэвэл, энэ хүн дээгүүр байр суурь эзлэхийг их л мөрөөддөг билээ. Гэвч цаг хугацаа, орчин үеийн цэцэглэл, хөгжил дэвшил юм бүхнийг зохицуулж, тэнцвэргүй гэрлэлт тун сайн өнгөрчээ. Одоо бид бүгдээрээ эвлэрэнгүй (би таныг маажвал та намайг маажиж чаддаг байх) үзэлтэй болцгоосон ажээ. Та парламентад байдаг, байдаггүй нь, эсвэл та цэвэрлэгч ч юмуу, ван байлаа гээд надад ямар хамаатай билээ? Энэ бол одоо цагийн ойлголт. Би орчин үеийн ойлголтыг баримталж байна. Эблвайтнхан Фризинхоллоос холгүй газар сайхан цэцэрлэгтэй гоёмсог байшинд суудаг, хавь ойрдоо маш их хүндтэй эрхэмсэг айл байлаа. Эблвайтн хоёр дахь хүү, та зөвшөөрвөл, мисс Рэчелд хамаатай болохоор ихээхэн чухал байр эзлэх мистер Годфригээс бусдынх нь тухай олныг нуршиж таныг чилээхгүй.

Бүхий л гялалзсан, ухаалаг байдал, ерөнхий сайн чанаруудаараа мистер Фрэнклин манай залуу авхайн нүдэнд мистер Годфригээс давуу харагдаж арай л дөнгөхгүй болов уу гэж би бодно. Нэгдүгээрт, мистер Годфри бол мистер Фрэнклинийг бодвол нуруу туруу сайтай эр. Зургаан тохой илүү өндөр, улаа бутарсан сайхан цэвэрхэн цагаан царайтай, сахлаа гөлчийтөл нь хуссан, ар тийш хайхрамжгүй унасан урт шаргал үстэй ажээ. Гэвч би түүний гадаад байдлыг дүрслэх гэж ийн

оролдох юун? Хэрэв та хэзээ нэг цагт Лондон дахь эмэгтэйчүүдийг тэтгэх тусламжийн газрын гишүүн байсан бол мистер Годфрийг миний нэгэн адил сайн мэдэх учиртай. Годфри бол өмгөөлөгчийн мэргэжилтэй, эмэгтэйчүүдэд нялгануур бөгөөд өөрийн хүслээр энэрэнгүй, тусч хүн болсон билээ. Эмэгтэйчүүдийн буяны үйл, эмэгтэйчүүдийн гулланчлал мистер Годфригүйдээр юу ч хийж чаддаггүй байв. Төрөх гэж буй ядуу эмэгтэйчүүдэд туслах эхчүүдийн нийгэмлэг, ядуу эмэгтэйчүүдийг аврах Магадалины нийгэмлэг, ядуу эрэгтэйчүүдийг гаргуунд нь орхиод оронд нь ядуу эмэгтэйчүүдийг ажиллуулахын төлөө тэмцдэг зэгсэн шаргуу нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч, дарга. гишүүн нь байлаа. Эмэгтэйчүүдийн хороо зөвлөлгөөний ширээнд суухад мистер Годфри малгайгаа барин, доохонтой нь суугаад, хурлын явцыг хянан хонгор эмэгтэйчүүдийг ажил хэргийн бэрх замд залан удирдах бөлгөө. Тэр эрхэм бол Англи улс урьд хожид төрүүлсэн нигүүлсэгч энэрэн тэтгэгчдийн сор нь (бага зэрэг хөрөнгөтэй) мөн гэж би боддог юм. Өглөөний хурал цуглаан дээр таны нулимсыг барж, мөнгийг чинь шавхахдаа түүнтэй эн зэрэгцэх уран илтгэгчийг олоход бэрх бизээ. Годфри бол бүрэн төгс олон нийтийн зүтгэлтэн байв. Саяхан Лондонд байхдаа ахайтан маань намайг хоёр удаа баярлуулсан юм. Хүн бүхэн хөл алдаж байсан бүжигчин бүсгүйн тоглолтыг үзүүлэхээр театрт явуулсан ба бас нэг удаа мистер Годфрийн илтгэлийг сонсохоор Экстер-Холлд очуулсан юм. Бүжигчин бүсгүй найрал хөгжимтэй тоглож, харин илтгэгч эрхэм нусны алчуур, шилэн аягатай ус хэрэглэн үг хэлж билээ. Нүдээр харах, чихээр сонсох гэж аль алинд нь дүүрэн хүн чихээстэй байж билээ. Энэ бүхний зэрэгцээ мистер Годфри бол таны уулзаж, учирсан улсын дотроос хамгийн эелдэг, сайхан зантай, хээгүй хүн билээ. Годфри бүх хүнийг хайрладаг, хүмүүс ч түүнийг хайрладаг байв. Ийм хүнтэй жирийн байр суурь, хүч чадвартай мистер Фрэнклин мэт өрсөлдөөд юу олж долоох билээ?

Арван дөрвөний өдөр мистер Годфригээс хариу ирлээ.

Ахайтны урилгыг аваад, төрсөн өдрийн баярын үеэр лхагва гаригаас баасан гаригийн орой хүртэл зочилно. Эмэгтэйчүүдийн тэтгэмжийн хороонд хариуцсан үүрэг бий тул хотод буцаж очих хэрэгтэй болно гэжээ. Мөн захидалдаа үеэл дүүгийнхээ ↔мэндэлсэн өдөр≈ гэж хээнцэр нэрлэсэн шүлэг хавсаргасан байв.

Өдрийн цайн дээр Рэчел Фрэнклинтэй нийлээд тэр шүлгийг нь доог тохуу болгож байсан гэдгийг би олж мэдсэн юм. Үүнийг юу гэж үзэж байна гэж Фрэнклиний талд байдаг Пенилоп их л ялан дийлсэн байртай асуув.

□ Мисс Рэчел чамайг чулуу хөөлгөж байгаа юм, охин минь. Харин миний хамар тийм хялбар андуурахгүй шүү. Шүлгийн араас мистер Эблвайтыг өөрөө иртэл нь хүлээ гэж хэлэв.

□ Яруу найрагчийг шүлгийнхээ араас ирэхийн өмнө мистер Фрэнклин азаа туршиж л таарна даа гэж охин минь хариулав.

Энэ тухайд гэвэл мистер Фрэнклин мисс Рэчелд үнэхээр тал олох гэж хичээж байсныг зөвшөөрөх хэрэгтэй.

Фрэнклин жинхэнэ архаг тамхичин байсан боловч нэг удаа Рэчел түүний хувцсанд шингэсэн тамхины гашуун үнэр жигшмээр муухай байна гэж хэлсэн учир тамхиа хаясан билээ. Ийнхүү бие хайргүй зүтгэн тамхины тайвшруулах нөлөөнөөс хагацсаны дүнд нойр муутай хонож, өглөөний цайнд их л ядарсан уруу царайтай орж ирэх тул дахиад тамхиндаа орооч гэж Рэчел өөрөө гуйдаг боллоо. Гэтэл үгүй ээ! Дахиад Рэчелийн тух тавыг хормын төдийд ч алдуулах юмүйлдэхгүй, харин муу зуршилтайгаа шийдвэртэй тэмцэж, зориг тэвчээрийнхээ хүчээр эрт орой хэзээ боловч тамхи таталгүй унтаж сурна гэж сэтгэл шулууджээ. Ийм үнэнч байдал, өдөр бүр хаалга чимэглэх ажил дэм болж буй эл үнэнч сэтгэл Рэчелд зохих нөлөөгөө үзүүлсэн нь лав гэж (зарц нарын өрөөнд ярилцаж байгаа шиг) та хэлэх биз. Энэ бүхэн тун сайн боловч мисс Рэчелийн унтлагын өрөөнд мистер Годфрийн гэрэл зураг байдаг юм. Тэр зураг дээр мистер Годфри уран үгэндээ уяран царай нь гийсэн, нүдэнд нь таны халааснаас мөнгө салгах хамгийн сэтгэл татам төрх илэрсэн байх ажээ. Энэ тухай та юу хэлэх вэ? Эмэгтэйчүүд өөрийнх нь оролцоотойгоор юу ч хийж чаддаг тэр хүний зураг өглөө болгон мисс Рэчелийн үсээ самнахыг харж байдаг юм гэж Пенилоп шууд хэлсэн билээ. Үнэхээр ч зургийн эзэн өөрийн биеэр тун удалгүй харах биз гэж би бодож байв.

Зургадугаар сарын арван зургаанд, миний бодлоор бол мистер Фрэнклиний горьдлогыг бүр тасалсан нэг явдал тохиолдлоо. Тэр өглөө ангиар гадаад аялгуутай ярьсан нэг танихгүй эрхэм манайд ирж мистер Фрэнклинийг сураглаад, ажил албаны талаар уулзах гэсэн юм гэлээ. Уулзах хэрэг нь очир алмазтай доорх хоёр шалтгааны улмаас холбогдох аргагүй юм. Нэгдүгээрт, мистер Фрэнклин надад үг цухуйлгаагүй хоёрдугаарт, нөгөө гадаадын хүнийг явсны хойно ахайтанд энэ тухай мэдэгдсэн билээ. Ахайтан охиндоо энэ тухай дамжуулсан бололтой. Юу боловч тэр орой, төгөлдөр хуурын ард сууж байхдаа мистер Фрэнклиний сууж байсан орны хүмүүсийн талаар, гадаадад эзэмшсэн ёс зарчмынх нь талаар мисс Рэчел баахан хатуу үг хэлсэн гэж дуулав. Маргааш нь, хаалга чимэглэх ажил анх удаагаа тасалдлаа. Эх газар байхдаа эмэгтэйчүүд юмуу, мөнгөний өр ширээс

үүдэн гаргасан хөнгөмсөг эвгүй явдлуудын үр дагавар Фрэнклинийг Англид ирсэн хойно нь ч дагалдаж байгаа болов уу гэж би таамагласан юм. Гэвч энэ бол таавар төдий юм. Энэ талаар мистер Фрэнклин мөн гайхалтай нь ахайтан хүртэл намайг нүдэн балай хэвээр үлдээв. Надад юу ч хэлсэнгүй.

Арван долооны өдөр, бүх юм аятайхан өнгөрсөн нь байдлаас илт ажээ. Тэд урьдын адил сайн нөхдийн ёсоор хаалга чимэглэх ажилдаа орлоо. Пенилопын хэлсэн үнэн бол Фрэнклин эвлэрсэн боломжийг ашиглан мисс Рэчелд сэтгэлээ илчилсэнд хариуд нь хар цагаан үг дуугараагүй гэнэ. Залуу эзэгтэй нь мистер Фрэнклинд итгэхгүй байна гэж мэдэгдсэн боловч дараа нь тэгж харьцсандаа гэдэгт зарим шинж тэмдгээс үндэслэн (үүнийг тоочиж уншигч таныг чилээх хэрэггүй гэж үзэв) охин маань итгэлтэй байв. Багадаа бараг хамт өсөж, хүмүүжсэн болохоор Пенилоп зарц шивэгчнийг бодвол залуу авхайтай арай дотно байдаг хэдий боловч үг цөөнтэй мисс Рэчел бодол санаагаа хүнд тэгж илэн далангүй хэлэх хүн биш гэдгийг би даанч мэдэлгүй яахав. Охины маань надад хэлсэн зүйл бол, одоогийн нөхцөлд авхайн амнаас гарсан гэхээсээ илүү Пенилопын хүсэл болов уу гэж би сэжиглэж байлаа.

Арван есний өдөр бас нэг явдал болов. Миний бие та бүхэнд хэдийнээ танилцуулсан манай бага шивэгчин Розанна Спирманыг эмчлүүлэхээр эмч авчирсан юм.

Тэр хөөрхий бүсгүй (Нуранги элсэн дээр байхдаа намайг ихэд мухардуулсаныг та мэдэж байгаа) өгүүлж буй энэ хугацаанд нэг биш удаа миний гайхлыг төрүүлсэн билээ. Розаннаг мистер Фрэнклинд дурлачихжээ гэсэн Пенилопын үг (миний тушаалаар охин минь үүнийг чандлан нууцалж буй) надад мөн л утгагүй мэт санагдаж байв. Гэвч Пенилоп бид хоёрын ажигласнаар манай шивэгчний байдал нэг л учир битүүлэг болж эхэлснийг олон таван үггүй шууд хэлье.

Жишээлбэл, Розанна тун овжин, тайвнаар мистер Фрэнклинтэй үргэлж тааралдана. Мистер Фрэнклин түүнийг муурнаас өөрцгүй үзэж, үл анхаарах бөгөөд Розаннагийн үзэмжгүй царайг нэг удаа боловч харъя гэсэн бодол толгойд нь огт орохгүй байгаа бололтой. Хөөрхий бүсгүй тэртэй тэргүй бага иддэг байснаа хоолноос гарч, шөнөжин уйлж нойргүй хоносноос болж өглөө улайж бөлцийсөн нүдтэй явах боллоо. Нэг өдөр Пенилоп тун эгзэгтэй нээлт хийснийг нь бид таг нуусан юм. Товчныхоо нүхэнд хийгээрэй хэмээн мистер Фрэнклинд мисс Рэчелийн өгсөн сарнайг өөрийнхөө түүсэн яг ижил сарнайгаар солиод, Фрэнклиний өрөөнд тольтой ширээнийх нь хажууд зогсож байхыг нь Пенилоп харсан юмсанж. Үүний хойно, миний бие Розаннад биеэ авч явах талаар анхаарах хэрэгтэй гэж сайн санаагаар зөвлөсөнд өөдөөс хэгжүүрхсэн билээ. Тэр ч байтугай, мисс Рэчел хааяа нэг түүнтэй санаандгүй ярихад тун тоомжиргүй харьцана.

Эл өөрчлөлтийг ахайтан ажиглаж мэдээд миний бие үүнийг хэрхэн үзэж байгааг асуув. Би Розаннаг хаацайлах санаатай, ↔бие нь муудсан шиг байна≈ гэж хариулсан ба арван есөнд эмч авчирсаныг нэгтгээ өгүүлсэн билээ. Эмч түүнийг үзээд, мэдрэлийн сульдаанд оржээ, шивэгчнээр ажиллаж чадах болов уу даа гэлээ. Агаар солихын тулд далайгаас хол алсын нэг эдлэндээ явуулъя гэж хатагтай санал гаргав. Гэтэл Розанна эндээс бүү явуулаач хэмээн нүдэндээ нулимс мэлмэрүүлэн гуйж, гувшиж гарлаа. Хэрэг бишдэж ирэхэд, түүнийг эндээ жаахан байлгаад үзье гэж би ахайтанд зөвлөв. Энэ бол миний өгсөн хамгийн адгийн зөвлөгөө байсныг хэрэг явдал харуулах ба та ч мөд үзэх болно. Хэрэв ирээдүйг ядаж нэг хяламхийж чаддагсан бол би Розанна Спирманыг өөрийн гараар байшингаасаа гаргаж явуулах байсан юм.

Хорины өдөр мистер Годфригээс зурвас ирэв. Эцэгтэйгээ зөвлөж хэлэлцэх ажил гарсан тул тэр шөнө Фризинхоллд хонох болжээ. Маргааш нь, үдээс хойш, хоолны өмнөхөн хоёр дүүтэйгээ хамт мориор ирэх гэнэ. Тэр зурвасын хамт үеэлдээ хүндэтгэлээ илэрхийлэн сайн сайхныг хүссэн чамин хийцтэй бяцхач хятад шаазан хайрцаг илгээжээ. Мистер Фрэнклин мисс Рэчелд тэр хайрцагны үнийн талд нь ч хүрэхгүй хямдхан үнэтэй хүзүүний гуу бэлэглэв. Гэтэл миний охин Пенилоп мистер Фрэнклинийг ялна гэж эм хүний зөрүүд зангаар зүтгэсээр байлаа.

Тэнгэрийн ивээлээр, эцсийн эцэст, маргааш мисс Рэчелийн төрсөн өдөр болно! Би таныг энэ хүртэл нэг их саатуулж сатааруулалгүй авчирсныг та хүлээх биз. Одоо би танд бас нэг шинэ бүлэг, тэр тусмаа манай туужийн зангилаа руу шууд хөтлөх бүлгээр таныг баярлуулсугай.

## IX бүлэг

Зургадугаар сарын хорин нэгэнд мисс Рэчелийн төрсөн өдөр нар мандахаас эхлээд тэнгэр бүрхэг байснаа орой тийш бүр цэлмэлээ.

Зарц нар бид заншил ёсоор Рэчелд бяцхан бэлэг гардуулан, миний бие зарц нарын ахлагчийн хувьд жил бүр энэхүү аз жаргалтай өдрийг тохиолдуулан хэлдэг ёслолын үгээ хэллээ. Би ингэхдээ

парламентыг нээх үеэр хатан хааны хэрэглэдэг аргыг дагадаг буюу өөрөөр хэлбэл жил бүр нэг л янзын үг хэлдэг билээ. Үгээ эхлэхийн өмнө миний ярихыг (хатан хааных шиг) урьд огт сонсоогүй шинэ зүйл мэт тэсэж ядан хүлээнэ. Үг хэлсний дараа хүмүүс баахан урамгүй бувтнацгаах боловч хойтон жил арай шинэ зүйл сонсох биз хэмээн найдан хүлээх бөлгөө. Үүнээс үүдэн парламентынхан болон гал тогооныхныг захирахад хялбар байдаг гэсэн дүгнэлт хийж болно.

Саран чулууг Фризинхоллын банкнаас авч мисс Рэчелд гардуулах цаг болсон талаар цайны дараа мистер Фрэнклин бид хоёр сэм зөвлөлдөв.

Мистер Фрэнклин хувирамтгай, туушгүй хачин зан их гаргах болсны шалтгаан үеэлдээ хайр сэтгэлээ илчлэх гэж дахин оролдоод бүтэлгүйтсэнийх юмуу, эсвэл олон шөнө дараалан нойр алдсаных алин болохыг би мэдэхгүй. Ямар ч гэсэн, төрсөн өдрийн өглөө Фрэнклин их л эвгүй зантай байлаа. Очир алмазын талаар хорин минутын дотор л хорин янзын санаа сэднэ. Миний хувьд гэвэл, мэдэгдэж буй энгийн баримтыг л хөдөлбөргүй баримталж байв. Эрдэнийн чулуутай холбогдуулан ахайтны сэтгэлийг түгшээх хэрэг бидэнтэй огт тохиолдсонгүй, харин хууль ёсоор бол Фрэнклин Саран чулууг үеэлнийхээ мэдэлд өгөх хэрэгтэй байлаа. Уг хэргийн талаар миний бодол ийм байсан бөгөөд мистер Фрэнклин хэдий олон удаа эргэж буцсан боловч эцэстээ миний саналыг арга буюу зөвшөөрсөн билээ. Өдрийн хоолны дараа Фризинхоллд мориор очиж, банкнаас алмаз аваад мистер Годфри болон хоёр залуу авхайн хамт эргэж ирэхээр тогтов.

Ийнхүү шийдээд манай залуу эрхэм, мисс Рэчел дээр буцаж очлоо.

Тэд бүхэл өглөөжин, мөн үдийн хагасыг нөгөө л хаалга чимэглэсээр өнгөрөөлөө. Пенилоп хажууд нь зогсоод зааврын дагуу будаг холино. Цайны цаг дөхсөн тул манай хатагтай нусны алчуураараа хамраа дарсаар (тэр өдөр тэд мистер Фрэнклиний найруулсан шингэлэгчийг дэндүү их хэрэглэжээ) зураачдыг ажлаас нь хөндийрүүлэх санаатай дэмий л оролдон өрөөнд нь орж гарна. Гурван цагийн үед л сая нэг хормогчоо тайлж, шингэлэгч бодис хангалттай нэвчсэн Пенилопыг суллаж, өөрсдөө зааварч халтартсан гар хуруугаа цэвэрлэв. Тэд хүссэнээ биелүүлжээ. Хаалганы чимэглэлийг мисс Рэчелийн төрсөн өдөр дуусгаж, ажлаараа их л бахархаж байлаа. Зурсан хан гарди, дурлалын тэнгэр зэрэг нь харахад сайхан байсныг хэлэх хэрэгтэй. Гэвч хэтэрхий олон бас цэцэг, уриа дүүрэн ороолдсон, янагийн тэнгэрүүдийн байдал төрх учир нь олдохооргүй тул та уг бүтээлийг харах завшаан олдсоноос хэдэн цагийн хойно ч таны толгойд тун тааламжгүй байдлаар хадагдан үлдэх вий. Пенилоп өглөөний ажил дуусгаад бөөлжис нь цутгаж байсныг нэмж хэлж байгаа минь нөгөө шингэлэгч бодисыг муучлах гэсэн хэрэг огт биш билээ. Үгүй, үгүй! Будаг хатмагцаа өмхий ханхлуулахаа больсон. Хэрэв урлаг иймэрхүү хохирол шаарддаг бол, миний төрсөн охин мөн хэдий боловч би ↔Урлаг минь, эднийг авагтун!≈ гэж хэлнэ.

Фрэнклин ум хумгүй хооллоод үеэлүүдээ авчирна гэж ахайтанд хэлчихээд Фризинхолл руу мордов. Саран чулууг авчирна гэдгийг бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй байлаа.

Энэ бол миний бие зуушны газар зохих байраа эзлэн хоол ундны үеэр анхаарч зааварлах ёстой болдог том баяр ёслолын нэг байсан тул мистер Фрэнклиний эзгүйд надад бодож санах юм зөндөө байлаа. Би архи дарс бэлтгэж, ширээнд үйлчлэх зарц, шивэгчид нарыг шалгаж үзээд зочид ирэхээс өмнө ухаач бодлоо төвлөрүүлэх санаатай өрөөндөө орлоо. Хэд сайн сорж аваад (чухам юуг гэдгийг та мэднэ) хэдэн удаа дурдах завшаан тохиолдсон нөгөө номоо хараад бие сэтгэл тайвшрав. Гэтэл би морьдын туурайн тачигнах чимээнээр нойроос биш, гүн бодлоос ангижран морьтны багийг угтахаар үүд рүү очлоо. Мистер Фрэнклин ба гурван үеэлийг нь Эблвайт өвгөн нэг хиа дагалдан иржээ.

Годфри, Фрэнклинтэй нэг талаар адилхан, өөрөөр хэлбэл сэтгэл санаа нь хэвийн бус байсанд би багагүй гайхав. Урьдын адил миний гарыг найрсгаар атгаад, хуучны анд Бэттережийгээ ийм энх тунх явааг харахад тун сайхан байна гэж их л эелдэг хэллээ. Гэвч ямар учиртайг бүү мэд, нэг л дүнсгэр байна. Эцгийнх нь амар мэндийг асуухад минь, ↔Янзаараа л байгаа≈ хэмээн их л товчхон хариу өгөв. Гэтэл Эблвайтын хоёр охин хорин хүнтэй тэнцэхүйц хөгжил хөөртэй авирлан байдлыг тэнцүүлнэ. Тэр хоёр бараг ах шигээ өндөр, биерхэг, шар үстэй, улаа бутарсан тарган цатгалан, эрүүл чийрэг, цовоо хөхүүн зантай ажээ. Тэднийг авч ирсэн хөөрхий морьдын хөл бүр цуцжээ. Хоёр бүсгүй туслахыг ч хүлээлгүй морин дээрээсээ яг л хаймран бөмбөг шиг үсрэн буулаа. Эгч дүү хоёр ярих бүрдээ том ↔О≈ үсгээр эхэлнэ, юм бүхнийг чимээ шуугиантай хийнэ, инээх инээхгүй юманд сав л хийвэл хөхөрч, гуугачих бөлгөө. Тэднийг би ↔дуржигнуур≈ гэж нэрлэсэн юм.

Залуу авхай нарын шуугилдах зуур үүдний өрөөнд би мистер Фрэнклинтэй самбаачлан хэдэн үг сэм сольж амжив.

Эрхэм ээ, алмазаа эсэн мэнд авчрав уу?

Фрэнклин толгой дохиод хувцасныхаа энгэрийн халаасанд гар хүрлээ.

Нөгөө энэтхэгүүдээс харагдав уу?

Бараа нь ч үзэгдээгүй.

Ийн хариулаад, ахайтныг сураглаж зочны жижиг өрөөнд байгаа гэхэд шууд тийшээ явлаа. Тэнд ороод минут ч болоогүй байтал хонх хангинаж, Пенилопыг мисс Рэчел рүү явуулсан нь мистер Фрэнклин уулзаж ярилцах гэсэн юмсанж. Түүнээс бараг хагас цагийн дараа үүдний танхимаар гарч явтал зочны бага өрөөнөөс гэнэт часхийтэл хашгиралдахыг сонсоод би хадагдсан мэт зогтусав. Тийн хашгирахад мистер Элбвайтын хоёр охины хэлэх дуртай ↔О≈ авиаг ялгаж таньсан болохоор миний бие цочсон гэхэд хэцүү үгүй гэхэд ч хэцүү. Гэсэн ч хоолны талаар заавар авах далимаар ямар нэг сүрхий хэрэг үнэхээр гарсан эсэхийг мэдэх санаатай тэр өрөөнд орлоо.

Ширээний ард мисс Рэчел хурандаагийн гайтай алмазыг бариад гайхаж биширсэн янзтай зогсож байна. Хоёр талд нь хоёр ↔дуржигнуур≈ сөхрөн суугаад алмазыг залгих шахам ширтэж, чулуу өнгө хувиран гэрэлтэх бүрийд бахдан дуу алдах ажээ. Ширээний нөгөө талд мистер Годфри хүүхэд шиг алга ташин ↔Чамин эд байна. Хосгүй эд байна!≈ хэмээнэ. Харин мистер Фрэнклин шүүгээний хажууд сахлаа чимхлэн суух бөгөөд цонхны зүг сэтгэл зовлон шинжтэй үе үе хяламхийж ажээ. Цонхны дэргэд түүний хараад байгаа зүгт манай хатагтай хурандаагийн гэрээслэлийн хуулбарыг барин буруу харан зогсож байлаа.

Миний бие хоолны талаар ямар захирамж өгөхийг асуусанд эзэгтэй над руу эргэн харахад нь удмынхаа онцлог байдлаар хөмсгөө зангидаж, хөмхийгөө хилэгнэн зуусныг олж үзэв.

□ Хагас цагийн дараа миний өрөөнд ороорой. Танд хэлэх юм байна гэж хариу айлдаад ахайтан гарлаа.

Нуранги элсэнд байхад Фрэнклин бид хоёрын ямар байсан шиг байдалд орсон нь лавтай байв. Саран чулууг ер нь ямар учраас зээ охиндоо гэрээслэж үлдээгээ вэ? Манай эзэгтэй ахтайгаа хуншгүй шударга бусаар харьцаж байв уу, эсвэл ах нь бодож байснаас нь долоон дор эр байв уу? Ахайтан энэхүү бэрх асуудлыг шийдэж ядан байхад, хурандаагийн зан авирыг өчүүхэн ч үл төсөөлөх охин нь төрсөн өдрийнхөө бэлгийг барин зогсох ажээ.

Танхимаас гарахаар завдтал минь төрсөн цагаас нь өдий хүртэл тэднийд ажилласан өвгөн зарцдаа үргэлж анхаарал тавьдаг мисс Рэчел намайг зогсоож,

□ Габриэл гуай хараа! Хэмээн өгүүлээд эрдэнийн чулууг цонхоор туссан нарны гэрэлд гялбуулан миний нүдний өмнө барьж үзүүлэв.

Бурхан тэнгэр өршөө! Жинхэнэ очир алмаз байв!

Бараг л сүвээ цагааны өндгийн чинээ том алмаз байлаа! Цацрах гэрэл нь тэргэл сарны туяа мэт ажээ. Тэрхүү чулууг харвал хязгаар нь үл үзэгдэх шаргал туяа татсан ёроолгүй мэт гүн рүү таны хараа өөрийн эрхгүй бэлчинэ. Эрхий, долоовор хоёроороо чимхэн барьж болох тэрхүү эрдэнийн чулуу танд хурмаст тэнгэр лугаа адил хязгааргүй гүн мэт санагдана. Бид тэр алмазыг наранд харж байв. Тэгснээ бид цонхныхоо хаалтыг буулгасанд харанхуйд сарны мөнгөлөг туяа татуулан жигтэйхэн хурцаар гэрэлтэн гялалзаж байлаа. Мисс Рэчелийн бахдан шагшсаныг, үеэл охидынх нь дуу алдацгаасныг гайхах юун. Очир алмазыг хараад миний бие өөрийн эрхгүй ↔дуржигнуурууд≈ шиг ↔О≈ хэмээн дуу алдав. Бидний дотроос мистер Годфри л ганцаараа барьц алдсангүй. Хоёр дүүгийнхээ бүсэлхийгээр тэврэн зогсоод нэг очир алмазыг, нэг намайг ээлжлэн ивээнгүй ширтэж,

□ Нүүрс байна, Бэттереж минь! Жирийн л нэг нүүрс байна, сайн нөхөр минь! гэж байв.

Намайг сэхээрүүлэх гэж тийн хэлсэн болов уу хэмээн би бодож байна. Гэтэл үүнийг сонсоод би хоолны тухай л санасан юм. Тэгээд өрөөнөөс гарч доошоо үйлчлэгчийн арми руу буув. Намайг гартал Годфри, ↔Хөөрхий өвгөн Бэттереж, би үнэхээр хүндэтгэдэг юм шүү!≈ гэж намайг ялдам үгээр шагнах зуураа хоёр дүүгээ тэврэн, Рэчелийг хайр дүүрэн энхрий харцаар ширтэн байв.

Юутай их хайр сэтгэлийн нөөц агуулж байдаг юм бэ! Фрэнклин ч түүний дэргэд ёстой л зэрлэг хүн байв.

Хагас цагийн дараа миний бие тушаасан ёсоор ахайтны өрөөнд орлоо.

Ахайтан бид хоёрын хооронд ерөнхийдөө Нуранги элсэнд мистер Фрэнклин бид хоёрын хооронд болсонтой төстэй яриа болсон ба ялгаа нь гэвэл, ахайтныг дэмий айлгах шаардлага гараагүй гэж үзсэн тул илбэчдийн талаарх саналаа хэлсэнгүй өнгөрөв. Явах зөвшөөрөл аваад гарахдаа ахайтан хурандааг адгийн хар санаа агуулсан биз гэж бодоод боломж гармагц л охиноосоо саран Чулууг салгая гэж шийдсэнийг нь ойлгосон билээ.

Зарц нарын суудаг хэсэг рүү явж байтал мистер Фрэнклинтэй тааралдав. Үеэл дүү Рэчелийг харсан эсэхийг асуух гэжээ. Би хараагүй гэдгээ хэлэв. Үеэл Годфрийгээ сураглахад нь би бас л мэдэхгүй гэлээ. Гэвч үеэл нь үеэл дүү Рэчелээс нь төдий л холгүй байгаа болов уу гэж би сэжиглэсэн юм. Өөрөө ч бас тэгж сэжиглэсэн бололтой. Сахлаа чимхэлж номын санд орон хаалга тасхийтэл савж хаасан нь их л учиртай байлаа.

Миний бие зочдыг хүлээн авахад бэлтгэн ёслолын хувцсаа өмсөх хүртэл баярын ширээ засах ажлаас дахиад хөндийрсөнгүй. Цагаан хантаазаа өмсөхөөр завдаж байтал Пенилоп миний цөөн хэдэн

үсийг самнаж, цагаан эрвээхий зангиаг минь янзалж өгөх гэсэн бололтой орж ирэв. Охин маань их л баясгалантай байх бөгөөд надад нэг юм хэлэх гэж байгаа нь илт. Миний толгойны халцарсан оройг үнсээд,

□ Аав аа, танд сонин дуулгая! Мисс Рэчел түүнээс татгалзсан шүү! Гэж шивнэв.

□ Хэнээс тэр вэ? Гэж би асуув.

□ Эмэгтэйчүүдийн хорооны гишүүнээс. Балиар зальт этгээд! Мистер Фрэнклинийг шахаж зайлуулах гэж оролддог болохоор нь зэвүү хүрдэг юм! гэж Пенилоп өгүүлэв.

Олигтой амьсгал авч чадахаар байсан бол тэрхүү ивээгч буянтны тухай тийм зохисгүй үг ярихыг эсэргүүцэх байсан минь мэдээж. Гэтэл яг тэр үед охин маань миний зангиаг янзалж байсан ба сэтгэлийн нь бүх хүч гарт нь шилжсэн байлаа. Энэ насандаа ингэж боомилуулахад дөхөж байсан минь үгүй.

□ Авхайг дагуулан сарнай цэцгийн хүрээлэн рүү явахыг нь харчихаад ямаршуухан янзтай буцаж ирэхийг нь харья гэж шийдээд балуу модны ард нуугдан хүлээв. Тэр хоёр инээж хөхрөн хөтлөлцөөд явсан. Харин буцаж ирэхдээ ихэд хүйтэн царайлан, хоёр биеэсээ зайтай, өөр өөр тийш харцгаан явахыг харахад эргэлзэх юм байсангүй. Аав минь, би энэ яваа насандаа тэгж баярлаж үзээгүй! Хорвоогийн эмэгтэйчүүд дундаас мистер Годфри Эблвайтаас татгалзсан цор ганц ч болов бүсгүй байх нь! Би сурвалжит авхай байсан бол бас л татгалзаж хоёр дахь нь болох байсан! гэж Пенилоп ярив.

Үүнд би дахиад эсэргүүцэл илэрхийлье гэтэл Пенилоп миний хэдэн үсийг самнаж байсан бөгөөд бүх хүч нь тийшээ шилжжээ. Хэрэв та халзан бол миний бие хэрхэн хэлмэгдсэнийг ойлгоно биз. Үгүй бол та энэ мөрийг орхиод, хожгороо самнаас хамгаалах юм толгой дээрээ байдагт тэнгэр бурханд талархагтун. Пенилоп цааш нь өгүүллүүн,

□ Мистер Годфри яг миний нуугдсан балуу модны хажууд саатаад, ↔Бидний хооронд юу ч болоогүй юм шиг энд үлдвэл та дургүйцэхгүй биз?≈ гэсэнд мисс Рэчел цахилгаан мэт эргэж хараад, ↔Та ээжийн урилгыг хүлээж авсан, түүний зочидтой хамт энд байна. Элдэв хов жив гаргая л гэж бодоогүй юм бол та мэдээжээр энд үлдэж л таараа!≈ гэв. Тэгээд хэд алхсанаа арай зөөлрөв бололтой, ↔Годфри, саяын явдлыг мартацгаая, үеэл ах дүү хэвээрээ байцгаая≈ гэж хэлээд гараа өгсөнд гарыг нь үнсэв. Мисс Рэчел түүнийг орхиод явлаа. Мистер Годфри толгойгоо унжуулан, өсгийгөөрөө өсгийгөөрөө элс хонхойлгон хэсэг зогсов. Тэгтлээ шалдаа буусан хүн та ер үзээгүй биз. Нуруугаа цэхлэн байшин руу явахдаа ↔Балай юм, шал балай юм!≈ гэж шүд зуун үглэж байв. Өөрийгөө тэгж хэлсэн бол аргагүй л оножээ. Зэгсэн балай хүн шүү дээ. Аав минь, эцэстээ миний ярьж байснаар л болж байна. Харин мистер Фрэнклин бол ёстой хүн шиг хүн шүү! Гэж Пенилоп хашгирахдаа эцсийн удаа хуйхыг минь хамаг хүчээрээ маажиж билээ.

Би самыг нь авч (та зөвшөөрөх биз) эвгүй овилгогүй загнасанд нь зохих ёсны зэмлэл өгөхөөр амаа нээж, үг дуугарч амжаагүй байтал гадаа сүүх тэрэгний дугуй таржигнах сонсдож саатуулав. Эхний зочид морилон иржээ. Пенилоп төдхөн гарч гүйлээ. Би хувцсаа өмсөөд толинд харсанд толгой минь хавч шиг улаан байсан хэдий ч тэр оройн ёслолын нэг чухал хүний хувьд дэгжин хувцасласан байлаа. Анхны хоёр зочин ирснийг мэдэгдэхээр танхимд яг амжиж оров. Энэ зочдыг та бүхэн онцолж анхаарах хэрэггүй. Манай эрхэм энэрэн тэтгэгчийн л эцэг, эх буюу авгай нөхөр Эблвайт нар байв.

## Х бүлэг

Эблвайт нарын дараа нэг хоёроороо цувсаар зочид бүрэн цугларлаа. Гэрийн эздийг оролцуулаад нийт хорин дөрвөн хүн байв. Зочид ширээ тойрон сууж, фризинхоллын унзад хоолойтой шашны тэргүүн босож мөргөл уншиж байгаа нь бахдам сайхан ажээ.

Зочдыг нэг бүрчлэн танилцуулж уншигч таныг чилээх хэрэггүй буй заа. Тэдний хоёроос бусадтай нь ямар боловч миний энэ өгүүлэх зүйлд дахин учрахгүй.

Тэр хоёр үнэхээр зочдын хамаг анхаарлыг татан буй найрын эзэн мисс Рэчелийн хоёр талд суужээ. Энэ удаад авхай хүн бүрийн харааг ер бусын ихээр булаасны учир бол (манай хатагтай дотроо ихэд дургүйцэж байв) төрсөн өдрөөрөө авсан гайхамшигт бэлгийг, ойр хавийнхаа бүх зүйлийн сүрийг дарсан Саран чулууг энгэртээ зүүсэн байв. Чулууг анх цулгүй бэлэглэсэн боловч олон талын авьяастай мистер Фрэнклин ухаан зарж, хэсэг мөнгөн утас ашиглан уран гараараа цагаан палаажин дээр нь энгэрийн зүү шиг тогтоожээ. Бүгд л очир алмазны лут том хэмжээ, өнгө үзэсгэлэнг шагшин гайхсан нь мэдээж. Харин хоёр хүн, дээр нэгэнт өгүүлсэнчлэн мисс Рэчелийн хоёр талд сууж байсан зочид л жигтэй юм хэлсэн билээ.

Зүүн гарт нь сууж байсан зочин бол манай Фризинхоллын эмч мистер Канди юм. Энэхүү намхан эр, найрсаг хүнтэй нийцтэй хэдий боловч нэг дутагдал байдгийг хэлэх ёстой. Хошигносон үгэндээ зохих зохихгүй үед хөхиж хөгжих дэндүү дуртай, зэгсэн хөнгөмсөг зантай болохоор хүнтэй хялбар танилцаж, яриа хөөрөө дэлгэх бөлгөө. Олны дунд байнга алдаа гаргаж, огт санаандгүйгээр хүмүүсийг хооронд нь хэрэлдүүлж орхино. Харин ажилдаа сүрхий няхуур байдаг бөгөөд илүү хашир эмч нарын алдаж бурууддаг зүйл дээр (дайснуудынх ньхэлдгээр) зөн совиноороо голдуу зөв онош тавьдаг байлаа. Очир алмазын талаар Рэчелд хэлсэн зүйл нь мөн л будлиантай, шоглосон хоёрын хооронд үг байв. Шинжлэх ухааны тусын тулд уг алмазыг гэртээ аваачиж шатааж үзэхийг зөвшөөрөөч хэмээн эмч, авхайгаас төв царайлан гуйж,

□ Мисс Рэчел бид үүнийг хэд ч юм градуст халаагаад, дараа нь агаарт тавибал бага багаар ууршиж, таныг ийм их үнэ цэнэтэй чулуу хадгалах хэцүү ажлаас ангижруулна гэж өгүүлэв.

Ахайтан эмчийг үнэнээсээ ийн ярьж, төрсөн өдрийнхөө бэлгийг шинжлэх ухаанд зориулъя гэсэн хүслийг Рэчелд төрүүлж чадаасай билээ гэсэн шинжтэй сонсож байлаа.

Манай авхайн баруун гар талд сууж байсан нөгөө нэг зочин бол нэг л европ хүн хөл тавиагүй газар саад бэрхшээлийг даван амь сөрөн явсан энэтхэгийн алдарт жуулчин мистер Мэртвэт билээ.

Энэ дуу цөөтэй, өндөр, туранхай бор эр ядрангүй боловч тун гярхай, шийдмэг харцтай нэгэн ажээ. Түүнийг эндхийн хэвийн амьдралаас залхаж, дорнын зэрлэг газар нутагт эгэн очиж, хэрэн хэсэхсэн гэж мөрөөддөг гэлцэнэ. Зоогийн үеэр Рэчелд эрдэнийн чулууных нь тухай хэлснээс өөр үг цухуйлгасан, ядаж ганц жүнз дарс амссан гэх нь юу л бол. Бага ч гэсэн хэмжээгээр сонирхлыг татсан цорын ганц зүйл бол Саран чулуу байлаа. Энэтхэгийн бөглүү хязгаар нутгаар жуулчилж явахдаа энэ чулууны цуу алдрыг аль хэдийнээ сонссон бололтой. Чулууг ширтэж байснаа Рэчел авхайг эгдүүцтэл нь юм дуугаралгүй хэнэггүй тайван зангаараа,

□ Мисс Вериндер та хэзээ нэг цагт Энэтхэгт очвол нагац ахынхаа өгсөн бэлгийг авч явах хэрэггүй шүү. Энэтхэгийн очир алмаз энэтхэгийн шашинтай салшгүй холбоотой байх нь олонтаа. Яг одоогийнх шигээ ингэж хувцаславал таван минутын ч насгүй болж магадгүй зарим хот, сүм хийдийг би мэднэ гэв.

Англид аюулгүй болохоор мисс Рэчел Энэтхэгт учирч болзошгүй аюулын тухай их л бахтай сонсож байлаа. Хоёр ↔ Дуржигнуур ≈ бүр ч их бахдан, хутга сэрээгээ тар няр хийтэл унагаад Оо! Ямар сонин юм бэ? хэмээн чанга чанга дуу алдав. Харин ахайтан суудал дээрээ тогтож ядан ,ярианы сэдвийг өөрчиллөө.

Хоол, зоог барих явцад энэ өдрийн баяр урьд өмнийхөд яагаад ч хүрэхгүй болохыг миний бие аажим аажмаар анзаарч билээ.

Дараа нь тохиолдсон явдлыг нэгэнт мэдсэн хойно, одоо сайхи төрсөн өдрийг дурсан санахдаа тэр гайтай очир алмаз хүмүүсийн сэтгэлийн тавыг алдуулсан гэдэгт би бараг эргэлздэггүй юм.

Би зочдод архи дарс сөгнөн их л ёсорхог царайлан ширээ тойрч, гар браг хүрээгүй хоол байвал зочдод,

Та үүнээс амсана уу, таны сэтгэлд лав нийцнэ байх хэмээн сэм шивнэж явлаа.

Арав хэлэхэд, есөн удаад нь тэд өвгөн Бэттережийг хүндэтгэн (намайг ийн нэрлэхэд тэдэнд таатай байжээ) хоолноос амсаж байсан боловч ер олигтой юм болсонгүй. Хоолны үеэр яриа нэг л авцалдахгүй, би хүртэл эвгүйрхэж эхлэв. Хэн нэг нь ам нээхээрээ зохисгүй, дэмий юм хэлнэ. Жишээлэхэд л Канди эгч урьд нь тийм болхи ярьж байсныг нь би санахгүй байна. Түүний гаргасан авираас ганц жишээ өгүүлбэл, найр амжилттай сайхан болоосой хэмээн чин сэтгэлээсээ хүсэн аяга савны шүүгээн дэргэд зогсож байсан миний бие ямаршуу байлалд орсоньг та лав ойлгоно биз.

Манай зочдын нэг, профессор агсны бэлбэсэн гэргий хүндэт Тридголл авгай талийгаач нөхрөө дурсан эцэс төгсгөлгүй яриа дэлгэдэг бөгөөд тэгэхдээ энэ сайхан сэтгэлт эмэгтэй нөхөр нь аль хэдийн нөгөө ертөнцөд очсон гэдгийг ер хэлдэггүй ажээ. Бага сага боловсролтой англи хүн бүхэн энэ тухай мэдсэн байх учиртай гэж боддог бололтой. Хэсэг чимээгүй байснаа зочны нэг нь хүний биеийн бүтцийн тухай сонирхолгүй, зэгсэн балай сэдэв цухуйлгатал сайхан сэтгэлт Тридголл авгай нас барчихсан гэдгийг нь мөн л дурсалгүйгээр талийгаачийнхаа тухай шууд ярьж гарав. Хүний биеийн бүтцийг судлах явдал бол профессорын чөлөөт цагаараа оролддог хамгийн дуртай ажил гэнэ. Гай болоход, талийгаач профессорыг мэддэггүй байсан мистер Канди Тридголл авгайн өдөөс харж суугаад яриаг нь сонсож байв. Туйлын эелдэг эрийн хувьд энэ боломжийг ашиглаж чөлөөт цагаараа сонирхон оролддог ажилд нь профессор тусалъя гэсэн хүслээ илэрхийлэхээр шийджээ.

Мэс заслын академид олон сайхан араг яс өгсөн байна билээ. Хатагтай минь, профессор чөлөө гарвал заавал тийшээ очоорой гэж зөвлөх байна хэмээн мистер Канди ширээний цаанаас цовоо дуугаар чанга өгүүлэв.

Зүү унасан ч сонсогдохоор нам гүм болов. Профессорын дурсгалыг хүндэтгэсэндээ зочид огтхон чдуу чимээгүй сууна. Би тэгэхэд Тридголл авгайн ард зогсоод аяганд дарс хийж байсан юм. Тридголл авгай толгойгоо унжуулан <<Миний хайрт нөхөр нас барсан >> гэж тун аяархан өгүүлэв.

Гэтэл заяагүй Канди эмч үгүү нь сонссонгүй, үнэн учрыг өчүүхэн ч төсөөлөлгүй улам эелдэг бүр чанга дуугаар,

Академийн гишүүний үнэмлэхтэй хүн ням гаригаас бусад өдөр арваас арванзургаан цагын хооронд очиж болно гэдгийг профессор мэдэхгүй байж магадгүй гэлээ.

Тридголл авгай энгэрийнхээ торонд нүүрээ шигтгэн бүр ч нам дуугаар ↔Миний хайрт нөхөр нас барчихсан≈ гэдэг ёсорхуу үгээ давтав.

Би ширээний цаанаас нүдээ анивчин Кандид дохио өгөв. Мисс Рэчел гарт нь хүрэв. Ахайтан ойлгомжтой харц чулуудлаа. Ямар ч тус алга! Яаж ч зогсоох аргагүй чин сэтгэлээсээ хүүрнэсээр байв.

□ Та надад одоогийнх нь хаягийг хэлж соёрхвол би нэрийн хуудсаа профессор дуртайяа өгөмз.

□ Эрхэм ээ, одоогийнх нь хаяг гэвэл булш. Профессор нас нөгчөөд арван жил болж байна! гэж гэнэт тэсвэр алдсан Тридголл авгай их л ууртай ширүүн хэл сэнд хундага жингэнэн доргив.

□ Ээ, ивээлт тэнгэр минь! гэж мистер Канди дуу алдахад хоёр ↔дуржигнуур≈ хөхрөлдөв. Харин бусад зочин профессорыг булшнаас нь дуудахаар араас нь харайлдахад бэлэн байгаа янзтай болчихоод сууцгааж байлаа.

Мистер Кандийн хувьд хангалттай өгүүллээ. Бусад зочид ч эмчийн нэгэн адил цаанаа л нэг нийлэмжгүй байв. Ярих хэрэгтэй үед үг дуугарахгүй, эсвэл нэг ярихаараа солио гажуу юм ярих ажээ. Олны өмнө төчнөөн уран ярьдаг мистер Годфри дуугарахгүй байлаа. Ааш муутай байснаас ч юмуу эсвэл сарнайн цэцэрлэгт ялагдсандаа ичингүйрсэн ч юмуу бүү мэд. Хамаг уран үгээ дэргэдээ сууж байсан манай гэр бүлийн нэг хатагтайн чихэнд л шивнэж байв. Тэр бол эмэгтэйчүүдийн зөвлөлийн ажилд оролцдог, шампанск дарсанд учиргүй дуртай (дангаар нь ихээхэн уучихдаг гэдгийг та ойлгоно биз) зэгсэн намбатай бүсгүй. Шүүгээний дэргэд, тэр хоёрын ардхан зогсож, тэдний хоорондоо хэлэлцэхийг сонссон миний бие лонхны бөглөө мулталж, хонины мах хуваах зэргээр ширээний ард үйлчлэх үеэр минь чих дэлсдэг байсан элдэв сонин сургамжтай яриа хөөрөө цугларагсдын дунд үүсэх хөг одоо нэгэнт өнгөрснийг гэрчилж чадна. Тэдний өглөгийн хорооны ажил төрлийн тухай чухам юу хүүрнэснийг би сонссонгүй. Нэг чагнахад, төрсөн эхчүүдийн тухай, гачигдал ядуурлаас аврагдсан эмэгтэйчүүдийн яриагаа орхиод арай ноцтой сэдэвт орсон байлаа. Лонхны бөглөө мулталж, мах хэрчих зуур мистер Годфрийн үгээс миний ойлгосон зүйл гэвэл, шашин бол хайр сэтгэл гэсэн үг ажээ. Хайр сэтгэл бол шашин гэнэ. Ертөнц бол нэлээд муудаж өгөршсөн Тэнгэр байсан ажээ. Харин Тэнгэр бол шинэчлэгдсэн ертөнц байв. Ертөнц дээр шалиг завхай улс элбэг суудаг. Гэвч тэднийг засан хүмүүжүүлэхийн тулд тэнгэрийн бүх эмэгтэйчүүд хэзээ ч хэн ч хэрүүл уруул хийдэггүй агуу том хороонд нэгдэх болно. Харин захирагч □ сахиулсан тэнгэр нь болсон эрчүүд тэдний хүсэл зоригийг биелүүлж байх аж. Мөн ч сайхан! Догь доо! Гэтэл мистер Годфри яагаад үүнийгээ нийтийн сонорт дуулгахгүй тэрүүхэндээ ярилцана вэ?

Фрэнклин хүмүүсийг хөгжөөж тэр үдшийг аятай тавтай болгох гэж оролдсон гэж та бодож байж болох оо доо?

Даанч үгүй шүү! Мистер Фрэнклиний байдал бүр засарч, тун сайхан зантай болжээ. Пенилоп л мистер Годфрийн сарнайн цэцэрлэгт бүтэлгүйтсэнийг мэдээлж амжсан байх л даа. Гэтэл юу ч ярьсан арваас есөн удаад нь бүтэл муутай сэдэв сонсох юмуу, эсвэл буруу хүнд хандах учраас зарим хүнийг гомдоож, нөгөөг мэл гайхуулах ажээ. Би дээр нэгэнт дурдсан франц, герман, итали гэх мэтийн гадаадад олсон хүмүүжил нь манай ахайтны зочломтгой ширээний ард хамгийн эвгүй, хачин хэлбэрээр илэрч гарлаа.

Жишээлбэл, нөхөртэй бүсгүй хүн хөндлөнгийн эр хүнд хэдий хэмжээгээр талтай болж болох талаар өөрийнхөө саналыг Фризинхоллын сүмд хүмүүжсэн хадамд гараагүй нагац эгчдээ, франц маягийн хурц ухаан гарган хэлсний нь та юу гэж үзэх вэ? Герман талын зан нь дийлж ирэхэд, бух өсгөх туршлагынхаа талаар өгүүлж байсан мал аж ахуйн агуу их мэдлэгтэн, газрын эзэн нэг ноёнд туршлага гэдэг бол шулуухан хэлэхэд юу ч биш, харин бух өсгөх зөв зүйтэй ажил бол дотроо сайтар гүнзгий боловсруулж үлгэр жишээ болохуйц бух бий болгох санаагаа хөгжүүлэн хэрэгжүүлэхэд оршино гэж ярьсныг яана. Манай гүнлэгийн нэг эрхтэн бяслаг, шанцай барих цагаар ам нь ихэд халан Англид ардчилал газар авч байгаа тухай ярьж байснаа ↔мистер Блэйк бид эрхээ хамгаалах хуучны ёсыг нэгэнт алдаж байгаа бол бидэнд юу үлдэх вэ гэж асууж болохсон болов уу?≈ гэхэд нь,

□ Эрхэм ээ, бидэнд Дурлал, Хөгжим, Шанцай гурав л үлдэнэ хэмэн ёстой л итали зангаар хариуллаа. Юу ч гэх вэ дээ? Энэ мэт төрхгүй аашлан хүмүүсийг балмагдуулаад зогссонгүй, англи зан нь эцэстээ дийлээд, гадаадын бүхий л ааш маяг нь арилах ажээ. Анагаах ухааны мэргэжлийн

сэдвээр ярилцахдаа докторуудыг дооглож тохуурхсан нь цайлган сэтгэлт, жижигхэн биет мистер Кандийн уур хилэнг буцалгаж орхив.

Фрэнклин сүүлийн үед тун ч нойр муутай хонодог болсноо хүлээхэд хүрснээс (яагаад ч тэр юм би мартжээ) тэдний маргаан эхэлсэн билээ. Тэгэхэд нь Канди эмч мэдрэл ядарч сульдсанаас болсон хэрэг, тийм учраас даруйхан эмчилгээ хийлгэвэл зохино гэв. Тэгтэл хариуд нь Фрэнклин эмчилгээ хийлгэх, харанхуйд тэмтчих хоёр яг адилхан гэж үзэж буйгаа мэдэгдэв. Мистер Фрэнклинийг үнэндээ нойроо бэдрэн тэмтчиж байна, нойроо олж авахад нь эмчилгээ тус болно хэмээн мистер Канди тун ч цэцэн онож хэлэв. Фрэнклин мөчөөгөө өгсөнгүй, ↔сохор нь сохроо хөтөлж явах≈ гэдэг үгийг олонтаа дуулсан боловч утгыг нь одоо л ухаарлаа гэв. Энэ мэтээр хурц ширүүн шидэлцсээр эцэстээ хоёул улайрчээ. Ялангуяа Канди эмч мэргэжлээ өмгөөлөхдөө бүр тэвчээр алдсан учраас манай хатагтай ярианд нь оролцон, маргаанаа даруй зогсоо гэж шаардахаас өөр аргагүй боллоо. Энэхүү аргагүйн эрхэнд гарсан шаардлага хүмүүсийн хөгжил баяслыг бүрмөсөн унтрааж орхив. Хааяа нэг яриа үүсэвч ганц хоёрхон минут үргэлжлэх ба хуурай хоосон ажээ. Нөгөө шулам буюу очир алмаз зочин гийчнийг захиран ноёрхсон байв. Ахайтан босож, эрчүүдийг дарстай нь орхин гарах дохио эмэгтэйчүүдэд өгөх үед бүгдийнх нь сэтгэл хөнгөрөх шиг болжээ.

Миний бие тэр оройн зоог дээр гэрийн эзнийг орлож байсан Эблвайт өвгөний өмнө галуун хүзүүт өрөөд дуусаж байтал дэвсгийн зүгээс гарсан дуунаас би учиргүй почин балмагдаж, дээдсийн намба төрхөө агшин зуур алдчихав. Мистер Фрэнклин бид хоёр өөд өөдөөсөө харав. Тэр бол энэтхэг дамрын дуу байлаа. Манайд Саран чулуу орж ирэхийн хамт нөгөө илбэчид бас ирснээс зайлахгүй гэж тангараглахад ч би бэлэн байв!

Дэвсгийн булан тойрон гараад ирэхэд нь тэднийг буцааж явуулахаар би яаран ухасхийсэн боловч хясахад, хоёр дуржигнуур надаас урьтжээ. Энэтхэг илбэчдийн ид шидийг үзэх гэж тэсэж ядсан эгч дүү хоёр дэвсэг дээр гарчээ. Эмэгтэйчүүд хойноос нь дагаж, эрэгтэйчүүд ч бас гарч ирэв. ↔Бурхан тэнгэр өршөө!≈ гэж хэлж амжихаас өмнө луйварчид хүмүүст мэхийн ёсолж, дуржигнуурууд хөөрхөн хөвгүүнийг үнсч байлаа.

Мистер Фрэнклин мисс Рэчелийн хажууд, би ард нь зогсов. Бидний сэжиглэл үнэн байсан бололтой, энгэр дээрээ очир алмаз зүүсэн Рэчел энэтхэгчүүдийн өмнө өчүүхэн ч сэжиггүй зогсож байлаа!

Гурван энэтхэг ямар илбэ хэрхэн үзүүлснийг би хэлж чадахгүй. Хоол олиггүй өнгөрсөнд урам хугарч, очир алмазыг өөрийн нүдээр үзэх гэж амжиж ирсэн луйварчдад уурласан миний бие бүр алмайрч орхисноо хүлээвэл зохино. Жуулчин Мэртвэт гэнэт гарч ирснийг л анх сэхээ аван ажигласнаа санаж байна. Зарим нь зогсож, нөгөө зарим нь сууж байсан зочдын хажуугаар чимээгүйхэн өнгөрч, илбэчдийн ард очоод гэнэт төрөлх хэлээр нь ярьж эхэлсэн юм. Мистер Мэртвэт тэднийг жадалчихлаа гэхэд тэр гурван энэтхэг дөнгөж ам нээмэгц нь цочиж, барс мэт шалмаг эргэж харсан шигээ тийм хурдан хөдлөхгүй байсан буй заа. Дараагийн эгшинд тэд мистер Мэртвэтэд тун найрсаг, хүлцэнгүй мэхийн ёслов. Мэртвэт тэдэнтэй хачин хэлээр хэдэн үг солиод ирсэн шигээ чимээгүйхэн явчихав. Хэлмэрчийн үүрэг гүйцэтгэж байсан ахлагч илбэчин үзэгчдийн зүг эргэн харахад хүрэн бор царай нь үнсэн саарал болчихсон байхыг би ажигласан юм. Ахайтны зүг мэхийгээд үзүүлэх тоглолт дууссан гэж мэдэгдлээ. Дуржигнуурууд өгүүлшгүй ихээр гутарч, ↔О!≈ хэмээн уулга алдацгаан мистер Мэртвэтийг тоглолт зогсоочихлоо гэж зэмлэж гарлаа. Ахлагч илбэчин цээжин тушаа гараа доожоогүй зөрүүлээд тоглолт дууссан гэж дахин хэлэв. Нөгөө жаал хүү малгайгаа тосон тойрон явав. Эмэгтэйчүүд зочдын өрөө рүү зүглэж, Фрэнклин Мэртвэт хоёроос бусад эрэгтэйчүүд дарс уухаар орлоо. Миний бие зарцын хамт энэтхэгчүүдийг эдлэнгээс гаргаж өгөхөөр хойноос нь дагав.

Цэцэрлэг дундуур буцаж явтлаа тамхины утаа үнэртэж, улмаар мистер Фрэнклин ороомол навчин тамхи татаж буй мистер Мэртвэт хоёр моддын хооронд хойш урагш аажуухан алхаж явааг олж харлаа. Фрэнклин намайг хүрээд ир гэж дохив.

□ Энэ хүн бол миний танд ярьж байсан Габриэл Бэттереж, өвгөн зарц, манай гэр бүлийн нөхөр юм хэмээн намайг агуу их жуулчинд танилцуулаад, □ Та дургүйцэхгүй бол түрүүхэн надад ярьсан зүйлээ хэлээд өгөөч гэв.

Мистер Мэртвэт амнаасаа тамхиа авч, нөгөө л ядрангүй байдлаараа мод налан зогсоод ,

□ Бэттереж гуай, тэр гурван энэтхэг та биднээс ялгаагүй илбэчид юм гэж яриагаа эхэллээ.

Бас нэг жигтэй зүйл гарах нь! Тэдэнтэй өмнө нь уулзаж байсан эсэхийг жуулчнаас асуулаа л даа.

□ Ер үгүй. Гэхдээ энэтхэгийн илбэчид ямаршуу улс байдгийг би андахгүй. Өнөө орой та бүхэн илбэчдийг дууриах гэж оролдсон тун ч эв дүйгүй болхи зүйл үзлээ. Би эндүүрээгүй л бол миний олон жилийн их туршлага тэднийг дээд зиндааны бярманууд гэж хэлж байна. Тэднийг илбэчид биш байна гэж хэлэхэд минь, энэтхэг хүн хэдийгээр сэтгэлийн хөдөлгөөнөө чадмаг нууж чаддаг ч тэр үг

яаж туссаныг та харсан биз дээ. Тэд нэг л биш, гэвч би тайлбарлаж чадашгүй нь. Тэд нэгдүгээрт, их далай гаталснаар, хоёрдугаарт, илбэчин болж зүсээ хувиргаснаар бярганы явцуу хүрээний ёсыг зөрчин нүгэл үйлдсэн байна. Ийм явдлыг нутагт нь аймшигт гэмт хэрэг гэж үзэх бөлгөө. Тэгэхээр хожим эх орондоо буцахад нь цагаатгаж нүглийг нь хэлтрүүлж, хүрээндээ багтаан авах бололцоо олгох маш ноцтой нэг шалтгаан байж таарна.

Би гайхан алмайрч мистер Мэртвэт нөгөө тамхиа баагиулав. Мистер Фрэнклин олон зан чанарынхаа дунд гуйван эргэлзэх шиг болсноо сая ам нээн нам гүмийг эвдэж өгүүлдүүн:

Мистер Мэртвэт танд огт сонирхолгүй байж болох ба миний бие гэр бүлийнхээ хүрээнээс халиахыг хүсэхгүй байгаа нэг хэрэг явдлыг өгүүлж таныг чилээхийг түвдэхгүй байхсан билээ. Гэвч таны яриаг сонсоод Вериндер ахай, түүний охин хоёрын тусын тулд танд хэргийн гогцоог атгуулж чадах хэдэн үг хэлэх нь зүйтэй гэж үзэж байна. Танд аминчлан нууцыг дэлгэж буйг минь та болгоох биз.

Ийм оршилтойгоор, Нуранги элсэнд надад өгүүлсэн бүхнээ ярьж эхлэхэд нь аймшиггүй жуулчин Мэртвэт тамхиа ч унтрахыг анзааралгүй туйлгүй сонирхон сонсож билээ.

За, таны туршлага үүнийг юу гэхсэн бол? хэмээн Фрэнклин ноён яриагаа дуусгаад асуув.

Фрэнклин Блэйк, би энэ насандаа тань шиг тэгж үхэлд ойр очсон удаагүй гэх байна. Энэ ч их учиртай үг юм шүү.

Одоо Фрэнклиний гайхах ээлж болжээ.

Үнэхээр тийм ноцтой юм гэж үү?

Би тэгж л бодож байна. Таны ярианаас үзвэл Саран чулууг Энэтхэгийн бурхны магнайд буцаан аваачих гэдэгт л бярганы ёсыг зөрчсөн шалтгаан, нүглийг нь наманчлах зүйл байгаа юм байна гэдэгт би эргэлзэхгүй байна. Энэ хүмүүс зорилгодоо хүрэх боломжийг муур шиг тэсвэртэй хүлээж, бар шиг хэрцгий ашиглах болно гээд агуу их жуулчин тамхиа асааж, Фрэнклинийг сүрхий ширтээд  Та яаж амьд гарсныг би ойлгохгүй юм. Та Лондонд байхдаа ч, энд ирээд ч тэр очир алмазыг ийш тийш авч явсан хэрнээ одоо хүртэл амьд явж байдаг! Алив, учрыг нь олох гээд үзье. Алмаз авах гэж Лондонгийн банк руу хоёр удаа очихдоо дандаа өдрийн цагаар явсан уу? гэж асуусанд,

Тийм гэж Фрэнклин хариулав

Гудамжинд хүн олонтой байсан уу?

Олон байсан.

Та, мэдээжээр, Вериндер ахайнд ирэх цагаа товлосон байсан биз дээ? Эндээс буудал хүртэл зэлүүд газар бий. Та товлосон цагтаа ирсэн үү?

Үгүй, товлосноосоо дөрвөн цагийн өмнө ирсэн.

Баяр хүргэхийг зөвшөөрнө үү! Тэр очир алмазыг эндхийн банканд хэдийд аваачиж хийсэн бэ?

Эднийд ирснээс нэг цагийн дараа буюу намайг энд ирнэ гэж хүлээж байснаас гурван цагийн өмнө аваачиж хийсэн.

Дахин баяр хүргэхийг зөвшөөрнө үү! Нааш нь авчрахдаа ганцаараа байсан уу?

Үгүй, үеэл ах дүү нар, нэг зарцтай хамт наашаа ирсэн.

Гурав дахь удаагаа баяр хүргэхийг зөвшөөрнө үү! Мистер Блэйк та, соёл иргэншилт нутгийн чанадад хэзээ нэгэн цагт явахаар болбол надад мэдэгдээрэй, хамт явъя. Та үнэхээр азтай хүн юм!

Миний гайхсан гэдэг жигтэйхэн. Иймэрхүү зүйлийг англи үеэл маань зөвшөөрөхгүй байв.

Боллоцоо олгосон л бол тэд очир алмазаа авахын тулд мистер Фрэнклиний амийг бүрэлгэх байсан гэж та хэлэх гэсэн юм биш биз? Гэж би асуулаа.

Бэттереж гуай, та тамхи татдаг уу? гэж жуулчин асуув.

Татдаг.

Та гансныхаа үнсийг унагахдаа харамсдаг уу?

Үгүй шүү.

Энэ хүмүүсийн эх оронд хүний амийг бүрэлгэхдээ гансны үнс унагаахаас өөрцгүй үздэг юм. Очир алмазаа эргүүлж авах замд нь мянган хүн саад болж, тэр мянгыг цээрлэл үзэлгүйгээр чадна гэж үзвэл цөмийг нь алахдаа ер сийхгүй. Зиндаа хүрээгээ золиослоно гэдэг энэтхэг тун ноцтой хэрэг, харин амь нас золиослох бол ёстой юу ч биш.

Миний бие тэгэхэд нь алуурч, хулгайч нарын бүлэг яваа юм болов уу гэж бодсоноо хэлсэнд, Мэртвэт тэднийг нэг л жигтэй улс гэж бодож буйгаа хэлэв.

Фрэнклин ямар ч санал онол хэлсэнгүй, харин биднийг ажил хэрэгт буцаан оруулж,

Тэр хүмүүс, мисс Вериндерийн энгэр дээр Саран чулуу байхыг үзсэн дээ. Одоо яах билээ? гэв.

Авга ахынхаа сүрдүүлгийг хэрэгжүүл. Хурандаа хэнтэй холбогдсоноо сайн мэдэж байж. Маргааш очир алмазыг (нэгээс илүү хүнээр харгалзуулан) Амстердам руу явуул. Тэнд зургаа, долоон

хэсэг хуваалга. Энэтхэгийн ариун шүтээн болсон Саран чулуу нэгэнт үгүй болбол аюул занал нь ч эцэс болно шүү дээ гэж Мэртвэт хариу өгүүлэв. Фрэнклин эргэж, надад хандан,

Ингээд тусгүй. Бид маргааш мисс Вериндертэй ярилцах хэрэгтэй гэлээ.

Өнөө шөнө яах вэ, эрхэм ээ? Энэтхэгүүд эргээд ирвэл яах болж байна? гэж би асуув.

Мистер Мэртвэр урьтан,

Өнөө шөнөдөө ирж зүрхлэхгүй. Өчүүхэн алдаанаас сүйрч болох энэ хэргийг ярихаа байя гэхэд, ер нь аливаа зүйлийг шууд шулуун замаар гүйцэтгэх нь үгүй хэмээлээ.

Гэвч энэ луйварчид таны санаснаас хавьгүй зүрхтэй улс юм биш байгаа даа, эрхэм ээ? Гэж би хаширлан асуув.

Тэгвэл нохойгоо тавь. Танайд том ноход бий биз дээ?

Хоёр бий. Нэг бух нохой, нэг эрүүлч нохой бий.

Хангалттай. Ийм бух, эрүүлч ноход нэг сүрхий сайн чанартай байдаг юм. Хүний амь бусниулахыг үл тэвчдэг танай сэтгэлийг гонсойлгохгүй.

Тийнхүү надад үг хаяж байхад нь зочны өрөөнөөс төгөлдөр хуурын аялгуу сонсогдсонд тамхиа хаячихаад эмэгтэйчүүд рүү очихоор мистер Фрэнклинийг сугадав. Миний бие тэдний хойноос байшин өөд явахдаа тэнгэр тун түргэн бүрхэж байхыг ажиглав. Мистер Мэртвэт ч бас ажиглажээ. Миний зүг хэнэггүй, шооч зангаараа эргэн хараад,

Бэттереж гуай, өнөө шөнө энэтхэгүүдэд шүхэр хэрэг болох нь ээ! гэв.

Түүнд ч инээд байлаа! Гэтэл миний биее агуу жуулчин ч биш, энэ насандаа далайн чанадад гарч, хулгайч, алуурчдын дунд амь наана, там цаана явсан минь үгүй. Муу умгар өрөөндөө орж, түшлэгт сандал дээрээ хөлсөө асгаруулан яахаа ч мэдэхгүй, арчаагүй гайхашран суув. Өөр хүмүүс сэтгэлийн ийм хямралд орвол бүр цухалдаж дуусах байсан биз. Харин би өөрөөр шийдсэн юм. Гансаа гарган тамхи нэрж, ↔Робинзон Крузогоо≈ сөхөн хараад, таван ч минут болоогүй байтал зуун жран нэгдүгээр хуудсанд,

↔Нүдээр хараагүй цагт аюул мянга дахин аймшигтай санагддаг бөгөөд сэтгэлийн дарамт маань биднийг зовоож буй гай гачлангаас хавьгүй хэтэрсэн байдгийг бид олж мэднэ≈ гэсэн их л оновчтой мөр тааралдаж билээ.

Үүний дараа ↔Робинзон Крузод≈ итгэхгүй хүн бол эсвэл тархинд нь эрэг боолт дутуу, эсвэл биеэ тоох өвчинд нэрвэгдсэн этгээд биз! Тийм хүнд баталж, нотлохыг орхиж, арай итгэмтгий хүнд зориулсан нь дээр буй заа.

Цай өгч үйлчилж байсан Пенилоп зочны өрөөний сонинг дуулгахаар ирэх үес би гансандаа хэдийн дахин нэг тамхи нэрж татчихаад гайхамшигт номоо шагшсаар сууж байв. Дуржигнуураад хөгжим даган мөн л том ↔О≈-гоор эхлүүлэн хоршин дуулж байхад нь Пенилоп гарч иржээ. Ахайтан хөзөр тоглож байхдаа урьд нь гаргадаггүй алдаа гаргаж байхыг нь ажигласан гэнэ. Их жуулчин нэг буланд унтаж байсан гэнэ. Фрэнклин Годфрийн эмэгтэйчүүдийн хорооны ажлыг нь дайруулан даажигнаж, Годфри зөөлөн зан аалиараа алдаршсан эрхэм гэхэд арай л хэгжүүн, хурц хариу өгч байхыг нь сонссон гэнэ. Мисс Рэчел Тридголл авгайг тайвшруулах гэж гэрэл зураг үзүүлж буй мэт харагдавч үнэн хэрэг дээрээ ямар ч ухаалаг шивэгчин огт эндүүрэхээргүй, хулгай нүдээр мистер Фрэнклинийг ширтэн байхыг нь ажиглажээ. Эцэгт нь, зочны өрөөнөөс сэм гарч яваад мөн л сэм орж ирсэн Канди эмчийг, мистер Годфритэй аминчлан ярилцаж байхыг олж харсан гэнэ. Ерөнхийдөө, байдал санасныг бодвол хоолны үеийнхээс овоо дээрдсэн ажээ. Дахиад ганцхан цаг л өнгөрчихвөл өвгөн буурал Цаг хугацаа гийчдийн маань тэргийг аван одож, биднийг зочдоос ангижруулах юм.

Ертөнцийн юм бүхэнд төгсгөл байдаг хойно, Пенилопыг явсны дараа ↔Робинзон Крузогийн≈ сайхан нөлөө хүртэл өнгөрчээ. Дахиад л сэтгэлийн тав алдагдаж, борооноос өмнө хавь орчноо эргэн тойрохоор шийдлээ. Ямар нэг хэрэг тохиолдвол зарцын маань хамар тус болохгүйг бодолцон эрүүлч нохойгоо авч явав. Гадны улс байвал үнэрийг нь андахгүй гэж найдсан минь тэр. Бид хоёр байраа тойрчихоод зам дээр гарч, нуугдаж хоргодсон хүн хар ч илрүүлсэнгүй, явсан шигээ л хоосон буцаж ирлээ.

Би нохойгоо гинжилчихээд бутан дундуур буцаж явтал, зочны өрөөнөөс гарч яваа хоёр эрхэмтнийг харав. Канди эмч, мистер Годфри хоёр байлаа. Пенилопын хэлсэн нь үнэн болж, ямар нэг хөгийн юм бодож олсон бололтой аяархан инээлдэж хоорондоо хүүрнэлдсээр явна. Тэр хоёрыг ийнхүү төө зайгүй болсонд нь гайхсан авч, хараагүй дүр үзүүлэн хажуугаар нь өнгөрөв.

Зочдын сүүх тэргүүд хүрэлцэн ирэхэд бороо ч асарав. Шөнөжин цутгах асарч гарав. Хоёр дугуйт задгай тэргээ хүлээлгэсэн доктороос бусад гийчид бүрхүүлтэй тэргэндээ морилон гэрийн зүг их л тухтай одоцгоов. Мистер Кандийг нэвт норчих вий дээ гэсний хариуд, эмч хүний арьс ус нэйтэрдэггүй юм гэдгийг өдий их наслахдаа мэдээгүй яваа хэрэг үү хэмээн гайхаж байгаагаа хэлэв.

Тэгээд өөрийнхөө шог үгэнд баясан хөхөрсөөр усан борооноор хөдлөв. Бид зочдоо ийм байдлаар үдлээ. Одоо тэр шөнийн явдлыг өгүүлсүгэй.

## XI бүлэг

Зочдоо үдчихээд Сэмюэл хажуугийн ширээнд соодтой шарз бэлтгэж байсан дотоод танхимд буцаж оров. Ахайтан Рэчел нар хоёр залуу эрхмийн хамт зочны өрөөнөөс орж ирлээ, Годфри соодтой устай шарз ууж, Фрэнклин юу ч уусангүй. Үхтлээ ядарчихсан царайтай амьтан суув. Энэ төрсөн өдрийн баяраар хэтэрхий их ярьж хөөрсөн бололтой.

Ахайтан тэдэнд сайхан нойрсохыг ерөөхөөр эргэн харахдаа охиных нь энгэр дээр гялалзан буй хүний мөсгүй хурандаагын бэлгийг анхааралтай ширтээд, Рэчел өнөө шөнө чи очир алмазаа хаана тавих гэж байна? гэж асуув.

Залуу охид өдөржингөө жигтэйхэн хөөрч догдолсондоо болоод утгагүй хөгийн юм ярьж ухаалаг зөв юм хэлчихсэн мэтээр түүнээ гөжүүдлэн хамгаалдгийг та анзаарсан байж болох юм. Рэчел яг тийм хөөрүү сэтгэлтэй байлаа. Эхлээд очир алмазаа хаана хийхээ мэдэхгүй байна гэлээ. Дараа нь, бусад юмтайгаа хамт тольтой ширээн дээрээ тавилгүй яахав гэв. Тэгснээ харанхуйд очир алмаз сар шиг хачин их гэрэл цацруулдгийг санаад шөнө өөрөө айж мэднэ гэж боджээ. Тэгтэл зочныхоо өрөөнд байдаг энэтхэг шүүгээг санамагц харь орны хоёр сайхан бүтээл бие биеэ сонирхог хэмээн энэтхэгийн алмазыг энэтхэгийн шүүгээнд хийе гэж шийджээ.

Хонгор охин минь! Энэтхэг шүүгээ чинь түгжигддэггүй шүү дээ гэж ахайтан хэлэв

Тэнгэр минь, ээж ээ! Бид зочид буудалд байгаа биш. Манайд хулгайч байгаа хэрэг үү? Гэж мисс Рэчел дуу алдлаа.

Ахайтан охиныхоо адархыг тоосон ч үгүй залуу эрхмүүдэд тавтай нойрсохыг ерөөв. Дараа нь Рэчел рүү эргэж үнсээд, Өнөө шөнө очир алмазаа ээждээ хадгалуулж болохгүй юм уу? гэж асуув.

Арван жилийн өмнө мисс Рэчелийг шинэ хүүхэлдэйгээс нь салгана гэвэл яг л иймэрхүү янзтай байх байсан биз. Хатагтай энэ үдэш охиноо яавч итгэж дийлэхгүйгээ ойлгож, Рэчел, өглөө босонгуутаа миний өрөөнд ороорой. Хэлэх юм байна хэмээгээд биднийг орхин үзтэл сэтгэлд тавгүй бодолдоо дарагдан аажуухан гарч явав.

Араас нь мисс Рэчел ч гарахаар завдаж, эхлээд танхимын цаад өнцөгт зураг үзэн зогсож байсан мистер Годфри руу очиж гар барив. Дараа нь буланд дуу шуугүй ядарч тамирдан суусан мистер Фрэнклин рүү очлоо.

Чухам юу ярилцсаныг би хэлж чадахгүй. Гэвч унтахаар явахын өмнө царсан хүрээтэй том толины ойролцоо саатан зогсоод палаажныхаа энгэрийн цаанаас Фрэнклиний бэлэглэсэн зүүлтийг сэм гарган Фрэнклинд харуулж, учиртайхан инээмсэглэх нь толинд тусаж харагдсан юм. Эл байдал миний урьдын итгэлийг баахан сулруулж ер нь Пенилоп залуу эзэгтэйнхээ сэтгэлийг зөв гадарласан болов уу гэсэн бодол төрж билээ.

Харцыг нь татан байсан мисс Рэчелийггарч одмогц Фрэнклин намайг харав. Ямагт хувирч байдаг зангаараа энэтхэгүүдийн талаарх бодлоо хэдийн өөрчилж амжсан байжээ.

Бэттереж гуай, бид цэцэрлэгт ярилцах үед мистер Мэртвэтийн үгийг би дэндүү сүртэйгээр ойлгосон гэж бодоход бэлэн байна. Жуулчдын сайрхуу зангаар үлгэр зохиож, бидэнд гайхуулсан юм биш байгаа даа?

Та үнэхээр нохдоо тавья гэж бодож байна уу? гэлээ.

Хүзүүвчийг нь салгаад гадны хүний үнэр авч чадах л юм бол өнөө шөнөдөө сул тавьчихая гэж би хариу өгүүлэв.

Зүйтэй. Цаашид явал зохихыг маргааш харан байж больё. Ноцтой шалтгаан үгүй байхад нагац эгчийнхээ сэтгэлийг үймүүлье гэж ер бодохгүй байна. Сайхан нойрсоорой.

Тийн өгүүлээд толгой дохихдоо их л ядарч цонхийсон мэт санагдсан учраас дээд давхарт гарахаар явахад нь унтахынхаа өмнө соодтой шарз уухыг зүрхлэн зөвлөсөн юм. Танхимын цаад үзүүрээс бидэн дээр ирсэн мистер Годфри намайг дэмжин орондоо орохоос өмнө юм уу хэмээн эелдгээр ятгаж гарлаа.

Энэ өчүүхэн явдлыг өгүүлсний учир бол, тэр өдөр миний үзэж, сонссон бүхний дараа ч манай хоёр залуу эрхэм урьдын хэвээр найрсаг харилцаатай байгааг харахад надад таатай байсан билээ.

Зочны өрөөнд Пенилопын сонссон хоорондоо хаялцсан үгс мисс Рэчелийн тааллыг хүртэх гэсэн оролдлого нь ноцтой зөрөлдөөн үүсгэсэнгүй ажээ. Ер нь ч хоёул тун сайхан зантай, ихсийн хүрээлэнгийн залуус шүү дээ. Дээд зиндааны улс доодсуудын адил хэрүүл маргаан хийцгээдэггүй сайн талтай байдаг юм.

Мистер Фрэнклин шарз ухаас татгалзаад мистер Годрфитэй хамт дээшээ явав. Тэдэнд зэргэлдээ өрөө гаргасан байлаа. Замдаа үеэл нь ятгасан ч юмуу, бас л эргэлзэж санаагаа өөрчилж амжсан ч юмуу ямар боловч шатан дээрээс надад,

□ Шөнө би ууж магадгүй. Миний өрөөнд соодтой шарз явуулчихаарай гэв.

Би Сэмуэлд шарз өгч явуулаад, гадагш гарч хоёр нохойгоо тавив. Ийм шөнийн цагаар сул тавьсанд ноход маань учиргүй гайхан над руу бяцхан гөлөг мэт үсчин байлаа! Гэвч төдөлгүй бороонд норж даараад номхорч, жаахан ус уугаад хонууртаа буцаж орлоо. Миний бие харих замдаа тэнгэр цэлмэг шинжийг олж харсан юм. Харин одоохондоо ширүүн бороо цутгаж, газраар нэг шавар шалбааг болж байв.

Сэмуэл бид хоёр заншил ёсоор байшингаа эргэж тойроод үүд хаалгаа түгжив. Энэ удаад туслахдаа ч итгэн даатгахыг түвдэн би бүхнийг өөрийн биеэр шалгасан билээ. Үүд хаалгаа ян тан цоожлоод зовлогоо амраахаар шөнө дүл өнгөрсөн хойно орондоо хэвтлээ.

Өдрийн эсэн бусын явдалд миний бие зэгсэн их хэл мэгдсэн бололтой. Юу боловч мистер Фрэнклиний муу оёг тэр шөнө надад халдаж орхиод үүр хаяарахад нэг юм дугхийсэн болов. Эргэж хөрвөөн сэрүүн хэвтэж байхад байшин булш мэт нам гүм байлаа. Бороо шаагих, өглөөний сэвэлзэх салхинд мод шуугихаас өөр чимээ үл сонсогдоно.

Долоо хагасын үед би сэрж цонхоо нээв. Нарлаг сайхан өдөр болжээ. Найман цаг цохиход миний бие нохдоо гинжлэхээр гартал ард, шатан дээр эмэгтэй хүний банзлын хормой сэржигнэх дуу гарлаа. Эргэн харвал Пенилоп галзуурсан мэт уруудан айсуй.

□ Аав аа! Дээшээ гараад ир, бурхан минь! *Алмаз алга болчихож* хэмээн чарлав.

□ Чи чинь солиороо юу? гэж би асуулаа.

□ Байдаггүй! Яаж алга болсныг хэн ч мэддэггүй! Хүрч ирээд хар л даа!

Тийн өгүүлээд намайг чангаасаар залуу эзэгтэйн унтлагын өрөөний цаана байдаг зочны өрөөнд дагуулан оров. Унтлагын өрөөнийхөө босгон дээр өмссөн бошинз шигээ цайж цонхийсон мисс Рэчел зогсож байлаа. Энэтхэг шүүгээний хаалганы хоёр хавтсыг цэлийтэл дэлгэж, нэг шургуулгыг нь бараг сугалаад орхижээ.

□ Хараач! Мисс Рэчел урьд шөнө энд очир алмазаа хийж байхыг би нүдээрээ харсан юм гэж Пенилоп өгүүлэв.

Би шүүгээ рүү очив. Шургуулга хоосон байлаа.

□ Энэ үнэн үү, авхай? Гэж би асуусанд царай нь танихын аргагүй хувирч харц нь өөр болсон мисс Рэчел миний охины нэгэн адил ↔ *Алмаз алга болчихож!* ~ гэж хачин өөр дуугаар хариулав. Тийн хэлчихээд унтлагын өрөөндөө орж үүдээ түгжив.

Биднийг хэрхэхээ шийдэж ядан байтал, охиныхоо зочны өрөөнд миний дуу гарахыг сонссон Вериндер ахай орж ирээд, юу болсныг асуулаа. Алмаз алдагдсан гэдэг мэдээг дуулаад мэл гайхаж, цэл хөхөрчээ. Тэгснээ мисс Рэчелийн унтлагын өрөө рүү даруйхан очиж, оруулахыг шаардсанд орууллаа.

Энэ түгшүүрт мэдээ манай байшингаар түймрийн гал шиг тархан хоёр залуу эрхмийн сонорт хүрчээ.

Мистер Годфри эхлээд өрөөнөөсөө гарч ирлээ. Юу болсныг сонсоод гайхан шагширч байгаа нь түүний зоримог занг төдийлөн илтгэж чадсангүй. Мистер Фрэнклинийг ухаалаг болохоор бидэнд зөвлөгөө өгөх биз хэмээн баттай найдаж байтал уг мэдээг сонсоод үеэл ахынхаа нэгэн адил арчаагүй болчихлоо. Гайхалтай нь гэвэл, урьд шөнө мистер Фрэнклин хачин сайхан унтжээ. Эл ер бусын амралт толгой мансууруулчихлаа гэж байв. Гэвч гадаадынхны заншлаар өглөөний цайнаас хэдэн цагийн өмнө үргэлж уудаг кофеноосоо нэг аяга уугаад толгой нь сэргэж, төрөлхийн саруул ухаанаараа сэтгэж шийдмэг мэргэн арга хэмжээ авсныг өгүүлсүгэй.

Юуны түрүүнд зарц нарыг дуудуулж авчраад доод давхрын бүх үүд хаалгыг (миний онгойлгосон гол хаалгаас бусад) өнгөрсөн шөнө цоожилсон хэвээр нь байлгахыг тушаав. Дараа нь цаашид ямар нэг алхам хийхийн өмнө алмаз хаа нэгтээ жишээлбэл, шүүгээний араар ч юмуу, эсвэл шүүгээ дээр нь байгаа ширээн доогуур уначихсан байж юу магад вэ, үзье гэж мистер Годфри бид хоёрт хэллээ. Нөгөө газруудаар эрж хайгаад юу ч эс олсноос гадна Пенилопоос бас асуугаад урьд нь надад хэлж байснаас илүү юм мэдээгүй тул мистер Фрэнклин мисс Рэчелээс лавлаж асуухаар шийдэж, Пенилопыг явуулав.

Пенилоп мисс Рэчелийн унтлагын өрөөний үүдийг тогшсонд Вериндер ахай онгойлгож гараад хаав. Төдхөн мисс Рэчел дотроос нь түгжих сонсогдов. Эзэгтэй маань биднийг илт мэгдэж, харамссан янзтай хараад,

□ Алмаз алга болсонд Рэчел бүр балмагдаж орхижээ. Яагаад ч юм энэ тухай надтай ч ярих хүсэлгүй байна. Та одоохондоо түүнтэй уулзана гэж санахын ч хэрэггүй биз ээ гэж Фрэнклиний асуусны хариуд өгүүлэв.

Рэчелийн байдлыг ийнхүү мэдэгдэж биднийг бүр ч мухардуулчихаад ахайтан жаахан хүч гарган биеэ барьж, тайван хэнэггүй байдалдаа ороод ердийн шийдмэг зангаараа ажиллаж эхэлсэн юм.

□ Одоо юу ч тус болохгүй. Цагдаагийн газар мэдэгдэхээс өөр юмгүй гэж би бодож байна хэмээн тайван өгүүлсэнд Фрэнклин үгий нь өлгөн авч,

□ Цагдаагийн газар юуны өмнө урьд шөнө тоглолт үзүүлсэн энэтхэг илбэчдийг баривчилбал зохино гэв.

Ахайтан, Годфри хоёр Фрэнклин бид хоёрын мэдэж буй зүйлийг гадарлах ч үгүй тул цочирдон мэл гайхацгаав. Фрэнклин цааш өгүүллүүн,

□ Одоо элдэв тайлбар хэлэх цаг алга. Харин тэр энэтхэгүүд очир алмазыг хулгайлсан гэдгийг л хэлж чадна гээд ахайтанд хандан, □ Фризинхоллын нэг шүүгчид, миний бие таны эрх ашиг, хүсэл зоригийг төлөөлж байгааг танилцуулсан захидал бичиж өгөөд, даруйхан мордохыг минь зөвшөөрнө үү. Бид ганц ч минут дэмий үрэхгүй бол хулгайч нарыг баривчлах боломжтой юм гэв. (Жич: франц, англи зангийнх нь аль нь ч давамгайлсан бай, мистер Фрэнклин тун зөв шийдсэн шиг санагдлаа. Гагцхүү энэ нь хэр удаан үргэлжлэх бол доо?).

Нагацынхаа өмнө үзэг, цаас, бэх авчирч тавьсанд түүний хүссэн захиаг Веридер ахай баахан дурамжхан (надад тэгж санагдсан юм) бичив. Хорин мянган фунтын үнэ цэнэ бүхий очир алмаз алдагдсан явдлыг тоохгүй өнгөрч болдогсон бол талийгаач ахынхаа талаарх сэтгэгдлээс нь ч, төрсөн өдрийн бэлгийг сэжиглэж байхаас нь ч үзсэн, хулгайч нар Саран чулууг аваад эсэн мэнд зайлбал ахайтан тэднийг зөнд нь дуртайяа орхих байсан биз. Миний бие Фрэнклинтэй хамт морины жүчээ рүү явахдаа эл боломжийг ашиглан түүнээс энэтхэгүүд (мэдээжээр, би ч бас эргэлзэхгүй сэжиглэж байв) байшинд хэрхэн орж чадав гэж асуулаа.

□ Зочдыг явах үеэр хөл үймээнийг ашиглан нэг энэтхэг нь байшинд сэмхэн орсон байж л дээ. Тэр этгээд буйдан доор нуугдаад нагац эгч, Рэчел хоёр очир алмазыг шөнө хаана хадгалах талаар ярилцахыг сонсчээ. Тэгээд хүмүүс унтаж, шүүгээнээс хэрэгтэй зүйлээ авах цагийг хүлээх л үлджээ гэж хэлчихээд мистер Фрэнклин зарцыг дуудаж, хаалга нээлгээд хатируулан одов.

Энэ бол үнэхээр ухаалаг тайлбар шиг санагдав. Гэвч хулгайч байшингаас хэрхэн зайлж чадав? Би өглөө босоод гол хаалга онгойлгохоор очиход урьд шөнө миний орхисон янзаар дангинатал цоожтой байсан, Бусад үүд хаалга, цонхны тухайд гэвэл эргэлзэх юмгүй, цөм ян тан түгжээтэй байлаа. Бас ноход байна. Хулгайч дээд давхрын нэг цонхоор харайж буусан гэж бодоход манай нохдоос хэрхэн мултарч гараа вэ? Хортой мах авч явсан юм болов уу? Ийн бодтол хоёр нохой маань нойтон өвсөн дээр хөрвөөн тоглосоор эрүүл саруул, хөгжилтэй цовоогоор булан тойрон давхилдаж айсуу. Тэднийг барьж, гинжлэх гэж багагүй зүдэрч билээ. Бодох тусам мистер Фрэнклиний тайлбарт эргэлзэх минь ихсэв.

Бид өглөөнийхөө ундыг ууцгаалаа. Айлд дээрэм тонуул юмуу хүн амины хэрэг гарсан байсан ч цай ундаа уух л хэрэгтэй биз дээ. Цайны дараа ахайтан намайг дуудуулсан бөгөөд өдий хүртэл нууж явсан энэтхэгүүдийн тухай, тэдний хуйвалдааны тухай бүгдийг ярихад хүрсэн билээ. Их зоригтой хүүхэн болохоор миний мэдэгдсэн зүйлийг сонсоод анх төрсөн айдсаа төдөлгүй давсан юм. Тэр тэрслүү луйварчид болон тэдний хуйвалдаанаас илүүгээр охиных нь зан байдал ахайтны сэтгэлийг ихэд түгшээж байх шиг санагдав.

□ Рэчелийн хэчнээн хачин зантайг үеийн охидоосоо шал өөр авирладгийг та мэднэ шүү дээ. Гэвч ийм жигтэйхэн, ингэтэл дуугаа хураасан байхыг нь би энэ насандаа үзээгүй. Эрдэнийн чулуу алга болсон явдал бүр ухааныг нь балласан бололтой. Тэр аймшигт чулуу ийм богино хугацаанд түүнийг ингэтлээ илбэдчих юм гэж хэн санах билээ? гэж Вериндер ахай өгүүлэв.

Үнэндээ ч хачин байлаа. Мисс Рэчел ер нь элдэв тоглоом, үнэ цэнэтэй юманд ихэнх залуу бүсгүйчүүд шиг ухаан алдан дурлах нь үгүй. Гэтэл энэ зуур тайтгаршгүй уй гасланд дарагдсан мэт унтлагынхаа өрөөнд түгжээд суусаар байв. Манай байшинд ганцхан мисс Рэчел барьц алдсан гэвэл хилс болно. Жишээлбэл мистер Годфри олныг аргадан тайтгаруулдаг мэргэжлийн хүн атлаа одоо учраа олохоо больжээ. Зовлонд учирсан эмэгтэйчүүдийг тайтгаруулдаг туршлага чадвараа Рэчелийн эрх ашигт хэрэглэх бололцоогүй, ганцаардсан Годфри байшин, цэцэрлэгээр ямар ч зорилгогүй, хэцүүхэн байдалд орсон хүний шинжтэй ийш тийш холхин байлаа. Бидэнд золгүй явдал тохиолдсоны дараа хэрхвэл зохихыг мэдэхгүй тээнэгэлзэж байжээ. Ийм байдалд нь орхиод зочны хувиар явах уу,

эсвэл өчүүхэн ч гэсэн тус болж юу магад гээд үлдэх үү? Тийн эргэлзсээр эцэстээ иймэрхүү жирийн бус гай дайрсан нөхцөлд үлдвэл арай зохистой бөгөөд санаа тавьж буйгаа үзүүлсэн хэрэг болох юм гэж шийджээ. Нөхцөл байдал хүнийг шалгадаг Годфри тийм сорилт ороод миний бодож явснаас хавьгүй дорой болохоо харуулсан юм. Зарц хүүхнүүдийн тухайд гэвэл, зожиг Розанна Спирманаас бусад нь айлд ямар нэг этгээд сонин явдал гарахад байдагчлан хорвоогийн эмс хүүхнүүдийн ерийн зангаар булан мухарт шивнэлдэн энэ тэрийг сэжигтэй ажиглана. Би ч гэсэн догдолж бачимдаад ааш муутай байснаа хүлээе. Тэр гайтай Саран чулуу хамаг юм урвуулчихсан билээ.

Арван нэгэн цаг дөхөж байхад Фрэнклин эргэж ирэв. Бүхий л байдлаас үзвэл, түүний шийдмэг зан ногдсон үүрэгтээ дарагдан сарнижээ. Эндээс мориор хатируулан одсон бол одоо гэлдэрсээр ирэв. Явахдаа хатаасан болд шиг бат зоримог байснаа хагарсан гүзээ шиг шалчийгаад шалдаа буусан буцаж ирэв.

□ За, цагдаагийн газраас хүн ирэх нь үү? гэж ахайтан асуув.

□ Ирнэ. Миний араас шуугиулаад ирэх юм хэлсэн. Орон нутгийн цагдаагийн газрын ахлах байцаагч Сигрев хоёр хүнтэйгээ ирнэ. Хоосон ёсорхол! Ямар ч найдвар алга гэж мистер Фрэнклин өгүүллээ.

□ Юу! Нөгөө энэтхэгүүд зугтчихаж уу, эрхэм ээ? гэж би асуусанд

□ Хөөрхий золгүй амьтдыг дэмий шоронд хорьсон байна. Тэд саяхан төрсөн хүүхэд шиг гэмгүй улс байжээ. Тэдний нэг нь байшинд нуугдаж хоцорсон байх гэсэн миний таамаглал бусад таамаглалын нэгэн адил угаа болон замхарлаа гээд тэгж үлдэх ямар ч боломжгүй байжээ гэдэг нь батлагдсан хэмээн алдаагаа их л хангалуунаар цохон хэлэв.

Саран чулууны хэргийг үндсээр нь өөрчилсөн эл мэдээг сонсгон биднийг алмайруулж орхисон манай залуу эрхэм нагац эгчийнхээ шаардсан ёсоор сууж, бүрхэг яриагаа тайлбарласан юм.

Мистер Фрэнклин Фризинхолл хүртэл шийдэмгий байсан аж. Болсон хэрэг явдлыг шүүгчид дэлгэрэнгүй өгүүлсэн бөгөөд шүүгч түүнийг нэн даруй цагдаагийн газар руу явуулжээ. Эхний сураг мэдээгээр л энэтхэгүүд хотоос гарах гээгүй нь мэдэгджээ. Дараа нь тэр гурав орой арав, арван нэгэн цагийн үед жаал хөвгүүнийхээ хамт Фризинхоллд эргэж ирсэн тухай цагдаагийн газар мэдсэн байна. Цаг хугацаа зайг баримжаалан үзвэл манай өмнөх дэвсэг дээр илбэ үзүүлчихээд шууд буцсан нь батлагдсан байна. Бүүр сүүлд шөнө дунд тэдний буусан байшинд цагдаа нар эргүүл хийж яваад тэр гурвыг нөгөө хөвгүүнтэйгээ хамт байхыг харжээ. Миний бие хаалга үүдээ өөрийн биеэр шөнө дундын дараахан түгжсэн билээ. Энэтхэгүүдийн гэмгүйг батлах үүнээс илүү нотолгоо үгүй буй заа. Тэгэхээр тэднийг сэжиглэх үндэс ер үгүй гэж шүүгч хэлсэн байна. Гэвч цагдаагийн газраас газар дээр нь хэргийг мөрдөж байгаад, илбэчидтэй холбоотой ямар нэг зүйл илрүүлэх юм бол тэднийг хэрмэл тэнүүлчид хэмээн бидэнд хэрэгтэй гэж үзвэл хэд хоног хорьж болно гэжээ. Энэтхэгүүд мэддэггүйн харгайгаар хотын ямар нэгэн дэг журам зөрчсөн тул баривчилж болох шалтаг гаргажээ. Зөв хэрэглэж л чадаж байвал хууль ёсыг ч хүртэл ашиг сонирхолдоо нийцүүлж болдог. Тэрхүү хүндэт шүүгч бол ахайтны эртний найз ажээ. Өглөө шүүх ажлаа эхэлмэгц л энэтхэгүүдийг нэг долоо хоногийн хугацаатай ↔баривчилсан≈ гэнэ.

Фризинхоллд болсон явдлыг Фрэнклин ийнхүү өгүүллээ. Эрдэнийн чулуу алдагдсан нууцын бидний гарт орсон энэтхэг түлхүүр хугарчээ гэдэг нь энэ бүхнээс илт болов. Хэрэв илбэчид энэ хэрэгт буруугүй юм бол мисс Рэчелийн шүүгээнээс Саран чулууг чухам хэн авсан байж таарах вэ?

Арваад минутын дараа ахлах байцаагч Сигрев ирэхэд бидний сэтгэл хачин их уужирч билээ. Дэвсэг дээр наранд ээн сууж байсан Фрэнклиний (түүний итали зан давамгайлаад байсан бололтой) хажуугаар цагдаа нар гарахад мөрдлөг эхлээ ч үгүй байсан атал мөрдөж сурвалжлаад юу ч олохгүй гэж тэдэнд сануулсан гэж мистер Сигрев мэдэгдэв.

Манайх шиг ийм байдалд орсон айлд, Фризинхоллын ерөнхий байцаагч шиг сайн мөрдөгч олдохуйяа бэрх. Мистер Сигрев бол өндөр чацтай, цэрэг хүний шалмаг, цэмцгэр байдалтай, захирангуй сайхан дуутай, тун шийдмэг харцтай эр бөгөөд бууных нь савхин гэрийг хүрсэн товчоо ганган гэгч ирийтэл товчилсон дүрэмт хувцас өмсчээ. ↔Би бол та бүхний хүсэн хүлээсэн хүн байна!≈ гэж ёстой л нүүрэн дээрээ бичээстэй байв. Хамт яваа доод тушаалын хоёр цагдаатай хатуухан харьцахыг хараад түүнийг даажигнах гэвэл сайнаа үзэхгүй гэдэгт бид итгэсэн бөлгөө.

Эхлээд манай байшинг гадна дотногүй нягтлан шалгасны дүнд хулгайч гаднаас нэвтрэн ороогүй, тэгэхээр байшинд байсан хүн л хулгай хийжээ гэсэн дүгнэлтэд хүрэв. Энэ албан ёсны мэдэгдэл сонорт нь хүрэхэд зарц нар ямаршуу байдалд орсныг та төсөөлөөд үз л дээ. Ахлах байцаагч юуны түрүүнд авхайн зочны өрөөг нэгжиж, дараа нь зарц нарыг байцаахаар шийджээ. Тэгэхдээ зарц нарын унтлагын өрөөний үүдний шатан дээр нэг хүнээ зогсоож, өөр захирамж өгтөл байшинд байгаа улсаас хэнийг ч бүү оруул гэж тушаав.

Эл сүүлчийн тушаал эмэгтэйчүүдийг бүр галзууруулах дөхөв. Булан мухраасаа үсрэн гарч, мисс Рэчелийн өрөө рүү дээш харайлдан (энэ удаа Розанна Спирман хоморгонд нь оржээ) байцаагч Сигрев өөд дайран ороод, бүгдээрээ гэмшсэн царайтай хэнийг нь сэжиглээд байгааг хэлэхийг шаардаж эхлэв.

Ахлах байцаагч барьц алдсангүй, тэднийг зоримог харцаараа ширтэн, сүрлэг дуугаараа зүрхийг нь мохоожээ.

Алив хүүхнүүдээ бүгдээрээ доошоо буцаж оч! Би та нарыг ир гээгүй шүү. Сайхан мэдээрэй! Гэснээ мисс Рэчелийн өрөөний зурж чимэглэсэн хаалганы цоожны доохинтой халтартсаныг заагаад  Та нарын банзлын хормой яаж балласныг хараач. Зайлцгаа, зайлцгаа! гэв.

Байцаагчийн хажууханд хаалганд хамгийн ойр зогсож байсан Розанна Спирман бусдадаа үлгэр үзүүлэн дуулгавартайяа холдож, ажилдаа даруйхан орлоо. Шивэгчингүүд ч түүний жишээг дагав. Байцаагч өрөөг шалгаж дуусаад юу ч илрүүлсэнгүй бөгөөд хулгай орсныг хэн хамгийн түрүүнд мэдсэн бэ гэж надаас асуув. Миний охин эхлээд мэдсэн байлаа. Охиныг минь дуудуулахаар хүн явуулав.

Эхлээд байцаагч Пенилоптой яггүй ширүүн харьцаж байв.

Залуу бүсгүй минь, та намайг анхааралтай сонс. Үнэн зөв ярих хэрэгтэйг бүү март! Гэсэнд Пенилоп улсхийн уурлаж,

Цагдаа гуай, би худлаа ярьж сураагүй. Охиныг нь гүтгэж, хулгайд сэрдэн, өрөөнд нь оруулахгүй, хөөрхий бүсгүйн ганц эрхэмлэдэг сайн нэрийг нь гутааж буйг эцэг маань энд зогсоод харж, сонсож чадаж байгаа бол миний бодож явсан шиг тийм сайн эцэг биш байжээ! гэлээ.

Миний зүгээс цагийг нь олж хэлсэн үг хууль зүй, Пенилоп хоёрын харьцааг нааштай болгосон юм. Асуулт, хариулт хэвийн явагдаж, дууссан бөгөөд энд давтан өгүүлэх хэрэггүй гэж бодно. Урьд шөнө мисс Рэчел очир алмазаа шүүгээнд хийж байхыг миний охин харжээ. Өнөө өглөө найман цагт мисс Рэчелийн аягатай цайг барьсаар орж иртэл шүүгээ онгорхой, хоосон байжээ. Үүнийг хармагц Пенилоп түгшүүр зарласан байна. Пенилопын үзсэн харсан гэвэл ердөө л энэ байлаа.

Дараа нь ахлах байцаагч мисс Рэчелтэй ярилцахыг хүсэв. Пенилоп эл хүсэлтийг нь хаалганы наанаас уламжилсанд ↔Цагдаад хэлээд байх юм алга. Би хэнтэй ч уулзаж чадахгүй≈ гэсэн хариуг хаалганы цаанаас өгөв. Ийм хариу авсан хашир байцаагч гайхаж гонсойсон бололтой харагдахаар нь манай залуу авхайн бие тааруухан байгаа, жаахан хүлээнээд дараа уулзаач гэж би учирлан гуйлаа. Тэгээд бид дахин доош буутал үүдний тасалгаанд Годфри, Фрэнклин хоёртой тааралдав.

Манай гийчин хоёр эрхмээс хэрэг явдалд тус болчихоор юм хэлж чадах эсэхийг асуув. Хэн нь ч юу ч мэдэхгүй гэв. Урьд шөнө сэжигтэй чимээ анир сонссон уу гэвэл, бороо шаагихаас өөр чимээ сонсоогүй гэлээ. Тэднийг унтсанаас хойш удтал сэрүүн хэвтсэн миний бие элдэв дуу чимээ сонссон билүү? Юу ч сонсоогүй! Байцаалтаас сая нэг мултарсан Фрэнклин ( цөхөрч, аргаа барсан хэвээр л байв),

Энэ хүн бидэнд ямар ч тус болохгүй, Ахлах байцаагч Сигрев бол ёстой л илжиг байна гэж надад шивнэж билээ.

Годфри байцаалтаас мултарч ирээд,

Бэттерез гуай энэ ажлаа мэддэг сүрхий хүн бололтой! Би тун их найдаж байна гэж надад шивнэн хэлэв.

Толгой бүхэн өөрийн бодолтой гэж эрт цагт нэгэн эрдэмтэй хүн хэлжээ.

Дараа нь мистер Сигрев Пенилоп бид хоёрыг дагуулан авхайн өрөө рүү явлаа. Шөнө тавилга хөдөлгөсөн эсэхийг шалгах гэсэн юмсанж. Үүний өмнө үзэж шалгасан боловч юу ч ололгүй сэтгэл дундуур үлдсэн бололтой.

Биднийг сандал, ширээний хооронд эргэлдэж байтал унтлагын өрөөний хаалга гэнэт онгойв. Бидэнтэй уулзахаас татгалзаж байсан мисс Рэчел өөрөө гарч ирсэн нь туйлын гайхалтай байв. Сандал дээрээс малгайгаа аваад шууд Пенилоп руу очиж,

Өнөө өглөө Фрэнклин надад танаар зурвас өгүүлсэн үү гэж асуулаа.

Тэгсэн авхай.

Надтай ярилцах гээ юү?

Тийм ээ, авхай.

Одоо хаана байна?

Дэвсэг дээр гарах чимээнээр миний бие цонхоор харвал хоёр залуу эрхэм хойш урагш холхиж байв.

Мистер Фрэнклин дэвсэг дээр байна гэж би охиныхоо өмнөөс хариуллаа.

Бодолдоо нэг л жигтэй дарагдаад үхдэл мэт цонхийсон мисс Рэчел яриа өдөх гэж оролдсон байцаагчийг огтхон ч тоож харалгүй, нэг ч үг дуугаралгүй өрөөнөөс гарч үеэл нар дээрээ очихоор уруудав.

Миний зүгээс зохих ёсоор хүндэтгээгүй, ёс журам алдсан мэт үзэгдэх хэдий боловч, тэр үед амь насанд минь халтай байлаа ч гэсэн мисс Рэчелийг хоёр залуу эрхэмтэй хэрхэн уулзахыг харах гэж цонхоор тэвчилгүй шагайх байсан юм. Авхай Годфрийг харсан ч шинжгүй, шууд Фрэнклинийг чиглэсэн тул цаадах нь тэр хоёрыг орхин холдов. Мисс Рэчел нэг зүйлийг ихэд эгдүүцэн хэлж байгаа бололтой. Удаан ч ярьсангүй, харин цонхоор царайг нь харваас мистер Фрэнклин учиргүй балмагджээ. Тэгж хамт зогсож байтал нь ахайтан тэдэн рүү ирж явааг Рэчел харчихаад Фрэнклинд нэг үг хэлээд гэнэт эргэн явж эхийгээ хүрч очихоос өмнө байшинд орчихов. Ахайтан үүнд гайхаж, Фрэнклинийг бас гайхсан байхыг хараад нэгийг ярилцаж эхлэв. Годфри тэр хоёртой нийлж мөн л ярилцаж байна. Фрэнклин юу болсныг хүүрнэж байгаа бололтой, тэр хоёрын дунд орон жаахан алхав. Нөгөө хоёр хэд алхсанаа цочиж гайхсан мэт зогтусан доороо зогсов. Миний бие энэ бүхнийг ажиглаж байтал зочны өрөөний үүд сэвхийн нээгдэж, нүд нь гялалзан минчийглээ уурлаж хилэгнэсэн мисс Рэчел унтлагын өрөө рүүгээ түргэн түргэн алхалсаар орлоо. Ахлах байцаагч түүнээс юм асуух санаатай дахин оролдсонд өрөөнийхөө босгон дээрээс эргэн хараад,

□ Би таныг дуудаагүй! Таны хэрэг надад байхгүй! Миний алмаз алга болсон. Та ч, ер нь хэн ч түүнийг олохгүй! Гэж эгдүүцэн хашгираад дотогш орж, улаан нүүрний нь өмнө хаалгаа хаав. Ганцаархнаа болмогч эхэр татан орилохыг нь хаалганд хамгийн ойр зогсож байсан Пенилоп сонсчээ. Эхлээд галзууртлаа уурлаж байснаа одоо усан нүдэлж байдаг ер юу л болж байна даа?

Эрдэнийн чулуугаа алдчихсандаа Рэчел авхай ямар их бачимдаж байгаа нь харагдаж байна хэмээн би мистер Сигревт хэлж байв. Залуу авхай маань гадны хүний (хэдий цагдаагийн дарга боловч) дэргэд дэндүү эвгүй авирлахыг хараад сэтгэл гонсойж, гэр бүлийн нэр төрийг бодож санаа зовсон миний бие чадах хэрээрээ л уучлал гуйж гарсан билээ. Гэвч би мисс Рэчелийн жигтэй үг яриа, дүрслэх аргагүй хачин байдлыг дотроо гайхан учрыг олж цөхөн байв. Унтлагын өрөөний босгон дээрээс хэлсэн үгий нь үндэслэн учрыг тайлах гэж үзвэл, цагдаа дуудсан явдалд үхтэлээ гомдсон бөгөөд цагдаа нар авчрах ажлыг гардан эрхэлсэн хүний нь хувьд мистер Фрэнклинд дэвсэг дээр байхад нь тэгж их балмагдуулсан үг түс тас хэлж дургүйцлээ илэрхийлсэн байх гэхээс өөр дүгнэлт хийж би чадсангүй. Энэ таавар үнэн л бол очир алмазаа алдчихаад, түүнийг нь олж өгөх ёстой улсыг гэртээ ирэхэд тэгтлээ юундаа дургүйцнэ вэ? Түүнчлэн тэнгэр минь, Саран чулууг дахиад хэзээ ч олохгүй гэж хаанаас мэдээ вэ?

Харваас одоогоор эдгээр асуултанд хариулж дөнгөх хүн үгүй байлаа. Дэвсэг дээр мисс Рэчелийн хэлсэн зүйлийг зарц хүнд, тэр тусмаа насаараа эднийд зүтгэсэн над шиг өвгөнд хэлээд хэрэггүй гэж Фрэнклин үзсэн бололтой. Боловсон эр, тэгээд бас садангийн нь хүн болохоор Годфри, Фрэнклиний бодлыг зөвшөөрч, анхаарвал зохино гэж үзсэн юм байх. Мисс Рэчелийн хүлээж авсан цорын ганц хүн, нөгөө нууцыг эргэлзээгүй мэдэж байгаа манай хатагтай охинтойгоо ярилцъя гэвч бүтэлгүй юм болсонгүй гэдгээ илэн далангүй хүлээсэн юм. Ахиухан юм мэдэж авах гэсэн эхийн оролдлого талаар өнгөрч, ↔Тэр алмазыг ярьсаар байгаад та намайг галзууруулах нь!≈ гэхээс өөр үг охин нь хэлдэггүй гэнэ.

Тийнхүү бид мисс Рэчелийг бүр ойлгохыг байж, Саран чулууны хэргийн талаар мухардаж орхисон билээ. Рэчелийн тухай асуудалд манай хатагтай бидэнд тус дөхөм үзүүлэх бүү хэл, өөрөө ч арчаагүй байдалд орсон байлаа. Нөгөө чулууны хувьд гэвэл (та ч мөд ойлгоно) мистер Сигрев арга тасрахад тун ч дөхчихөөд байв.

Авхайн өрөөгөөр баахан шиншиж, тавилга хэрэгсэл нэгжиж онгичоод юу ч эс олсон манай хашир байцаагч эцэстээ надад хандан шөнө алмаз хадгалсан газрыг зарц нараас хэн мэдэж байсан, хэн мэдээгүй байсныг асуув.

□ Эрхэм ээ, би мэдэж байсан хэмээн өөрөөсөө эхлээд, □ Хүүхнүүдийг очир алмазаа шөнө хаана тавих тухай хэлэлцэж байх үеэр танхимд байсан учраас Сэмүэл мэдсэн. Миний охин мэдсэн гэдгээ танд хэдийн хэлсэн. Сэмүэл тэр хоёрын нэг бусаддаа ярьсан байж магадгүй. Эсвэл арын шат руу гардаг танхимын хажуугийн хаалганы цаанаас тэд сонссон ч байж болох юм. Урьд шөнө очир алмаз хадгалсан газар энэ байшинд байсан хүн бүхэнд илэрхий болсон мэт санагдах юм гэв.

Миний хариулт ахлах байцаагчийн сэжиглэлийн хүрээг зэгсэн тэлсэн учраас арай нарийсгахын тулд зарц, шивэгчин нарын зан чанарын талаар сонирхов.

Розанна Спирман шууд л санаанд орж ирэв. Гэвч манайд ирсэн цагаасаа хойш үнэнч шударгад нь эргэлзэх юм хийгээгүй хөөрхий бүсгүйг ийм үед дурдах нь зохисгүй бөгөөд би ч түүнийг сэжиглээсэй гэж хүсээгүй юм. Засан хүмүүжүүлэх газрын харгалзагч авгай манай хатагтайд Розаннаг чин сэтгэлээсээ гэмшсэн, бүрэн итгэж болох бүсгүй гэж танилцуулсан билээ. Байцаагч эхлээд түүнийг сэжиглэх шалтаг олчихдог юм бол Розаннаг ахайтныд хэрхэн ирснийг ярих нь миний үүрэг.

□ Манай хүмүүс бүгдээрээ өөгүй сайн даа. Эзэгтэйн итгэлийг хөсөрдүүлсэн хүн үгүй гэж би хэллээ.

Үүний дараа мистер Сигрев манай зарц нарын зан байдлыг өөрийн биеэр судлахаас өөр замгүй болсон юм.

Зарц, шивэгчдийг толгой дараалан байцаав. Цөмөөрөө л, ялангуяа эмэгтэйчүүд ямар ч ашиггүй жигтэйхэн их юм ярьсан бөгөөд өрөөндөө орохыг хорьсонд зэгсэн их дургүйцэж байлаа. Тэднийг доош нь буцаагаад харин Пенилопыг дуудуулж дахин ганцаарчлан асууж шалгав.

Охин минь түрүүн авхайн өрөөнд жаахан уурласан, мөн энэ хэрэгт сэжиглэгдсэнээ гайхаагүй зэрэг нь байцаагч Сигревт эвгүй сэтгэгдэл төрүүлсэн бололтой. Урьд шөнө очир алмаз үзсэн хамгийн сүүлчийн хүн бол Пенилоп байсан гэдгийг л онцолж бодоод байгаа төлөвтэй. Хоёр дахь удаагийн байцаалт дуусахад охин минь ганиртлаа уурлачихаад хүрч ирсэн юм. Цагдаагийн дараг түүнийг хулгай хийсэн гэж хэлэх нь холгүй байсанд эргэлэх юм үгүй байв! Тэр байцаагчийг мистер Фрэнклиний хэлснээр ёстой л илжиг юм гэдэгт би бараг итгэсэн билээ. Мистер Сигрез иймэрхүү үг цухуйлгаагүй хэдий боловч охиныг минь харж буй нүдний нь харц тун ч аягүй байсан юм. Энэ явдлыг ноцтойгоор авч үзэхийн аргагүй (үнэн чанартаа ч тийм байсан билээ) хэтэрхий хөгийн юм гэж би хөөрхий Пенилопт хэлээд тоглоом шоглоом болгон өнгөрөөх гэж оролдов. Би өөрийгөө уурлаж тэнэглэх вий гэж битүүхэндээ айж байсан билээ. Үнэндээ миний зэвүү баахан хүрчээ. Миний охин өрөөний буланд очиж хормогчоороо толгойгоо бүтээгээд учиргүй гутарч цөхрөн суулаа. Улаа нцай буруутгаагүй байтал тэнэглэж байна гэж та хэлэх биз. Би шударга, тайван хүн болохоор ингэж бодохыг зөвшөөрнө. Ахлах байцаагч юу ч бодсон байлаа гэсэн пад алга! Түүнийг чөтгөр аваг. Байцаалтын дараагийн буюу сүүлчийн шат байдлыг ёстой л хямруулаад хаяхчихав. Цагдаагийн дараг ахайтантай (би байлцав) ярилцлаа. Очир алмазыг байшинд байгаа улсын нэг л авсан байж таарлаа гэж мэдэгдээд, зарц нарын өрөө, авдар савыг нэгжих зөвшөөрлийг өөртөө олон өөрийнхөө улсад өгөхийг хүслээ. Ууч сэтгэлтэй, хүмүүжилтэй бүсгүйн хувьд манай сайн санаат эзэгтэй биднийг хулгайч мэт харьцахыг эсэргүүцэн,

-Миний гэрт суудаг үнэнч зарц нарынхаа ач тусыг ийм маягаар хариулахыг би яасан ч тэвчихгүй! Гэв..

Ахлах байцаагч хатагтайд мэхийгээд миний зүг харахад “Та нар энэ мэтээр гарыг минь мухарлах байсан юм бол намайг юунд дуудсан юм бэ?” гэсэн асуулт харцанд нь илэрхий байлаа. Бид эзэгтэйнхээ сайхан сэтгэлийг ашиглавал шударга ёсонд харшилна гэдгийг би зарц нарын ахлагчийн хувьд шууд ойлгосон учраас,

-Сайхан сэтгэлд тэнэ гялайлаа ахайтан. Гэвч одоогийн нөхцөлд бид түлхүүрээ өгөх нь зүйтэй учраас өгөхийг зөвшөөрнө үү гээд байцаагч Сигрев гуйг үүдэнд зогсоон, -Габриэл Бэттереж үлгэр жишээ үзүүлбэл бусад зарц, шивэгчин дууриан, хараарай. Май, юуны түрүүнд өөрийн түлхүүийг өгье! Гэлээ.

Ахайтан миний гарыг атгаж, нүдэндээ нулимс цийлэгнүүлэн баярлаж талархсан билээ. Тэнгэр минь, тэр үед байцаагч Сигревийг цохиод унгачихаж чаддагсан бол би юугаа ч үл хайрлах байлаа!

Миний хэлсэнчлэн бусад зарц нар мэдээжээр баахан дурамжхан боловч миний жишээг дагав. Цагдаа нар юм хумыг нь онгичон байхыг эмэгтэйчүүд ямаршүү янзтай ажиглаж байсан гэж санана. Манай тогооч авгай ахлах байцаагчийг амьдаар нь хайруулын таваг дээр шарах гэж байгаа мэт, харин бусад нь түүнийг болмогц нь идэх гэж байна уу гэлтэй ширтэнэ.

Нэгжлэг дусч мэдээжийн хэрэг очир алмаз байтугай, ул мөрийг нь ч олсонгүй. Мистер Сигрев цаашид хэрхэхээ эрэгцүүлж бодох санаатай миний бяцхан өрөөнд очив. Цагдаа нар манайд хэдэн цаг болсон авч Саран чулуу хэрхэн алдагдсан хэн хулгайлсныг мэдэхд нааштай юм юу ч хийж чадсангүй. Цагдаагийн байцаагч ганцаараа суугаад тунгаан байх хооронд намайг мистер Фрэнклин номын санд ирээч гэж дуудуулжээ. Би хаалганы бариулас татахаар завдтал хаалга гэнэт онгойж Розанна Спирман өөдөөс гарч ирсэнд би туйлгүй их гайхав.

Номын санг өглөө арчиж цэвэрлэсний дараа тийшээ орох хэрэг аль ч зарцад үгүй билээ. Би Розанна Спирманыг зогсоож, гэрийн сахилга журам зөрчлөө гэж зэмлэв.

-Өдийд та номын санд яах гэж ороо вэ? Гэж асуулаа.

-Мистер Фрэнклин бөгжөө дээр орхичихсон байхаахр нь би авчирч өгсөн юм. Тийн хариулахдаа бүсгүйн царай чавга шиг улайсан боловч явахдаа толгойгоо өргөн ихэмсгээр ширтсэний н учрыг ойлгосонгүй. Манайд болсон явдал эмэгтэй зарц нарын сэтгэлийг их бага хэмжээгээр үймүүлсэн нь эргэлзээгүй авч Розанна Спирман шиг зан чанар нь үндсээрээ өөрчлөгдсөн хүн байхгүй.

Намайг ороход Фрэнклин ширээний ард суугаад юм бичиж байснаа галт тэрэгний буудал руу явахад унах морь эмээллэж өгөөч гэж гуйлаа. Түүний дууг сонсмогц л одоо шийдмэг зан нь дахин дийлснийг шууд ухаарав. Тугалган жад шиг шантарч байсан хүн маань хатаасан болд шиг мятаршгүй болжээ.

-Лондон явах нь уу, эрхэм ээ? Гэж би асуув.

-Лондон руу цахилгаан явуулъя. Бидэнд байцаагч Сигревээс илүү ухаалаг толгой тус болно гэдэгт би нагац эгчийг итгүүлээд, аавд цахилгаан явуулах зөвшөөрөл авчихсан. Аав цагдаагийн даргыг таньдаг болохоор очир алмазын хэргийн нууцыг тайлж чадах хүн олж чадах биз. Нууц гэснээс хэмээн Фрэнклин дуугаа намсгаад –Таныг морины жүчээ рүү явахаас өмнө нэг хэлэх юм байна. Одоохондоо энэ тухай хэнд ч үг бүү цухуйлгаарай. Нэг бол Розанна Спирман ухаан согогтой байх, эсвэл Саран чулууны талаар мэдвэл зохихоос илүү юм мэдэж байгаа болов уу гэж би айж байна гэлээ.

Үүнийг сонсоод миний бие айж сандарсан, харамаж гутарсан алин болсноо хэлэхэд хэцүү байна. Би залуухан байсан бол энэ тухайгаа мистер Фрэнклинд хэлэх байсан биз. Гэвч нас ахиад ирэхээр сайн ойлгоогүй үедээ амаа татаж чаддаг сайхан зуршилтай болдог юм. Фрэнклин цааш өгүүллрүүн:–Тэр бүсгүй унтлагийн өрөөнд унагачихсан бөгжийг минь аваад орж ирлээ. Би ч түүнд талархаж баярласнаа хэлээд одоо явна байх гэж бодлоо л доо. Гэтэл гараад явахын оронд ширээний цаана өөдөөс хараад ямар ч гэх юм бэ дээ айсан мөртөө дотно нэг л хачин жигтэй ширтэн зогсов. “Энэ очир алмазын хэрэг мөн сонин оо, эрхэм ээ!” гэж гэнэт хэлэхээр нь би “Тийм ээ” гээд цааш юу болохыг гайхан хүлээв. Бэттереж ээ, тэр бүсгүй лав гажигтай гэж би нэр төрөө барин тангараглая! “Эрхэм ээ, тэр алмаз хэзээ ч олдохгүй, тийм ээ? Авсан хүнийг нь ч олохгүй, би үүнийг батална” гэж хэлчихээд толгой дохин инээмсэглэсэн шүү! Энэ чинь юу гэсэн үг вэ гэж асууж амжаагүй байталу таны хөлийн чимээ дуулав. Энд байж байгаад танд харагдахаас айсан бололтой, ямар боловч царай нь хувьсхийгээд гараад явчихсан. Энэ ямар учиртай байж таарах вэ?

Тэр үед би Розаннагийн тухай мистер Фрэнклинд ярихыг төвдсөн билээ. Тэгвэл бүсгүйг хулгайч гэж шулуухан хэлсэнтэй утга нэг болох юм. Түүнээс гадна би Фрэнклинд бүгдийг ний нуугүй ярилаа ч гэсэн ямар учраас хорвоогийн хүн зоны дундаас чухамхүү Фрэнклинийг сонгож, нууцаа илчилсний шалтгааныг мөн л мэдэхгүй үлдэх билээ.

-Сэтгэл нь хөөрч тун хачин ярьж байсныг нь харахад л хөөрхий бүсгүйг энэ хэрэгт холбоотой гэж үзэх аргагүй. Хэрэв надад хэлсэн зүйлээ ахлах байцаагчид хэлсэн бол тэр тэнэг эр... гээд Фрэнклин үгээ гүйцээлгүй орхив.

-Боломж гармагц л би энэ тухай эзэгтэйдээ хэлэх нь зүйтэй байх эрхэм ээ. Ахайтан Розаннад их элэгтэй хандаж, сонирхож байдаг юм. Энэ бүсгүй ер нь ухаан хомс, увайгүй зантай байж тун болзошгүй. Айлд ямарваа нэг эвгүй явдал гарахад эмэгтэй зарц нар аль муу талаас нь бодох дуртай байдаг бөгөөд энэ нь тэр хөөрхийсийн нүдэнд нэг л чухал мэт үзэгддэг бололтой. Хэрэв хүн өвдчихвөл тэр хүнийг үхэх гэж байна гэлцэн эрдэнийн чулуу алдагдвал олдох хөг нь өнгөрсөн гээд л шуугилддаг улс. Миний энэ үг митсер Фрэнклиний санааг нэлээд амраав бололтой. Бичсэн цахилгаанаа эвхэж, яриагаа цэглэв. Миний бие хөнгөн сүйх тэргэнд морьд хөллө гэж тушаахаар морины жүчээ рүү явах замдаа зарц нар цайгаа ууж байсан танхимаар шагайсанд Розанна-Спирман үзэгдсэнгүй. Бие нь гэнэт муудаад өрөөндөө очиж хэвтэнэ гээд явсан гэж миний асуусны хариуд хэлцгээлээ.

-Хачин юм даа! Түрүүхэн л зүгээр байсан шүү дээ гэж би хэлэв.

Пенилоп миний хойноос гарч ирээд,

-Аав аа, та эдэнд ийм юм бүү ярь. Тэгвэл Розаннаг улам л нүд үзүүрлэцгээнэ шүү дээ. Хөөрхий амьтан мистер Фрэнклин Блэйкэд сэтгэлтэй болчихоод байгаа юм гэв.

Розаннагийн араншиг бас нэг янзаар тайлбарлах нь тэр. Пенилопын зөв бол Розаннагийн хачин юм хэлж, жигтэй авирлаан нь Фрэнклин ноёнттой л үг солихын тулд тэгжээ гэж ойлгож болох юм. Номын сангийн үүдэнд Розанна миний дэргэдүүр тун бардам өнгөрснийг нь санаад энэ үнэн мэт. Мистер Фрэнклин үнэндээ ганц хоёрхон үг дуугарсан хэдий болов өөртэйгөө ярилцсан хэмээн бодож явжээ.

Би өөрийн биеэр байлцан хөнгөн сүйх хөллүүлэв. Биднийг хүрээлэн буй энэхүү учир битүүлэг нууц явдлын адармаатай гогцоонд орооцолдоод байсан энэ үед морины хөллөгөөний сур тоног хэчнээн сайхан эвлэж байхыг харахад сэтгэл юутай амгалан байсныг хэлбэл зохино! Морьдыг тэргэнд хөллөсөн хойно нь үзвэл та миний үгэнд огт эргэлзээгүй итгэх буй заа. Итгэл гэгч одоо эргэлзээ тээнэгэлзэл ноёрхсон манайх шиг айлд тун ч ховор үзэгдэл болчихоод байсныг хэлсүгэй.

Миний бие сүүх тэргэнд суугаад гол халганд хүрвэл мистер Фрэнклинээс гадна мистер Годфри байцаагч Сигрев нар намайг бас шатан дээр хүлээж байлаа.

Зарц нарын өрөө тасалгаа, авдар савыг нэгжээд очир алмазыг олж чадаагүй байцаагч маань бодож тунгаасны эцэст өөр нэг дүгнэлтэнд хүрсэн бололтой. Алмазыг гэрт байсан улсын нэг л хулгайлсан гэж итгэсээр буй манай хашир эрүүлч тэр хулгайчийг энэтхэгүүдтэй сэм хуйвалджээ гэж үзсэн ажээ. (Хөөрхий Пенилопмыг минь шууд нэр заагаагүй ч гэсэн дотроо лав сажиглаж байсан л даа). Ийм учраас илбэчдийг хорьж байгаа Фризинхоллын шоронд очиж байцаалтаа үргэлжлүүлэхээр шийджээ. Энэ шинэ шийдийг нь сонсоод Фрэнклин ахлах байцаагчийг хотод нь хүргэж өгье, тэгээд ч Лондон руу тэндээс цахилгаан утас явуулах нь манай галт тэрэгний буудал дээрээс явуулснаас хавьгүй

хялбар гэжээ. Сигревт гуйвалтгүй итгэсээр байсан Годфри энэтхэгүүдийг байцаахад байлцахсан хэмээн туйлгүй хүсэх тул Фризинхолл руу хамт явъя гэж гуйсан юмсанж. Хэрэг тохиолдож болзошгүй хэмээн нэг цагдаа үлдэж, нөгөө нь байцаагчийн хат хот руу буцах болов. Ийнхүү сүүх тэрэгний дөрвөн суудал бүгд эзэнтэй болжээ.

Фрэнклин жолоо барихын өмнө наайг дагуулан бусдад сонсогдохооргүй зайд очоод өгүүлсэн нь:

-Энэтхэгүүдийг байцаасны үр дүнг мэдтэлээ би Лондон руу цахилгаан явуулахаа азная. Энэ мулгуу цагдаа бас л юу ч олж чадахгүй гэдэгт би эргэлзэхгүй байна. Дэмий л цаг хожих гэсэн хэрэг. Миний бодоход, зарц нараас энэтхэгүүдтэй хуйвалдсан хүн байна гэдэг огт утгагүй санаа юм. Намайг иртэл гэр орны байдлыг сайтар харж, Розанна Спирманаар ямар нэг юм хэлүүлэхийг хичээгээрэй, Бэттереж гуай инь. Би танаас нэр төрдөө харшлах зүйл үйлдэх буюу тэр бүсгүйд догшин ширүүн хандаарай гэж гуйж байгаа юм биш. Зөвхөн улам няхуур, сэрэмжтэй байгаарай гэж гуйя. Нагац эгчид энэ бүхнийг аль болохоор шальгүй зүй мэтээр таниуламц. Гэвч энэ маань магадгүй таны санаснаас ч илүү ноцтой хэрэг юм шүү.

-Хорин мянган фунтын хэрэг шүү дээ гэж би алмазын үнийг бодон хэлсэнд,

-Хэргийн учир нь Рэчелийг л тайвшруулахад байгаа юм. Миний саана их зовж байна гэхчээ, цааш ярилцахыг хүссэнгүй юу гэлтэй намайг гэнэт орхин одов. Үүний учрыг би ойлгох шиг болов. Яриа үргэлжилбэл түрүүн мисс Рэчел дэвсэг дээр байхад нь хэлсэн үгийг ам алдаад хэлчих вий гэж айсных биз.

Тийнхүү тэд Фризинхоллыг зорин хөдөллөө. Миний бие Розаннагийн эрх ашгийг бодож ганцаарантай нь ярилцахааи шийдлээ. Гэвч сайхь ашигтай боломж талаар өнгөрсөн юм. Розанна зөвхөн цайны цагаар л бууж ирсэн бөгөөд муужирч унахад ойрхон тун их догдолж, дэнсэлсэн байх тул Вериндер ахайн тушаасан ёсоор давс үнэртүүлээд өрөөндөө очиж хэвт хэмээн явуулав.

Тэр өдөр баахан дүнсгэр, уйтгартай өнгөрсөн билээ. Мисс Рэчел бие муу учраас цайнд орж чадахгүй гэхчээ өрөөндөө түгжин суусаар байлаа. Хатагтай маань охиныхоо байдалд туйлгүй шаналж бйсан тул миний бие Розанна Спирманы мистер Фрэнклинд хэлсэн үгийг өгүүлж зовлон дээр нь нэрмээс болохыг зүрхэлсэнгүй. Пенилоп өөрийгөө удалгүй хулгайн хэрэгт таслан шийтгүүлнэ биз хэмээн зүтгэнэ. Бусад авгай хүүхнүүд хөлгөн судар, мөргөлийн номоо шүүрэн авцгааж, хүйтэн царайлан уншиж суусан бөгөөд энэ нь өдрийн далад болоогүй цагаар явагддаг мөргөлийн үеийн дүр зураг гэдгийг би амьдралынхаа туршид ажигласны үр дүнд мэддэг болсон билээ.

Миний хувьд гэвэл “Робинзон Крузогоо” ч нээж харах зүрх хүрсэнгүй. Арай хөгжөөнтэй орчинд орохыг мөрөөсөн гадагш гарч, нохойн хонуурын дэргэд сандал тавьж ноходтойгоо ярилцан суулаа.

Үдийн хоолноос хагас цаг орчмын өмнө манай хоёр залуу эрхэм эргэж ирсэн бөгөөд ахлах байцаагч Сигрев маргааш манайд дахиж ирэхээр тохиролцжээ. Манай хоёр залуу, жуулчин Мэтрвэйтийн хотоос холгүй байдаг байранд нь очсон байна. Фрэнклиний хүссэний дагуу нөгөө гурван энэтхэгийн англи хэл огт гадарладаггүй хоёрыг нь байцаахад орчуулж өгөхийг дуртайяа зөвшөөрчээ. Нарийн чамбай, удаан үргэлжилсэн байцаалт, ямар ч үр дүн өгсөнгүй, манай зарц нарын нэгтэй холбоо сүлбээтэй гэж сэжиглэх шалтгаан ч гарсангүй. Ийм дүгнэлт хийгээд мистер Фрэнлин Лондон руу цахилгаанаа явуулсан агаад хэрэг явдал маргааш болтол хойшлогджээ.

Төрсөн өдрийн маргаашийн явдлын тухай ханаглттай өгүүллээ. Тэгэхэд бид энэ хэргийн талаар ёстой л нүдэн балай байсан юм. Харин нэг хоёр хоногийн дараа нууцын сэжүүр бяцхан ч гэсэн тайлагдаж эхэлсэн юм. Хэрхэн, ямар үр дүнд хүрснийг та одоо мэдэх болно.

## **XII БҮЛЭГ**

Пүрэв гаригийн шөнө нам тайван өнгөрлөө. Баасан гаригийн өглөө хоёр шинэ сонинтой болов.

Эхний мэдээ гэвэл, өчигдөр нар хэвийсэн хойно Розанна Спирман Фризинхолл руу намаг гардаг замаар зузаан гивлүүртэй явж байхыг нь талхны наймаачин харжээ. Өөр хүнийг бусдаас содон далиу мөртэй хөөрхий тэр бүсгүйтэй эндүүрэх аргагүй ч гэсэн буруу харснаас зайлсангүй бололтой. Учир юу гэвэл, Розанна пүрэв гаригийн үдээс хойш өрөөндөө өвчтэй хэвтэж байсныг та бид сайн мэднэ.

Хоёр дахь мэдээг шуудан зөөгч авчрав. Эрхэмсэг Канди эмч усан онгоцоор харихдаа эмчийн арьс ус нэвтэрдэггүй юм гэж надад хэлэхдээ бас нэг том алдаа хийсэн юмсанж. Тэр оройдоо салхи цохиулж одоо зайлуул, халураад эрүү лсаруул үе шигээ зогсоо зайгүй дэмийрч донгосон хэвтэж байгаа гэнэ. үүнийг сонсоод бид тагдгар эмчийг ихэд өрөвдөцгөөсөн бөгөөд мистер Фрэнклин гол нь мисс Рэчелийг бодоод бүр ч ихээр харамсав. Өглөөний цайны үеэр намайг байхад Фрэнклин Вериндер ахайд хэлсэн үгнээс үзвэл, Саран чулуутай холбогдсон энэхүү битүүлэг явдлын учир хардан

тайлагдахгүй бод бид эмчийн сайныг олж мисс Рэчелийн талаар зөвлөгөө авахаас өөр аргагүйд хүрч байгаа бололтой.

Цайны дараахан Фрэнклиний эцгээс хариу цахилгаан ирэв. Түүндээ, өөрийн найз цагдаагийн даргын тусламжтайгаар, бидэнд тус хүрэгж чадах хүн олсон, тэр хүнийг түрүүч Кафф гэдэг ба Лондонгоос өглөөний галт тэргээр очно байх гэжээ. Тэр хүний нэрийг сонсоод Фрэнклин давхийв. Лондонд байхдаа эцгийнхээ хэрэг хөтлөгчөөс эрүүл Каффын тухай элдэв сонин шог яриа бишгүйдээ дуулсан юмсанж.

-Бидний сэтгэлийн зовлон мөд дуусна гэдэгт итгэл төрж эхэллээ. Миний сонссон яриануудын хагас нь ч атугай үнэн бол хэргийн нууцыг тайлахад Каффтай эн зэрэгцэх хүн Англид нэг ч үгүй гэж хэлэв.

Тэрхүү авъяаслаг, алдартай хүний ирэх цаг дөхөх тусам бид цөм сэтгэл догдлон тэсч ядан байлаа. Ахлах байцаагч Сигрев болзсон цагтаа ирээд эрүүлч Каффыг хүлээж буйг сонсоод үзэг, бэх, цаас авч, өөрөөс нь зайлшгүй шаардах тайлан бичихээр нэг өрөөнд орж түгжин суув. Миний бие галт тэргэний буудал руу явж, эрүүлчийг тосч авах гэсэн боловч ахайтан алдарт Каффт морь, тэрэг бэлтгэх талаар бодох ч үгүй байсан ба хөнгөн сүүх тэргийг Годфри хэрэглэх болсон юм. Нагацыгаа ийм түгшүүрт цагт орхиж явах болсондоо гүнээ харамсаж буйгаа хэлээд эл хэргийн талаар Лондонгийн ухаалаг эрүүлийн санал бодлыг сонсохын тулд сүүчлийн галт тэргээр явах боллоо. Эмэгтэйчүүдийн хороо нэг төвөгтэй асуудал шийдэхэд бямбад зөвлөгөө өгөөч гэсэн учир баасан гаригийн орой хотод байх ёстой гэлээ.

Эрүүл Каффын ирэх цаг ойртсонд миний бие түүнийг угтан авахаар гол хаалга руу гарав.

Манаачийн шовгорын дэргэд очтол нэг хөлсний тэрэг буудлын зүгээс ирж айсуу. Тэндээс буурал үстэй, ёстой л яс арьс болсон нэгэн хижээл эр буув. Аятайхан хар хувцас өмсөж, цагаан зангиа зүүжээ. Ясарха, гонзгой, намрын навч шиг хуурай, шаравтар царайтай, сорьж туршсан шинж тодорсон болдын өнгөтэй тунгалаг бор нүдтэй, харц тулгарвал хүнээс мэдэж байгаагаас нь илүү юм олж харах гэсэн мэт айхтар ширтэнэ. Хөнгөн алхаатай, үхээнц дуутай, урт чөргөр хуруунууд нь махийгаад хумс мэт харагдана. Санваатан ч юм шиг, эсвэл оршуулгын товчоно эзэн шиг ер ямар боловч цагдаагийн газрын эрүүлч гэхээргүй ажээ. Сандарч тэвдсэн айлын хувьд Кафф шиг сэтгэл хөнгөрүүлж чадах хүн үгүй буй заа.

-Энэ хатагтай Вердиндерийнх үү? Гэж асуув.

-Тийм ээ, эрхэм ээ.

-Би түрүүч Кафф байна.

-Морилогтүн.

Байшин руу явах замдаа ахайтныхаа даалгах гэж буй хэргийн талаар ярих боломж олгоё хэмээн бодоод би нэр, эрхэлсэн ажлаа хэллээ. Гэтэл эрүүлч тэр тухай нэг ч үг дурссангүй. Хари нманай цэцэрлэгийг магтан шагширч, далайн агаар тунч цэнгэг, тунгалаг юм гэлээ. Энэ цуутай эрүүлч юугаараа тийм их алдар нэр олсон юм бол хэмээн миний бие гайхаж бав. Бид анх удаа нэг доор гинжлэгдсэн, бие биеэ огт мэддэггүй нохдын төрхтэйгөөр байшинд хүрэв.

Ахайтныг сурагласанд хүлэмжинд буй гэсэн тул хатагтайг олуулахаар нэг зарцыг цэцэрлэг рүү илгээв. Ахайтныг хүлээх зуур Кафф мөнх ногоон ургамал хэрсэн нуман хаалгаар шагайж, сарнай тарьдаг талбайд шууд орохдоо манайд ирсээр анх удаа сонирхож гайхсан маягийн шинж үзүүлсэн юм.

Энэхүү алдарт мөрдөгч сарнай цэцэг тарих мэтийн дэмий зүйл сонирхдог ялихгүй занг нь мэдээд манай цэцэрлэгч ихэд гайхаж, би баахан зэвүүрхэж билээ.

-Өө, танайх урд, баруун урд талдаа тун үзэсгэлэнтэй юмаа хэмээн буурал толгойгоо сэгсрэн өгүүлэхэд уйтгартай дуунд нь бага зэрэг сэтгэл ханасан өнгө тодров. Энэ хэсэг нь ёстой сарнай ургуулахад тохиромжтой, талбайд тойруулж суулгасантай адилгүй юм. Тийм юм гэх, мандал бүрийнхээ хооронд жимтэй, гэхдээ ингэж элс асгах шаардлагагүй л дээ. Цэцэрлэгч гуай, танай бутнуудад элсэн зам дэндү бүдүүн бааз харагдах юм байна. Зүлэг тарьвал зүгээр сэн. Нэг эгнээнд цагаан, ягаан сарнай салаавлан суулгахад гоё харагддаг, их сайхан хосолдог юм шүү, тийм ээ? Энд цагаан сарнай байх шив, Бэттереж гуай, манай эртний англи сарнай хамгийн гоёмсог, шинэхэн үзэгдэж байна шүү гээд эрүүлч Кафф цагаан сарнайг чөргөр хуруугаараа энхрийлэн хэлээд, "Хөөрхөн хонгор минь!" хэмээн нялх хүүхэд өхөөрдөх мэт хэллээ.

Мисс Рэчелийн очир алмазыг олж, хулгайчийг илрүүлэх ёстой хүн маань ийм л сайн хүн ажээ!

-Та сарнай цэцэгт дуртай юмаа даа, эрхэм ээ? Гэж би асуув.

-Надад ер нь аливаа юмыг шохоорхох цаг олддоггүй. Харин ганц нэг хором гарвал дандаа сарнайд зориулдаг юм, Бэттереж гуай. Би сарнай цэцгийн дунд, эцгийнхээ цэцэрлэгт амьдралтай золгож, ухаан суусан болохоор чадвал сарнай цэцгийн дунд л амьсгал хурааэна даа. Тийм ээ, нэг л сайхан өдөр хулгайч барих ажлаа орхиж, сарнай тарьж ургуулахыг бодно доо. Хари нминий цэцгийн мандал

бүрийн хооронд зүлэгт жим байх болно, цэцэрлэгч гуай гэж эрүүлч хэлсэн нь манай элс асгасан жим сэтгэлд нь нийцээгүй бололтой.

-Таных шиг ийм мэргэжилтэй хүнд тун жигтэй сонирхол байна гэж би хэлж зүрхэллээ.

-Хэрэв та эргэн тойрноо ажиглаад үзвэл (ихэнх улс ажигладаггүй юм) хүний сонирхол гэгч голдуу ажил төрөлтэй нь харшилж байдаг. Сарнай, хулгайч хоёроос өөр харш зүйл хэл л дээ. Тэгвэл хэтэрхий оройтоогүй дээрээ би сонирхло даруйхан сольё. Дамаскийн сарнай хагмийн эмзэг, булбарай цэцгүүдийн өвөг болдгийг та мэднэ биз дээ, цэцэрлэгч гуай? Аа, би тэгж бодсон юмаа, ахайтан айсуу. Вериндер ахай мөн үү?

Ахайтан аль зүгээс ирэхийг мэдээгүй атлаа мэдэжбайсан цэцэрлэг бид хоёроос өмнө олоод харчихжээ. Анх санасныг бодвол хавьгүй гярхай хүн юм гэж би бодов.

Эрүүлчийн царай зүс, үүрэгт ажлын аль нэд нь, эсвэл хоёуланд нь манай хатагтай баахан аягүйцсэн шинжтэй. Ахайтан үл таних хүнтэй уулзаад хэлэх үгээ олж ядан самгардаж байхыг нь би анх удаа үзэж билээ. Гэвч Кафф тэр даруй хүнд байдлаас нь гаргав. Өөрийг нь дуудуулахаас өмнө эл хулгайн хэргийг өөр хүнд даалгасан эсэхийг лавлаж, нэг хүн хэдийн ирсэн, одоо байшинд байгаа гэдгийг сонсоод давын өмнө түүнтэй очиж уулзах зөвшөөрөл гуйлаа.

Вериндер ахай гэр рүүгээ түрүүлэн алхахад, эрүүлч явахын өмнө элст жимийн талаар цэцэрлэгчид хэдхэн үгээр саналаа хэлж

-Зүлэг таръя гэж ахайтнаа ятга хэмээн зам руу зэвүүцэн хараад, -Элс хэрэгтэй шүү, хэрэггүй! Гэв.

Эрүүлч Каффтай танилцуулах үед ерөнхий байцаагч яагаад тийм их намхан болчихсныг би тайлбарлах гэж оролдохгүй, харин энэ үнэнийг л дурдаж чадна. Тэд хоёул нэг өрөөнд орж түгжин удтал суусны эцэст ахла хбйацаагч догдолж хөөрсөн, харин эрүүл эвшээлгэсээр гарч ирлээ.

-Мистер Кафф мисс Вериндерийн зочны өрөөг үзье гэж байна хэмээн мистер Сирев надад тун сүржин, цогтойгоор мэдэгдээд, -Хэдэн юм асуух гэсэн бололтой, та хүргэж өгнө үү гэлээ.

Энэ зааврыг авах зуураа би алдарт Каффыг харвал байцаагчийг миний түрүүн ажигласан янзаар тайван, тэсвэртэй харж байлаа. Мэргэжил нэгт нөхрөө илжиг шиг тэнэг загнахыг нь хүлээж байсан гэж би нотолж чадахгүй, гэвч яг л тэгсэн байх гэж би баттай бодсон билээ.

Би дээш дагуулан гарав. Мистер Каф энэтхэг шүүгээг анхааралтай үзэж, өрөөн дотуур аллахдаа хааяа нэг ахлах байцаагчаас, голдуу насдаас юм асууж лавлах бөгөөд тэдгээрийнх нь учрыг бид хоёр хоёулаа ухаарахгүй байсан гэдэгт миний бие үл эргэлзэнэ. Эрүүлч явсаар таны мэдэх нөгөө хаалганы чимэглэл зурагт тулж очоод зарц хүүхнүүд өрөөнд бөөнөөрөө орох үед байцаагч Сигрев хэдийн олж харсан, цоожны яг доор байсан халтартсэн хэсэг дээр чөргөр хуруугаа тавилаа.

-Ямар харамсалтай вэ! Яагаад ийм болчихоо вэ? Гэж надаас асуухад нь өчигдөр өглөө зарц бүсгүйчүүд энэ өрөөнд бөөнөөрөө асуугдаж байхдаа нэг нь хормойгоороо арччихсан юм билээ гэж тайлбарлаад ахлах байцаагч Сигрев тэднийг хаалга дахиад балиартуулахаас нь өмнө гаргасан гэв.

-Үнэн шүү хэмээн байцаагч дйачин зангаараа батлаад, -Би тэдэнд гарахыг тушаасан. Нэг нь хормойгоороо шүргээд л ийм болгочихсон юм л даа, мистер Кафф гэж хэлэв.

-Хэн нь шүргэснийг та мэдэж байна уу? хэмээн мистер Кафф мэргэжил нэгт нөхрөөсөө бус мөн л надаас асуулаа.

-Үгүй эрхэм ээ.

Тэгэхэд байцаагч руу эргэж хараад,

-Та ажиглаа биз дээ? Гэв.

Байцаагч барьж алдсан боловч,

-Би тархиа зовоох дургүй. Тэр чинь дэмий шал хэрэггүй зүйл байсан шүү дээ хэмээн биеэ зөвтгөв.

Эрүүлч Кафф, Сигревийг сарнайн цэцэрлэгийн элст жимийг харж байсан шигээ ширтээд, бидэнд ердийн номой байдлаараа авъяас чадварынхаа тааар анхны ойлголтыг өгсөн юм.

-Байцаагч гуай, өнгөрсөн долоо хоногт би нэг нууц хэрэг мөрдлөө. Хэргийн нэг үзүүрт хүний амь бусниулсан явдал, нөгөө үзүүрт нь ширээний бүтээлэг дээр дуссан бэхийн толбо байса нба түүний учрыг хэн ч тайлбарлаж чадахгүй байв. Гэмт хэргийн бузар ертөнцийн элдэв бохир булан тохойд шалихгүй, дэмий гэж орхх зүйл ер байдаггүй юм\_ Дараагийн алхам хийхийн өмнө бид хаалганы зургийг балиартуулсан хүнийг мэдэж, зураг хэдийд хатсаныг тогтоох ёстой.

Ахлах байцааг энэ сануулгыг баахан дүнсгэр царайлан хүлээж аваад эмэгтэйчүүдийг дуудаж авчрах эсэхийг лавлахад алдарт Кафф түр бодолхийлснээ санаа алдаад толгой сэгсрэв.

-Хэрэггүй, эхлээд будгийн учрыг олъё. Энийг ч доор нь шийдчихнэ, харин банзлын эзнийг тогтооход төвөгтэй болох вий. Өчигдөр өглөө зарц нарыг энэ өрөөнд оруулахад хэдэн цаг болж байсан бэ? Арван нэгий? Өглөөний арван нэгэнц агт будаг нойтноороо байна уу эсвэл хатсан байв уу гэдгийг мэдэх хүн байна уу?

-Хатагтайн зээ мистер Фрэнклин Блэйк мэднэ гэж би хариуллаа.

-Тэр эрхэм чинь энд бий юу?

Фрэнклин ноён алдарт Каффтай танилцах аятай боломж гарахыг хүлээн тун ойрхон эргэлдэж байжээ. Төдхөн орж ирээд доорх зүйлийг мэдэгдэв.

-Эрхэм ээ, энэ хаалгыг мисс Вериндер миний заавар, тусламжтайгаар, миний найруулсан будгаар зурж чимэглэсэн юм. Ямар ч өнгө байсан арван хоёр цагийн дотор хатна.

-Энэ балиартсан хэсгийг хэдийд дуусгасныг та санаж байна уу?

-Сайн санаж байна. Хамгийн сүүлд зурсан хэсэг. Өнгөрдөг лхагва гаригт дуусгах ёстой байсан, өдөр гурван цагийн дараа эсвэл арай хойхно би өөрөө зурж дуусгасан юм.

-Өнөөдөр баасан гэснээ эрүүлч Кафф, Сигревт хандаж, -Байдлыг эргэн харъя, эрхэм ээ. Лхагва гаригт өдрийн гурван цагт зураг чимэглэл хийж дууссан. Будаг арван хоёр цаг болоод хатдаг гэхээр пүрэв гаригийн арван нэгэн цагт энд байцаалт явуулсан. Арван нэгээс гурвыг хасвал найм үлдэнэ. Тэгэхээр байцаагч гуай, шивэгчин нарын нэг хормойгооро балиартуулжээ гэж таныг тааварлаж байхад зураг хатаад найман цаг болсон байж хэмээв.

Мистер Сигревт анхны том цохилт өглөө! Хөөрхий Пенилопыг минь сэжиглэж гомдоогоогүй бол би түүнийг өрөвдөх л байлаа.

Зураг чимэглэлийн асуудлыг шийдсэн мөчөөс эхлэн эрүүлч Кафф мэргэжил нэгт нөхрөө мартсан мэт, Фрэнклинийг арай найдватай туслагч гэж үзэн хандах боллоо.

-Та бидэнд нууц тайлах түлхүүр атгуулсан байж тун болзошгүй юм, эрхэм ээ.

Тийн хэлж дуусаагүй байтал унтлагийн өрөөний үүд онгойж, мисс Рэчел гэнэт гарч ирлээ.

Каффыг огт танихгүй гдэгээ анзаараагүй буюу тоомсорлохгүй байна уу гэлтэй ярьж эхлэв.

-Энэ хүн танд нууцыг тайлах түлхүүр атгуулсан гэв үү? Хэмээн Фрэнклинийг заан асуув.

-Энэ мисс Вериндер гэж би Каффын араас шивнэв.

Мистер Кафф болдын өнгөт бор нүдээрээ залуу авхайн царайг няхуур шинжин,

-Энэ эрхэм бидэнд нууц тайлах түлхүүр өгсөн байж тун болзошгүй юм, авхайтан гэж мэдэгдлээ.

Рэчел огцом эргэж Фрэнклиний өөдөөс харах гэж оролдов. Би "оролдов" гэсний учир бол тэдний харц тулгарахаас өмнө авай гэнэт нүүр буруулсан юм. Сэтгэл санаа нь жигтэй хачин догдолж хямарсан бололтой, царай нь улайснаа цонхийв. Тийн цонхийход нь царайд нь сэтгэл сэрдхийлгэм хачин шинж тодорч билээ.

-Би таны асуусанд хариуллаа. Одоо танаас юм асуухыг зөвшөөрнө үү? Энд, таны өрөөний хаалганы зураг балиартсан байна. Хэдийд, хэн ингэснийг та мэдээгүй биз? Гэж мистер Кафф асуулаа.

Гэтэл мисс Рэчел хариу хэлэхийн оронд эрүүлч юу ч асуугаагүй буюу эсвэл үгийг нь огт сонсоогүй мэтээр,

-Та бас цагдаагийн дарга уу? гээлэ.

-Би эрүүгийн цагдаагийн газрын түрүүч Кафф гэдэг хүн.

-Та залуу бүсгүйн зөвлөгөөнийг сонсох хэрэгтэй гэж боддог уу?

-Дуртайяа сонсоё, авхай.

-Та үүргээ ганцаараа гүйцэтгэ. Мистер Фрэнклин Блэйк танд тусалъя гэж байгаа бол бүү зөвшөөр! Хэмээн учиргүй хилэгнэн сануулахад дууны нь өнгө, нүдний нь харцанд Фрэнклинийг ер бусаар жигшин зэвүүцсэн шинж илэрсэн тул миний бие Рэчелийг хар нялхаас нь сайн мэдэг, хатагтайнхаа дараа бүхнээс илүүгээр хайрлан хүндэтгэдэг хэдий боловч энэ насандаа анх удаа авхайн өмнөөс нүүр халж билээ.

Эрүүлч Кафф гөлийсөн харцаа авхайгаа үл салган широэнэ.

-Баярлалаа, авхай. Та энэ толбоны талаар юм мэдэх үү? Та өөрөө санаандгүй ингэчихсэн юм биш биз?

-Толбоны талаар би юу ч мэдэхгүй гэж хэлчихээд Рэчел өрөөндөө ороод түгжчихэв. Тэгээд түрүүнд Пенилопын сонссончлон ганцаараа эхэр татан уйлж эхлэхийг нь би сонслоо.

Би мистер Каффыг харж зүрхэлсэнгүй, харин ойр зогсож буй Фрэнклинийг харвал дээрх явдалд надаас илүүгээр сэтгэл гонсойсон байв.

-Миний санаа зовоод байна гэж би танд хэлсэн шүү дээ. Одоо учрыг нь ойлгов уу? гэж надад шивнэлээ.

-Мисс Вериндер алмазаа алдчихаад жаахан бухимдаж байна л даа. Их үнэтэй чулуу хойно аргагүй, аргагүй! Гэж Кафф учирлав.

Өчигдөр байцаагч Сигревийн дэргэд Рэчел эвгүй аашлахад нь би өмнөөс нь уучлал гуйсан, харин өнөөдөр тэс хөндлөнгийн энэ хэрэгт над шиг санаа нь зовох ёсгүй хүн уучлал гуйж байдаг! Миний нуруу хүйт оргин бие зарсхийсний урыг би тэгэхэд ойлгоогүй юм. Харин одоо бодоход мисс Рэчелтэй анх уулзаж, хэдэн үг сольсноо үндэслэн эрүүлч Каффын гэнэт сэдсэн шинэ, аймшигтай саанаг би тэр үед анх тааварласан биз ээ.

-Залуу авхай нар юу дуртйагаа дархан эрхтэй ярьдаг юм, эрхэм ээ. Энэ явдлыг мартаж, ажил хэргээ үргэлжлүүлэе. Зураг хэдийд хатсаныг хэлж өгсөнд тань баярлалаа. Дараагийн асуудал бол хаалганы

зургийг балиартаагүй байхад нь хамгий нсүүлд хэдийг харсныг тогтоох явдал мөн. Мөрөн дээр чинь бөндгөр байгаагийн хэрэг юү билээ намайг ойлгож байгаа биз хэмээн Кафф Фрэнклинд хандан өгүүлэв.

Фрэнклин тайвширч, Рэчелийг маратж, ажил хэрэгт идэвхтэй оролцохыг хичээж байлаа.

-Ойлгох шиг боллоо. Цагийг хичнээн нарийн тогтоох тусам мөрдлөгийн хүрээг төчнөөн багасгана гэсэн үг.

-Зүйтэй, эрхэм ээ. Лхагва гаригийн орой зурж дууссанаа дараа та зургаа харсан уу?

Фрэнклин толгос сэгсрээд:

-Харсан гэж хэлж чадахгүй нь гэв.

-Та харсан уу? гэж түрүүч Кафф над руу эргэн асуухад нь

-Би ч бас харсан гээд хэлчихэж чадахгүй гэв.

-Лхагва гаригийн шөнө хамгйн сүүлд энэ өрөөнд хэн орсон бэ?

-Мисс Рэчел байх.

-Эсвэл таны охин ч байж магадгүй шүү дээ, Бэттереж гуай хэмээн мистер Фрэнклин үг хавчуулаад Пенилопыг мисс Рэчелийн шивэгчин гэдгийг мистер Каффт тайлбарлав.

-Бэттереж гуай, охиноо нааш нь дуудаач. Үгүй байз! Гээд хэнд ч сонсогдохооргүй газар ,цонхны дэргэд намайг дагуулан очиж, -Цаадах ахлах байцааг чинь энэ хэргийг мөрдсөн тухай дэлгэрэнгүй тайлан бичиж надад өгсөн юм. Дашрамд хэлэхэд, энэ хүн зарц нарыг уурлуулсан гэдгээ хүлээсэн байна. Охиндоо болон бусад зарцад миний өмнөөс мэхийн ёслоод доорх хоёр зүйлийг уламжлагтун. Нэгдүгээрт, очир алмаз хулгайлагдсан гэж үзэх нотолгоо одоогоор надад алга, зөвхөн алмаз алга болсон гэдгийг л мэдэж байна. Хоёрдугаарт, алмаз эрж олоход надад хамтран тусална уу гэж зарц нараас хүсэх гэсэн юм.

Ахлах байцаагч Сигрев зарц бүсгүйчүүдийг өрөөндөө орохыг хориглоод юунд хүргэснийг нүдээрээ харсан учраас би,

-Мистер Кафф, бүсгүйчүүлд бас нэг зүйл хэлчихэж болох уу? Тэд одоо шатаар чөлөөтэй гүйлдэж, өрөөндөө дураараа орж, гарч болно гэдгийг таныг хэлүүллээ гэж дамжуулж болох уу? хэмээн лавлав.

-Бололгүй яахав

-Тэгвэл тогоочоос авахуулаад сав угаагч хүртэл цөм дорхноо тайвширна, эрхэм ээ гэсэнд,

-Бэттереж гуай минь, явж тэднийг даруйхан тайвшруулагтун гэв.

Би дээрх үүргийг таван минут ч бололгүй гүйцэтгэв. Чингэхэд ганцхан бэрхшээл тохиолдсон бөгөөд юу гэвэл, эмэгтэйчүүд бүгдээрээ сайн дураар гэрч болж, эрүүлч Каффт туслах гэж хөөрцөглөн Пенилоп бид хоёрын хойноос ухасхийн давхих гэгцгээсэнд тэднийг зогсоохын тулд би даамал хүний бүхий л эрх мэдлээ ашиглахад хүрсэн билээ.

Пенилоп, түрүүч Каффын сэтгэлд нийцэв бололтой. Хүйтэн царай нь арай зөөлөрч, цэцэрлэгт цагаан сарнай үзчихээд илэрсэн шиг байдал царайд нь тодров. Миний охины өгсөн гэрчийн мэдүүлгийг дурдсугай. Мэдүүлгээ их л ялдам, хөөрхөн өгөх шиг санагдлаа. Ер намайг яг өвчсөн, эхийнхээ юуг ч дууриагаагүй хүүхэд л дээ! Тэнгэрийн ивээлээр эхээсээ юу ч өвлөж аваагүй ажээ

Пенилопын өгүүлсэн нь: Будаг холиход нь туслах зуураа хаалганы зургийг үнэхээр сонирхож байлаа. Хамгийн сүүлд гүйцээсэн тул цоожны доод хэсгийг ажигласан. Хэдэн цагийн дараа харахад тэр хсэг балиартаагүй байлаа. Сүүлд шөнийн арван хоёр цагт өрөөнөөс гарахад мөн л хэвээрээ байв. Тэр үед залуу авхайд тавтай нойрсохыг ерөөгөөд унтлагын өрөөнд нь байсан бөгөөд зочны өрөөнд цагийн хони цохиж байсан. Тэгэхд би хаалагны бариулаас бариад зогсож байлаа. Будаг нь нойтон гэж мэдэж байсан учир хаалганд хүрчихгүйг хичээж, хормойгоороо шүргэхсэн байх вий гээд харахад зүгээр байсан. Өрөөнөөс гарахдаа санаандгүй хүрээгүй гэж нотолж чадахгүй, юу өмсөж байснаа санаж байна. Яагаад гэвэл Рэчел авхайн бэлэглэсэн шинэ палааж байсан юм. Эцэг маань ч саанж байгаа, баталсан ч чадна. Одоо аваад ирье.

Өчигдөр оройн өмссөн хувцсыг нь би ч танилаа. Өргөн банзал байсан болохоор ихэд удаан шалгаж үзээд өчүүхэн толбо олсонгүй.

Пенилоп мэдүүлгээ мөн л тун ялдамхан, итгэлтэй дуугсва. Яг л Габриэл Бэттережийг хуулсан хүн дээ.

Дараа нь эрүүлч Кафф, энэ өрөөнд гүйж орохдоо сүүлээрээ хаалганы будаг арчихаар том нохой манайд бий эсэхийг надаас лавлав. Байхгүй гэдгийг сонсоод томруулагч шил авчруулж, толбоны шинж байдлыг мэдэх гэж оролдов. Зураг дээр хүний хурууны хээ ер байсангүй. Бүхий л шинж тэмдэг нь нүднээ илт бөгөөд нэг этгээд хажуугаар нь өнгөрөхдөө хувцсаараа шүргэж балиартуулсан ажээ.

Тэр этгээд Пенилоп мистер Фрэнклин хоёрын мэдүүлсэнчлэн шөнө дундаас пүрэв гаригийн өглөөний гурван цагийн хооронд өрөөнд байж, хаалгаын зургийг балиартуулсан байх ёстой.

Мөрдлөгийг энд хүргээд түрүч Кафф, ахлах байцаагч Сигрев гэгч хүн байдгийг санаж, олж мэдсэн зүйлсээ нэгтгэн дүгнээд мэргэжил нэгт өнөхөртөө өгүүлсэн нь:

-Байцаагч аа, таны хэрэггүй гэж үзсэн энэ зүйл хэмээн хаалганы халтарсан хэсгийг заагаад – Хамгийн сүүд харснаас чинь хойш зэгсэн чухал юм болж хувирлаа. Миний бодлоор брөл мөрдлөгийн одоогийн шатанд, эл толбо гурван зүйлийг илрүүлэх ёстой болж байна. Нэгдүгээрт, будаг хүрсэн хувцас энэ байшинд байгаа эсэхийг мэдэх; хоёрдугаарт, хувцасны эзнийг олох; гуравдугаарт, тэр этгээдээс шөнийн арван хоёроос гурван цагийн хооронд энэ өрөөн дямар зорилготой орж ирснийг нь асуух. Хэрэв тэр хангалттай хариу өгч чадахгүй байвал очир алмаз авсан хүнийг нэг их холоос эрэлтгүй гэсэн үг болно. Та зөвшөөрвөл энэ ажлыг би гүйцэтгэе. Таныг хотод эрхэлдэг тогтмол ажлаас чинь цаашид хөндийрүүлэхийг больё. Та энд нэг хүнээ үлдээжээ. Надад хэрэг болж магадгүй учраас миний захиргаанд үлдээчих. Сайн яваарай гэв.

Ахлах байцаагч Сигрев мөрдөгчийг ихэд хүндэтгэдэг хэдий боловч өөрийн биеийг арай илүү хүндэлдэг юмсанж. Алдарт Каффаас хатуухан банга хүртснийхээ хариуг чадах чинээгээрээ ончтой өглөө. Өрөөнөөс гарахдаа,

-Миний бие өдий болтол саналаа хэлсэнгүй түдгэлзлээ. Энэ хэргийг таны гарт үлдээхдээ ганц зүйл хэлье. Заримдаа туулайн чинээ юмыг уулын чинээ болгоход тун хялбар байдаг. Баяртай, эрхэм ээ гэсэнд,

-Бас хэтэрхий дээгүүр харж явдаг хүн туулаг анзааралгүй өнгөрөх нь хялбар байдаг юм шүү хэмээн Кафф мэргэжил нэгт нөхрийнхөө тааламжтай үгэнд хариу өгөөд эргэж цонх руу алхав.

Фрэнклин бид хоёр цаашид юу болохыг хүлээж байлаа. Кафф халаасандаа гараа шургуулаад “Зуны сүүлчийн сарнай” аяыг намуухан исгэрэн цонхны цаана зогсоно. Ухаан санаагаа хөвчлөн дайчилсан үедээ биеэ барих заншлаа умартан исгэрдэг нь ямар нэгэн дүгнэлтэнд ямх ямхаар хүрч буй хэрэг болохыг би хожим мэдсэн юм. Ийм үед нь “Зуны сүүлчийн сарнай” тусалж зоригжуулдаг бололтой. Энэ ая Каффын зан авиртай нэг л зохицдог мэт санагддаг юм. Энэ ая түүнд дуртай сарнай цэцгийг нь санагдуулдаг, тэгэхдээ маш их гунигтай исгэрэх ажээ.

Мистер Кафф нэг, хоёр минут болоод цонхноос холдож, Рэчелийн унтлагын өрөөний үүдийг гүн бодолд дарагдан ширтсээр, өрөөний голд зогсов. Төдөлгүй сэхээ авч, “Тэр нь дээр!” гэсэн мэт толгой дохисноо, надад хандан, боломжтой бол хатагтайтай арван минут ярилцах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

Ийм даалгавар аваад гарах гэтэл Фрэнклин Каффаас нэгийг асуух шиг болохоор нь босгон дээр саатан сонсвол,

-Та одоо алмазыг хэн хулгайлсан гэж таамаагалж байна? Гэж байна.

-Хэн ч хулгайлаагүй гэж мөрдөгч хариулав.

Эл хэргийн талаар ийм ер бусын хариу сонсоод бид хоёул мэл гайхаж, ямар учиртай болохыг ам өрсөн шалгаасанд,

-Жаахан хүлээзнэ. Зарим эргэлзээтэй зүйлс хараахан тодроогүй байна гэв.

## XIII БҮЛЭГ

Намайг очиход ахайтан зочны өрөөндөө сууж байлаа. Түрүүч Кафф уулзаж ярилцах хүсэлтэй байгааг нь уламжилсанд хирдхийн цочиж,

-Би заавал уулзах ёстой юм уу? Габриэл чи намайг төлөөлөөд ярилцаж болохгүй юу? Гэж асуулаа.

Ийн дургүйцсэний учрыг би ухаараагүй бөгөөд нүүрэн дээр гайхсан маань илэрсэн бололтой. Ахайтан учир байдлаа тайлбарлаж соёрхсон биэлэ.

-Би баахан сандарч балмагдсан шиг байна. Энэ Лондонгоос ирсэн цагдаагийн даргад яагаад ч юм нэг л зэвүү хүрээд байна. Энэ хүн манайд зовлон, хямрал авчирч байх шиг санагдах юм. Миний хувьд тун тэнэг их л зохисгүй боловч тэгж санагдаад байх юм гэж өгүүлэв.

Би хэлэх үгээ олсонгүй. Түрүүч Каффыг харах тусам миний сэтгэлд улам улам нийцэж байсан юм.

Ахайтан сэтгэлээ нээгээд төдөлгүй биеэ барьж чадав. Ер нь төрөлхийн эршүүд зантай эмэгтэй гэдгийг би дээр нэгэнт дурдсан билээ.

-Уулзах ёстой бол уулзъя даа. Гэхдээ хоёулахнаа ярилцаж чадашгүй. Габриэл, нааш нь дагуулаад иргэхдээ, чи энд хамт байгаарай.

Ахайтнаа хар багаас нь мэддэг болсоор ийм арчаагүй байхыг нь анх удаа үзэж билээ. Би буцаж явав. Мистер Фрэнклин цэцэрлэг рүү гарч, мордох цаг нь хариугүй дөхөж буй мистер Годфри дээр очжээ. Эрүүлч Кафф бид хоёр ахайтны өрөө рүү шууд явлаа.

Каффыг хараад ахайтны царай бага зэрэг цонхийлоо! Гэвч сэтгэлийн хөдөлгөөнөө илчлэлгүй, биеэ барьж, намайг байлцахад дургүйцэх эсэхийг Каффаас асуулаа. Тэгээд намайг өвгөн зарцдаа төдийгүй итгэмжлэгдсэн ойрын зөвлөг нь бөгөөд гэр орны ажил хэрэгт хэнийг ч дагуулахгүй ашигтай зөвлөлөгөө өгдөг хүн юм гэж нэмж хэлэв. Түрүүч Кафф миний байлцахыг дуртайяа зөвшөөрөх бөгөөд зарц нарын талаар ер нь нэг зүйл хэлэх ёстой, энэ хэрэгт миний сүрхий туршлагатайг түрүүн нүдээр харсан хэмээн эелдгээр хариуллаа. Ахайтан суухыг урихад бид ч цааргалалгүй суулаа.

Энэ хэргийн талаар би хэдийнэ өөрийн бодолтой болоод байна. Гэвч одоогоор үүнийг өөртөө хадгалахыг зөвшөөрнө үү. Одоо бол мисс Вериндерийн зочны өрөөнд илрүүлсэн зүйлийг, мөн цаашид юуны өмнө хэрхэх бодолтой байгаагаа ахайтанд танилцуулахыг зөвшөөрнө үү.

Дараа нь хаалганы зураг балиартсан гухай, түүнээс хийсэн дүгнэлт зэргээ яг л (гэхдээ арай боловсон байдлаар) ахлах байцаагч Сигревд хэлсэн шигээ өгүүлэв. Төгсгөлд нь,

-Алмаз шүүгээний нүднээс алдагдсан гэдэг л ямар ч маргаангүй зүйл болж байна. Бас нэг зүйл тодорхой байна. Зураг балиартуулсан хувцасны эзэн энэ байшинд л байх ёстой. Цааш нь бас нэг алхам хийхийн тулд хувцасны эзнийг олох хэрэгтэй байна гэв.

-Тэгвэл хулгайчийг олоход дөхөмтэй болох юм шив дээ? Гэж ахайтан асуув.

-Уучлаарай, ахайтан. Очир алмазыг хулгайлсан гэж би хэлээгүй. Одоохондоо алга болчихоод байгаа юм. Халтарсан хувцсыг олж чадвал алмазыг олох зөв замдаа орж чадах юм.

Ахайтан намайг хараад

-Та ойлгов уу? гэж асуухад нь

-Мистер Кафф ойлгож байгаа, ахайтан гэж би хариуллаа.

-Тэр халтартсан хувцсыг та яаж олох гэж байна? Хэмээн Кафф дахин хандаж лавлаад, -Өчнөөн олон жил ажилласан өө сэвгүй зарц, шивэгчин маань авдар савыг хэдийн нэгжсэн гэдийг хэлэхэд ичмээр байна. Тэднийг дахин тэгж доромжлохыг би зөвшөөрөхгүй! Гэв (хатагтай маань ийм л хүн дээ! Түмэн хүнээс ганцхан тохиолдох сайн бүсгүй гэхэд болно!)

-Ахайтан тантай чухам үүнийг л ярилцах гэсэн юм. Түрүүчийн мөрдөгч зарц нарыг сэжиглэж эвгйү ойлголт өгч, мөрдлөгийн ажилд их гай уджээ. Одоо би тэднийг сэжиглэж байна гэсэн бодол дахиад төрүүлчихвэл ялангуяа эмэгтэйчүүд миний ажилд ямар саад учруулж болохыг мэдэж цөхөх юмгүй. Гэлээ гэхдээ тэдний авдар савыг дахиад нэгжиж үзэх хэрэгтэй байна. Яагаад гэвэл, анх алмаз эрж нэгжсэн, одоо бол будаг эрсэн хувцас эрэх жирийн шалтгааны үүднээс дахин нэгжих болно. Зарц нарын сэтгэл санааг харж үзэх ёстой гэж таны хэлдэг тун зөв. Гэтэл зарц нарын хувцасны шүүгээр нэгжих зайлшгүй хэрэгтэй байна.

Бид мэдээж мухардаж таарлаа. Ахайтан үүнийгээ миний энэ хэлснээс хавьгүй хээнцэр үгээр иэлхийлсэн юм.

-Энэ бэрхшээлтэй нүүр тулах нэг санал надад байна. Ахайтан зөвшөөрвөл би зарц нарт учир байдлыг таниулах гээд үзье гэж мистер Кафф хэлэв.

-Эмэгтэйчүүд шууд л өөрсдийг нь сэжиглэж байна гэж бодоцгооно доо гэж би үгийг нь тасалсанд,

-Тэгэхгүй, Бэттерез гуай. Лхагва гаригийн шөнө энэ байшинд хоносон бүх хүний шүүгээр ахайтныхаас эхлээд нэгжинэ гээд хэлчихвэл тэгж бодохгүй гэснээ хатагтай руу хяламхийгээд, -Энэ бол зөвхөн ёс төдий юм шүү дээ. Тэгвэл тэд өөрсдийг нь ноёд, дээдэстэй адил тэгш үзэж гэж ойлгоод мөрдлөгийн ажлыг саатулахын оронд тус дэм үзүүлэх нь нэр төрийн хэрэг гэж бодох юм гэлээ.

Мистер Каффын зөв болохыг би зөвшөөрөв. Гайхахаа нэгэнт больсон ахайтан ч бас зөвшөөрөөд

-Нэгжлэг заавал хийх хэрэгтэй гэж та бодож байна уу? гэж лавлав.

-Энэ хэргийг дуусгах хамгийн дөт зам гэж би хэлэх байна.

Ахайтан шивэгчнээ дуудах хонх цохихоор өндийнгөө,

-Та зарц нартай ярилахдаа миний шүүгээний түлхүүрийг барьж байвал дээр болов уу гэв.

Гэтэл Кафф огт санаанд оромгүй юм асуулаа.

-Бид эхлээд байшинд байгаа бусад ноёд, хатагтай нарын зөвшөөрлийг авбал дээр бус уу? гэв.

-Энд надаас өөр хатагтай гэвэл миний охин л байна шү дээ хэмээн ахайтан гайхан өгүүлээд, -Ноёд гэвэл миний зээ Блэйк, Эблвайт хоёр л байна. Тэр гурвыг татгалзана гэж айхын хэрэг ер үгүй гэлээ.

Тэгэхэд нь би мистер Годфри мордох гэж буйг сануулав. Тийн хэлж дуусаагүй байтал Годфри буудал хүртэл гаргаж өгөхөөр болсон Фрэнклиний хамт үүд тогшин салах ёс гүйцэтгэхээр ирлээ. Хатагтай тэдэнд үүссэн бэрхшээлийг тайлбарлан ярьсанд Годфри даруй зөвшөөрлөө. Цонхоор Сэмуэлд аяны цүнхээ дахин дээш нь оруул гэж хашгираад түлхүүрээ Каффт тушааж,

-Нэгжлэг дууссаны дараа миний юмыг араас Лондон руу илгээчихэж болно шүү гэв.

Мистер Кафф уучлал эрэн,

-Хоосон ёсорхож төвөг удсаныг минь уучлаарай эрхэм ээ. Гэвч дээдсийн жишээ зарц нарт нааштай нөлөө үзүүлэх юм гэж хэлэв.

Годфри ахайтантай их л наалинхай маягаар салах ёс үйлдэж, Рэчелд мэнд дамжуулах нь авхайн татгалзсан хариуг эцсийн шийд гэж үзээгүй, дараа аятай боломж таармагц гэрлэх саналаа дахин хэлэх санаатай байгаа нь надад даанч илэрхий харагдаж билээ. Фрэнклин үеэлийнхээ хойноос гарахдаа хувцас хунар нь ил байгаа тул шалгахад саадгүй, ер юмаа цоож түгжээтэй саванд хийдэггүй хэмээв. Кафф тун их талархсанаа илэрхийллээ. Түүний саналыг хатагтай, Годфри, Фрэнклин гурав огт түдгэлзэлгүй доор нь хүлээж авсныг та харлаа. Одоо зарц нарыг бүгдийг дуудаж, нөгөө будаг болсон хувцсыг эрж хайхын өмнө Рэчелийн зөвшөөрлийг авах л үлджээ.

Ахайтан түрүүч Каффыг жигтэйгээр зэвүүцэх нь улам нэмэгдсэн бололтой. Бид гурвуул үлдсэн хойно,

-Мисс Вериндерийн түлхүүрийг танд өгч явуулбал одоогоор миний зүгээс өөр хийх юм байхгүй биз дээ? Хэмээн асуулаа.

-Уучлаарай, ахайтан. Юуны өмнө угаалагсан зүйлийн бүртгэлийн дэвтрийг үзмээр байна. Толботой хувцас дотуур хувцас байсан ч байж магадгүй. Хэрэв энэ эрэл маань үр дүнгүй болбол энэ байшинд байгаа болон угаалганд өгсөн бүх цагаан хэрэглэл, дотуур хувцасны бүртгэлийг надад үзүүлэхийг хүсье. Ямар нэг юм дутвал чухам түүн дээр л будагны толбо байгаа бөгөөд эзэн нь өчигдөр юмуу, өнөөдөр албаар нуужээ гэж таамаглаж болох юм гээд надад хандан, -Ахлах байцаагч Сигрев, пүрэв гаригийн өглөө эмэгтэй зарц нарыг цугларсан байхад хаалганы будаг заварсан хэсгийг зааж анхааруулсан. Энэ явдал түүний бас нэг ноцтой алдаа байсан байж болох юм шүү гэв.

Ахайтан намайг хонх цохиж, угаалгын бүртгэл авчрах тушаал өгөөч хэмээн хүслээ. Эрүүлч Кафф дэвтэр үзээд юм асууж юу магад гэж дэвтэр авчиртал хамт байлцав.

Угаалгын бүртгэлийг Розанна Спирман авчирч өгөв. Энэ бүсгүй өчигдөр өглөөний цайнд жигтэйхэн цонхийж, ядарчихсан орж байсан ч гээлэ өчигдрийнхөөсөө овоо тэнхэрч, ажлаа хийхтэйгээ болсон ажээ. Эрүүлч Кафф манай бага шивэгчинг өрөөнд орж ирэхэд царайг нь, өрөөнөөс гарахад хазгай мөрийг нь тун анхааралтай ажиглаж билээ.

-Танд өөр хэлэх юм байна уу? хэмээн мөрдөгчийн дэргэдээс холдохын түүс болж байсан ахайтан асуув.

Алдарт Каф угаалгын дэвтрийг сөхөж, хаагс минут хэртэй үзээд л учрыг ойлгон хараад,

-Ахайтан ганц юм асууж таныг чилээхийг зөвшөөрнө үү. Энэ дэвтрийг авчирч өгсөн залуу бүсгүй танайд бусад зарцын адил хугацаатйа ажиллаж байна уу? гэлээ.

-Та яагаад энэ тухай асууж байна вэ?

-Түүнийг хулгай хийсэн хэргээр шоронд сууж байхад нь би харсан юм байна.

Нэгэнд байдал ийм болсон учраа түүнд үнэнийг ярихаас өөр аргагүй боллоо. Хатагтай ахайтан Розаннаг ажилсаг, зан ааш сайтай гэж элдвээр магтаж, засан хүмүүжүүлэх газрын захирал авгай Розаннагийн талаар тун сайхан сэтгэгдэлтэй байсныг дурдаад эцэст нь,

-Та энэ бүсгүйг сэжиглээгүй биз дээ? Хэмээн чин сэтгэлээсээ нэмж өгүүлэв.

-Ахайтан, миний бие энэ мөчийг хүртэл энэ байшинд байгаа нэг ч хүнийг хулгайд сэрдээгүй гэдгээ танд нэгэнт хэлсэн билээ.

Эл хариултыг сонсоод хатагтай маань дээшээ гарч Рэчелийн түлхүүрийг гуйж авах гэж суудлаасаа бослоо. Эрүүлч надаас урьтан хаалга нээж өгөөд доор мэхийв. Ахайтан хажуугаар нь гарахдаа агадсхийх шиг болов.

Бид хоёр хүлээгээд л байлаа, түлхүүр авчрахгүй л байв. Эрүүлч амнаасаа нэг ч үг унагасангүй. Дүнсгэр царайгаа цонх өөд хандуулж, чөргөр гараа халаасандаа хийж, “Зуны сүүлчийн сарнай” гэдэг аяыг намуухан исгэрнэ.

Эцэст нь Сэмүэл ирэв. Гэхдээ түлхүүр авчирсангүй, харин надад нэг зурвас авчирчээ. Эрүүлч Кафф гунигтай харцаа үл салган ширтэхийг нь мэдэрч байсан тул миний бие нүдний шилээ эв дүйгүй, баахан зүдэрч зүүсэн билээ. Ахайтан хоёр гурван мөр бичсэн нь мисс Рэчелийн хувцасны шүүгэгээ нэгжихийг зөвшөөрөхгүй байна гэж мэдэгджээ. Учрыг нь асуусанд уйлж хайлсан гэнэ. Дахин шалгааж лавласанд “Би хүсэхгүй байгаа учраас зөвшөөрөхгүй. Та албадах юм бол би дагах ёстой, харин өөр хэний ч үгийг дагахгүй шүү” гэжээ. Охиноосоо ийм хариу авчихаад мистер Каффын царайг харахаас зовсон учрыг би ойлгож байлаа. Би залуу насны ичимтгий сул талыг ууч сэтгэлээр ойлгодог буурал настан бишсэн бол Каффт өөрийн биеэр учрыг тайлбарлана гэж бодохоос л лав нүүр улайх бйасан биз.

-Мисс Рэчелийн түлхүүрийн талаар мэдээ байна уу? гэж эрүүлч асуув.

-Манай залуу авхай шүүгээгээ нэгжүүлхээс дургүйцжээ.

-Өө! Гэж түрүүч дуугарав.

Тэр дуунд царайд нь тодорч байсан шиг төгс тайван шинж байсангүй. “Өө!” гэхдээ тийм хариу сонсоно гэж мэдэж байсан өнгөөр хэлсэн юм. Кафф миний уурыг хүргэж, бас айдсыг төрүүлж билээ. Яагаад тэгснийг бүү мэд.

-Нэгжлэг хийхээ болих хэрэг үү? Гж би асуув.

-Тэгнэ. Яагаад гэвэл бусад хүн зөвшөөрч байхад танай залуу авхай татгалзжээ. Бид нэг бол энэ байшинд байгаа бүх шүүгээг нэгжих ёстой, үгүй бол нэгийг ч нэгжихгүй. Мистер Эйблвайтын аяны цүнхийг дараагийн галт тэргээр Лондон руу явуул, угаалгын бүртгэлийг нөгөө бүсгүйд өгөөд талархаж баярласныг минь дамжуулаарай.

Угаалгын бүртгэлийг ширээн дээр тавиад тонгоргоо гарган хумсаа цэвэрлэж гарав.

-Таны таамаглал нэг их зөрсөнгүй юу? Гэж би асуусанд,

-Тийм ээ, нэг их зөрсөнгүй гэв.

Учрыг нь хэлүүлэх санаатай,

-Мисс Рэчел яагаад таны ажилд саад хийж байна вэ? Ашиг сонирхлоо бодож танд тусалмаар юм даа? Гэж шалгаавал

-Бэттереж гуай, та жаахан хүлээ, жаахан хүлээж бай гэлээ.

Түүний хэлснийг надаас арай ухаалаг толгой ч юмуу эсвэл мисс Рэчелийг надаас дутуу хайрладаг хүн ухаарах буй заа.

Ахайтан Каффын сэжиглэлийг бүдэ гбадаг таамагласан учраас түүнд зэвүүцэж байжээ гэж би хожим ойлгосон юм. Харин тэгэхэд үүнийг хараахан таамаглаагүй билээ.

-Одоо яах вэ? Гэж би асуулаа.

Эрүүлч Кафф хумсаа цэвэрлэж дуусаад хэдэн хором гунигтайгаар сонирхон харснаа тонгоргоо далд хийж,

-Цэцэрлэгт гарч, сарнай цэцэг сонирхоцгооё гэв.

## ХИҮ БҮЛЭГ

Ахайтны зочны өрөөнөөс цэцэрлэг рүү орох хамгийн дөт зам бол уншигч таны хэдийн мэдэх болсон бутат зөрөг билээ. Цаашдын явдлыг ойлгоход танд дөхөм болгохын тулд эл бутат зөрөг мистер Фрэнклиний зугаалах хамгийн дуртай газар байсныг нэмж хэлье. Гадаа гараад олдохгүй бол энд л байж байдагсан.

Миний бие зэгсэн зөрүүд өвгөн гэдгээ хүлээе. Эрүүлч Кафф бодол санаагаа надаас хэдий их шаргуу нуух тусам би түүнийг нь мэдэхсэн гэж төдийчинээ шамдан зүтгэж байлаа. Бид бутат зөрөг рүү эргэх үедс би бас нэг янаар оролдоод үзэв.

-Би таны оронд ийм байдалд орсон бол бүр мухардаж гүйцсэн дээ гэж би хэллээ.

-Та миний оронд ийм байдалд орсон бол аливаа эргэлзээг тас цохих дүгнэлт хийх болно. Одоо тэр дүгнэлтийг түр хойш тавъя, Бэттереж гуай. Намайг шалгааж зовоогоосой гэж би таныг эндээс дагуулж гараагүй, харин танаас хэдэн юм мэдэж авах гэсэн юм. Мэдээжээр дотор байхдаа та надад хэлж өгч чадах л байлаа. Гэвч сэм чагнадаг хүн, хаалга хочр нийлээд гайхалтай овжин ажилладаг юм. Минийх шиг мэргэжилтэй улс агаарт алхах дуртай, энэ нь эрүүл мэндэд ч тустай байдаг гэж мистер Кафф хариу өгүүлэв.

Энэ хүнийг давна гэдэг санашгүй хэрэг ажээ! Би ч үүнтэй эвлэрч, дараа нь юу гэхийг нь чадлынхаа хэрээр тэсэн хүлээлээ.

Эрүүлч цааш өгүүллүүн:

-Бид танай залуу эзэгтэйн ааш араншинг нягталж, учрыг олох гээд яахав. Надад туслахаас татгалзсанд харамсахаас өөр юм алга яагаад гэвэл ингэснээрээ мөрдлөгийн ажлыг хэвийн байдлаас нь хүндрүүлж байна. Одоо бид хаалганы толбоны нууцыг, та миний үгэнд итгээрйе, мөн очир алмаз алга болсны нууцыг өөр замаар тайлах гэж оролдох ёстой болов. Бэттереж гуай, би одоо зарц нарын шүүгээ савыг нэгжихийн оронд тэдэнтэй уулзаж санаа бодол, аж байдлы нь хянаж тандахаар шийдлээ. Гэвч энэ ажлаа эхлэхийн урьд танаа ганц хоёр юм асуумаар байна. Та бас ажигч гярхай хүн, очир алмаз алга болсныг мэдсэний дараа зарц нарын хэн нэг нь (мэдээжээр, хэрэг явдлын улмаас айж сандарсныг эс тооцон) жигтэй байдалд орохыг та ажиглав уу? Тэдний дунд ямар нэгэн онцгой хэрүүл гарсан уу? Аль нэг нь сэтгэл санаа алдагдсан янзтай харагдсан уу? Жишээлбэл, санаандгүй уурлаж, эсвэл гэнэт өвдсөн хүн бий юу?

Миний бие Розанна Спирман өчигдөр хоолны үеэр гэнэт өвдсөнийг даруй санасан боловч Кафф гэнэт буруу харснаа амандаа аяархан “уухай” гэхэд нь хариу хэлж амжсангүй.

-Юу болоо вэ? Гэж би асуулаа.

-Нуруугаар шархираад уналаа. Тэнгэр муухайрах шинжтэй хэмээн гурав дахь этгээдэд сонсгох гэсэн мэт чанга хэлэв.

Хэд алхаад байшингийн буланд хүрэв. Баруун тийш огцом эргээд дэвсэг дээр гар шатаар уруудан доод цэцэрлэг рүү буулаа. Эргэн тойрноо харж болохуйц задгай газар ирээд эрүүлч Кафф зогсов.

-Нөгөө залуу хүүхнийг Розанна Спирман гэдэг байх аа? Тийм бие галбиртай хүнд сэтгэлтэй залуу бий гэхэд юу л бол. Гэвч бүсгүйн тусын тулд танаас нэг юм одоохон асуух хэрэгтэй байна. Зайлуул, бусдыг дууриаж хүнд дурлаж сүйд болж байсан уу? гэж Кафф асуулаа.

Одоогийн нөхцөлд надаас ийм юм асуудаг нь ямар учиртай хэрэг вэ? Хариу хэлэхийн оронд би түүнийг гөлрөн ширтэв.

-Биднийг хажуугаар өнгөрөхөд Розанна Спирман бутан дунд нуугдсан байхыг би харлаа гэж эрүүлч өгүүлэв.

-Таныг “Уухай” гэж хэлэх үед үү?

-Тийм ээ, намайг “Уухай!” гэж хэлэх үед. Хэрэв хайрлаж шүтдэг хүн байдаг бол тэгж нуугдсаныг нь гайхах юмгүй л дээ. Байдаггүй бол энэ айлын одоогийн нөхцөлд нуугдана гэдэг маш сэжигтэй явдал бөгөөд надад хичнээн харамсалатй хэдий боловч би зохих ёсоор ажиллах хэрэгтэй болно.

Бурхан минь, би юу гэж хариулах билээ дээ? Бутат зөрөг бол Фрэнклиний зугаалах дуртай газар гэдгийг би мэднэ. Галт тэрэгний буудлаас эргэж ирэхдээ мэдээжээр энэ зөрөгөр явна гэдгийг ч гадарлаж байлаа. Розанна түүгээр эргэлдэж байхад нь Пенилоп олон удаа тааралдсаныг ч би мэднэ. Фрэнклиний анхаарлыг татах санаатай тийнхүү эргэлддэг юм гэж охин маань батлан хэлдэг билээ. Охиын зөв бол Розанна, Фрэнклинийг хүлээгээд сууж байхад нь Кафф олж харсан биз. Миний бие Пенилопын оргүй таамаглалыг өөрийн санаа мэтээр хэлэх үү, эсвэл хөөрхий золгүй бүсгүйг эрүүлч Каффын сэжиглэлд оруулж хожим нь маш хэцүү байдалд унагаах уу гэсэн ацан шалаанд орж мухардаж орхилоо. Хүүхнийг чин сэтгэлээсээ өрөвддөг учраас би Каффт шаардлагатай тайлбарыг Розанна, Фрэнклин Блэйкэд дурла нбуруу юм хийж байгаа хүн дээ гэж хэллээ.

Түүрүүч огт инээдэггүй хүн. Хааяа ямар нэг юм зугаатай санагдвал мушийх төдий болно. Одоо бас мушилзлаа.

-Түүнийг муухай төрж, зарц болж буруутсан юм гэж хэлсэн чинь дээр бус уу? гэж Кафф асуугаад, - Фрэнклин Блэйк шиг зан аальтай, царай зүстэй залууд дурлана гэдэг бүсгүйн хувьд нэг их буруудах юмгүй мэт надад санагдана. Гэвч энэ асуудал тодорхой болсонд би баяртай байна. Нэг зүйл тайлагдахад сэтгэл нэг л хөнгөрдөг юм. Бэттереж гуай, би үүнийг чандлан нууна. Хэдийгээр ийм ажил мэргэжилтэй над мэтийн хүнд ховор тохиолддог авч би хүний сул атлыг өршөөх дуртай байдаг. Фрэнклин Блэйк бүсгүйн хоосон мөрөөдлийг огт гадарлаагүй гэж та бодож байна уу? Аяа, бүсгүй царайлаг байсан бол ч зэгсэн түргэн ажиглачих байсан даа. Муухай төрсөн эмэгтэйчүүд энэ хорвоог барахад бэрх шү. Гэвч өөр талаар азтай байх биз гэж найдацгаая. Танайх сайхан цэцэрлэгтэй бас аятайхан нугатай юм. Очир алмаз алга болсныг анх мэдээд, зарц нарын дунд сэжигтэй юм гарахыг та ажигласан уу? гэв.

Өдий хүртэл би эрүүлч Каффтай их л илэн далангүй байсан билээ. Гэтэл сүүлчийн асуултаа далд бодолтой тавьсан учраас би үгээ цэнэх нь зүйтэй гэж үзсэн юм. Энгийн үгээр хэлбэл, хэрэв Кафф мөрдөж сурвалжилсаар өвсөн дундуур мөлхөх могой мэт манай нөхөд, зарц нарын дунд шургалах чигтэй бол би туслах гэж нэг их баярлахгүй сэн.

-Юу ч ажиглаагүй. Тэгээд ч надаас авахуулаад бүгдээрээ самгардаж орхисон байлаа гэсэнд,

-Өө, таны хэлэх юм ердөө л энэ үү? Гэж эрүүлч хэлэв.

-Ердөө л энэ хэмээн би хэнэггүй тайван (ийм байж чадсан гэж би битүүхэндээ сайрхдаг юм) өгүүлэв. Түүрүүч Кафф намайг гунигтай харцаараа тун няхуур эглэн ширтэж,

-Бэттереж гуай, гар барихыг зөвшөөрнө үү? Та миний сэтгэлд онцгой их нийцэж байна гэлээ.

Надад талтай байдгаа хэлэхдээ яагаад чухамхүү түүнийг мэхэлсэн яг төр мөчийг сонгож авсныг би хэрхэвч үл ойлгоно! Гэхдээ л алдарт Каффыг ямар ч гэсэн залилж дөнгөсөндөө би тоглоом ч үгүй маадгар байсан нь мэдээж.

Бид хоёр байшин руу буцлаа. Эрүүлч өрөө гаргаж өгөхийг надаас хүсээд, дараа нь зарц нарыг (зөвхөн дотор ажилладаг) зэрэг дугаараар нь нэг бүрчлэн явуулаач гэж гуйв.

Эрүүлчийг өрөөндөө оруулж, зарц нарыг хүлээх танхимд цуглууллаа. Розанна Спирман тэдний хамт ирэхдээ хэвийн байдалтай харагдав. Розанна тэрүүхэндээ Каффаас дутахааргүй сэргэлэн байжээ. Түүнийг бутны ард нуугдсаныг мэдэхээс өмнө зарц нарын талаар Каффын хэлснийг сонсчихсон болов уу гэж би сэжиглэдэг юм. Ямар ч атугай манай бутат зөргийг энэ насандаа үзээгүй хүн шиг ажиггүй царай гаргана.

Каффын хүссэн ёсоор зарц нарыг ээлжлэн илгээж эхлэв. Тогооч хамгийн түрүүнд үнэн шударгын шүүхэд, өөрөөр хэлбэл миний өрөөнд оров. Тэнд төдий л удсангүй, “эрүүлч Кафф гунигтай хүн юм. Гэвч түрүүч Кафф ёстой л боловсон эрхэм юм” гэдэг яриатай гарч ирлээ. Ахайтны шивэгчин очоод арай удлаа. Тэгээд гарч ирэхдээ “Эрүүлч Кафф нэр хүндтэй эмэгтэйн үгэнд итгэдэггүй юм бол ядахаа санаа бодлоо дотроо хадгалж чаддаг баймаар юм!” гэсэн дүгнэлт хийжээ. Дараа нь Пенилоп

очив. Тэнд нэг, хоёр хором саатлаа. “Аваа эрүүлч Кафф их өрөвдмөөр юм. Залуудаа лав дурлад бүтэлгүйтсэн байхаа” гэсээр гарч ирэв. Пенилопын дараа ахлах зарц явлаа. Ахайтны шивэгчний нэг адил удав. “Бэттереж гуай, нэг муу цагдаад улаан цайм сэрдэгдэх гэж би хатагтайнд ажилд ороогүй юм даг!” гэж хэлсээр гарч ирэв. Дараа нь Розанна Спирман явав. Тэнд бусдаасаа удлаа. Гарч ирээд нэг ч үг дуугарсангүй, уруул нь үнсэн саарал өнгөтэй байв. Розаннагийн дараа Сэмуэл ороод “мистер Каффын гутлыг цэвэрлэсэн хэн бугай ч ичмээр юм” гэсээр гарч ирэв. Эцэст нь сав угаагч Нэнси очлоо. Нэг хоёр минут болоод “Бэттереж гуай, түрүүч Кафф өрөвч хүн юм. Хөөрхий ажилчин бүсгүйг шоолж даажигнахгүй байна” гэдэг дүгнэлттэй гарч ирэв.

Үнэн шударгын шүүх ажиллагаа дууссаны дараа надад өөр захирамж өгөх эсэхийг мэдэх санаатай өрөөндөө орсон эрүүлч цонхоор харан “Зуны сүүлчийн сартай” аяг исгэрэн зогсож байна.

-Юм мэдэж авав уу, эрхэм ээ? Гэж намайг асуусанд,

-Розанна Спирман гадагшаа явъя гэж гуйвал хөөрхийг явуулаарай, гэхэдэ надад эхлээд хэлнэ биз гэж Кафф өгүүлэв.

Розанна мистер Фрэнклин хоёрын тухайд амаа хамхих минь яав даа! Золгүй бүсгүй эрүүлийн хараанд орон нь тодорхой боллоо. Би яаж ч оролдоод Розаннаг аварч дийлсэнгүй.

-Та Розаннаг очир алмаз алга болсон хэрэгт холбогдолтой гэж бодоогүй биз дээ? Хэмээн зүрхлэн асуулаа.

Мистер Кафф гунигтайяа мушилзаад намайг цэцэрлэгт байсан шигээ сүрхий ширтлээ.

-Танд юу ч хэлээгүй нь дээр гэж бодож байна! Эс тэгвэл дахиад л таны урам хугарах болно.

Ер нь би алдарт Каффыг залилж дөнгөсөн гэж үү хэмээн эргэлзэхэд хүрэв. Үүд тогшиж, яриа тасран сэтгэл амраав. Тогоочоос мэдэ ирсэн юмсанж. Розанна Спирманы толгой мөн л өвдсөн учир салхинд гаръя гэж гуйсан гэнэ. Каффын дохисны дараа би зөвшөөрөл өгч, “Гараг, гараг” гэж хэлэв.

Хэл хүргэж ирсэн хүнийг явсан хойно,

-Зарц нарын гардаг хаалаг хаана байдаг вэ? Гэж Кафф асуув.

Би тэр хаалгыг зааж өгсөнд,

-Өрөөгөө түгжих. Намайг хүн сураглавал энд хэрэг явдлыг тунгаан цэгнэж байгаа гээрэй хэмээснээ мушийх аядаад гарч одлоо.

Ганцаараа үлдчихээд эл хэргий нучрыг бие даан олъё гэсэн их хүслэнд автсанаа би мэдэрсэн юм.

Миний өрөөнд зарц нартай нэгбүрчлэн уулзаж ярилцахдаа Розанна Спирманыг сэжиглэж байсан нь улам лавширчээ гэдэг тодорхой байв. Розаннагаас дутахгүй нэлээд удаан асуугдсан манай хатагтайн шивэгчин, гэрийн ахлах зарц хоёр бол золгүй бүсгүйг тэргүүн зэргээр улайран мөрддөг улс байсан юм. Миний бие ийнхүү дүгнэлт хийчихээд зарц нарын өрөөгөөр санаандгүй юм шиг орвол цай ууцгааж байх бөгөөд намайг ч дайллаа. Жич тэмдэглэхэд, ховч эмсийн цай уух гэдэг бөхөж буй дэнлүүнд тос дусаантай чанар нэг билээ.

Цай ууж суугаад үг олж сонсох гэсэн оролдлого маань талаар өнгөрсөнгүй. Хагас цаг ч өнгөрөөгүй байхад Каффын мэдэж байсан бүхэн надад тодорхой болсон юм.

Ахайтны шивэгчин, ахлах зарц авгай хоёр Розаннаг өчигдөр өвдсөн гэдэгт би огт итгээгүй ажээ. Тэр хоёр шулам (намайг уучлаарай, гэвч тийм нүнжиггүй улсыг өөрөөр юу ч гэх вэ дээ?) Пүрэв гаригийн үдээс хойш хэдэн удаа дээшээ гарч, Розаннагийн өрөөг онгойлгох гэж үзсэнд дандаа түгжээтэй байжээ. Тогшсонд хариу өгсөнгүй гэнэ. Чих тавин чагнасан боловч ямар дуу чимээ гарсангүй. Дараа нь Розанна цайнд орж ирээд бие нь муудсан тул очиж хэвт хэмээн явуулсанд мань хоёр шулам өрөөнд нь орох гэж дахиад нэг оролдвол түгжээтэй байж. Цоожных нь нүхээр шагайх гэтэл бөглөчихсөн байжээ. Хаалганы нь доод завсраар галын гэрэл тусч, дотор шад падхийн юм шатах чимээ гарч байжээ (зургадугаар сард зарцын өрөөнд шүү!) Шөнө дөл хэдийн өнгөрч, өглөөний дөрвөн цаг болж байсан гэнэ. Үүнээс үүдэн миний өрөөнөөс Каффын талаар ам муутай гарч ирцгээсэн нь тэр юмсанж. Мөн л түүнээс үүдэн, дээр нь бас данхтай цайны нөлөөгөөр түрүүч Кафф тэдэнтэй хэрхэн бүдүүлэг харьцсаныг ам булаалдан ярилцахад бэлэн байлууа.

Алдарт Каффын булзааруулаад байсныг, Розаннаг салхинд гарахад хойноос нь сэм тандах гэсэн саанаг нь би гадарлаж байсан учраас хатагтайн шивэгчин, ахлах зарц хоёр Каффт хичнээн их тус хүргэсэн боловч тэдэнд зориуд мэдэгдээгүй юм байна гэдэг надад тодорхой байлаа. Хэрэв тэдний мэдүүлэгт итгэж буй шинж тэмдэг цухалзуулах юм бол тэр авгай нар хөөрч сагсуураад илүү дутуу үг донгосч, Розанна Спирманд хар авахуулчихн улс байгаа юм.

Миний бие зуны үдшийн цэнгэг агаарт гарав. Хөөрхий бүсгүйг туйлаас өрөвдөж хэрэг явдал ийнхүү эргэсэнд сэтгэл ихэд зовж байв. Бутат зөрөг рүү очиж нэлээд явтал мистер Фрэнклинтэй тааралдлаа. Үеэл ахыгаа үдэж гаргачихаад ирсэн хойноо Вериндер ахайтай удтал ярилцсан гэнэ. Рэчел хувцасны шүүгээгээ үзүүлэхээс татгалзсан ойлгомжгүй явдлыг сонсоод ихэд гутарч, залхуу авхайн талаар цаашид ярилцахыг төвдөхгүй болсон бололтой. Тэр орой анх удаа түүний удмын зан төрх тэр чигээрээ тод илэрч билээ.

-За, Бэттереж гуай, бидний одоо амьдарч байгаа нууц, сэжиглэлийн агаар таны санаанд таарч байна уу? Очир алмаз авч ирсэн анхны өглөөг та санажбайна уу? Тэрнийг элсэнд хаячихгүй яв даа, бурхан минь! Гэж Фрэнклин өгүүлэв.

Тийнхүү уурлан цухалдсаны дараа биеэ тайвшрахаас нааш ярих хүсэлгүй болжээ. Бид нэг хоёр минут үг дуугүй зэрэгцэн алхасны эцэст эрүүлч Кафф хаачаа вэ гэж асуулаа. Каффыг миний өрөөнд байгаа мэтээр Фрэнклинийг хуурах боломжгүй тул хатагтайн шивэгчин, ахлах зарц хоёрын Розанна Спирманы тухай ярьсан зүйлийг онцлон анхааруулж байгаад болсон явдлыг нэгд нэгэнгүй хүүрнэв.

Мистер Фрэнклин сэргэлэн толгой эрүүлчийн сэжиглэл хаашаа чиглэснийг нүд ирмэх зуур ухаарчээ.

-Өчигдөр өрөөндөө өвчтэй хэвтэж байгаа гэж бидний бодож байсан цагаар Фризинхолын замаар явж байхыг нь нэг худалдаачин харсан мэтээр ярьсан гэж та өнөө өглөө хэлсэн бил үү?

-Тийм ээ, эрхэ ээ.

-Манай нагацын шивэгчин, нөгөө авгай хоёр үнэн л хэлсэн бол худалдаачин түүнийг үнэхээр харсан хэрэг. Хүүхний өвдсөн гэдэг нь биднийг мэхлэх арга байж. Хот руу нэг л базаахгүй хэргээр сэм явсан нь лавтай. Будаг хүрсэн хувцас Розаннагийнх байж, хар үүрээр дөрвөн цагт өрөөндөө гал түлсний учир бол тэр хувцсаа устгах гэжээ. Тэгэхээр Розанна Спирман очир алмазыг хулгайлжээ. Би хэрэг явдал ингэж эргэсэн гэдгийг нагацад одоохон очиж хэлье.

-Одоохондоо хэрэггүй, эрхэм ээ гэсэн үхээнц дуу ард гарав.

Бид хоёр эргэн харвал эрүүлч Каффтай улаан нүүр туллаа.

-Яагаад одоо болдоггүй юм? Гэж Фрэнклин асуусанд,

-Яагаад гэвэл, та ахайд хэлчихвэл ахайд мисс Вериндерт хэлчихнэ шүү дээ гэв.

-Хэллээ гээд юу болох юм бэ? Хэмээн мистер Фрэнклин үхтлээ доромжлуулсан мэт гэнэт шаралхан тун омогтой хэлэв.

-Ийм цагт, ийм асуулт тавих нь зөв гэж та бодож байна уу? гэж мистер Кафф тайван асуув.

Тэд нэг хэсэг дуугүй байцгаалаа. Фрэнклин Кафф руу дөхөж очоод хоёул бие биесээ эгцлэн ширтэв.

Тэгснээ Фрэнклин түрүүлэн ам нээж, дуугаа гэнэт өндөрсгөсөн шигээ гэнэт намсгаж,

-Мистер Кафф та туйлын эмзэг асуудал хөндөж байна гэдгээ мэдэж байгаа биз дээ? Гэсэнд

-Анхны юм биш, би хэдэн зуун удаа эмзэг асуудал хөндөж байсан юм хэмээн Кафф аанай л тайван хариуллаа.

-Тэгэхээр хэрэг явдлыг нагац эгчид ярихыг та хориглож байгаа юм шив дээ?

-Та намайг зөвшөөрөхөөс наана Вериндер ахайд ч юмуу, өөр хүнд үг цухуйлгасан байвал би энэ хэргийг орхино гэдгээ хэлэх гэсэн юм.

Ийнхүү хэлсэн нь асуудлыг шийджээ. Мистер Фрэнклин үгий нь дагахаас өөр аргагүй болж, ууртай гэгч эргэн биднийг орхин одлоо.

Миний бие чухам хэнийг сэрдэх, дараа нь хэрхвэл зохихыг ч мэдэхгүй, тэдний яриаг айж дагжин сонсож байлаа. Тийнхүү балмагдсан авч дараах хоёр зүйлийг ойлгосон юм: Нэгдүгээрт, учир нь олдохгүй зан гаргаж буй манай залуу авхайгаас болж тэд хоорондоо ёжтой үг хаялцжээ. Хоёрдугаарт, тэр хоёр элдэв тайлбаргүйгээр бие биеэ наана цаанагүй ойлгож байгаа юмсанж.

-Бэттереж гуай, та миний эзгүйд маш тэнэг юм хийж дээ. Та бие дааж бяцхан мөрдлөг явуулсан юмаа даа. Хойшид та надтай хамт мөрдлөг хийж ч магадгүй юм гэж түрүүч өгүүллээд намайг сугадан ирсэн замаараа буцаад алхав.

Тийм зэмлэл зүй ёсны хэдий боловч Розанна Спирманыг урхинд оруулахад нь тусалъя гэж огт санаагүй гэдгээ хэлэх байна. Хулгайч ч бай, биш ч бай, хуулинд нийцсэн ч, харшилсан ч надад ер падгүй. Ямар боловч би бүсгүйг өрөвдөж байсан юм.

-Та надаас юу хүсээ вэ? Хэмээн би гараа татаж аваад зогтусан асуув.

-Нутаг орны талаар л жаахан юм мэдэж авах гэсэн юм.

Эрүүлч Кафф газарзүйн мэдлэгээ баяжуулахад нь туслахаас өөр аргагүй болов. Энэ хавьд байшингээс далайн эрэгт шууд хүрэх зам бий юу? Хэмээн эрүүл Нуранги элсний цаана байдаг гацуур модны зүг зааж асуув.

-Тийм ээ, зам бий.

-Надад үзүүлээч.

Зуны үдшийн бүрийд мистер Кафф бид хоёр Нуранги элсийг чиглэж зэрэгцэн алхлаа.

## ХҮ БҮЛЭГ

Нуранги элсний наадах гацуурт ойд орон ортол эрүүлч бодолдоо автан дуу шуугүй явснаа гэнэт шийдсэн хүний байртай сэрэгж, надтай дахин ярьж эхлэв.

-Бэттереж гуай, хүмүүсийн ярьдгаар та энэ хэрэгт миний өрөөл жигүүр болон соёрхож байгаа болохоор өнөө орой надад бас нэг тус хүргэнэ байх хэмээн найдаж цашид бидэнд бие биенээсээ нууж хаах шаардлага үгүй тул өөрийн зүгээс илэн далангүй байх жишээ үзүүлэе. Таны хажууд өө сэвгүй байдаг учраас, та чин сэтгэлээсээ өрөвддөг учраас Розанна Спирманд хор хүргэх мэдүүлэг надад өгөхгүй гэж та шийджээ. Таны хүнлэг санаа бахдууштай боловч одоогийн нөхцөлд огт ашиггүй юм. Очир алмаз алдагдсан хэрэгт оролцсон гэдгийг нь улайм цайм нотлоод өгөх баримт оллоо ч гэсэн Розанна Спирманд огтхон ч гай болохгүй.

-Ахайтан түүнийг хуулийн дагуу мөрдөхгүй гэж та хэлж байна уу?

-Танай ахайтан мөрдөж чадахгүй гэж хэлэх байна. Розанна Спирман өөр хүний гарт зүгээр л зэвсэг нь болсон бөгөөд тэр хүний төлөөнөө Розанна Спирманыг өршөөх болно гэж Кафф хэлэв.

Энэ үгийг үнэхээр буурьтай өгүүлсэн тул эргэлзэж тээнэгэлзэх аргагүй ажээ. Гэтэл миний санаанд нэг л сэжиг төрөөд байлаа.

-Тэр өөр хүний нэрийг хэлж болохсон болов уу? гэж би асуусанд,

-Бэттереж гуай, та хэлж чадах уу? гэв.

-Үгүй.

Эрүүлч Кафф огцом зогтусаад намайг гунигтайяа сонирхон ширтэв.

-Хүмүүсийн сул таылг уучлахад ямагт таатай байдаг юм. Яг одоо бол би таныг уучлахсан гэж туйлаас хүсч байна. Харин та бас л ийм сайхан шалтгааны улмаас Розанна Спирманыг уучлахыг тэсгэлгүй их хүсч байгаа биз дээ, тийм үү? Розанна ойрын үес шинээр дотуур хувцас оёсон эсэхийг та мэдэх ү?

Яах гэж ийм хачин асуулт гэнэт тавьсны учрыг би гадарласангүй. Үнэнийг хэллээ гээд Розаннад гай тарихгүй учраас, бүсгүй манайд ирэхдээ хувцас их муутай байсан, хатагтай маань сайн ажилласны нь учир (сайн гэдэг үгийг би зориуд оцлон хэлэв) хоёр долоо хоногийн өмнө шинэ дотуур хувцас бэлэглэсэн юм хэмээн мэдэгдлээ.

Кафф өгүүллүүн: Энэ хорвоо гэдэг хөөрхийлөлтэй юм! Хүний амьдрал гэгч, гай зовлон байнга хараалан буудаж, сум нь ямагт мэргэн тусдаг байтай чанар нэг билээ. Тэр дотуур хувцсыг өгөөгүй бол бид шүүгээнээс нь шинэ цамц юмуу банзлыг хялбархан олох бөгөөд ийм маягаар Розаннаг илчилж болох байлаа. Та миний санааг ойлгож байгаа биз дээ? Зарц нарыг та өөрөө байцаасан болохоор нөгөө хоёр авгай Розаннагийн өрөөний гаднаас юу олж нээснийг та мэдэж байгаа. Өчигдөр өвчтэй гэж яваад чухам юу хийснийг та мэдэх үү? Та гадарлахгүй байна уу? Ай тэнгэр минь, энэ бол моддын чанаш тусч буй тэр зурвас гэрэл шиг л илэрхий зүйл юм. Пүрэв гаригийн өглөө аравн нэгэн цагт хүний сул талын хуримтлал болсон ахлах байцаагч Сигрев бүх шивэгчинд хаалганы толбыг зааж харуулсан байна. Розаннад өөрийн хувцсаар мөр үлдээчихсэн гэж сэрэмжлэх шалтгаан байжээ. Тэгээд боломж гармагц өрөө рүүгээ очиж, будаг хүрсэн шөнийн цамц, эсвэл банзал, өөр юугаа ч юм олоод өвдсөн дүр үзүүлж, хот руу сэм явж шинээр цамц юмуу банзал оёх даавуу авчраад пүрэв гаригийн шөнө өрөөндөө ганцаархнаа сууж оёсон байна. Гал түлсний учир бол (нөгөө хувцсаа шатаах гэсэндээ биш, хоёр шивэгчин хаалганы гаднаас тандаж байсан юм шатаавал үнэр гарч илчилнэ, тэгэд ч тэр их үнсийг зайлуулах аргагүй гэдгийг сайн ойлгож байжээ) оёон хувцсаа хатааж, индүүдэх, балиартсан хувцсаа өрөөндөө нуух гэсэн юмсанж. Харин энэ мөчид түүнийгээ нэг аятайхан газар, бидний өмнө үзэгдэх энэхүү зэлүүд газар аваачих устгах санаатай байгаа юм. Өнөө орой Розанна загасчны тосгонд нэг байшинд орохыг нь би харсан, одоо буцахдаа хоёул тэр айлаар дайрч болно шүү дээ. Розанна тэднийд хэсэг саатаад гарахдаа цуван дотуураа нэг зүйл нуусан шиг харагдсан. Эмэгтэй хүний өмссөн цув гэдэг бол нигүүлсэнгүй, сэтгэлийн тэмдэг байдаг бөгөөд тун ч их нүгэл хилэнцийг хаацайлдаг юм даа. Тэр айлаас гараад эрэг даган хойшоо явчихсан... Танай далайн эрэг хавийг их үзэсгэлэнтэй сайхан гэлцдэг байх аа, Бэрттереж гуай?

Би "тийм" хэмээн чадах чинээгээрээ товчхон хариулав.

-Хүний сонирхол янз бүр байх юм. Энэнээс дор далайн байгаль ер н байхгүй биз. Та нэг хүнийг мөшгөж дагах хэрэг гараад хэрэв тэр хүн чинь гэнэт эргэж харвал та араар нь ороод нуугдчихаж болохоор сөөм газар ч алга.Надад Розаннаг нэг бол сэжиглэж баривчлах, нэг бол түр дураар нь байлгаж ажиглах хоёр замын нэгийг сонгох хэрэгтй болов. Танд хэлж чилээх хэрэггүй хэдэн шалтгааны улмаас миний бие нэрийг нь үл өгүүлэх нэг хүнд өнөө шөнө хар авахуулахгүйн тулд ямар ч хамаагүй хохирол хүлээхээр шийдсэн юм. Тэгээд би эргийн хойд хэсэгт өөр замаар хүргэж өгөөч гэж танаас гуйх санаатай танай руу буцсан юм. Тод мөрөөр хөтлөн дагуулдаг учраас элс бол мөрдөгчийн шилдэг туслагч билээ. Розанна Спирмантай замд тааралдахгүй, гэгээ тасарчихгүй л бол бүсгүй чухам хаана байсныг нь элс хэлээд өгнө. За, энэ элс. Чимээгүй, намайг өмнөө оруулаад яваарай гэвэл та дургүйцэхгүй биз дээ гэж эрүүлч Кафф хэлэв.

Анагаах ухаанд мөрдөж мөшгих солиорол гэгч байдаг бол надад одоо яг л тийм дон тусчээ. Эрүүлч Кафф элсэн манхан дундуур эрэг уруудан алхална. Зүрх хөөрөн дэлссээр араас нь яваад юу болохыг хүлээзнэн зайдуухан зогсов.

Тэр нэгэн өдөр Розанна бид хоёр ярилцаж байтал мистер Фрэнклин гэнэт хүрч ирсэн газарт бид ирчихээд зогсож байгааг би мэдсэн юм. Би Каффыг харж байвч санаа бодол минь Розанна бидний хооронд болсон явдал руу өөрийн эрхгүй билчин байлаа. Хөөрхий бүсгүй эелдэг харьцлаа гэж надад талархан гарыг минь атган байсансан. Энэхүү Нуранги элс хүсээгүй байхад нь дуудан даллаад байх шиг санагддаг гэж ярьсан нь чихнээ сонсогдох мэт, элс манхны цаанаас бид хоёр дээр гэнэт хүрч ирсэн Фрэнклинийг анх хармагц царай нь туяарч гийгээд явчихсан нь нүднээ үзэгдэх мэт болж билээ. Үүнийг бодох тусам сэтгэл улам гуниглах тул бодлоосоо ангижирья хэмээн эргэн тойрноо ажиглаваас тэрхүү далайн өнчин тохойн байдал сэтгэлийн тавыг улам алдуулах ажээ.

Үдшийн бүүдгэр гэгээ замхарч, эл дүнсгэр газрын зэвүүн нам гүм өнгөрчээ. Далайн давалугаа тохойн элс эргийг өчүүхэн ч анир чимээгүй мөргөх ажээ. Харин үлээх салхигүй тул тохойн ус цэлийн бараантна. Усны толигор мандал дээр хэсэг хэсэг бохир хар ногоон замаг тогтжээ. Хойд, өмнө талд усны мандал дээр сүндэрлэх аварга хоёр цонхны хооронд, жаргах нарны сүүлчийн туяа туссан газар лаг, хөөс үл мэдэг цайвартан гялалзана. Далайн түрлэг эхлэх цаг болжээ. Би ч хүлээн зогсч байлаа. Нуранги элсний бор өнгө гадаргуу бүхэдээ үрчилзэн, чичиргэнэх нь энэхүү гутамшигт газрын цорын ганц хөдөлгөөн ажээ.

Элс оволзохыг үзээд Кафф чацавхийн цочихыг нь би ажиглав. Элсний зүг нэг, хоёр минут ширтэн зогссоноо эргэж, над дээр ирж,

-Бэттереж гуай, энэ ч найдваргүй газар байна даа. Эрэг дээр Розанаа Спирманы нэг ч мөр үлдсэнгүй, эрж хайгаад ч ашиг алга гээд намайг дагуулан уруудав. Тэнд зөвхөн бид хоёрын мөр үзэгдэж байлаа.

-Одоо эндээс загасчдын тосгон аль зүгт бйана вэ? Гэж эрүүлч асуув.

-Коббс Хол (тосгоны нэр) эндээс өмнө зүгт бий.

-Өнөө орой бүсгүй Коббс Холоос гараад эргийн дагуу хойшоо явахыг би харсан. Тэгэхээр энд л ирсэн байх ёстойсон. Коббс Хол энэ хошууны цаана бйгаа юу? Одоо ус гүехэн болохоор эргээр дамжаад очиж болох у?

-Тийм ээ хэмээн асуусанд нь хариулав.

-Уучлаарай, хоёулаа түргэн явъя. Харанхуй болохоос өмнө бүсгүйг эрэг дээр чухам хаана байж байгаа дявсныг нь мэдмээр байна.

Бид Коббс Холын зүг элбэг хоёр зуун ярд алхаж явтал эрүүлч Кафф гэнэт бурханд залбирч мөргөх хүсэлд автсан мэт огцом сөхөрч суув.

-Танай далайн байгалийн тухай нэг ч гэсэн нааштай үг хэлж болохоор байна х эмээн эрүүлч хэлснээ  
-Бэттереж гуай, энд эмэгтэй хүний мөр байна! Үгүйсгэх нотолгоо хараахан гараагүй байгаа үед үүнийг Розанна Спирманы мөр гэж үзье. Мөр баларчээ, хараач, зориуд баллажээ гэж би хэлэх байна. Ай хөөрхий элсний илчлэх чанартайг надаас дутуугүй мэддэг ажээ! Гэвч мөрөө баллахдаа дэндүү их яарч байсан юм биш биз? Тэгсэн шиг байна. Коббс Холын зүгээс ирсэн нэг мөр бас буцсан нэг мөр байна. Гутлынх нь хоншоор шууд ус чиглэсэн байна бус уу? Мөн эрэг дээр өсгийний хоёр мөр усны захад ч бас гарсныг би харсан. Би таны урмыг хугалъя гэж байгаа юм биш. Розанна бол зальтай хүн юм. Саяха та бид хоёрын байсан тэр газар элсэн дээр нэг ч мөр үлдээлгүй очих санаатай байсан бололтой. Хадан хошуу хүртэл усаар яваад хоёр өсгийний мөр үлдээсэн замаараа эргэж явсан гэж үзэж болох уу? За, тэгсэн гэж үзье. Тэгвэл нөгөө айлаас гарахдаа цуван доороо нэг юм нуусан байсан гэж миний хэлсэнтэй тохирч байгаа юм. Гэхдээ тэр зүйлээ устгах гэсэн биш. Үгүй. Тэгвэл очсон газраа мэдэгдэхгүй гэж мөрөө баллах хэрэг юү билээ? Харин тэр зүйлээ нуух гэсэн байх. Энэ нь ч үнэн байх аа. Хоёулаа тэр айлд очвол бүсгүй чухам юу авч явсныг нь мэдэж магадгүй еэ?

Эл саналыг сонсоод мөрдөх дон минь гэнэт замхрав.

-Би ч танд хэрэггүй юээ. Танд ямар тус болох билээ? Гэж асуусанд,

-Бэттереж гуай, би тантай ойр танилцах тусмаа хэчнээн буянтай хүн болохыг тань ойлгох юм. Даруу төлөв байдал! Ай бурхан минь, энэ ертөнцөд даруу төлөв зан юутай ховор билээ! Гэтэл танд энэ чанар ямар их байна вэ! Би тэр оромжинд ганцаараа ороод ам нээнгүүт л хүмүүсийн хэл ам нь татчих биз. Тантай хамт орвол намайг эрхэм хүндтэй хөрш нь танилцуулах тулү яриа аяндаа ундарна шүү дээ. Ийм л байна даа, та юу гэж бодож байна?

Товхийсэн хариу шагхийтэл өгье гэтэл олигтой үг санаанд орсонгүй тул цаг хожих санаатай, чухам аль оромжинд орох гэснийг нь лавлав.

Эрүүлч Каффын хэлсэн үгнээс Ёолланд хэмээх загасчин, эхнэр, насанд хүрсэн хүү, охин хоёртойгоо суудаг оромж болохыг даруй ухаарлаа. Уншигч та эргэж үзвэл, Розанна Спирман Нуранги элс рүү очихдоо Коббс Холл дахь найз нарынхаараа хааяа ордог гэж дурдсаныг минь санах буй заа. Тэр найз нар нь бол Ёолландынх бөгөөд нэр төртэй айл саахалт дундаа хүндэтгэл хүлээсэн хүмүүс

билээ. Манай нутгийнхан хазгар Люси гэж нэрлэдэг тэдний доголон охинтой Розанна танилцаж, улмаар Ёолландын гэрийнхэнтэй танилцсан юмсанж. Эрэмдэг охид хоёр биеэ хайрлаж дотносдог байх гэж би боддог юм. Ямар ч атугай Ёолландынхан Розаннатай ховорхойн уулзах бүрийдээ их л найртай нөхөрсөг байцгаадаг билээ. Эрүүлч Кафф бүсгүйг тэдний байшин хүртэл мөшгөсөн явдал түүний туслаач гэж гуйсны нь хариуд огт өөрөөр хандахад хүргэсэн юм. Розанна дандаа очдог айлдаа очсоныг, загасчны байсныг батлах нь түүнд ямар чгэм зэм байхгүй гэдгийг нотолсон хэрэг болох байлаа. Тэгэхээр Каффын гуйсныг биелүүллээ гэхэд бүсгүйд хор хүргэлгүй харин ч тустай зүйл болох байв.

Биднийг Коббс Холыг зориход, үдшийн гэгээ хараахан тасраагүй тул элсэн дээр мөр үзэгдэж байв. Байшинд орвол гэрийн эзэн хүүгийн хамт загасчлахаар явсан, сул дорой, тамир муутай хазгар Люси амарна гээд дээшээ өрөөндөө орсон байлаа. Зан сайт Ёолланд авгай биднийг гал тогоондоо урьж оруулав. Эрүүлч Каффыг Лондонд алдаршсан хүн гэдгийг дуулмагц нэг лонх голланд хуурай дарс, хоёр шинэ ганс гаргаж ширээн дээр тавиад сайн харж чадахгүй байгаа мэт Каффыг нүд үл салган ширтэнэ.

Миний бие буланд тайван суугаад эрүүлч Кафф яриаг Розанна Спирман руу хэрхэн шилжүүлэх бол хэмээн сонирхож байв. Энэ удаад ч нөгөө л зангаараа, тойруу замаар яриагаа эхэллээ. Гэхдээ вангий гэр бүл, арга зүйчид, загасны үнэ цэнэ цэргийн тухай гунигтай, битүүлэг зангаараа ярьсаар аажимдаа Саран чулуу алга болсон, манай ахлах шивэгчний жөтөөрхөл, зарц шивэгчингүүд Розанна Спирмантай ширүүн харьцдаг тухай сэдэв рүү орло. Эл маягаар гол сэдэвтээ хүрээд, өөрийн биеийг, нэг талаар очир алмазыг эрж олох нөгөө талаар дайснуудынх нь шударга бус сэжиглэлээс Розаннагийн нэрийг цэвэрлэх зорилгоор мөрдлөг явуулж байна гэж ярив. Биднийг ирээд мөч хэртэй болоход цайлган Ёолланд авгай, Розаннагийн сайн андтай ярилцаж байна хэмээн итгэчихээд эрүүлч Каффыг ходоодоо баясгаж, сэтгэлээ сэргээгтүн хэмээн голланд дарсаар нэмж дайлав.

Эрүүлч Кафф Ёолланд авгайтай ярьж цаг дэмий барж байна хэмээн баттай итгэсэн миний бие, тэдний яриаг урьдын цагт жүжиг үздэг байсан шигээ суугаад чагнаж байлаа. Алдарт Кафф гайхам тэвчээр гаргаж, энэ тэр арга замаар уйтгартайгаар аз турших нь нэг сум эрхбиш байнд тусах биз хэмээн хойно хойноос нь таамгаар буудах мэт ажээ. Гэвч хэчнээн хичээгээд бүгд л Розаннагийн нэр төрд хал балгүй дуусаж байв. Ёолланд авгай ам хамхилгүй урсгаж, хамаг нууцаа эрүүлчид итгэмжлэн хүүрнэлээ. Бид цагаа хараад тэднийхээс явахаар завдтал Кафф гомдлын мөрд сүүлчийн удаа туршиж, -Баяртай, эзэгтэй. Эцэст нь хэлэхэд, таны дуулгавартай зарц би Розанна Спирманд чин үнэнээсээ сайныг ерөөж байна. Гэвч, бурхан минь, Розанна энд байж хэрэггүй, явсан нь дээр гэж зөвлөмөөр байна гэлээ.

-Бурхан өршөө! Явах гэж байгаа шүү дээ! Хэмээн Ёолланд авгай дуу алдлаа. (Ёолланд авгайн хэлснийг би Йоркшир аялгуунаас англи хэлэнд хөрвүүлсэн юм. Кафф түүнтэй ярилцах зуураа намайг туслахаас нааш ойлгохгүй тээнэгэлзэж байсан гэдгийг хэлбэл Ёолланд авгайн төрөлх аялгуу ямаршуу болохыг та гадарлах буй заа).

Розанна Спирман манайхаас явна гэнэ ээ! Би чих тавилаа. Олон таван үггүй хэлэхэд, манай хатагтайд ч надад ч энэ тухай дуулгаагүй нь хачирхалтай санагдсан юм. Эрүүлч Каффын сүүлчийн сум байнд тусчихсан юм биш биз гэсэн эргэлзэл төрөөд байлаа. Энэ хэрэгт би бодож байсан шигээ балаг тарилгүй оролцож чадсан эсэхдээ эргэлзэж эхлэв. Шударга эмэгтэйг худал хуурмагийн зангандаа орооцолдуулж ам алдуулсан ч байж магад бус уу? Миний бие протестанд мөргөлтний хувьд чөтгөр бол худал хуурмагийн эцэг бөгөөд чөтгөр явсан газраа ямагт гай зовлон тарьж байдгийг мартаж ёсгүй билээ. Нэг л муу совин татсан тул эрүүлч Каффыг авч гарах санаатай оролдсон боловч мань хүн төдхөн буцаж суугаад голланд дарснаас дахиад нэг балгаж жаал хүч сэлбэе гэж гуйлаа. Ёолланд авгай өөдөөс нь харан суугаад хундаганд нь дарс хийж өгөв. Ихэд сэтгэл зовсон миний бие үүдэнд очоод баяртай гэж л хэлсэн байх, гэхдээ арай явж төвдсөнгүй.

-Тэгэхээр Розанна Спирман явах гэж байгаа хэрэг үү? Тэгээд юу хийх юм бол доо. Өрөвдмөөр юм. Зайлуул, та биднээс өөр найз нөхөд байх биш дээ гэж Кафф өгүүлсэнд Ёолланд авгай,

-Өө, бий шүү! Түрүүн манайхаар ирсэн гэж би танд хэлсэн. Энд баахан сууж, Люси бид хоёртой ярьж хөөрч байснаа дээд давхарт Люсигийн өрөөнд ганцаараа жаахан байа гэж гуйсан юм. Ганцхан тэр өрөөнд үзэг, бэх байдаг юм л даа. "Би нэг найздаа захиа бичмээр байна. Бусад зарц шивэгчин намайг мөрдөж мөшгөөд байдаг болохоор гэртээ бичиж чадахгүй байна" гэлээ. Чухам хэнд захиа бичсэнийг мэдэхгүй, их л удаан суусан болохоор лав хачин урт захиа бичсэн байх. Бууж ирэхээр нь шуудангийн марк авах уу гэж н амайг асуухад гарт нь захиа харагдаагүй, бас марк ч аваагүй. Хөөрхий минь, юм хийж барихдаа хүнээс жаахан нуудгийг та ч мэднэ. Гэвч нэг газар найз нөхөр нь байдаг, түүн дээрээ очих гэж байгаа юм гэдгийг батлан хэлж чадна хэмээв.

-Мөд явах уу? гэж Кафф асуув.

-Аль болох хурдан явна гэсэн.

Тэгэхэд нь би бас л хаалганаас холдов. Манай нэг шивэгчний явах эсэхийг миний дэргэд эрээ цээргүй хэлэлцэхийг зарц нарын ахлагчийн хувьд би цашид тэвчих сонсох аргагүй байлаа.

-Розанна Спирманы тухайд та эндүүрсэн байж таарна. Эндээс явах санаатай байгаа бол хамгийн түрүүнд надад хэлэх ёстой гэж би хэллээ.

-Эндүүрсэн ий? Хэмээн Ёолланд авгай дуу алдаад

-Ганцхан цагийн өмнө, яг энэ өрөөнд надаас замд хэрэглэх зүйлс авсан юм шүү, Бэттереж гуай! Розанна юм худалдаж авсан гэснээс нэг гуйх юм байна гээд тэр яршигтай авгай халаасаа ухаж эхэлснээ,

-Та хоёр буцаж очоод Розаннатай уулзах уу? гэв.

-Хөөрхий бүсгүйд би таныг даалгаврыг дуртайяа дамжуулъя хэмээн намайг ам нээж амжихаас өмнө Кафф хариулав.

Ёолланд авгай халааснаасаа хэдэн шиллинг, зургаан пенс гаргаад алган дээрээ тавин тун гонсойсон янзтай ихэд хичээнгүйлэн тооллоо. Түрүүч Каффт гардуулахдаа тэр хэдэн мөнгөнөөс салахдаа дурамжхан байгаа нь илэрхий янзтай байв.

-Үүнийг Розаннад эргүүлэн өгч, хайрлан ёсолсныг минь дамжуулна уу? Өнөө орой хэрэглэх нэг хоёр зүйл аваад заава үний нь төлнө гээд болоогүй юм. Манайд ч мөнгө хэрэгтэй л дээ, үүнийг үгүйсгэхгүй. Гэхдээ амьтны жаал хуримтлуулсан мөнгий нь авчихаж сэтгэл үл төвдөнө. Үнэнийг хэлэхэд, өвгөн маань маргааш өглөө ирээд Розанна Спирманаас мөнгө авсан гэдгийг дуулбал сайшаахгүй нь лав. Надаас авсан тэр зүйлсийг баяртайгаар бэлэглэж байна гэж хэлнэ үү. Ширээн дээр битгий орхиорой гээд мөнгө гарыг нь хайрах мэт гэнэт Каффын өмнө тавилаа. –Эс тэгвэл одоо цаг үе хатуу, махан бие сул болохоор би буцаагаад халаасандаа хийчихмээр санагдаж магадгүй юм.

-За явъя? Би удаан хүлээж чадахгүй, харих хэрэгтэй байна гэсэнд,

-Одоохон явлаа гэж эрүүлч Кафф өгүүлэв.

-Миний бие хоёр дахь удаагаа хаалга руу зүглэж, гарахаар завдсан боловч бас л босго алхаж чадалгүй түдгэлзэв.

-Хатагтай, мөнгө эргүүлж өгнө гэдэг төвөгтэй ажил даа. Та тэр юмнуудаа хямдхан өгөө биз дээ? Гэж Каффын хэлэх сонсогдлоо.

-Хямд гэнээ! Та өөрөө бодоод үз л дээ гэж Ёолланд авгай өгүүлээд дэн авч Каффыг дагуулан гал тогооны булан руу очив. Амь насанд минь харш байлаа ч гэсэн тэдний хойноос очихгүй байж би хэрхэвч чадахгүй буй заа. Загасчдын живсэн хөлгөөс олж цуглуулсаар борлуулж амжаагүй есөн шидийн новш, голдуу хуучин төмөр овоолоотой байв. Ёолланд авгай тэрхүү новшинд гараа хийж таг, өлгөхөд зориулсан цагираг бүхий төмөр лааз гаргаж ирсэн нь иймэрхүү чийдсэн хайрцгийг газар зүй, далайн замын зургийг ус чийг орохоос хамгаалан хөлөг дээр хэрэглэдэг эд байлаа.

-За, хар! Розанна өнөө орой ирээд ийм хайрцаг авсан. “Зах, ханцуйны эмжээрээ хийхэд яг тохирно. Авдранд өөр юмнуудтай холилдохгүй шүү дээ” гэж хэлээд нэг шиллинг, есөн пенс надад өгсөн. Хагас пенс илүү өгөөгүй гэдгийг батлахын тулд одоо үхэхэд ч бэлэн байна, мистер Кафф минь! Гэж Ёолланд авгай өгүүлэв.

-Хачин хямд өгчээ! Хэмээн Кафф хүндээр санаа алдан хариулав.

Кафф нөгөө хайрцгийг алган дээрээ тавин жигнэж үзнэ. Тэр хайрцгийг харж байхдаа “Зуны сүүлчийн сарнай” дууг аялах нь сонсогдлоо. Эргэлзэх юм байсангүй. Розанна Спирман нэр төрд харшгүй гэж миний итгэж байсан чухамхүү тэр газраас Кафф, Розаннаыг сүйдлэх бас нэг зүйл олжээ. Бүх юм надаас болжээ! Кафф Ёолланд авгай, эрүүлч хоёрыг танилцахад зууч болсондоо чин сэтгэлээсээ юутай их гэмшсэнийг минь та эрэгцүүлэн бодог хэмэнэ орхиё.

-Боллоо. Одоо явцгаая гэж би хэллээ.

Ёолланд авгай намайг огтхон ч тоосонгүй нөгөө новшийг дахин дахин онгичиж, нохойн гинж гаргаж ирээд,

-Эрхэм ээ, үүнийг бариад үз дээ гэж Каффт хэлэв. –Манайд ийм гурван гинжнбайсан юм. Розанна хоёрыг нь авсан. “Хонгор имнь, нохойн гинжээр яах нь вэ? Гэж би асуулаа. “Хооронд нь холбочихвол авдар орооход элбэг хүрэлцэх юм” гэж хариулав. “Олс авбал хямд шүү дээ” гэлээ би. “Гинж нь найдвартай” гэв. “Авдрыг гинжээр багладаг гэж ер сонсоогүй юм байна” гэсэнд, “Өө, Ёолланд гуай минь, битгий дургүйц л дээ. Надад гинжээ авахыг зөвшөөрч үз!” гэж гуйсан юм. Хачин охин шүү, мистер Кафф. Алт шиг сайн, Люси минь дүүгээсээ өөрцгүй хайрладаг, гэхдээ нэг л хачин зантай байдаг юм. За, тэгээд би ч тэр хоёр гинжийг гурван шиллинг зургаан пенсээр өгчихлөө. Шударга эмэгтэйн үнэн үг шүү, ердөө л гурван шиллинг зургаан пенсээр өгсөн дөө.

-Тус бүрийг үү? Гэж Кафф асуусанд,

-Хоёуланг нь! Хоёуланг нь гурван шиллинг зургаан пенсээр өгсөн гэж Ёолланд авгай хариулав.

-Сул өгчээ, хатагтай. Ёстой л сул өгсөн байна! Хэмээн түрүүч толгой сэгсрэн өгүүллээ.

-Энэ мөнгө шүү дээ гэж Ёолланд авгай хэлээд ширээн дээр овоолсон цөөн тооны мөнгөн зоос руу өөрийн эрхгүй татагдах мэт очив.

-Розанна төмөр лааз нохойн гинж л аваад явсан. Нэг шиллинг есөн пенс, гурван шиллинг зургаан пенс, нийлээд тав гурав болсон. Хөөрхий охинд хэрэг болоод байхад нь хуримтлуулсан хэдхэн мөнгийг нь авчих сэтгэл хүрэхгүй байна гэж хэлээд хайр хүндэтгэлийг минь дамжуулна уу.

-Мөнгийг буцааж өгнө гэхэд миний сэтгэл үл тэвчинэ. Та тэдгээр зүйлийг зүгээр өгсөнтэй адил болохоор үнэхээр бэлэглэсэн байна шүү дээ гэж эрүүлч Кафф хэллээ.

-Та үнэхээр тэгж бодож байна уу, эрхэм ээ? Хэмээн Ёолланд авгай асуухдаа царай нь жигтэйхэн гэрэлтээд явчив.

-Үүнд эргэлзэх явдал огт үгүй. Бэттереж гуайгаас асуу л даа гэж Кафф хариуд нь өгүүллээ. Надаас асуух хэрэг ч байсангүй. Миний амнаас “Баяртай!” гэдэг үг л гарав.

-Мөнгө хөрөнгө чөтгөр шулам руугаа тонилог! Гээд Ёолланд авгай биеэ барьж чадахаа больсон мэт нөгөө мөнгөн зооснуудыг гэнэт санд мэнд хамж аваад халаасандаа хийлээ. –Мөнгө хамаагүй хэвтэж, хэн ч авахгүй байгааг хараад би тэвчиж чаддаггүй юм хэмээн яншаа тэр авгай дуу тавиад сандал дээр лагхийн сууж Кафф өөд “Одоо мөнгө миний халаасанд дахиад орсон. Чаддаг юм бол ав л даа!” гэсэн янзтай харж байсан билээ.

Энэ удаад миний бие хаалга руу очсон төдийгүй гэртээ харих гэж босгы нь шийдмэг алхан гарсан билээ. Та юу л гэж ойлгодог санж вэ, тэр хоёрын нэг, эсвэл хоёулаа намайг үхтэл доромжилсон мэт санагдаад явчихсан юм. Гурав алхаагүй байтал эрүүлч араас гүйцэн ирэх чимээ гарав.

-Бэттереж гуай, тусалсанд чинь баярлалаа. Загасчны авгай надад цоо шинэ санаа төрүүллэ би бүр мухардаж орхив гэж Кафф хэллээ.

Каффт миний уур хүрч, бас биедээ зэвүүцэж байсан тул егөөтэй үг аман дээр гарч ирсэн боловч мухардсанаа нуулгүй хэлэхийг нь сонсоод ер н би балаг тарихаар юу хийсэн билээ хэмээн битүүхэн тээнгэлзэж эхэлсэн юм. Тэгээд амаа татаж, Каффын юу гэхийг хүлээв.

-Тийм ээ, хэмээн миний бодлыг таасан мэт өгүүлээд, -Та намайг хэргийн мөрөөр оруулахын оронд харин хазайлгачихлаа. Та Розаннад талтай болохоор үүнийг сонсоод сэтгэл чинь амрах биз. Өнөө орой тэр бүсгүйн үйлдсэн зүйл ойлгомжтой нь мэдээж. Хоёр гинжийг төмөр хайрцагны цагирагт холбоод, усанд юмуу элсэнд хийж, нөгөө үзүүрийг нь зөвхөн өөрөө л мэдэх нэг газар, хадан доогуур бэхэлжээ. Мөрдлөг ямаршуу янзтай дуусахыг ажиглаж, тэнд нь нууж байгаад хожим дуртай цагтаа хайрцагийг нуусан газраасаа гаргаж болох юм. Одоогоор бүх зүйл тов тодорхой байна гээд, -Гэвч тэр хайрцагт чухам юу нуусан юм бол, чөтгө рав хэмээхэд дуунд нь тэвчээр алдсан аяс байхыг би түүнтэй танилцсанаар анх удаа сонсож билээ. Би “Саран чулуу!” гэж бодсон боловч

-Та гадарлахгүй байна уу? гэж л асуув.

-Тэнд очир алмаз хийгээгүй. Розанна Спирман тэр алмазыг авсан бол миний насан турш хуримтлуулсан бүх туршлага сохор зоосны үнэгүй боолно гэж Кафф хариуллаа.

Үүнийг сонсоод эрж сурвалжлах гэсэн хүсэл оргилж намайг дахин эзэмдэн авав. Ямар ч атугай энэ шинэ оньсогыг таая гэхэс ухаанаа алдаж гүйцээд “Будаг хүрсэн хувцас байх нь!” хэмээн бодсон ч юмгүй дуу алдав.

Эрүүлч Кафф харанхуйд зогтусан зогсож, миний гар дээр гараа тавиад,

-Танай нуранги элсэнд ямар нэг юм хаявал дээшээ хөвж гардаг уу? гэж асуухад

-Ер үгүй. Хүнд, хөнгөн юу ч байсан Нуранги элсэнд орвол сорж аваад хэзээ ч ил гарахгүй гэлээ.

-Розанна Спирман мэдэх үү?

-Надаас дутахгүй мэднэ.

-Тэгвэл тэр балиартсан хувцсыг чулуунд ороогоод Нуранги элс рүү шидэхэд л гүйцэх байжээ? Түүнийг нуух шаардлага үгүй байтал нуусан байж таарах нь гээд Кафф цааш алхах зуур, -Тэгэхээр тэнд будаг хүрсэн банзал юмуу, цамц, эсвэл ямар ч лгэсэн нуух хэрэгтэй өөр зүйл байна уу? Бэттереж гуай, ямар нэг саад гарахгүй бол би маргааш Фризинхолл явж, Розаннаа хотод очоод шинэ хувцас оёх даавуу сэм авахдаа чухам юу авсныг нь тодруулъя. Хэргийн байдал иймэрхүү байхад танайхаас явна гэдэг ярвигтай хэдий боловч баримжаагүй сохроор ажиллана гэдэг бүр ч осолтой юм. Жаахан цухалдсаныг минь уучлаарай. Розанна Спирманд дөнгүүдлснээ бодохоос өөртөө дургүй хүрээд байна гэлээ.

Биднийг харихад зарц нар оройн хоолондоо оржээ. Хашаанд ороод хамгийн түрүүнд уулзсан хүн бол ахлах байцаагч Сигревийн эрүүлч Каффын мэдэлд үлдээсэн цагдаа байлаа. Розанна Спирман эргэж ирсэн эсэхийг Кафф түүнээс асуув. Ирсэн. Хэзээ? Цаг орчмын өмнө. Ирээд яаса нбэ? Малгай цуваа тайлах гэж дээшээ гарсан, одоо зарц нартай хамт тайван хооллож байна.

Кафф өөр юу ч асуулгүй, биедээ улам бүр зэвүүцсээр байшингийн арын хаалга руу зүглэв. Харанхуйд миний дуудсаныг ч тоолгүй хаалганы хажуугаар өнгөрчихөөд цэцэрлэгт орохн уд модон

явган хаалганд тулж сая зогслоо. Буцаах санаатай хойноос нь очвол, мань хүн унтлагын өрөөнүүд байдаг хэсгийн нэг цонхыг онцгой анхааран ширтэж байхыг нь харав.

Би бас тийш хараад түүни харцыг тэгтэл булаасан зүйл бол мисс Рэчелийн цонх байсныг мэдсэн бөгөөд цонхны цаана гэрэл хойш урагш хөдлөх нь өрөөнд нэг л жигтэй юм болж буй бололтой.

-Тэр мисс Рэчелийн цонх биз? Гэж эрүүлч Кафф асуулаа.

Миний бие мөн гэдгийг нь нотлоод оройн хоолонд хамт оръё гэж урив. Гэтэл Кафф шөнийн цагаар цэцэрлэгт цэнгэг агаар амьсгалах сайхан байдаг гэх маягийн юм хэлээд байрнаасаа хөдөлсөнгүй. Би ч түүнийг зөнд нь орхиж, үүд рүү эргэтэл явган хаалганы зүгээ “Зуны сүүлчийн сарнай” аялах сонсогдлоо. Эрүүлч Кафф бас нэг нээлт хийжээ! Энэ удаад манай залуу авхайн цонх нээлтийнх нь үндэс болсон аж! Ийм бодол төрмөгц эрүүлч рүү эргэж очоод ганцааранг чинь орхиж зүрхлэхгүй байна хэмээн эелдгээр мэдэгдэх нь зүйтэй гэж үзсэн юм. Тэгээд би Рэчелийн цонхыг заан,

-Танд ойлгомжгүй юм байна уу? гэж нэмж асуулаа.

Каффын дууны өнгөнөөс үзвэл биеэ гэнэт дахиад хүндэтгэн тоож эхлэв бололтой.

-Танай Йоркширийнхэн мөрийцөх нь их дуртай улс байх аа?

-За, тийм гэж бодъё. Тэгээд юу гэж?

Эрүүлч Кафф миний гараас барин,

-Би Йоркширийн хүн байсан бол танай залуу авхай гэрээсээ явах гэж гэнэт шийдсэн гэж тантай нэг соверенээр ч мөрийцөхөд бэлэн байна. Хэрэв би энэ мөрийг авбал, тэгж явъя гэсэн санаа цагийн өмнөөс л төрсөн байна гээд нэг соверен тавихад бэлэн байна гэв.

Каффын эхний таамаглал намайг айлгаж орхилоо. Нөгөө таамаглал нь яагаад ч юм Розанна Спирманыг Нуранги элснээс цагийн өмнө ирсэн гэсэн цагдаагийн мэдээлэлтэй хутгалдаж толгой эргэж гүйцлээ. Эл хоёр таамаглал надад хачин нөлөөлжээ. Хоолны өрөө рүү явахдаа би Каффын гараас гараа суга татан аваад ёс журмыг ч умартан өөрөө учрыг лавлах санаатай хаалгаар түрүүлж оров.

Үүдний өрөөнд хамгийн түрүүнд Сэмуэлтэй тааралдав.

-Ахайтан, түрүүч Кафф та хоёрыг хүлээж байна.

-Биднийг хэр удаан хүлээж байна? Гэх Каффын дуу ард сонсогдлоо.

-Цаг боллоо, эрхэм ээ.

Дахиад л Розанна цагийн өмнө ирсэн, мисс Рэчел ямар нэг жирийн бус хэрэг сэдсэн, одоо хатагтай маань Кафф бид хоёрыг хүлээж байна. Бүгд л нэг цагийн өмнө болсон байх юм! Өөр өөр хүн, элдэв юмс ийм маягаар холбогдсон нь ихэд авцалдаагүй байлаа. Би эрүүлч Каффын зүг харсан ч үгүй, үг дуугарсан ч үгүй шатаар өгслөө. Ахайтны өрөөний үүдийг тогшихоор өргөх үед гар минь цочир салганаж билээ.

-Өнөө орой танайд хэрүүл шуугиан үүсвэл би огт гайхахгүй. Бүү ай! Би энэнээс ярвигтай гэр бүлийн будлианыг зохицуулж явлаа гэж эрүүлч араас шивнэв.

Каффыг тийн хэлэв үү, үгүй юу биднийг орогтун гэх хатагтайн дуу гарлаа.

1Соверен –нэг фунт стерлингийн алтан зоос

## ХҮИ БҮЛЭГ

Ахайтны өрөөнд юм уншихдаа асаадаг ганц жижиг чийдэнгээс өөр гэрэл үгүй байв. Бүрхүүл нь дэндүү доордсон тул хатагтайн нүүр сүүдэрт оржээ. Эрс шулуун зангаараа бидний өөдөөс эгцлэн харахын оронд ширээний хажууд суугаад нээлттэй номоо салахгүй ширтэнэ.

-Мистер Кафф энэ байшингаас нэг хүн явахаар завдаж байгаа учраас урьдаас мэдэж авах нь таны одоогийн гардаж буй мөрдлөгт чухал хэрэгтэй юү? гэж Вериндер ахай асуулаа.

-Маш чухал, ахайтан минь.

-Мисс Вериндер, Фризинхолл руу Эблвайт нагац эгч дээрээ очих гэж байгааг танд хэлэх ёстой. Маргааш өглөө эрт явна.

Эрүүлч Кафф над руу харав. Би Вериндер ахайтай ярилцахаар ухасхийснээ, үнэнийг хэлэхэд, зүрх хүрэхгүй нь гэдгээ мэдсэн учраас ухарч зогсоод нэг ч үг дуугараагүй билээ.

-Ахайтан, мисс Вериндер нагац дээрээ очно гэдгэ хэдийд мэдэгдсэнийг хэлж өгнө үү гэж эрүүлч лавласанд

-Цаг орчмын өмнө гэж ахайтан хариулав.

Эрүүлч Кафф над руу харав. Би Вериндер ахайтай ярилцахаар ухасхийснээ, үнэнийг хэлэхэд, зүрх хүрэхгүй нь гэдгээ мэдсэн учраас ухарч зогсоод нэг ч үг дуугараагүй билээ.

-Ахайтан, мисс Вериндер нагац дээрээ очно гэдгээ хэдийд мэдэгдсэнийг хэлж өгнө үү гэж эрүүлч лавласанд

-Цаг орчмын өмнө гэж ахайтан хариулав.

Эрүүлч Кафф над руу дахиад харав. Настай хүмүүсийн зүрх барагтай бол дэлсэдэггүй гэлцдэг. Гэвч би эргээд хорин тавт боллоо ч гэсэн зүрх минь тэр удаагийн шиг тэгтлээ түргэн дэлсэхгүй буй заа!

-Мисс Вериндерийн юу хийхийг тагнах эрх надад үгүй. Харин чадвал явахыг нь маргааш өдөр болтол хойшлуулаач гэж л танаас гуйх байна. Маргааш өглөө би Фризинхолл руу яваад хоёр цагийн алдад түүнээс эртхэн ч юмуу эргэж ирнэ. Тэр болтол саатуулж дөнгөвөл огт санаандгүй байхад нь яг хөдлөхийнх нь өмнө би мисс Вериндерт нэг хоёр үг хэлмээр байна хэмээн эрүүлч өгүүлэв.

-Маргааш хоёр цагаас нааш мисс Рэчелд сүүх тэрэг өгч болохгүй гэсэн тушаалыг хөтчид очиж дамжуул хэмээн хатагтай надад тэр даруй зарлиг буулгаад дараа нь, -Өөр хэлэх юм байна уу? гэж Каффаас асуув.

-Ганц зүйл байна. Ахайтан, хэрэв мисс Вериндер мордох цагийг нь өөрчилсөнд гайхан, учрыг лавлавал ийнхүү хойшлуулсан шалтгаан нь Би байсан гэж бүү дурсаарай.

Ахайтан нэгийг өгүүлэхээр завдах мэт гэнэт толгойгоо өргөснөө ихэд хүчлэн болиод дахин нээлтэй ном руугаа тонгойн биднийг явж болно хэмээн гараараа дохилоо.

-Гайхамшигтай бүсгүй юм. Гэвч ингэж их биеэ барихгүй байгаа бол таныг мухардуулж буй нөөц өшөө шөнө л тайлагдах сан даа гэж үүдний өрөөнд орохдоо эрүүлч Кафф хэллээ.

Эдгээр үгийг сонсоод л хөгшин тэнэг толгой би сая учрыг ухаарсан юм! Би лав хором хэртэй эрүүл ухаанаа алдсан байх, Каффын цувнаас заамдан авч хананд шахаад,

-Чөтгөр аваг, таныг! Гэж хашгиран –Мисс Рэчел нэг л биш байгааг та надаас дандаа нууж байсан байна гэлээ.

Хананд шахагдан зогссон Кафф эсэргүүцэл үзүүлсэнгүйгээр үл барам номой царай нь өчүүхэн ч хувирсангүй, зөвхөн намайг ширтэх ажээ.

-Өө, та эцсийн эцэст тааварлах шив дээ гэв.

Би түүний энгэрээс гараа салгаж, толгой гудайлгаж билээ. Энэ айлд тавин жил зүтгэснийг минь санаж, тийнхүү дүрсхийн уурласныг минь та уучлах буйзаа. Мисс Рэчел багадаа миний өвөр дээр гараад сахал хуузнаас минь мөн ч олон удаа зулгааж байсан сан. Мисс Рэчел хэчнээн дутагдалтай байвч өвгөн зарц миний хувьд эелдэгхэн ааштай, хамгийн хөөрхөн, хонгохон сайн охин билээ. Түүрүүч Каффаас би уучлал гуйхдаа зохих ёсоор бус усан нүдэлж байсан болов уу гэж эмээнэм.

Гэтэл Кафф сананд оромгүй эелдэг зөөлнөөр,

-Бэттереж гуай, бүү гутар. Бидний мэрэгжлийн улс амархан гуныж гоморхдог бол хумсын толион чинээ ч нэр хүндгүй байх сан. Таны сэтгэлд өчүүхэн атугай хөнгөрнө гэвэл намайг дахиад заамд л даа. Та учрыг нь ухаарахгүй байх, гэвч би таны сэтгэлийг бодоод бухимдсаныг чинь уучилж байна гэсэн билээ.

Сурсан зангаараа гунигтай мушилзах нь тун сайн тоглолоо хэмээн сэтгэсэн бололтой. Би түүнийг зочны бяцхан өрөөндөө дагуулж ороод үүдээ хаав.

-Кафф, та надад үнэнчийг хэлээч. Та чухам юу сэжиглэж байна вэ? Одоо нуувал их л эвгүй шүү дээ гэлээ.

-Би сэжиглэж байгаа юм биш, харин лавтай мэдэж байна гэж Кафф хариулав.

-Мисс Рэчел өөрийнхөө очир алмазыг хулгайлсан гэж та надад цэвэр англи хэлээр хэлж байх шив дээ! Хэмээн шарандаа эгдүүцэн өгүүллээ.

-Тийм ээ, үүнийг л хэлэх гэсэн юм. Мисс Вериндер бүр анхнаасаа Саран чулууг нуужээ. Розанна Спирманд найдаж байжээ. Учир нь, бид Розанна Спирманыг хулгайд сэрдэнэ гэж итгэсэн байж. За, бүх хэрэг алган дээр байгаа мэт илхэн болоо биз. Намайг заамд л даа. Бэттереж гуай... Сэтгэл чинь бага ч гэсэн хөнгөрөх юм бол намайг заамд!

Бурхан өршөө! Тэглээ гээд сэтгэл минь өчүүхэн ч тайтгарахгүй, би зөвхөн,

-Учрыг нь хэлж өгөөч! Гэж л дуугарах сөхөөтэй байжээ.

-Танд учрыг маргааш хэлье. Мисс Вериндер нагац эгчийндээ айлчахаа хойшлуулахаас татгалзвал (татгалзаж л таарна даа та хараарай) би бүх хэрэг байдлыг маргааш танай хатагтайд илтгэхээс өөр аргагүй боллоо. Үүнээс чухам ямар юм болохыг би төсөөлөхгүй байгаа учраас таныг гэрчийн ёсоор хамт байлцаач гэж гуйя. Өнөө оройдоо энэ хэргийг орхиё. Үгүй ээ, Бэттереж гуай, одоо Саран чулууны тухайд дахиад нэг ч үг дуулгах гэж шалгаасны хэрэггүй. Таны ширээг засчихаж. Энэ бол хүн төрөлхтний олон сул талын нэг, миний ямагт уучилдаг дутагдал юм. Таныг зарц дуудах зуур би мөргөл уншихъя.

-Та сайхан хооллоорой. Надад хоол идэх дур алга, харин таныг зохих ёсоор үйлчлэх эсэхийг хараад дараа нь, уучлаарай, явж ганцаараа бие сэтгэлээ барихыг бодъё гэж би хэллээ.

Түүнд дээд зэргээр бэлдсэн төрөл бүрийн хоол унд авчирч өгсөн бөгөөд мань хүн бүгдээс нь бялуурч бөөлжөтлөө идсэн ч би харамсахгүйсэн. Яг энэ үеэр ахлах цэцэрлэгч Бэгби долоо хоногийн тооцоо хийхээр орж ирэв. Кафф тэр даруй сарнай цэцэг, мөн зүлэгт зөрөг хайрга асгасан зөргөөс хавьгүй сайн болох тухай яриа өдөв. Миний бие тэднийг орхиод өрөөнөөсөө сэтгэлийн хүнд дарамттай гарсан юм. Энэ олон жилийн турш анх удаа гансаа нэрэх байтугай “Робинзон Крузодоо” ч хүрэх сөхөөгүй болтлоо балмагдсан байж билээ.

Ядарч туйлдсан, гутарч гонсойсон миний бие өрөөгөө эрүүлч Каффт найр тавьж өгөөд одоо суух газаргүй болоод ганцаархнаа бүгдийг нам гүмд уужуухан эрэгцүүлж тунгаахаар дэвсэг дээр гарав. Бодоод байхаар их юм ч байсангүй.

Насны эцэст тулж, тэнхэл доройтсоноо тод ухамсарч, намайг эрлэг хэдийд аваачих юм бол хэмээн энэ яваа насандаа анх удаа хачирхах сэтгэл төрсөн юм. Ямар боловч би мисс Рэчелд баттай итгэсээр байсан. Түрүүч Кафф, Соломон хаан шиг алдар нэртэй ч байг, манай залуу авхай бузар булай хэрэг хутгалдсан гэж хэлбэл, “Та мисс Рэчелийг мэдэхгүй, харин би мэднэ” тэр мэргэн Соломонд хариулах болно доо.

Миний бодлыг Сэмуэл тасалдуулав. Ахайтнаас зурвас авчирчээ. Тэр зурвасыг гэрэлд унших санаатай байшин руу алхтал тэнгэр муухайрч магадгүй байна гэж Сэмуэл анхааруулав. Сэтгэл хямарсны улмаас би үүнийг урьд нь ажигласангүй байжээ. Гэвч одоо ингэж анхааруулахад нь нохдын гийнэх, салхиын намуухан исгэрэхийг сонслоо. Тэнгэр өөд харвал бөөн бөөн үүл улам бараантан харлаж, зөвхий сарыг залгийн авахаар яаран яаран нүүх ажээ. Шуурга айсуй, Сэмуэлийн зөв байлаа.

Ахайтан зурвасандаа, Фризинхоллын шүүгч нөгөө гурван энэтхэгийн тухай бичсэн гэж мэдээлжээ. Ирэх долоо хоногийн эхээр луйварчдыг суллах ёстой бөгөөд тэд ч зоргоороо явах болно. Тэднийг дахиад байцаах хэрэгтэй юм бол одоо цаг дэмий алдаж болохгүй. Эрүүлч Каффтай уулзахдаа үүнийг дамжуулахыг умартан цалгардсаныг минь нэн даруй залруулагтүн гэж тушаасан байв. Энэтхэгүүдийг би ор тас мартжээ. (Уншигч та ч бас мартсан нь эргэлзээгүй). Энэ сэдэв рүү дахин ороход нэг их ашиг гарахгүй гэж санагдав. Гэвч мэдээжээр ахайтны зарлигийг алгуурлалгүй гүйцэтгэхээр явлаа. Түрүүч Кафф, цэцэрлэгч хоёр дундаа нэг лонх шотландын виски тавьчихаад сарнай ургуулах сэдвээр хүүрнэн сууж байв. Кафф маргаанд бүрэн автаж, намайг ороход яриа тасалж болохгүй хэмээн гараараа дохилоо. Нэг нь цагаан сарнай ургуулсан нь дээр, нөгөө нь нохойн хошуу сайн ургадаг гээд л маргалдацгааж байгаа бололтой. Бэгбийг нэг үг хэлэхэд Кафф эсэргүүцнэ, Каффын хэлснийг Бэгби эсэргүүцнэ. Тэг тоглоомдоо улайрсан багачууд шиг маргаанаа таслуулах гэж намайг дуудсан авч сарнай ургуулах талаар ямар ч төсөөлөлгүй болохоор би төвийг сахихаар шийдэв. Шударга ёс дээсэн дөрөөн дээр санжигнасан эгзэгтэй үед ч буурьтай байдаг хатан хааны шүүгчид лугаа адил би, - Эрхмүүд ээ хэмээн ихэмсгээр өгүүлээд –Та нар хоёулаа хангалттай их ярилцлаа хэмээн түс тас хэлж тэдний маргаан түр намдсаныг ашиглан ахайтны зурвасыг Каффын урд ширээн дээр тавилаа.

Тэгэхэд би эрүүлчийг хорсон жигшихэд бэлхэн байв. Гэвч Кафф бол овжин сэргэлэн ухаанатй бахадмаар хүн байсныг үнэн шударгыг эрхэмлэхийн тул хүлээвэл зохино.

Зурвасыг уншаад асар удалгүй ахлах байцаагч Сигревийн мэдээлэлд энэтхэгүүдийн тухай дурдсан хэсгийн нэхэн санасан учир өгөх хариу бэлэн байжээ. Сигрев мэдээлэлдээ энэтхэгүүдийн зан заншил, хэл яриаг сайн мэддэг нэг алдарт жуулчны тухай бичсэн байх аа? Маш сайн. Тэр эрхмийн нэр алдар, хаягийг нь мэддэггүй биз? Тун сайн. Хатагтайн зурвасны ард тэмдэглээд өгөхгүй юу. Надад их баярлаж гялайснаа илэрхийлээд маргааш өглөө фризинхоллд очоод өөрийн биеэр тэр эрхмийнхээр орно гэлээ.

-Тэгээд шиг гарна гэж та бодож байна уу? Ахлах байцаагч Сигрев тэр энэтхэгүүдийг хорхойд гэмгүй улс байна гэсэн шүү дээ гэлээ би,

-Ахлах байцаагч Сигревийн хийсэн дүгнэлт бүхэн нь буруудсаар ирлээ шүү дээ. Энэтхэгүүдийн талаар ч гэсэн эндсэн эсэхийг нь маргааш шалгавал муугүй л байх гэхихээд Бэгби рүү эргэн харж, “Цэцэрлэгч гуай, та бид цэцэг тарих хөрс шороо, цаг улирал, уйгагүй арчилгааны асуудлыг хэлэлцэж байна. Тэгэхээр одоо танд бас нэг аргын талаар өгүүлье. Та цагаан сарнайгаа...” гээд маргаанаа яг тасалсан газраас нь үргэлжлүүлэв.

Би энэ үед нь тэр хоёрын байсан өрөөний хаалгыг хаан гарсан учир маргааны үргэлжлэлийг сонссонгүй.

Гудамд Пенилоптой тааралдаад юу хийж зогсоно вэ гэж асуула.

Залуу авхайн маргаашийн аяны юмыг бэлтгэх учраас хэзээ хонх цохиж дуудахыг хүлээж байгаа ажээ. Гэрт нь цагдаа ирсэнд мисс Рэчел ичиж зовон, мөн цаашид тэр цагдаатай нэг байшинд сууж байх тэвчээр барагдсан тул нагац эгчийндээ очих болсон гэнэ. Маргааш үдээс хойш, хоёр цагаас өмнө явуулахгүй болсныг хагас цагийн өмнө дуулаад айхавтар их уурлажээ. Тэгэхэд өрөөнд нь байсан Вериндер ахай охиноо сүрхий ширүүн зэмлээд дараа нь ганцаарчлан хэлэх юм байсан бололтой,

Пенилопыг түр гаргасан байна. Манайд тохиолдсон энэхүү золгүй явдал охиныг минь сэтгэлээр унагааж гүйцжээ.

-Аав аа, нэг л биш дээ, хамаг юм учир зүйгээ алдлаа. Бид нарт нэг л гай зовлон ирнэ гэж би ёрлоод байна.

Миний сэтгэл ч бас зовниж байсан хэдий боловч охиныхоо хажууд тайван, цовоо дүр үзүүлсэн юм. Биднийг тийн ярилцаж байтал Рэчелийн хонх жингэнүүлэх дуугаар Пенилоп дутуу орхисон ажлаа гүйцээхээр явлаа. Харин би агаарын даралт хэмжигч үзэж, тэнгэрийн байдлыг мэдэх санаатай үүдний өрөө рүү зүглэв. Үүдний өрөөнд ороод зарц нарын байрны хаалганд дөхөж явтал хаалга гэнэт нээгдэж, Розанна учиргүй шаналж зовсон царайтай, өвдөж зовуурласан мэт нэг гараараа зүрхээ дарсаар ухасхийн гарч, хажуугаар өнгөрөв.

-Хүү минь юу болоо вэ? Бие чинь муу байна уу? гэж би тогтоон саатуулж асуувал,

-Бурхан тэнгэрийг бодож, битгий яриач дээ гэж хэлчихээд гараас минь мултран арын шатруу гүйчихэв.

Би ойрхон зогсож байсан тогооч авгайг дуудаад хөөрхий бүсгүйн хойноос явууллаа. Гэтэл тогоочоос гадна бас хоёр хүн хажууханд байсан юмсанж. Эрүүлч Кафф миний өрөөнөөс сэмхэн гарч ирээд юу болсныг сонирхсонд би “юу ч болоогүй” гэв. Мистер Фрэнклин зарц нарын байрны хаалгыг онгойлгосноо намайг үүдний өрөөнд байхыг хараад, Розанна Спирманыг үзсэн эсэхийг надаас лавлав.

-Саяхан миний хажуугаар жигтэйхэн гутарсан царайтай, их л хачин байдалтай өнгөрсөн шүү, эрхэм ээ.

-Бэттереж гуай яадаг билээ, Розаннаг би өөрөө мэдэлгүй зовоочих шиг боллоо.

-Та юу!

-Би учрыг нь хэлж чадахгүй нь, хэрэв бүсгүй очир алмаз алдагдсан хэрэгт оролцсон бол, хоёрхон минутын өмнө яагаад ч юм бүү мэд, олны дундаас чухам надад л хамаг хэргээ хүлээхийг яг завдсан шүү.

Тэгж ярихад нь би сэрэмжлэн хаалганы зүг хартал яльгүй онгойлгосон мэт санагдлаа.

-Бидний яриаг хүн сэм чагнав уу даа. Намайг босож очих гэсээр байтал хаалгыг зай завгүй ягштал хааж амжсан байв. Онгойлгоод шагайванас эрүүлч Кафф хар цамцныхаа хормойг дэрэвсхийлгэн булан ороон алга болчих шиг санагдав. Каффын мөрдлөгийн чиг чухам хаашаа хандсаныг одоо би нэгэнт мэдсэнээс хойш миний зүгээс тусламж горилоод дэмий гэдгийг Кафф надаас дутуугүй ойлгосон ажээ. Нэгэнт тийнхүү мухардсан тул өөрөө аргалах хэрэгтэй болсноос зайлахгүй учир тэгж сэм хулгайгаар ажиглахаас сийхгүй хүн л дээ.

Хаалгаар шагайхад тэнд Кафф үнэхээр байсан эсэхийг лавтай мэдээгүй миний бие тэртэй тэргүй чамгүй зовлон учраад байхад нэрмээс болохын хэрэггүй хэмээн сэтгээд, байшинд нэг нохой оров бололтой гэж мистер Фрэнклинийг тайтгаруулаад, Розаннатай чухам юу ярьсныгаа хэлээч гэж гуйлаа.

-Эрхэм ээ, та үүдний өрөөгөөр гарсан уу? Розанна тантай санаандгүй тааралдаад юм хэлээ юу? гэж би асуулаа.

Мистер Фрэнклин билъярдын ширээг заан,

-Би Саран чулууны энэ гайтай хэргийг мартагнах санаатай ясан бөмбөг цохиж байлаа. Гэнэт хартал Розанна Спирман хажууд зогсож байлаа, яг л хий үзэгдэл шиг! Тэгж хачин сэмхэн орж ирсэн болхоор нь би анхандаа хэрхэхээ мэдэхгүй баахан гэвдлээ. Учиргүй догдолсон байхыг үзээд, надтай ярилцах гээ юу гэж асуусанд, “Тийм ээ, зүрх хүрвэл ярина” гэв. Бүсгүйг хэрэгт сэрдэж буйг мэдэж байсан учраас ийм үг дуулаад ганц л юм санаанд орлоо. Би ч үнэндээ тулгамдаж орхив. Бүсгүйг надтай илэн далангүй ярилцаач гэж өдөхийг хүссэнгүй. Гэвч бидэнд ийм гай зовлон дайрчихаад байхад хүн надад юм хэлье гэхэд нь цаашаа гэвэл даан ч болчимгүй явдал болно шүү дээ. Тийм ярвигтай байдлаас би зэгсэн болхи мултрах шиг боллоо. “Би таныг сайн ойлгосонгүй. Танд ямар тус хүрэгж чадахсан бол?” гэж асуучихлаа. Гэхдээ би эвгүй муухай харьцаагүй шүү, Бэттереж гуай! Ийм муухай төрсөн нь хөөрхий бүсгүйн буруу биш шүү дээ. Би барьц алдсанаа нуух санаатай цохиур модоор бөмбөг цохин булзааруулж байлаа. Гэтэл байдлыг улам төвөгтэй болгож орхижээ. Би дотроо доромжилъё гэж санаагүй байтлаа бүсгүйг гомдоочихсон бололтой. Розанна огцом эргэж, “Энэ хүн билъярдын бөмбөгөөс хараа салгахгүй, намайг л харахгүй юмсан гэж байх шив!” гэх дуулдав. Араас нь дуудаж зогсооё гэтэл гүйгээд гарчихсан. Бодохоос сэтгэл зовоод байна. Намайг муухай загнах гээгүй юм гэдгийг Розаннад хэлэхгүй юу, Бэттереж гуай? Бүсгүйг очир алмаз алга болсон хэрэгт холбогдолтой болов уу гэж битүүхэндээ сэрдэж байсны улмаас дотроо баахан зэвүүцсэн байх л даа би. Хөөрхий бүсгүйд муу юм санаагүй, харин... гэснээ дуугаа хурааж, билъярдын ширээ рүү буцаж очоод бөмбөг цохиж эхэллээ.

Кафф бид хоёр нэгэнт ярилцсан болохоор Фрэнклиний хэлэхгүй орхисон зүйлийг би дэндүү сайн ойлгосон юм.

Саран чулууг манай бага шивэгчин хулгайлжээ гэдгийг илчилсэн цагт л мисс Рэчелийг зүй бусаар эл хэрэгт сэжиглэж буй эрүүлч Каффын бодлыг тас цохиж чадах юм. Одоо залуу авхайг тайтгаруулах тухай бус, харин гэм буруугүй болохыг нь нотлоход хэргийн учир байлаа. Хэрэв Розанна тийм хэрэг үйлдээгүй бол мистер Фрэнклиний битүүхэн найдлага нь өөрийнх нь хэлснээр Розаннагийн хувьд их л нүнжиггүй бодол байх сан. Гэтэл хэрэг явдал шал өмнөө байлаа. Розанна өвдсөн гэж баашлаад Фризинхолл руу сэмхэн явжээ. Шөнөжин нойргүй сууж нэг юм нууцлан хийсэн ч юмуу, устгасан байна. Мөн энэ үдэш хачин битүүхэн байдлаар Нуранги элс рүү очжээ. Розаннаг хэчнээн их өрөвддөг ч гэлээ энэ бүх шалтгааны улмаас Фрэнклин ноёны таамаглалыг үгүй гэх газаргүй, үнэний хувьтай юм гэдгийг би зөвшөөрөхөөс өөр аргагүй болсон билээ. Энэ тухайгаа ч Фрэнклин хэлсэнд өөдөөс өгүүлдүүн:

-Тийм, тийм! Гэвч горьдлого арай тасраагүй, одоогоор олж хараагүй зүйлийг Розаннагийн гаргасан зан авираас бид хожим мэдэж авч болох юм. Би эмэгтэй хүн гомдоохыг тэвчиж чаддаггүй юм. Би түрүүн хөөрхий бүсгүйд хэлээрэй гэж танаас гуйсан үгийг та заавал дамжуулаарай. Надтай ярилцахсан гэвэл ярилаа гээд би гай зовлонд унах ч бай, үгүй ч бай, ялгаа алга над руу, номын сан руу явуулчихаарай.

Тийм найрсаг үг хэлээд цохиур модоо тавьж, намайг орхин гарлаа.

Зарц нарын байранд орж сураглаваас Розанна өрөөндөө орсон гэнэ. Тусалъя, баръя гэгцгээхэд нь талархсанаа илэрхийлээд, зөвхөн тайван байлгаж ганцааранг минь орхиж үзээч гэж гуйсан байна. Тэгэхэд өнөө орой гэм буруугаа хүлээнэ гэдэг хөг нь өнгөрчээ. Үүнийг мистер Фрэнклин мэдэгдсэнд төдхөн номын сангаас гарч, унтахаар явлаа.

Би гэрэл унтрааж, цонх түгжиж байтал Сэмуэл ирж миний өрөөнд ярилцсаар үлдсэн хоёр гийчний талаар сонин дуулгав.

Цагаан сарнайн тухай маргаан эцэстээ нэг дууссан бололтой. Цэцэрлэгч харьж, харин эрүүлч Кафф хаачсан юм бүү мэд, доод давхарт л лав үзэгдэхгүй байсан гэнэ. Би өрөөгөө шагайлаа. Үнэхээр ч өрөө эзгүй, ширээн дээр хоёр хоосон шилэн аяга байх бөгөөд халаасан архины үнэр хамар цоргино. Кафф өөрт нь бэлдсэн өрөөнд очиж унтах гээд явсан юм болов уу гэж бодоод би дээшээ гарав.

Хоёрдугаар давхрын шатны талбайд гартал зүүнтэйгээс жигд намуухан амьсгалах чимээ гарах шиг санагдлаа. Солгой талд мисс Рэчелийн өрөө рүү ордог гудам байдаг юм. Тийшээ шагайвал гудам хөндлөн тэгнүүлж тавьсан гурван сандал дээр эрүүлч Кафф буурал толгойдоо нусны улаан алчуур зангидаж хар сюртукээ дэрлээд унтаж байх нь тэр!

Намайг дөхөн очтол нохой шиг дорхноо сэртхийн сэрэв.

-Тавтай нойрсоорой, Бэттереж гуай. Танд гэж хэлэхэд, хэрэв та сарнай тарих болбол цэцэрлэгч чинь юу ч гэж эсэргүүцлээ гэсэн нохойн хошуу сайн ургахгүй байхад цагаан сарнай харин ч сайхан ургана гэдгийг та бүү мартаарай.

-Та энд юу хийж байгаа юм бэ? Яагаад өрөөндөө унтахгүй байна гэж би асуусанд,

-Яагаад өрөөндөө унтахгүй байна вэ гэвэл, би бол энэ нүгэлт хорвоо дээр шударгаар биеийн амрыг харалгүй хөдөлмөрлөжмөнгө олдог олон хүний нэг. Өнөө орой Розанна Спирман Нуранги элснээс буцаж ирсэн цаг, мисс Рэчелийн гэрээсээ явна гэсэн цаг тун хачирхалтайгаар тохирч байгаа юм. Розанна нөгөө зүйлийг нууж чадсан байлаа ч танай залуу авхай нуусэн эсэхийг нь мэдэхээс наана явж чадахгүй. Тэр хоёр хэдийн ярилцчихсан байх л даа. Танайхан бүгдээрээ унтсан хойно дахиад харилцах гэж оролдвол би замд нь байж саад хийх гэсэн юм. Намайг засуулсан орон дээрээ унтсангүй гэж бүү зэмлээрэй, очир алмазын балгаар л ингэж байна шүү дээ, Бэттереж гуай минь гэж Кафф өгүүлэв.

-Тэнгэр минь, тэр алмаз манай гэрт огт үзэгдээгүй болоосой! Хэмээн би өөрийн эрхгүй дуу алдав.

Эрүүлч Кафф тэр шөнийг өнгөрөөх гэж өөртөө ор болгон зассан гурван сандлыг харамсангуй хараад,

-Тийм ээ гэж буурьтай хэлэв.

## ХҮИ БҮЛЭГ

Шөнө амар тайван өнгөрлөө. Баяртайгаар нэмж хэлэхэд Рэчел Розанна хоёр ярилцах гэж оролдоогүй тул Каффын сэрэмжилсэн нь талаар өнгөрчээ.

Кафф өглөө босоод л Фризинхолл руу явна байх гэж бодов. Гэтэл эхлээд өөр юм хийх гэсэн бололтой явахгүй азнаад байлаа. Би бодолдоо дарагдсан Каффыг зөнд нь орхиод гадагш гартал мистер Фрэнклин зугаалах дуртай бутат зөргөөрөө алхаж явахтай тааралдав.

Биднийг хоёр ч үг сольж амжаагүй байтал эрүүлч Кафф гэнэт хажууд ирчихсэн байлаа. Фрэнклин Каффтай зэгсэн ихэмсэг харьцсан гэдгийг хүлээх хэрэгтэй.

-Сайхан нойрсов уу, гэж Каффын тун эелдэг асуусны хариуд: “Та надад юм хэлэх гээ юу?” гэж асуув.

-Тийм ээ, энд явуулсан мөрдлөгийнхөө талаар хэд гурван хэлэх үг байна, эрхэм ээ. Мөрдлөг хаашаа эргэснийг өчигдөр та мэдсэн. Таны самгардаж, гутарсан чинь аргагүй юм. Гэр бүлийн будлианд уурсан хилэгнэснээ надад гаргадаг чинь бас ч аргагүй юм гэж Кафф өгүүлэв.

-Танд юу хэрэгтэй юм бэ? Гэж Фрэнклин үгий нь таслан ширүүн асуув.

-Эрхэм ээ, өдий хүртэл миний бие ямар боловч алдаж эндүүрээгүй болохыг хэргийн явц нотолсон шүү гэдгийг танд анхааруулах гэсэн юм. Мөн би бол цагдаагийн газрын хүн, энд энэ гэрийн эзэгтэйн даалгавраар ажиллаж байгааг дашрамд нь бас сануулахыг зөвшөөрнө үү. Одоогийн нөхцөлд та ухамсартай иргэний хувьд олж сонссон юм байвал дуулгаж сонсгох үүрэгтэй юу үгүй юу?

-Би ч юу ч олж сонсоогүй.

Эрүүлч Кафф, Фрэнклиний хариултыг чихнийхээ хажуугаар өнгөрөөж,

-Та намайг ойлгож, надтай илэн далангүй ярих юм бол миний цагийг хэмнэн, элдэв хэрэггүй баримт сэлттэй зууралдах ажлаас ангижруулах юм.

-Би таныг ойлгохгүй байна. Тэнд дуулгах юм надад даанч алга гэж Фрэнклин хариулав.

-Урьд шөнө нэг эмэгтэй зарц (нэрийг нь хэлүхээ байя) тантай аминчлан ярилцсан шүү дээ, эрхэм ээ.

Фрэнклин Каффын үгийг дахин тасалж “Танд хэлэх юм надад алга” гэж дахиад л хэлэв. Би тэдний хажууд дуугүй зогсож байхдаа өчигдөр орой хаалга ялимгүй онгойсон байсныг, хар сюртукийн хормой гялсхийн булан ороон бараа тасарсныг санав. Намайг саад хийхээс өмнө эрүүлч Кафф бидний яриаг чагнаж, Розанна Спирман, Фрэнклин Блэйкд ямар нэг хэрэг хүлээгээд сэтгэл нь уужирчээ гэж бодсон нь эргэлзээгүй ажээ.

Ийм бодол дөнгөж цухалдаж эхэлтэл бутат зөргийн нөгөө үзүүр дээр Розанна Спирман биеэрээ гараад ирэх нь тэр! Пенилоп байшин руу буцаах гэсэн бололтой, араас нь дагана.

Мистер Фрэнклин ганцаараа биш байгааг хараад Розанна зогтусан, хэрхэхээ мэдэхгүй балмагдах шиг боллоо. Пенилоп ч ард нь хүлээн зогсов. Фрэнклин хоёр бүсгүйг надтай зэрэг олж харав. Кафф шулам шиг башир зангаараа тэднийг огт ажиглаагүй, дүр гаргав. Энэ бүхэн нүд ирмэх зуур болсон юм. Мистер Фрэнклин бид хоёр ам нээж амжаагүй байтал эрүүлч Кафф зүгээр ярилцаж байгаа мэтээр Фрэнклинд хээв нэг, тэгэхдээ Розаннад дуулдахуйц чанга дуугаар,

-Эрхэм ээ, тэр бүсгүйд балаг тарина гэж айх хэрэггүй. Харин ч бүсгүйд санаа зовж байвал надад итгэж болно шүү гэж хэлэв.

Фрэнклин ч төдхөн хоёр бүсгүйг үзээгүй дүр гаргаж, мөн л чанга дуугаар,

-Розанна Спирман надад огт хамаагүй гэлээ.

Би зөргийн нөгөө үзүүр рүү харав. Фрэнклиний тэр үгийг сонсмогц Розанна огцом эргэж, саяхан зөрж зүтгэж байснаа болиод Пенилоп түүнийг сугадан байшин руу явахад дуулгавартай даган одов.

Тэгтэл ч өглөөний цайны хонх тачигнаж, эрүүлч Кафф үг олж сонсох гэсэн оролдлогоо орхихоос өөр замгүй болов!

-Бэттереж гуай, би Фризинхолл руу явлаа. Хоёр цагаас өмнө ирнэ гэж надад тайван мэдэгдээд өөр ганц ч үг хэлсэнгүй явсан бөгөөд хэдэ нцаг Кафф үзэгдэхгүй яс амар байж билээ.

Хоёулахнаа үлдсэн хойно Фрэнклин өгүүллрүүн:

-Та Розаннад тайлбарлаж өгөх хэрэгтэй. Тэр золгүй бүсгүйн өмнө би буруудах үг хэлж, эвгүй зүйл хийх учиртай юм байлгүй. Түрүүч Кафф та бид хоёрт занга тавьсныг та хараа биз дээ. Хэрэв намайг будлиулж, бүсгүйн уурыг хүргэж чадсан бол бид хоёрын аль нэгээр өөртөө хэрэгтэй үг олж сонсож дөнгөх байлгүй яхав. Хугацаа даанч давчуу байсан болохоор би өөр олигтой үг олсонгүй. Тэгж хэлснээрээ би бүсгүйд илүү дутуу үг алдавзай гэж анхааруулж, бас эрүүлч Каффт далдын санааг нь ойлгосноо харуулсан юм. Урьд шөнө танд ярьсныг мань хүн чагнаснаас зайлаагүй.

“Чагнасаас ч долоон дор юм болсон! Бүсгүй Фрэнклинд сэтгэлтэй болсон тухай надаас сонссон зүйлээ мартаагүй байж, мистер Фрэнклин Розаннад ямар байдгийг зориуд хөндөж, Розаннад дуулдахаар асуугаад хариуг хэлүүлсэн байна гэж би бодлоо”.

-Чагнасны хувьд гэвэл хоёр дахь бодлоо хав дарья гэж шийдээд –Иймэрхүү байдал нэлээд удаан үргэлжлэх юм бол бид бүгдээрээ л адилхан зовлонд унасан улс болох нь ээ. Сэм тандаж, ажиглах, үг чагнах гэдэг бол тухайн байдалд жирийн зүйл юм. Нэг, хоёр өдрийн дараа бид бүгдээрээ бие биенийхээ нууцыг чагнаснаа мэдээд мэл гайхацгаах биз ээ. Цухалдаж байгааг минь уучлаарай, эрхэм ээ. Манайхыг эзэмдсэн энэ ёрын битүүлэг явдал тархи толгойг мангууруулж орхилоо. Таны надад хэлснийг би мартаагүй. Розанна Спирманд боломж гармагц л байдлыг ойлгууламз.

-Урьд үдшийн талаар Розаннатай ярилцаагүй байгаа юм уу? гэж Фрэнклин асуув.

-Тийм ээ, эрхэм ээ.

-Тэгвэл одоо юм хэлээд хэрэггүй. Би бүсгүйн итгэлийг хүлээхгүй нь дээр, ялангуяа бид хоёрын хамт байхыг Кафф харах гэж тэгтлээ хүсэж бйагаа үед дэмий биз. Би зохисгүй зан гаргаж байна уу? Очир алмаз Розаннад байхгүй бол би хэрхэх билээ гэж бодохоос л жигтэйхэн аймшигтай санагдах юм. Гэтэл тэр бүсгүйн хэргийг улайлгахад Кафф тусалъя гэж би огтхон ч хүсэхгүй байна.

Энэ бол үнэхээр мунхаг утгагүй зүйл болох нь илэрхий. Гэвч би ч бас яг тийм бодолтой байсан учраас Фрэнклинийг даанч сайн ойлгосон билээ. Та нэг үхэх үйлтэн гэдгээ ганц удаа ч болов санах юм бол Фрэнклинийг лав ойлгох буй заа.

Эрүүлч Кафф Фризинхоллыг зорин явах зуур манай байшинд болон гадуур юу болсныг товч өгүүлбэл:

Мисс Речел, нагац эгчийнд нь хүргэж өгөх тэрэг бэлэн болох цагийг хүлээн өрөөгөө дотроос нь түгжээд зөрүүдлэн суусаар байв. Ахайтан, Фрэнклин хоёр хамт цай уулаа. Цайны дараа Фрэнклин гэнэт шийддэг зангаараа холхин явж, толгойгоо сэргээхээр ухасхийн гарав. Тийнхүү зугаацахаар гарахыг нь надаас өөр хүн хараагүй бөгөөд эрүүлчийг буцаж ирэхээс өмнө амжиж ирнэ гэж надад хэлсэн билээ. Шөнө тэнгэр муухайрах төлөвтэй байсан нь ёсоор болж, ширүүн бороо утган асгараад, дараахан нь үүрээр хүчтэй салхи тавьж эхэлсэн юм. Өдөржин салхи сэвэлзэн тэнгэр улам бүрхэн харанхуйлавч бороо орохгүй л байлаа. Залуу болоод чийрэг, далайн зүгээс үе үе үлээх хүчтэй салхийг сөрөн тэсэх чадалтай хүнд бол зугаацан алхахад муугүй өдөр байсан юм.

Цайны дараа би хатагтайдаа гэрийн орлого зарлагын тооцоо хийхэд нь тусаллаа. Саран чулууны хэргийг ганцхан удаа цухас дурдса нн тэр хэргийн талаар ярилцахыг хориглосон үг байлаа.

-Цаад хүнээ иртэл хүлээзнэ. Тэртэй тэргүй ярилцах болно. Одоо хэн ч биднийг тэр тухай ярь гэж шахахгүй хэмээв.

Өрөөндөө орвол Пенилоп хүлээгээд сууж байна.

-Аав аа, та очиж Розаннатай ярилцаач дээ. Миний санаа хачин их зовж байна.

Юу болсныг би гадарласан юм. Гэвч би бол эрчүүд дээд төрөлтний хувьд, боломжтой үе таармагц л эмсэд нөлөөгөө үзүүлэх ёстой гэсэн зарчим баримталдаг билээ. Эмэгтэй хүн миний охин ч байсан ялгаагүй, надаа юм гуйж шалгаавал чухам ямар хэрэгтэй болохыг нь заавал мэдэх гэж эрмэлздэг юм. Тэдний толгойг ажиллуулах гэж та хэдийчинээ их оролдох тусам хэчнээн богино ухаантай болохыг нь төдийчинээ сайн ойлгоно. Бодохоосоос өмнө хэлж, санахаасаа өмнө хийдэг нь тэр хөөрхийсийн буруу биш, харин тэднийг даажигнадаг тэнэгүүдийн буруу юм. Пенилопын сандарсан учрыг өөрийнх нь үгээр уламжилъя.

-Аав аа, мистер Фрэнклин Розаннаг санаандгүй их л муухай доромжилсон шиг байна, яанаа.

-Розанна яах гэж бутат зөрөг рүү очсон юм бэ? Гэж би асуулаа.

-Солиорч л байхгүй юу. Үүнээс өөр юу гэх вэ дээ. Өнөө өглөө ямар ч байсан мистер Фрэнклинтэй заавал ярилцана гээд байсан. Би хориглоод ядсан, та харсан биз дээ. Тэр аймшигт үгийг сонсохоос нь өмнө аваад явж чадсан ч болоосой!

-За боль, боль. Битгий сүржигнээд бай. Розаннаг гомдоож, сүйд болохоор юм гараагүй шүү дээ, би л санахгүй байна.

-Сүйд болоогүй л дээ. Гэвч мистер Фрэнклин Розанна надад ямар ч хамаагүй гэж, пээ ямар хүйтэн өнгөөр хэллээ дээ!

-Эрүүлч Каффын амыг таглах гэж л хэлсэн юм.

-Би Розаннад хэлээд байсан юм шүү дээ. Гэхдээ, аав минь мистер Фрэнклин өөрөө ч мэдэлгүй Розаннаг өчнөөн хоног гомдоож, доромжлоод, одоо бүр иймдээ хүрэх гэж! Мистер Фрэнклинд тоогдох горьдлого байхгүй л дээ. Бие, царай, байр сууриа мартжээ гэж хэлбэл их л нүнжиггүй хэрэг болно. Харин Розанна сэхүүн зангаа хаяж, сэтгэл санаагаар унаж, гуньж гутраад бүр царай алдаж гүйцжээ. Мистер Фрэнклиний үгийг сонсоод хачин аймаар болсон шүү. Тэр үг Розаннаг хад чулуу болгон хувиргах шиг болсон. Тэгээд гэнэт жигтэйхэн тайвширч, одоо ажилдаа орсон ч гэсэн зүүд нойрон дундаа байгаа юм шиг л байна.

Миний сэтгэл баахан уймарч орхив. Пенилопын дууны өнгө эрэгцүүлж бодоход минь саад болж байлаа. Өнгөрсөн орой Фрэнклин, Розанна хоёрын хооронд юу болсныг эргэн саналаа. Тэгэхэд бүсгүйн зүрхийг шимшрүүлсэн бол өнөөдөр тэгэхээс тэгэх гэсэн шиг хөөрхий амьтны эмзэг зүрхийг нь дахиад шархдуулсан байжээ. Даанч тоогүй, тусгүй юм болжээ. Бүсгүйн зүрхний шархыг эдгээх юм үгүй, горьдож найдах ч аргагүй, үүнд л хамаг гай нь байгаа юм.

Миний бие Розаннатай ярилцана гэж мистер Фрэнклинд ам өгсөн бөгөөд одоо үгэндээ эзэн болох тохиромжтой цаг иржээ.

Розаннаг дээд давхрын гудам шүүрдэж байхад нь очлоо. Даруухан эрээн даавуун палажаа аанай л цэмцгэр өмссөн, царай нь цонхигор бөгөөд тайван ажээ. Нүд нь цоггүй мөртлөө, уйлж хайлсан шинжгүй, тэртээ алсыг ширтэх мэт гөлийсөн хачин харцтай байхыг нь би ажиглав. Бодолдоо гүн

автсанаас тэр буй заа. Тэгтлээ гиюүрэн хэдэн зуу дахин ширтээд байх юм ойр хавьд нь мэдээжээр байсангүй.

-Алив, Розанна цовоо байж үз! Дэмий юм бодож, биеэ зовоохоо боль. Мистер Фрэнклин чамд юм хэлээрэй гэсэн шүү гэж би хэлэв.

Тэгээд чадах хэрээрээ эелдэг, зохистой үгээр учир явдлыг үнэн зөвөөр тайлбарлан өгүүллээ. Миний бие эмэгтэйчүүдтэй маш хатуу харьцах хэрэгтэй гэсэн зарчим баримталдгийг та лав ажигласан биз. Гэтэл яг амьдрал дээр, тэдэнтэй нүүр тулаад ирэхээр яагаад ч юм тэр зарчмаасаа ухарчихаад байдаг юм.

-Мистер Фрэнклин их халамжтай, сайн хүн юм. Баярлалаа гэж хэлээрэй гэв. Өөр нэг ч үг амнаасаа унагасангүй. Розанна элий балай мэт ажиллаж байхыг охин маань хэдийн ажигласан билээ. Нэмж хэлэхэд, надтай бас л тиймэрхүү янзтай ярилцсан учраас миний хэлснийг зөв ухаарсан нь юу л бол.

-Розанна, миний хэлснийг ойлгосн биз? Гэж би лавлав.

-Ойлгосон.

Миний үгийг тийнхүү цуурай шиг давтах нь амьд хүн биш, хөдөлдөг хүүхэлдэй гэмээр ажээ. Тэр зуур шал угаасаар байсан тул би чадах чинээгээрээ эелдэг, зөөлнөөр шүүрийг нь аваад,

-За боль, боль охин минь. Сэтгэл чинь тавгүй байгаа даа. Би чиний найз нөхөр, чи буруу хэрэг хийсэн байлаа ч гэсэн анд нөхөр чинь хэвээр үлдэнэ. Розанна, надад ний нуугүй үнэнээ хэлээч дээ! Гэв.

Ийм маягаар ярихад Розанна уярч, нүдэнд нь нулимс цийлэгнэдэг удаа байсан билэ. Гэтэл одоо царай нь ч хувирсангүй.

-Тэгнэ. Би илэн далангүй ярина.

-Ахайтанд уу?

-Үгүй.

-Мистер Фрэнклинд үү?

-Тийм ээ, мистер Фрэнклинд.

Надад хэлэх үг олдсонгүй. Фрэнклин Розаннатай ганцаарчлан ярилцах боломжгүй гэдгийг сануулаарай гэж надад хэлсэн билээ. Гэвч одоо Розаннад сануулаад ч ашиггүй, ойлгох шинжгүй байлаа. Би сорих санаатай Фрэнклин гадагш гарсныг л хэлсэнд

-Тэр х амаагүй. Би өнөөдөр мистер Фрэнклинийг зовоохгүй гэж Розанна хариулав.

-Яагаад ахайтанд ярихгүй гэж байгаа юм бэ? Танд үргэлж сайн байдаг ууч сэтгэлтэй, христос мөргөлтөн эзэгтэйдээ ярьчихвал сэтгэл минь хөнгөрнө шүү дээ.

Миний хэлснийг тогтоож авах гэсэн мэт намайг хэсэг зуур сүрхий анхааралтай ширтэв. Тэгснээ миний гараас шүүрээ авч, аажуухан холдож шал шүүрдэх зуураа

-Үгүй ээ, сэтгэлээ амраах арай дээр арга би мэднэ хэмээн өөртөө хэлэх нь сонсогдов.

-Ямар?

-Намайг зүгээр орхиоч дээ, ажлаа хийе!

Пенилоп хойноос нь очоод тусалъя гэсний хариуд,

-Хэрэггүй. Би эхэлсэн ажлаа дуусгамаар байна. Баярлалаа, Пенилоп оо гээд эргэж харснаа –Гялайлаа Бэттереж гуай гэж билээ.

Розаннад юу ч хэлээд нэмэргүй болжээ. Би Пенилопоп явъя гэж дохив. Биднийг явахад Розанна шал шүүрдсээр дэн дун байдалтай хоцров.

-Эмчид үзүүлэх хэрэгтэй болжээ. Би ч барахгүй юм байна гэж би хэлэв.

Мистер Канди төрсөн өдрийн цайллагаас харьж яваад салхинд цохиулж (та мартаагүй биз дээ) одоо өвчтэй байгаа шүү дээ гэж охи нмаань сануулав. Мистер Кандийн туслагч Эзра Женнингс гэгчийг дуудаж болно л доо. Гэвч манайханд түүнийг мэддэг хүн ховор. Мистер Кандийн дэргэд зэгсэн хачин байдалтай ажилладаг юм. Ямар ч атугай бидний хэн нь ч Эзра Женнингст итгэдэггүй, бас дургүй билээ. Фризинхоллд өөр эмч нар бий боловч манайхан сайн таньдаггүй байв. Танихгүй эмч үзвэл Розанна сайжрахын оронд бүр дордчих болов уу гэж Пенилоп айгаад байлаа.

Би ахайтантай ярилцъя гэж бодсон авч тэртэй тэргүй зовж шаналж байхад нь зовлон нэмчихэж магадгүй хэмээн түдгэлзэв. Гэтэл нэг араг хэмжээ авах хэрэгтэй байдаг. Розаннагийн байдал тун ярвигтай байгаа тул эзэгтэйд мэдэгдэх нь чухал гэж сэтгээд зочны өрөө рүү нь дурамжхан зүглэв. Өрөө нь эзгүй байлаа. Ахайтан охиныхоо өрөөнд оржээ. Тэгэхээр гарч ирэхээс нааш уулздаг хөг өнгөрсөн аж.

Миний бие ахайтанг дэмий л хүлээсээр байтал гол шатны цаг хоёрт арван таван минут дутуу болохыг илтгэн цохив. Таван минутын дараа гаднаас намайг дуудах сонсогдсон бөгөөд хэн дуудсаныг даруй танилаа. Эрүүлч Кафф Фризинхоллоос буцаж иржээ.

## ХҮИИ БҮЛЭГ

Би голын хаалга руу очиж Каффыг шатан дээр тосон авч уулзав.

Бидний хооронд болсон явдлын улмаас би мистер Каффын ажил хэргийг огт тоомсорлохгүй байгаа мэт дүр арга буюу үзүлэх хэрэгтэй болов. Гэвч сониуч зандаа аргагүй дийлдэж бардам нэрэлхүү зангаа даран,

-Фризинхоллоор ямар сонинтой байна? Гэж асууж орхилоо.

-Нөгөө энэтхэгүүдтэй уулзлаа. Бас өнгөрсөн пүрэв гаригт Розанна хот орж чухам юу авсныг нь мэдлээ. Энэтхэгүүдийг ирэх лхагвад сулана гэсэн. Тэд Саран чулуу хулгайлах санаатай энд ирсэн гэж мистер Мэртвэйт бид хоёрын таамаглал эргэлзээгүй зөв байж. Лхагва гаригийн шөнө гарсан хэрэг тэдний төлөвлөгөөг баллаж орхисон л доо. Алмаз алга болсон хэрэгт тэд таны адил даанч буруугүй. Гэвч, Бэттереж гуай очир алмазыг бид олохгүй юмаа гэхэд тэд олно гэдэг ганц зүйлийг хэлж чадах байна. Тэр гурван илбэчний тухай цаашид та нэлээд юм сонсоно байх шүү гэлээ.

Фрэнклин зугаалаад эргэж ирэхэд Кафф энэхүү гайхалтай зүйлээ хүүрнэж бйлаа. Фрэнклин сониуч зангаа надаас хавьгүй чадмаг дарж, бидний хажуугаар юу ч хэлэхгүй өнгөрөн байшинд оров.

Миний бие бардам зангаа хэдийн огоорч, дүүрсэн хэрэг гэж бодоод,

-Энэтхэгүүдийн хувьд тийм байж Розаннагийн тухайд юу байна? Гэж асуулаа.

Эрүүлч Кафф толгой сэгсрэв.

-Учир нь бүр олдохоо байлаа. Би Розаннагийн мөрөөр явсаар Молтби гэгч худалдаачны дэлгүүрт очлоо. Тэднийхээс нэлээд урт дааваа авснаас биш цэмбэний дэлгүүрээр ч ороогүй, оёдолчныд ч очоогүй байна. Тэр даавууг авахдаа чансаатай эсэхийг нь их сонирхож байжээ. Тэгээд унтлагын цамц хийхэд элбэг хүрэлцэх хэмжээний даавуу авсан юм байна.

-Хэнд? Гэж би лавлав.

-Өөртөө л байж таарна. Пүрэв гаригийн арван хоёроос гурван цагийн хооронд, та нарыг унтсан хойгуур Саран чулууг чухам хаана нуух талаар тохиролцох байсан тул залуу авхайн өрөөнд орох хэрэг гарчээ. Өрөө рүүгээ буцаж яваад хаалганы нойтон будгийг унтлагын цамцаараа шүргэсэн ажээ. Будгийг угаагаад арилгаж дийлээгүй байна. Бас дотуур хувцсаар бүрэн байлгахаар солчих яг тийм цамцгүй байсан болохоор шууд устгачихаж болохгүй байжээ.

-Розаннагийн цамц гэдгийг юугаар батлах юм бэ? Гэж би шалгаав.

-Цамц хийх гэж авсан даавуугаар нь баталж болно. Мисс Вериндерийн цамц байсан бол тор, хуниас, бас бус юм авах ёстой. Тэгээд ч ганц шөнө оёж гүйцэхгүй. Энгийн даавуу л авсан болохоор зарц хүний эгэл цамц оёлоо гэсэн хэрэг. Бэттереж гуай, ээн бүхэн зэгсэн тодорхой байгаа юм. Харин шинэ цамц оёж авчихаад будаг хүрсэн цамцаа устгахын оронд яах гэж нуусны учрыг олоход л хэцүү байна. Бүсгүй хэлэхгүй бол тэрх бэрхшээлийг давах ганцхан зам бий. Нуранги элсийг нэгжих хэрэгтэй, тэгвэл сая үнэн учрыг тайлах болно гэж эрүүлч хариуллаа.

-Нуусан газрыг нь та яаж олох юм бэ? Гэж би бас л шалгаасанд Кафф,

-Уучлаарай, таны урмыг хугалах нь дээ. Энэ нууцыг өөртөө хадгалъя гэж би бодож байна гэв.

Намайг тэгж зовоосон шиг таны сониуч занг хөдөлгөж бас зовоохгүйн тулд, Кафф Фризинхоллоос нэгжих эрхийн бийг авчирсан гэдгийг урьдаар хэлчихье. Розанна юм нуусан газраа тэмдэглэж авсан нь лавтай агаад нөхцөл байдал өөрчлөгдөж, цаг хугацаа улиран өнгөрөхөд тийшээ хэзээ нэг цагт очно гэдгийг Кафф туршлагаасаа мэдэж байжээ. Тэр тэмдэглэлийг нь олоод авчихвал зорьсон хэргээ бүтээж чадах ажээ.

-За, Бэттереж гуай хэмээн Кафф цааш үргэлжлүүлэн, -Элдэв таамаглаа орхиж, ажил хэрэгтээ орё. Розаннаг тандаж байгаарай гэж Жойст хэлсэн юмсан. Жойс хаана байна вэ? Гэлээ.

Жойс гэдэг нь ахлах байцаагч Сигревээс түрүүч Каффын мэдэлд үлдээсэн Фризинхоллын цагдаа юм. Энэ үед хоёр цагийн хонх цохив. Хөтөч товлосон цагийг ягштал баримтлан, Рэчелийг нагац эгчийнд нь хүргэж өгөх сүүх тэрэг үүдэнд ирж зогслоо.

-Би Жойсын хойноос явахыг завдтал Кафф,

-Байзаарай, эхлээд нэг ажлаа гүйцээчихье. Мисс Вериндертэй ярилцах хэрэг байна гээд намайг саатуулав.

Тэнгэр бүрхэж, бороо орох төлөвтэй байсан боловч мисс Рэчелийн Фризинхоллд аваачих тэргийг гаргажээ. Сүүхний хойд талын гишгүүр дээр байсан Сэмуэлийг Кафф хуруугаараа дохин дуудаж ирүүлээд,

-Дааман хаалганы наахна манай нэг нөхөр модон дотор хүлээж байгаа. Сүүх тэрэгний явдал дунд, таны хажууд гарна. Тэгэхэд нь та нүдэн балай байж, амаа хамхиж яваарай. Эс тэгвэл танд тоогүй юм болох байх шүү гэлээ.

Тийн зөвлөөд зарцыг буцааж явуулав. Сэмуэл юу бодсоныг бүү мэд. Мисс Рэчел гэрээсээ явах л юм бол хүн тагнаж мөрдөх юм бйана гэдэг тодорхой болов. Манай авхайг хүн тандах нь ээ! Эхийнх нь сүүх тэрэгний арын гишгүүр дээр нэг тандагч явах юм байна!

Эрүүлч Каффтай элдвийг донгосож мунхаг загнасныхаа төлөө би хэлээ тас огтолж хаяхад бэлэн байлаа.

Байшингаас эхлээд ахайтан гарч ирээд доор болж байгаа зүйлийг нэгд нэгэнгүй харж болохоор довжоон дээр зогсов. Кафф бид хоёрын хэнд ч юу ч хэлсэнгүй. Амаа тас жимийн гараа нимгэн цув доороо барьж, охиноо хүлээн хөшөө шиг хөдөлгөөнгүй зогсоно.

Төдий л удалгүй мисс Рэчел гарч ирэв. Бор царайд нь сайхан зохисон зөөлөн шар эдээр хийсэн тун дэгжин хувцас өмсчээ. Хантааз нь гоолиг бэлхүүсийг тас барин таарчээ. Цагаан гивүүртэй, хөөрхөн ганган бүрх малгай тавьж, гартаа яв цав таарсан цайвар шаргал бээлий өмсчээ. Малгай доороос цухуйсан сайхан хар үс нь хилэ нмэт гялалзана. Ягаахан чихэндээ сувдан ээмэг зүүсэн нь тун ч гоёхон харагдана. Сараана цэцэг мэт туялзан, муур шиг хөнгөн шалмаг алхалсаар бидний зүг айсуу. Үзэсгэлэн гоо царйа нь хувираагүй боловч нүд нь хачин янзтай гялалзан хилэнгийн оч бадрах бөгөөд уруул нь үнсэн саарал болжээ. Эхийнхээ хацрыг яаран үнсээд “Намайг уучлахыг бодоорой, ээж ээ” гэж хэлчихээд гивлүүрээ огцом буулгахдаа урж орхив. Дараагийн эгшинд шатаар гүйн бууж, сүүх тэргэнд нуугдах гэсэн мэт ухасхийн оров.

Эрүүлч Кафф ч маш шалмаг хөдлөв. Мисс Рэчел сүүхэнд орж суух яг тэр агшинд Сэмуэлийг хойш нь түлхээд сүүхний нээлттэй хаалганы бариулаа барин авхайн өөдөөс харан зогслоо.

-Танд юу хэрэгтэй вэ? Гэж мисс Рэчел гивлүүрээ сөхөлгүй асуув.

-Таныг хөдлөхийн өмнө ганц үг хэлэх гэсэн юм. Нагац эгчийндээ очихыг чинь хориглож зүрхлэхгүй. Харин одоогийн байдалд биднийг орхиж явснааара таны очир алмазыг олох хэрэгт саад хийж байна гэдгийг л зүрхлэн хэлье. Үүнийг ойлгож үз. Тэгээд явах эсэхээ шийдэгтүн гэж Кафф хэлэв.

Мисс Рэчел үүнийг нь огт хайхарсангүй,

-Жеймс ээ, хөдөл! Гэж хөтчид тушаалаа.

Кафф ч дахиад юм хэлсэнгүй, сүүхний үүдийг хаав. Яг тэр үеэр мистер Фрэнклин шатаар гүйсээр бууж ирээд,

-Рэчел ээ, баяртай! Гээд гараа сунгав.

Гэтэл Рэчел Каффыг тоогоогүй шигээ Фрэнклинийг ч бас тоосонгүй,

-Хөдөл! Гэж бүр ч чангаар тушаалаа.

Мистер Фрэнклин аянганд ниргүүлсэн мэт цочин ухрав. Хөтөч хэрхэхээ мэдэхгүй самгардаж орхиод, шатны дээд гишгүүр дээр хөдөлгөөнгүй зогсоор байсан хатагтай руу харлаа. Ахайтны царайд уур хилэн, уй гашуу, ичгүүр сонжоор харшлан холилдох ба хөтлөгчид хөдлөгтүн хэмээн дохио өгөөд огцом эргэн гэртээ яаран оров. Үг хэлэх сөхөөтэй болсон Фрэнклин сүүх тэрэг хөдлөн одоход хатагтайн араас дуудаж,

-Эгч ээ, таны зөв байжээ! Анхаарал халамж тавьж гэртээ сайхан байлгасанд тань их баярлалаа. Одоо явахыг зөвшөөрнө үү гэлээ.

Ахайтан эргэн хараад нэгийг хэлэх гэж завдсанаа тээнгэлзэх мэт гараа эелдгээр савав.

-Явахаасаа өмнө надтай уулзаарай л даа гэж тасалданги дуугаар өгүүлээд өрөө рүүгээ зүглэлээ.

-Бэттереж гуай, сүүлчийн удаа нэг тус хүргээч. Намайг шалавхан галт тэрэгний буудал дээр хүргээд өгөөч дээ гэж мистер Фрэнклин нулимс цийлэгнүүлэн байж гуйлаа.

Тэгээд байшинд оров. Мисс Рэчелээс болоод барьж алдаж гүйцжээ. Тэгэхээр Рэчелийг халуун сэтгэлээр хайрладаг байх нь ээ!

Эрүүлч бид хоёр шатны доор өөд өөдөөсөө хараад хоцорлоо. Эрүүлч Кафф моддын завсар чөлөөгөөр үзэгдэх замын эргэлтийг нүд салгалгүй ширтэх агаад гараа халаасандаа хийж “Зуны сүүлчийн сарнай” дууны аяг тэрүүхэндээ намуухан исгэрнэ.

-Цагийн юм цагтаа! Одоо исгэрч байх цаг биш шүү хэмээн би нэлээд ууртай хэлчихэв.

Тэгтэл гол хаалга чиглэж явж буй сүүх тэрэг моддын чөлөөгөөр цухуйхад хойд талд нь Сэмуэлийн хажууд нэг хүн харагдав.

-Зүйтэй! Зүйтэй гэж Кафф амандаа хэлээд над руу эргэж,

-Исгэрэх цаг биш гэж таны хэлдэг зөв шүү. Одоо хэний ч толгойг илж эрхлүүлээгүй хатуухан ажиллая. Розанна Спирманаас эхэлье. Жойс хаана байна? Гэлээ.

Бид хоёулаа Жойсыг дуудсан боловч хариу өгсөнгүй тул эрэлд адуучны туслах хөвгүүнийг илгээсэн юм.

-Мисс Вериндерт миний юу хэлснийг та сонссон уу? Миний үгийг хэрхэн хүлээж авахыг нь харсан уу? Хэрэв явах юм бол очир алмазыг нь олох хэрэгт саад хийнэ гэж шулуухан хэлсэн. Гэтэл тэгж сануулсаар байтал явчихлаа! Бэттереж гуай, мисс Вериндерийн суусан эхийнх нь сүүх тэргэнд нэг замын хань хамт яваа. Тэр бол Саран чулуу юм.

-Би юу ч хэлсэнгүй. Харин дотроо мисс Речелд итгэл алдсангүй билээ.

Адуучны туслах хөвгүүн тун дурамжхан йагаа бололтой Жойсыг дагуулсаар ирэв.

-Розанна Спирман хаана байна? Гэж мистер Кафф асуув.

-Эрхэм ээ, би бүр учраа олохгүй нь... одоо яах билээ Гэхдээ яагаад ч юм... гэж Жойс тайлбарлаж эхэлтэл Кафф үгийг нь тас дайран,

-Би Фринзинхолл явахаасаа өмнө, Розанна Спирманыг хар авахуулалгүй тандаж, ажиглаж бйа гэж танд тушаасан байх аа. Тэр бүсгүй хараанаас мултарч дөнгөлөө гэж надад илтгэх гэсэн юм биш биз?

-Үгүй, эрхэм ээ... би хар авахуулахгүй гэж хэтэрхий хичээсэн бололтой. Энэ байшингийн доод давхар учир тоймгүй олон салаа гудам хонгилтой хэмээн Жойс салганан чичирч бувтнав.

-Бүсгүйг хараанаасаа алдаад хэр удаж байна?

-Цаг хэртэй, эрхэм ээ.

-Та Фризинхолл руу ажил албандаа очиж болно. Жойс гуай, таны авъяас билэг манай ажилд таарахгүй юм шиг байна даа. Энэ ажил таны хэрээс давсан юм байна. Баяртай гэж Кафф нөгөө л хачин тайван, гунигтай маягаараа өгүүлэв.

Цагдаа явлаа. Розанна Спирманыг хараанаасаа чухам яаж алдсаныг дуулаад би хэрхсэн гэдгээ хэлхэд даанч бэрх байна. Тэгэхэд толгойд нэгэн зэрэг тавь жаран янзын бодол агшин зуур эрээлжлэх шиг болж, Каффыг дэмий л ангайн ширтсээр зогсож билээ.

-Үгүй ээ, Бэттереж гуай хэмээн эрүүлч миний бодлыг гадарлаад арай давамгайлж байсан нэгд нь юуны түрүүнд хариулья гэсэн мэт-Таны залуу нөхөр Розанна миний гараас таны бодож байгаа шиг хялбар мултарч чадахгүй. Мисс Вериндерийн байгаа газрыг мэдэх хойно хамсаатныг нь эрж олоход хэрэгтэй зэвсэг миний гарт байна гэсэн үг. Өнгөрсөн шөнө тэдний ярилцахыг саатуулж чадсан маань их сайн болсон юм. Тэр хоёр энд уулзаж чадахгүй болохоор Фризинхоллд уулзах нь дамжиггүй. Одоо мөрдлөгийн ажил мисс Вериндерийн очсон айлд миний санаснаас хавьгүй хурдан шилжлээ. Одоогоор зарц нарыг дахиад цуглуулаа гэж таныг бас зовоох болох нь ээ дээ гэв.

Бид хоёр зарц нарын байр руу явлаа. Миний хувьд маш зохисгүй явдал боловч Каффын хэлснийг сонсоод дахиад л мөргөж мөшгих их хүсэлд автсан минь үнэн болно. Эрүүлчийг үзэж чадахгүй байснаа ч умартаад дотночлон сугадаж,

-Бурхан тэнгэрийг бодож, одоо зарц нарыг дуудаж яах гэсэн юм, хэлчихээч дээ гэв.

Алдарт Кафф зогтусан хоосон газар руу харж,

-Энэ хүн (намайг л хэлэв бололтой) сарнай тарьж ургуулах талаар мэдплэгтэйсэн бол ёстой л хосгүй хүн байхсан! Хэмээн бахдан догдолж өгүүлээд санаа алдсанаа намайг сугадан ажил хэрэгтээ эргэн орж, -Юү гэвэл, Розанна хоёр зүйлийн аль нэгийг хийсэн байж таарах юм. Намайг очиж амжихаас өмнө Фризинхолл руу шууд явсан, эсвэл эхлээд Нуранги элс рүү нөгөө юм нуусан газраа очсон. Тэгэхээр байшингаас гарч явахад нь Розаннаг харсан хүнийг юуны өмнө олох хэрэгтэй байна гэлээ.

Зарц нараас асууж ярилцсаны эцэст Розаннаг хамгийн сүүлд сав угаагч Нэнси харсан болохыг тогтоов. Розанна захиа барьсаар гарч ирснээ хойд хаалган дээр тогоочид мах өгчихөөд буцаж явсан махны наймаачныг дуудаж зогсоогоод Фризинхоллд очихоороо энэ захиаг шууданд хийчхээж гэж гуйхыг нь сонсчээ. Нөгөө хүн захианы хаяггийг харснаа, Коббс Холд гэж хаягласан байхад Фризинхоллын шууданд аваачиж хийнэ гэдэг хачин юм, тэр тусмаа өнөөдөр бямба тэгэхээр захиа даваа гаригийн өглөөнөөс нааш хүрэхгүй шүү дээ гэсэнд Розанна, тэр яах вэ, хамаагүй гэсэн байна. Харин хүссэн ёсоор нь захиаг шууданд заавал хийгээрэй гэж гуйжээ. Нөгөө хүн тэгье хэмээн ам өгөөд явжээ. Нэнсиг гал тогооноос дуудсан тул ажил руугаа буцсан бйана. Дараа нь ч Розаннаг хараагүй гэнэ.

-За яах вэ? Гэж хоёулаа үлдсэн хойно би асуулаа.

-Одоо би Фризинхолл явах хэрэгтэй гэж Кафф хариулав.

-Захианы хэргээр үү, эрхэм ээ?

-Тийм ээ. Юм нуусан газрыг заасан тэмдэглэл тэр захианд байна. Захиаг хэнд хаягласныг мэдэх хэрэгтэй. Миний таавар зөв бол, та бид оёр ирэх даваа гаригт Ёолланд авгайнд зочлох болно доо.

Би задгай сүүх тэрэг захиалахаар эрүүлчтэй хамт явав. Жүчээнд бид сураггүй болсон бүсгүйн тухай шинэ мэдээ дуулсан билээ.

## **ХИХ БҮЛЭГ**

Розанна алга болсон тухай мэдээ зарц нарын дунд дорхноо таржээ. Тэд хэрдээ таарсан мөрдлөг явуулж байгаад заримдаа цэцэрлэгийн зэрлэг өвс зулгаадаг Дефф гэгч сэргэлэн хөвгүүн, Розаннаг

хагас цагийн өмнө харсан гэдгийг олж мэджээ. Бүсгүй нарсан ойгоор далайн эргийн зүг хөл мэдэн гүйж байхыг харсан гэнэ.

-Энэ жаал эрэг хавийг сайн мэдэх үү? Гэж Кафф асуусанд,

-Эрэг дээр төрж өссөн хүн дээ гэж би хариулав.

-Дефф! Чи нэг шиллингийн ажил хийх үү? Тэгвэл надтай хамт яв. Бэттереж гуай, намайг эрэгж ирэхэд тэрэг бэлэн болгочихоход байгаарай.

Кафф, Нуранги Элсний зүг учиргүй түргэн алхсан тул хэдийгээр миний бие насандаа овоо тэнхлүүн боловч түүнийг гүйцэх найдлага даанч байсангүй. Бяцхан Дефф манай нутгийн “зэрлэг” хөвгүүдийн нэгэн адил баярлахдаа хөөрөн хашгираад түрүүчийн хойноос харайлгав.

Каффыг яваад эрэгж ирэх хүртэл чухам юу бодож санаснаа тодорхой хэлж чадахгүй байна. Миний сэтгэлийг жигтэйхэн, битүүлэг түгшүүр эзэмджээ. Элдэв хэрэгтэй, хэрэггүй юм хийж, гэрт орон гаран байсан боловч чуха юу хийгээд байснаа одоо огт үл санана. Кафф хэдий хэр болоод Деффиийг над руу явуулсныг ч би тодорхой мэдэхгүй байна. Эрүүлч Кафф тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсан дээр “Розаннагийн нэг гутлыг түргэхэн явуулаач” гэж харандаагаар бичсэн зурвас илгээжээ. Нүдэнд өртсөн нэг шивэгчинг Розаннагийн өрөө рүү явуулж, би өөрөө гутал авч очно гэж дамжуулагтун хэмээн хөвгүүнийг буцаав.

Энэ бол авсан даалгавраа шуурхай биелүүлэх арга биш гэдгийг би сайн мэдэж байлаа. Гэвч Розаннагийн гутлыг мистер Каффт гардуулахын өмнө ямар шинэ санаа төрснийг нь үзье гэж бодсон юм. Бүсгүйг өрөвдөх сэтгэл дахин сэргэсэн боловч одоо нэгэнт хожимдсон бололтой. Эл сэтгэлдээ хөтлөгдөн (мөрдөн мөшгөх дон туссанаа ярихаа больё гэхэд) Розаннагийн гутлыг авмагцаа далан настай өвгөн би чадах хэрээрээ яаран алхлаа.

Эрэгт дөхөж явтал тэнгэрийн үүлс улам бараантан нүүгэлтээд бороо хувингаар цутгах мэт асгарлаа. Тохойн тэртээ далайн давалгаа элст харгиаг мөргөн шуугих сонсдоно. Нэлээд яваад элст манхны нөмөрт борооноос хоргодон буй жаал хөвгүүний хажуугаар өнгөрөв. Төдөлгүй догшрон шуурах далайн давалгаа элсэн харгиа дээгүүр бялхан түрээд, зогсоо зайгүй асгарах бороо, далай дээгүүр хөшиглөх манан, зэлүүд эрэг үзэгдэн түүн дээр торойх нэгэн бараан дүрс нүднээ тусав. Тэр бараан дүрс нь эрүүлч Кафф ажээ.

Намайг харчихаад хойд зүг гараараа заан,

-Энэ талаа бариад яваарай! Нааш ир! Гэж хашгирав.

Амьсгөл бөглөрчих шахан уухилсаар алхахад зүрх амаар гарчихмаар булгиан дэлсэнэ. Үг ч дуугарах тэнхээ байсангүй. Асуумаар юм өчнөөн төчнөөн байвч ганц ч үг амнаас унагасангүй. Каффын царай зүсийг хараад би хирдхийсэн юм. Нүдэнд нь айдас илэрсэн байхыг ажиглав.

Миний гараа гутал шүүрэн авч бидний байгаа газраас урагш, Өмнөд цохио хэмээгч хадан хошууны зүг хандсан хөлийн мөрөн дээр тавьж үзвэл яв цав тохирч байлаа.

Кафф тэрхүү гутлыг үг дуугүй авав.

Би Каффын гараас шүүрэн бариад ярилцъя гэтэл мөн л үг дуугарч чадсангүй. Түрүүч, мөр даган хадан цохио хүртэл явлаа. Өмнөд цохио Нуранги элс далайн түрлэгт улам улам автаж, элсэн дээгүүр ус хальжээ. Эрүүлч нөгөө гутлыг дандаа л хадны зүг чиглэсэн мөрнүүд дээр үе үе тонголзон, үг дуугүй уйгагүй тавьж үзэхийг харахад үнэхээр аймшигтай байлаа. Хэчнээн эрж хайгаад буцаж явса нмөр олж чадсангүй.

Эцсийн эцэст зогсож, намайг дуу шуугүй харснаа Нуранги элс дээгүүр улам улам халин бялхах усны зүг ширтэв. Би харцыг нь дагуулж хараад Каффын санааг ойлгосон юм. Миний бие гэнэт учиргүй чичрэн дагжаад элсэн дээр өвдөг сөхрөн унаж билээ.

-Бүсгүй юм нуусан газраа ирж, тэгээд энэ хадан дээр золгүй явдал болжээ хэмээн Кафф тэрүүхэндээ ярих сонсдов.

Розаннагийн эрс хувирсан царай, яриа хөөрөө, байдал хөдөлгөөн, хэдэ нцагийн өмнө гудамж шүүрдэж байхад нь очиж ярилцахад нэг л дүйнгэ байдалтай байсан зэрэг нь санаанд бууж, эрүүлчийн таавар аймшигт үнэнэс хол зөрөөгүй болов уу гэж ёрлоод байлаа. Би айж жихүүцсэн учраа гайлбарлаж, “Розанна хүссэн ёсоороо нас нөгчжээ” гэж хэлье гэтэл а эвлэдэггүй! Би сандарч мэгдсэндээ хөшиж орхисон байлаа. Асгарах бороог ч улам ихсэх далайн түрлэгийг ч хайхраа болиод хөөрхий бүсгүй зүүд нойронд үзэгдэх мэт нүдний өмнө тодорч ирэв. Би Розаннаг гэртээ харь гэж дуудахаар хойноос нь энд ирэхэд сууж байсан янзаар нь харах шиг болов. Мөн Нуранги элс хүсээгүй байхад нь соронздон татдаг, чухам тэнд л булш минь хүлээж байгаа болов уу гэж ярьсан нь чихэнд сонсдох шиг болов. Охин минь санаанд орон, үл ойлгогдох аймшиг эзэмдлээ. Тэр хоёр үе тэнгийнх. Миний охин Розанна шиг зовлонд учраад бас ийнхүү эмгэнэлтэйгээр амь үрэгдэхийг хэн байг гэхэв... Кафф намайг эелдэгхэн босгоод Розаннагийн осолдсон газраас холдууллаа.

Миний сэтгэл жаахан хөнгөрч, орчны байдлыг анхаарах сөхөөтэй боллоо. Элст манхны зүг хартал манай хэдэн зарц, Ёолланд загасчин гээд баахан хүн гүүлдэн айсуй бөгөөд Розаннаг олсон эсэхийг сандран асууцгаав.

Эрүүлч тэдэнд хөлийн мөрийг зааж харулаад золгүй явдал тохиолдсоноос зайлахгүй гэдгийг товчхон тайлбарлав. Дараа нь загасчныг зайдуу аваачаад далайн зүг харан,

-Тэнгэр ийм байхад бүсгүйн мөр үлдсэн хадны хавиас завь хөдөлж чадах уу? гэж асуув.

Элст харгиа дээгүүр бялхан хальж, хадан хошуу мөргөн хөөсрөн цахрах их давалгааг загасчин заагаад,

-Ийм шуурганаар бүсгүйг авч чадах завь гэж байхгүй биз гэж өгүүлэв.

Одоо бороонд угаагдан хурдан арилж буй мөрийг Кафф сүүлчийн удаа хяламхийн,

-Эндээс буцаж яваагүйг энэ мөр харуулж байгаа юм гээд загасчин өөд харж –Харин длайд гарч чадахгүйг шуураг баталж байна гэснээ дуугүй болж, минут хэртэй бодлогошров.

-Намайг Вериндер ахайнхаас гарахаас хагас цагийн өмнө Розанна ийшээгээ гүйж байхыг нь хүн харсан байсан. Тэрнээс хойш зэгсэн уджээ, бараг цаг болсон байх. Тэгэхээр цагийн өмнө усны түвшин цохионы энэ талд ямар байсан бол? хэмээн өмнөд хэсгийн нь өөрөөр хэлбэл сордог элсгүй газрыг зааж лавлав.

-Өнөөдөр цохионы тэр зүгээс түрсэн усны төвшинг харвал цагийн өмнө муурын зулзага ч живчихээргүй л байж дээ гэж загасчин хариу өчив.

Түүрүүч Кафф хойшоо эргэж, Нуранги элсний зүг заагаад,

-Энэ талдаа хэр зэрэг байсан бол? Гэхэд

-Бүр бага байсан. Нуранги элс гавьтай нуруу ч үгүй байсан биз гэж хариулав.

Кафф над руу эргэж, золгүй явдал Нуранги элсэнд л болсноос зайлахгүй нь гэлээ. Миний хэл ам сая эвлэж

-Золгүй явдал болоогүй! Амьдралаас залхаж цөхрөөд, энд ирсэн юм гэж би хэллээ.

Кафф давхийн ухарч,

-Та яаж мэдсэн юм? Гэж асуув.

Бусад хүмүүс намайг бүчин авлаа. Эрүүлч төдхөн сэхээ авч, өвгөн хүн, энэ явдалд мэгэж сандарчээ хэмээн хүмүүсийг холдуулаад,

-Алив энэ хүнийг тайван байлгаач гээд Ёолланд руу харж,

-Далайн татлага эхэлсэн хойно бүсгүйг олох найдлага бий юу? Гэхэд

-Ямар ч найдлага байхгүй. Нуранги элс залгилсан л бол тэр чигтээ өнгөрнө.

Тийн өгүүлээд загасчин надад дөхөж ирээд өгүүлдүүн:

-Бэттереж гуай, залуу бүсгүйн үхлийн талаар танд хэдэн үг хэлмээр байна. Цохионы энэ талын дагууд элсэн доор бараг гурван тохой гүнд дөрвөн тохой өргөн тавцан байдаг. Би юу асуух гээд байна гэвэл талийгаач яагаад тийшээ унаагүй юм бэ? Санамсаргүй халтирсан бол элсэнд дөнгөж бүсэлхийгээ хүртэл шигдээд, тэндээсээ хялбар гарч чадах газар унах байлаа. Тэгээд одоо эсэн мэнд байхсан. Санамсаргүй гай тохиолдсон биш ээ, эрхэм ээ! Нуранги элсний гүн хэсэг бүсгүйг залгижээ, гэхдээ хүслээр нь залгижээ.

Мэдлэг туршлагад нь бүрэн найдаж болох хүний нотолгоог сонсоод Кафф юм хэлсэнгүй. Бид нар ч дуу шуугүй байснаа бүгдээрээ эрэг өөд буцлаа.

Элсэн манхан дунд биднийг угтан гүйх адуучны туслагчтай тааралдав. Тэр бол намайг чин сэтгэлээсээ хүндэлдэг сайн хүү билээ. Их л уй гашуутайгаар надад нэг зурвас өгөөд,

-Бэттереж гуай, Пенилоп явууллаа. Розаннагийн өрөөнөөс олсон юм гэнэ гэв.

Тэр бол хөөрхий охинд ямагт сайхан сэтгэлээсээ туслах гэж явсан өвгөн надад ханда нбичсэн хагацлынх нь үг байжээ.

“Бэттереж гуай, та сүүлийн үед намайг дандаа уучилж байлаа. Та хожим Нуранги элс рүү очвол намайг бас дахиад уучилж үзээрэй. Намайг хүлээж байсан булш руугаа би очлоо. Би таны сайхан сэтгэлд үргэлж баярладаг байсан, одоо ч талархсаар үхэх болно, эрхэм ээ”

Ийм хэдхэн үг байлаа. Тэр зурвас хэдий богино байсан боловч би сэтгэлээ барьж дийлсэнгүй. Хүн хорвоод мэндлээд амьдралын босго алхаж байгаа бага залуу насандаа уйлах нь хялбар бөлгөө. Бас хадан гэр нь ойртсон өтөл буурал насандаа нулимс унагах нь бүр ч хялбар байдаг. Би асгартал уйлав.

Эрүүлч Кафф над руу дөхсөнд (сайн санааны үүднээс тэгсэн биз) би зэвүүцэж ухраад,

-Надад бүү хүр. Та л түүнийг айлугаж, ийм юманд хүргэсэн гэхэд,

-Бэттереж гуай, та ташаарч байна. Гэвч танайд очоод энэ тухай дахиад ярилцамз гэж Кайфф тайван хариуллаа.

Бид ширүүн бороонд цохиулсаар айж, самгардсан улс хүлээж буй байшин руугаа явцгаалаа. Би адуучны гарыг түшин хүмүүсийн хойноос гэлдрэв.

## ХХ БҮЛЭГ

Түрүүлж очсон хүмүүс гунигт мэдээг тарааж амжжээ. Биднийг очиход зарц нар жигтэйхэн самгардсан байлаа. Ахайтны өрөөний хажуугаар гартал хаалга нь цэлсхийн нээгдэж, ахайтан гарч ирэв. Мистер Фрэнклин араас нь дагаж, тайтгаруулах гж дэмий л оролдох авч эмгэнэлт явдлыг дуулаад бүр хямарч орхижээ.

-Та л буруутай! Хэмээн Каффыг чичин өгүүлээд,

-Габриэл ээ, энэ үл бүтэх этгээдэд зохих хөлсий нь өгөөд, миний нүднээс зайлуулж үз! Гэв.

Биднээс ганцхан Кафф л барьц алдаагүй байсан тул ахайтны эвийг олж чадах байлаа.

-Энэ гунигт явдалд би таны нэгэн адил буруугүй шүү. Одоо хагас цагийн дараа та намайг яв гэж дахин шаардах юм бол би зөвшөөрнө, харин мөнгө авахгүй.

Каффын маш хүндэтгэлтэйгээр тун шийдмэг өгүүлсэн үг ахайтан бид хоёрт арга буюу нөлөөлсөн юм. Ахайтан мистер Фрэнклиний үгийг дагаж, өрөөндөө буцаж оров. Өрөөний нь хаалгыг хаасан хойно эрүүлч Кафф гярхай нүдээрээ шивэгчин нарыг тойруулан хараад, бусад нь зүгээр л айж мэгдсэн, харин Пенилоп л уйлсан байхыг ажиглажээ.

-Аавыгаа хувцсаа сольчихоор нь аавынхаа өрөөнд очоорой гэж Пенилопт хэлэв.

Хагас цаг ч өнгөрөөгүй байхад би хуурай хувцас өмсч, Каффт гуйсан ёсоор нь солих хувцас өгөөд хоёул хувцаслаж амжсан байлаа.

Эрүүлчийг чухам юу сонирхоо юм бол гэдгийг мэдэхээр Пенилоп орж ирэв. Яг тэр мөчид би хичнээн сайн дуулгавартай охинтой болохоо нэн хурц ухаарсан юм. Пенилопыг өвөр дээрээ суулгаад охиныг минь ивээж тэтгэх болтугай хэмээн бурхан тэнгэрт дотроо залбирлаа. Пенилоп миний энгэрт нүүрээ нааж, хүзүүгээр тэврэн аваад бид хоёр хэсэг чимээгүй суулаа. Хоёулаа хөөрхий талийгаач бүсгүйг бодоцгоосон биз ээ. Эрүүлч цонх руу очоод цонхоор харан мөн л дуу шуугүй зогсоно. Каффын тэр эелдэг занд талархах нь зүйтэй гэж сэтгэгд баярласнаа хэлэв.

Пенилоп бид хоёр Каффын хэзээ юу асуусныг хүлээ хариулахад бэлэн байлаа. Розанна Спирман чухам юунаас болж амь насаа бүрэлгэснийг мэдэж байна уу гэж асуухад нь (уншигч та гадарласан байх) Фрэнклин Блэйкэд сэтгэлтэй болчихоод л тэгж дээ хэмээн Пенилоп хариулав.

-Энэ тухай өөр хүнд хэлсэн үү?

-Розаннаг өрөвдөөд хэнд ч яриагүй.

Энд хошуу нэмэх нь зүйтэй гэж үзээд би,

-Хонгор охин минь, бас мистер Фрэнклинийг өрөвдөөд. Розанна, Фрэнклинд сэтгэлтэй болоод амиа хорлосон бол Фрэнклин ер мэдэгүй байсан, ямар ч гэмгүй шүү дээ. Өнөөдөр тайван яваг, үнэнийг хэлж сэтгэлийг нь дэмий зовоогоод яах вэ дээ гэв.

Эрүүлч Кафф “зүйтэй” гэхихээд дахиад л дуугаа хураав. Пенилопын мэдүүлэг, өөрийнхөө санаа бодлыг эрэгцүүлэн тунгааж байгаа бололтой.

Хагас цагийн дараа хатагтайн хонх жингэнэв. Дуудсан ёсоор очиж втал Фрэнклинтэй тааралдсанд нагац эгч нь эрүүлч Каффтай (гэхдээ намайг байлцуулна) уулзъя гэснийг уламжлаад, мөн өөрөө эхлээд Каффт хоёр үг хэлмээр байна гэв. Миний өрөө рүү алхтал Фрэнклин зогтусаад танхимд хадсан галт тэрэгний цагийн хувааргийг харлаа.

-Эрхэм ээ, та одоо үнэхээр явах нь уу? Та жаахан азна л даа, мисс Речел заавал ирнэ.

-Тийм ээ, миний явсныг сонссод, миний барааг энд дахиад харахгүй гэж мэдсэн хойноо гарцаагүй ирнэ л дээ.

Манай залуу авхайн зан авирт баахан цухалдсан учраас л тэгж ярилаа гэж би бодсон билээ. Гэтэл үгүй байжээ. Манайд цагдаагийн газраас хүн ирсэн мөчөөс эхлэн, Фрэнклиний нэрийг цухуйлгамагц Речел жигтэйхэн уурсаж байхыг хатагтай хэдийн ажиглажээ. Фрэнклин үеэл дүүдээ жигтэйхэн хайртай болсноо өөрөөсөө ч нууж байтал, Речелийг нагацын руугаа явах мөчид үнэн учир тодорхой болжээ. Речел хэрцгий авирласанг мартаагүй биз, чухам тэр бэрх мөчид мистер Фрэнклин аливаа бардам хүний адил манайхаас явъя хэмээн хатуу шийдсэн юмсанж.

Каффтай миний хажууд ярилцлаа. Вериндер ахай эрчүүдтэй хэтэрхий ширүүн харьцсан буруугаа хүлээхэд бэлэн байгааг дурдаад, буруугаа хүлээвэлү ажлынхаа хөлсийг аваад Саран чулууны хэргийг энэ чигт нь орхиж явахыг зөвшөөрөх эсэхийг лавлав.

-Үгүй, эрхэм ээ. Би үүргээ биелүүлсэн цагт л хөлс авдаг. Үүргээ биелүүлэхээс нааш би хөлс авахгүй.

-Би таныг ойлгохгүй байна.

-Би танд тайлбарлая л даа. Би энд ирэнгүүтээ очир алмаз алга болсон хэргийн нууцыг тайлах учигны үзүүрээс барьж авсан. Одоо хэргий учрыг олсон, зөвхөн хэлсэндээ хүрэх боломжийг л хүлээж байна. Би Вериндер ахайтай уулзаж, хэргий нбайдлыг танилцуулаад, очир алмазыг олохын тулд одоо чухам хэрхвэл зохихыг шууд хэлбэл би хүлээсэн үүрэг хариуцлагаа сая л мөрнөөсөө авч хаях болно. Тэр цагт ахайтан намайг явуулах эсэхийг шийдэг л дээ. Нааштай хариу өгвөл би эхэлсэн ажлаа дуусгаж, шагналаа ч авна гэж Кафф мэдэгдэв.

Каффын энэ үг цагдаагийн газрын эрүүлчид ч хүртэл эрхэмлэж явдаг нэг төр бий гэдгийг сануулж билээ.

Каффын бодол үнэхээр эсэргүүцэх аргагүй үнэн байлаа. Би эрүүлчийг хатагтай нөрөө рүү дагуулж явахаар босох үед Кафф, хамт очих уу гэж Фрэнклинээс асуув.

-Үгүй ээ, Вериндер ахай намайг байлц гээгүй гэж Фрэнклин хариулаад, намайг Каффын хойноос гарах гэтэл,

-Энэ хүн Рэчелийн тухай юу хэлэх гэж байгааг нь би сайн мэдэж байна. Би Рэчелд дэндү сайн болохоор тайван сонсож чадахгүй биз. Тэгэхээр энд үлдсэн нь дээр гэж шивнэж билээ.

Фрэнклин цонхны тавцан тохойлдон, нүүрээ хоёр гараараа даран гутарч гонсойсон байдалтай суусаар хоцров. Пенилоп түүнийг тайтгаруулахсан гэхээс байж ядан хаалгаар цухалзана. Би л Фрэнклиний оронд байсан бол Пенилопыг дуудаж оруулна даа. Нэг эмэгтэй хүн таныг гомдоосон бол өөр эмэгтэйд яривал сэтгэл чинь онгойгоод ирнэ. Яагаад гэвэл арван бүсгүйгээс ес нь заавал таны талд орох болно. Намайг явсны хойно Фрэнклин Пенилопыг дуудсан байж юу магад бус уу? Тэгсэн бол Фрэнклиний сэтгэлийг засах гэж оролдоод бүтээгүй гэдгээ охин маань шударгаар хүлээхээс өөр замгүй болох буй заа.

Энэ зуур Кафф бид хоёр ахайтны өрөөнд оров.

Үүнээс өмнө уулзаж ярилцахаар ороход ахайтан ширээн дээр дэлгээстэй номноосоо нүд салгахгүй байснаа бодвол одоо арай найрсаг угтав. Каффын шулуун харцтай нүдийг үл далдиран ширтэнэ. Тэднийхний өвөрмөц шазруун зан царайд нь тодрон буйг хараад, манай ахайтан шиг ийм ааш авиртай бүсгүй адгийн муу үг сонсоход зэхэж, бие сэтгэлээ нэгэнт чангалан дайчилсан болохоор эрүүлч Кафф ч яггүй өрсөлдөгчтэй учирчээ гэж би бодсон юм.

## XXI БҮЛЭГ

Биднийг суудлаа эзлэхэд манай ахайтан эхлэн ам нээв.

-Мистер Кафф аа, хагас цагийн өмнө танд эвгүй үг хэлсэндээ уучлал гуйя. Гэхдээ би ингэж уучлал эрье гэж нэг их хүсэхгүй. Би илэн далангүй хэллээ, хэрэв таныг гомдоосон бол харамсалтай л юм.

Ахайтны уучлал гуйсан эелдэг төрх, дууны өнгө Каффт зохих ёсоор нөлөөлжээ. Биеэ цагаатгахыг хүсээд, хатагтайг хүндэтгэхийн үүднээс л ийнхүү биеэ цагаатгаж байна гэв. Розанна Спирманыг айлгаж, үргээлгүй тун болгоомжтой харьцаж чадвал мөрдлөг нь амжилттай дуусах чухал шалтгаан байсан тул бид бүхнийг цочоон балмагдуулсан тэр гайтай явдалд түүнийг буруутгах үндэс огт байхгүй хэмээн Кафф тайлбарлаад, энэ бүхэн үнэн гэдгийг гэрчилж өгөөч гэж надаас гуйв. Би үгүй гэж чадсангүй, тэгээд ч энэ хэрэг үүгээр шувтарна буйзаа гэж горьдсон билээ.

Гэтэл Кафф арай цаашилсан нь Вериндер ахайтай ярилцах гэсэн зүйлээсээ эмзэг нэгийг нь хөндье гэж бодсон бололтой өгүүлрүүн:

-Залуу бүсгүйн амиа хорлосон, үнэн байж ч болзошгүй нэг шалтгааныг би дуулсан. Гэвч тэр бол миний энд мөрдөж байгаа ажилд огт падгүй юм. Гэхдээ би өөр саналтай байна гэдгээ хэлэх хэрэгтэй. Очир алмаз алга болсонтой уялдан учир битүүлэг шалтгаанаар зовж шаналаад хөөрхий бүсгүй амиа бүрэлгэсэн гэдэгт би эргэлзэхгүй байна. Юунд тэгж учиргүй айж шаналсныг тайлбарлах гэж ч оролдохгүй. Харин, ахайтны зөвшөөрлөөр, миний зөв эсэхийг шийдэж чадах нэг хүнийг хэлье гэж бодож байна.

Хатагтай нэг хэсэг дуугүй сууснаа,

-Тэр хүн одоо энд бий юу? Гэж асуулаа.

-Тэр хүн эндээс явсан, ахайтан минь.

Энэ хариулт бол мисс Рэчел гээд шулуухан хэлчихснээс өөрцгүй сонсогдлоо. Өрөөнд нам гүм болсон нь төгсгөлгүй үргэлжлэх мэт надаад санагдаж билээ. Би Кафф, ахай хоёрын аль нь эхэлж ам наах бол хэмээн хүлээж суув. Бурхан минь, гадаа салхи юутай догшин улин исгэрч аадар бороо цонхны шилийг ямар хүчтэй дэлдэн асгарч байсан гэж бодноо!

-Та арай тодорхой хэлж хайрла. Миний охиныг хэлж байна уу? гэж Вериндер ахай дуугарав.

-Тийм ээ гэж Кафф шулуухан хариулав.

Биднийг ороход ахайтны ширээн дээр чекийн дэвтэр үзэгдсэн нь түрүүчтэй тооцоо хийх гэж байснаас зайлахгүй. Одоо харин хайрцагт буцааж хийв. Өвгөн зарц намайг төчнөөн их ивээж тэтгэж байсан гар нь ертөнцөөс халихын цагт миний гарыг атгаж байгаасай хэмээн бурхан тэнгэрээс хүсэн залбирдаг гар нь хөөрхийлөлтэйгээ салганахыг хараад зүрх шимширч билээ.

Хатагтай тайван дуугаар үгээ зөөн,

-Мисс Вериндерийн нэрийг ингэж шууд дурдахгүйгээр таны хөлсийг төлөөд танаас сална гэж би найдаж байсан юм. Таныг орж ирэхээс өмнө зээ маань танд үүнийг цухуйлгасан биз дээ? Гэлээ.

-Мистер Фрэнклин таны даалгаврыг гүйцэтгэсэн шүү, ахайтан минь. Гэхдээ би Фрэнклин Блэйкэд ямар учиртай болохыг...

-Надад тэр учир шалтгаанаа тайлбарлаад хэрэггүй. Та нэгэнт хэлдгээ хэлсэн болохоор, одоо ухарч буцахаасаа өнгөрсөн гэдгийг надаас дутуугүй мэдэж байгаа шүү дээ. Өөрийнхөө болон охиныхоо төлөө таныг энд үлдэж, илэн далангүй ярихыг танаас шаардаж байна.

Түрүүч цагаа харав.

-Хатагтай минь, завтайсан бол илтгэлээ танд амаар биш, бичгээр өгмөөр байна санж. Гэвч мөрдөх ажлыг цааш үргэлжлүүлэх болбол тайлан бичихэд хайран цаг дэмий үрэгдэнэ. Би ажлаа нэн даруй эхлэхэд бэлэн байна. Үүнийг ярихад надад их хэцүү, танд ч сонсоход бэрх болно...

Вериндер ахай дахиад л үгийг нь таслан,

-Би ч өөрийн зүгээс яриаг зоригтой эхлэх үлгэр үзүүлбэл танд ч, миний зарц анд нөхөр Габриэлд ч арай хялбар болно байх.

-Мисс Вериндер очир алмазыг хувьдаа хэрэглэх гэж нуугаад бид бүхнийг мэхэлж байна гэж та сэжиглэж байна уу? Тийм үү? Гэлээ.

-Яг тийм, ахайтан аа.

-Их сайн байна. Одоо таныг ярихын өмнө би Рэчелийн эхийн хувьд хэлэх юм байна. Юу гэвэл, мисс Вериндер таны сэрдэж байгаа хэргийг үйлдэж даанч чадахгүй юм шүү. Та Рэчелийг нэг хоёр хоногийн өмнөөс л мэднэ. Тэгэхэд би хорвоод мэндэлсэн цагаас нь эхлээд мэднэ. Та сэжиг таамгаа ил шулуун хэл л дээ, тэглээ гээд би гомдохгүй. Хэдийгээр хашир туршлагатай хүн боловч та тухайн энэ учралд алджээ гэдэгт би одоо ч итгэлтэй байна. Би мэдэж сонссон зүйлээ нуугаагүй болохыг бүү мартаарай! Энэ хэргийн талаар охиныхоо итгэлийг танаас илүүгээр хүлээж чадсан гэж сайрхах юм даанч алга. Охиноо ингэж хамгаалах болсо нучраа би түрүүн хэлсэн. Би хүүхдээ сайн мэднэ гэж хэлээд хатагтай маань над руу эргэж, гараа сунгасанд би гарыг нь дуугүй үнсэв.

-Та яригтүн гэж Кафф өөд шийдмэг харан өгүүлэв.

Түрүүч Кафф мэхэсхийв. Ахайтны үгийг сонсоод зөвхөн өрөвджээ. Баргар царай нь хатагтайг өрөвдсөн мэт хоромхон зуур зөөлрөв. Кафф баттай гэж үзсэн бодлоосоо сөөм ч ухрахгүй нь илэрхий байлаа. Сандалдаа тухлан суугаад мисс Рэчелийн нэр төрд халдсан шившигт довтолгооноо ийн эхэлсэн юм.

-Сүүлчийн хорин жил миний бие гэр бүлийн эмзэг будлианы учрыг олох хэрэгт голдуу уригдан ажиллаж байна. Иймэрхүү (тухайн хэрэг ч хамаарна) хэргийг шийдвэрлэх явцдаа ганц дүгнэлтэд хүрснээ цөөн үгээр тайлбарлая. Туршлагадаа дулдуйдан хэлэхэд, дээд зиндааны, баян залуу бүсгүйчүүд ихэвчлэн нууцаар өр тавиад түүнийгээ садан төрөл, найз нөхдөдөө мэдэгдэхээс айдаг юм. Зарим нь сайван, уран дарчуулд өртэй байна. Нөгөө нэг нь өөр зүйлд мөнгөө үрсэн байдаг. Энэ удаад тиймэрхүү зүйл гарсан гэж би сэжиглэхгүй байна, танд хэлж дургүйг чинь хүргээд ч хэрэггүй биз. Ахайтан аа, миний хэлснийг анхааралдаа тольдож, танайд гарсан хэрэг урьд өмнө илрүүлж байсан хэргүүдийг яахын аргагүй санагдуулсан болохыг одоо авч үзье л дээ!

Бодлоо төвлөрүүлэх мэт хэсэгнэн чимээгүй болсноо биднийг ойлгог гэж албадан айдас хүргэм тодорхой, хэнийг ч үл өршөөх үнэн зүйл хүүрнэв.

-Очир алмаз алдагдсан хэргийн тухай мэдээллийг би анх ахлах байцаагч Сигревээс сонссон. Энэ хэргийг Сигрев илрүүлж огт чадахгүй болохоо харуулсан юм. Мэдээллээс нь авах ганц юм байлаа. Тэр бол, мисс Вериндер байцаагчийн асуултанд хариулахаас татгалзсан, түүнтэй хачин бүдүүлэг, зэвүүцсэн янзтай харьцаж байсан гэжээ. Эхлээд би гайхсан боловч байцаагч эвгүй загнаж, залуу бүсгүйн дургүйг хүргэсэн байх гэж би бодсон билээ. Энэ зүйлийг санаандаа хадгалж, эл хэргийг бие даан гардаж аваад байцаалт явуулсны эцэст хаалганы будаг хэсэгхэн газраа халтартсан байхыг, Фрэнклин Блэйкийн мэдүүлэг ёсоор хаалганы тэр толбо, очир алмаз алдагдсан явдал хоёр холбоотой болохыг илрүүлснийг та бүхэн мэднэ. Эдүгээг хүртэл би, Саран чулууг хулгайлжээ, танай зарц нарын нэг л хулгайлсан байх гэж бүдэг бадаг сэжиглэж байсан юм. Зүйтэй. Тэгтэл мөрдлөгийн тэр шатанд чухам юу болсон бэ? Мисс Вериндер өрөөнөөсөө гэнэт гарч надтай ярилцсан. Тэгэхэд би авхайн зан авираас гурван сэжигтэй зүйл ажигласан юм. Очир алмаз алдагдаад бараг бүтэн нэг хоног өнгөрсөн байхад мисс Вериндер учиргүй цухалдаж, бачимдсаар байсан. Надтай, мөн л Сигревтэй харьцсан шигээ увайгүй харьцаж байлаа. Мистер Фрэнклин учиргүй их уурсаж хилэгнэсээр байв.

Зүйтэй. Очир алмаазаа алдсан залуу бүсгүй энэ байна гэж би дотроо бодлоо. Их л ширүүн зантай болохыг нь нүдээр харж, чихээр сонслоо. Ийм нөхцөл байдалд иймэрхүү зан авиртай охин яасан бэ? Фрэнклин Блэйк, ахлах байцаагч Сигрев, бид гурвыг, өөрөөр хэлбэл, очир алмазыг нь олж туслах санаатай чадах чинээрээгээ өөрийн гэсэн аргаар зүтгэж буй гурван хүнийг учир битүүргээр дайсагнан зэвүүцэж байна. Мөрдөж сурвалжилсаар энэ асуудалтай тулгарах үед зөвхөн тэр л үед шүү, мэдлэг, туршлагадаа дулдуйдахад хүрсэн юм. Амьдралын туршлага маань мисс Териндерийн үл ойлгогдох зан авирыг тайлбарлаж өгсөн билээ. Туршлагадаа тулгуурлан мисс Вериндер, миний мэддэг хэдэн залуу бүсгүйн нэг адил юм байна гэж бодсон юм. Түүнчлэн мисс Вериндер хэнд ч хэлж зүрхлээгүй, юу боловч төлөх ёстой өр шир тавьсан байжээ гэдгийг туршлага маань хэлсэн юм. Тэгэхээр тэр өрийг сэмхэн цайлгах хэрэгтэй учраас очир алмаз алга болсон юм биш биз? Гэсэн асуулт арга буюу гарч ирсэн билээ. Миний хуримтлуулсан туршлага энгийн баримт сэлтээс ийм л дүгнэлт хийж байна. Ахайтан таны туршлага үүний эсрэг юу гэж хэлэх вэ?

-Би хэлдгээ хэлсэн. Нөхцөл байдал таныг төөрөгдүүлж байна гэж эзэгтэй эрс хэлэв.

Би нэг ч үг дуугарсангүй. Зөнөг миний мунхаг толгойд "Робинзон Крузо" л бодогдоно. Яагаад тэгснийг бурхан тэнгэр л мэдэх буй заа. Хэрэв яг энэ мөчид эрүүлч Кафф, Баасан шиг хань болох хүн ч олдохгүй аврах онгоц ч очихгүй эзгүй аралд хаягдчих юм бол миний хүсэл биелэх нь тэр! (Nota bene: Миний бие дориун сайн христос мөргөлтөн гэдэгт та нэг их эргэлзэх хэрэггүй. Та нарын ихэнх нь тухайн нөхцөлд над шиг л байх нь лав)

Эрүүлч Кафф цааш өгүүллрүүн:

-Миний бодол зөв ч бай, буруу ч бай, юуны өмнө шалгах ёстошй байлаа. Би энэ байшинд байгаа хувцасны бүх шүүгээ савыг нэгжье гэсэн саналаа танд хэлсэн. Тэр бол будаг хүрсэн хувцсыг олох гэсэн зорилготой байсны зэрэгцээ би таамаглалаа шалгах гэсэн юм. Тэгээд юу болов оо? Ахайтан та зөвшөөрсөн, мистер Блэйк зөвшөөрсөн, мисс Вериндер л ганцаараа мөрдлөгийн ажилд саад хийж, эрс татгалзсан. Үүгээрээ миний таамаглал зөв болохыг нотолсон юм. Бэттереж гуай та хоёр миний энэ хэлснийг зөвшөөрөхгүй байвал, өнөөдрийн явдлыг харахгүй сохор байж л таарна. Мисс Вериндерт гэрээсээ явах н бэрдэнийн чулуу олох ажилд саад хийж байна гэж би дуулдахуйц чанга хэлсэн. Гэтэл тэр сануулгыг ч үл хэрэгсэн явчихсныг та нүдээрээ харсан шүү дээ. Эл хэргийн учрыг тайлахад минь бүхнэс их тус болсон Блэйкийн ачийг умартаж, эхийнхээ байшингийн үүдэнд олны нүдэн дээр доромжилсныг харсан биз дээ. Энэ бүхэн юу гэсэн үг вэ? Мисс Вериндер очир алмаз алга болсон хэрэгт холбогдолгүй юм бол энэ бүхнийг юу гэж үзэх вэ?

Каффын харц над дээр тусав. Мисс Рэчелийг буруутгасан зүйл өчнөөн төчнөөнийг гарган нотлохыг сонсож тэр бүрд нь Рэчелийг өмгөөлж хамгаалахсан гэж тэсгэлгүй хүсэвч Каффын хэлснийг тас цохих аргагүй гэдгээ мэдэж суух даанч аймшигтай ажээ. Бурхны авралаар, миний бие тэрхүү баталгаа нотолгооноос хавьгүй цааш харж байсан учраас Вериндер хатагтайтай яв цав саана нийлж байсан юм. Үүндээ эрэмшиж, түрүүч Каффын харцыг зоригтой даалаа. Уншигч та, миний жишээг дагаад үзэгтүн! Таныг олон эвгүй зүйлээс аварна шүү. Та баталаа нотолгооноос гүнзгий харж сур. Тэгвэл таны сэтгэлийн тавыг алдуулах гэж оролдсон ямар ч хүний өмнө эрх ашгаа хамгаалан гуйвалтгүй зогсож чадна!

Хатагтай бид хоёр үг дуугарсанүйд, Кафф яриагаа огт хэнэггүй үргэлжлүүлэхийг хараад бурхан минь! Би галзуурах дөхөж билээ.

-Ахайтан минь, зөвхөн мисс Вериндерийн эсрэг баримтууд гэвэл энэ байна. Одоо мисс Вериндер талийгаач Розанна Спирманыг хоёуланг буруутгасан нотолгоонуудыг авч үзье. Таны охин хувцасны шүүгээгээ нэгжүүлэхээс татгалзсан үеийг эргэн саная. Тэгж татгалзсаных нь дараа би дүгнэлтээ хийсэн боловч хоёр асуудал шийдэх ёстой байлаа. Нэгдүгээрт, мөрдлөгийг ямар маягаар явуулах. Хоёрдугаарт, мисс Вериндер зарц нараас хамсаатан элсүүлсэн эсэхийг мэдэх явдал байв. Сайтар тунгаан бодсоны эцэст манай албаныхан тун буруу гэж үзэх аргаар мөрдлөгөө явуулахаар санаа шулуудсан юм. Яагаад? Яагаад гэвэл, би гадагш халих ёсгүй гэр бүлийн будлианы хэргийг гардаж авсан, иймээс шуугиан бага дэгдээж, хөндлөнгөөс хүн цөөн оролцуулах тусмаа сайн байв. Ахайтан, таны охин энэ хэргийн гол буруутан (би эргэлзэхгүй байна) болж байгаа нөхцөлд сэжиглэгдсэн хүнийг баривчилж, шүүхийн өмнө байцаах зэрэг ердийн арга энд огтын зохисгүй юм. Тэгэхээр Бэттереж гуай шиг ийм зан араншинтай, ийм байр суурьтай бөгөөд зарц нарыг арван хуруу шигээ андахгүй мэддэг, танай гэр бүлийн нэр төрийг чин сэтгэлээсээ хамгаалдаг хүнээс өө рсайн туслагчийг би гарынхаа доор байгаа улсаас олохгүй гэдгээ мэдсэн юм. Мистер Блэйкийг туслагчаа болгоё уу гэтэл нэг зүйл саад болоод байв. Юу гэвэл мистер Блэйк имний ажлын чиг хандлагыг аль эрт гадарласан бөгөөд мисс Вериндерт сайн байдаг нь бид хоёр биеэ ойлголцох нөхцөлгүй болгожээ. Би гэр бүлийн нууцыг гэр орны хүрээнд чанд сахиж буйгаа үзүүлэхийн тулд энэ нарийн ширийн зүйлсийг дурдаж, ахайтныг чилээж байна. Миний бие танай нууцыг мэдэж байгаа ганц хөндлөнгийн хүн бөгөөд бид ажилдаа ахиж, дэвших нь амаа хэр зэрэг хамхиж чадсанаас ихээхэн шалтгаалдаг юм.

Тэгж хэлэхэд нь миний ажилдаа ахиж дэвших явдал аль хэр яриа хөөрөөтэй байдгаас шалтгаалдгийг санаж билээ. Хөгширсөн хойноо цагдаагийн эрүүлчийн туслагч мэтээр эзэгтэйдээ үзэгдэх нь миний хэрээс хэтэрсэн зүйл байлаа.

-Ахайтан минь, би энэ ой гутмаар мөрдлөгийн ажил эхлэхээс аваад дуустал нь санаатайгаар тусалж байсан удаагүй гэдгээ хэлэхийг зөвшөөрнө үү. Кафф та чаддаг юм бол миний үгийг няцаа л даа! Гэж би хэллээ.

Би тийнхүү зэвүүцлээ нууж хаалгүй хэлчихээд дотор баахан уужирлээ. Ахайтан миний мөрийг нөхөрсгөөр аяархан алгадав. Миний батлан хэлснийг сонсоод юу бодсоныг нь мэдэх гэж би эрүүлчийг эгдүүцэн харсанд харин сэтгэлд нь бүр ч их нийцсэн бололтой, миний өөдөөс зөөлөн харц чулуудаж билээ.

Ахайтан, тайлбараа үргэлжлүүлэгтүн гээд,

-Таны үзэж байгаагаар миний эрх ашгийг хамгаалж, та сайн сэтгэлэр чадах бүхнээ хийснийг би ойлгож байна. Таныг одоо юу хэлэхийг сонсьё доо гэв.

Түүрүүч Кафф хариу өгүүллүүн:

-Миний одоо хэлэх зүйл бол Розанна Спирманд хамаарах юм. Тэр бүсгүй угаалгын бүртгэлийн дэвтэр авчирч өгснийг ахайтан лав санаж байгаа биз, тэгэхэд би бүсгүйг таньсан юм. Мисс Вериндер нууцаа хүнд итгэж, даатгасан нь юу л бол гэж би тэр мөчийг хүртэл тээнэгэлзэж байлаа. Харин Розаннаг хараад эргэлзэхээ больсон бөгөөд бас очир алмаз алга болсон хэрэгт холбоотой байх гэсэн сэжиг төрлөө. Зайлуул, аймшигтайгаар нас нөгчсөн шүү. Одоо талийгаач болсон хойно нь ясыг нь өндөлзүүлж, гүтгэж муулаа гэж та бүү бодоорой. Жирийн хулгайн хэрэг байсан бол би Розаннаг бусад зарц нараас илүү үзэж, сэжиглэхгүйсэн. Засан хүмүүжүүлэх газар хүмүүжсэн эмэгтэйчүүд ажилд ороод, өөртэй нь ялдам, шударга харьцвал ихэвчлэн чин сэтгэлээсээ гэмээ наминчлан, үзүүлж буй халамжийг үнэнчээр хариулдаг болохыг олон жилийн туршлага харуулж байгаа юм. Энэ хулгай бол жирийн хулгай биш. Энэ бол алмазын эзэн өөрөө тун зальжинаар бодож боловсруулсан төлөвлөгөө гэж би үзэж байна. Ийн үзээд Розаннатай холбогдол бүхий зүйл хамгийн түрүүнд миний санаанд орсон нь зүйн хэрэг. Мисс Вериндер бид бүхэнд алмаз зүгээр л алга болжээ гэсэн бодол төрүүлээд (ахайтнаас уучлал эрье) орхих болов уу? Эсвэл арай цаашилж, алмазыг хулгай авсан байна гэж итгүүлэх оролдлого хийх болов уу гэж би бодсон юм. Энэ тохиолдолд ахайтан та, бидний гмэхэлж элбэг дөнгөх, урьд хулгайч байсан Розанна Спирман гар доор нь байв.

Мисс Рэчел, Розанна хоёрыг хүн үүнээс илүү шившигтэйгээр яллан буруутгаж чадна гэж үү хэмээн би дотроо бодож суулаа. Чадах юм байж гэдгийг та одоо харна!

-Талийгаач бүсгүйг сэжиглэх өөр нэг үндэс байсан юм гэж Кафф хэлээд –Тэр нь одоо бүр нотлогдсон мэт санагдана. Хэн тэр алазыг нууцаар зарж, мөнгө болгож чадах вэ? Розанна Спирман, Вериндер авхай шиг залуу бүсгүйчүүд тийм осолтой хэргийг гардан хийж зүрхлэхгүй. Туслах хүн хэрэгтэй. Розанна Спирманас өөр тохирох хүн олдоно гэж үү? Ахайтны талийгаач шивэгчин хулгай хийдэг байхдаа туйлын чадмаг, овжин ажилладаг байлаа. Саран чулуу мэтийн алдартай эрдэнийн чулууг илүү дутуу юм шалгааж, элдэв бусын болзол шаардалгүй их хэмжээний бэлэн мөнгө өгч чадах Лондонгийн цөөн тооны мөнгө хүүлэгчийн нэгтэй холбоо сүлбээтэй байсныг нь би мэдэхгүй яахав. Хатагтай минь, үүнийг болгоогтун. Одоо Розаннагийн үйлдсэн алхам, түүнээс үүдэн гарсан тодорхой дүгнэлтүүд миний таамаглалыг хэрхэн нотолсныг тайлбарлахыг зөвшөөрнө үү.

Дараа нь Розаннагийн хамаг ааш авирыг тайлбарлан тоочиж гарлаа. Тэр зан авирыг нь уншигч та бид хэдийн мэдэх тул үүнийг Кафф, хөөрхий талийгаач бүсгүйг алмаз алдагдсан хэрэгт холбоотой болохын няцаашгүй баримт болгон өгүүлснийг та ойлгох буй заа. Хатагтай маань Каффын үгийг сонсонгоо бүр айж орхиод юу ч хариулсангүй. Гэвч хүн хариу хэлсэн, хэлээгүй нь Каффт огт хамаагүй бололтой яриагаа ажиггүй, шийдмэг үргэлжлүүлж (чөтгөр аваасай билээ!)

-Хэрэг явдлыг хэрхэн үзэж байгаа дэлгэрэнгүй илтгэсэн болохоор одоо цаашид юу хийх санаатайгаа ахайтанд мэдэгдэх л үлдлээ. Мөрдлөгийг амжилттай дуусгах хоёр арга зам байна. Нэг нь боломжийн бөгөөд нөгөө нь аз сорьсон туршилт төдий л юм. Эхлээд найдвартай аргаар нь үзээд алдах уу? Ахайтан өөрөө шийд дээ гэв.

Вериндер ахай эрүүлчийг өөрөө мэдтүгэй гэж дохиогоор ойлгуулав.

-Баярлалаа, намайг шийд гэж та нэгэнт зөвшөөрөн соёрхсон учраас боломжийн аргаасаа эхэлье. Мисс Вериндер Фризинхоллд саатсан ч гэртээ эргээд ирсэн ч ер нь зан аашийг нь ажиглаж, орж гарах хол ойр явахад нь тандаж, уулзаж ярих хүн, бичиж явуулах буюу авах захиа сэлтийг хатуу хянах бодолтой байна.

-Дараа нь яах вэ? Гэж ахайтан асуулаа.

-Дараа нь, иймэрхүү нууц ажилд дассан нэг эмэгтэйг Розанна Спирман оронд аваач гэж ахайтнаас гуймаар байна. Түүний даруу няхуур гэдгийг би даана гэж эрүүлч ярив.

-Дараа нь яах вэ? Гэж нөгөө л асуултаа хатагтай маань давтав.

-Дараа нь буюу эцэст нь ажлынхаа нэг нөхрийг Лондон руу явуулах болно. Тэнд очоод Розанна Спирман урьд таньдаг байсан нөгөө хүүлэгчтэй холбоо тогтоох юм. Тэр мөнгө хүүлэгчийн нэр, хаягийг Розанна, мисс Вериндерт өгсөн гэдэгт та эргэлзэхгүй байж болно. Миний авах энэ арга хэмжээ багагүй мөнгө, их цаг шаардана гэдгийг би үгүйсгэхгүй. Гэвч үр дүн нь баттай юм. Бид Саран чулууг тойруулан хүрээ татаж улмаар мисс Вериндер чулууг биедээ авч хоцрохоор шийдэх хүртэл нь хүрээгээ багасгана. Хэрэв өр ширээ даруйхан төлөх шаардлагатай болоод чулуугаа зарахаар шийддэг юм гэхэд манай хүн Лондонд бэлэн байж, Саран чулууг очмогц нь гартаа оруулах юм.

Охиныг нь иймэрхүү зүйлд холбогдуулан ярихыг сонсоод манай ахайтны тэсвэр алдан, өөрийн эрхгүй хилэгнэсэн дуугаар,

-Таны энэ саналыг огт зөвшөөрөхгүй. Мөрдлөг дуусгах нөгөө аргаа хэл! Гэв.

Түүрүүч Кафф аанай л хэнэггүй янзаар,

-Миний нөгөө арга бол туршилт юм. Би мисс Вериндерийн зан чанарын талаар овоо зөв дүгнэж чадсан гэж бодож байна. Тун бөх зүрхтэйгээр мэхэлж чадах хүн шиг санагдана. Гэвч хэтэрхий огцом ширүүн зантай, хуурч мэхэлж хараахан сураагүй учраас уурлаж, эгдүүцэх үндэс байхад хуурмаг эелдэг зан гаргаж, биеэ барьж чаддаггүй юм байжээ. Эл хэргийн үеэр сэтгэл санааны байдлаа нуухыг хэдий хичээвч санасны нь зоргоор болохгүй, хэд хэдэн удаа тэвчээр алдсан билээ. Одоо би чухамхүү энэ өвөрмөц чанарыг нь л барьж туршаад үзэх гэж байгаа юм. Ёстой л голыг нь олж, палхийтэл цочооно доо. Би илүү дутуу үггүй, шууд л Розанна Спирманыг амь үрэгдсэн гэж хэлнэ. Тэгвэл сэтгэл нь уярч, үнэнээ хэлэх болов уу. Ахайтан энэ аргыг зөвшөөрөх үү? Гэлээ.

Ахайтан тэр дуруй,

-Зөвшөөрч байна гэсэнд би хязгааргүй гайхаж билээ.

-Задгай сүүх тэрэг бэлэн болгожээ. Баяртай, ахайтан.

Ахайтан гараа өргөн Каффыг үүдэн дээр саатуулж,

-Таны хэлснээр миний охины сэтгэл уярах нь лав. Гэвч би эхийн хувьд тэр туршилтыг өөрөө хийх эрхтэй бөгөөд энэ эрхээ эдлэх ёстой. Та энд үлдэгтүн, би Фризинхолл руу явна гэж айлдав.

Алдарт Кафф энэ яваа насандаа алв анх удаа жирийн хүн шиг мэл гайхан ангайн зогссон нь тэр буй заа.

Ахайтан хонх цохиж, шивэгчнээ дуудаад борооны цув авчирч өгөхийг тушаав. Бороо асгарсаар байсан агаад ахайтны сүүх тэргээр мисс Рэчел Фризинхолл руу явсныг та мэднэ. Тэнгэр ийм муухай байхад биеэ зовоож яваад юу хийнэ, дэмий гэж ятгаад дийлсэнгүй. Би шүхэр бариад хамт сууж явъя гэж гуйгаад ядлаа. Хөнгөн тэргийг зарц авч ирлээ.

-Энэ сорилтыг би таны хийх байсны нэгэн адил зоригтой хийнэ гэдэгт та итгэж болно. Лондон руу явах өнөөдрийн сүүлчийн галт тэрэг хөдлөхөөс өмнө үр дүнгийн нь танд амаар буюу бичгээр мэдэгдэнэ хэмээн үүдний өрөөнд Каффт хэлэв.

Тийн өгүүлээд, тэрэгний жолооноос барьж, Фризинхоллын зүг хөдөлж билээ.

## XXII БҮЛЭГ

Ахайтны явсны дараа эрүүлч Каффт зориулах чөлөө зав гарав. Эрүүлч доод танхимын нэг мухарт тухлан суугаад, тэмдэглэлийн дэвтрээ үзэн байдгаараа мушилзан байв.

Ажлаа тунгааж байна уу? гэж асуусанд,

-Үгүй ээ, одоо ямар хэрэг дээр ажиллах билээ гэдгээ бодож сууна гэв.

-Өө! Манай хэрэг дууссан гэж та бодоод байна аа даа?

-Вериндер ахай Английн ухаалаг эмэгтэйчүүдийн нэг гэж би бодож байна. Бас сарнай цэцэг алмазаас хавьгүй сайхан үзэгдэнэ гэж би бодож байна. Бэттереж гуай, нөгөө цэцэрлэгч одоо хаана байна вэ?

Саран чулууны талаар ганц ч үг дурссангүй. Явуулсан мөрдлөгөө одоо нэгэнт сонирхохоо больж, цэцэрлэгчийн эрэлд гарав. Нэг цаг ч болоогүй байтал тэд мөн л нохойн хошууны цэцгийн талаар чанга чанга дуугаар маргалдах нь сонсогдож билээ.

Энэ зуур миний бие мистер Фрэнклинийг оройны галт тэргээр үнэхээр явах эсэхийг нь мэдэх хэрэгтэй байв. Ахайтны өрөөнд болсон яриа, тэр яриа хэрхэн төгссөнийг сонсмогц мистер Фрэнклин Фризинхоллоос мэдээ иртэл хүлээхээр шийдсэн юм. Ийнхүү төлөвлөснөө өөрчлөх нь жирийн хүмүүсийн хувьд бол эгэл хэрэг билээ. Гэтэл мистер Фрэнклиний хувьд нэг л тавгүй дууссан юм. Одоо хийх юмгүй, дэмий л цаг нөхцөөн хүлээхэд хүрсэн бөгөөд яваандаа түүний англи биш хамаг зан авир цувран илэрч байв.

Нэг бол итали-англи, эсвэл герман-англи, заримдаа франц-англиар ашилж, мисс Рэчел өөртэй нь хэрхэн харьцсаныг л байн байн үглэн өрөө тасалгаагаар орж гаран холхиж, надаас өөр хүнтэй үл дуугарна. Жишээлбэл, номын санд орчин үеийн Италийн газрын зургийн доор суугаад учирсан зовлонгоо тоочин биеэ тайтгаруулах гэж ядаж байхыг нь би харсан билээ.

-Бэттереж гуай, надад хэдэн догь хүсэл байгаа юм. Гэвч одоо ямар хэрэг байх вэ дээ. Мисс Рэчел туслах юм бол надад өдий төдий сайн чанар нуугдаж байгаа шүү дээ! гэнэ.

Чин санаан зүтгэлийг нь үл тоомсорлосныг их л урнаар дүрслэн түүнд нь гомдсоноо элэг эмтрэм өгүүлэхийг нь сонсоод миний бие Фрэнклиний сэтгэлийг хэрхэн засах ухаанаа олохгүй мэгдэж орхиод байтал, энэ бол "Робизон Крузо" л тустай юм хэлж чадах хэрэг даруй мөн гэсэн бодол гэнэт төрлөө. Би өрөө рүүгээ харайн орж, тэрхүү мөнхийн номыг барьсаар харайлган ирсэнд номын сан эзгүй байв! Орчин үеийн Италийн газрын зураг л мэлийн, би зургийг ширтэн зогтусав.

Зочны өрөөнд орвол Фрэнклиний амны алчуур шалан дээр хэвтэж харагдах нь үгээр ороод гарсныг илтгэх ажээ.

Цайны өрөөгөөр орсонд, Сэмуэл нэг жижигхэн шилэн аягтай дарс бариад ганцаараа гөлийгөөд зогсож байлаа. Дөнгөж саяхан мистер Фрэнклин гол зогооё гэсэн учиргүй өлөрхсөн орж иржээ. Сэмуэл идэж, уух юм санд мэнд бэлтгээд өгөх гэтэл хаалганы хонх ч дуугарч амжаагүй байхад хэдийн гараад алаг болчихсон байж.

Амрах өрөөгөөр орвол мистер Фрэнклиний барааг сая олж харав. Цонхны тоостой шилэн дээр хуруугаараа элдвийг эрээчин зогсож байлаа.

-Эрхэм ээ, түүнд дарс бэлтгэчихсэн байна гэж хэлсэн маань эзгүй өрөөнд ороод амьгүй хананд хандсанаас өөрцгүй болжээ. Мистер Фрэнклин гүн бодолд дарагдан гөлөрсөн байх ба "Бэттереж гуай, та Рэчелийн гаргасан авирыг юу гэж бодож байна?" гэснээс өөр юм дуугарсангүй. Ийм юм асууна чинээ санаагүй байсан миний бие "Робинзон Крузогоо" нээв. Нэлээд тэсвэртэйгээр эрэх юм бол зохих хариу олж чадна гэдэгт би огт эргэлзээгүй юм. Гэтэл мистер Фрэнклин "Робинзон Крузог" хаагаад,

-Би харж яагаад болдоггүй билээ? Хэмээн би л саад хийж хориод бйгаа юм шиг харснаа герман-англи маягаар ээрч түгдчин түргэн түргэн бувтнасан нь –Шударга ёсонд тэвсэр хатуужлыг хамгийн ихээр шаардаж байхад яагаад тэсвэр алддаг юм бэ, Бэттереж гуай? Миний үгийг бүү таслаарай. Хэрэв та нийгмийн шударга ёсыг дагаж эхлээд бодит талаас нь, дараа нь хийсвэр талаа нь үзээд эцэст нь бодит хийсвэр талыг хамтад нь харвал Рэчелийн зан оёг маш ойлгомжтой юм. Бид юу мэдэж байна вэ? Өнгөрсөн пүрэв гаригийн өглөө Саран чулуу алга болсны улмаас Рэчел уур уцаартай болж, сэтгэлийн хямралд ороод өдий болтол тайвшраагүй байгааг бид мэдэж байна. Та хэргийн бодит талыг үгүйсгэх гэж байна уу? Их сайн, дараа болоорой, миний үгийг бүү тасал. За тэгэхээр сэтгэлийн хямралд орчихоод байсан түүнийг ойр орчныхоо улстай өөрөөр яаж харьцана гэж бид бодох ёстой юм бэ? Бид ингэж дотоод чанараас гадагш батлах замаар юунд хүрэх вэ? Бид хийсвэр талд нь хүрнэ. Хийсвэр талыг үгүйсгэхийг би зөвшөөрөхгүй. Их сайн, за дараа нь юу билээ? Ивээлт тэнгэр минь, мэдээжээр бодит хийсвэр талаас нь тайлбарлалгүй яах вэ дээ! Энүүхэндээ гэж хэлэхэд Рэчел, Рэчел биш өөр хүн болжээ. Өөр хүн гэж бодоод ширүүхэн байж болох уу? Бэттереж гуай, та учрыг сайн ухаараагүй ч гэсэн намайг хатуу зэмлэж болно шүү. Тэгвэл энэ хэрэг яаж шувтрах вэ? Таны хараал идсэн англи явцуурал, утга санааг эс харгалзан тун жаргалтай, эвтйхэн төгсөх вий. Дарс хаана байна?

Тэр зуур миний мөрөн дээр байгаа бөндгөр минийх үү, мистер Фрэнклинийх үү гэдгийг би олигтой ялгахгүй байсан юм. Тийм хөөрхийлөлтэй нөхцөлд миний бие ямар боловч гурван бодит зүйлийг гүйцэтгэж дөнгөсөн билээ. Мистер Фрэнклинд дарсыг нь авч өгөөд өрөөндөө орж, гансаа нэрэн урьд хожид үзэгдээгүй ихээр баагиулан сэтгэлээ онгойлгохоор суулаа.

Гэвч намайг мистер Фрэнклин тийм хялбар хэдэн үг хэлээд орхисон гэж та бүү бодоорой. Үүдний танхимд гарч яваад миний тамхины үнэрийг авч, мисс Рэчелийн төлөө л тамхиа хаяснаа гэнэт санасан аж. Нүд нь гялалзан хайрцагтай янжуур барьсаар миний өрөөнд чавхдан оёр ирээд хээнцэр, ухаалаг, үл итгэх франц зангаараа нэгэн мөнхийн сэдвийн талаар гуйвалтгүй бодолтой гарч одсон билээ.

-Бэттереж гуай, гал өгөөч. Тамхиных нь хайрцгийн ёроолд бүсгүйчүүдийн уршгаар туссан өвчнийг анагаах эм байдгийг мэдэлгүй өчнөөн жил тамхи татсан эр хүн байна гэж юү гэсэн үг вэ! Анхааралтай сонсож бай л даа, үүнийг би хоёрхон үгээр батлаад орхиё. Та нэг ороомол навчин тамхи авлаа, татаад үзлээ, таны сэтгэлд таарсангүй. Тэгвэл та яах вэ? Түүнийгээ хаячихаад дахиад нэгийг татаж үзнэ. Одоо юу хүсч буйгаа ажиглагтун! Та нэг бүсгүй сонгож авлаа, ярилцаж, харьцаад үз, гэтэл таны зүрхийг шархлуулж, урмыг хугаллаа. Баларсан юм! Тамхины хайрцагаасаа сургамж авагтун! Тэгээд тэр бүсгүйг хаяад өөр нэгийг олж ав!

Би тэгэхэд нь толгой сэгсрэв. Гайхмаар ухаалаг үг боловч миний амьдралын туршлага үүнийг зөвшөөрөхгүй байв.

-Бэттереж авгайн амьд сэрүүн үед би ч бас ингэж бодох хандлагатай байлаа. Гэхдээ эрхэм минь, та нэгэнт л сонгож авснаас хойш тэр л тамхиа татаж дуусахыг хууль ёс шаарддаг юм даа хэмээн би нүдээ цавчлан сануулав.

Фрэнклин Блэйк инээд алдав. Тэгээд түүний зан жам ёсоороо хувиран хувиртал бид зугаатай хүрэлзгэнүүд шиг л байцгаалаа. Эрүүлч, цэцэрлэгч хоёр сарнай цэцгийн талаар маргалдаж байх зуур манай залуу эзэн бид оёр иймэрхүү янзаар цаг нөхцөөн Фризинхоллоос ирэх мэдээг хүлээж байв.

Хөнгөн сүүх санасныг бодвол элбэг хагас цагийн өмнө эргэж ирлээ. Ахайтан эгчийндээ үлдэх болж, зарцаар хоёр зурвас явуулсны нэгийг нь мистер Фрэнклинд нөгөөг надад ирүүлжээ.

Мистер Фрэнклинд захиаг нь номын сан руу хүргүүлэв. Харин би өрөөндөө орж захиагаа уншлаа. Дугтуйг задлахад мөнгөний чек унаанд Саран чулууны хэрэг шувтарч, эрүүлч Каффын ажлын хөлсийг өгөх ёстой болсныг би ойлгосон юм.

Мистер Каффыг даруйхан дууд гэж хүн явууллаа. Цэцэрлэгч, нохойн хошууны цэцэг хоёроос өөр бодох юмгүй ч гэмээр, дөргүй бух шиг зөрүүд хүн мистер Бэгбигээс өөр байхгүй биз хэмээн үгээ барсаар орж ирлээ. Тэгэхэд нь би энэ аа рсаар дэмий яриагаа орхиж, арай ноцтой хэрэгт анхаарсан нь дээр байх шүү гэсэнд миний гарт захиа байхыг гэнэт олж харав.

-Өө, та ахайтнаас сураг сонсоо юу? Бэттереж гуай, надад хамаатай юм байна уу? хэмээн Кафф гунигтай өнгөөр асуулаа.

-Та өөрөө тунгаа л даа гээд би захиаг сэтгэл догдлон уншиж өгсөн бөгөөд доор сийрүүлбэл:

“Эрхэм сайн Габриэл минь, намайг хэлсэндээ хүрснийг түрүүч Каффт уламжлаад, үр дүнг нь мэдэгдэнэ үү. Мисс Вериндер золгүй Розаннаг манай босгыг анх алхан орсон цагаас эхлэн аминчлан ганц боловч үг сольсон удаагүй гэдгээ батлан хэлж байна. Алмаз алга болсон шөнө, санаандгүй ч гэсэн, уулзаагүй. Алмаз алдагдсаныг анх мэдсэн пүрэв гаригийн өглөөнөөс мисс Вериндер гэрээсээ явсан бямба гаригийн үд хүртэл Розаннатай ямар ч харилцаагүй байсан гэнэ. Розанна Спирманыг амиа бүрэлгэсэн тухай охиндоо гэнэт, товчхон мэдэгдсэний үр дүн ийм байна”.

Энэ хэсэгт хүрээд би эрүүлчээс энэ тухай юу гэж бодож байна гэж асуулаа.

-Саналаа хэлчихвэл таныг гомдоож орхино байх. Цааш нь уншаач, Бэттереж гуай, цааш нь хэмээн Кафф тун эгдүүцэм хүлцэнгүй янзаар өгүүлэв.

Манай цэцэрлэгчийн зөрүүдийг гайхаж ичгүүргүй авирласныг нь гэнэт санаад “цааш нь” ахайтны бичсэнээс шал өөр үгээр уншъя уу гэтэл миний бие шударга христос мөргөлтөн учраас мэхэлж төвдсөнгүй, захиаг төв дуугаар цааш уншсан билээ.

“Түрүүчийн дэвшүүлсэн аргаар мисс Вериндэртэй ярилцаад, дараа нь арай их нөлөөлөх болов уу гэж бодсон аргаараа ярилцаад үзлээ. Гэрээсээ явбал чамайг үлэмж шившигт хэрэгт сэжиглээн шүү дээ гэж би явахы нь өмнө охиндоо хоёр ч удаа битүүхэн анхааруулсан билээ. Би дэмий айгаагүй байснаа сая шулуухан тодорхой хэллээ. Үүний хариуд, нэгдүгээрт, нэг ч хүнээс сохор зоос нууцаар зээлээгүй; хоёрдугаарт, лхагва гаригийн шөнө шүүгээндээ хийж орхисноос хойш алмазын барааг ч олж хараагүй хэмээн гуйвалтгүй баталж байна.

Охин маань надад үүнээс илүү юм итгүүлэх гэж оролдсонгүй. Очир алмазыг алга болсны учрыг хэлж чадах уу гэж асуусанд дуугаа хураачихав. Эхийгээ бодоод нууж хаалгүй яриач гэж гуйснад нулимс асгаруулан дургүйцэж, “Би өөрийгөө муухай хэрэгт сэрдэхийг ч үл хайхран, танаас хүртэл ингэж нуугаад байгаа учрыг та хожим ойлгоно. Би эхийгээ зовоох юм их хийсэн, гэхдээ эхийнхээ нүүрийг улайлгах юу ч хийгээгүй” гэлээ. Охин маань яг ингэж хэлсэн юм шүү.

Түрүүч бид хоёрын хооронд болсон яриаг бодоход мисс Вериндэрийн хариуг Каффт (хөндлөнгийн хүн ч гэлээ) бас мэдэгдэх нь зүйтэй юм. Миний захиаг уншиж өгөөд, энэ чекийг өгөөрэй. Мөрдлөгийн ажлыг нь зогсоохын ялдамд шударга зан, мэргэн ухаанд нь талархаж буйгаа хэлэх ёстой. Гэвч энэ удаа түрүүч Кафф үйлийн үргүй сүрхий алджээ гэдэгт би бүр ч гүнзгий, баттай итгэлээ”.

Захиа ийнхүү төгсчээ. Мөнгөний чек өгөхөөсөө өмнө би хэлэх юм байгаа эсэхийг Каффаас асуувал,

-Бэттереж гуай, нэгэнт дууссан хэргийн талаар ярих шаардлага байдаггүй юм гэв.

Би мөнгөний чекийг ширээн дээр чулуудаад,

-Та ахайтны захианы тэр хэсэгт үнэмшиж байна уу? гэсэн увайгүй асуулт тавилаа.

Түрүүч Кафф чек рүү харснаа ахайтны өглөгт талархаж, баргар царайлан хөмсгөө хөдөлгөөд,

-Миний хувьд энэ бол тун том үнэлгээ учраас ачийг ачаар хариулах ёстой гэж би бодож байна. Бэттереж гуай, хэрэг явдал аяндаа сануулах цаг ирэхэд би энэ чекэнд бичээстэй мөнгөний тоог мартажгүй гэв.

-Энэ чинь юу гэсэн үг вэ?

-Ахайтан энэ хэргийг одоохондоо тун ухаалгаар нэг тийш болголоо. Гэвч энэ бол та нарыг огт санаандгүй байтал дахин сөхөгдөж бөөн хэрэг мандах гэр бүлийн будлиан юм. Саран чулуу нэг их олон сар бололгүй та бидэнд дахиад л нэг эрэн сурвалжлах ажил тарина даа, эрхэм ээ.

Энэ үгнийх нь далд санааг уудалбал, Рэчл авхай бол хэчнээн ширүүн харьцлаа ч сөрөн зогсож чадахаар, мөн төрүүлсэн эхийгээ удаа дараа хэнэггүй муухай мэхэлж (авралт бурхан минь, ийм үед шүү!) дөнгөх яггүй хатуу сэтгэлтэй бүсгүй юм гэдгийг Вериндер ахайн захиа нотолж гэнэ дээ. Өөр хүмүүс миний оронд байсан бол чухам ямар хариу өгөх байсныг бүү мэд, харин би,

-Түрүүч Кафф, та ахайтныг охиных нь хамт доромжиллоо гэж би бодож байна! Хэмээн улалзтал нь хэлэв.

-Бэттереж гуай, үүнийг та өөртөө өгөх сануулга гэж бод, тэгвэл байнд арай ойр тусна.

Хэдийгээр миний уур хилэн бадарч, хор шар буцлавч зэвүүцэм итгэлтэй хэлсэн үгэнд нь амаа таглуулсан юм.

Би тайвшрах санаатай цонх руу очив. Бороо арилжээ. Нохойн хошууны цэцгийн тухай маргаанаа үргэлжлүүлэх гэж эрүүчлийг хүлээн зогсож буй цэцэрлэгч Бэгбигээс өөр хүн хашаанд үзэгдсэнгүй.

Мань хүн намайг олж харчихаад

-Эрүүлч гуай буудал руу алхана гэвэл би дуртайяа хань болно гэдгийг хэлээрэй гэв.

-Юу! Та санаснаараа зүтгэсээр байна уу? гэж эрүүлч хашгирав.

-Сөөм ч ухрахгүй шүү!

-Тэгвэл би буудал руу алхана даа!

-Тэгвэл хаалган дээр уулзацгаая!

Би нэлээд уурлачихаад байсныг та мэднэ. Гэвч иймэрхүү юманд хүн уураа яаж барих билээ? Түрүүч, миний царай хувирахыг ажаад тэгэхээс тэгэх гэсэн шиг

-За боль доо боль! Яахаараа тэр талаар миний бодсоныг хатагтайн адил бодож болохгүй байна аа? Нөхцөл байдлын эрхээр намайг тун ч сүйдтэй эндүүрч дээ гэж яагаад хэлж болохгүй билээ? Гэсэн ончтой үг хэлэв.

Каффын надад боломж олгосон нь угтаан олиггүй гэлээ ч гэсэн аливаа юмыг хатагтайн адил ойлгох нь баярлууштай байлаа. Тэгсгээд уур дарагдаж, би яваандаа ердийнхөө байдалд орсон юм. Би мисс Рэчелийн талаар ахайтан бид хоёроос өөр бодол агуулсан хэний боловч бодлыг үнэн голоосоо зэвүүрхэнэ. Нэг л юмыг, Саран чулууны тухай зүйлийг орхиж би яагаад ч чадахгүй байлаа. Эрүүл ухаанаар бодоод тийм юмнаас холуур явсан дээр биз гэж бишгүй бодогдоно, би сайн мэдэж байна, гэвч эдүгээ үеийн хүмүүсийг бусад үеэс гоц болгосон сайн үйлс гэгч миний үед зохиогдсонгүй юм байна л даа. Эрүүлч миний хамгийн эмзэг хөндүүр газар цохиод авах шиг болж, хэдийгээр би түүнийг аль муугаараа занавч хөндүүр газар маань өвдсөөр байлаа. Ингээд эцэст нь би ямар ч болтугай хорондоо ахайтны захидлын тухай үг өдөв.

-Миний хувьд бол эргэлзэх юм огт алга. Гэхдээ яахав, зоволтгүй! Миний бодлыг өөрчлөх гэж оролд л доо. Мисс Рэчелийн үгийг үнэмшиж болохгүй, Саран чулууны тухай сураг дахин гарна гэж та бодож байна. Түрүүч гуай та энэ бодлоо л нотол, нотлх л хэрэгтэй гэж хөөрүү байдалтай хэлэв.

Түрүүч, миний хэлсэн үгэнд муу санахын оронд гарын минь хэдэн хурууг өвдтөл чанга атгаснаа,

-Бэттереж гуай хэрэв би тантай хамт байх завшаан олдож гэмээнэ маргааш эхлэн эгэл үйл ажилд зүтгэх байна гэж бурхан тэнгэрийг барьж тангараглах байна! Эрхэм минь, таныг жаахан хүхэд шиг гэнэ хонгорхон хүн гэж хэлбэл тийм арван хүүхдийн есөд нь ахдах магтаал болно. Нээрэн, хоёул үүнээс хойш түүнээс цааш маргахаа больё, нээрэн шүү! Та үнэнийг надаас төвөггүй амархан мэдэх болно. Би ахайтны тухай эсвэл мисс Вериндерийн тухай ганц ч үг цухуйлгахгүй, харин би амьдралдаа анх удаа, тэгэх мөртлөө таны төлөө ирээдүйг таагч болно. Саран чулууны хэрэг дуусаагүй хэвээр байгаа гэж би танд нэгэнт сануулж хэлсэн. За тэр ч яахав. Одоо би явахынхаа өмнө таныг дуртай дургүй байсан ч анхаарлыг тань татах учиртай гурван зүйл мөд тохиолдохыг хэлье гэж хачин дарга маань их л ёсорхгоор хэлэв.

Ингэхэд нь би ажиггүй өнөө л хөөрүү байдлаараа,

-Цааш нь хэл л дээ! Гэхэд түрүүч,

-Нэгдүгээрт, дараачийн даваа гаригт шуудан зөөгч, Розаннагийн захидлыг Коббс Холд хүргэж ирэхэд та Ёолландоос нэг юм сонсоно гэлээ.

Ийм үг сонссоноос хувин хүйтэн ус толгой руугаа цутгуулсан маань дээр санагдах байсан болов уу. Мисс Рэчел өөрөө ямар ч гэмгүй хэмээн зүтгэсэн нь Розанна яагаад шинэ бошинз хийсэн, будаг болсон бошинзоо яагаад нуух болсон гэхчлэн бусад зүйл бүгд тайлбарлахын аргагүй болно. Эрүүлч ганцхан агшин дотор ийм юм санаанд минь оруулахаа өмнө энэ тухай урьд бодож байсангүй.

-Хоёрдугаарт, өнөөх гурван энэтхэгийн сураг танд дахин дуулдана. Хэрэв мисс Рэчел энэ хавьдаа байх ахул тэдний сураг энэ хавиас танд сонсоно. Мисс Рэчел Лондонд очвол тэдний сургийг та тэндээс дуулна гэж түрүүч цааш нь хэлэв.

Би, гурван илбэчнийг огт сонирхохоо больж, авхайнхаа гэмгүйд баттай итгээд энэ хоёр дахь таамаглалыг нэг их юманд бодсонгүй учраас,

-Тохиолдохн гурван зүйлийн хоёр нь ийм юм биз дээ, одоо уграв дахий нь сонсьё доо гэлээ.

-Гуравдугаарт, хамгийн сүүлчийнх нь гэвэл, би танд хоёр удаа хэлж байсан бйах, нөгөө Лондоны мөнгө хүүлэгч тэр хүнээс эрт орой алин боловч нэг юм сонсоно доо. Ийм юм үнэхээр боллоо гэхэд эндүү андуу болгохгүйн тулд би нэр усы нь бичээд өгье, та өврийнхөө дэвтрийг өг дөө гээд Кафф цагаан хуудсан дээр, “Мистер Септимус Люкер, Мидлекс талбай, Ламбет, Лондон” гэж бичсэнээ хаяг руу зааж, -Одоо таныг Саран чулуу гээд зовоож байгаа хамгийн сүүлчийн маань үг энэ шүү. Миний зөв бурууг улирах цаг харуулна. Харин тэр болтол эрхэм минь, би хувьдаа таны талаар тун сайнаар санаж явна, энэ маань та бид хоёуланд тун сайнаар санаж явна, энэ маань та бид хоёуланд маань таатай билээ. Намайг мэргэшсэн ажлаасаа чөлөөнд гарах хүртэл та бид хоёр уулзалдаж чадахгүй бол Лондонд ойролцоо байдаг, миний нүд булаасаар буй нэг жижигхэн байшинд ирж надтай таныг уулзах бол уу гэж найдаж байна. Цэцэрлэг дундуур маань зүлгэн зам гарсан байх болно гэж Бэттереж гуай танд би ам бардам хэлэх байна. Харин цагаан сарнайн тухайд гэвэл... гэтэл цонхны цаанаас

-Эхлээд нохойн хошуу тарихгүйгээр цагаан сарнай ургуулна гэдэг чинь гонж гэх дуу гарав.

Бид хоёл эргэж харвал хашааны хаалган дээр нөгөөх Бегби маргалдахын мөн болон тэсч ядан буй бололтой зогсож байв. Түрүүч миний гарыг түлхэж орхиод хор шар нь буцлав бололтой хашаа руу год үсрэн гарав. Тэгснээ надад цонхоор,

-Эргэж ирэхээр нь цагаан сарайн тухай асуугаарай, надтай мөчөөрхөж чадахаар байна уу, үгүй юу ажаарай гэж хашгирав. Би тэр хоёрын омгийг түрүүнд нэг удаа намдааж байсан шигээ энэ удаа бас тийм янзаар,

-Цагаан сарнайн тухайд та хоёрын аль аль чинь зөндөө юм ярьж чадах байх л даа! Гэж хариулав.

Уг нь би (Ирланд хүмүүсийн ярьдгаар) чулуу хөөлгөө гэвэл болох л байсан. Нөгөө хоёр маань бие биедээ мөчөөгөө өгөлгүй сарнайн тухай маргалдсаар хамт гарч одов. Тэр хоёрын барааг эцсийн удаа харсан маань энэ билээ. Бегби зөрүүд толгойгоо байн байн сэгсэрч байхад түрүүч Кафф өрөөсөн гараас нь хуяг шиг барьчихсан явж харагдсан. Ай, миний бие түрүүчийг ямагт үзэн яддаг байсан хэрнээ түүнд муу байж чаддаггүй маань хачин юм шүү!

Яахлаараа ийм байдгийг тайлбарлаж чадах аваас тайлбарлагтугай. Харин та одоохон надаас болон миний сэтгэл санааны ийм зөрчилт байдлаас түр салах болно. Мистер Фрэнклиний явсан тухайг мэдээлэх үед, бямба гаригт болсон хэрэг явдлын түүх төгсгөлөө үзэх болно. Харин шинэ долоо хоногийн дотор гарсан хэд хэдэн хачин явдлын тухай би дараа тоочин өгүүлж энэхүү явдлын талаар өөрт ногдсон хувийг нэгэнт хийж дуусгасан цагтаа, эхэлснийг цаашид үргэлжлүүлэхээр томилогдсон хүн үзгээ шилжүүлэх болно.

Хэрэв энэ хүүрнэлийг бичих гэж хэчнээн их ядарсанчлан та унших гэж мөн ядарсан бол бурхан минь, цааш нь хэдэн хуудас нэмэх үес явал аль аль маань аятайхан сэтгэгдэлтэй байж чадах бол!

## XXIII БҮЛЭГ

Мистер Фрэнклин өнөө оройн галт тэргээр явна гэж зүтгээд байсан тул би хөнгөн сүүх бэлэн байлгав. Фрэнклиний араас ачаа тээшийг нь аваад гарч буйг хараад мань хүн насандаа анх удаа ам буцсангүй гэдэг нь надад тодорхой болсон юм. Би үүдний танхимд тааралдаад,

-За, та үнэхээр явах нь уу, эрхэм ээ? Мисс Рэчелийг энэ талаар ухаартал нэг хоёр хоног харзнах юм биш үү? Гэлээ.

Фрэнклиний англи биш зан авир ул мөргүй арилсан агаад надад хариу хэлэхийн оронд Вериндер ахайн захиаг миний гарт атгуулав. Тэр захианд нэгэнт өгүүлсэн зүйлийг мэдээлээд эцэст нь мисс Рэчелийн тухай хэдэн үг нэмжээ. Чухам энэ л Фрэнклин ноёнг тийнхүү тууштай шийдмэг байхад хүргэсэн буй за.

Ахайтны бичсэн нь:

“Би охиноосоо учрыг асууж шалгаахгүй зөнд нь орхиж байгааг та лав гайхах биз. Хорин мянган фунтын үнэтэй очир алмаз алга боллоо. Үүний нууц Рэчелд тодорхой бөгөөд миний үл мэдэх нэг юмуу, хэдэн хүний төлөөнөө миний бие гадарлах ч үгүй нэг шалтгааны улмаас дуугүй байгаад байна гэж санагдана. Охиноо зөнд нь орхисны учир ойлгомжтой болов уу? Рэчелийн одоогийн ааш авираас энэ тун ойлгомжтой юм. Хачин их уурлаж, цухалдахыг нь харахаас өрөвдмөөр юм. Рэчелийг бага ч атугай тайвшрахаас нааш би Саран чулууны талаар үг ч цухуйлгахаас зүрх алдаж байна. Ийм учраас ч би цагдаагийн эрүүлчийг явуулахдаа огт түдгэлзээгүй юм. Биднийг мухардуулж орхисон энэ хэрэг

түрүүчийг ч бас мухардууллаа. Уг хэргийн олоход хөндлөнгийн хүн бидэнд тусалж чадахгүй. Харин ч надад зовлон нэмж байна. Рэчел тэр хүний нэрийг сонсов уу, үгүй юу л галзуурах дөхнө.

Цаашид хэрхэхийг би боломжтой талаас нь бодож тунгаалаа. Одоо Рэчелийг Лондон авч явъя. Өөр газар очоод тайвшраг, бас сайн эмчтэй уулзаж явал зохихыг зөвлөө. Хотод очоод бидэнтэй уулзаарай гэж таныг гуйх нь хаашаа ч юм. Хонгор Фрэнклин минь, та миний нэгэн адил аятайхан цаг ирэхийг тэвчин хүлээх хэрэгтэй болжээ. Мөрдлөгийн ажилд үзүүлсэн таны үнэтэй тусламжийг сэтгэл санааны хямралд ороод бйгаа Рэчел уучилшгүй доромжлол мэтээр үзэж байна. Энэ хэрэгт мухар сохроор хөдөлснөөрөө та нууцыг нь тайлахад тус болж, зовлонгий нь нэмжээ. Та бид хоёрын хэн хэн нь төсөөлөх ч, таамаглах ч аргагүй байсан үр уршгийн төлөө таныг гомдмоор муухай зэмлэснийг нь уучлах боломжгүй юм. Рэчелийг өрөвдөхөөс л биш учирлаж, ятгаад нэмэргүй. Надад хэдийгээр харамсалтай байгаа боловч Рэчел, та хоёр одоогоор уулзах хэрэггүй гэж хэлэх ёстой боллоо. Рэчелд ойлгож ухаарах цаг олгооч л гэж зөвлөмөөр байна”.

Би захиаг нь эргүүлж өгөв. Манай авхайд хэчнээн сайн байдгий нь мэддэг болохоор би Фрэнклин ноёнг үнэн сэтгэлээсээ өрөвдөж билээ. Рэчелийн эхийн бичсэн зүйл зүрхийг нь шархдуулсан нь илт байв.

-Эр хүн долоо дордож, найм сэхдэг гэсэн зүйр үг бий. Мистер Фрэнклин минь, одоо ч бид долоо дорддоогоо дордчихоод байна шүү дээ гэхээс өөр юм би хэлж чадсангүй.

Миний үгэнд нэг их тайвширсангүй бололтой, нагацынхаа захиаг эвхэнгүүтээ,

-Лондонгоос тэр гайтай алмазыг авч авч ирэх үед Англид эднийх л хамгийн зол жаргалтай айл шиг санагдаж билээ. Гэтэл одоо энэ айлыг хар л даа! Тарж сарниад, ойр орчны агаар нь хүртэл бөөн нууц, сэжиг таавраар бохирдсон мэт болжээ. Манай нагац ах Хэрнкастлийн тухай, төрсөн өдрийн бэлгийн тухай Нуранги элсэн дээр та бид хоёр ярилцсан өглөөг санаж байна уу? Бэттереж гуай, тэр Саран чулуу хурандаагийн өс хонзонгийн зэвсэг болжээ. Ийм маягаар хонзонгоо авна гэж хурандаа өөрөө ч төсөөлөөгүй биз! Гэчихээд миний гарыг атгаад тэрэг рүү хөдөллөө.

Би хойноос нь уруудлаа. Насныхаа хамгийн жаргал цэнгэлтэй үеийг өнгөрөөсөн газрыг ийнхүү орхин одохыг нь харахад тун ч гунигтай ажээ. Манайд тохиолдсон хэрэг явдалд байдгаараа самгардаж орхисон Пенилоп, Фрэнклинтэй салах ёс хийхээр уйлж унжсаар гарч ирлээ. Фрэнклин Пенилопыг үнсэв. Би “Эрхэм ээ, сайн яваарай! “ гэж хэлэх мэт гараа савав. Хэдэн шивэгчин бүсгүй байшингийн булангаас цухалзан харна. Фрэнклин бол эмс хүүхнүүдийн шохоорхлыг татдаг эрчүүдийн нэг билээ. Эцсийн мөчид би тэргийг зогсоож, захиа бичиж, мэнд усаа мэдэгдэж байгаарай хэмээн гуйлаа. Фрэнклин миний үгийг анзаарсан шинжгүй, сэтгэлдээ дотно байшин, цэцэрлэгтэй салах ёс гүйцэтгэх мэт хавь ойроо тойруулан харна. Би тэрэгнээс зуурч,

-Эрхэм ээ, та одоо хаачих гэж байгаа юм бэ? Хэмээн цаашдын санааг нь мэдэх санаатай асуулаа.

Мистер Фрэнклин гэнэт бүрхээ чихэндээ хүртэл дарж өмсөөд

-Хаачих гэж байгаа юм бэ? Хэмээн миний үгийг цуурай шиг давтсанаа –Эрлэг рүү явлаа! Гэв.

Христос мөргөлтний ёсоор энэ үгнээс айн ширвээтэхийг мэдэрсэн мэт сүүх тэрэг чичирсхийн хөдлөв. Тэрэгний бараа тасрахаас өмнө,

-Хаана ч явсан бурхан таныг ивээх болтугай! Гэж л хэлж амжлаа.

Ялдамхан, хонгор залуу эрхэм! Хэдүй их дутагдал, мунхаг зан гаргадаг ч гэсэн ялдамхан хонгор залуу билээ! Манай хатагтайнхныг орхин одохдоо уйтгартай хоосон хөндий ором үлдээв.

Зуны сайхь бямба гаригийн урт өдөр шувтрах үес гэрт жигтэйхэн дүнсгэр гунигтай болов.

Би сэтгэлээ засахын тулд шалавхан ганс, “Робинзон Крузогоо” шүүрч авлаа. Пенилопоос бусад эмэгтэйчүүд Розаннагийн амиа бүрэлгэсэн тухай хэлэлцэж цаг нөхцөөнө. Тэд хөөрхий бүсгүйг Саран чулууг хулгайлаад илчлэгдэхээс айсандаа амиа хорлосон гэж баттай бодож байлаа. Гэвч Розаннагийн амиа хорлосны шалтгааны тухай таамаглал нь, хатагтай тэр бүсгүйн буруугүйд итгэж байсны адилаар биднийг очир алмазын талаар ямар нэг дүгнэлт хийхэд хүргэж чадсангүй. Розаннагийн Фризинхоллд сэм очсон явдал, ер бүх л үйлдсэн хэрэг нь битүүлэг үлджээ. Энэ талаар Пенилопт сануулаад огт тусгүй, харин ч борооны цуван дээр дусал унахаас өөрцгүй билээ. Хэргийн учир юу гэвэл, охин маань оюун дүгнэлтийг үл хайхардаг миний занг өвлөн авснаар үл барам энэ чанараараа надаас хол давсан ажээ.

Маргааш нь (ням гаригт) мистер Эблвайтынд үлдсэн битүү сүүх тэрэг хоосон буцаж ирлээ. Ахайтан маань надад нэг зурвас, мөн өөрийн шивэгчин, Пенилоп хоёртоо захирамж явуулсныг хөтөч надад өглөө.

Даваа гаригт мисс Рэчелийг Лондонгийн байшиндаа аваачихаар шийдсэн болохоо зурвасанд бичжээ. Захирамжиндаа хоёр шивэгчин хотод ямар ямар хувцас аваачвал зохих, хэдэн цагт хатагтай нараа угтах ёстойг дурдаад мөн зарц нарын ихэнхийг хотод оч гэжээ. Болсон явдлын улмаас мисс Рэчел гэртээ харих гэж огтхон ч дурлахгүй байгааг ахайтан ойлгоод Фризинхоллос шууд Лондонд очихоор шийдсэн аж. Миний бие дараагийн захирамж гартал тосгонд үлджэ гадна дотнын ажлыг хариуцах

хэрэгтэй болов. Надтай үлдээх зарц нарт нэмэгдэл хөлс олгохоор тогтжээ. Энэ бүгд надад, тарж сарнисан гэр орон болжээ гэсэн Фрэнклиний үгийг санагдуулж, мистер Фрэнклинийг өөрийн эрхгүй дурсан бодлоо. Түүнийг бодох тусам, ирээдүйд нь улам улам сэтгэл зовнино. Эцэст нь би эцгийн нь зарц, эртний танил Жеффкодоо, мистер Фрэнклин Лондонд очоод ямаршуу байга талаар мэдэгдэж байхыг гуйсан захиа бичээд ням гаригийн шуудангаар явуулсан юм. Урьд өдрийнхөөс долоон дор дүнсгэр орой болов. Амралтын энэ өдөр шувтрах үес манай арлын хэдэн зуун мянган хүний нэгэн адил бид орондоо орох цагийг хүлээсээр сандал дээрээ тэсгэлгүй унтаж орхисон байлаа.

Даваа гаригийг бусад улс хэрхэн өнгөрөөснийг бүү мэд. Миний хувьд дориухан цохилт өгсөн юм. Намайг Ёолландынхнаас нэг юм дуулна гэж эрүүлчийн хэлсэн анхны таамаглал үнэхээр биелсэн билээ.

Пенилоп, ахайтны шивэгчин хоёрыг ачаа бараатай нь галт тэрэгний буудал дээр хүргэж Лондон руу явуулчихаад цэцэрлэгээр сэлгүүцэн алхаж байтал нэрээр минь дуудлаа. Эргэж харвал, загасчны охин хазгар Люситай улаан халз тулгарав. Хазгар, эцэнхий (эцэнхий байх нь эмэгтэй хүний хувьд их муухай согог гэж би үздэг юм) болохоос биш эрчүүдийн нүдэнд аятайхан харагдах олон шинж энэ бүсгүйд байлаа. Ухаалаг бор царай, цээлхэн хоолой, сайхан хүрэн үстэй. Тулсан алмуур золгүй хувь заяаг нь илтгэнэ. Түүний түргэн уур нь энэ бүх дутагдлы нь гүйцээгээд өгнө.

За хонгор минь, юу гээ вэ? Гэсэнд,

-Фрэнклин Блэйк гэгч хүн хаана байна вэ? Хэмээн алмуураа тулан, намайг зэвүүнээр ширтэн асуув.

-Эрхмүүдийн тухай ингэж ярих нь зохисгүй хэрэг. Хэрэв манай ахайтны зээ хүүг асууж байгаа бол мистер Фрэнклин Блэйк гэж гуйлаарай хэмээн хариуд нь санууллаа.

Люси хазганан ойртоод амьдаар минь залгих гэсэн мэт цоргитл ширтэн,

-Мистер Фрэнклин Блэйк гэнэ үү? Гэж давтан хэлээд –Алуурчин Фрэнклин Блэйк гэвэл таарна! Гэв.

Талийгаач Бэттереж авгайтай харьцаж байсан туршлага маань энэ удаа надад тус болсон юм. Эмэгтэй хүн таныг уурлуулах гэж оролдвол та буцаагаад уурлуулж бай. Эмэгтэйчүүд ер нь үүнээс бусад бүхий л эсэргүүцлийг няцаахад бэлэн байдаг юм. Ганцхан үг л зуун үгнээс жинтэй тусдаг агаад хазгар Люсид нэг үг хэлэхэд л хэрэг бүтсэн билээ. Би Люсигийн өөдөөс тааламтай хараад,

-Үгүй ер! Гэлээ.

Бүсгүй ч дүрсхийн уурлав. Эрүүл хөл дээрээ бат зогсоод алмуураараа газар гурвантаа дэвсэж,

-Тэр чинь алуурчин! Алуурчин! Розанна Спирмаэн тэрнээс л болж нас барсан шүү дээ! Хэмээн байдаг хоолойгоороо чарлалаа.

Цэцэрлэгт биднээс холгүй ажиллаж байсан ганц, хоёр хүн өндийн хазгар Люсийн хашгирсныг хараад яаж ч авирлаж чадах хүн гэдгийг мэдцгээх тул ажлаа үргэлжлүүлэв.

-Розанаа Спирман түүнээс болж нас барсан ий? Люси, энэ чинь юу гэсэн үг вэ?

-Танд ямар хамаатай юм бэ? Ер нь эрчүүлд ямар хамаа байна? Ай зайлуул, эр хүний талаар надтай нэг бодолтой байсан бол өдийд амьд мэнд явж байхсан!

-Хөөрхий амьтан, надад дандаа сайн байдагсан. Би ч тус болох гэж хэрдээ л чармайдаг байлаа, хэмээн би Люсийг аль болохоор тайвшруулах санаатай хэллээ.

Үнэнийг хэлэхэд би хэгжүүн хариу өгч тэр охиныг дахиад уурлуулах зүрх хүрээгүй юм. Урьд би түүний муухай занг л ажиглажээ. Одоо бол золгүй бүсгүй гэдгийг ойлгов. Золгүй хувь заяа, эгэл хүмүүсийг шазруун догшин болгодог ажээ. Хазгар Люси миний үгэнд уярч, толгойгоо гудайлган,

-Би Розаннаг өрөвдөж хайрладаг байсан юм хэмээн аяархан өгүүлдээ –Бэттереж гуай, хөөрхий талийгаач даанч золгүй амьдрал туулжээ. Муу хүмүүс уруу татсан боловч төрөлхийн уян сэтгэлийг нь эвдэж чадаагүй юм. Ёстой л бурхан шиг сэтгэлтэй хүн байлаа. Надтай хамт жаргаж болох л байсан. Лондонд хамт очоод эгч дүү хоёр шиг сууж, юм оёж шидээд амь зууя гэж би төлөвлөж байсан юм. Гэтэл энэ хүн ирж, хамаг юм баллачихлаа. Тэр эр Розаннаг илбэдэж орхижээ. Тэр хүн зориуд тэгээгүй, мэдээ ч үгүй байсан гэж надад хэлэх хэрэггүй. Мэдсэн л байх ёстой. Талийгаачийг өрөвдөх ёстой байсан. “Би түүнгүйгээр амьд явж чадахгүй, гэтэл Люси минь, ай хаархий, тэр хүн намайг нүднийхээ булангаар ч хараагүй юм даа” гэж билээ. Хэрцгий, нүнжиггүй амьтан. “Эр хүний хойноос ингэж тарчлах хэрэг ер байхгүй” гэж би хэлсэнд, “Люси минь өмнөөс нь амиа өгчихөж болох эр хүн бйадаг юм шүү” гэсэн юм. Би нэлээд мөнгө хадгалсан, эцэг эхтэйгээ яриад тохирчихсон байв. Энд эдэлж шаналж байсан зовлонгоос нь холдуулъя гэж би бодсон юм. Лондонд нэг жижиг өрөө хөлсөлж аваад эгч дүү хоёр шиг суух байсан юм. Розанна овоо боловсролтой, сүрхий сайн бичдэгийг та мэднэ. Оёхдоо ч чадмаг байлаа. Би ч бас дориун боловсролтой сайн бичдэг. Оёхдоо Розаннагаас маруухан боловч сурчих л байсан. Бид хоёр товхийтэл амь зууж чадах байлаа. Ай-яа! Гэтэл өнөө өглөө юу болох нь энэ вэ? Юу болох нь энэ вэ? Өглөө би захиагий нь авч, амиа бүрэлгэсэн болохыг нь мэдлээ. Надтай үүрд хагацан салсан үгтэй захиа нь өглөө ирсэн. Тэр залуу хаана байна? Гэж толгойгоо өндийлгөн, нулимсаа залгин дахин хилэгнэн хашгираад, -Би заавал хүндэтгэлтэй ярих ёстой тэр эрхэм хаа байна? Бэттереж гуай, ядуучууд баячууды өөдөөс тэмцэн

босох өдөр холгүй шүү. Тэр хүнээс л эхэлж тооцоо бодоосой гэж бурхан тэнгэрээс мөргөн гуйж байна. Түүнээс л эхлээсэй билээ, бурхан минь гэв.

Энэ үед нь Люсийг санваартан ч (хэдийгээр энэ үг дэндүү ахадсан ч гэлээ) ятгаж ухуулаад сэнхрүүлж чадахгүй буй заа. Авууштай юм сонсож юу магад гэж горьдон уур хилэнг нь оргилуулсан зүйлд эргэн орж зүрхэлснээр хязгаарласан юм.

-Мистер Фрэнклин Блэйкээр яах гэсэн юм бэ?

-Уулзах гэсэн юм

-Чухал хэрэг байгаа юм уу?

-Нэг захиа өгнө.

-Розанаа Спирманы захиа юу?

-Тийм.

-Танд бичсэн захиан дотроо хийж үү?

-Тийм.

Харанхуй манан сарниж эхлэв үү дээ? Тайлах санаатай үхэн хатан хөөцөлдөж байсан нууц хар аяндаа тайлагдаж байгаа юм биш үү? Харзнах хэрэгтэй. Эрүүлч Кафф надад өвчнөө халдаагаад явжээ. Миний мэдэх болсон шинж тэмдгээр надад дахиад мөрдөж сурвалжлах дон шүглэж эхлэхийг би гадарлав.

-Мистер Фрэнклинтэй уулзахаас өнгөрсөн гэж би хэлэв.

-Би түүнтэй нүүрээрээ уулзах хэрэгтэй, уулзаан чиг!

-Өчигдөр Лондон явсан.

Хазгар Люси намайг сонжин няхуур гэгч хараад үнэн хэлсэн гэдгийг ойлгожээ. Нэг ч үг дуугарсангүй огцом эргэж Коббс Хол руу алхав.

-Хүүш, хүлээж бай! Маргааш мистер Фрэнклин Блэйкийн тухай сураг сонсоно. Надад захиагаа өгчих, би шуудангаар явуулчихъя.

Хазгар Люси алмуураа тулан эргэж хараад,

-Би гарт нь л өгөх ёстой гэв.

-Би таны хэлснийг түүнд бичих үү?

-Би түүнийг жигшиж байна гээрэй. Тэгээд бүх үнэнийг бичээрэй.

-Тэгье, тэгье. Тэгээд захианы тухай юу гэхэв?

-Хэрэв захиаг авъя гэж хүсвэл энд ирээд миний гараас аваг.

Тийн өгүүлээд Коббс Холл орох замаар хазганан одлоо. Мөрдөн сурвалжлах хэнээ тусаад намба төрхөө ч алдаж, хойноос нь даган үг өдөх санаатйа оролдоод юу ч бүтсэнгүй. Заяа нь хаяахд би эр хүн бйаж, хазгар Люси миний урам хугарсныг хараад тавлан баярлана. Оройхон тийшээ би эхтэй нь уулзаж, азаа сорилоо. Сайхан сэтгэлт Ёолланд авгай дэмий л уйлж унжин, голланд дарснаас балгаж, жаахан тайвшир гэж зөвлөж байлаа. Загасчин эр эрэг дээр байхад нь би олж очлоо. "Их л будлиантай хэрэг шүү" гэж хэлээд тор сэлбэх ажлаа үргэлжлүүлэв. Люсийн эцэг, эх нь надаас илүү мэдсэн юмгүй ажээ. Өглөөний шуудангаар Фрэнклин Блэйкэд захиа явуулахаас өөр зам үлдсэнгүй.

Мягмар гаригийн өглөө миний бие шуудан хүргэгчийг тэсэж ядан хэчнээн хүлээж байсныг уншигч та төсөөлөөд үз л дээ. Надад хоёр захиа авчирч өглөө. Нэг нь Пенилогоос ирснийг овоо тэвчээр гарган уншваас, Вериндер ахай, мисс Речел хоёр Лондонд мэнд хүрч төвхнөцгөөсөн гэж мэдэгджээ. Нөгөө нь Жеффкогийн захиа агаад эзнийх нь хүү аль хэдийн Англиас мордсон гэнэ.

Нийслэлд хүрээд мистер Фрэнклин эцгийн дээ шууд очсон бололтой. Гэвч тун зохисгүй цаг таарчээ. Эцэг нь Парламентын доод танхимын ажилд ухаангүй улайрч, тэр үдэш "хувийн тооцоо" гэгч бичиг зохиох зугаатай тоглоомдоо бүрэн автсан байжээ. Жеффко, мистер Фрэнклинийг эцгийнх нь ажлын өрөөнд дагуулан орсон байна.

"Хонгор Фрэнклин минь! Яагаад ингэж гэнэт ирээ вэ? Элдэв муу юм болоогүй биз?"

"Тэглээ Речелд гай тохиолдлоо. Миний сэтгэл хачин их зовж байна".

"Харамсалтай юм болж дээ. Гэвч одоо надад чамтай ярилцах чөлөө алга, чадашгүй".

"Хэзээ чадах вэ?"

"Хонгор хүү минь! Би чамайг хуураад яахав. Энэ ажлыг дуусахаас нааш үнэндээ зав гарахгүй. Сайхан нойрсоорой".

"Баярлалаа эрхэм ээ. Сайхан нойрсоорой".

Мистер Блэйкийн ажлын өрөөнд иймэрхүү яриа болсныг Жеффко надад бичсэн байв. Өрөөнөөс гарсан хойно бүр ч товчхон яриа болсон аж.

"Жеффко, эх газар руу явах хөлөг онгоцны зогсоолд хүрэх галт тэрэг маргааш өглөө хэдэн цагт хөдлөхийг мэдэх үү?"

"Зургаа дөчид хөдөлнө"

"Намайг таван цагт сэрээгээрэй"

“Эцэгт тань хэлэх үү, эрхэм ээ?”

“Тэгээрэй, ажлаа дуусахаар нь хэлээрэй”

Маргааш өглөө нь мистер Фрэнклин хилийн чанадад оджээ. Чухам аль газрыг зорьсныг хэн ч (тэр өөрөө ч гэсэн) үл тааварлана. Европ, Ази, Африк, эсвэл Америкаас ч юмуу чимээ дуулж болох л юм. Дэлхийн бөмбөрцгийн дөрвөн тивийн хаана ч хамаагүй оччихсон байж чадах л хүн гэж Жеффко бодож байлаа.

Эл явдал, хазгар Люси, мистер Фрэнклин хоёрыг уулзуулах бүхий л бололцоог хааж, тэгснээрээ миний мөрдөн илрүүлэх замд саад болов. Харин талийгаач бүсгүй бүтэлгүй хайрын улмаас амиа бүрэлгэсэн гэсэн Пенилопын таамаглалыг нотолсноос цаашгүй. Амьд ахуйдаа Розанна гэм буруугаа наминчлах гэж завдсан мэтээр Фрэнклин ярьсан бөгөөд тэр тухайгаа Фрэнклинд үлдээсэн захиандаа бичсэн эсэхийг хэлэх аргагүй юм. Хэрээсээ хэтэрсэн хүнд сэтгэлээ өгсөн золгүй дурлалаасаа өөр юу ч бичээгүй, хагацлын хэдэн үг л байгаа биз. Эсвэл Саран чулуу, алга болсон цагаас Нуранги элсэнд амиа бүрэлгэх хүртэл нь түрүүч Кафф талийгаачийг сэрдэн сэжиглэж байсан тэр жигтэй явдлын бүхий л үнэн учрыг өгүүлсэн буй заа. Миний хувьд ч, төрүүлсэн эцэг эх нь болон бүсгүйн таньж мэдэх хүн бүхний хувьд тэр захиад битүүмжилсэн хэвээр хоцорчээ. Талийгаач бүсгүй Люсид сэтгэлээ нээж илчилсэн байх гэж бодоод тэр тухай үг олж сонсох санаатай бүгдээрээ оролдсон боловч цөм хоосон хоцорсон билээ. Розаннаг очир алмаз хулгайлаад нуусан гэдэгт одоо хэр нь итгэсээр буй зарц нар бүсгүйн осолдсон хадан цохио хавьд үе үе ганц нэгээрээ очиж юм эрж хайн дэмий л эргэлдэцгээх бөлгөө.

Өдөр, шөнө ээлжлэн солигдсоор, зуныг үдэж намартай золгов. Нуранги элс, Розаннагийн цогцсыг залгиад нууцыг нь бас чандлан хадгалсаар ажээ.

Мистер Фрэнклин ням гаригийн өглөө Англиас мордсон, Вериндер ахай мисс Рэчел даваа гаригийн үдэш Лондонд хүрэлцэн очсон тухай мэдээ надад мягмар гаригийн шуудангаар ирснийг та мэдсэн билээ. Лхагва гариг шинэ сонин юмгүй өнгөрч, Пенилопоос пүрэв гаригт дахиад мэдээ ирлээ. Охин маань захиандаа иймэрхүү юм бичжээ. Лондонгийн цуутай нэгэн докторыг залж, залуу авхайг үзүүлсэнд авхайн сэтгэлийг сэргээх хэрэгтэй хэмээн зөвлөөд алтан зоос хөлсөнд нь авчээ. Цэцгийн үзэсгэлэн, дуурь, үдэшлэг зэргийн элдэв янзын зугаа цэнгэл учир тоймгүй агаад мисс Рэчел энэ бүгдэд ихэд шимтэн дурласан нь эхийг нь үлэмж гайхуулжээ. Мистер Годфри тэднийд айлчлан очсон гэнэ. Төрсөн өдрөөр нь азаа сориод бүтэлгүйтсэнээ ч хайхралгүй, үеэл дүүдээ сэтгэлтэй хэвээр байгаа нь илэрхий гэнэ. Энэ удаа дмисс Рэчел түүнтэй тун элэгсэг уулзахыг хараад Пенилопын урам хачин их хугарчээ. Годфри эмэгтэйчүүдийн тэтгэмжийн хорооны гишүүдийн тоонд мисс Рэчелийг оруулжээ. Манай ахайтны сэтгэл үймэрч зовнисон янзтай байгаа, хуульчтайгаа хоёр ч удаа удаанаар ярилцсан гэнэ. Мисс Рэчелийн төрсөн өдрийн зоогон дээр Годфри ноёны хажууд сууж байсан шампан дарс танихдаа гоц, тэдний садангийн бэл хөрөнгөөр даржин мисс Клак гэгчийн тухай би дээр цухас дурдсан билээ. Тэр бүсгүйн талаар Пенилуоп аар саар юм бичжээ. Түүний өдий хүртэл ирэхгүй байгаа нь Пенилопт хачирхалтай санагдсан байна. Мисс Клак бие биеэ үгээр буюу бичгээр дайрч, егөөдөж байгааг бүсгүй хүний зангаар манай ахайтанд мөд наалдах буй заа. Нэг шалтгааны улмаас үүнийг дурсахгүй өнгөрч болоогүй юм. Та надаас салаад мисс Клактай уулзах болно гэж дуулсан юм байна. Тэгвэл мөхөс миний тухай Клакийн хэлсэн нэг ч үгэнд үнэмшихгүй байж буян болоорой гэж гуйх сан.

Баасан гаригт нэг нохой маань чихнийхээ ард уруулсныг эс тооцвол элдэв юм тохиолдсонгүй. Нохойдоо өвсний ханд уулгаад, юу боловч махгүй хоол идүүлэв. Энэ тухай өгүүлснийг уучилна уу, санаандгүй дурдчихлаа. Орхиод уншина уу. Таны орчин үеийн сонирхолд харш юм нуршихыг даруйхан цэглэхийн ялдамд нохой гэгч гайхамшигтай амьтан сул сайн эмчлэх нь үнэхээр зохистой гэдгийг хэлье.

Долоо хоног бямба гаригаар шувтарч, миний өгүүлэх явдал ч мөн бямба гаригт төгсөж байна.

Өглөөний шуудангаар санаанд оромгүй жигтэй мэдээ нийтэлсэн Лондонгийн сонин надад авчирсан юм. Хаяг бичсэн гарын үсгийг хараад би мэл гайхав. Тэр үсгийг миний өврийн дэвтэр дээр мөнгө хүүлэгчийн нэр хаягийг тэмдэглэж өгсөн түрүүч Каффын гарын үсэгтэй харьцуулан үзвэл яг дүйж байлаа.

Дараа нь уг сониныг зэгсэн шуналтайгаар гүйлгэн хараад “Шүүхийн танхимаас” гэсэн тэмдэглэлийг бэхээр дугуйлсныг олж үзэв. Одоо түүнийг уншигч танд толилуулъя. Та миний нэгэн адил уншаад энэхүү мэдээг надад илгээсэн эрүүлч Каффын хичээнгүй зүтгэлийг зүй ёсоор үнэлэх болно.

“Ламбет. Хуралдаан дуусахын өмнөхөн эртний сийлбэр, бар зураг, эрдэнийн чулуу гэх мэтийн нэрд гарсан худалдаачин Септимус Люкер шүүхээс зөвлөгөөн авахаар иржээ. Гурван хэрмэл энэтхэг хүн өдөржин мистер Люкерийн гэрийн ойролцоо байн бйан эргэлдээд сэтгэлий нь зовоожээ. Цагдаа хөөж явуулчихаад байхад дахин дахин ирснээр барахгүй юм гуйх нэрийдлээр байшинд орох гэж

оролдсон байна. Гол хаалганаас зайлуулсанд арын хаалган дээр нь очигдожээ. Мистер Люкер тэдгээр гуйлгачны төвөг удсанд гомдол мэдүүлэхийн хамт тэднийг хулгай дээрэм хийх санаа агуулсан байж болзошгүй хэмээн сэжиглэж буйгаа хэлжээ. Цуглуулгад нь эртний болон дорно дахины үнэ цэнэтэй зүйлс болон бий. Яг урьд өдөр нь зааны ясаар юм урладаг нэгэн сийлбэрчнийг (энэтхэг гарлын хүн бололтой) хулгай хийхээр завдсан гэж сэрдэн ажлаас нь халсан бөгөөд тэр сийлбэрчин, нөгөө гурван хэрмэл илбэчинтэй холбоо сүлбээтэй гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Олон хүн цуглуулж, гудамжинд дэгсдэн хөл үймээнийг далимдуулан байшинд орох зорилготой байсан биз. Гэхдээ хулгай хийхээр зэхэж байсныг нь нотолж чадахгүй харин тэр гурван энэтхэг амар заяаг нь үзүүлэхгүй залхааж байна гэж л гомдол мэдүүлэх байна хэмээн үнэнээ хэлжээ. Дахиад ийм явдал гарвал гомдол эрэгч этгээд, тэр энэтхэгүүдийг шүүхэд дуудуулж, хуулийн дагуу ярилцаж болох юм гэж шүүгч зөвлөсөн байна. Үнэт эдлэлийнх нь талаар гэвэл мистер Люкер өөрөө түүнийгээ хамгаалах зохистой арга хэмжээ авах хэрэгтэй юм. Ямар болов энэ тухай цагдаагийн газар мэдэгдэж, холбоо тогтоогоод, цагдаагийн түшмэдийн туршлагад түшиглэн сэрэмжлэх арга хэмжээ авбал зохих ч байж магадгүй юм. Мистер Люкер шүүгчид талархаад гарч явжээ”.

Эрт цагт нэг мэргэн хүн дотныхоо хүмүүст (чухам ямар учраас гэдгийг би мартжээ) “юмны эцсийг хар” гэж сургасан байдаг. Сүүлчийн энэ хуудсыг хараад хэдхэн хоногийн өмнө эл өгүүллийг бичиж дөнгөх болов уу хэмээн гайхаш тасран байснаа санах. Тэгтэл харин ч хэрэг явдлыг тод томруун дүрслэн гаргаж чадаад тун эвтэйхэн төгсгөсөн байна. Саран чулууны энэ хэрэгт бид алхам тутамдаа гайхам зүйлтэй тугарсаар эцэст нь гайхамшгийн оргилд тулав. Тухайлж хэлбэл, түрүүч Каффын зөгнөн өгүүлсэн гурван зүйл долоо хоног ч өнгөрөөгүй байтал биелжээ.

Даваа гаригт Ёолландынхнаас юм сонссон бол одоо гурван энэтхэг, мөнгө хүүлэгчийн тухай Лондонгоос сураг сонслоо. Мисс Рэчел бас Лондонд байгаа гэдгийг санагтун. Байдал улам дордсоноор үл барам миний итэгж явсан үзлийг маань хүртэл эвгүй байдалд оруулсныг та харж байна. Хэрэв та энэ нөхцөлд намайг огоорон, түрүүч Каффтай нэгсэж байгаа бол мисс Рэчел, Люкер хоёр хуйвалдаж амжаад өдийд Саран чулууг мөнгө хүүлэгчид барьцаанд өгсөн байж таарна гэдгээс өөр оновчтой тайлбар үгүй гэж үзэж йгаа бол, хилс дүгнэлээ гэж таныг зэмлэж би чадахгүй. Нэгэнт би пад харанхуйд таныг дагуулж энд хүрлээ. Доор мэхийн ёслоод таны гмөн л харанхуйд орхихоос өөр аргагүй болов.

Яагаад тэр вэ? Гэж асуух нь лавтай. Өөрөө хамаг учрыг мэдчихсэн атал өдий удтал хамт дагуулан явсан хүнээ юунд орхив? Үүнд өгөх цорын ганц хариу бол, миний бие шударга ёсыг сахихын үүднээс тийнхүү үйлдсэн билээ. Тэр үед мэдээж байснаасаа хальж, илүү үг бичих эрх надад бйахгүй. Бүр тодорхой хэлбэл, би зөвхөн өөрт холбогдол бүхий явдлыг хүүрнэх ёстой бөгөөд дбусад хүний надад өгүүлсэн зүйлийг танд дамжуулалгүй, та тэр хүмүүсээс шууд сонсох ёстой улайтай шалтгаан байгаа юм.

Энэхүү Саран чулууны хэргийг зүгээр нэг илтгэсэн журмаар бус, гэрчийн баримт маягаар бичихээр төлөвлөсөн билээ. Тавин жилийн хойно эдгээр хуудсыг уншиж үзэх эдний үр садыг би дотроо дүрсэлнэм. Тэнгэр минь, энэ тухай юуг ч дам сургаар дуулсан бус, бүхий л талаар байраа эзэлсэн шүүгч мэт хандана гэдгийг мэдрэх тэдэнд хэчнээн таатай байх бол доо.

Та бид удтал хамт явахдаа санаа нийлэн нөхөрсөг явсан гэж би анйдах агаад одоо салах цаг ирлээ. Энэтхэгийн очир алмаз адармаатай бэрх мөр үлдээсээр Лондон хүрсэн ба та намайг хөдөөгийн байранд үлдээгээд алмазын хойноос Лондонд очих болно. Миний өгүүлэлд эндэж осолдсон зүйл байвал уучина уу. Би өөрийнхөө тухай дэндүү олныг өгүүлж, тантай хэтэрхий илэн далангуй байв уу даа. Би таныг гомдоохыг хүсэхгүй байна. Үдийн хоолоо идчихээд хатагтайн шар айрагнаас сэнжтэй аягаар дүүрэгж, таны эрүүл мэнд, сайн сайхны төлөө ууя. Миний өгүүлийн хуудаснаас та, Робинзон Крузо зэлүүд арал дээр аж төрөх үедээ “сэтгэлээ тайтгаруулахын тулд өр, авлага жагсаах мэтээр нөхцөл байдлын сайн, муу талыг харьцуулж цувуулсан бичиг” шиг шинэ зүйлийг олж харч ч болох юм.

Баяртай.

## I бүлэг

Миний бие, одоо хоёул тэнгэрт хальсан эцэг эхийн буянаар хар багаасаа цэгц журамтай, нягт нямбай занд сурсан билээ.

Аль эрт улиран өнгөрсөн тэрхүү аз жаргалтай үед би үс гэзгээ ямагт сэмбийтэл самнаж, унтахаар хэвтэхийн өмнө хувцас хунараа тайлаад нэг бүрчлэн сандал дээр, орны хөлд гээд нэг л байранд нь тваьж заншсан юм. Хувцас хунараа эвхэж тавихын өмнө тэр өдрийн явдлыг жижиг

дэвтэртээ заавал тэмдэглэнэ. Хувцас хунараа эвхэж тавьсны дараа оройн мөргөл (орондоо ороод бас давтдаг) заавал уншина. Миний бие орой мөргөл уншихаад хүүхэд ахуйн тааламжтай нойронд умбана.

Харин сүүлийн үед, ай халаг! Оройн мөргөлийн дараа элдэв гунигтай, гашуун бодол төрж, тааламжтай нойрсохын оронд хар даран зүүдэлж, тух алдан эргэж хөрвөөх боллоо. Гэвч би бусад зуршлаа хаясангүй. Хувцас хунараа нямбайлан эвхэж тавихдаа, аав маань дампуурч сүйрэхээс өмнөх үеийн цэнгээнт бага насаа дурсдаг юм. Тэмдэглэл хөтлөх явдал хүн төрөлхтний эцэг Адамаас бид бүхэнд удамшиж ирсэн нүгэлт жам ёсыг журамлахад минь нэг даруухан хэрэгцээнд огт санаанд оромгүй байдлаар чухал тус хүргэсэн билээ. Тэмдэглэлийнхээ ачаар ядуу даржин миний бие нагац ахын маань хүргэн орсон айлын нэгэн баян чинээрэг гишүүнд учирсан адармаатай явдалд оролцох болсон юм. Мистер Фрэнклин Блэйкт тийнхүү хэрэг болсондоо би зэгсэн баяртай байна.

Тусдаа амьдралаа зохиож гарсан энэхүү төрөл садангуудтайгаа би нэг хэсэг холбоо тасарсан байлаа. Ганцаардаж, ядарч яваа цагт биднийг мартах нь цөөнгүй билээ. Одоо би, бэл хөрөнгөнийхөө чинээг харж, протестанд шашны санваартан, зах зээл нь хямд төсөр бараатай хоёр давуу тал бүхий Бретоны нэг бяцхан хотноо эрхэмсэг англи нөхдийнхөө дунд сууж байна.

Гэтэл энэ бөглүү газар надад Англиас нэг захиа ирдэг юм байна. Өчүүхэн намайг мистер Фрэнклин Блэйк гэнэт санасан нь тэр. Миний баян хамаатан (мөн уужим сэтгэлтэй гэж нэмж хэлмээр байна!) надаас нэг зүйл гуйх гэснээ нууж хаасан ч үгүй. Нөгөө Саран чулууны будлиантай хэргийг сөхөх солиотой санаа сэдсэн аж. Тэгээд Лондонд Вериндер нагацынд айлчлах үеэр үзэж харснаа бичиж тус болооч гээд баячуудын хайнга зангаар мөнгөн шагнал амласан байв. Цагийн аяст дөнгөж аньж эхэлсэн сэтгэлийн шархаа сэдрээж, гаслан зовлонт үеэ эргэн дурсах ёстой болсон ба нэг зовлон нэмэрлэв. Би уян сэтгэлтэй хүн. Христос шашинтны эвлэрэнгүй чанарт харш дэмий бардам сэхүүн зантайгаа удтал тэмцэлдсэний эцэст биеэ ялж, мөнгөний чек авахыг зөвшөөрсөн билээ.

Өдрийн тэмдэглэл хөтлөдөггүйсэн бол би тэр мөнгөний хариуд мадаггүй юм бичиж өгч чадах байсан болов уу даа. Гэвч Блэйк ноёны гомдоосныг бүрэн уучилсан ядуу хөдөлмөрч бүсгүй миний бие тэмдэглэлээ ашиглан төлсөн хөлсөндөө харамсахааргүй юм хийнэ. Эрхэмсэг Вериндер бэргэнийдээ айлчилж байх үеэр тэнд болсон нэг ч явдал миний хараанаас мултарсангүй. Багаасаа тэмдэглэл хөтөлж зуршсаны ачаар бүгдиг өдөр бүр гээлгүй бичсэн агаад одоо нарийн ширийн зүйлийг ч энд тодорхой өгүүлэх болно. Миний хувьд, үнэн мөнийг нандигнан эрхэмлэх нь (Тэнгэрийн аврал!) хүмүүсийг хүндэтгэхээс чухаг билээ. Голлон анхаарууштай нэгэн хүний талаар зохисгүй мэт санагдсан хэсгийг мистер Блэйк хялбар хасаж чадах юм. Тэр миний цагийг худалдан авсан гэж хэчнээн өгөөмөр загналаа ч гэсэн би сэтгэлээ худалдахгүй хүн шүү!1

Тэмдэглэлээ сөхвөл 1848 оны долдугаар сарын гуравны даваа гаригт миний бие Монтегю талбайд байдаг Вериндер бэргэний байшингийн хажуугаар санаандгүй гарч яваад цонхны нь хаалт нээлттэй, хөшгиг нь татаастай байхыг харж, эелдэг зангийн үүднээс тэднийхээр орж амар мэндийг нь эрье гэж шийджээ. Бэргэн эгч охиынхоо (үеэл дүү гэж би үнэндээ хэлж чадашгүй!) хамт хөдөөнөөс ирээд долоо хонож байна Лондонд дахин хэд хонох санаатай гэж үүд тайлсан бүсгүй мэдэгдэв. Тэр бол манай бэргэнийх олон жил, даанч олон жил хүлцэн тэвчиж байгаа Бэттереж гэгч нүнжиггүй өвгөний охин аж. Би хариу хүлээн, үүдний өрөөнд суунгаа үргэлж цүнхэндээ авч явдаг шашны номыг гаргав. Гоёж гоодохын нүгэл хилэнцийн тухай сэдвээр залуу бүсгүйчүүлд зориулан бичсэн бүхэл бүтэн цуврал товхимлын нэг юм. Үнэхээр сүсэг дүүрэн тун ч энгийн найруулж бичсэн, “Таны малгай дээрх бүчийн тухай цөөн үг” гэсэн гарчигтай билээ. үүдний өрөө нь балиар, сандал нь хатуу байсан авч мууг сайнаар хариулж буйгаа тааламжтайяа ухамсарлаж, энэ мэтийн аар саар өчүүхэн юмыг тоомсорлоогүй юм.

-Хатагтай таны ирсэнд их баярлаж, маргааш хоёр цагт үдийн цайн дээр урьж байна.

Тэр шивэгчин энэ үгийг ямаршуу өнгө аястайгаар, хэчнээн муухай эрээ цээргүй ширтэн байж уламжилсныг дэлгэрэнгүй өгүүлэхээ больё.

1 Фрэнклин Блейкийн нэмэлт: “мисс Клак огт санаа зоволтгүй. Түүний болон бусад хүний гар бичмэлийг үзэхдээ би юу ч нэмж хасаагүй, юу ч өөрчлөөгүй. Зохиогчдын хэн нь ч ямар ч санаа бодол илэрхийлэх гэсэн байг, тэмдэглэсэн зүйл нь онцлогтой буюу одоо миний цуглуулан буй хүүрнэлүүдийг найрлагын хувьд гаж болгож мэдэх боловч миний бие эхнээс нь аваад эцсийг нь хүртэл ганц ч мөрийг нь дур мэдэн өөрчлөхгүй. Тэдгээр хүүрнэлийг надад жинхэнэ баримттай юм гэж илгээсэн агаад би ч жинхэнэ ёсоор нь, гэрчийн этгээдүүд нотлох батлах үнэн чигээр нь хадгалах болно. Ганц зүйлийг нэмж хэлэхэд, мисс Клакийн хүүрнэлд дурдсан “голлон анхаарууштай” хүн нь мисс Клакийн хурц үзэгний хамгийн гашуун шүүмжлэлийг зоригтой угтаж чадах төдийгүй түүнийг нь мисс Клакийн зан авирыг илрүүлэх мэтгэшгүй зэвсэг мөн хэмээн хүлээн зөвшөөрөх зэгсэн азтай хүн юм.

Тэр нүгэлт бүсгүй талархаад, христос мөргөлтний элэгсэг сэтгэлээр,

-Та энэ товхимлыг авч болгооно уу? Гэж хэллээ.

Тэгтэл нэрийг нь харснаа,

-Авхайтан, энэ номыг эмэгтэй хүн бичсэн юмуу, эрэгтэй хүн бичсэн юмуу? Эмэгтэй хүн бичсэн бол надад үнэндээ унших хэрэгцээ алга. Харин эр хүн бичсэн бол, эмэгтэйчүүдийн малгайны талаар ямар ч төсөөлөлгүй шүү дээ гэдгийг зохиогчид нь уламжилан уу гээд надад товхимлыг эргүүлэн өгч, үүдээ нээв.

Бид сайн сайхны үрийг явсан газраа, чадах хэрээрээ тарих ёстой билээ. Гэвч үүд хаагдахы нь хүлээж байгаад нөгөө номоо шуудангийн хайрцагт хийчихэв. Бас нэг товхимол үүдний цэцэрлэгийн торон хашааны завсраар шургуулсны эцэст ойр дотнын хүмүүсийнхээ сэтгэл санааны төлөө зовох маань багасаж, дотор баахан онгойлоо.

Өнөө орой "Насанд хүрэгчдийн хувцсаар хүүхдийн хувцас хийх эхчүүдийн нийгэмлэгийн" сонгуульт хорооны хуралтай байв. Энэхүү гайхамшигт тэтгэмжийн газрын зорилго бол (аливаа төлөв төвшин хүн ойлгох нь дамжиггүй) хилэнцэт эцэг өмдөө барьцааны газраас эргүүлж авахаас нь урьтаж аваад гэмгүй үрд нь таарах өмд даруйхан оёж өгөхөд оршино. Тэр үед би энэ сонгуульт хорооны гишүүн байсан агаад эл нийгэмлэгийг дурдсаны учир гэвэл, миний хосгүй, бишрэм анд мистер Годфри Эблвайт манай ажилд ёс суртахууны болон эд мөнгөний талаар тусалж, дэмждэг байсан юм. Өгүүлж буй даваа гаригийг үдэш хороон дээр мистер Годфритэй уулзахдаа эрхэмсэг Вериндер бэргэний Лондонд ирснийг дуулгая гэсэн бодолтой байлаа. Хясахад Годфри ноён хороон дээр очсонгүй тул миний сэтгэл ихэд гонсойв. Яагаад үзэгдэхгүй байгаа учрыг лавласанд эгч дүүс маань есөн шидийн өмднөөс хараа салгах сөхөөгүй (тэр орой бид жигтэйхэн их ажилтай байсан юм) сууснаас сонин дуулаагүй хэрэг үү хэмээн гайхацгаав. Юу ч сонсож мэдээгүй үнэнээ хэлсэнд одоо хүүрнэх зүйлийн эхлэл болох явдлыг надад ярьсан билээ. Нийгэмд огт өөр өөр байр суурь эзэлдэг хоёр эрхэм өнгөрсөн Баасан гаригт Лондон даяар донсолгон хэрдхийлгэсэн хачин хэргийн золиос болсны нэг нь Ламбетэд суудаг Септимус Люкер, нөгөө нь мистер Годфри Эблвайт байжээ.

Хүмүүсээс тусгаар сууж байгаа учраас тэр гайхалтай явдлын тухай сонинд нийтэлсэн мэдээг хүүрнэлдээ ашиглах бололцоогүй байна. Түүний зэрэгцээ тэр явдлын тухай урнаар дүрслэн өгүүлэхийг нь мистер Годфри Эблвайтын амнаас сонсох зүйргүй үнэт боломжийг нэгэнт алдсан байлаа. Тэгэхээр тэр нэгэн даваа гаригт сонсож дуулсан баримт сэлтийг л өгүүлэхээс өөр замгүй болов. Бүгдийг нарийн эрэмбэ дараатай ярья. Эдгээр мөрийг ядуу дорой бүсгүй бичиж байна. Ядуу дорой бүсгүйгээс үүнээс илүү юм шаардах хатуу сэтгэлтэн бий гэж үү?

Мянга найман зуун дөчин найман оны зургадугаар сарын гучны баасан гаригт доорх явдал болсон аж (эцэг, эхийнхээ ачаар миний бие ямар ч хуанлийг дагуулахгүй нарийн тэмдэглэл хөтөлдөг билээ)!!!.

Тэрхүү дурсгалт өдрийн өглөөгүүр манай авьяас билэгт мистер Годфри Ломбардын гудамжны банкнаас чекээр бэлэн мөнгө авахаар явжээ. Пүүсийн нэрийг бэх баагаад санаандгүй дарсан байх бөгөөд тэр үгийг гаргах гэж оролдохыг үнэн мөнийг бишрэн эрхэмлэдэг сэтгэл маань хориглож байна. Аз болоход пүүсийн нэр чухал биш, харин мистер Гофдри ажил хэргээ дуусгасны хойно тохиолдсон нэг явдал чухал юм. Нэгэн огт танихгүй эрхэмтэн хаалган дээр таарч, бие биедээ найрсгаар зам тавьжээ. Тэгж байгаад нөгөө хүн мистер Годфрийг түрүүлэн гаргасанд наадах нь талархсан хэдэн үг хэлээд хоёул мөр мөрөө хөөжээ.

Шалихгүй дэмий юм, ямар ч утга холбогдолгүй бичиж байна гэж хөнгөн хийсвэр хүмүүс хэлэх буй заа. Ай, залуу нөхөд минь, нүгэлт ах дүүс минь дорой ухаандаа найдаж, яаран дүгнэхээс сэрэмжлэгтүн! Ёс суртахууны хувьд тогтвортой, няхуур байгтүн! Итгэлээ оймс шигээ, оймсоо итгэл шигээ байлгагтүн. Аль алинд нь өчүүхэн ч толбо хүргэлгүй нандигнаж, гарын доор ямагт бэлхэн байлгаж бай! Мянгантаа уучлал гуйя. Өөрийн эрхгүй ням гаригийн сургуулийн маяг руу орчихлоо. Энэ бол иймэрхүү тайланд хамгийн зохисгүй маяг билээ. Амьдралд арай ойр бичихийг оролдъё. Ихэни тохиолдлын нэгэн адил өгүүлэн буй явдлын үеэр өчүүхэн шалихгүй мэт зүйл аймшигт үр уршиг тарьсан гэдгийг хэлэхийг зөвшөөрнө үү.

Дээр дурдсан ялдам зант үл таних эрхэм бол Ламбетын мистер Люкер байсныг урьдаар тайлбарлаад мистер Годфрийн хойноос Килбурн дахь гэрт нь очицгооё.

Ядуу хувцас хунар өмссөн боловч хөөрхөн нүдэнд дулаан хөвгүүн үүдний танхимд нь түүнийг хүлээж байлаа. Нэгэн үл таних хөгшин хатагтай танд захиа өгүүлсэн, хариуг нь авч ир гэж хэлээгүй хэмээн гэж нөгөө жаал тайлбарлажээ. Өглөгийн нийгэмлэгийн гишүүний хувьд мистер Годфрид иймэрхүү явдал хэвийн үзэгдэл байсан тул хөвгүүнийг явуулаад захидлыг задалбал огт танихгүй бичгийн хэв байжээ. Мистер Годфрийг урьд өмнө нь шагайж ч үзээгүй Нортумберландын гудамжны нэг байшинд цагийн дараа хүрэлцэн очихыг урьсан байв. Хэрэв сонирхсон хэдэн зүйлд нь хангалттай хариу өгч чадвал тэтгэмжийн нийгэмлэгийн өглөгт зориулан дориун хандив оруулах хүсэл бүхий нэг

хогшин хатагтай тийнхүү урьжээ. Өөрийнхөө нэрийг тавиад, Лондонд цөөн хонох тул алдар цуут өглөгийн эзэнтэй тухтай уулзах өөр цаг олдсонгүй гэдгээ нэмж тэмдэглэжээ.

Эгэл хүмүүс бол ажил төрлөө хаяад огт үл таних хүний төлөө явахын өмнө хэдэнтээ эргэж хургах буй заа. Гэтэл жинхэнэ христос мөргөлтөн бол сайн үйл бүтээхэд туслай л гэвэл огтхон ч эргэлзэж түдгэлздэггүй юм. Мистер Годфри тэр даруй гэрээсээ гарч, Нортумберландын гудамжийг зорьжээ. Ялимгүй бүдүүрсэн авч зэгсэн хүндтэй байрын хүн хаалга тайлж, мистер Годфрийн алдрыг сонсмогц хашаа руу харсан цонхтой, хажуугийн нэг эзгүй өрөөнд дагуулан оров. Өрөөн дороод хоёр жигтэй зүйлийг ажигласан байна. Нэгд гэвэл, хүдрийн заар, гаврын үнэр үл мэдэг ханхалж байлаа. Хоёрт гэвэл ширээн дээр нь энэтхэг бичиг, зураг ихтэй дорно дахины эртний судар дэлгээстэй байлаа.

Үүдний өрөөнөөс орж ирдэг хаалттай хаалганы зүг нуруугаа хандуулан зогсоод судар бичгийг сонирхож эхлэв. Өчүүхэн ч чимээ анир гараагүй атал араас нь нэг хүн гэнэт багалзуурдан авчээ. Нүдий нь боож, аманд нь алчуур чихэхээс өмнө нүцгэн бор гарыг л харж амжсан ба төдхөн хүчинд автан (хоёр хүн байх шиг санагдсан гэнэ) шалан дээр арчаагүй гулдайн унажээ. Гэтэл бас нэг этгээд бүх халаасыг нь ухааж төнхөөд, ичгүүр сонжуургүйгээр толгой түрүүгүй (ингэж хэлэхийг зөвшөөрөх биз) нэгжиж тэмтэрчээ. Гагцхүү чин сүсэг бишрэлтэй учраас л мистер Годфри ийм санаанд оромгүй аймшигт явдалд орж хэлмэгдсэнийг бахдан сайшааж хэлэхдээ би ихэд баярлаж байна. Дээр дурдсан балмад халдлагын үед гайхамшигт анд маань ямаршуу янзтай байсныг бүсгүйүүд бид шүүн хэлэлцэх хэрэг юун. Тэр цөөн эгшнийг орхиж, түүний биеийг жигшүүртэйгээр нэгжсэний дараах байдлыг өгүүлэхийг зөвшөөрнө үү. Балмадаар халдахдаа нөгөө гурван шившигт этгээд дуу шуугүй байцгаасан бөгөөд, сүүлдээ мистер Годфрийн үл төсөөлөх нэгэн хэлээр хэдэн үг сольцгоосонд дуунчх нь өнгө аялгаар тэдний урам хугарч найдвар тасарсан болохыг (сонор сонсголонтой тул) ойлгосон байна. Түүнийг гэнэт өргөн сандал дээр суулгаад гар, хөлийг нь янгинатал хүлэжээ. Дараа нь салхи сэвэлзэн хаалга онгойхыг мэдэрч чих тавин чимээ чагнаад өрөөнд ганцаар хоцорсноо мэдэв. Хэсэг хугацаа өнгөрсний хойно эмэгтэй хүний хувцас сэрчигнэх чимээ гарч, шатаар өгсөн ойртсоор гэнэт зогтусах нь сонсдов. Бүсгүй хүний чарлах дуу нам гүмийг эвдэв. Доороос нэг эрэгтэй хүн “Яав аа?” хэмээн дуу алдаж, төдөлгүй шатаар өгсөх хөлийн чимээ дуулджээ. Христос шашинтны гар хүрч, хүлгийг нь тайлан аманд нь чихсэн алчуурыг авлаа. Өмнө нь эрхэмсэг эр, эм хоёр зогсож байхыг хараад учиргүй гайхсандаа мистер Годфри,

-Ямар учиртай юм болов оо? Гэж сулхан дуугарчээ.

Нөгөө үл таних эрхэмсэг хоёр эргэн хараад,

-Бид чухам танаас л ингэж асуух гэсэн юм гэцгээв.

Үүний хариуд учир явдлыг тайлбарласан нь зайлшгүй. Үгүй шүү! Үйл явдлыг яг таг, нарийн ширийн өгүүслүгэй. Хөөрхий мистер Годфрийг тайтгаруулахын тулд давс үнэртүүлж, ус уулгасны дараа ярих тэнхээтэй болсон байна.

Байшингийнхаа нэг, хоёрдугаар давхрыг, үүний урьд өдөр нэг эрхэмсэг байдалтай хүнд буюу мистер Годфрид үүд тайлж өгсөн нөгөө эрд долоо хоногийн хугацаагаар хөлсөлсөн гэдгээ айл саахалтынхаа дунд ихэд нэр хүнд бүхий гэрийн эзэн, эзэгтэй хоёр мэдэгджээ. Тэр эрхэм долоо хоногийн хөлсийг нэмэгдэлтэй нь хамт урьдчилан төлөөд Англид анх удаа ирж буй дорно зүгийн түшмэд, гурван найзыгаа суулгахад тохиромжтой өрөө байна гэсэн юмсанж. Эл балмад гарсан өдрийн өглөө эрт дорно зүгийн түшмэдийн хоёр нь нөгөө англи нөхрийнхөө хамт ирж буусан байна. Гурав дахь нь удахгүй ирэх бололтой, ачаа тээшийг нь (учиргүй том гэнэ) орой тийшээ гаалийн газраас авчрах ёстой гэжээ. Мистер Годфрийн ирэхээс арваад минутын өмнө гурав дахь хүн нь иржээ. Саяхан болтол доод давхарт байсан гэрийн эзэн, эзэгтэй хоёр гаж буруу зүйл юу ч ажигласангүй бөгөөд таван минутын өмнө нөгөө гадаадын гурван хүн, хүндэт англи андтайгаа дөрвүүл гадагш гарч, Страндын зүг тайван одохыг л харсан байв. Гэтэл түрүүхэн нэг хүн ирсэн мөртлөө тэдэнтэй цуг гараагүйг санаад юунд тэр эрхмийг ганцааранг нь дээр орхио вэ хэмээн эзэгтэй баахан хачирхжээ. Нөхөртэйгөө товч зөвлөсний эцэст, элдэв юм болсон биш байгаа гэж очиж үзэхээр шийдэж гэнэ. Тэгээд юу бослныг би дээр нэгэнт дүрслэн үзүүлэхийг оролдсон билээ. Үүгээр гэрийн эзэн, эзэгтэй хоёрын тайлбар төгсөв.

Дараа нь нөгөө өрөөг тун няхуур шалгажээ. Эрхэм Годфрийн хамаг юмыг ийш тийш нь ундуй сундуй хаялжээ. Гэвч юм хумыг нь цуглуулахад бүгд тоо ёсоор бүрэн байв. Цаг, гинж, түрийвч, түлхүүр, амны алчуур, тэмдэглэлийн дэвтэр болон завсар нь байсан цааснуудаа нягтлан бүртгэвэл бүгд байжээ. Түүнчлэн тэр айлын эд хогшлоос сэтэрхий зүү ч авсангүй ажээ. Дорно зүгийн түшмэд эртний судар бичгээ л авснаас биш өөр юунд ч гар хүрсэнгүй.

Энэ бүгд ямар учиртай хэрэг вэ? Энгийнээр тайлбарлавал, мистер Годфри эндрүүрлээр үл таних хүмүүсийн золиос болон хэлмэгдсэн бололтой. Энд нэг бузар хуйвалдаан явагдаж, бидний хайрт, гэм зэмгүй анд мистер Годфри гэмт этгээдүүдийн торонд санаандгүй орчихжээ. Шашны

үүднээс тайлбарлавал, хэдэн зуун буянтай үйл бүтээсэн христосын баатар эр, эндүүрлээр тавьсан занганд орсон нь бид мэтийн улс хэчнээн сэрэмжтэй байвал зохихыг сануулж байна! Бидний муу дур хүсэл биднийг гэнэдүүлэн довтолсон дорно дахины тэр түшмэд шиг хэчнээн түргэн хувирч чадна вэ?

Миний бие ганц энэ сэдвээр хэдэн ч хуудас дуртайяа бичиж чадах авч ай хөөрхий надад үүнийг бус, харин болсон явдлыг өгүүлэхийг даалгасан билээ. Баян садангийн маань ирүүлсэн (тэр цагаас хойш надад лай тарьж буй) мөнгөний чек намайг эл хүүрнэлээ дур зоргоор бичиж хараахан болохгүй гэдгийг сануулна.

Одоо бид мистер Годфрийг Нортумберландын гудамжнаа орхиод, тэр үдэш мистер Люкерт юу тохиолдсоныг үзвэл зохино.

Мистер Люкер банкаас гараад ажил төрөл хөөцөлдөн Лондоноор баахан явж явж харивал саяхан нэг жаалү хөвгүүн авчирлаа гээд нэг захиа өгчээ. Мистер Годфрийн адил бичгийн хэвийг таньсангүй, харин мистер Люкерийн нэг захиалагчийн нэрийг тавьсан байлаа. Түүний бие Лондонд гэнэт дуудагдан ирсэн, одоо Альфредын талбайд Тотенхем-Курт-Роудод буусан ба мистер Люкертэй нэн даруй уулзаж, нэг наймааны талаар ярилцах хүсэлтэй байгааг уг захидалдаа (нарийн бичгийн дарга нь бичсэн бололтой) мэдэгджээ. Тэр эрхэм бол дорно дахины зүсэн бүрийн ховор нандин зүйл цуглуулдаг агаад Ламбетын Люкерийн өглөгч түнш болсоор удсан юмсанж. Ай яа, эд баялгийн өмнө сөхөрдгөө бид хэзээ болих юм бол доо! Мистер Люкер хөлсний тэрэг дуудаж, өглөгч түнш рүүгээ яаран одов. Нортумберландын гудамжнаа мистер Годфрид тохиолдсон шиг яг адилхан явдал Альфредын талбайд мистер Люкерт учирсан байна. Мөн л эрхэмсэг эр үүд нээж, дээд давхарт зочны арын өрөөнд оруулжээ. Нөгөө л зураг чимэглэл бүхий эртний судар ширээн дээр нь байж. Энэтхэгийн урлагийн эл гайхамшигт номыг мистер Годфрийн нэгэн адил учиргүй шимтэн сонирхож эхлэв. Тэгтэл бас л нэг нүцгэн бор гар араас нь багалзуурдан авч, нүдий нь боож аманд нь алчуур чихээд газар унаган, толгой түрүүгүй нэгжжээ. Дараа нь мистер Годфригээс аруй удаан ганцаараа байсан бөгөөд эцэстээ мөн л жаахан сэжиг авсан гэрийн эзэд чухам юу болсныг үзэхээр иржээ. Нортумберланд гудамжны байрны эзэн мистер Годфрид өгсөн тайлбартай эгээ л ижил зүйлийг Альфредын талбайн байрны эзэн мистер Люкерт дуулгасан байна. Байрны эзэд, гадаадын найз нартаа үйлчилж яваа мэтээр биеэ танилцуулсан үл таних эрхэмсэг хүний чихэнд чимэгтэй санал, түнтийсэн хэтэвчинд хууртан маллуулжээ. Түрүүчийн явдлаас ялгаатай байсан ганц зүйл гэвэл мистер Люкерийн халааснаас гаргаж хаялсан зүйлийг цуглуулж, бүртгэсэнд цаг, хэтэвчтэй мөнгө нь хэвээр атал (мистер Годфри шиг азтай эр биш ажээ) нэг цаас алга байлаа. Тэр бол мистер Люкер тэр өдөр банкиндаа нэгэн үлэмж үнэтэй зүйлийг хадгалуулахаар өгсөн баримт байжээ. Гэвч тэрхүү үнэт зүйлийг зөвхөн эзнийх нь гарт буцаан өгөх ёстой тул алдсан баримт хулгайчид ямар ч тус болохгүй аж. Мистер Люкер сэхээ орж, тэнхээ авмагц, хулгайч нар энэ тухай мэдэхгүй тул нөгөө баримтыг нь аваад очсон байж болзошгүй хэмээн банк руу харайлгав. Гэтэл дээрэмид банкинд тэр өдөрч, маргааш нь ч үзэгдсэнгүй. Тэр баримтыг ашиглах гэж оролдохын өмнө эрхэмсэг англи анд нь учрыг ухаарч, цагаа олж сануулсан бололтой хэмээн банкны эзэн таамаглажээ.

Хохирсон хоёр, хоёул цагдаагийн газарт мэдэгдсэн агаад зохих мөрдлөг эрчимтэй явуулсан нь дамжиггүй. Дээрэмчид дутуу дулимаг мэдээллийг үндэслэн үнэт зүйл тонох ажил төлөвлөжээ гэж цагдаагийн газрын эрхтнүүд дүгнэсэн байна. Мистер Люкер үнэт зүйлээ өөрийн биеэр аваачиж өгсөн эсэхийг дээрэмчид үнэндээ мэдхгүй, эргэлзэж байсан бөгөөд хөөрхий эелдэг зант мистер Годфри мистер Люкертэй хэдэн үг санаандгүй сольсон учраас хэлмэгджээ. Нэмж хэлэхэд даваа гаригийн үдэш мистер Годфри цагдаагийн газрын эрхтнүүдийн зөвлөгөөн дээр байлцах ёстой болсон учраас манай хорооны хуралд ирж чадаагүй байна.

Миний бие танд шаардлагатай мэдээллийг нэгэнт өгсөн тул Монтэрю талбайд надад тохиолдсон даруухан явдлыг хүүрнэж болох юм.

Би мягмар гаригийн цайн дээр нь яг цагтаа очлоо. Энэ өдөр харамсмаар ч, баярламаар ч юм олонтой эрэнтэй бараантай өдөр байсан нь миний тэмдэглэлээс харагдана.

Хонгор Вериндер бэргэн маань надтай аанай л эелдэг, ялдам уулзлаа. Гэвч төдий л удалгүй нэг л биш байхыг би ажигласан юм. Охиноо сэтгэл зовсон байртай хэдэн удаа хараад авав. Би Рэчелийг харах бүрдээ эрхэм Жон, Вериндер хатагтай хоёр шиг ийм ховор сайхан эцэг эхэд ийм бүтэлгүй өөдгүй хүүхэд заяах ч гэж дээ хэмээн үргэлж гайхдаг юм. Гэтэл энэ удаа Рэчелийг хараад урам хугарснаар барахгүй бүр балмагдаж орхисон билээ. Ярьж хөөрөх, явж хөдлөхдөө даанч намбагүй. Ааш зангий нь харахаас нүд халтирмаар ажээ. Нэг л цочир ууртай, түргэн зантай, инээхдээ учиргүй чанга тас тас хөхөрч, идэж уухдаа нүгэлтэй цамгаан загнана. Хэрэг явдлыг ний нуугүй өгүүлэхээс өмнө л би хөөрхий эхийг нь тун их өрөвдөж байлаа.

Үдийн хоол дуусахад,

-Рэчел, чамайг хоолны дараа ном уншиж, тайвширч бай гэж доктор зөвлөснийг мартаж болохгүй шүү гэж эх нь хэлэв.

-За, ээж ээ би номын сан руу явлаа. Годфри ирвэл надад хэлүүлээрэй. Нортумберланд гудамжинд болсон адал явдлынх нь тухай тодорхой сонсохсон гэхээс би бүр тэсэж ядаж байна гээд эхийнхээ духыг үнсээд, дараа нь над руу харж,

-Баяртай, Клак хэмээн тоомжиргүй хэлэв.

Тийн хэгжүүрхэнд нь уур зэвүүцэл хүрсэнгүй, зөвхөн төлөө нь залбирья гэж санаандаа тогтоож авав. Бид хоёул үлдсэн хойно, энэтхэгийн алмазын аймшигт түүхийг Вериндер бэргэн нэгд нэгэнгүй ярьсан бөгөөд аз болоход энд давтан өгүүлэх хэрггүй ажээ. Тэр явдлыг тэгсгээд дарж өнгөрөөсөн нь дээр эгж бодож байгаагаа надаас нуусангүй. Гэвч одоо бүх зарц, шивэгчин нь алмаз алга болсныг мэдсэн, зарим нэг зүйлийг сонинд хүртэл нийтэлсэн, түүнчлэн Вериндер ахайн хөдөө гэрт гарсан хэрэг, Нортумберланд гудамж, Альфредын талбайд тохиолдсон явдлын хооронд холбоотой хэмээн хөндлөнгийн улс хэлэлцэж буй үед нууж хаана гэдэг утга учиргүй юм. Харин ч муу нуухаар сайн илчил гэгчээр илэн далангүй байх нь энэ хэрэгт тус болох төдийгүй чухал шаардлагатай болжээ.

Миний оронд ийм юм сонсоод олон хүн мэл гайхаж, цэл хөхрөх буй заа. Би бол мисс Рэчелийн олиггүй аашийг багаас нь үл андах тул охиынхоо талаар бэргэн маань юу ч хэллээ гэхэд гайхахгүй байв. Үүнээс ч долоон дор юм болж, бүр хүн амины хэргээр шувтарсан байлаа гэхэд “Тэгж л таарна даа! Ай, хаархий зайлуул, тэгж л таарна!” гэж өөртөө хэлэх байсан юм. Иймд нөхцөлд мисс Вериндер санваартнаас тусламж эрвэл зохих байсан атал эмчид хандсан явдал л миний гайхшийг төрүүлж билээ! Хөөрхий бэргэн маань бурхан шүтлэггүй эцгийнхээ дэргэд бага насаа өнгөрөөсөн хойно арга ч үгүй биз! Тэгж л таарна! Ай, хөөрхий зайлуул, тэгж л таарна даа!

-Эмч нар, Рэчелийг дандаа хөдөлгөөнтэй, хөгжилтэй байлаж, өнгөрсөн явдлыг аль болох мартагнуулж сатааруулах хэрэгтэй гэж надад хатуу захисан юм гэж Вериндер ахай яриу.

“Өө, яасан бүдүүлэг зөвлөгөөн бэ! Христос мөргөлтний оронд ийм тэрс зөвлөгөөн өгдөг байх ч гэж дээ!” хэмээн би бодож билээ.

Бэргэн маань яриагаа үргэлжлүүлэн, -Би тэр зааврыг чанд баримтлахыг байдгаараа л хичээж байна. Гэтэл Годфрид тун ч олиггүй цагаар хачин явдал тохиолдлоо. Тэр тухай сонсоод л жигтэйхэн догдолж, сандарсан. Годфри Элбвайтад энд иэрэч гэж бичихээс өмнө надад ер амар заяа үзүүлсэнгүй. Бас нэгээ нэг хэлмэгдсэн Люкер ч билүү, хэн билээ... тэр огт танихгүй хүнийг хүртэл сонирхоод байгаа юм гэлээ.

-Бэргэн минь, хорвоогийн явдлыг та надаас сайн мэднэ хэмээн би хүндэтгэн өгүүлээд –гэвч Рэчелийн энэ хачин авирлаад байгаад нэг учир байж таарна! Танаас, ер нь хүн бүрээс нэг нүгэлтэй юм нуугаад байна даа. Саяхны явдлууд тэр нууцыг нь илчлэх аюултай байсан юм биш биз? Гэв.

-Илчлэх ий? Юү гэсэн үг вэ? Мистер Люкер манай зээ хоёроор дамжин илрэх гэж үү? Хэмээн бэргэн гайхан асуув. Ийн хэлж дуусав уу, үгүй юу л тэнгэрийн бошгийг үзүүлэх шиг юм болов. Зарц үүд нээн, мистер Годфри Элбвайт ирснийг мэдэгдлээ.

## II Бүлэг

Мистер Годфри зарцын араас орж ирэв. Ер нь хэдий ч ёстой л сайн хүн санаагаараа гэгчээр хүрээд ирдэг хүн дээ. Зарцын араас ухасхийн орж ирж биднийг цочоосон ч үгүй, хэзэ орж ирэхийг нь хүлээн нээлттэй хаалга ширтэх завдал ч өгсөнгүй. Энэ бол жинхэнэ христос мөргөлтний нэг шинж юм. Энэ эрхэм бол ёстой л хосгүй нэгэн билээ.

-Мисс Рэчелд очоод Элбвайт ирснийг мэдэгд гэж бэргэн зарцдаа тушаав.

Бид хоёр мистер Годфрийн амар мэндийг эрж өнгөрсөн долоо хоногт учирсан аюумшигт явдлаас хойш одоо давгүй болсон уу хэмээн шалгаасанд хоёуланд маань тун ч эвтэйхнээр нэгэн зэрэг хариулж чадлаа. Вериндер ахайд үгээр хариу өгсөн бол надад сэтгэл татам сайхан инээмсэглэл барьсан юм.

-Юунд намайг ийнхүү өрөвдөгцөөнө вэ? Хэмээн туйлын ялдамхнаар дуу алдаад, -Хайрт нагац минь! Хайрт мисс Клак минь! Намайг нэг хүнтэй л зүгээр андуурч л дээ. Миний нүдийг боож, багалзуурдах шахан, хачин хатуу шалан дээр дэвссэн маш нимгэн хивсэн дээр унагаснаас л цаашгүй. Үүнээс долоон дор юм болхыг хэн байг гэх вэ? Намайг нухах ч юмуу, тонож ч болзошгүй байсан шүү дээ. Би юу алдсан юм бэ? Шүүх өмч хөрөнгө гэж үл тооцдог сэтгэлийн хүчээ л алдсан. Тэгэхээр шулуухан хэлэхэд би үнэндээ юу ч алдаагүй. Миний дураар болдогсон бол би тэр адал явдлыг дуугүйхан дараад өнгөрөх бйсан юм. Ингэж хэл үймээнэтй, дуулиантай юм болж байгаа нь ндад тун тусгүй санагдана. Гэвч мистер Люкер өөртөө тохиолдсон явдлыг нийтэд зарласан ба үүний улмаас надад тохиолдсон явдал ч нийтэд ил болсон билээ. Эрхэм уншигчид уйдаж залхах хүртэл нь миний

бие сонины өмч болжээ. Би үнэндээ бүр залхчихаад байна. Эрхэм уншигчид ч над шиг болоосой билээ! Хонгор Рэчел ямар байна? Лондоны зугаа наадамд оролцож, хөгжиж цэнгэсээр л байна уу? Юун сайн юм бэ! Мисс Клак надад таны өршөө лхэрэгэти байна. Хорооныхоо ажлаас болон хонгор хатагтай нараасаа холдоод арай л бэтгэрчихсэнгүй. Гэхдээ ирэх долоо хоногоос хувцас хасах эрчүүдийн нийгэмлэгээр ороод гарна байх. Хорооны ирээдүйн төлөв хэр зэрэг найдвартай байна? Өмд элбэг үү? Гэлээ.

Түүний тэнгэрлэг сайхан инээмсэглэлд автахгүй байхын аргагүй. Ажил хэргийн ийм сонирхолтой асуудлыг түүний хүнгэнэсэн ялдам дуу хоолой улам ч сэтгэл булаам болгоно. Үнэндээ, бид хангалттай олон өмд нөөцөлснөөр үл барам бүр дарагдчихаад байгаа билээ. Энэ тухай хэлэхээр завдтал үүд онгойж, хорвоогийн түгшүүр зовлон мисс Рэчелийн дүрээр хийсэн орж ирэв. Үс гээг нь үзэмжгүй сэгсийж, царай нь муухай улайсан мисс Рэчел бүсгүй хүнд зохимжгүй гүйх шахам түргэн алхалсаар эрхэм мистер Годфри рүү очлоо.

-Годфри, таны ирдэг яасан сайн юм бэ! Мистер Люкерийг авчирсан бол мөн догь доо! Манай дуулиантай явдлын үеэр одоо Лондонд та хоёр ч хамгий нсонин улс болоод байна шүү дээ. Энэ бол мисс Клак шиг журамтай хүн өөрий нэрхгүй хэрдхиймээр бүрхэг, ер бусын зүйл. За тэр ч яахав. Нортумберланд гудамжинд болсон явдлыг надад яриад өгөөч. Сонинд зарим юмыг хаяж бичсэнийг би сайн мэдэж байна хэмээн залуу эрчүүд хоорондоо харьцдаг шиг нүүрэмгий, найзархаг аясаар өгүүллээ. Хүн төрөлхтний Адамаас өвлөсөн гутарь болсон тун ч шалихгүй чанарыг хүндэт Годфри хүртэл өвлөн авчээ! Годфри Рэчелийн гарыг хоёр гараараа атган бариад хантаазныхаа зүүн энгэрт наахыг нь харахад даанч харамсмаар байв. Энэ бол мисс Рэчелийн эрээ цээргүй яриаг, намайг увайгүй дайрсныг нь өөгшүүлж байна гэсэн үг юм.

-Эрхэм хайртай Рэчел минь, сонинд юу ч орхилгүй нэгд нэгэнгүй бичсэн, би ярилаа гээд хаана нь ч хүрэхгүй хэмээн манай нийгэмлэгийн хэтийн төлөв, өмд цуглуулах талаар ярихад нь би гайхан бахдаж асан яг л тэр дуугаараа учирлав.

-Биднийг хэтэрхий их сүр бадруулж байна гэж Годфри бодоод байгаа юм. Тэгээд ч тэр явдлын тухай ярихад эвгүй байна гэж саяхан бид хоёрт хэлсэн гэж бэргэн маань анхаарууллаа.

-Яагаад?

Ийн асуухад нүд нь гэнэт гялалзан мистер Годфрийн улаан нүүр өөд ширтэв. Мистер Годфриг өөдөөс нь тун ч хүлцэнгүй, даанч зохсигүй харсан тул би нүдээ аниад өнгөрч эс чадаад,

-Хонгор Рэчел минь! Жинхэнэ сүр хүч, жинхэнэ эр зоригтон ямагт даруу байдаг юм хэмээн зөөлхөн эсэргүүцэв. Рэчел миний үгийг юман чинээ саналгүй,

-Годфри та тэрүүхэндээ их сайн хүн боловч агуу их хүн огт биш шүү дээ. Таныг ер бусын зоригтой гэвэл би ер үнэмшихгүй. Хэрэв та даруу зантай байсан бол, танай хатагтай нар нэлээд олон жилийн өмнө таныг тэр сайн чанараас чинь ангижруулсан нь лавтай. Нортумберланд гудамжинд тохиолдсон явдлыг ярихгүй байх нэг хувийн шалтгаан танд байна. Би түүнийг чинь мэдмээр байна гэж залуу эрчүүд хоорондоо ярилцах мэт үеэлдээ хэнэггүй хэлэв.

-Үүний шалтгаан тун ойлгомжтой хялбар юм. Би бүр ярьсаар байгаад залхаж орхилоо гэж мөн л хүлцэнгүй хариуллаа.

-Залхсан гэнэ ээ? Хайрт Годфри имнь. Танд нэгэн зүйл сануулмаа рбина.

-Ямар?

-Та ихэнх цагаа эмэгтэйчүүдийн дунд өнгөрөөх юм. Тэнд та хоёр муу зан сурчээ. Шалихгүй дэмий юмыг сүрхий ноцтой юм болгон зөвхөн сэтгэлээ л зогоохын тулд худал ярьдаг. Таныг шүтэж биширдэг хатагтай нартайгаа та эрс шууд харьцаж чаддаггүй. Гэвч би таныг надтай эрс шууд яриулах болно. Нааш ир, энд суу. Би танаас илэн далангүй асуухсан гэж тэсэж ядаж байна. Мөн надад илэн далангүй хариулна гэдэгт найдаж байна.

Тэгээд өрөөний нөгөө булан хүртэл хөтлөн явсаар цонхны наана мистер Годфриг гэрлийн өөдөөс харуулан суулгав. Миний бие ийм яриа, ийм харьцааг уншигч танд толилуулах гээд хэчнээн хүнд үүрэг болохыг хэлэх юун. Гэвч нэг талаас мистер Фрэнклин Блэйкийн өгсөн мөнгөний чек, нөгөө талаас, шударга үнэнийг ариунаар эрхэмлэх сэтгэл минь шаардах тул би хэрхэх билээ? Би бэргэн өөдөө харвал, тэр хоёрын ярианд оролцох санаа огтхон ч үгүй мэт хөдөлгөөнгүй сууна. Тийнхүү хөшүүн байхыг нь урьд өмнө ер үзсэнгүй. Хөдөө байхдаа зовж шаналсны дараа ийм болсон ч байж магадгүй юм. Ямар ч атугай тэр бол Вериндер ахайн насан дээр Вериндер ахай шиг тарган цатгалан, чийрэг биеотэй хүнд үнэндээ тохирохгүй зүйл байв.

Энэ завсар рэчел цонхны наана манай цайлган хүлцэнгүй, хэтэрхий хүлцэнгүй мистер Годфрийн хажууд суугаад эхийгээ ч, намайг ч хүн гэж тоолгүй, түрүүн сүрдүүлж байснаараа Годфриг асууж шалгааж эхэллээ.

-Цагдаа нар юм олов уу?

-Юу ч олоогүй дээ.

-Таныг занганд оруулсан гурван хүн, хожим нь мистер Люкерийг бас занганд оруулсан биз?

-Хайрт Рэчел минь, үүнд эргэлзэх юм байхгүй.

-Тэдний сургийг гаргаагүй юу?

-Үгүй.

-Тэр гурван хүн, хөдөө, манайд очиж байсан энэтхэгүүд байх гэлцэх юм, үнэн болов уу?

-Зарим хүн тэгж бодож байгаа юм.

-Та бас тэгж бодож байна уу?

-Хонгор Рэчел минь, тэдний царай зүсийг ажиглаж амжихаас өмнө миний нүдийг боочихсон шүү дээ. Энэ талаар үнэндээ ямар ч төсөөлөлгүй байж ямар нэг таамаглал хэлж чадах уу даа?

Мистер Годфри хэдийгээр тэнгэр шиг ялдам дөлгөөн боловч тийнхүү яршигтайгаар салахгүй хоргооход нь тэсвэр алдаж эхлэв. Мисс Рэчелийн асуултанд жолоогүй сониуч зан, дарагдашгүй аймшгийн аль нь ноёрхож байсныг би лавтай хэлж эс чадна. Харин дээр дурдсан асуултын дараа мистер Годфри босохыг завдан өндийтөл Рэчел хоёр мөрөн дээрээс нь шулуухан түлхэж, буцааж суулгасан гэдгийг л хэлж чадах байна. Ай-яа, та түүнийг нүүрэмгий зан гэж бүү бод! Энэ харьцааг зөвхөн нийцгүй хүний ширүүн авир гэж тайбалралх ч хангалтгүй юм! Бид бусдыг шүүмжлэх ёстгүй. Христос мөргөлтөн анд нар минь, бид үнэндээ, өрөөл бусдыг шүүмжлэх хэрэггүй билээ!

Рэчел хэнэггүй асууж хоргоосоор байв. Ертөнцийн үерээс өмнө чөтгөрийн мунхаг үр сад ичгүүргүй наргиж, садарлаж явсныг христосын үнэнч шавь нар миний нэгэн адил санаж байгаа буй заа.

-Годфри, би мистер Люкерийн талаар хэдэн юм мэдмээр байна.

-Рэчел минь, дахиад миний заяа дутахад, мистер Люкерийг би даанч сайн мэдэхгүй л дээ.

-Банкан дээр санаандгүй тааралдахаас өмнө уулзаж учирсан удаа бий юу?

-Огт үгүй.

-Түүнээс хойш уулзсан уу?

-Уулзсан. Цагдаагийн газар биднийг нэг нэгээр нь бас хамт асуусан л даа.

-Мистер Люкерийн банкны эзнээс авсан баримтыг дээрэмдсэн гэсэн байх аа? Юун баримт юм бол?

-Банканд хадгалуулахаар өгсөн нэг үнэт зүйлийн баримт юм гэнэ билээ.

-Сонинд тэгж бичсэн. Энэ бол жирийн уншигч нарт хангалттай боловч миний хувьд дулимаг мэдээ байна. Тэр баримт дээр чухам ямар эрдэнэ өгсөн болохыг тэмдэглэсэн байх ёстой биш үү?

-Баримт дээр тиймэрхүү юм тэмдэглээгүй байсан гэж би дуулсан юм байна. Мистер Люкер тэр үнэт эрдэнээ банканд хадгалуулахаар өгч, өөрийнхөө тамгаар лацадсан учраас хожим зөвхөн мистер Люкерийн гарт эргүүлж өгөх юм. Ерөнхийдөө иймэрхүү байна. Би өөр юу ч мэдэхгүй.

Рэчел үүнийг сонсоод хэсэг чимээгүй байснаа эхийгээ харж, шүүрс алдав. Дараа нь Годфри рүү эргэж байцаалтаа үргэлжлүүлээ.

-Манай гэрт болсон явдал бас сонинд гарчихсан шиг байна, тийм үү?

-Үнэхээр тэгсэн нь даанч харамсалтай.

-Зарим хийх юмаа олж ядсан бидний огт таньж мэдэхгүй улс манай Йоркширийн байшинд гарсан хэргийг Лондонд тохиолдсон эдгээр хэрэгтэй холбож тайлбарлах гээд байгаа юмуу даа?

-Олон түмний сониуч зан чухам ийшээ л хандаж байгаа нь тун эвгүй байна.

-Мистер Люкер та хоёрт халдсан гурван үл таних этгээд бол нөгөө гурван энэтхэг гэлцэх юм. Бас тэр эрдэнэ... гээд Рэчел дуугүй болов.

Царай нь зугуухан цайсаар бүр цонхийчихлоо. Тас хар үс, цонхигор царай нь харшиж аймаар ёозгүй харагдсан тул Рэчелийг асуултаа гүйцээлгүй муужирч унах нь уу даа гж бид бүгдээрээ бодоцгоосон билээ. Эрхэм Годфри босох гэж дахиад оролдов. Бэргэн охиноосоо элдэв юм ярихаа болиоч гэж гуйв. Би бэргэндээ алгуурлалгүй туслахын тулд хамгий нэнгийн тайвшруулах эм болох давсны уусмалтай сав өглөө. Рэчел бид гурвыг өчүүхэн ч хайхарсан шинжгүй, жишимгүйгээр,

-Годфри, наанаа сууж бай. Ээж ээ, надад санаа зовсны хэрэг ерөөсөө байхгүй. Клак аа, та энэ ярианы төгсгөлийг сонсохсон гэж тэсэж ядан байгаа...таныг бодож би муужирч унахгүй гэв.

Чухам яг л ингэж хэлснийг нь гэртээ харимагцаа би тэмдэглэлийн дэвтэртээ үг гээлгүй бичсэн юм. Гэвч өрөөл буесдыг шүүмжлэхээ больё! Христос мөргөлтөн анд нар минь, өрөөл бусдыг шүүмжлэхээ больё.

Рэчел дахиад мистер Годфрид хандаж, түрүүнд тасалсан асуултаа үргэлжлүүлэхийг харахад зэвүүн ажээ.

-Хавь ойрын хүмүүс юу гэлцэж байгааг би дөнгөж сая танд дуулгалаа. Годфри, мистер Люкерийн тэр эрдэнийг Саран чулуу гэж байгаа хүн алга уу? Та шулуухан хэлчих!

Энэтхэгийн очир алмазыг нэрлэмэгц гайхамшигт нөхрийн маань царай барсхийн хүрлийв. Түүний сайхан чанарын нэг болсон зөөлөн ялдам харьцаа нь арилж, зүй ёсны эгдүүцэл нэвт шингэсэн хариу өчсөн нь:

-Тийм ээ, хүмүүс түүнийг гэлцэж байна. Хувийн ашиг сонирхлын үүднээс мистер Люкерийн тухай худал цуурхал тараахдаа ер төвдөхгүй зарим нэг хүн байгаа юм. Тэр гутамшигтай шуугианаас өмнө Саран чулууны талаар юу ч сонсоогүй гэдгээ олон дахин баталсан. Гэтэл тэр олиггүй хүмүүс, мистер Люкерт нууж хаах нэг шалтгаан байна гэж хэв нэг зүтгээд, “бид тангарагласанд нь итгэхээс татгалзаж байна” гэлцэнэ. Ичмээр, шившигтэй юм!

Годфрийг хүүрнэх зуур Рэчел түүнийг тун жигтэй (хэрхэн харсныг дүрслэн бичиж чадашгүй) ширтэж байв. Ярьж дуусахад нь,

-Мистер Люкерийг та зүс таних төдий байтлаа нэг л их улайран хамгаалах юм гэлээ.

Авъяас билэгт нөхөр минь жинхэнэ христосын номлолын дагуу миний амьдралдаа дуулаагүй сайхнаар хариу өгсөн юм.

-Рэчел ээ, би аливаа хавчигдсан хүнийг улайран өмгөөлнө шүү.

Үүнийг хад чулуу боловч уяраамаар уриалаг зөөлөн өгүүлсэн юм. Гэвч, нөхөд минь, хад чулуунаас хатуу юу байдаг билээ. Хүний хөндий, хүйтэн цэвдэг, хатуу сэтгэлээс өөр юм үгүй! Рэчел тургив. Мистер Годфрийн нүүр өөд тургисан гэдгийг энд дурдахад ч нүүр халж байна.

-Годфри, наад нялуун үгээ гамнаж эмэгтэйчүүдийн хороон дээр хэрэглэнэ биз. Мистер Люкергт учирсан будлиан таныг тойрч гараагүй нь лав.

Энэ үг бэргэнийг хүртэл бэгтэрсэн байдлаас гаргажээ.

-Хонгор Рэчел минь чи арай дэндэж байна шүү гэж охиноо зэмлэв.

-Ээж ээ, би муу юм бодоогүй, сайн санаагаар асуу байна. Жаахан тас, дараа нь хараарай.

Тийн өгүүлээд мистер Годфрийн зүг гэнэт өрөвдсөн мэт харлаа. Тэгснээ эмэгтэй хүнд баймгүйгээр даварч, мистер Годфрийн гараас барив.

-Та энэ хэргийн талаар ээж, бид хоёрт ярих дургүй байгаагийн учрыг би таамаглаж байх шиг байна. Золгүй учралаар та хүмүүсийн нүдэнд мистер Люкертэй холбоотой үзэгдэх болжээ. Мистер Люкерийн талаар гутамшигтай шуугиан дэгдсэнийг та ярилаа. Таны тухай ямар шившигтэй яриа дэгдэж байна вэ?

Энэ үед ч хүртэл усыг тусаар хариулахад хэзээ ямагт бэлэн байдаг эрхэм мистер Годфри Рэчелийг уучлах гэв.

-Надаас үүнийг бүү асуу. Рэчел минь, энэ тухай мартсан нь дээр, нээрэн шүү, мартсан нь дээр!

-Би мэдмээр байна! Хэмээн Рэчел байдаг хоолойгоороо улангасан хашгирав.

-Годфри, ярьчихааж дээ! Одоо таны дуугүй байхаас илүү хортой юм байхгүй гэж бэргэн маань оролцлоо.

Мистер Годфрийн сайхан нүднээ нулимс мэлтэлзэж, сүүлчийн удаа гуйж гувшсан шинжтэй хараад эцэст нь,

-Рэчел, та мэдмээр байгаа бол хэлье л дээ. Саран чулууг мистер Люкерт барьцаанд өгсөн, тэр өгсөн хүн нь намайг мэтээр ярьцгааж байгаа гэсэн үйлийн үргүй хариу дуугарсан юм.

Рэчел чарлан ухасхийж босов. Мистер Годфри бэргэн хоёрыг ухаангүй мэт ээлжлэн харахад нь солиорчихоогүй байгаа даа гэж би үнэхээр айсан билээ.

-Надтай бүү ярь! Надад бүү хүр! Хэмээн дуу алдаад биднээс зугтан хөөгдсөн араатан мэт өрөөний булан руу ухрав. –Би л буруутай! Үүнийг залргуулах хэрэгтэй! Би биеэ золиосонд гаргасан, хүсвэл тэгэх ч эрхтэй би. Гэтэл хүний амьдрал баларч байхад нууцыг хадгалж гэмгүй хүнийг хохироох гэж үү! Ай, бурхан минь, даанч аймшигтай юм! Би түүнийг тэвчихгүй!

Бэргэн маань өндөсхийснөө гэнэт лагхийн суучихав. Намайг сулхан дуугаар дуудаж, ойр зуур хэрэглэх зүйлс хийдэг сагсанд нь байсан жижиг шилэн савыг заагаад,

-Түргэлээрэй! Усанд зургаа дусаа. Рэчелд харуулав аа! Гэж шивнэлээ.

Өөр үедсэн бол би үүнийг хачирхах байлаа. Гэтэл тэгж эрэгцүүлж бодох цаг биш, эм даруйхан өгөх хэрэгтэй байв. Эрхэм Годфри надад тус болж өрөөний нөгөө өнцөгт очоод Рэчелийг тайгаруулан аргадна.

-Та үнэндээ дэгсдүүлж бодоод байна. Миний нэр төр иймэрхүү түр зуурын будлианд хугарчихаагүй бат бэх шүү дээ. Нэг долоо хоног өнгөрөхөд л энэ бүхэн мартагдана. Энэ тухай дахин дурсахаа больцгооё хэмээн мистер Годфри өгүүлэх нь сонсдов.

Рэчел тэр сайхан уужим сэтгэлийг ч үл тоомсорлон хуншгүй авирлаж, долоон дор аашилж байлаа.

-Би энэ гүтгэлгийг зогсоох ёстой, зогсоох ч болно. Ээж ээ, миний хэлэхийг сонс! Клак, миний хэлэхийг сонс! Саран чулууг авсан хүнийг би мэднэ. Би мэдэж байна... гэдэг үгээ их л

онцолж хэлээд уур хилэндээ багтран хөлөө дэвсэлж, -Годфри Эблвайт гэмгүй гэдгийг би мэдэж байна! Годфри, намайг шүүгч дээр дагуулаад оч! Намайг шүүгч дээр аваад очооч, би тангараглаж, үнэнийг хэлье гэлээ.

Бэргэн маань миний гарыг шүүрэн барьж,

-Намайг Рэчелээс халхалж жаахан зогсооч гэж шивнэв.

Царай нь зэвхий даан хөхөрснийг хараад би цочин давхийв. Миний айсныг бэргэн ажиглаад,

-Нэг, хоёр минутын дараа эм үйлчилнэ гэснээ нүдээ анин хүлээлээ.

Тэр зуур эрхэм мистер Годфри,

-Та энэ мэт хэргээр олны өмнө очиж болохгүй. Таны нэр төр бол зоргоорг тоглох аргагүй даанч цэвэр ариухан шүү дээ. Английн хосгүй сайн эрүүлч намайг очир алмаазаа өөрөө хулгайлсан гэж байна. Очоод асуу л даа, тэгвэл намайг нууц өр шир дарах гээд Саран чулуугаа барьцаан дөгсөн гэж хэлэх вий Тжэгснээ дуугаа хурааж, эхийнхээ зүг гүйн очоод хөлд нь сөхрөн унаж, -Ай, ээж минь, ээж минь! Одоо ч гэсэн би хэргийн нууцыг задлахгүй байх чингь, лав галзуурсан байх, тийм ээ? Гэв.

Айхта руурлаж, ганирсан тул эхийнхээ байдлыг ажиглах ч сөхөөгүй босон харайж, Годфри тийш давхин очив.

-Таныг, ер нь гэм зэмгүй хэнийг ч гэсэн миний буруугаас болж хохирохыг би зүгээр хараад сууж чадахгүй. Намайг шүүгч дээр авч очихгүй бол гэм зэмгүй гэдгээ баталж, нэг цаасан дээр мэдэгдэл бич. Би нотолж гарын үсгээ зуръя. Годфри, та миний хэлснээр гүйцэтгэ, эсвэл би сонинд бичнэ, гадаа гарч гудамжаар нэг зарлана шүү!

Гэмшсэндээ ч бус, хийрхээд л ингэж хэлсэн бйаж таарна. Номхон хүлцэнгүй мистер Годфри хуудас цаас аван мэдэгдэл бичиж, Рэчелийн сэтгэлийг амраалаа.

Цаадах нь гарын үсгээ ум хумгүй зураад өгөнгөө,

-Үүнийг явсан газраа үзүүлж байгаарай. Надад зовсны хэрэггүй. Годфри, би таны талаар өдий хүртэл буруугаар бодож явжээ. Та миний бодож байснаас хавьгүй сайхан сэтгэлтэй хүн юм. Та манайд дартай цагтаа ирээрэй, би танд буруу санаж явнаа залруулахыг хичээе гээд гараа өгөв.

Ээ халаг, бидний гутарь болсон чанар уу! Мистер Годфри мөн тоогүй ээ! Рэчелийн сунгасан гарыг үнсэж арчаагүй загнасаар үл барам хариу өчих дуунд нь ийм нөцхөлд даанч нүгэлтэй өнгө сонсдож билээ.

-Энэ ой гутмаар зүйлийг дахиж сөхөж ярихгүй гэдэг болзол тавибал би ирнэ, хонгор минь.

Христос шашны зүтгэлтнийг ийм шалдаа буусан байхыг нь би огт хараагүй билээ. Хэн маань ч ам нээж амжаагүй йатал гадан үүдийг гэнэт пижигнэтэл балбаж, биднийг учиргүй цочоов. Цонхоор харвал сүүх тэрэг, морьд, оо энгэсэг тавьсан зарц, мөн миний бие энэ насандаа ч хараагүй дэндүү эрээгүй хувцасласан гурван хүүхний дүрээр хорвоо, махбод, чөтгөр гурав үүдэн дээр зогсож байлаа.

Рэчел давхийснээ тайвширч, эх дээрээ очоод

-намайг цэцгийн үзэсгэлэн рүү аваачих гэж иржээ. Ээж ээ, явахаасаа өмнө ганц юм асууя. Та надад гомдсон уу? гэлээ.

Дөнгөж сая тэгж муухай авирлачихаад өрөвдүүлэх юмуу, зэмлүүлэх талаар хэнэггүй асууж байгаа нь нүнжиггүй сэтгэлийн илрэл бус уу? Б ич ууч сэтгэлтэй хүн л дээ.

Нөгөө дусаалга тус нөлөөгөө үзүүлж, хөөрхий бэргэн маань овоо сэргэн царай нь засарчээ.

-Үгүй, хаанаас даа, хонгор үр минь. Найз нартайгаа явж, зугаац гэж хэлсэнд охин нь тонгойж, эхийгээ үнслээ.

Би цонхноос холдож, Рэчелийг гарахаас өмнө хаалган дээр очив. Энэ зуур зан нь бас дахин хувирч амжсан ба нүдэнд нь нулимс цийлэгнэж байлаа. Тэрхүү хатуу сэтгэлийн түр уярсныг миний бие сонирхон ажиглаад хэдэн сэнхрүүлэх үг хэлэхээр завдав. Ээ халаг, гэтэл сайхан сэтгэлийн үг зөвхөн доромжлол мэт болжээ!

-Та намайг юу болж өрөвдөө вэ? Хэмээн гашуунаар шивнэн асуугаад -Намайг хэчнээн жаргалтбайхыг харахгүй байна уу? Би одоо цэцгийн үзэсгэлэн явлаа, Клак аа Лондонд надаас өөр ийм гоё малгайтай хүн байхгүй шүү гэж намайг даажигнаад, дээр н ьбас хий үнсэлт илгээж, өрөөнөөс гүйн гарав.

Тэр ааш муутай, олиггүй охиныг хэчнээн өрөвдсөнөө илэрхийлэн гаргахыг хүсэвч би үгийг бараг л мөнгөнөөс дутуугүй хэмнэдэг билээ. Түүнийг үнэхээр их өрөвсөн гэдгээ хэлэхийг зөвшөөрнө ҮҮ.

Бэргэнийхээ хажууд очтол эрхэм мистер Годфри нэг юм сэмхэн эрж, өрөөн дотуур ийш тийш холхихыг харав. Намайг тусалъя гэтэл эрсэн юмаа олоод бидэн рүү ирсэн нь нэг гартаа гэмгүй гэдгээ нотолсон бичиг, нөгөө гартаа чүдэнзний хайрцаг барьжээ.

-Хайрт нагац минь, бяцхан хуйвалдаан зохиоё! Үлгэр жишээч шулуун шударга эрхэм мисс Клак та ч уучилж болохоор гэмгүй заль юм! Рэчел уужим сэтгэлээр нэр төрөө золиослон гарын үсэг

зурсан энэ бичгийг миний бие хүлээж авсан гэдэг үнэмшлийг нь та хоёр бататгаж тусална уу? Эндээс явахын өмнө би энэ цаасыг устгана. Та хоёр гэрч болцгооно уу? гээд чүдэнз зуран нөгөө цаасыг шатааж, ширээн дээр байсан пял дээр тавив. –Надад учирсан жижиг сажиг эвгүй явдал бол энэ хүний болор мэт тунгалаг нэрийг хорвоогийн элдэв халдвараас хамгаалах явдлын дэргэд ёстой юу ч биш. За! Хэнд хоргүй жаахан үнс болж шив дээ. Бидний юу үйлдсэнийг цочмог зантай хонгор Рэчел маань гадарлах ч үгүй! Та хоёр ямар байна? Эрхэм найз нар минь ямар байв даа? Өчүүхэн миний хувь гэвэл жаал хөвгүүн шиг л зовох юмгүй, дотор уужирчихлаа.

Тийн өгүүлээд дур булаам инээмсэглэн нэг гараа нагацдаа, нөгөө гараа надад өгөв. Би түүний буянтай үйлийг жигтэйхэн шагшиж, гүнээ догдолсон тул үг дуугарах сөхөөгүй байлаа. Би нүдээ анив. Миний бие илбэдүүлсэн мэт бүхнийг умартан гарыг нь уруулдаа хүргэв. Мистер Годфри зөөлнөөр татгалзан шивнэнэ. Ай-яа, тэр бол үнэхээр бахдам, ер бусын гайхамшигт мөч байсан юм! Миний бие хөөрч баясахдаа өөрийн эрхгүй (юун дээр ч юм бүү мэд) доош суулаа. Нүдээ нээж харвал би хурмастаас газар дээр бууж ирсэн мэт санагдана. Өрөөнд бэргэнээс өөр хүн байсангүй. Мистер Годфри явчихжээ.

Миний бие мистер Годфрийн энэ буянтай ариун үйлийг дурдаад хүүрнэлээ цэглэмээр байна санж. Гэвч харамсалтай нь мистер Блэйкийн мөнгөний чиек бичихийг шаардаж бйагаа өө ролон зүйл бий. Намайг тэр нэг мягмар гаригт Монтегю талбайд бэргэнийдээ айлчлах үед илэрхий болсон эвгүй зүйлс ч хараахан дуусаагүй.

Вериндер ахай бид хоёул үлдсэний дараа түүнийг бие тавгүйцсэнээ болон эм ууснаа Рэчелээс нуух гэж оролдоход нь би ихэд гайхснаа аятайхан цухуйлгаад, эрүүл мэндийнх нь талаар ултай яриа үүсгэсэн юм.

Бэргэнийхээ хариуг сонсоод би мэл гайхсан билээ.

-Друзилла (хэрэв миний шашны нэрийг Друзилла гэдгийг дээр дурдаагүй бол одоо хэлэхийг зөвшөөрнө үү), та огт санаандгүй тун эмзэг асуудал хөндлөө гэж өгүүлэхэд нь би даруй босов.

Эелдэг зангийн үүднээс эхлээд уучлал гуйгаад дараа нь гарч явах хэрэгтэй байлаа. Гэвч Вериндер ахай намайг зогсоож, буцаж суу хэмээн шаардав.

-Зөвхөн Эблвайт эгч, хуульч Брафф хоёрт л итгэж хэлсэн нууцыг минь та санамсаргүй мэдчихлээ. Тэднийг ам алдахгүй гэж найдаж байгаа юм. Учир байдлыг тайлбарлаад танд бас найдаж болно гэдэгт би эргэлзэхгүй байна. Друзилла, та өнөө орой завтай юу?

Миний бие тэр оройг бүхэлд нь бэргэндээ зориулахад бэлхэн буйгаа нэн даруй мэдэгдсэнийг хэлэх юун.

-Тэгвэл дахиад нэг цаг хамт байгаач. Миний ярих зүйл таны сэтгэлийг зовооно доо. Та дургүйцэхгүй бол сүүлд нь би танаас нэг зүйл хүсье гэж Вериндер бэргэн хэлэв.

Би дургүйцэх битгий хэл харин ч туслахсан гэж үнэхээр их хүсэж байснаа энд хэлэхэд илүүдэх биз ээ.

Бэргэн маань цааш өгүүлсэн нь,

-Мистр Браф таван цагт ирнэ, та хүлээж бай. Тэгээд намайг гэрээслэлдээ гарын үсэг зурахад гэрчээр байлцаарай.

Гэрээслэл! Нөгөө хайрцагт байсан дусаал эм санаанд оров. Бэргэний црай зэвхий даан хөхөрч байсныг ч санав. Энэ ертөнцийн бус, хараахан үхэж амжаагүй булшнаас цацрах гэрэл миний бодлыг нээж өглөө. Бэргэний маань нууц надад илэрхий болов.

### III бүлэг

Хөөрхий Вериндер ахайг хүндэтгэдэг учраас тэрхүү гунигт үнэнийг ам нээхээс нь өмнө таамагласан гэдгээ огт мэдэгдсэнгүй. Яриагаа эхлэхийг нь дуугүй хүлээж, дэмжих үг хэлэхээр дотроо зэхэн, мөн ээн бол тун эмзэг хэрэг тул өөр юу тохиолдож магадгүй хэмээн бэлтгэлтэй байлаа.

-Друзилла, би айхавтар өвчин тусаад нэлээд уджээ. Харин тэр өвчнээ өдий хүртэл мэдээгүй ясван минь хачирхалтай хэмээн бэргэн яриагаа эхлэв.

Санаа сэтгэлийн эмгэгээ ухаарч мэдэлгүй амьсгал хурааж буй мянга мянган хүний тухай би бодлоо. Хөөрхий бэргэн маань тэдний тоонд орох вий гэхээс үлэмж айдас төрөх ажээ.

-Тийм ээ, хонгор минь, тийм хэмээн би гунигтай дуугарав.

-Би Рэчелийг эмч нарт үзүүлэх гэж Лондонд авчирсныг та мэднэ. Би хоёр доктортой уулзах нь зүйтэй гэж бодсон юм хэмээн Вериндер ахай үргэлжлүүлэв.

Хоёр доктор гэнэ шүү! Рэчелийг ийм ааш араншинтай байхад нэг ч санваартантай уулзаагүй байна шүү!

-Тийм үү, хонгор минь? Гэж би хариу өгүүллээ. Вериндер ахай өгүүлргүүн:

-Нэг эмчийг би таньдаггүй байв. Нөгөөдөх нь бол талийгаач нөхрийн маань найз байсан бөгөөд талийгаачийг бодож, надад үнэн сэтгэлээсээ тусалдаг юм. Рэчелд хэдэн эм бичээд, өөр өрөөнд орж надтай аминчхан ярилцмаар байна гэлээ. Би ч мэдээжийн хэрэг, охины маань эрүүл мэндийн талаар тусгай заавар өгөх нь дээ гэж бодлоо. Гэтэл гайхалтай юм болж, эмч миний гараас сэтгэл нь зовсон байртай бариад “Вериндер ахай, би таныг найзын төдийгүй эмч хүний нүдээр харлаа. Эмчийн зөвлөгөөн охинд чинь гэхээсээ танд л илүү шаардлагатай болов уу гэж би эмээж байна” гэсэн билээ. Тэгээд хэдэн юм асуухад нь эхэндээ тоохгүй байснаа, доктор миний хариуг сонсоод ихэд сандрахыг ажиглалаа. Эцэст нь дараачийн өдөр, Рэчелийн эзгүйд, бас нэг эмч нөхрийнхөө хамт ирж намайг үзэхээр тогтсон юм. Тэд үзлэгийнхээ дүнг надад тун болгоомжтой, эвтэйхэн танилцууллаа. Хайран үнэтэй цагийг дэмий алдаж, одоо өвчин маань эмчилгээ авахаас нэгэнт өнгөрөөд, тэдний хэрээс хэтэрчээ гэгцгээв. Би онц их шаналаагүй боловч аминд минь алгуурхан хүрч байгаа зүрхний өвчин тусаад хоёр жил гаруй болжээ. Одоо би хэдхэн сарын настай, бүр өнөө маргаашаас хэтрэхгүй байж магадгүй. Энэ талаар эмч нар тодорхой хэлж чадахгүй, эсвэл зүрхлэхгүй байгаа юм.

Тийм хүнд өвчтэй болсноо мэдээд гутраагүй гэж худлаа яриад дэмий биз ээ, хонгор минь. Гэвч би хувь тавилантайгаа нэгэнт эвлэрч, одоо хорвоогийн амьдралын аар саар явдлаа зүй зохистой байлгах гэж чадах ядахаараа хичээдэг боллоо. Рэчел үнэн учрыг мэдчих вий гэж л сэтгэл зовох юм. Мэдчихвэл тэр алмазаас л болж миний бие муудсан эгж үзээд, хөөрхий охин минь ямар ч буруугүй атал гашуудан өөрийгөө зэмлэж сүйд болно. Миний зүрх хоёр, гурван жилийн өмнөөс мууджээ гэж хоёр эм санал нэгтэй үзсэн. Друзилла таныг миний энэ нууцыг чандлан хадгална гэдэгт би итгэж байна. Бас таны царайнд чин сэтгэлээсээ харуусаж өрөвдсөн шинж илэрснийг би харж байна.

Харуусаж, өрөвдсөн гэнэ! Ай-яа, гүн бат христос сүсэгтэй англи бүсгүйгээс юун тэрслүү сэтгэл хүлээгээ вэ!

Гунигт яриагаа дуусахад нь сүсэглэн талархах сэтгэл намайг бүхэлд нь эзэмдэн авсныг хөөрхий бэргэн маань өчүүхэн ч төсөөлхгүй буй заа. Юутай чухал ажил гарав аа! Хонгор хайрт бэргэн маань хадан гэр нь тун ойртож агуу их өөрчлөлтийн босгон дээр ямар ч бэлтгэлгүй тулж очоод байдал төлөвөө надад учирлах боломжийг тэнгэр соёрхжээ! Тэр мөчид, энэ хэргийг итгэж болох ховор сайн санваартан нөхөд маань, нэг хоёроор ч бус арав, хориороо санаанд орж ирлээ! Оволзон буй энхрийлэл багтахгүй халин гарч, би бэргэнээ тэврэн авав.

-Ай-яа, та өгүүлж баршгүй сонин хүн юм даа! Ай, бид салан хагацахын өмнө хонгор минь танд тустай сайн үйл бүтээмз! Хэмээн би бишрэлтэйгээ өгүүллээ.

Урьдаар бэргэндээ хоёр, гурван нухацтай үг хэлж, дараа нь бүгдээрээ л үүрийн гэгээнээс үдшийн бүрий болтол хавь ойроор өглөг буяны үйл эрхэлдэг, бүгдээрээ л ширгэшгүй уран үгтэй, бүгдээрээ л намайг нэг үг дуугармагц билиг чадвараа дайчлахад бэлэн гурван сайн санваартан нөхрөө хэлж, хэнийг нь сонгох вэ гэдгийг лавлав. Ай зайлуул, бүтэл муутай юм боллоо! Хөөрхий Вериндер ахайн царайнд айж, балмагдсан шинж илэрч, миний хэлсэн бүхний хариуд бие нь сул дорой байгаа тул үл таних улстай уулзаж дийлэхгүй хэмээн цэвэр хорвоогийн амьдралын шалтан заан татгалзах бөлгөө. Би арга буюу бууж өгөв, зөвхөн энэ удаад шүү дээ. Энэ удаад зохих уншлааг хийх замаар бэлтгэх шаардлагатай болсныг арван дөрвөн санваартан андтай сүсэгтэн, номлогчийн хувьд хуримтлуулсан баян туршлагаасаа би ойлгосон юм.

Уг байдалд яг тохирсон, бэргийн маань сэргээж, итгүүлж сэхээрүүлж, зоригжуулан чадах ном бүхий бяцхан сан надад байдаг билээ.

-Та уншихаас татгалзахгүй юм байгаа биз дээ. Хонгор минь? Би үнэ цэнэтэй номнуудаа авчирч өгвөл та унших уу? Чухал газар хуудсыг нь нугалчихсан, түр саатаж, “Энэ надад хэрэгтэй бус уу?” гэж өөрөөсөө асуух ёстой хэсгийг харандаагаар зурж тэмдэглэсэн байгаа хэмээн би туйлын уриалгахан хэллээ. Ийм энгийн хүсэлтийг сонсоод бэргэн маань хэрдхийн цочих шиг болов. Хорвоогийн нүгэлт нөлөө даанч хүчтэй ажээ!

-Таны таалалд нийцүүлэхийн тулд би чадах бүхнээ хийе гэж хэлэхдээ намайг гайхан ширтэх нь сургажтай агаад аймшигтай.

Ганц ч хором алдаж болохгүй байлаа. Зуухан дээр тавьса нцагийг харвал миний бие гэрээрээ хурдхан орж, уншлагын түүврийн эхний хэдэн цувралыг (арван хоёрхон ном) аваад эргэж иэрхэд яг амжих хугацаа үлджээ. Хуульч ч ирж, би ч Вериндер ахайн гэрээслэлд гэрчийн ёсоор гарын үсэг зурж амжих болно. Яг таван цагт бэлэн байя гэж ам өгөөд буяны ажлаараа гэр өөдөө яаран одов.

Хувийн хэргээр бол би омнибусаар явахдаа огт дургүйлхэхгүй. Энэ удаад гар таталгүй хөнгөн сүүх хөлслөн авснаа хэлбэл миний бие бэргэнийхээ тусын тулд хэчнээн үнэн сэтгэлээсээ зүтгэснийг та бүрэн төсөөлөх буй заа.

Гэртээ ороод эхний цувралуудаас хэдийг шилж, тэмдэглэж аван, Европын аль ч орны номын сангаас олдохгүй ховор нандин арван хоёр ном хумбаганд хийгээд Монтегю талбай руу буцлаа. Дэлбэгчид зохих хөлсийг нь тоо ёсоор төлтөл хараал ширээл тавьсаар авахад нь би даруйхан шастираасаа нэгийг сарвайв. Хэрэв би цохонд нь гар буу тулгасан бол тэр эрээгүй шившигт этгээд тэглээ айн ширвээтэх байсан болов уу даа. Дэлбэгч суудал дээрээ үсрэн сандайж, булай үгээр эгдүүцэн хараагаад ум хумгүй довтолгон одов. Гэвч тэгж зугтаад ч ашиггүй болсныг баяртайяа тэмдэглэх байна! Дэлбэгчийн дургүйлхсэнийг үл хайхран шастираасаа нэгийг авч, сүүхний цонхоор нь чулуудаж сайны үрийг цацаж амжсан билээ.

Үүд тайлж өгсөн зарц (алаг эрээн тууз бүхий малгай өмссөн шивэгчин биш, залуу гоцго бйасанд миний дотор жигтэйхэн уужирсан юм) доктор хэдийн ирж, Вериндер ахайн өрөөнд сууж байна гэж мэдэгдэв. Хуульч Брафф саяхан ирээд номын санд хүлээж буй ажээ. Намайг бас түр хүлээзнэхийг гуйж, номын санд орууллаа.

Мистер Брафф намайг үзээд гайхав бололтой. Мистер Брафф бол тэдний хуулийн зөвлөх байсан тул Вериндер ахайн гэрт бид хоёр нэг бус удаа уулзсан билээ. Харамсалтай нь энэ хүн үсэн буурал болтлоо хорвоогийн хэрэг үйл эрхэлсээр иржээ. Ажлын цагаараа хууль, эд баялаг эзэмших эрхийг хамгаалахдаа сонгомол зөнч, чөлөөт цагаараа элдэв роман уншиж, шашны шастирыг урж тасчих бөлгөө.

-Мисс Клак та эднийд суух гэж байгаа юм уу? хэмээн миний хумбагыг ширтэн асуув.

Энэ мэт хүн ийм үнэт цүнхэнд чухам юу байгааг мэдэх юм бол тэрслүү булай үг хэлэхээс цаашгүй билээ. Би биеэ түүний төвшинд хүртэл буулган гутааж, эднийд ямар хэргээр зорьж ирснээ тайлбарлахад хүрсэн юм.

-Бэргэн маань гэрээслэлээ батлах гэж байгаагаа хэлээд намайг гэрч болохыг хүссэн юм л даа гэж хариуллаа.

-Өө тийм үү? Мисс Клак та ч яг тохирно шүү. Та насанд хүрсэн, Вериндер ахайн гэрээслэлээс өчүүхэн ч ашиг хонжоо харахгүй хүн.

Вериндер ахайн гэрээслэлээс өчүүхэн ч ашиг хонжоо харахгүй хүн гэнэ ээ! Ай, үүнийг сонсоод би хэчнээн их баярлав аа! Хэдэн мянгын хөрөнгөтэй бэргэн маань тавхан мянган фунт ч учиргүй идэх ядуу даржин намайг марталгүй гэрээслэлдээ багтаан өчүүхэн өв үлдээх юм бол, миний бие нимгэн хэтэвчээ хоослох шахан байж сүүх тэрэг хөлсөлж, хосгүй шилмэл номнуудаа эднийд авчрах болсны цаад шалтгаанд миний дайснууд эргэлзэж болох юм. Гэвч эдүгээ үүнд хамгийн хорон хэлтэн ч эргэлзэхгүй билээ. Үнэхээр тэгээсэй билээ! Тэгвэл ч мөн зүгээр сэн дээ!

Мистер Браффын дуунаар би энэхүү сэтгэл амраасан бодлоосоо ангижрав. Намайг бодлогоширч дуугаа хураахаар залхаж, дуртай дургүй ч яриа өдөв бололтой.

-За Клак танай өглөг буяны нийгэмлэгээр ямар сонинтой байна даа? Танай найз мистер Эблвайт Годфри Нортумберлэнд гудамжинд хэдэн луйварчинд айхтар чадуулсныхаа дараа ямаршуу байна вэ? Манай клубийнхэн тэр буянт эрийн тухай сүрхий л юм ярилцах юм байна шүү дээ!

Тэр этгээд намайг хорин нэг хол гарсан, бэргэнийхээ гэрээслэлийг ашиг хонжоо харахгүй гэж хэлсэн өнгийг нь би анзаараагүй мэт өнгөрөөсөн. Гэтэл эрхэм мистер Годфрийн тухай ярих өнгө нь миний дургүйг даанч их хүргэсэн тул би тэссэнгүй. Энэ өдөр болсон явдлыг нүдээр үзсэний хувьд, гайхамшигт андынхаа гэм буруугүй гэдгийг хаана ч, хэнд ч нотлох үүрэгтэй гэж үзсэн тул мистер Браффын ёжтой зэмлэлийг тас цохиж, шударга үүргээ биелүүлэх нь зүйтэй хэмээн сэтгээд,

-Би хорвоогийн амьдралыг огоорсон хүн, надад танай клубийн гишүүн байх онцгой эрх ч байхгүй. Гэвч таны дурссан тэр хэргийг санаандгүй олж мэдсэнээс гадна түүнээс илүү шившигтэй худал яриа байхгүй гэдгийг ч мэдэж байна гэлээ.

-Зөв, зөв мисс Клак та найздаа итгэж байна. Түмэн зөв. Гэтэл Годфри Эблвайт тэтгэмжийн хороон бүсгүйчүүдийг итгүүлдэг шигээ хорвоош ертөнцийг тийм хялбар үнэмшүүлж чадахгүй. Баримт сэлт яах ч аргагүй түүнийг эсрэг байна шүү дээ. Тэр хүн алмаз алдагдсан айлд байсан. Дараа нь тэндээс хамгийн түрүүнд Лондонд ирсэн. Сүүлчийн явдлыг харгалзан үзвэл энэ бол тун ёозгүй юм шүү, хатагтай.

Зүй нь би хуульчийг олон таван үг дуугарахаас нь өмнө зогсоох ёстой байжээ. Хэрэг явдлыг зөв талаас нь ярьж чадах ганц хүн маргашгүй эрхийнхээ дагуу мистер Годфрийг гэм буруугүй болохыг нь нотолсон баталгаа өгснийг огт мэдэхгүй учраас л тэгж яриад байгааг нь би мистер Браффт хэлбэл зохих байжээ. Ай зайлуул, тэр хуульчийн бурууг ойлгуулах нь миний хувьд юунаас ч чухаг байв! "Сүүлчийн явдал" гэж юугаа хэлээд байна вэ хэмээн би огт гэмгүй царайлан асуулаа.

Мистер Брафф цааш ярих тусмаа улам маадайж, надад ихэрхэн өгүүлсэн нь:

-Сүүлчийн явдал гэж нөгөө энэтхэгүүд оролцсон хэргийг хэлсэн юм. Фризинхоллын шоронгоос сулламагц тэр гурван энэтхэг юу хийв? Тэд шууд Лондонд ирж, мистер Люкерийг ажиглан дагах болжээ. Дараа нь юу болов? Мистер Люкер барьцаанд авсан нэгэн “үлэмж үнэтэй эрдэнээс” болж баахан сэтгэл түгших болсон байна. Түүнийгээ банкны эзэнд ерөнхий нэрийн доор хадгалуулахаар нууцаар өгчээ. Мистер Люкер гайхмаар ухаалаг хөдөлсөн авч энэтхэгүүд бас сүрхий ухаалаг байж. “Үлэмж үнэт эрдэнийг” өөр газар аваачсэн гэдгийг тэд гадарлаж, тэр таамаглалаа ер бусын зоримог баараггүй аргаар шалгасан байна. Тэд хэнийг барьж, нэгжив? Мистер Люкерийг энэ ч гайхалтгүй юм гэтэл бас мистер Годфри Эблвайтыг барьж, нэгжлээ. Яагаад! Мистер Люкергтэй санаандгүй ганц хоёр үг зөрснийг хараад л сохор эндүүрлээр барьсан гэж Эблвайт тайлбарлаж байна. Утгагүй дэмий үг! Тэр өглөө мистер Люкергтэй тав зургаан хүн ярилцсан. Яагаад бас тэднийг харихад хойноос нь дагаж занганд оруулаагүй юм бэ? Мистер Эблвайт мистер Люкерийн нэгэн адил “үнэт эрдэнийг” сонирхож йасан бөгөөд лавтай мэдээгүй учраас хоёуланг нь нэгжихээс өөр зам үлдсэнгүй гэсэн маш хялбар дүгнэлт гарч ирч байна. Олон түмэн ингэж л үзэж байна даа, мисс Клак минь. Тухайн хэрэгт олны саналыг үгүйсгэх ч амаргүй дээ!

Сүүлчийн үгийг жигтэйхэн итгэлтэй хэлсэн тул би түүнд үнэнийг дуулгаж, гайхуулахаасаа өмнө яриаг нь тас цохиж үнэндээ чадаагүй гэдгээ хүлээхэд ичгүүртэй байна.

-Тань шиг ийм чадварлаг хуульчтай би маргахгүй. Гэвч энэ хэргийг мөрдсөн Лондонгийн алдарт эрүүлчийн санал бодлыг мистер Эблвайтын тухай ярихдаа тоомсорлохгүй өнгөрч болно гэж үү? Түрүүч Кафф, мисс Вериндерээс өөр нэг ч хүнийг огтхон ч сэжиглэхгүй байгаа юм шүү гэж би хэллээ.

Та эрүүлийн саналыг зөвшөөрч байна гэсэн үг шив дээ?

-Эрхэм ээ, би хэнийг ч буруушааж зэмлэдэггүй, надад бсдож санасан юм алга.

-Тэгвэл би аль алиныг нь хийнэ, ахайтан. Эрүүлч Каффыг шал буруу дүгнэлт хийсэн гэж би буруушааж байна. Хэрэв тэр эрүүлч Рэчелийг миний дайтай мэддэгсэн бол Рэчелээс бусад бүх хнийг сэжиглэх байсан юм гэж би бодож байна. Рэчелийн дутагдлыг би үгүйсгэхгүй. Хэдийгээр дур зоргоороо, нууж хаадаг, этгээд адайр зантай, үеийнхээ охидоос шал өмнөө ч гэсэн ган болд мэт нугаршгүй шударга чигч, уудам ариун сэтгэлтэй билээ. Барин тавин баримтуудын эсрэг мисс Рэчел цорын ганц шударга үг хэлэх юм бол би хуульч хүн хэдий боловч түүний үгийг л эрхэмлэнэ дээ! Дэндүүлж байж магад боловч үнэхээр тэгнэ шүү, мисс Клак.

-Таныг ойлгосон эсэхээ магадлахын тулд хэлснийг тань тайлбарлая гэвэл та дургүйцэхгүй биз дээ, мистер Брафф? Эблвайт, Люкер нарт тохиолдсон явдлыг мисс Рэчел тун учир битүүлгээр сонирхоод байсныг бодоод үз л дээ. Тэр шившигт гүтгэлгийн тухай жигтэй юм асууж, үнэн учрыг дуулаад тун ч ойлгомжгүйгээр догдолж сүйд болсныг та бодоод үз л дээ.

-Мисс Клак та юу ч гэж бодсон мисс Рэчелд итгэх миний итгэлийг хумсны толион чинээ ч ганхуулж чадахгүй.

-Рэчелд үнэхээр найдаж болно гэж та үзэж байгаа юм шив дээ?

-Үнэхээр найдаж байна.

-За тэгвэл мистер Брафф аа, энэ байшинд хоёрхон цагийн өмнө, Саран чулуу алга болсонд мистер Годфри Эблвайт ямар ч буруугүй гэдгийг мисс Рэчел өөрийн биеэр зарласныг танд мэдэгдэхийг зөвшөөрнө үү. Залуу бүсгүйн амнаас тийм хурц үг гарч байхыг би энэ насандаа урьд өмнө сонсоогүй.

Би ялалтдаа бахдан баясав. Гэвч миний хэлсэн тэдгээр жирийн үгийг дуулаад мистер Брафф хэрхэн балмагдаж, шалдаа буусныг хараад нүгэл ч болов уу гэж сэтгэл баахан зовж билээ. Мистер Брафф босон харайж, намайг үг дуугүй ширтэв. Би байрнаасаа үл хөдлөн хэнэггүй тайван сууж, уг явдлыг дэлгэрэнгүй ярьж өгөөд,

-Одоо та мистер Эблвайтын талаар юу хэлмээр байна? Хэмээн чадах хэрээрээ эелдэг асуулаа.

-Нэгэнт Рэчел гэрчилсэн юм бол би Эблвайтын буруугүйд танаас өөрцгүй бат итгэж бйагаагаа огт түдгэлзэхгүй хэлнэ. Би бусдын адил гаднаас нь өнгөц харж эндүүрсэн байжээ. Одоо би таны найзын нэрийг гутаасан шившигтэй гүтгэлгийг сонссон газраа олны өмнө няцааж, алдаагаа засъя. Та намайг сүрхий гэнэдүүлж, овжин давлаа. Энэ дашрамд, таны ийм чадвартайд баяр хүргэхийг зөвшөөрнө үү? Та эр хүн байсан бол, миний мэргэжлээр агуу ихийг бүтээх байж дээ.

Тийн өгүүлээд нүүр буруулж, өрөөн дотуур өөд уруугаа цухалдан холхиж гарлаа.

Хэрэг явдлын талаар миний дуулгасан цоо шинэ мэдээнд учиргүй гайхаж, балмагдсан нь харваас андашгүй. Бодолдоо улам гүн автах тусам үе үе ганц хоёр үг амнаасаа унагаах бөгөөд тэдгээр үгнээс үзвэл, мань хүн Саран чулуу алга болсны нууцыг өдий хүртэл хэчнээн муухайгаар төсөөлж явсныг нь илтгэнэ. Мистер Брафф эрхэм Годфрийг алмаз хулгайсан жигшүүртэй хэрэгт сэрдэж, Рэчел тэрхүү гэмт хэргийг нь нууж далдлах гэсэн өгөөмөр сайха нсэтгэлийн улмаас хачин зан авир гаргалаа хэмээн эргэлзэж тээнэглээгүй боджээ. Мисс Вериндерийн баталгаа ёсоор (түүнийг

халдашгүй дархан хэмээн Брафф гуай зүтгэж байсныг та нэгэнт мэднэ) уг таамаглал үндсээрээ буруу гэдэг нь харагдлаа. Энэ лут хуульч даанч учраа олохоо байгаад үүнийгээ надаас ч нуух тэнхээгүй болжээ. Холхихоо больж, цонхны цаана зогсоод хуруугаараа шил тоншин, “Юу гээч хэрэг вэ! Тайлбарлахын аргагүй, бариад авах өчүүхэн ч сэжүүр алга” хэмээн амандаа бувтнах нь сонсдов.

Тэгэхдээ хариу сонсох гээгүй нь лавтай байсан авч би хариу өгсөн юм! Мистер Браффуг ингээд зөнд нь орхичихож болохгүй мэт санагдлаа. Дөнгөж сая хэлсэн үгнээс нь жирийн тэнэг гөжүүн зан төдийгүй түүнийг хувьдаа үл таашааж буйгаа мэдэгдэх бас нэг боломж гарсныг ойлгосон юм. Муу чанар, биднийг дийлдэг шиг үнэмшилтэй зүйл бий гэж үү!

-Таны бодлыг тасалсан бол уучлаарай. Гэвч одоохондоо таны толгойд ч ороогүй байсан ба нэг таамаглал сэдэж болох юм хэмээн ажиг сэжиггүй байсан Браффт хэлэв.

-Магадгүй мисс Клак. Юун таамаглал юм бол?

-Алмаз алдагдах үед мистер Эблвайт тэр байшинд байсан нь сэжиглэх бас нэг үндэс болсон гэж миний түүний гэм буруугүйг танд итгүүлэх завшаан тохиолдохоос өмнө та дурдсан билээ. Алмаз алга болох үед мистер Фрэнклин Блэйк ч бас тэр байшинд байсан гэдгийг сануулахыг зөвшөөрнө үү.

Нүгэлт өвгөн цонхноос холдож миний эгц өөдөөс харан суугаад хорсолтой хүйтнээр инээвхийлэн цоо ширтсээр,

-Мисс Клак, таныг овоо сайн хуульч болно гэж бодсон маань буруу байж. Та цаашламтгай хүн юм хэмээн бодлогоширонгуй өгүүллээ.

-Мистер Брафф би таныг ойлгосонгүй бололтой гэж би даруухан өгүүллээ.

-Энэ удаад та амжилт олохгүй, үнэн шүү мисс Клак, Фрэнклин Блэйкэд миний хайртайг та бэлээхэн мэднэ. Гэвч энэ чухал биш л дээ. Таныг довтолж амжихаас өмнө би энэ хэргийг таны үзлийг баримтлан нэг хараад орхиё. Хатагтай, таны түмэн зөв. Би Эблвайтыг сэжиглэхдээ Блэйкийг ч бас сэжиглэж болох шалтгаануудыг үндэслэсэн байна. За, тэгэхлээр, хоёуланг сэжиглээд үзье л дээ. Тиймэрхүү зан араншинтай хүн Саран чулууг сийхгүй хулгайлна гэж бид хэлэн байх. Гэвч тэгж хулгайлах хэрэг бий юу гэсэн нэг асуудал байгаа юм.

-Мистер Фрэнклиний өр ширийг хэн ч андахгүй шүү дээ гэж би санууллаа.

-Харин мистер Годфри Эблвайтийн өр шир тийм хэмжээнд хараахан хүрээгүй байгаа л даа. Үнэхээр зөв. Гэвч мисс Клак таны онолыг батлахад хоёр бэрхшээл учирч байна. Миний бие Фрэнклин Блэйкийн хэргийг хөтөлж хариуцдгийн хувьд, мөнгө зээлдүүлэгчдийн дийлэнх нь мистер Фрэнклиний эцгийг баян гэж мэддэг учраас зээллэгийн хүүг авч сэтгэл ханаад мөнгийг танд дуулагж болохсон болов уу. Энэ бол нэг дэх, зэгсэн хүнд бэрхшээл. Хоёр дахь нь бүр ч хүнд байх вий. Энэтхэгийн тэр гайтай алмаз гэрээс нь алга болохоос өмнө, охин нь Фрэнклин Блэйкийн эхнэр болоход бэлхэн байсан гэж Вериндер ахай надад өөрөө хэлсэн юм шүү. Речел залуу бүсгүйн сээтэгнүүр зангаар Фрэнклинд нэг найдвар төрүүлж, нэг урмыг нь хугалж байв. Гэвч үеэл ахдаа хайр сэтгэлтэй болсон үнэхээ эхдээ хэлж, эх нь зээ хүү Фрэнклиндээ тэр нууцыг итгэж ярьжээ. Тэгэхээр мистер Фрэнклин ямар байдалд орсныг та хар л даа. Зээлдүүлэгчид нь авлагаа хойшлуулж, мань хүн их хөрөнгө өвлөж авах баян бүсгүйтэй тун удахгүй гэрлэх гэж байсан байна. Та түүнийг олиггүй этгээд гэж хэлбэл ч хэл. Гэхдээ харин, Фрэнклин Саран чулууг хулгайлаад яах юм бэ гэдэг асуултанд хариулж соёрхоно уу.

-Хүний дотор орж болох биш дээ. Цаанаа юу бодож явдгийг хэн мэдэх вэ? Гэж би ялдамхан хариулав.

-Өөрөөр хэлбэл (хэдийгээр Фрэнклинд алмаз хулгайлах хэрэг хумсын чинээ ч байгаагүй боловч) шалиг зангаараа алмазыг авчихсан гэж үү? Их сайн. Хулгайлсан гээд бодъё л доо. Гэтэл ямар чөтгөрөө хийж...

-Өршөөгөөрэй мистер Брафф. Та чөтгөр шулмас гэж яриад байх юм бол би явахаас өөр аргагүй.

-Өршөөгөөрэй мисс Клак минь, үүнээс хойш үг хэлээ цэгнэж, болгоомжтой байя. Би зүгээр л ингэж асуух гэсэн юм. Ямар учраас Фрэнклин (өөрөө авсан гэж бодъё л доо) очир алмазыг олж илрүүлэх ажилд бусдаас илүү зүтгээд байгаа юм бэ? Хүмүүсийн сэжгийг биеэсээ овжноор зайлуулжээ гэж та хэлэх биз. Хэн ч түүнийг хардаж сэжиглээгүй учраас тэгэх хэрэгцаа байгаагүй гэж би хариулна. Эхлээд ямар ч шалтгаангүйгээр, зөвхөн шалиг зангаараа Саран чулууг хулгайлаад, дараа нь тэр эрдэнийн чулууг эрж хайхад идэвхтэй оролцох нь бүр ч хэрэгцээгүй бөгөөд ингэн нь хэрэв ийм явдал гараагүйсэн бол эхнэр нь болохдоо татгалзахгүй байсан залуу бүсгүйг үхтэл нь доромжилохоос цаашгүй билээ. Очир алмаз алга болсон хэрэгт Фрэнклин Блэйкийг холбогдуулах гэж оролдох юм бол та ийм утгагүй булай дүгнэлтэнд гарцаагүй хүрнэ. Тэгж болохгүй мисс Клак! Та бид хоёрын өнөөдрийн ярианы дараа бүрмөсөн мухардах нь ээ. Речелийн гэм буруугүй гэдэгт тээнэгэлзэх юм алга. Үүнийг эх нь, би ч мэдэж байна. Мистер Эблвайтын буруугүй гэдгийг үгүйсгэх арга алга, эс тэгвэл Речел хаанаас баталж гэрчлэх вэ дээ. Фрэнклин Блэйк буруугүй болох нь бэлээхэн

харагдаж байгааг та сая үзлээ. Нэг талаас бид үүнд огт эргэлзэхгүй байна. Нөгөө талаас нэг хүн Саран чулууг Лондонд хулгайлан авчирч, одоо мистер Люкер банкны эзэн хоёрын аль нэгэнд байгаа гэдэгт бид мөн итгэж байна. Ийм хэрэгт миний амьдралын туршлага, ер хэний ч туршлага мар хэрэг болох юм бэ? Энэ хэрэг намайг бүр самууруулж орхилоо. Таныг ч бас, ер нь бүх хүний толгойг эргүүлээ дээ.

Үгүй, бүх хүний ч биш ээ. Эрүүлч Каффын толгойг самууруулаагүй юм шүү. Миний бие энэ тухай, бололцооны хэрээр даруу номхноор сануулахын ялдамд намайг Рэчелийн нэр төрд буртаг суулгах гэж эрмэлзсэн мэтээр үзэхийг эрс эсэргүүцэж буйгаа мэдэгдэхийг завдтал зарц орж ирэн доктор явсан, Вериндер ахай биднийг хүлээж байна гэж хэллээ.

Бидний маргаан тийнхүү тасалдав. Мистер Брафф яриандаа баахан түүртэж ядарсан шинжтэй, бичиг цаасаа хумив. Миний бие дахиад хэдэн ч цаг давгүй ярьчихаж чадахаар санагдаж, ховор нандин ном бүхий хумбагаа авлаа. Бид хоёр Вериндер ахайн өрөө рүү дуу шуугүй алхацгаав.

Өөр явдлын тухай цааш өгүүлэхийн өмнө, хуульч бид хоёрын дунд болсон, миний дурдалгүй өнгөрсөн нэг зүйлийг товчхон нэмж, хэлэхийг зөвшөөрнө үү. Энэтэхгийн очир алмазыг Лондон байгаа гэж итгэж байсан үед сэжиг таавар хэрхэн эргэснийг төдийгүй хэн хэнийг сэрдэх болсон өчүүхэн нээлтийг, Саран чулууны шуугиант түүхэнд н эмэрлэж буй хэсэгтээ багтаахыг надад даалгасан юм. Номын санд мистер Браффтай хүүрнэсэн яриа маань энэ даалгаврын яг зохих ёсны биелэл мэт санагдсанаас гадна тэр бол биеэ тоох хилэнцэт сэтгэлийг огоороход тус нэмэр үзүүлсэн, миний хувьд нэн чухал ёс суртахууны агуу давуу чанар дүүрэн байлаа. Гутарь болсон чанар маань намайг дийлснийг хүлээхээс яахав. Эл доромж үнэнийг ухаараад би гутарь болсон чанараа давсан юм. Ёс суртахууны тэнцвэр сэргэж, сүсэг бишрэл дахин тодорлоо. Эрхэм найз нар минь, одоо цааш үргэлжлүүлье.

## IV бүлэг

Гэрээслэл батлах ажил миний санаснаас хавьгүй хурдан дууслаа. Их л яарч хуумгүй үйлдэх шиг бодогдов. Бас нэг гэрчээр оролцох ёстой тэдний зарц Сэмуэлийг дуудуулсан атал ирэхийг нь ч хүлээлгүй Вериндер бэргэнд үзэг бариулав. Энэхүү ёс төртэй хэрэгт холбогдуулан хэд гуравн зохимжтой үг хэлье гэж үнэхээр хүссэн боловч Брафф гуайн зан аягийг хараад түүний бие энэ өрөөнд байгаа цагт аа татвал өлзийтэй болохыг би ойлгосон юм. Хоёр ч минут хүрэхгүй хугацаанд бүгдийг амжуулж дуусгаад, Сэмуэл ч (энэ залууд сайн нөлөө хэрэгтэй гэдгийг хэлбэл зохино) явлаа.

Мистер Брафф гэрээслэлийг эвхээд намайг тэр хоёрыг үлдээн явахгүй юм болов уу гэсэн байртай миний зүг харав. Гэтэл миний бие буянт үйлээ гүйцэтгэх ёстой, тэгээд ч нандин чухал шастиртай хумбагаа өвөр дээрээ бэлэн тавиад сууж байлаа. Тийнхүү ширтэж намайг хөдөлгөнө гэвэл хутагт Павелын цогчин дуганыг тэгж ширтээд байрнаас нь хөдөлгөх гэсэнтэй чанар нэг буй заа. Браффын ажигч гярхай (олон оймс элээсний ач биз) сайн чанарыг би үгүйсгэхгүй. Би мистер Браффт нөгөө дэлбэгчид төрүүлсэн шигээ бараг адилхан сэтгэгдэл төрүүлэв бололтой. Мань хүн бас л үл ухагдах юм амандаа бувтнасаар намайг ялагч болгон үлдээгээд яаран гарч одов.

Хоёул үлдмэгц бэргэн маань буйдан дээр хажуулдаад, гэрээслэлийнхээ талаар баахан сандарсхийн ярилаа.

-Друзилла, таныг хайхарсангүй гэж бүү бодоорой. Хонгор минь, бяцхан өвийг чинь би өөрөө өгөмц гэв.

Ёстой эгзэгтэй боломж таарлаа даа! Би ч уг боломжийг нэн даруй ажиглав. Өөрөөр хэлбэл, хумбагаа түргэн нээж, дээрээс нь нэг ном авлаа. Тэр бол нэр нь үл мэдэгдэх зохиогийн (хосгүй Беллоус авхай бичсэн гэж тааварладаг юм) “гэрт шүгэлсэн буг” хэмээх алдарт номын анхны, дөнгөж хорин тав дахь хэвлэл байлаа. Уг ном (шүтлэггүй уншигчид мэдэхгүй ч байж магад) өдөр тутмын амьдралын гэм хоргүй мэт үйлдэлд ч биднийг хорлохоор чөтгөр отон хүлээж байдгийг харуулах зорилготой юм. Эмэгтэйчүүдэд зориулсан, “Саманд шүгэлсэн шулам”, “Толины ард нуугдсан шулам”, “Цонхоор шагайсан чөтгөр” гэх зэрэг бүлгүүдтэй билээ.

-Хонгор бэргэн минь, энэ үнэтэй сайхан номыг анхааралдаа толилон авна уу. Тэгвэл надад өгч байгаа дээд зэргийн бэлэг болох нь тэр гээд номоо дэлгээстэй нь өглөө. Тэр нь “Буйдангийн жинтүү дунд нуугдсан шулам” хэмээх гайхамшигт гарчиг бүхий хуудас таарчээ.

Хөөрхий Вериндер ахай буйдангийнхаа жинтүүг хөнгөмсгөөр налан байж номыг үзээд бүр ч зовлон байртай эргүүлж өгөөд,

-Друзилла, би жаахан тэнхэрч аваад уншилгүй горьгүй байх. Эмч... гэлээ.

Докторын нэрийг дурсмагц л би учрыг ойлгосон юм. Тэрслүү үзлээрээ алдаршсан эмнэлгийн мэргэжилтнүүд, өвчтөнийг тайван байлгах учиртай хэмээн арчаагүй шалтаг заан аргацааж, миний буянт үйлсэд саад хийх ба эмч нар өвчтөний сэтгэл санааг хямруулж болзошгүй гэлцэх аливаа нөлөөнөөс, тухайлбал мисс Клак түүний номны нөлөөнөөс айж сэрэмжлэдгийн уршгаар хадан гэр нь ойртож байсан ойр дотнын улсад маань юу тохиолдсоныг би мөн ч олон удаа үзсэн билээ. Яг тийм мунахг материализм ар хударгаар минь итгэл эвдэн хөдөлж, ядуу зүдүү надаас цорын ганц эрхийг минь буюу хадан гэртээ явах нь ойртсон бэргэнийхээ нөгөө ертөнцөд мордох замд бэлтгэх эрхийг минь булааж аавх гэж зүтгэж байна.

-Миний биеийг өнөөдөр тааруухан байна гэж доктор хэлсэн. Гаднын хүмүүстэй уулзахыг хориглож, юм уншвал хялбар, зугаатай ном л унших хэрэгтэй гэсэн юм. "Вериндер ахай, та тархиа ядрааж, зүрхээ өвтгөх юм хийж огт болохгүй" гэж надад захиад явсан шүү. Друзилла минь хэмээн төөрөлдсөн хөөрхий бэргэн маань өгүүлэв.

Миний бие дахиад л түр буулт хийхээс өөр аргагүй боллоо. Миний үйл хэрэг эмч нарынхтай зүйрлэхэд хамаагүй чухаг болохыг үзүүлсэн аливаа баталгааг тэр доктор харгалзан үзээд, эмчилгээгээ зогсооно хэмээн сүрдүүлэх замаар өвчтөнийхөө сул талыг засах хэрэгт туслах ёстойсон. Азаар, сайны үрийг цацах арга зам ганц нэгээр зогсохгүй өчнөөн олон, тийм аргыг олохдоо над шиг овжин сүйхээтэй хүн ховор ажээ.

-Бэргэн минь, нэг, хоёр цаг болоод бие чинь дээрдэх биз ээ. Эсвэл маргааш өглөө нэг л юм үгүйлсээр сэрвэл энэ эгэл жирийн ном түүнийг чинь нөхөж чадна. Энэ номыг орхихыг зөвшөөрнө үү? Доктор дургүйцэж хориглох нь юу л бол!

Тийн хэлээд номоо жинтүүн доогуур нь, амны алчуур, шилэн савтай үнэрлэх спиртний хажуугаар шургуулав. Энэ хоёр зүйлийнхээ аль нэгийг авахаар тэмтрэх бүрдээ номд хүрч, эрт орой хэзээ нэгэн цагт ном сэтгэлийг минь хөндөхийг хэн байг гэх вэ? Асуудлыг тиймэрхүү маягаар нэг тийш болгочихоод явах нь зүйтэй гэж үзсэн юм.

-Хонгор бэргэн минь, би явъя, та ч амар даа. Би маргааш бас ирнэ ээ! Гэж хэлэхдээ цонх руу санаандгүй харлаа.

Цонхны тавцан ваар саванд суулгасан цэцгээр дүүрчээ. Вериндер ахай эдгээр зуурдын эрдэнэд амь тавин дзурлах ба тэднийгээ харж үнэртэх гэж байсгээд л босож очдог зантай билээ. Миний толгойд шинэ санаа зурсхийн оров.

-Өө, би нэг цэцэг авч болох уу? гэж дуу алдаад ажиг сэжиг төрүүлэлгүй цонх руу очлоо. Цэцэг таслан авахын оронд харин нэгийг нэмсэн юм. Өөрөөр хэлбэл, хумбаганаасаа нэг юм гаргаж, шимтэглэй, сарнай хоёрын дунд тавьж, бэргэн маань гэнэт үзээд баярлах биз гэж бодов. Ордог өрөө болгонд нь ингэж ном тавьж хөөрхийд тус хүргэхэд болохгүй нь юу байх вэ? Гэсэн бүтэмжтэй сайхан бодол төрлөө. Би шалавхан баяртай гэхчээд үүдний өрөөгөөр гарч, номын санд оров. Сэмуэл намайг гаргах гэж үүд рүү очсоноо явчихаж гэж санаад буцаж доошоо уруудав. Номын сангийн ширээн дээр буруу номтон докторын заавраар гаргасан хоёр "зугаатай ном" байхыг би олж хараад, нандин номноосоо хоёрыг нэн даруй дээрээс нь тавьж, нүднээс далд болгов. Цайны өрөөнд бэргэний хайртай хамбага бялзуухай торондоо донгодон байна. Бэргэн бялзуухайгаа дандаа хооллодог зантай. Торны харалдаа ширээн дээр хэсэг тариа асгасан байх ба нэг ном дунд нь тавилаа. Зочны өрөөнд ороод хумбагаа бүрэн суллах бүр ч боломжийн завшаан таарсан юм. Бэргэний маань дурладаг хөгжмийн нотнууд төгөлдөр хуур дээр байсны завсар хоёр ном хавчуулж орхив. Зочны хойд өрөөнд Вериндер ахайн арай дуусгаагүй хатгамал харагдахаар нь бас нэг номоо доор нь хийчихлээ. Тэр өрөөний цаана хаалганы оронд хөшиг татсан нэг бяцхан тасалгаа бий. Бэргэний маань хуучны нэг муу дэвүүр зуухан дээр байв. Би хумбаганаасаа ес дэх номоо авч, нэн чухал хуудасны нь завсар нөгөө дэвүүрийг хавчуулж орхив. Тэгтэл унтлагын өрөөнд нэвтэрч орох хэрэг байна уу, үгүй юу гэсэн асуулт үүсэв. Хэрэв дээд давхарт явж байхыг минь нөгөө малгайндаа туузтай бүсгүй харчихвал миний хувьд тун ичгүүртэй, доромжлол болох зайлшгүй аюул байгаа юм. Гэвч тэглээ гээд яах вэ? Хөөрхий христос мөргөлтөн доромжлолыг юман чинээ санахгүй. Миний бие юу ч тохиолдсон хүлцэн тэвчихэд бэлдэн шатаар өгсөв. Байшинд хөл хөдөлгөөнгүй, нам гүм байсан нь зарц нарын цайны цаг таарсан бололтой. Бэргэний өрөө хамгийн наана байв. Талийгаач Жон ноёны бяцхан хөрөг орны эсрэг хананд өлгөөстэй агаад намайг инээмсэглэн харж "Друзилла, номоо энд тавь!" гэж өгүүлэх мэт. Орны хоёр талд нэг нэг ширээ байна. Нойр муутай зовох шөнө хэрэг болдог, эсвэл хэрэг болох юм шиг санагдсан элдэв аар саар юм өржээ. Нэг ширээн дээр нь байсан шүдэнзний хайрцаг доор нэг ном, нөгөө ширээн дээр байсан шоколадны үрэл бүхий савны доогуур бас нэг номоо тавилаа. Гэрэл гаргах гэхэд нь ч юмуу, үрэл идэх гэхэд нь эдгээр үнэ цэнэтэй ном нүдэнд нь тусч, гарт нь өртөн тухай бүр "Алив, намайг уншаач! Намайг уншаач!" хэмээн үг дуугүй байж байг. Хумбаганд ганцхан ном үлдсэн байх ба миний ороогүй зөвхөн ганц өрөө хоцорсон нь унтлагын өрөөний хажууд байдаг халуун усны тасалгаа билээ. Тийшээ шагайсанд, "Друзилла, чи номнуудаа газар сайгүй тавилаа.

Одоо халуун усны тасалгаанд нэгийг орхивол ажил чинь гуйцэх нь тэр” гэж хэзээ ч алдаж ташаардаггүй, ариун дуу хоолой сэтгэлийн гүнээс шивнэх шиг болсон юм. Сандал дээр хаясан халад нүднээ тусав. Би халаасанд нь сүүлчийн нмоо хийв. Миний бие байшингаас хэнд ч үзэгдэлгүй гарч, хоосон хумбага сугавчлан гудамжаар алхахдаа үүргээ амжилттай биелүүлсэн гэхээс догдлон хөөрсөн сэтгэлийг илэрхийлэн дүрслэх үг олдоно гэж үү?

Ай, сүсэг бишрэлгүй найз нар мань. Ай, садар самуун амьдралын нүгэл хилэнцэт будлиан дундаас бүтэхгүй хоосныг мөрөөдөж, аз завшаан эрэлхийлэгч сүсэг бишрэлгүй найзууд минь, та нар нинжин сайхан сэтгэлтэй л байх юм бол аз жаргалатй болоход хэчнээн хялбар гэж санана!

Тэр шөөн юм хумаа цэгцэлж байхдаа баян чинээлэг бэргэнийхээ гэрт жинхэнэ баялгийг өгөөмөр сэтгэлээр гар таталгүй цацаж, тарааснаа санахад хүүхэд шиг амарлингуй байж билээ. Сэтгэл өег, уужуу тул би оройн мөргөлөөс нэг бадгийг дуулав. Сэтгэл тэнэгэр, тайван учраас цааш нь дуулж чадалгүй нойронд автлаа. Буцаад хүүхэд болсон мэт санагдана! Яг л хүүхэд шиг амарлингуй байлаа.

Тэр жаргалтай шөнө тийнхүү тайван нойрслоо. Маргааш өглөө нь өөрийгөө залуужсан мэт санаж бослоо! Мөнх бус бие бялдраа тодорхой дүрсэлж чаддагсан бол би зөндөө залуу харагдсан байх гэдгийг нэмж хэлбэл зохино. Би даанч тэгж бичиж чадахгүй, тийм учраас энэ талаар өөр нэг ч үг нэмэхгүй.

Өглөөний цайны өмнөхөн, миний бие ойр зуурын хэрэгцээ гарсан учраас ч бус, харин хонгор бэргэнтэйгээ уулзах гэж Монтегю талбай руу явахаар малгайгаа өмслөө. Гарахаар завдтал миний сууж байсан байрны шивэгчин үүдээр шагайж,

-Мисс Клак, Вериндер ахайн зарц ирлээ гэв.

Лондонд байх хугацаандаа би хямд буудлын доод давхар тсуудаг байлаа. Зочны өрөө маань тун жижигхэн маш намхан адартай, их л ядуу тавилгатай боловч хачин цэвэр цэмцгэр билээ! Вериндер ахайн зарц намрын хэн нь намайг сураглаж ирснийг мэдэх санаатай шагайвал, улаа бутарсан царайтай, эелдэг ааштай, хүний үг сайн авдаг, их л тусч байрын Сэмуэл нэлээд сүсэгтэйг гадарладаг болохоор хэдхэн нухацтай үг хэлье гэж дандаа боддог байсан юм. Энэ удаад түүнийг зочны өрөөнд оруулав.

Нэг том боодолтой юм сугандаа хавчуулжээ. Боодолтой зүйлээс айж балмагдсан мэт доор тавьж, хатагтайн мэндийг уламжлаад энэ дотор захиа бий гэж хэлээрэй гэсэн гэв.

Даалгавраа гүйцэтгэхчээд улаан хацарт залуу шалавхан гарч гүйхийн мөн болж байхыг хараад миний гайхаш төрж билээ.

Хэд гурван аятайхан юм асуух гэж түүнийг саатууллаа. Одоо Монтегю талбайд очвол бэргэнтэй уулзаж чадах болов уу? Үгүй, гадагшаа явсан. Мисс Рэчел хамт явсан, бас мистер Эблвайт сүүх тэргэнд нь цуг сууна билээ. Мистер Годфри тэтгэмжийн ажлаа хойш тавьсан нь юутай харамсалтай болохыг миний бие ойлгохын хажуугаар алмай амьтан шиг дэмий зугаацахаар мордсон нь тун хачирхалтай санагдав. Сэмуэлийг босгон дээр дахин саатуулан, бас хэдэн юм лавлав. Орой нь мисс Рэчел бүжигт үдэшлэгт очих гэж байгаа, мистер Эблвайт оройн цайнд ирээд хамт явахаар болзсон гэнэ. Мистер Эблвайт зэрэг нэлээд хэдэн хүнд маргааш өглөөний концертын билет ав гэж Сэмуэлд тушаасан ажээ.

-Хатагтай би одоохон гүйхгүй бол билет дуусчихаж магадгүй гэж тэр гэнэн залуу хэлэнгээ гүйн одов.

Миний толгойд элдэв янзын түгшүүрт бодол эргэлдэн ганцаар хоцорлоо.

Бид тэр үдэш “Хувцас хасаж оёх эхчүүдийн нийгэмлэг” дээр мистер Годфригээс тусламж, зөвлөгөө авах зорилгоор зориуд зохих шуурхай хуралтай байсан юм. Гэтэл өчнөөн төчнөөн өмд овоорч манай муу өчүүхөн хороог дарж гүйцээд байхад эгч дүсдээ тусалж, дэмжихийн оронд Монтегю талбайд, айлд кофе ууж, дараа нь бүжигт үдэшлэгт явах гэж байдаг! Маргааш орой нь “Британы бүсгүйчүүдийн ням гаригийн мөргөлийг хянах нийгэмлэгийн” баяр наадам хнийхээр товлосон байв. Тэнд оролцож, оршин тогтнох эрхийнхээ төлөө яггүй тэмцэж буй энэхүү нийгэмлэгийн амин сүнс нь болж байхын оронд өглөөний концертод очно гэж сүсэг бишрэлгүй хүмүүст ам өгч байдаг! Энэ ер юу болж байна гэж би өөрөөсөө асуув. Ай зайлуул, манай христос мөргөлтөн баатар эрийн цоо шинэ чанар илэрч, манай үеийн хамгийн аймшигт нүгэл хилэнцтэй холбоотойгоор санаанд буух боллоо.

Гэвч өнөөдрийн явдалд эргэн орсугай. өрөөнд ганцаар үлдсэн хойно, нөгөө улаан хацарт залууг тэгтэл хачин жигтэй айлгасан боодолтой зүйл үнэндээ миний сонирхлыг татсан юм. Бэргэн надад амласан өв хөрөнгөө илгээв үү? Тэр нь хуучирсан хувцас хунар, элэгдсэн мөнгөн халбага, сэрээ, хоцрогдсон аар саар зүйл гээд есөн шидийн юм болов уу? Юу ч байлаа гэсэн ундууцалгүй бүгдийг авахаар зэхэн боодолтойг задалтал, юу харагдсан гэж санана? Өчигдөрхөн би тэднийд тарааж тавьсан арван хоёр нандин номыг докторын заавраар надад буцааж явуулсан юмсанж! Үүнийг

миний өрөөнд оруулахдаа залуу Сэмуэл чичрэхгүй байж яахин чадах билээ! Ийм жигшүүрт даалгавар гүйцэтгэж явсан хойно ум хумгүй зугтахаас ч яах вэ? Бэргэн захидалдаа, хөөрхий зайлуул, эмчийнхээ үгнээс зөрж зүрхлээгүй гэж товчхон мэдээлжээ.

Одоо хэрхвэл зохих вэ? Олсон хүмүүжил, баримталдаг зарчимдаа тулгуурлан би ганц ч хурам тээнгэлзсэнгүй.

Нэгэнт нинжин сэтгэлдээ хөтлөгдөж дотнын хүнийхээ тусын тулд зүтгэсэн л бол жинхэнэ христос мөргөлтөн хүн сэтгэлээр унана гэж үгүй. Бид аруин үйлсээ эхэлсэн цагт олон нийтийн ч, хувь хүний ч нөлөө ятгалганд огт автдаггүй билээ. Алба гувчуур, үймээн самуун, дайн дажин гэгч бүгд л нэг хувь тавилангийн үр буй заа. Бид бол, бидэнд падгүй хорвоогийн амьдралыг хөдөлгөж байдаг хүмүүсийн үзэл бодлыг эс хайхран ажил үйлсээ үргэлжлүүлдэг хүмүүс юм. Бид бол оюун ухаанаас давуу чанартай, доог тохуунд өртөмгүй нандин бөгөөд зөвхөн өөрийн нүдээр үзэж, чихээр сонсож, зүрх сэтгэлээр мэдэрдэг улс билээ. Гайхамшигтай, үнэхээр дархан эрх ямба шүү! Үүнийхээ ачийг хэрхэн хариулж байна вэ? Ай, нөхөд минь, та нар хэрэггүй юм асуухгүй байван байж болно! Тийм эрх ямбыг зүй зохисоор нь хариулж чадах улс гэвэл зөвхөн бид л байна. Төөрөлдсөн бэргэнд маань тохиолдсон энэ хэрэгт миний тууштай сүсэг бишрэл зайлшгүй оролох ёстой болсон нь надад даанч илэрхий байв.

Вериндер ахай илэрхий дургүйцсэний харгайгаар клерикал нөхдийнхөө тусламжаар түүний биеийг нөгөө ертөнцөд очих замд нь бэлтгэх ажил нурлаа. Номын тусламжаар бэлтгэх ажил тэрслүү докторын зөрүүд аашилсны балгаар нуржээ. Тэгсэн л байг! Одоо яах вэ? Одоо захидал зурвасыг ашиглах үлджээ. өөрөөр хэлбэл орхисон ном буцаасан болохоор номноос хэсэг хэсгийг сонгож, өөр өөр хүнээр хуулуулаад янз бүрийн газраас, заримыг нь шуудангаар, заримыг нь түрүүн хэрэглэсэн аргаараа гэрт нь тарааж тавъя. Захиа учраас сэжиг төрүүлэхгүй, захиа учраас задална, задлах юм бол уншиж ч магадгүй.

Хэдэн захиаг би “Хонгор бэргэн минь, энэ хэдэн мөрийг анхааран толилно уу?...” “Хонгор бэргэн минь, би өчигдөр үүнийг уншиж суугаад доорх зүйлийг санаандгүй харав..” гэсэн үгээр эхэлж өөрөө бичлээ. “Хувцас хасах эхчүүдийн нийгэмлэгийн” сайн сэтгэлт хамтран зүтгэгч, эгч дүүс маань бусдыг нь бичиж өгсөн билээ. Үүнд, “Эрхэмсэг хатагтай, номхон хүлцэнгүй боловч үнэнч шударга анд нөхрөөс чинь таныг халамжлан анхаарч буйг соёрхоно уу”, “Эрхэмсэг хатагтай, төлөв төвшин хүн таны сэтгэлийг амраах хэдэн үг хэлэхийг зөвшөөрөн үү?” гэх мэтийн эелдэг үгээр хандаж, үнэтэй нандин номнуудаа, ажигч гярхай, тэрслүү доктор ч огт сэжиг авахааргүй хувилан явуулж чадсан юм. Үдшийн бүрий нөмрөхөөс өмнө би бэргэндээ арван хоёр сургаалын номын оронд арван хоёр сургаалын захидал бэлэн болгосон байлаа. Зургааг нь нэн даруй шуудангаар илгээж, бусдыг нь дараачийн өдөр өөрийн гараар тэдний гэрт тараахаар шийдэж, халаасандаа хадгалав.

Хоёр цагийн дараа бие буянт үйлсийн төлөө тэмцэлд дахин орж, Вериндер ахайн үүдэнд Сэмуэлээс бас хэдэн зүйл эелдгээр асуун зогсож байлаа. Бэргэн тух муутай унтжээ. Миний бие гэрчээр байлцаж, гэрээслэл баталсан өрөөнд ороод буйдан дээр дугхийх санаатай хэвтсэн гэнэ. Түүнтэй уулзаж магадгүй хэмээн номын санд хүлээзнэе гэж хэллээ. Захидлуудаа л шалавхан энд тэнд хийх гэсэн бадрангүй эрмэлзэлдээ автагдчихаад Рчелийн байдлыг асууж сонирхоё гэж санасан ч үгүй. Байшинд нам гүм агаад концерт эхлэх цаг болжээ. Бэргэн болон баяр цэнгэл хөөцөлдөгчид (ай халаг, мистер Годфри хамт яваа!) бүгдээрээ концерт үзэхээр завдаж байгаа гэж лавтай итгээд тийм аятайхан боломж, чөлөө сиймхий миний мэдэлд бүрэн орсныг сайн үйлсдээ хавтайяа ашиглалаа.

Бэргэний өглөөний шуудангийн хамт, миний урьд шөнө илгээсэн сургаалын зургаан захидал битүүмжилсэн хэвээр номын сангийн ширээн дээр хэвтэж бйав. Тийм олон захиа унших тэнхээгүй байсан бололтой тэгэхээр хожим орж ирээд үүнээс олон захиа харваж сүрдэж магадгүй юм. Тийм болохоор авчирсан зургаан захианыхаа нэгийг, нөгөө зургаагаас онцгой тавьж сониуч занг нь хөдөлгөхийн тулд зуухан дээр орхив. Би нэгийг цайны өрөөний шалан дээр тавилаа. Өрөөнд түрүүлж орсон ямар ч зарц, бэргэнийг захиагаа унагачихаж гэж бодоод түүнд өгөх нь лавтай. Доод давхарт сайны үрийг цацаж дуусаад миний бие дээд давхарт хөнгөн шингэн алхлан гарав.

Зочны өрөөнд дөнгөж ортол, гадаа хаалгыг зөөлхөн, жигд цохих дуулдав. Намайг номын санд буцаж орохоос өмнө үүдний танхимд байсан нэгэн шалмаг залуу зарц хаалга онгойлгочихлоо. Би үүнийг нэг их хайхарсангүй. Бэргэний биеийн байдлаас болоод ерөнхийдөө зочин хүлээж авахаа больсон үе билээ. Гэтэл тэр хаалга зөөлөн, болгоомжтой тогшсон хүн онцгой эрх дархтай этгээд байсанд би хэрдхийн гайхсан юм. Миний сонсоогүй асуултанд хариулж байгаа бололтой Сэмуэлийн,

-Дээшээ гар л даа, эрхэм ээ гэх нь тов тодхон дуулдав.

Дараагийн эгшинд шатаар өгсөх эр хүний хөлийн чимээ гарав. Эднийд ийм ойр шадар ямар эр хүн байж таарах вэ? Ийм асуулт толгойд орж ирэхийн хамт хариулт нь зурсхийн бодогдлоо. Доктороос өөр хэн байх вэ дээ?

Ямар ч хүн байлаа гэсэн би зочны өрөөнд тааралдахаасаа дургүйцэхгүй сэн. Номын санд хүлээж, хүлээж залхаад өөр өрөөнд ороход болохгүй нь юү билээ. Гэтэл миний номыг буцааж, намайг доромжилсон хүнтэй нүүр учрахыг хүсээгүй юм. Зочны арын өрөөтэй холбосон бяцхан тасалагаг санаж, тийшээ ороод үүдний хөшгийг хаав. Тэнд нэг, хоёр минут азнавал бүх юм хэвийн өнгөрнө. Өөрөөр хэлбэл, докторыг өвчтөний өрөөнд оруулна.

Би ганц, хоёр минутаас ч удаан хүлээлээ. Нөгөө зочин урагш хойш зосголтгүй холхих агаад бас амандаа дүнгэр дүнгэр үглэх нь сонсогдов. Би дууг нь таньдаг ч юм шиг санагдав. Эндүүрсэн юм биш байгаа? Доктор биш, өөр хүн юмуу даа? Жишээлбэл мистер Брафф ч юм уу? Үгүй Би мэргэн зөнгөөрөө мистер Брафф биш гэдгийг мэдсэн юм. Хэн ч байлаа гэсэн, эр хүн амандаа үглэсээр ажээ. Би үүдний хөшгийг ялимгүй ярж, чих тавилаа.

“Өнөөдөр л амжуулан!” гэсэн үгс чих дэлссэн бөгөөд тэр бол Мистер Годфри Эблвайтын дуу байв.

## Ү бүлэг

Би өөрийн эрхгүй хөшигнөөс гараа авав. Гэвч намайг туйлын хүнд байдалд орсондоо балмагдаж сандарсан гэж бүү бодоорой, ай халаг, тэгж л бүү бодоорой! Мистер Годфрийг эгчийн ёсоор анхааран халамжлах сэтгэл асар их тул яагаад концертэнд очоогүй юм бол гэж ч санасангүй. Үгүй шүү! Харин саяхан амнаас нь гарсан үгийг тэр аюумшигт үсгийг л гайхан бодож байлаа. Өнөөдөр нэг юм хийх ёстой байжээ. Яахаас ч үл буцах өнгөөр тэгж хэлсэн билээ. Юу, чухам юу хийх гэсэн юм бол! Нэгэнт үйлдсэнээс ч долоон дор зохисгүй юм хийх гэж байна уу? Сүсэг бишрэлээ хаях гэж байгаа юм биш биз? Эхчүүдийн нийгэмлэгээс хөндийрөх гэж байгаа юм биш биз? Манай хороон дээр дахиад ялдам сайхан мишээлтээ хайрлахаа болино гэж үү? Зүйрлэшгүй уран үгсийг нь Экстерийн танхимд дахиад сонохгүй юм гэж үү? Иймэрхүү аймшигтай явдал гарч болзошгүй гэж бодохоос сэтгэл жигтэйхэн үймэрч догдолсны улмаас нуугдсан газраасаа даруйхан гүйж гараад Лондон дахь эмэгтэйчүүдийн хороодын нэрийн өмнөөс гуйж гувшихаас ч буцахгүй болчихоод байтал гэнэт өөр хүний дуу гарав. Хөшигний цаанаас тод сонсогдох тэрхүү эмэгтэй хүний сэтгэл булаам өнгө аяс өчүүхэн ч үгүй, чанга, эршүүд дуу бол Рэчел Вериндерийн дуу байжээ!

-Годфри, та яагаад ийшээ ирээ вэ? Номын санд орохгүй яасан юм бэ? Гэж асуулаа.

Годфри аяархан инээд алдаад,

-Мисс Клак номын санд байгаа гэнэ гэв.

-Клак ий? Хэмээгээд Рэчел буйдан дээр сууж

-Годфри, таны түмэн зөв. Би энд байсан нь дээр гэлээ.

Нэг хуримын өмнөхөн би хэрхэхээ үл мэдэн, сэтгэл хөөрөн сандарч байлаа. Харин одоо бол сэтгэл хөрч эргэлзэн тээнгэлзэхийг болив. Тийм үг сонсчихоод ил гарах аргагүй юм. Зууханд л орохгүй юм бол өөр нуугдчихаар газар байсангүй. Тэгэхээр зовж тарчлах л үлдлээ. Тэр хоёрыг харж, үгий нь сонсож болохойцаар хөшгийг болгоомжтой яраад эртний христос шашинтнуудын үлгэр жишээг даган зовлон зүдгүүрийг тосон хүлээлээ.

-Буйдан дээр битгий суу. Сандал ав. Би хүнтэй ярихдаа өөдөөс нь харах дуртай гэж залуу бүсгүй хэлэв.

Мистер Годфри хамгийн ойр байсан сандал дээр суулаа. Тэр нь түүн шиг өндөр хүнд дэндүү намдсан сандал ажээ. Мистер Годфрийн хөл тийм эв дүйгүй таарийж байхыг би ер үзээгүй билээ.

-За, за та тэдэнд юу гэж хэлэв дээ? Гэж Рэчел асуув.

-Хонгор Рэчел минь, таны хэлснийг л хэллээ.

-Өнөөдөр ээжийн бие тааруухан байгаа, намайг ээжийгээ орхиод концерт үзэж чадахгүй нь гэдгийг үү?

-Яг тэгж хэлсэн. Таныг ирээдгүйд харамсавч, таны байдлыг бүрэн ойлгож байна билээ. Бүгдээрээ таны амрыг эрж, Вериндер хатагтайн бие удахгүй эдгэрнэ гэж найдаж байгаагаа илэрхийлсэн шүү.

-Та ээжийн өвчнийг гайгүй гэж бодож байна уу?

-Тэгэлгүй яахав! Хэд хоногоос бие нь сайжирч зүгээр болно л доо.

-Би ч бас тэгж бодох юм. Эхлээд баахан айсан, гэхдээ одоо гайгүй гэж бодож байна. Та бараг танихгүй хүмүүс дээр очиж миний өмнөөс уучлал гуйж их тус боллоо. Гэвч яагаад концерт үзээгүй юм бэ? Та тэр хөгжмийг сонсолгүй өнгөрөөдөг тун ч харамсалтай.

-Рэчел минь, битгий ингэж ярь! Энд, тантай цуг байхдаа хэчнээн жаргалтай байгааг минь мэддэг ч болоосой!

Годфри алга хавсран түүнийг ширтэнэ. Ингэж суухад царай нь нааш хандсан байв. Экстериин танхимын индэр дээр гараад сая сая үгээгүү хоосон ахан дүүсээ өмгөөлөн хамгаалж ярихдаа сэтгэл татан уяраадаг шинж нүүрэнд нь тодрохг хараад хэчнээн их зэвүүцэл төрснийг илэрхийлэн хэлэх үг эс олдоно!

-Сурсан занг сураар боож болдоггүй гэдэг. Гэвч та болж өгвөл, тал засдаг зангаа орхимоор юм даа.

-Рэчел минь, би энэ насандаа танд тал засаж яваагүй. Азтай дурлад заримдаа гоё сайхан үг хэлдэг л байх. Харин, хайрт минь, бүтэлгүй дурлалд хүн ямагт үнэнийг л ярьдаг юм.

Сандлаа бүр ойртуулж “бүтэлгүй дурлал” гэж хэлэхдээ Рэчелийн нэг гарыг атгаад авав. Минут хэртэй чимээгүй болцгоов. Хүн бүхний сэтгэлийг хөдөлгөн догдлуулдаг тэр эр Рэчелийг ч бас уярааснаас зайлахгүй. Зочны өрөөнд ганцаар байхдаа “Өнөөдөр л амжуулъя!” гэж үглээд байсны учрыг би сая ухаарах шиг болов. Дээд зэргийн даруу төлөв хүн ч түүнийг чухам юу хийх гэж буйг нь одоо төвөггүй гадарлах буй заа!

-Хөдөө байхад юу гэж тохиролцсоноо та мартчихаа юу? Хоёулаа үеэл нар байхаас цааш хэтрэхгүй гэж тохирсон биз дээ.

-Рэчел ээ, би таныг харах бүрдээ хэлэлцсэн үгээ мартаж юм.

-Тэгвэл надтай уулзах хэрэггүй.

-Тэгээд ч ашиггүй! Таныг бодох бүрдээ хэлэлцсэн үгээ мартдаг юм шүү. Ай, Рэчел минь, та намайг урьдынхаасаа арай сайнаар үзэх болсноо хэдхэн хоногийн өмнө хэчнээн ялдамхан хэлсэн билээ! Би тэр сайхан үгэнд чинь найдаад солиорч байна уу? Таны зүрх сэтгэл уярч надад нааштай хандах өдөр ирнэ гэсэн мөрөөдөл минь дэмий хэнээрхэл гэж үү? Солиорч байна гэж надад бүү хэлээрэй! Хонгор минь, намайг ингэж төөрөлдсөн хэвээр нь орхи! Надад өөр юм үлдээгүй бол мөрөөдлөөр сэтгэлээ зогоож, тайтгаруулж явъя!

Түүний хоолой зангирч, цагаан алчуураар нүдээ дарав. Дахиад л Экстериин танхим санаанд орлоо! Яг адилхан болоход нь сонсогч олон, дэмжин уулгалах дуу, шилэн аятай л ус л дутаж байв!

Рэчелийн царцанги сэтгэл хүртэл уярчээ. Годфри рүү ялимгүй тонгойх нь харагдав.

Годфри, та намайг үнэхээр тэгтлээ их хайрлаж байна уу? гэж асуух дуунд нь цоо шинэ сонирхсон аяс сонсогдлоо.

-Үнэхээр ий? Рэчел та намайг ямаршуу байсныг мэднэ. Одоо ямар хүн болсноо хэлье л дээ. Би хорвоо дээр танаас өөр юу ч сонирхож, бодохоо больсон. Би зөндөөн өөрчлөгдлөө, өөрөө ч тайлбарлаж чадахгүй байна. Та үнэмших үү? Өгдөг буяны ажил одоо тэсвэрлэшгүй тээртэй санагдах болж, эмэгтэйчүүдийн хороог үзэхээрээ ертөнцийн цаад мухар хүртэл зугтахас ч буцахгүй болжээ!

Түүх шастираас сүсэг бишрэлээ огоорсон тухай үүнтэй зүйрлэх юм байдаг бол огт олж уншаагүй гэхээс өөр хэлэх үг алга. “Хувцас хасах эхчүүдийн нийгэмлэг”, “Ням гаригийн мөргөлийг хяах нийгэмлэг миний санаанд оров. Түүнчлэн энэ эрийн хүч чадлыг нуршгүй цамхаг мэтээр шүтэн түшиглэсэн тоо томшгүй олон нийгэмлэгүүд бодогдлоо. Мистер Годфрийн ачаар л хөл дээрээ тогтож алба ажлаа явуулдаг гэж хэлж болох эмэгтэйчүүдийн зөвлөлүүд санаанд оров. Гэтэл тэр мистер Годфри нь дөнгөж сая манай буянтай сайн үйлсийг залхмаар “тээртэй” гэж зүхэн, бидний дунд байснаас газрын мухар хүртэл зугтах хүсэлтэй боллоо гэж байдаг! Би зүй ёсны эгдүүцлээ тэсээд чимээгүй өнгөрөөхийн өмнө энэ бол миний ёс журмыг сорьсон хэрэг байсныг дурдах юм бол залуу бүсгүй над нар минь үйл хэргээ тууштай үргэлжлүүлэх зориг төгөлдөр болно биз дээ. Тэгэхдээ тэдний яриаг үг үсэг гээлгүй сонссон гэдгээ шударгаар нэмж хэлбэл зохино. Рэчел эхлээд ам нээв.

-Та надад ний нуугүй наманчлан ярилаа. Би бас танд нүглээ наманчилбал надад дэмий тэмүүлсэн сэтгэлээ татаж авахад чинь тус болохсон болов уу?

Мистер Годфри давхийв. Би ч бас давхийлээ. Түүнийг Саран чулууны хэргийн нууцыг тайлах нь гэж Годфри ч бодов, би ч бодов.

-Та намайг хараад, хорвоогийн хамгийн золгүй бүсгүй суу байна гэвэл итгэх үү? Энэ үнэн шүү, Годфри. Биеэ хүндэтгэх эрхгүй болохоос илүү золгүй муухай юм ер байх уу даа? Би одоо яг л тийм болчихоод байна гэж Рэчел үргэлжлүүлэн хэлэв.

-Хонгор Рэчел минь! Та өөрийгөө ингэж ярих үндэс өчүүхэн ч байхгүй шүү!

-Тийм үндэсгүй гэж та яаж мэдэж байгаа юм бэ?

-Ийм юм асууж болно гэж үү! Би таныг андахгүй учраас мэдэж байгаа юм. Хонгор минь, та дуугүй байлаа гээд үнэнч анд нөхдийн чинь хүндэтгэл огт буураагүй. Таны төрсөн өдрийн үнэт бэлэг алга болсон нь хачин санагдаж болно. Тэр явдалд та холбогдсон нь жигтэй сонин, бүр ч хачин санагдаж магадгүй...

-Годфри, та Саран чулууны тухай ярьж байна уу?

-Таныг тэр тухай л цухуйлгаж байна гэж бодоод...

-Би тэр тухай ерөөсөө дурсаагүй. Саран чулуу алдагдсан тухай хэний ч яриаг би сэтгэл төвдөхгүй, бардам сонсож чадна. Тэр алмазны түүх задрах цаг ирдэг юм бол, нэгэн олиггүй нууц хадгалах аймшигтай хариуцлагыг би биедээ үүрсэн болохыг, түүнчлэн миний бие өчүүхэн ч буруугүй гэдэг нь тэнгэрийн нар шиг тодорхой болно! Годфри, та намайг зөв ойлгосонгүй, тодорхой шиг ярьж л даа. Та надад биш, өөр нэг бүсгүйд хайртай гэж бод л доо.

-За тэгээд?

-Тэр бүсгүй танд огт тохирохгүй гэдгийг та мэдлээ гэж бод. Түүний тухай бодохоос ч танд басамжлалтай, тийм бүсгүйтэй амьдралаа холбоно гэж санахаас ч ичиж, нүүр чинь шатна гэж бод.

-За?

-Гэтэл энэ бүхнийг тоолгүй тэр хүнийг зүрх сэтгэлээсээ зайлуулж чадахгүй байна гэж бод. Та түүнд итгэж байсан үед түүний асаасан хайр сэтгэлийг мартаж болохгүй байна гэж бод. Тэр шившигт этгээдийн танд төрүүлсэн хайр сэтгэл... Ай, үүнийг илэрхийлэх үг хаанаас олох билээ! Намайг айлгахын хамт даллан татах энэ сэтгэлийг би эр хүнд хэрхэн ойлгуулж чадах вэ? Энэ бол миний амьсгалах агаар, бас намайг хөнөөх хор юм! Зайл! Миний ярьж байгааг ээ, солирсон байж таарна. Үгүй ээ, намайг битгий орхи, буруу бодолтой явж болохгүй! Биеэ хамгаалахын тулд би чадах бүхнээ хэлэх ёстой. Нэг зүйлийг санаж ав! Миний танд хэлсэн үгийг тэр хүн мэдэхгүй, хэзээ ч мэдэхгүй. Би түүнтэй уулзахгүй. Юу ч тохиолдлоо гэсэн би түүнтэй хэзээ ч, хэзээ ч уулзахгүй! Нэрийг нь битгий асуу. Алив, өөр юм ярьцгаая. Годфри, та эмнэлгийн мэдлэгээр хэр билээ? Би агааргүйтэж, амьсгаа боочих гээд байх шиг санагддаг ямар учиртай юм бол? Нус нулимс асгаруулахгүй, харин есөн шидийн юм донгосдог хийрхэл байдаг болов уу? Лав байдаг биз? За, ямар ч байсан хамаатай юу? Би таныг гомдоосон бол одоо та тэр гомдлоо хялбар мартаж биз. Одоо би таны сэтгэлд зүй ёсны байраа эзлэв үү? Намайг бүү анхаар! Намайг битгий өрөвд! Тэнгэрийг бодож, явж үз!

Тэгсэнээ огцом эргэж буйдангийн түшлэгийг балбаж жинтүүнд толгойгоо шаан цурхиран уйлав. Үүнийг хараад, би гайхаж ч амжаагүй байтал мистер Годфри огт санаанд оромгүй, хирдхийм явдал гаргаж намайг учиргүй айлгасан билээ. Мистер Годфри Рэчелийн өмнө өвдөг сөхрөн, бүр сөхөрч унасан гэвэл хүн итгэх үү дээ? Тэгээд бас тэвэрч авсныг нь хэлэхэд даруйуу биш болохгүй байх аа? "Ариухан бүсгүй минь!" хэмээн хоёрхон үг хэлж, түүнийг сэхээ авахуулахад нь би өөрийн эрхгүй бахдан шагшсан гэдгээ шударгаар хүлээсэн болно биз?

Мистер Годфри өөр юу ч хэлээгүй! Гэвч тэр үг олны дунд алдаршсан илтгэгийн урлагаар өгүүлсэн билээ. Рэчел балмагдсан ч юмуу, бахадсан ч юмуу, бүү мэд, гары нь зайлуулах гэж оролдох ч үгүй сууна. Миний хувьд гэвэл, ёс журмын тухай ойлголт маань бүр мухардаж орхисон юм. Би юуны түрүүнд нүдээ аньж, чихээ бөглөх ёстой байсан эсэхийг үл мэдэн тарчлавч, нүдээ ч аниагүй, чихээ ч бөглөөгүй билээ. Миний бие бүхнийг алдалгүй харж, сонсохын тулд үүдний хөшигнөөс зохих ёсоор барьж зогсоон маань зөвхөн хийрхэл хөдөлсний гай байсан юм. Хийрхсэн үед ямар нэг юмнаас сайн барих хэрэгтэй гэдгийг эмч нар ч зөвшөөрнө.

-Тийм ээ, та бол ариун шударга бүсгүй! Үнэн мэнийг хамгаалж үнэнийг ярьж чаддаг, мөн өөрийг нь хайрладаг шударга эрийг хохироохгүй гэж эрхэм нэр төрөө гаргуунд гаргахаас буцахгүй бүсгүй хүн бол ёстой олдшгүй эрдэнэ мөн. Тийм бүсгүй хадамд гарч, эр нөхрийгөө хүндэтгэх юм бол нөхөр нь насан туршдаа жаргал эдлэх нь тэр. Хонгор минь, та миний сэтгэлд эзэлдэг байрныхаа тухай түрүүн дурдсан. Шархдаж, эмзэглэсэн зүрхийг чинь анагаах эмчлэхийг надаад зөвшөөрөөч гэж өвдөг сөхрөн гуйж байгааг хөрөөд та миний сэтгэлд ямар байр суурь эзэлдгээ ойлгоно биз ээ. Рэчел ээ, миний эхнэр болж, намайг жаргаана уу? хэмээн уянгалаг сайхан хоолойгоор тэнгэрлэг ялдам байдлаар өгүүлэв.

Тэр үед би чихээ гарцаагүй бөглөх байсан авч миний уулзсанаас хойш Рэчелийн амнаас анх удаа ухаалаг үг гарсан учраас чих тавин сонссон юм.

-Годфри, та лав солиорчээ! Гэж хэллээ.

-Хонгор минь, та бид хоёрын ашиг сонирхлын үүднээс би энэ удаагийнх шиг ийм ухаалаг ярьж байсан удаагүй. Та ирээдүйгээ нэг зэрвэс хараад орхи л доо. Таны сэтгэлийг гадарлах үгүй байгаа хүний төлөө, та дахиад бараагийг нь ч харахгүй гэж шийдсэн хүнийхээ төлөө хохирох ёстой юм гэж үү? Өөрийгөө бодож тэр хайр сэтгэлээ мартаж нь таны үүрэг бус уу? Одоогин энэ амьдралдаа та юм мартагнахыг эрмэлзэх хэрэгтэй бус уу? Та энэ амьдралыг хангалттай амсаж, одоо бүр залхаж цөхөрлөө шүү дээ. Хорвоогийн ийм аар саар юманд санагаа зовоож байснаас арай эрхэм дээд зүйлд анхаарагтун. Таныг хайрлаж хүндэтгэдэг зүрх сэтгэл байна, нам тайван, жаргал цэнгэлтэй алба үүрэг нь өдөр хоног өнгөрөх бүр аажмаар татан дагуулах айл таныг хүлээж байна. Рэчел ээ, энэ тайтгарлыг амсаад үзээч! Би танаас хайр энхрийлэл шардахгүй, таны нөхөрлөл, хүндэтгэл надад хангалттай. Бусад зүйлийг орхи, эр нөхрийнхөө үнэнч шударгад, таных шиг ийм гүнзгий шархыг ч анагаах чадалтай улирах цаг хугацаанд бусад зүйлийг даатгаж орхи.

Рэчел түүний ятгалганд бүр автаж эхэлжээ. Ай-яа, ер яаж хүмүүжсэн хүүхэн гээч вэ! Би л түүний оронд байсан бол огт өөрөөр хариуцна даа!

-Годфри, намайг ятгасны хэрэггүй. Би тэртээ тэргүй зовж, цөхөрсөн хүн. Улам зовоогоод яах нь вэ?

-Ганцхан юм асууя. Та намайг жигшиж байна уу?

-Би юү? Би танд дандаа сайн байдаг. Сая хэлснийг чинь сонсоод таныг хүндэтгэж бахрахгүй бол ёстой хуншгүй этгээд болох биз ээ.

-Хонгор Рэчел минь, та эр нөхрийгөө хүндэтгэж, бахархдаг эхнэр олныг мэдэх үү? Гэлээ ч тэд нөхөртэйгөө жаргалтай сайхан суудаг шүү дээ. Болзоот хархүүдээ зүрх сэтгэлээ нээн илчлээд гэрлэх ёслол үйлддэг сүйт бүсгүй олон байдаг гэж үү? Гэлээ ч тэдний гэр бүлийн амьдрал зовлон болдоггүй, харин тэрүүхэндээ болоод л байдаг. Үүний учир бол эмэгтэйчүүд гэр бүлийн амьдралд өмөг түшиг, толгой хоргодох газар эрэлхийлэх нь санаснаас илүү бйадаг юм. Түүнээс гадна тэрхүү итгэл, найдвар нь гэр бүлийн амьдралд хөсөрдөөгүй болохыг хожим нь мэддэг юм. За, өөрийнхөө байдлыг дахиад нэг хар л даа. Тан шиг ийм залуу зандан, сайхан зүс царайтай бүсгүй ганц биеэр насыг барна гэж шийдэж болох уу даа. Амьдралын мэдлэг туршлагад минь итгэ, таны хувьд тийм амьдрал даанч бололцоогүй юм. Түр зуур тэгж явж болно л доо. Хэдэн жилийн дараа өөр хүнтэй гэрлэж болно. Эсвэл хонгор минь одоо таны хөлд сөхөрч, ертөнцийн аливаа бүсгүйн хайр сэтгэлээс таны хүндэтгэл, бахархлыг эрхэмлэн дээдэлж буй хүний гэргий болж ч магадгүй.

-Годфри, больж үз! Урьд өмнө төсөөлөө ч үгүй явсан зүйлийг та надад итгүүлэх гэж байна. Миний хамаг найдвар хөсөрдсөн үед та цоо шинэ найдвар төрүлж, миний сэтгэлийг татах гэж байна. Танд дахин хэлэхэд, би даанч зовж, цөхөрсөн болохоор таныг би нэг үг л дуугарах юм бол таны хэлсэн болзлыг зөвшөөрч гэрлэхээс буцахгүй юм шиг байна шүү. Энэ сануулгыг ашиглаж, одоохон явж үз!

-Таныг зөвшөөрөхөөс нааш би босохгүй.

-Би зөвшөөрчихвөл нэгэнт оройтсон хойно би харамсана, та ч харамсах болно шүү дээ!

-Би зүтгэсээр дийлж, та бууж өгсөн тэр өдрийг хоёулаа ерөөх болно, хонгор минь.

-Та ярьж байгаа шигээ үнэхээр итгэлтэй байна уу?

-Та өөрөө эргэцүүлээд үз л дээ. Би эцэг, эхийнхээ амьдралыг жишээлж ярья. Манай гэрийнхний тухай та юу гэж бодож байна вэ? Манай эцэг, эх хоёрын амьдрал жаргалгүй байна уу?

-Хаанаас даа, харин жаргалтай харагддаг шүү.

-Эх маань охин байхдаа (энэ тухай манай гэрийнхэн бүгдээрээ андахгүй) тан шиг л нэг хүнд, өөрт нь тэнцэхгүй эрд хайр сэтгэлээ өгсөн байжээ. Тэгээд манай эцэгтэй гэрлэж, эцгийг хүндэлж, бахархдаг, түүнээс цаашгүй. Эцсийн дүнг нь та нүдээрээ харсан. Энэ амьдралд та бид хоёрыг урамшуулан зоригжуулахгүй гэж үү?

-Годфри, та намайг шавдуулахгүй биз?

-Хэдийд хариу өгөх нь таны дурын хэрэг.

-Миний хэрээс хэтэрсэн юм шаардахгүй биз дээ?

-Хонгор минь, надад биеэ л даатгаач гэж хүсье.

-Даатгаж байна!

Ийм хоёр үг хэлж, түний саналыг зөвшөөрлөө. Мистер Годфри дахиад л хөөрч, сүйд болов, энэ удаад шалиг занагар баясан хөөрлөө. Рэчелийг биедээ дөхүүлэн татсаар нүүрэнд нь нүүрээ ойртуулж тэгснээ... Үгүй ээ, үнэндээ энэ зохисгүй явдлыг цааш дүрслэн өгүүлэн сэтгэл үл төвдөнө. Харин миний бие нүдээ анихаар завдсан боловч ганцхан хурмаар хожимдсон байснаа л хэлэхийг зөвшөөрнө үү. Рэчелийг эсэргүүцэх болов уу гэж би бодож байв. Гэтэл Рэчел аяыг нь дагав. Аливаа журамт бүсгүйн хувьд, бүхэл бүтэн боть ном ч үүнээс илүү ихийг хэлэхгүй буй заа.

Тиймэрхүү хэргийн талаар төсөөлөлгүй, гэнэн хонгор хэдий боловч би энэ яриа хаашаа хандахыг гадарлаж эхэлсэн юм. Тэд одоо хоёр биеэ дэндүү сайн ойлгож байгаа болохоор гэрлэх ёслол гүйцэтгэхээр хөтлөлцөн гарч явах нь гэж санаж билээ. Гэвч бас нэг хоосон ёсорхол заавал үйлдэх ёстойг мистер Годфрийн хэлсэн хэдэн үг сануулсан юм. Рэчелийн хажууд буйдан дээр (энэ удаа саад хийсэнгүй) суугаад,

-Ээжтэй чинь би ярих уу, эсвэл та ярих уу? гэж асуув.

Рэчел аль алиныг үл зөвшөөрөн,

-Ээжийн биеийг сайжиртал юм ярьсны хэрэггүй. Одоохондоо нууц баялгая. Одоо та яв, өнөө орой ирээрэй. Энд хоёулаа зэгсэн удаан суучихлаа гэв.

Тэгээд босохдоо миний бие зовж тарчлан зогсож байсан жижиг тасалгааны зүг гэнэт харснаа,

-Энэ хөшгийг хэн татчихаа вэ? Хэмээн дуу алдаад, -Тэртэй тэргүй бүгчим байхад салхи орж л байг гэлээ.

Рэчел хөшиг рүү дөхөв. Намайг гарцаагүй илрүүлэхийн даваан дээр хөшгинд гараа дөнгөж хүргэтэл нөгөө улаан хацарт зарц залуугийн дуу шатан дээр гарч, Рэчел бид хоёры зогтуслаа. Тэр бол учиргүй айж сандарсан хүний дуу байв.

-Мисс Рэчел! Мисс Рэчел та хаана байна? Гэж хашгира.

Рэчел хөшигнөөс давхийн холдож, үүд рүү ухасхийлээ.

Зарц ч өрөөнд орж ирэв. Улаан царай нь зөвхий цайжээ.

-Авхайтан, доошоо очооч! Хатагтай ухаан алдаад, бид сэргээх гээд дийлдэггүй!

Төдхөн би өрөөнд ганцаараа үлдэж, дараагийн эгшинд хэнд ч сэжиг авахуулалгүй доошоо бууж чадав.

Үүдний танхимд мистер Годфри доктор авчрахаар миний хажуугаар яарч тэвдэн өнгөрөхдөө

-Очиж туслаач! Хэмээн өрөөний зүг заан хэлэв. Намайг ороход Рэчел эхийнхээ толгойг энгэртээ наан тэврээд буйдангийн өмнө сөхрөн сууж байлаа. Бэргэнийхээ царайг би ганц хараад л (өмнө нь ингэнэ гэж гадарлаж байсан тул) аймшигт үнэнийг ойлгосон юм. Гэвч эмчийг иртэл би бодлоо ил гаргасангүй. Эмч нэг их удсангүй ирэв. Эхлээд Рэчелийг өрөөнөөс гаргаад, Вериндер ахай нас нөгчсөн хэмээн бидэнд мэдэгдлээ. Намайг харахдаа эмч өчүүхэн ч зовсон шинжгүй байсныг нь дуулгаавл, үл итгэх үхширмэл үзлийн жишээ сонирхдог төлөв томоотой хүмүүст их л сонин байхсан болов уу.

Дараа нь цайны өрөө, номын сангаар шагайв. Бэргэн миний захидлуудаас нэгийг нь ч задалж уншилгүй амьсгал хураасан байлаа. Тэгэхэд би айхтар гонсойж, урам хугарсан тул надад амласан бяцхан эд хөрөнгөө үлдээж амжилгүй нас нөгчсөн гэдгийг бодоо ч үгүй бөгөөд энэ тухай хэд хоногийн хойно л санасан билээ.

## ҮІ бүлэг

(1). Мисс Клак мистер Фрэнклиний амрыг эрэн ёсолж, ядуухан хүүрнэлийнхээ тавдугаар бүлгийг илгээхийн хамт Вериндер хатагтай нас эцэслэсэн ийм аймаар уй гашуу тохиолдсон байхад хүүрнэлээ цааш үргэлжлүүлэн бичихийг даанч зохисгүй гэж үзэж буйгаа зориглон уламжилжээ. Тийм учраас мисс Клак ховор нандин шастируудаасаа энэхүү хэцүү сэдэвт холбогдох ишлэл өчнөөн төчнөөнийг авч, гар бичмэлдээ хадсан байв. Эдгээр ишлэл нь мисс Клакийн чин сэтгэлээсээ хүсэж байгаачлан түүний хүндэт хамаатан мистер Фрэнклин Блэйкийн чихэнд бүрэн дуу мэтээр хангинаж болзошгүй юм.

(2). Фрэнклин Блэйк, мисс Клакийн амрыг эрж, ёслоод хүүрнэлийнх нь тавдугаар бүлгийг хүлээн авч талархсанаа илэрхийлэв. Нөгөө ишлэлүүдийг захианы хамт буцаахдаа номын тэдгээр хэсгүүд сэтгэлд нь үл нийцсэнийг дурдахаас түдгэлзэн эдгээр нэмэлт нь түүний хийх ажилд чухаг биш гэж зүгээр л мэдэгдсэн байна.

(3). Мисс Клак ишлэлүүдээ хүлээн авснаа мэдэгдээд өөрийгөө христос шашинтан бүсгүй, тийм ч учраас Фрэнклин Блэйк түүнийг гомдоож дорожлох хэрэггүй хэмээн эвтэйхэн сануулжээ. Мисс К мистер Блэйкийг ихэд анхааран сонирхож, өвчинд нэрвэгдэн хэвтэж болзошгүй хожмын нэгэн өдөр нөгөө ишлэлүүдээ дахин өгч тус болно гэж дотроо тангарагласан байна. Тэгэх зуур, хүүрнэлийнхээ сүүлчийн бүлгүүдийг бичиж эхлэхийн өмнө, Саран чулууны хэргийн нууцыг сөхөхөд хожим тус болсон мэдээ баримтыг ашиглан өөрийн даруухан өгүүлэмжийг гүйцээснээ мисс Клак мэдсэн бол баярлахсан.

(4). Мистер Фрэнклин мисс Клакийг гомдоосондоо өршөөл гуйлаа. Тэгээд хүүрнэл бичиж эхлэхийн өмнө түүнд өгсөн заавраа давтжээ. Хүмүүс болон үйл явдлын талаар хийсэн хувийн дүгнэлтээ өдрийн тэмдэглэлдээ бичсэнээр хязгаарлахыг түүнээс хүсчээ. Гэрчийн хувиар уг түүхийг үргэлжлүүлэн бичиж чадах хүмүүст хожмын нээлтүүдийг найр тавин үлдээх буй заа.

(5). Мистер Фрэнклин Блэйкд дахин нэг захиа илгээж төвөг удсандаа мисс Клак туйлын их харамсаж байна. Түүний ишлэлүүдийг буцааж, Саран чулууны хэргийн талаар сайтар бодож, тунгаасан дүгнэлтээ илэрхийлэхийг нь хориглов. Дуугий нь хорьж буйг ойлгоод машид эмзэглэжээ. Мисс Клакийн хүүрнэлд эдүгээгийн захидал харилцаагаа оруулахыг ер нь юм бүхнийг цагддаг зантай Блэйк ноён зөвшөөрөх эсэхийг лавлах гэж энэ захиаг бичсэн байна. Мисс Клакт зохиогчийнх нь хувьд мистер Блэйк саад хориг тавьж бйагаа явдлыг зарим талаар нийтээр дагах шударга ёсны үүднээс тайлбарлах юм. Мисс Клак захидлуудаа уншихад л аяндаа утга санаагаа илэрхийлж чадахуйц болгохсон гэж маш их чармайж байв.

(6). Мистер Фрэнклин Блэйк, мисс Клактай санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн бөгөөд тийн зөвшөөрснийг нь мисс Клак захидал харилцаагаа хаах гэсэн дохио хэмээн үзнэ гэж ойлгосны үндсэн дээр мэдэгджээ.

(7). Мисс Клакийг зориуд гомдоож, доромжлох санаа агуулсан Фрэнклин Блэйкийн сүүлчийн захидал зорилгодоо хүрч чадаагүй болохыг харилцаагаа зогсоохын өмнө мэдэгдэхийг мисс К. Христос шашитны үүрэг гэж үзэв. Тэгээд мистер Блэйкийг өрөөндөө ганцаархнаа суугаад хөөрхий нэг бүсгүйг хэмээс хэтэртэл доромжлох нь сайн чанар мөн эсэхийг, түүнчлэн одоо үзэж буй шигээ тэгтэл их бахархах нь зөв эсэхийг эргэцүүлэн бодохыг мистер Блэйкээс эелдгээр хүссэн юм. Тийн сануулсны дараа ч мисс К. нөгөө ишлэлүүдээ бүрэн бүтнээр нь Фрэнклин Блэйкд илгээнэ хэмээн өөртөө баяртайгаар андгайлжээ.

(Энэ захианд хариу авсангүй. Үүнд тайлбар хэрэггүй биз. Гарын үсэг Друзилла Клак).

## ҮII бүлэг

Миний бие, тавдугаар бүлгийн эцэст ямар учраас Вериндер ахай нас нөгчсөн тухай зүгээр л дурдаад өнгөрөөхөөс өөр аргагүй болсныг дээр толилуулсан захидал харилцаа танд тодорхой тайлбарлаж өгнө. Бэргэн талийгаач болоод даруй нэг сар өнгөрсний дараа би Рэчел Вериндертэй уулзсан гэдгийг хэлбэл зохино. Би түүнтэй хэдэн өдөр нэг гэрт суусан юм. Чухам тэр үед Рэчел, Годфри Эблвайттай сүй тавьсантай холбоо бүхий нэг явдал тохиолдсоныг энэ хуудсанд зориуд тэмдэглэвэл зохино. Энэхүү гэр бүлийн сүүлчийн аягүй хэрэг явдлыг өгүүлчихвэл би зохиогчийн үүргээ гүйцэтгэх нь тэр. Яагаад гэвэл би өөрийн эрхгүй уг хэргийн шууд гэрч болсны хувьд мэдэх бүхнээ уламжлах болно.

Бэргэний шарилыг Лондонгоос гаргаж, сүмийн ойролцоо цэцэрлэгийнх нь бяцхан оршуулгын газар хөдөөлүүлсэн юм. Хөдөөлүүлэх ёслолд миний бие бусад хамаатан садны хамт оролцохоор болов. Бэргэний нас барахад шашин шүтлэгийн үүднээс цочирдож балмагдаад нэлээд хэд хоног сэхээ авч чадахгүй явлаа. Тэгтэл бас хойтохыг нь Фризинхоллын санваартан гүйцэтгэх юм гэнэ. Тэр тэрслүү этгээдийг урьд Вериндер ахайнд хөзөр наадаж суухад нь тааралдсан учраас явах тэнхээтэй байлаа ч гэсэн оршуулах ёслолд оролцдог маань зохистой эсэхэд тээнгэлзэж байв.

Вериндер ахай охиноо хүргэн ах Эблвайтын асрамжинд орхиод ертөнцөөс халин оджээ. Гэрээслэл ёсоор Рэчелийг хадамд гартал буюу насанд хүртэл нь асрамжлах юмсанж. Мистер Годфри үеэл дүүтэйгээ тогтоосон шинэ харилцааныхаа талаар эцэгтээ мэдэгдсэн бололтой. Ямар боловч тэдний ураг бололцохоор тохирсон нь бэргэн нас нөгчөөд арав хонож байхад гэр бүлийн дотор хэдийн нууц зүйл биш болсон байв. Тэгэхээр бас нэг засаршгүй тэслүү этгээд, Эблвайт өвгөний хувьд асрамжлагчийн эрхийг хүүтэй нь гэрлэх гэж буй баян охины сонирхолд аль болохоор эвтэйхэн нийцүүлэх асуудал тун чухал болсон ажээ.

Эхлээд Рэчел суух байраа сонгох гэж мистер Эблвайтад яггүй төвөг удав. Монтегю талбайн байр эхийнх нь нас барсныг санагдуулаад байж. Иоркширийн байр Саран чулууны будлиантай хэргийг бодогдуулна. Харин асрамжлагчийнх нь Фризинхолл дахь гэр аль алинтай нь холбоогүй билээ. Гэвч саяхан ийм хүнд хагацал үзсэн Рэчел тэнд очвол үеэл охид нь зугаацаж цэнгэх аргагүй болох тул тохиромжтой цаг болтол хойшлуулъя гэж Рэчел өөрөө гуйжээ. Эцэст нь Эблвайт өвгөн Брайтонд нэг тохилог байр хөлслөн авах санал гаргав. Эхнэр нь өвчтэй охиныхоо хамт Рэчелтэй сууж, харин өвгөн хойноос нь сүүлд очихоор тохиролцов. Тэд хэдэн хуучин анд нараасаа өөр хүн урихгүй, Лондонгийн галт тэргээр өөд уруугүй зориж байдаг мистер Годфри тэдэнд үйлчлэхэд ямагт бэлэн байх болно.

Тэрхүү утга учиргүй нүүдэл суудал, биед ядаргаатай зовлон, сэтгэлд шаналгаатай уй гашууныг энд өгүүлсний учир бол тэдний эцсийн шийдвэрийг л үзүүлэх гэсэн билээ. Брайтонд байр хөлсөлж авсан нь Рэчел Вериндер бид хоёрыг дээд тэнгэрийн соёрхлоор дахин уулзуулсан юм.

Эблвайт эгч бол махлаг, биерхүү, цайвар үстэй, дуу цөөтэй, содон авиртай хүн. Хорвоод мэндэлснээсээ хойш өөрийнхөө төлөө нэг ч удаа, юу ч хийж үзээгүй, насан туршаа хүний гар харж, хүний үгээр явж иржээ. Шашин шүтлэгийн хувьд түүн шиг найдваргүй хүнтэй учирсан удаагүй билээ. Ер нь тогтсон зан чанар гэж ерөөсөө байхгүй хүнд яаж ч нөлөөлөх вэ дээ? Эблвайт эгч төвдийн далай ламын айлтгалыг яг л миний үгийг сонсож байгаа шигээ анхааран чагнаж, үзэл бодлыг нь бас л үг дуугүй зөвшөөрөн хэлэлцэх байсан нь дамжиггүй. Эблвайт эгч Лондонгийн нэг зочид буудалд байрлаж, буйдан дээр хэвтэж байгаад хүүгээ явуулж Брайтонд байр хөлслөн авчээ. Өглөө орондоо цай уух зуураа зарц, шивэгчин эрж, зугаалгын цагаас өмнө “мисс Клакийнд оччихоод

ир” хэмээн нэг шивэгчнээ явуулсан байна. Намайг арван нэгэн цагт очиход дэвүүрээр амарлингуй сэвэн унтлагын бошинзтойгоо сууж байв.

-Друзилла хонгор минь, би зарц хөлсөлж авмаар байна. Та хашир хүн, надад туслаач гэнэ.

Би замбараагүй хөглөрсөн өрөөг тойруулан харав. Сүмийн хонх өдрийн мөргөлийн цаг эхэлснийг зарлан дэлдэхэд бэргэнээ нөхөрсгөөр ятгаж сэнхрүүлэх хэрэгтэй гэдгийг би ухаарсан юм.

-Ай, эгч минь! Энэ байдал чинь христос мөргөлтөн англи бүсгүйд зохино гэж үү? Мөнхийн оронд иймэрхүү байдлаар залрах гэж үү? Хэмээн би гунигтайяа сануулав.

-Друзилла, та надад тусалж соёрхвол би одоо хувцаслая гэж бэргэн хариуллаа.

Ийм үг сонсоод юу ч гэх вэ дээ? Алуурчидтай ярилцаж гайхамшгийг бүтээж байса нминий бие Эблвайт эгчтэй яриад нэг ч сөөм ахиж байсангүй.

-Ямар, ямар зарц хөлслөх юм бэ, бичсэн үү?

Эблвайт эгч толгой сэгсрэв. Тэр бичгийг авчих ухаан ч сийлсэнгүй ажээ.

-Тэр өрөөнд Рэчелд бий, хонгор минь.

Би тэр өөрөө рүү орж, Монтегю талбайд салснаас хойш Рэчелтэй анх удаа учирлаа.

Гүн уй гансралд дарагдаад хачин өрөвдмөөр турж, жижиг ч болсон юм шиг харагдав. Хэрэв миний бие, хүний гадаад төрх зэргийн мөнх бус яль шальгүй юмыг сүрхий чухагт үзэн анхаардагсан бол, Рэчелийн царай зүс цагаан зах л зүүгээгүй бол тун аягүй үзэгддэг өнгөтэй байсныг нэмэн хэлж болох юм. Намайг ороход Рэчел суудлаасаа босож, гараа сунган тоссонд би учиргүй гайхаж билээ.

-Тантай уулзах яасан сайхан юм бэ. Друзилла, урьд би тантай тун мунхаг, их бүдүүлэг ярьдаг байжээ. Намайг уучлаарай, та уучилна биз дээ гэв.

Үүнийг сонсоод гайхаш тасарснаа би нууж чадаагүй бололтой, Рэчел улайснаа, тайлбараа үргэлжлүүлэн,

-Хөөрхий эхийн минь амьд сэрүүндээ үерхэж байсан нөхөд дандаа миний найз байсангүй. Одоо, эхийгээ алдсанаас хойш, миний зүрх сэтгэл эхийнхээ хайрлаж хүндэтгэж явсан хүмүүсээс тайтгарлыг эрэлхийлэн тэмүүлэх болов. Ээж танд сайн байсан. Друзилла, та чадвал миний анд нөхөр болооч дээ гэлээ.

Шалтгаанаа тэгж тайлбарлах нь юмыг ухаалгаар боддог аливаа хүнийг жигтэйхэн гайхуулах нь мэдээж. Христос мөргөлтэй Англи оронд ийм нөхөгдөшгүй хүнд хагацал амссан залуу бүсгүй, жинхэнэ амар амгалан чухам хаана эрвэл зохихыг үл мэдэн, харин эхийнхээ анд нөхдийн дунд эрэлхийжл байх юм даа! Хүмүүстэй эвгүй харьцаж байсан дутагдал, нүгэл хилэнцээ наманчилж, үүргээ ухамсарласны үндсэн дээр бус сэтгэлийн хөөрлийн нөлөөгөөр л ойлгосон нэг хамаатан гарч ирлээ! Үүнээс илүү гаслантай зүйл үгүй боловч буянтай үйл бүтээх хэрэгт туршлагажсан над шиг хүний хувьд горьдлдог тасраагүй юм шүү. Эхийгээ алдаад Рэчелийн зан авир хэр зэрэг хувирсныг магадлахад юу нь муу билээ гэж би сэтгэлээ. Үүний тулд эрхэмсэг Годфри Эблвайттай гэрлэхийг зөвшөөрснөө одоо хэрхэн үзэж буйг нь мэдвэл их л ашигтай сорилт болно гэж бодов.

Рэчелийн зан сайжирсны хариуд би бүхий л элэгсэг сэтгэлээ илэрхийлээд түүний урьсан ёсоор буйдан дээр хажууд нь суулаа. Бид гэр бүлийн хэрэг явдал, ирээдүйн төлөвлөгөөг хэлэлцэхдээ Рэчелийн гэрлэх тухай сэдвийг үргэлж тойроод байлаа. Яриагаа тийш чиглүүлэх гэж би хэчнээн оролдовч Рэчел миний битүү сануулгыг огт ойлгоогүй царайлна. Миний зүгээс тэр асуудлыг шууд хөндөнө гэдэг бол дөнгөж эв зүйгээ олж эхэлж байгаа үед арай хуумгүй хэрэг болно. Түүнээс гадан би мэдье гэсэн бүхнээ олж харсан юм. Одоо Рэчел, миний бие Монтегю талбайн байшинд зовлонгоо эдэлж байсан үедээ харсан шиг хөнгөмсөг, шазруун байхаа больжээ. Энэ бол дараагийн удаа ярилцахдаа түүнийг үгэндээ оруулж, эхлээд хадамд гарах асуудлыг хөнгөн хуудуу шийдсэнийг сануулж, аажимдаа арай нандин сэдвээр ярилцах боломжтой юм гэсэн найдварыг надад төрүүлсэн билээ. Одоо би Рэчелийг арай өөрөөр сонирхон харахдаа мистер Годфрийн гэрлэе гэсэн саналыг хөнгөмсгөөр яаран зөвшөөрснийг нь санаад алсдаа тэдний хэрэгт чин санаанаасаа оролцох нь миний ариун үүрэг мөн гэж үзсэн бөгөөд хошвор амжилтанд хүрнэ гэдэгт итгэл төгс байлаа. Тэр хэсэгт шалмаг түргэн ажиллах нь чухал гэж би бодсон. Нөгөө байранд ажиллуулах зарц, шивэгчин олох асуудалд нэн даруй шилжин орж,

-Жагсаалт хаана байна, хонгор минь? Гэсэнд Рэчел надад нэг бичиг өглөө. “Тогооч, сав угаагч, шивэгчин, зарц” гэж уншаад –Хонгор Рэчел минь, энэ зарц нарыг таны асрамжлагч тэр байшинг хөлслөх хугацаанд л түр ажиллуулна шүү дээ. Тийм богино хугацаанд ажиллуулах үнэнч шударга, дадлага туршлагатай хүмүүс Лондонгоос олъё гэвэл их л бэрхтэй. Брайтоны байрыг хөлслөөд авихсан уу? гэж би лавлалаа.

-Авсаан, Годфри авчихсан. Тэндэхийн зарц нар бас өөрсдийг нь хөлсөлж ажиллуулаач гэж гуйсан гэнэ билээ. Бидэнд тохирох эсэхийг нь мэдэхгүй болохоор шийдсэн юмгүй буцаад иржээ.

-Рэчел, та иймэрхүү хэрэгт ямар вэ?

-Маруухан даа.

-Эблвайт эгч энэ хэрэгт оролцож биеэ чилээхгүй нь үү?

-Үгүй ээ, хөөрхий минь. Друзилла, түүнийг зэмлээд яах вэ. Ер нь түүнээс өөр үнэхээр жаргалтай бүсгүй байхгүй биз ээ.

-Аз жаргалд янз бүрийн хэмжээ байдаг юм, хонгор минь. Энэ сэдвээр хожим жаахан ярилцах нь зүйтэй юм байна. Харин одоогоор зарц, шивэгчин сонгож олох хэцүүхэн үүргийг хүлээж авъя даа. Таны нагац эгч тэр байшингийн хүмүүст нэг захиа бичээд...

-Би өмнөөс нь биччихвэл гарын үсэг зурчихна аа. Ялгаа юу байх вэ.

-Огт ялгаагүй юм байна. Би тэр захиаг аваад маргааш Брайтон руу явъя.

-Та ман сайн хүн ээ! Таныг бүгдий нь ян тан болгомогц л бид очъё. Та миний зочны хувиар тэнд хамт байвал дургүйцэхгүй биз дээ? Брайтон их хөл хөдөлгөөнтэй газар, та лав уйдаггүй байх.

Намайг ийнхүү урьж байгаа нь бүх хэрэгт биеэр оролцох сайхан боломж нээсэн юм.

Бид хоёр долоо хоногийн дундуур ярилцсан билээ. Бямба гаригийн орой гэхэд байр бэлэн болов. Тэр давчуу хугацаанд миний бие надтай уулзсан зарц нарын зан авирын тодорхойлолтыг төдийгүй шашин шүтлэгийг нь шалгаж үзээд өөрийнхөө итгэл бишрэлд нийцүүлэн сонгож авлаа. Түүнчлэн Брайтонд ирсэн аруин зорилгынхоо тухай итгэмжлэн ярьж болох төлөв төвшин хоёр андыгаа ч олж уулзлаа. Нэг нь мяндаг тушаалтай санваартан агаад өөрийн сүмд манай бяцхан нийгэмлэг байр сууриа бэхжүүлэх хэрэгт надад тусалсан юм. Нөгөөдөх нь миний нэгэн адил ганц бие бүсгүй бөгөөд ховор нандин зохиол бүхий номын сангаа миний бүрэн мэдэлд найр тавьсан юм. Би Рэчелд зориулан зургаан ном чамбай гэгч шилж сонгоод зээлээр авав. Рэчелийн эзэмших ёстой өрөөнүүдэд эвтэйхэн тавьснаар бэлтгэл ажил дууссан гэж үзлээ. Түүнд үйлчлэх зарц, шивэгчин нарын гуйвалтгүй сүсэг бишрэл, номлох унших санваартны хөдөлбөргүй сүсэг бишрэл, ширээн дээр нь тавьсан шастирт өгүүлсэн бат бэх сүссэг бишрэл гэсэн гурван бэлгий гби өнчирсэн охинд хичээнгүйлэн бэлдсэн юм! Тэр бямба гаригийн орой төрөл садангуудаа хүлээн цонхны наана суух үес миний сэтгэл зүйрлэшгүй тэнэгэр байж билээ. Хийсвэр хөнгөмсөг улс нүдний өмнө хойш урагш сүлжилдэнэ. Ай хөөрхий, үүргээ өө сэвгүй биелүүлснээ миний адил ухаарч буй хүн эдний дунд олон болов уу? Аймшигтай асуулт байна даа. Тэр тухай саатан хэлэлцэхээ больсугай.

Зургаа, долоон цагийн үед манайхан ирлээ. Тэднийг мистер Годфри биш (би мэдэж байсан юм) харин хуульч мистер Брафф дагалдан ирснийг хараад би хэмжээлшгүй их гайхлаа.

-Мисс Клак сайн байна уу? Энэ удаад би эднийд айлчилж байгаа юм гэж мистер Брафф өгүүлэв.

Бид хоёр Монтегю талбайн байшинд тааралдаад түүнийг миний хэрэгт саад хийх гэснийг нь зэмлэж байсныг минь ийнхүү битүү ёжилсон нь эл нүгэлт өвгөн Брайтонд нэг бодол агуулж иржээ гэдгийг надад ойлгуулсан юм. Би хонгор хайртай Рэчелдээ товхийсон хөөрхөн диваажин бэлдчихээд байтал хорт могой хүрч иржээ!

-Друзилла, Годфри бидэнтэй хамт ирж чадаагүйдээ их л харамсаж байсан. Хоштод нэг хэрэг гарсан юм байх аа. Мистер Брафф оронд нь ирж манайд даваа гаригийн өглөө хүртэл амрахаар болсон. Ингэхэд мистер Брафф намайг өглөө бүр салхинд гарч бай гэсэн юм, гэтэл миний санаанд ер таарахгүй байан гэж Эблвайт эгч өгүүлснээ, дугуйтай сандал дээр суусан нэг өвчтэй хүнийг зарц нь түрж явааг цонхоор заагаад -Зугаалгын сонгодог жишээ энэ дээ. Агаар хэрэгтэй бол сандал дээр суугаад амьсгал, ядрах хэрэгтэй бол тэр зарцыг харахад л хангалттай гэж би бодож байна хэмээн нэмж хэлэв.

Рэчел далайн ус ширтэн ганцаараа цонхны наана дуу шуугүй зогсоно.

-Хонгор минь, ядраа юу? Гэж би асуув.

-Үгүй ээ, надад жаахан гунигтай санагдаад

Би Иоркширт байхдаа яг ийм гэгээтэй үеэр далайн усыг дандаа хардагсан. Друзилла, би дахиад хэзээ ч эргэж ирэхгүй өнгөрсөн өдрүүдийг дурсаж байна.

Мистер Брафф үдэд цуг хоолож оройжин хамт байв. Мистер Брафф харж ажиглах тусам, Брайтонд нэг нууц зорилготой иржээ гэдэгт нь улам итгэж тун няхуур ажиглаад байлаа. Орой явтлаа огт хэнэггүй царай гарган, сүнсгүй нүгэлтэй юм баахан чалчиж суулаа. Рэчелтэй гар барихдаа залирхаг ширүүн нүдэнд нь өвөрмөц сонирхол, анхаарал тодрон Рэчелийг хэсэг зуур тогтоун ширтээд авах нь миний хараанаас мултурсангүй. Түүний нууц зорилго Рэчелд хамаатай байжээ. Мистер Брафф явахдаа хэнд ч гойд юм хэлсэнгүй. Түүнийг маргааш өглөөний цайн дээр урьсан бөгөөд зочид буудалдаа очихоор гарч одлоо.

Маргааш өглөө нь Эблвайт эгчийг мөргөлийн цагаас өмнө хувцаслуулах гээд хүч хүрсэнгүй. Миний бодлоор бол эхээс өвлөн авсан эдгэшгүй залхуу хойрго зангаас өөр ямарч шаналгаагүй өвчтэй охин нь тэр өдөртөө хэвтэж өнжинө гэж мэдэгдлээ. Рэчел бид хоёр л сүмд очив. Хорвоогийн жижиг сажиг нүгэл хилэнцийг үл хайхардаг тэрслүү чанарын тухай мини анд санваартан номлов. Түүний бахдам сайхан дуу ариун орноо цаг гаруй хүнгэнэлээ.

-Хонгор минь, энэ мөргөл таны сэтгэлийг хөндөв үү? Гэж сүмээс гарахдаа би Рэчелээс асуусанд,

-Үгүй, харин толгой л өвтгөчихлөө гэж хариулсан юм.

Ийм үг зарим хүний урам зоригийг мохоож болзошгүй боловч нэгэнт буяны үйлийг эхэлсэн л бол намайг юу ч балмагдуулж чадахгүй бөлгөө.

Бид хоёрыг харихад Эблвайт эгч, мистер Брафф хоёр цай ууж бйав. Рэчел толгой нь өвдсөн учир юм идмээргүй байна гэсэнд зальтай шүүгч гарсан боломжийг доор нь шүүрч авав.

-Толгойн өвчинд ганцхан л эм байдаг юм. Зугаалга л таныг анагаан даа, мисс Рэчел. Та зөвшөөрч соёрхвол хань болж гарахад бэлэн байна гэж тэр зэвүүн өвгөн хэллээ.

-Маш сайхан байна. Би салхинд гарахын мөрөөсөл болоод байсан юм.

-Одоо хоёр өнгөрч байна. Өдрийн мөргөл гурван цагт эхэлнэ шүү дээ, Рэчел ээ гэж би ялдамхан сануулсанд,

-Толгой ингэж их өвдөж байхад би яаж дахиад сүмд очих вэ дээ хэмээн хэгжүүрхлээ.

Мистер Брафф түүнд бялдуучлан үүд нээж өгөв. Минутын дараа гэхэд хоёул гадагш гарчихсан байв. Миний бие тэдний хэрэгт оролцох ёстой ариун үүргээ тэр үеийнх шиг тийм гүнзгий ухамсарлаж байснаа би санахгүй л байна. Гэвч хэрхэх билээ? Хожим боломж гармагц л оролцохоос өөр зам үлдсэнгүй.

Намайг өдрийн мөргөлөөс ирэх үед тэр хоёр ч зугаалгаас яг буцаж ирж байлаа. Хуульч хэлэх эгснээ хэлж амжжээ гэдгийг би харцнаас нь ойлгосон юм. Рэчелийн тийм номхон, санааширсан байхыг нь би урьд өмнө ер хараагүй. Мистер Брафф Рэчелд тэгтэл үнэнч халамжлан зүтгэж, тэгж илэрхий хүндэтгэлтэйгээр ширтэж байхыг нь би урьд өмнө ер хараагүй. Өдрийн хоолонд уригдсан эгж (үнэн худлыг бүү мэд) хэлээд Лондонд өглөө анхны галт тэргээр буцах санаатай тул бидэнтэй салах ёс гүйцэтгэв. Үүдэн дээр,

-Та баттай шийдсэн биз? Хэмээн Рэчелээс асуухад нь,

-Баттай шийдсэн гэж хариулаад тэд салав.

Түүнийг эргэмэгц Рэчел өрөөндөө оров. Өдөр хоолонд ирсэнгүй. Малгайндаа эрээн туузтай нөгөө шивэгчин нь ирж, Рэчелийн толгойн өвчин дахин хөдөлсөн гэж бидэнд дуулгасан юм. Би өрөө рүү нь яаран очиж хаалганы наанаас эгчийн ёсоор тусалъя гэлээ. Гэтэл хаалга түгжээтэй хэвээр Рэчел тайлсангүй. Даван туулах ёстой саад тотгор мундахгүй ажээ! Тэр түгжээтэй хаалгыг хараад надад шинээр хүч зориг сэлбэгдэх шиг санагдсан юм.

Маргааш өглөө нь Рэчелийн өрөөнд аяга цай оруулж өгөхөд нь дагаад оров. Орных хажууд сууж, чин сэтгэлийн хэдэн үг хэлэв. Рэчел эелдэг боловч хайш яйш сонсоно. Ачит нөхрийн маань нандин номууд өрөөний буланд ширээн дээр овоорч байхыг ажиглав. Энэ номнуудыг уншиж үзэв үү? Үзсэн, гэхдээ сонирхолтой юм алга. Анзааралгүй өнгөрчихсөн байж болзошгүй туйлын их сонирхолтой хэсгээс нь уншиж өгөх үү? Үгүй, одоо хэрэггүй. Өөр бодох юм байна. Ийм хариулт өгчихөөд шөнийн бошинзныхоо хуниасыг эвхэж дэлгэж жигтэйхэн анхааралтай оролдож эхлэв. Түүний эрхэлдэг хорвоогийн явдлыг сануулж анхаарлыг нь татах хэрэгтэй боллоо.

-Хайрт минь, өчигдөр мистер Браффын талаар надад ямар хачин бодол төрснийг мэдэж байна уу? Зугаалгаас ирэхэд чинь хараад танд нэг ёозгүй юм дуулгаж дээ гэж бодсон шүү.

Рэчел гараа шөнийн бошинзноосоо салган, хур хар нүдээрээ намайг цоргитол ширтэж,

-Харин ч үгүй! Тэр мэдээг би их сонирхож сонссон. Тийм юм дуулгасанд нь мистер Браффт туйлгүй талархаж байна гэлээ.

-Тийм үү? Гэж би ялдамхан сониуч өнгөөр, лавлав.

Бошинзоо дахин шүүрэн авч, надаас огцом нүүр буруулав. Буянт үйл бүтээж явахдаа иймэрхүү харьцаатай хэдэн зуун удаа тулгарч байлаа л даа. Энэ удаа дахин нэг туршаад үзэх болж дээ. Рэчелийн сайн сайхны төлөө чин санаанаасаа чармайсны эрхээр тун осолтойгоор аз сорьж, хадамд гарах тухай асуудлыг нь шууд хөндсөн юм.

-Та тэр сониныг дуулаад их сонирхсон гэнэ ээ? Хэмээн лалаад, -Годфри Эблвайтийн тухай л биз дээ гэж би таамаглаж байна, хонгор Рэчел минь гэв.

Рэчел орон дээрээ өндөсхийснээ, царай нь үхдэл мэт цонхийв. Урьдын увайгүй ааш нь хөдөлж, хэгжүүн үг аман дээр нь гарч ирэв бололтой. Гэвч биеэ барьж, толгойгоо дэрэн дээр тавиад минут хэртэй бодолхийлснээ,

-Би Годфри Эблвайттай хэзээ ч гэрлэхгүй хэмээн гайхамшигт хариу өгч билээ. Энэ удаад би ухасхийн өндийв.

-Юу гэсэн үг вэ? Төрөл садангууд чинь үүнийг нэг тийш болсон гэж үзэж бйагаа шүү дээ? Хэмээн би дуу алдлаа.

-Годфри Эблвайт өнөөдөр ирнэ. Хүлээж бай, ирэхээр нь юу болохыг хараарай гэж гөжүүдлэн хэлэв.

-Гэхдээ, хонгор Рэчел минь...

Рэчел орныхшо толгойд өлгөөтэй хонхыг цохилоо. Тууз бүхий малгайтай нөгөө шивэгчин орж ирсэнд,

-Пенилоп, халуун ус бэлтгэ! Гэв.

Рэчелийн сайн талыг хэлэх хэрэгтэй. Тухайн үеийн сэтгэл санааны байдлг харгалзан намайг өрөөнөөсөө гаргах ганц боломжтой арга сийлснээс зайлахгүй.

Энгийн хүний бодлоор бол Рэчелд хандах миний байр суурь ер бусын адармаатай байсан гэж болох юм. Гэрлэх тухай сэдвээр орой руу нь ортол ятгах аргаар Рэчелийг эрхэм нандин бодолд хөтлөн аваачиж чадна хэмээн итгэж байлаа. Хэрэв түүнийг сэнхрүүлж дөнгөсөн бол одоо гэрлэж барих явдал огт гарахгүй. Гэвч та минь, хүнийг шашны номд оруулахаар зорьсон над шиг туршлагатай христос мөргөлтөн үүнээс ч холын хараатай байдаг шүү дээ. Эцэг, хүү Эблвайт нэг тийш болчихсон асуудал хэмээн үзэж байтал нь Рэчел гэрлэх амаа үнэхээр цуцалсан бол эцэстээ ямар үр дүнд хүрэх вэ? Хоёр талаас хаялцах хатуу ширүүн үг, гашуун зэмлэлийг Рэчел тэсэж чадвал л болох нь тэр. Тэр сүртэй хэрүүл уруул Рэчелд хэрхэн нөлөөлөх бол? Сэтгэл санаагаар түр унавч хойчийн өдөр ээлтэй нөлөө үзүүлж болох билээ. Тэр нөхцөлд Рэчел төрөлхийн чанараараа эрс тууштай тэмцээр бардам зан нь нугарч, гэжүүн ааш нь шавхагдах буй заа. Тэгээд энэрч өрөвдсөн хамгийн ойрын хүнд л хандана. Тэрхүү амраан тайтгаруулах увдис дүүрэн бөгөөд цагий нь олж, сэтгэлийг нь төвшитгөх шавхагдашгүй үгээ ундраан чадах ойрн хүн нь би бүлгээ. Шашны номд хүнийг оруулах зорилго маань одоогийнх шиг ийм тод томруун үзэгдэж байсан удаагүй билүү.

Рэчел өглөөний цайнд орж ирсэн боловч юу ч идэлгүй, үг дуу цөөнтэй суув. Цайны дараа өрөөнүүдээр дэмий баахан сэлгүүцсэнээ гэнэт сэхээ авч төгөлдөр баян хуурын тагийг сөхлөө. Бодохоос л бие зарсхиймээр жүжгийн зохисгүй, шившигтэй хөгжим сонгон авч наадаж эхэллээ. Ийм үед нь хөндлөнгөөс оролцвол хуумгай хэрэг болно. Годфри Эблвайтын ирэх цагийг сэм мэдээд байшингаа гарч нөгөө яршигтай хөгжмөөс зайлав. Ганцаараа гадагш гарсны далимд хоёр андындаа очлоо. Төлөв томоотой улстай нухацтай яриа хөөрөө дэлгэн суухад хэчнээн жаргалтай байсныг үгээр илэрхийлэх аргагүй. Хязгааргүй урамшиж сэргэсэн миний бие зочин ирэх цаг яагаа ч үгүй байхад буцаж явлаа. Өдийд ямагт хоосон байдаг цайны өрөөнд ортол Годфри Эблвайттай улаан халз тулгарчихав!

Надаас зугтах гэж огт оролдсонгүй. Харин ч учиргүй яаран ирж,

-Эрхэм мисс Клак би тантай л уулзахын мөн болж байна! Лондонд хэрэг явдлаа санаандгүй эрт дуусгаад болзсон цагаасаа хамаагүй өмнө хүрээд ирлээ гэв.

Монтегю талбайд болсон явдлаас хойш анх удаа уулзаж байгаа авч тайлбарлан хэлэх өнгөнд нь сандарч мэгдсэн шинж ер үгүй ажээ. Намайг тэр явдлуудын санамсаргүй гэрч болсныг өчүүхэн төдий ч гадарлахгүй байгаа нь лав. Гэвч нөгөө талаар намайг хувцас хасах эхчүүдийн нийгэмлэгт очдгийг, бусад өглөг буяны үйл эрхэлдэг анд нартайгаа харилцаа холбоотойг мөн эмэгтэйчүүд, ядуучуудаа ичгүүргүй хаясныг нь сонссон гэдгийг мэдэж байлаа. Одоо харин миний өмнө сэтгэл татам дуугаараа ярьж, өгүүлшгүй сайхнаар инээмсэглэн зогсоно.

-Та Рэчелтэй уулзсан уу? гэж би асуулаа.

Хөнгөхөн санаа алдаад миний гараас барив. Түүний хариу өгүүлэх өнгө намайг тэгтэл балмагдуулаагүйсэн бол би гараа даруйхан татаж авах л байсан.

-Би Рэчелтэй уулзсан. Надтай гэрлэхийг зөвшөөрсөн гэдгийг нь та сонссон биз дээ, эрхэм нөхөр минь. Гэтэл тэр шийдвэрээсээ гэнэт няцдаг юм байна. Эргэцүүлж, тунгаасны эцэст, хөнгөн хийсвэл шийдвэрээсээ няцаж, намайг илүү аз жаргалтайгаар өөр нэгийг сонгох нь зөв гэж үзжээ. Ийм л ганц шалтаг зааж, юу ч асуусан ганцхан ийм л хариу өгч байна хэмээн хачин тайван өгүүллээ.

-Тэгэхээр нь та яав даа? Бууж өгөв үү? Гэж би лавласанд,

-Тийм ээ, бууж өгсөн гэж огт хэнэггүй тайван хариулсан юм.

Тийм нөхцөлд түүний араншин даанч ухаарахын аргагүй байсан тул би гараа атгуулсан хэвээр мэл гайхаж, цэл хөхрөн зогсоор байлаа. Аливаа хүнийг алмайран ширтэх бүдүүлгийн шинж, тэр мөртлөө эр хүнийг алмайран ширтэх нь эвгүй явдал мөн. Гэтэл би ийм хоёр зохисгүй явдал зэрэг гаргасан юм.

-Юу гэсэн үг вэ? Хэмээн эцэст нь би зүүдлэх мэт арайхийн асуулаа.

-Танд тайлбарлахыг зөвшөөрнө үү? Суух уу даа? Гэж хариу хэлэв.

Тэгээд намайг сандал руу аваачлаа. Мистер Годфри туйлын эелдэг, халамжтай байсан нь бүүр түүр санагдана. Намайг түшин бүсэлхийгээр тэвэрч аваагүй байгаа даа, сайн санахгүй л байна. Би тэгэхэд даанч арчаагүй байсан ба мистер Годфри бүсгүй хүнтэй дандаа тийм их ялдам, дотно харьцаг юм. Ямар боловч бид сууцгаалаа. Өөр зүйлийн талаар сайн мэдэхгүй гэхэд сууснаа лавтай мэдэж байна.

## ҮIII бүлэг

Годфри өгүүллүүн:

-Би царайлаг сайхан бүсгүй, нийгэмд эзлэх гялалзсан байх суурь, ихээхэн хэмжээний орлого алдлаа. Тэгэхдээ мар ч тэмцэлгүй эвлэрлээ. Ийм жирийн бус явдлын учир шалтгаан юу байж таарах вэ? Хайрт найз минь, ямар ч шалтгаан байхгүй.

-Шалтгаан байхгүй гэнэ ээ? Гэж би лавлав.

-Эрхэм мисс Клак минь, хүүхдээр жишээ авъя л даа. Хүүхэд элдэв хачин хэрэг тарьдаг. Тэгэхэд нь та бүр гайхаж, шалтгааныг нь олох гээд үзнэ. Тэр хонгор хөөрхөн амьтан тарьсан хэргийнхээ учрыг тайлбарлах чадваргүй байдаг. Та өвс ногоо яагаад ургадгийг нь, жигүүртэн шувуудаас ягаад жиргэн донгоддогийг нь бас асуу л даа. За тэгэхээр, би яг л балчир хүүхэд шиг, өвс ногоо шиг, жигүүртэй шувуу шиг загнажээ. Мисс Вериндерт гэрлэе гэж яагаад хэлснээ ч мэдэхгүй. Хувцас хасах эхчүүдийн нийгэмлэгийг яагаад орхисноо ч мэдэхгүй. Хонгор бүсгүйчүүлээ яагаад тэгж шившигтэйгээр үл тоомсорлон хөндийрснөө ч мэдэхгүй. Балчир хүүхдээс “Яагаа дчи үймүүлээд байгаа юм?” гэж асуувал тэр хөөрхөн амьтан юу хэлэхээ ч мэдэхгүй хуруугаа хөхнө вий. Би яг л тийм болчихоод байна даа. Мисс Клак минь! Үүнийгээ би өөр хэнд ч ингэж илэн далангүй ярьж чадахгүй. Гэвч танд үнэнээ хэлэх ёстой гэж бодох юм.

Би сэхээ авч эхлэв. Энд ёс суртахууны асуудал гарч ирлээ. Миний бие энэ асуудлыг маш их сонирхдог бөгөөд дориун чадварлаг шийдчихдэг гэвэл хилсдэхгүй.

Мистер Годфри цааш үргэлжлүүлсэн нь:

-Хосгүй сайн нөхөр минь, ухаанаа гүйлгэж, надад туслаач дээ. Гэрлэх гэж шийдсэн маань зүүд нойронд болсон мэт санагдаад байдаг нь ямар учиртай юм бол. Даруухан боловч хүнд хэрэгтэй ажил үйлээ бүтээхэд нь хонгор бүсгүйчүүлдээ тусалж, нийгэмлэгийн дарга дуудаж уулзахад нь хэдэн учирласан үгээ хэлж суух шиг бахтай жаргал үгүй гэдгийг яагаад гэнэт ухаарсан юм бол? Нийгэмд эзлэх байр суурь юунд хүсээ вэ? Тэртэй тэргүй надад байна шүү дээ. Орлого ямар хэрэгтэй юм бэ? Би амиа борлуулаад, подхийсэн байрныхаа хөлсийг төлж, жилд хоёр пиджак аваад байж дөнгөнө. Мисс Вериндерээр яах гэсэн юм бэ? Танд гэж хэлэхэд, өөр хүнд сэтгэлтэй, тэр хүнийг умартахын тулд л надтай суухыг зөвшөөрч байна гэдгийг нь би Вериндер авхайн амнаас сонссон юм шүү дээ. Ямар аймшигтай холбоо болох вэ! Ай, тэнгэр минь, ямар аймшигтай вэ! Брайтонд ирэх замдаа би ийм л юм бодож явлаа. Түүрүүн Рэчелтэй хамт байхдаа ял шийтгэлээ хүлээж буй гэмт хэрэгтэн шиг санагдаад байлаа. Түүнийг бас амнаасаа буцсаныг сонсоод, үнэндээ цээж тэнийгээд явчихсан шүү. Сарын өмнө би түүнийг элгэндээ наан бахтайяа тэвэрч байсансан. Цагийн өмнө би түүнийг дахиад ер тэврэхгүй гэдгээ мэдээд ухаан мансууруулагч дарс уучихсан мэт хэчнээн баярлав аа. Энэ явдал байж боломгүй мэт санагдаж магадгүй. Гэхдээ энэ бол барин тавин үнэн бөгөөд та бид хоёр энэ сандал дээр суух үес би хэлнэ гэж танд амласан зүйл юм. Би царайлаг сайхан бүсгүй, нийгэмд эзлэх гялалзсан байр суурь, шагхийсэн орлогыг алдлаа. Ямар ч тэмцэлгүй бууж өглөө. Эрхэм анд минь, та үүнийг тайлбарлаж чадах уу? Өөрөө тайлбарлаж гэхнээ миний хэрээс хэтэрсэн зүйл юм даа.

Тийн өгүүлээд ганган тэргүүнээ гудайлгаж, тэрхүү ёс суртахууны асуудлыг шийдвэрлэлгүй хаяв.

Миний сэтгэл гүнээ догдолжээ. Отчийн үгээр хэлбэл, өвчний онош надад тов тодорхой болов. Агуу авьяас билэгтэн орчныхоо мунхаг улсын төвшинд хүртэл буудаг явдал олонтаа тохиолддогийг бид бүхэн амьдралд бишгүй л үзсэн. Дээд тэнгэрийн мэргэн бошгын учир бол агуу хүмүүс мөнх бус, тэдэнд хайрласан эрх дархыг эргүүлэн авч ч болно гэдгийг сануулах гэсэн буй заа. Тэгэхээр миний бие үл үзэгдэгч гэрч нь болсон, эрхэм мистер Годфрийн үйлдсэн нөгөө гунигт явдал бол хойчийн өдөр ээлтэй тийм басамжлалын нэг байжээ гэдгийг уншигч хялбар ойлгох бизээ. Түүнчлэн Рэчелтэй гэрлэнэ гэж санахаас л жигшин, айдас нь хүрч, тэтгэн хайрладаг бүсгүйчүүл, ядуустаа эрэгж очно гэхээс сэтгэл нь бахдаж оргилж байгаа явдал бол түүний ясны сай нчанар баярлууштай сэргэж байна гэдгийг уншигч бас хялбар ойлгон обиз ээ.

Би энэ бодлоо түүнд энгийн цөөн дотно үгээр илэрхийлэв. Баярлаж байхыг нь харахад сайхан ажээ. Миний үгийг сонсох тусам өөрийгөө харанхуйд төөрч мунгинаж яваад гэрэлд гарч, зүг чигээ олж буй хүнтэй зүйрлэнэ. Миний бие “Хувцас хасах эхчүүдийн” нийгэмлэгийн нэрий нөмнөөс түүнийг дуртайяа хүлээн авна гэж хариулбал манай христос шашны баата рэрийн талархлаар дүүрэн зүрх булгилан хөөрөв. Миний хоёр гарыг уруулдаа ээлжлэн аваачна. Түүнийг бидний дунд эргэж ирнэ гэхээс баярлаж бахадсандаа миний гарыг хэрхэхээ мэдэг хэмээн зөнд нь орхилоо. Би нүдээ анив. Хэт хөөрч, бүхнийг умартсан мистер Годфрийн мөрийг толгойгоороо түшив. Дахиад нэг минут

өнгөрвөл гар дээр нь муужирч унах болзошгүй байсан авч гаднаас чимээ гарч, ухаан оруулсан юм. Хутга сэрээ хавиралдах ёгүй дуу хаалганы цаана гарч, төдөлгүй хоолны ширээ засахаар зарц орж ирэв. Мистер Годфри босон харайж, зуухан дээрх цагийг харснаа,

-Тантай цуг байхад цаг хугацаа харвасан сум шиг л өнгөрөх юм. Галт тэрэгнээс хожигдох нь ээ гэж дуу алдав.

Хот руу юунд ингэтэл яарсныг нь учрыг зүрхлэн асуув. Түүний хариу, одоогоор учрыг нь олж зохицоогүй байгаа тэр гэр бүлийн доторх бэрхшээл, зөрөлдөөнийг сануулсан юм.

-Эцгээс захиа ирсэн. Өнөөдөр Фризинхоллоос Лондонд ирэх хэрэг гарчээ. Өнөө орой юмуу, маргааш өглөө ирэх санаатай гэнэ. Рэчел бид хоёрын хооронд болсон явдлыг хэлэлгүй горьгүй. Биднийг гэрлэнэ гээд бөөн баяр хөөртэй байсан. Большныг дуулаад сүйд болно доо, яана. Юу ч болсон үүнтэй эвлэртэл нь Лондонд саатуулах хэрэгтэй. Эрхэм хонгор найз минь, дараа уулзамц, баяртай!

Тийн өгүүлээд мистер Годфри яаран одлоо. Би ч бас түүнээс дутуугүй яарч, Эблвайт бэргэн, Рэчел хоёртой хамт хоолны ширээнд суухын өмнө тайвширч авахын тулд өрөө рүүгээ харайлгав.

Рэчел амнаасаа буцсан боломжийг шүүрэн авч зөвшөөрсөн нь нэг л учиртай хэмээн хорвоогийн бузар санаатнууд Годфри ноёныг зэмлэж байгааг би сайн мэднэ. Түүнчлэн амьдралын буян хишиг ихтэй, урьд миний дотны хайртай найз байсан, “Хувцас хасах эхчүүдийн” нийгэмлэгийн гишүүн нэг хүндэт хатагтай нараар дамжуулан эвлэрэх гэсэн далдын санаа агуулж л миний нүдэнд нэр хүндээ сэргээх гэж учиргүй хичээсэн гэдэг яриа миний чихийг дэлссэн юм. Энэхүү шившигт гүтгэлгийг дурдсаны учир бол эдгээр нь надад өчүүхэн ч нөлөөлөхгүй гэдгийг л хэлэх гэсэн юм.

Өгсөн зааврыг сахин дагасан тул миний биег манай христос шашинтай баатар эрд дотроо эргэлзэж байсан тухайгаа өдрийн тэмдэглэлдээ бичсэн яг тэр чигээр нь дээр толиулсан билээ. Миний сайн тал гэвэл, авъяаслаг андыгаа хүндэтгэн бишрэх сэтгэл маань нэгэнт сэргэсэн бөгөөд дахин унтраагүй гэдгийг нэмж хэлэхийг зөвшөөрнө үү. Үүнээс илүү ихийг өгүүлэх хүсэл бадран, нулимс цийлэгнүүлэн бичиж суунам. Гэвч болохгүй, хүн ба юмсын тухай жинхэнэ мэдлэгийг минь бүдүүлгээр хязгаарлаж байгаа юм. Одоогоос сар орчмын өмнө мөнгөний зах зээл (миний муу өчүүхэн орлогыг ч хүртэл хорогдуулсан) дээр болсон хэрэг явдал намайг гадаадад цөлсөн бөгөөд сүсэг бишрэлгүй улс гүжирдэн ширүүн шүүмжилж, шал дэмий шүүмжилж байсан мистер Годфрийн тухай энхрий сайхан дурсамжаас өөр юу ч үлдээгээгүй билээ.

Одоо нулимсаа арчаад, хүүрнэлээ үргэлжлүүлье.

Рэчел гэрлэх амнаасаа буцаад ямаршуу араншинтай байгааг нь шалавхан харав гэж тэсэж ядсаар хоолны өрөө рүү буулаа.

Миний бие иймэрхүү хэрэгт дулимаг гэдгээ хүлээе, гэвч Рэчел эрх чөлөөтэй болчихоод нөгөө сэтгэлтэй хүнээ дахиад л бодож, дотроо ичиж зовж байгаа сэтгэлээ дийлэх чадалгүйдээдээ бачимдан уурсаж байх шиг санагдсан юм. Тэр нь хэн юм бол? Элдвээр таамаглавч хоосон тааварт цаг үрээд дэмий байв. Яриа үүсгэж чадах л юм бол Рэчел надаас юу ч нуухгүй нь мэдээж. Тэгвэл би тэр хүнийх нь тухай бүгдийг мэдэж, Саран чулууны тухай ч сонсохсон. Рэчелийн оюун санааг ариутгах агуу зорилго би тавиагүй байлаа гэхэд, түүний санаа сэтгэлийг нүгэлт нууцуудаас салгах чин хүсэл намайг зоригжуулан хөтлөх байсан юм.

Хоолны дараа Эблвайт эгч эрэмдэг хүний сандал дээр сууж зугаалахад нь Рэчел хамт явлаа.

-Энэ сандлыг би чирэх юмсан. Бүр сөхөрч унатлаа ядрах сан! Гэж Рэчел гэнэт цухалдан өгүүлэв.

Оройжин тиймэрхүү ааш оёгтой байлаа. Би найзынхаа нандин номны нэг “Мисс Жен Анн Стамперийн амьдрал, захидал, хөдөлмөр” хэмээх бүтээлийн дөчин дөрөв дэх удаагийн хэвлэлийг сөхөн, Рэчелийн одоогийн байж байгаа байдалд гайхалтай тохирсон хэсгийг оллоо. Түүнийг уншиж сонсгоё гэсэнд Рэчел холдож, төгөлдөр баян хуур руу явчихав. Намайг төдий л удахгүй тэсвэр алдана гэж бодож байгаа бол Рэчел төлөв томоотой улсыг даанч бага мэддэг ажээ. Мисс Жен Анн Стамперийн номыг өвөр дээрээ тавиад цаашид юу болохыг хувиршгүй итгэл найдвартайгаар хүлээн суулаа.

Мистер Эблвайт тэр орой ирсэнгүй. Тэр сүсэггүй сувдаг өвгөн хүүгийнхээ мисс Вериндэртэй ураг холбох гэсэн саналыг чухагт үзэж байсныг би мэдэх тул (мистер Годфри саатуулах гэж оролдовч) маргаашаас хэтрэхгүй энд ирнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Мистер Эблвайт энэ хэрэгт оролцож бөөн хэрэг мандуулах нь зайлшгүй, Рэчел ч цөхөртлөө эсэргүүцэх нь дамжиггүй гэж би таамагласан юм. Эблвайт өвгөнийг ер нь ялангуяа доод хүмүүс нь хачин бодь сэтгэлтэй гэж магтаж байсныг би гадарлана. Ажиглаад байвал, үзэл бодлоо ягштал баримталсан цагтаа л нэр хүндээ хадгалахаас бус түүнээсээ өчүүхэн төдий хазайхад л хэрэг бишдэх юм.

Маргааш нь үнэхэр миний таамагласнаар мистер Эблвайт гэнэт ирсэнд эхнэр нь хойрго чанарынхаа чадах хэрээр гайхсан царай гаргав. Түүнийг ирээд минут ч болоогүй, огт санаандгүй байтал мистер Брафф орж ирсэн нь тун гайхалтай, ойлгомжгүй зүйл байлаа.

Хуульчийг үзээд тэгж их дургүй хүрч байсан удаа надад үгүй. Рэчелтэй талцан ямар ч саад тотгорын эсрэг тэмцэхэд бэлэн шинжтэй харагдана.

-Аятайхан сонин байна даа, эрхэм ээ! Өчигдөр таны ажлын өрөөнөөс гарахдаа Брайтонд уулзана чинээ санасангүй шүү хэмээн мистер Эблвайт өнгөн дээрээ эелдэг өгүүлэв.

-Таныг явсны дараа яриагаа бүгдийг тунгааж үзээд миний хэрэг гарч болзошгүй гэсэн бодол төрлөө. Би галт тэргэнд азаар амжиж суусан, таныг аль вагонд явсныг мэдэх завшаан даанч байсангүй дээ гэж мистер Брафф хариу өчөөд Рэчелийн хажууд суув.

Би буланд чимээгүйхэн очиж, онц шаардлага гарахад хэрэглэнэ гэж Жен Анн Стампер номоо өвөр дээрээ тавин суулаа. Мистер Эблвайт өрөөний голд зогсох бөгөөд халзан толгой нь урьд үзэгдээгүй ихээр ягаарна.

-Рэчел, хонгор минь гэж зээ охиндоо жигтэйхэн наалинхай хандаж –Би Годфригээс хүн үнэмшмээргүй сонин юм дууллаа. Тэр тухай лавлах гэж ирсэн юм. Энэ байранд чамд зочны өрөө бий байх аа? Намайг өрөөндөө хүргэж өгөөч гэв.

Рэчел огт хөдөлсөнгүй. Байдлыг хямралд хүргэх гэж бодов уу, эсвэл мистер Брафф сэмхэн дохисон юмуу, бүү мэд Эблвайт өвгөнийг зочны өрөөндөө дагуулж орохоос татгалзав.

-Та надад ярих зүйлээ энд, манай хамаатнууд болон эхийн маань итгэлт анд нөхрийн (тэгж хэлэхдээ мистер Брафф руу харав) дэргэд ярьж болно шүү гэж хариулсан юм.

-Хонгор минь, өөрөө л мэд гэж дуулгавартай мистер Эблвайт хэлээд сандал авч суув.

Бусад нь далан жил юм үзэж, нүд тайлсан хүн одоо л нэг үнэнийг хэлнэ байх гэсэн мэт түүний нүүрийг ширтэнэ. Хааяа халзан зулайг нь харахаар түүний элдэв зан араншин энд л бүртгэгддэг болов уу гэж бодогдоно.

-Хэдэн долоо хоногийн өмнө миний хүү Годфри, мисс Вериндер гэрлэхийг зөвшөөрсөн гэж мэдэгдсэн билээ. Таныг буруу ойлгосон, эсвэл худлаа ярьсан юм болов уу? хэмээн өвгөн эрхмийг шалгаахад Рэчел,

-Хаанаас даа. Би гэрлэхийг зөвшөөрсөн юм гэж хариулав.

-Их илэн далангүй, маш хангалттай хариу байна! Тэгэхээр хэдэн долоо хоногийн өмнө юу болсон тухайд Годфри эндүүрээгүй байж. Тэгвэл өчигдрийн явдлыг ярихдаа бурууджээ. Одоо л ойлгож эхэллээ. Та хоёр амрагуудын адил маргалдсаныг манай мунхаг хүү ноцтой юманд бодож л дээ. Ай зайлуул, би түүний насан дээр арай ухаалаг байсан юм.

Үүнийг сонсоод дээд эмэг Евагаас удамшиж ирсэн муу чанар нь сэргэж Рэчел эгдүүцэн цухалдав.

-Мистер Эблвайт, бие биеэ ойлгохыг хичээе. Өчигдөр таны хүү бид хоёр хэрэлдэж муудалцсан зүйл огт үгүй. Хэрэв намайг гэрлэх амнаасаа буцсаныг, мөн хүү чинь өөрөө ч үүнийг зөвшөөрсөн гэсэн бол танд үнэн хэлжээ.

Мистер Эблвайтын халзан толгойн өнгө хувиран халуун хүйтний хэмжүүр мэтээр уурлаж хилэгнэснийг нь илтгэнэ. Царай нь эелдэг ялдам байвч зулай нь бүр ч улаан болжээ.

-За, за хонгор минь! Бүү уурла, хөөрхий Годфрид хатуу сэтгэл бүү гарга! Санаандгүй тэнэг үг хэлсэн байх л даа. Багаасаа л тийм бойдго дүйгүй байсан, гэхдээ цагаан санаатай юм шүү. Рэчел ээ хэмээн жигтэйхэн аргадсан байртай хэллээ.

-Мистер Эблвайт эсвэл би санаагаа танд ойлгуулж чадсангүй, эсвэл та зориуд будлиад байна. Танай хүү бид хоёр хойшид зөвхөн үеэл ах дүү нар л байцгаая гэж нэгэнт тохиролцсон. Ойлгомжтой юу? Хэмээн Эблвайт өвгөн хүртэл будилсан дүр гаргах аргагүй өнгөөр тайлбарласа нбилээ.

Мистер Эблвайтын ааш зангийн хувирлын хэмжүүр болсон халзан зулайнх нь өнгө улам өтгөрч, бодь сэтгэлтэй гэж алдаршсан хүнд зохисон ялдам дуугаар ярихаа нэгэнт больжээ.

-Тэгвэл та хоёр гэрлэхээ больсон гэж ойлгох ёстой юм шив дээ?

-Тийм ээ.

-Таны санаачлагаар тэгж шийджээ гэж үзэж болох нь ээ?

-Эхлээд би санаачилсан, гэхдээ хүү тэнь зөвшөөрч, дэмжсэн гэдгийг би танд хэлсэн шүү дээ.

Мистер Эблвайтын термометр эцсийн хэмжээг заана, өөрөөр хэлбэл халзан зулай нь агшин зуур чинэрэн хүрээнтэв.

-Манай хүү ч хулчгар нохой юм даа! Хэмээн нүгэлт өвгөн хилэгнэн хашгираад –Мисс Рэчел таны сэтгэлд Годфри Эблвайтын чухам юу нь таараагүйг би түүний төлөө ч биш, харин эцгийн хувьд мэдмээр байна! Гэв.

Тэгэхэд мистер Брафф анх удаа ярианд оролцсон юм.

-Энэ асуултанд хариулах шаардлагагүй гэж Рэчелд санууллаа.

Эблвайт өвгөн тэр даруй мистер Брафф руу агсарч,

-Эрхэм ээ, таныг энд хэн ч залж авчраагүй гэдгийг бүү мартаарай. Гуйгаагүй байхад хөндлөнгөөс оролцох хэрэггүй, амаа хумхиад суувал дээрсэн гэлээ.

Мистер Брафф түүний үгийг тоосон шинж огт алга, шийдмэг царайны нь эрхэмсэг дөлгөөн шинж өчүүхэн ч хувирсангүй. Рэчел зөвлөгөө өгсөнд нь талархав. Эблвайт өвгөнтэй тийм залуу насны бүсгүй гэхэд хэтэрхий тоомжиргүй харьцсан нь харахаас ч аймшигтай ажээ.

-Танай хүү ч бас яг ингэж асуусан. Би түүнд нэг л хариу өгсөн, танд ч бас нэг л хариу өгье. Удтал эргэцүүлж үзээд, хэн хэнийхээ сайн сайхныг бодвол хөнгөн хийсвэр өгсөн амнаасаа буцаж, Годфрид өөр бүсгүйг сонгох боломж олгосон нь өлзийтэй болно гэж дүгнэсэнэ би хэлсэн.

-Манай хүү яачихаа вэ? Би үүнийг мэдэх эрхтэй. Манай хүү яасан юм бэ? Хэмээн Эблвайт салахгүй шалгаана.

Рэчел ч мөчөөгөө өгөхгүй шаргуу зүтгэнэ.

-Танд болон таны хүүд өгөх хэрэгтэй гэж үзсэн ганц тайлбараа хэлчихлээ шүү дээ гэж хариулав.

Та маяглаж, миний хүүгийн сэтгэлээр даажигная гэж бодсон юм шив дээ?

Рэчел нэг хэсэгтээ дуугарсангүй. Би арханд нь сууж байсан тул түүний шүүрс алдахыг сонсов. Мистер Брафф гараас нь барьж, атгалаа. Рэчел биеэ барьж, мистер, Эблвайтад түрүүчийн адил шазруун хариу өглөө.

-Миний зан араншин үүнээс долоон дор хэл амны бай болсон ч гэсэн би гэсвэрлэн давсан. Та намайг хөнгөмсөг маягтай хүүхэн гэх зэргээр доромжилж болох тэр цаг өнгөрсөн шүү гэж тун хорсолтой хэлсэн учир Саран чулууны хэргийг дурссан юм биш байгаа гэж надад санагдаж билээ.

-Надад өөр хэлэх юм алга! Гэж бидний хэнд ч хандалгүй ядарсан янзтай хэлээд нүүр буруулан ойролцоох цонхоор гадагш харав.

Эблвайт босон харайж, сандлаа хүчтэй түлхэн унагав.

-Тэгвэл надад хэлэх юм байна. Энэ доромжлолыг манай хүү ухаарахгүй байгаа бол би мэдэж байна! Хэмээн ширээ алгадан хашгичлаа.

Рэчел давхийн цочиж, ихэд гайхан ширтээд,

-Доромжлол ий? Та юу гэнэ ээ гэв.

-Тийм ээ, доромжлол! Миний хүүтэй гэрлэнэ гэсэн амнаасаа буцсан шалтгааныг чинь би мэдэж байна мисс Вериндер! Үүнийг бас царайнаас чинь хараад л ойлгож байна. Танай хараал идсэн гэр бүлийн барадм дээрэнгүй зан л намайг нагац эгчтэй чинь гэрлэж байх үед басамжилсан шигээ Годфрид бас доромжилж байгаа юм. Өөрийн чадлаар нийгэмд байр сууриа олж, энэ гараараа өмч хөрөнгөө цуглуулсан үнэнч шударга хүний эхнэр боллоо гэж танай төрөл садан, танай гуйлгачин төрөл садан нагц эгчээс чинь нүүр буруулсан. Би удам судраа эдэхгүй. Би аллага хядлага, дээрэм тонуул хийж амь зогоодог алуурчин дэрээмчний гаралтай хүн биш. Эблвайт овгийн өвөг дээдэс мөрөндөө хувцас тохолгүй явдаг байсан цагийг, овог нэрээ бичиж чаддаггүй байсан үеийг би хэлж чадахгүй. Үгүй ер! Би гэрлэх үедээ Хэрнкастлынханд тохирох хүргэн биш байсан! Одоо бол миний хүү танд тохирохгүй байх нь. Би ч бүр мэдээд байсан юмаа. Залуу авхай тан минь, Хэрнкастлынхны ачаар мах цусанд чинь нэвт шингэжээ! Би бүр мэдээд байсан юм.

-Тун зохисгүй бодол байна даа! Ингэж ярьж зүрхэлсэн чинь гайхалтай юм гэж мистер Брафф сануулав.

Мистер Эблвайтыг хариу хэлж амжихаас өмнө Рэчел туйлын зэвүүцэн басамжилсан өнгөөр,

-Үүнийг анхаараад хэрэггүй. Ингэж бодож байгаа бол бодог л доо гэж хуульчид хэллээ.

Мистер Эблвайтын минчийсэн царай одоо зэвхийрч ирэв. Амьсгаа нь давхцаж, хэн рүү нь эхэлж довтолохоо үл мэдэн ганирсан хилэнт харцаар Рэчел, Брафф хоёрыг ээлжлэн харна. Өдий хүртэл дэвүүрээр сэвэн жишимгүй сууж байсан эхнэр нь сая сандархийж, нөхрөө тайвшруулах гэж дэмий л аргадав. Энэхүү харамсмаар ярианы турш миний бие дундуур нь орж, чин сэтгэлийн хэдэн үг хэлье гэж нэ гбус удаа завдсан боловч мунхаг ухаанаар шийдэхэд бус, ёс суртахууны хувьд зөв байхыг эрмэлздэг христос сүсэгтэн англи бүсгүйд маш зохимжгүй үр дүнд хүрч болзошгүй хэмээн эмээсэн учир түдгэлзээд байсан юм. Харин одоо хэрэг явдал юунд хүрснийг хараад зүйд нийцэх эсэхийг ч үл харгалзан бослоо. Хэрэв би өөрөө бодож олсон ядуухан үгсээр учирлан эсэргүүцэх байсан бол магад эргэлзэх буй заа. Гэвч миний нүдний өмнө болж буй гэр бүлийн энэ гунигт маргааныг мисс Жен Анн Стампер гайхмаар мэргэн зөгнөн харж, "Гэр бүлийн амгалан байдал" хэмээх мянга нэг дэх захидалдаа бичжээ. Би буйд булангаасаа гарч, нандин номоош дэлгэлээ. Тэгээд,

-Эрхэм Эблвайт аа ганц үг хэлье! Гэв.

Би суудлаасаа босож, хүмүүсийн анаарлыг татах үес мистер Эблвайт надад бүдүүлэг үг хэлэхээр зэхэж байсныг нь ажиглаж болохоор байв. Гэвч миний нөхөрсөг хандлага түүнийг зогсоожээ. Намайг ичгүүргүй мэлрэн ширтэнэ. Би цааш өгүүлсэн нь:

-Таны сэтгэлийг тайтгаруулах уучлууштай үүргийг сайныг хүсдэг нөхрийн хувьд, хүмүүсийг сэрээж, итгүүлж, сэнхрүүлж, зоригжуулж хэдийнээ дадсан бүсгүйн хувьд надад олгоно уу.

Мистер Эблвайт сэхээ авч эхлэв. Уур хилэн нь бадрахын даваан дээр байжээ. Надаас өөр хүн тэгж ярьсан бол ч дэлбэртлээ уурлах байсан биз. Голдуу ялдамхан байдаг миний дуу хоолой чухал үед чангардаг юм. Тухайн тохиолдолд хамгийн өндөр дуугаараа ярих нь зүйтэй гэж санаса билээ.

Нөгөө нандин номоо өмнө нь барьж, нээлтэй хуудсыг хуруугаараа заан,

-Миний үг биш! Ай, намайг ядуу дулимаг үгээрээ таны анхаарлыг татах гэж байна хэмээн бүү бодогтун! Энэ бол ангасан газар буусан шүүдэр гэсэн үг! Сэтгэл амраах, цэцэн мэргэн, хайрын үгс, мисс Жен Анн Стамперийн гайхамшигт бахдам сайхан үг шүү! хэмээн би чин сэтгэлээсээ чармайсандаа дуу алдан учирлалаа.

Амьсгалаа дарах гэж үгээ түр таслав. Гэтэл намайг ухаарч амжихаас өмнө тэр хүн төрхтэй мангас,

-Тэр Жен Стампер чинь...! Гэж хашгирав.

Оронд нь гурва нцэг тавьсан тэр аюумшигт үгийг би энд бичиж зүрхлэхгүй. Амнаас нь тийм үг гарахыг сонсоод би өөрийн эрхгүй дуу алдан хашгирсан юм шүү! Хажуугийн ширээн дээр байсан цүнх рүүгээ ухасхийн гүйж очоод шастируудаа гарган муухай хараал зүхлийн тухай "Тэнгэрийг барьж амаа тат!" хэмээх номнолыг аваад мистер Эблвайтад цөхөрч гуйсан байдалтайгаар өгөв. Гэтэл хоёр хэсэг болгоод ширээ давуулан над руу чулуудчихлаа. Бүгдээрээ цашид юу болохыг үл ухааран, айж мэгдэн ухасхийн босоцгоов. Би төдхөн нөгөө буландаа очиж суулаа. Бараг л иймэрхүү зүйл тохиолдож, мисс Жен Анн Стамперийг заамдан авч хөөж гаргасан удаа бий. Миний бие түүний эрэлхэг зоригт урамшин, тэрхүү зовлонг нь эдлэхэд бэлэн байлаа.

Гэвч тийм юм болсонгүй. Эблвайт өвгөн эхнэртээ хандаж,

-Хэн-хэн-хэн энэ ичгүүрээ алдсан хэнхэг эмийг энд урьж ирүүлсэн юм бэ? Та юу? Гэж галзууртлаа уурсан бувтнав.

Эблвайт эгчийг ам нээхээс өмнө,

-Мисс Клак миний урилгаар айлчилж байгаа юм хэмээн Рэчел хариуллаа.

Энэ үг Эблвайт өвгөнд их л хачин нөлөөлсөн юм. Шатталаа уурлаж хилэгнэж байснаа гэнэт тайван цэвдэг дүртэй болчихов. Рэчелийн товч, тодорхой хариунаас Эблвайт өвгөн, Рэчелийн цаана гарч, хариугаа авах сэжим олжээ гэдгийг бүгд ойлгосон юм.

-Тийм бий? Мисс Клак миний байшинд таны урилгаар айлчилж байгаа хэрэг үү?

Үүнийг сонсоод Рэчел гэсвэр алджээ. Царай нь улайж, нүд нь хилэнтэй гялалзав. Хуульч руу эргэж, мистер Эблвайтыг заагаад,

-Юү гэсэн үг юм бол? Хэмээн ихэмсэг бардам асуув.

Брафф ярианд гурав дахь удаагаа оролцож, Эблвайтад хандан,

-Та энэ байшинг мисс Вериндерийн асрамжлагчийн хувьд мисс Вериндерт зориулан хөлсөлж авсана мартсан бололтой гэсэнд мистер Эблвайт үгий нь тас дайран,

-Тэгтлээ бүү яар. Надад эцсийн нэг хэлэх үг байна. Түрүүн энэ... гээд шившгийн муу нэр хоч сүвэгчлэн миний зүг харав –Түрүүн энэ гэртээ өтөлсөн галзуу хүүхэн бидний яриаг таслаагүйсэн бол хэлэх байсан юм. Эрхэм ээ, миний хүү мисс Вериндерийн нөхөр байхад тохиромжгүй юм бол, эцэг нь мисс Вериндерийн асрамжлагч байж бас таарахгүй гэж үзсэнээ мэдэгдэхийг зөвшөөрнө үү. Вериндер хатагтайн гэрээслэлээс татгалзаж байгааг минь ойлож соёрхоно уу. Би таны хуулийн мэргэжлийн хэлээр илтгэвэл, би асрамжлагчийн үүргээс биеэ чөлөөлж байна. Энэ байшинг би нэр дээрээ хөлсөлж авсан. Үнэ хөлс төлөхтэй холбогдсон бүхий л хариуцлагыг би үүрч байгаа юм. Энэ миний байр. Энэ байшинг эзэмшинэ үү, эсвэл хөлсөлнө үү, миний дурын хэрэг. Мисс Вериндерийг шавдуулах гэсэн юм алга. Харин ч өөрийн гийчин болон эд хогшлыг аятай үедээ л эндээс авч гараарай.

Эблвайт доор мэхийн ёслоод өрөөнөөс гарч одов. Хүүтэй нь гэрлэхээс татгалзсаны хариуг Эблвайт Рэчелээс ийнхүү авчээ!

Үүд хаагдмагц Эблвайт эгч ер бусын их хүч гаргахыг хараад бид цөмөөрөө дуугаа хураав. Өрөөгөөр хөндлөн гарах хүч хүрчээ!

-Хонгор минь хэмээн Рэчелийн гараас барьж, -Нөхөр маань уурлаж хилэгнэсэндээ чамтай тэгж харьцсаныг мэдээгүйсэн бол би түүний өмнөөс ичиж зовох байлаа гээд бас дахин хүч гарган, миний сууж байсан булан руу харж, -Та л түүний эгдүүцлийг хүргэсэн шүү. Таныг болон таны ном шастирын барааг дахиад харахгүй гэж найдаж байна гэв. Тэгээд Рэчел рүү эргэж очоод үнсэж,

-Хонгор минь хэмээн Рэчелийн гараас барьж, -нөхөр маань уурлаж хилэгнэсэндээ чамтай тэгж харьцсаныг мэдээгүйсэн бол би түүний өмнөөс ичиж зовох байлаа гээд бас дахин хүч гарган, миний сууж байсан булан руу харж, -Та л түүний эгдүүцлийг хүргэсэн шүү. Таныг болон таны ном шастирын барааг дахиад харахгүй гэж найдаж байна гэв. Тэгээд Рэчел рүү эргэж очоод үнсэж,

-Хонгор минь, нөхрийнхөө өмнөөс уучлал гуйя. Би чамд яаж тус болох билээ? Гэж хэлэв.

Ямагт зөрүүд гөжүүн загнадаг, насан туршаа эрхэлж тунин, мунхаг хөнгөн авирлаж ирсэн Рэчел тэр шалихгүй үгэнд уярч, нулимс асгаруулан нагацыгаа дуу шуугүй үнслээ.

-Мисс Вериндерийн өмнөөс хариулахыг надад зөвшөөрвөл, Пенилопыг доошоо орж, эзэгтэйхнээ малгай, ноосон алчуурыг аваад ир гэж хэлнэ үү гэснээ Брафф гуай дуугаа намсган –Бид хоёрыг арван минут үлдээгээч, та надад итгэж болно. Би хэргийг Рэчел та хоёрт хоёуланд ашигтайгаар шийдье хэмээн нэмж өгүүлэв.

Энэ айлынхан тэр хүнд итгэж найддаг нь нэг л хачирхмаар ажээ. Эблвайт эгч нэг ч үг дуугаралгүй өрөөнөөс гарав.

Брафф араас нь харсаар хоцроод,

-Хараач хө! Хэрнакстлийнханд дутагдал бий нь ч бий. Гэвч сайн гарал язгуурт нь өөр нэг юм байна шүү! хэмээн дуу алдлаа. Тийнхүү жинхэнэ төрийн хар хүний ёсоор дүгнэхчээд миний гарахыг хүлээх мэт наашаа сүрхий ширтэв. Рэчелийг гэсэн миний сэтгэл Браффыхтай зүйрлэх аргагүй их байсан тул би сандалд хадуулсан мэт суусаар байлаа.

Брафф Монтегю талбайн байранд намайг гаргах гээд дийлээгүй шигээ сая ч бас дийлсэнгүй. Цонхны хажууд байсан сандалд Рэчелийг аваачиж суулгаад тэнд ярилцаж эхэлсэн юм.

-Эрхэм авхай минь, мистер Эблвайтын зан авир үнэндээ, таныг балмагдуулж, гомдоолоо. Иймэрхүү хүнтэй маргах нь зохистой байсан ахул түүнийг дураараа авирлах эрхгүй гэдгийг нь тэр даруйд үзүүлэх байлаа. Гэвч маргаад дэмий байв. Түүнийг хайхрах хэрэггүй гэж та тун оночвтой хэлсэн.

Мистер Брафф үгээ таслан миний суусан булан руу хяламхийв. Би шаситрууднаа сугавчлан, мисс Жан Анн Стамперээ өөв рдээр тавиад огт хөдөлгөөнгүй сууж байлаа.

Мистер Брафф Рэчел рүү эргэн харж өгүүлдүүн:

-Хөөрхий эх чинь сайхан сэтгэлтэй хүн байсан болохоор хүмүүсийн муу талыг олж харахгүй, дандаа сайн талыг нь л хардаг байсныг та андахгүй. Хүргэн ахыгаа таны асрамжлагч болгох гэж гэрээсэлсний учир бол түүнд итгэж, бас эгчийгээ баярлуулах гэснийх билээ. Би хувьдаа Эблвайт өвгөнийг ер таашааж байгаагүй, тийм ч учраас би таны эхийг ятгаж, хожим хэрэг гарвал гэрээслэл гүйцэтгэгч нь надтай зөвлөсний дагуу асрамжлагчийг өөрчилж болно гэсэн зүйл оруулсан юм. Өнөөдөр яг л тийм хэрэг гарлаа. Эдгээр албан ёсны нарийн ширийн зүйлийг нэг тийш болгоод эхнэрийнхээ даалгаврыг дуртайяа уламжилъя. Та Брафф хатагтайн урилгыг хүлээн авч соёрхоно уу? Дараа хашир, ухаалаг хүмүүс бид хоорондоо зөвлөж, хэрхэхийг шийдтэл манай гэрийн нэг гишүүн болж манайд уухыг зөвшөөрөх үү?

Үүнийг сонсоод би бослоо. Эблвайт эгчээс Рэчелийн малгай, алчуурыг авчруулаач гэж хүсэхэд нь би яг л ийм юм болох вий гэж айж байсан билээ.

Намайг ам нээж амжаагүй байтал Рэчел түүний урилгыг маш халуун дотноор хүлээж авлаа. Хэрэв тэдний ийнхүү тохиролцсоноо хэрэгжүүлэхийг нь зөвшөөрвөл, хэрэв Рэчел, Брафын босгыг алхах л юм бол миний горьдлого талаар өнгөрч, аманд орсон тосыг хэлээрээ түлхсэнтэй чанар нэг болно. Ийм гай зовлонг ухаармагц би бүр мэгдэж орхилоо. Болгоомжтой хянуур бодлоос үүдэн гарах яль шальгүй саад тотгорыг арчиж хаяад, хөөрч догдолсондоо аманд осрон үгээ хэллээ.

-Зогс! Болиоч! Мистер Брафф та миний үгийг сонсох ёстой! Би Рэчелийн хамаатан болохоос, та биш. Намайг асрамжлагчаар нь томилооч гэж би гэрээслэл биелүүлэгчээс гуйна. Рэчел ээ, хайртай хонгор Рэчел минь, миний ядуу гэрт очооч. Дараагийн галт тэргээр Лондон явж, манайд очиж суу л даа, хонгор минь! Гэж дуу алдав.

Брафф юу ч хэлсэнгүй. Рэчел намайг улайм цайм сонжиж гайхан ширтэнэ.

-Друзилла, та их сайн хүн юм. Би Лондонд очихоороо танайхаар заавал орно. Гэвч би мистер Браффын урилгыг нэгэнт хүлээж авсан, тэгээд ч бас одоогоор мистер Браффын ивээлд орох нь дээр гэж бодогдоно гэж Рэчел хариулав.

-Өө, тэгж битгий яриац! Рэчел, би танаас хагацаж чадашгүй нь, чадашгүй! Хэмээн би гуйж гувшлаа.

Би түүнийг тэврэх гэтэл ухарч холдов. Миний сэтгэлийн хөөрөл Рэчелд нөлөөлсөнгүй, харин айлгажээ.

-Юунд ингэж дэмий сүйд болно вэ? Би ер ойлгосонгүй гэж Рэчел хэлсэнд,

-Би ч бас ойлгохгүй байна гэж Брафф өгүүлэв. Тэдний хатуу сэтгэл, сүсэггүй хатуу сэтгэл нь миний зэвүүг хүргэсэн юм.

-Ай Рэчел, Рэчел! Хэмээн би дуу алдаад, -Таныг христос сүсэгтэй болгохсон гэж чин санаанаасаа эрмэлзэн хичээж байгааг минь харахгүй байна гэж үү дээ? Хайрт эхийг чинь эрлэг миний гараас булааж авчихаас нь өмнө талийгаачийн төлөө зүтгэж байсныхаа нэг адил бас чамайг гэж санаж сарвайж байгааг минь ойлгохгүй байна гэж үү? Гэлээ.

-Рэчел нэг алхам ойртоод намайг тун жигтэй ширтэн,

-Юунд эхий минь ясыг өндөлзүүлнэ вэ? Мисс Клак, та тайлбарлаж хайрлана уу гэж асуув.

Намайг хариулахаас өмнө Брафф дөхөж ирээд Рэчелийг авч гарах санаатай гараа өгөнгөө,

-Хонгор минь, энэ яриаг зогсоосон нь дээр. Мисс Клак та тайлбар тавиад хэрэггүй биз гэв.

Хэрэв би саваа ч юмуу, чулуу байгаад хөндлөнгөөс ингэж хошуу дүрсэн явдал харсан бол үнэн мөнийг таниулаад өгөх байсан даа. Би Браффыг эгдүүцэн түлхээд, нүглээ наминчилалгүй нас нөгчихөөс илүү аймшигтай гай зовлон байдаггүй тухай христосын номлолыг ёслол төгөлдөр дуугаар учирлан ярив.

Рэчел айж мэгдсэн дуугаар чарлан надаас ухасхийн зайлсан гэдгийг бичихээс ч ичиж байна.

-Явъя! Бурхан тэнгэрийг бодож, энэ эмэгтэй өөр юм хэлэхээс өмнө шалавхан явъя! Ай, хайрт ээж минь хэнд ч гэмгүй, хүнд тустай сайхан амьдарч байсныг нь бодоод үз л дээ! Мистер Брафф та оршуулах ёслолд оролцсон. Хүн болгон ээжид чинь хэчнээн хайртай байсныг та харсан биз дээ. Гэтэл энэ олиггүй авгай, энэ ертөнц дээр бурхан шиг байсан ээжийг минь диваажинд очсон гэдэгт намайг эргэлзүүлэх санаатай оролдож байна! Ийм яриа сонсож зогсоод яах вэ! Явъя! Энэ авгайтай цуг нэг агаараар амьсгална гэхээс ч ой гутаж байна! Нэг өрөөнд хамт байна гэж бодохоос ч аймшигтай байна! Хэмээн Брафф хэллээ.

Яаж ч сэнхрүүлээд үг авахгүй үүд рүү харайлгав.

Яг тэр үед шивэгчин нь Рэчелийн малгай, ноосон алчуурыг барьсаар орж ирсэнд хам хум өмсөөд,

-Миний юмнуудыг бэлтгээд мистер Браффанд аваач гэж хэлэв.

Би Рэчелд ойртох гэж оролдов. Миний сэтгэл ихэд гонсойсноос биш гомдоогүй бөгөөд “Бурхан тэнгэр хатуу сэтгэлийг чинь уяраах болтугай! Би таныг дуртай уучилъя!” гэж хэлэх гэсэн билээ. Гэтэл Рэчел гивлүүрээ буулган, миний гараас алчуураа угз татан аваад ухасхийн гарч, улаан нүүр өөд хаалга саван хаав. Тэр доромжлолыг б ихээхэний хатуужилтай зангаараа тэсэн өнгөрөөв. Одоо энэ явдлыг өөрий биеийг аливаа доромжлолд өртөшгүй дээгүүр тавьж заншсанаараа дурсан санаж байнам.

Брафф бас л яаран гарч гүйхийнхээ өмнө элэг доог хийсэн ёжтой үг чулуудсан юм.

-Мисс Клак та тайлбар тавиагүй нь дээр байж дээ гэж хэлээд мэхийн ёсолж, өрөөнөөс гарав.

Нөгөө малгайдаа эрээн мяраан туузтай бүсгүй хойноос нь алхсанаа,

-Хүмүүсийн дунд яс хаясан гэмтэнг олж цөхөлтгүй, харваас андашгүй байна. Би нэг муу шивэгчин гэлээ ч таны өмнөөс ичиж зовсноо хэлчихье! Гээд бас л хаалга саван гарч одлоо.

Би өрөөнд ганцаар хоцров. Бүх хүнд загнуулж, хаягдаад ганцаархнаа хоцорлоо.

Сүсэггүй улсын дунд хавчигдаж, хяхагдсан христос мөргөлтөнд учирсан энэхүү сэтгэл уяраам явдалд энэхүү тодорхой баримт нотолгоон дээр хэлэх юм байна уу? Алга! Миний амьдралд тохиолдсон олон арван эрээн мяраан явдлыг нэг ингээд шувтарсан нь өдрийн тэмдэглэлээс тодорхой байна. Тэр нэгэн өдрөөс хойш би Рэчелийн барааг ер хараагүй. Намайг доромжилсныг нь би тэр даруй өршөөсөн. Хожмын өдрүүдэд би түүний төлөө залбирч байлаа. Би амьсгал хураах цагтаа Рэчелийн бачийг ачаар хариулж, мисс Жан Анн Стамперийн “Аж төрөл, захидал, хөдөлмөр” хэмээх номоо гэрээслэн үлдээнэ.

## I бүлэг

Сайхан анд мисс Клак маань үзгээ тавьж, миний бие залган авч бичих болсонд хоёр шалтгаан бий юм.

Нэгдүгээрт гэвэл, өдий хүртэл балархай үлдсэн хэдэн зүйлийг зохих ёсоор тодруулж чадна. Гэрлэх амнаасаа буцах нэг нууц шалтгаан мисс Вериндерт байсан бөгөөд би түүний буруутан билээ. Годфри Элбвайт дур булаам үеэл дүүгийнхээ гарыг гуйх аливаа эрхээсээ татгалзах болсонд нэг нууц шалтгаан байсан бөгөөд би түүнийг нь илрүүлсэн билээ.

Хоёрдугаарт, аз уу, эз үү бүү мэд, ямар боловч одоо танд толилуулахаар завдан буй тэр үед миний бие энэтхэгийн алмазын хэрэгт орооцолдчихсон юм. Нөгөө гурван энэтхэгийн тэргүүлэгч байснаас зайлахгүй ер бусын эелдэг сайхан төрхтэй дорно зүгийн нэг үл таних хүнийг ажил дээрээ хүлээн авч ярилцах завшаан надад нэг удаа тохиолдлоо. Маргааш нь би алдарт жуулчин Мэртвэтэй

уулзаж, Саран чулууны талаар ярьж хөөрсөн ба тэр нь хожмын үйл явдалд маш чухлаар нөлөөлсөн гэдгийг нэмж хэлсүгэй. Дараачийн хэдэн хуудсыг бичих эрхтэй болсноо товчоор учирлахад ийм байна.

Гэрлэх ёслол хийхээр тохирсноо цуцалсан үнэнч учрыг нэгдүгээрт дурдсан тул өмнө энэ тухай өгүүлэх ёстой. Үйл явдлын хэлхээсийн нэг үзүүрээс хөөж дуустал нь эргэн хараад, миний сайн танил найз агсан Жон Вериндер ноёны унтлагын өрөөнөөс хүүрнэлээ эхлэх нь зүйтэй хэмээн шийдсэн маань танд зэгсэн хачин санагдах буй заа.

Эрхэм Жон Вериндер хүн төрөлхтөнд заяасан гэм хоргүй хүлцэнгүй (дэндүү их ч байж болзошгүй) хүн байлаа. Одоогийн өгүүлэх явдалд холбоотой нэг сул тал байсан нь, түүний бие эрүүл саруул ахуйдаа гэрээслэл бичихээс зайлсхийн жигтэйхэн дургүйцдэг байлаа. Түүний эл үүргийн чухлыг ойлгуулах гэж Вериндер ахай ч чадлаараа оролдож, би ч бас ятгасан билээ. Түүнийг булшинд аваачсан өвчин тусахас өмнө бидний үгийн үнэн зөвийг зөвшөөрөхөөс ер хэтэдэггүй байв. Тэгсээр эцэстээ нэг өдөр гэрээслэлийнхээ талаар заавар өгөх гэж намайг дуудуулжээ. Би хуульчийн ажил эрхэлсээр тийм энгийн гэрээслэл ер үзсэнгүй.

Намайг өрөөнд нь ороход Жон Вериндер ноён зүүрмэглэж байлаа. Миний бараанаар сэрж,

-Сайн байна уу, мистер Брафф? Би нэг их удахгүй ээ. Тэгээд унтах минь гэж хэлээд намайг үзэг, бэх, цаас гаргахыг ихэд сонирхон харснаа, -Та бэлэн болов уу? гэж асуув.

Би мэхэхсийж, үзгээ бэхэнд дүрээд заавар хэлэхийг хүлээлээ. Гэтэл Жон Вериндер ноён,

-Бүх юмаа эхнэртээ үлдээе. Гүйцээ гэгчхээд цаашаа эргэж унтахаар зэхэв.

-Та өнөө хүртэл эзэмшиж байсан бүх эд хөрөнгөө цөмийг Вериндер ахайд үлдээж байгаа хэрэг үү? Гэж би лавлав.

-Тийм ээ, харин би их л товчхон хэллээ. Та ч гэсэн товчхон шиг бичээд намайг унтуулж болохгүй юу? Бүгдийг эхнэртээ үлдээе. Миний гэрээслэл гэвэл энэ л байна.

Эд хөрөнгө нь бүгд түүний эзэмшлийнх агаад үндсэндээ эдлэн газар ба мөнгөн хөрөнгө (би зориуд албаны нэр томъёо хэрэглэхээс зайлсхийе) гэсэн хоёр төрлийн байв. Иймэрхүү тохиолдлын ихэнхэд байдаг шигээр би гэрээслэлээ дахин шүүж үзэхийг түүнээс шаардахыг өөрийн үүрэг гэж үзэх байсан билээ. Гэвч тухайн тохиолдолд Вериндер ахайтан аливаа сайн эхнэрийн ёсоор нөхрийнхөө бүрэн итгэлийг үл хөсөрдүүлэх төдийгүй, тэр их эд хөрөнгийг эзэмшиж эрхлэх чадвартайг (гэтэл ийм чадвар мянган эмэгтэйн дөнгөж нэгд нь л байдгийг би туршлагаасаа мэднэ) би мэдэж байв. Аравхан минутын дотор Жон ноёны гэрээслэлийг бичиж, баталсан бөгөөд Жон Вериндер ноён тасалдсан нойроо авахнаар унтав.

Вериндер ахай ч нөхрийнхөө итгэлийг хөсөрдүүлсэнгүй. Бэлбэрснийхээ дараахан намайг дуудаж, гэрээслэлээ болосруулсан юм. Өөрийнхөө байдлыг тун ухаалаг зөв ойлгож байсан учраас түүнд зөвлөгөө өгөх шаардлага надад гараагүй билээ. Зөвхөн гэрээслэлийн төслийг албаны хэлбэрт оруулан хуулснаар миний хариуцлага гүйцсэн юм. Жон ноёныг оршуулаад хоёр долоо хоноогүй байхад охиных нь ирээдүйг маш ухаалаг, халамжтайгаар шийджээ.

Гэрээслэл нь миний ажлын өрөөний шатдаггүй төмөр шүүгээнд хэчнээн жил болсныг ч мартжээ. Мянга найман зуун дөчин найан оны зун л тэр гэрээслэлийг нэн уй гашуудалтайгаар дахин гаргаж харж билээ.

Яг тэр үед докторууд хөөрхий Вериндер ахайд шууд утгаар нь хэлбэл алах ял заачихаад байлаа. Биеийн байдлаа хамгийн түрүүнд надад мэдэгдсэн ба гэрээслэлээ надтай цуг эргэж нэг үзье гэжээ.

Охинтойгоо холбогдуулан гэрээслэлд шинээр юм нэмэлтгүй байв. Гэвч улирах цагийн явцад зарим нэг хамаатан садандаа үлдээх өвийн талаар бодлоо нэлээд өөрчилсөн тул гэрээслэлийн эхэд гургав, дөрвөн зүйл нэмж оруулах шаардлага гарсан юм. Юу ч тохиолдлоо билээ. Сэрэмжилсний учир үүнийг нэн даруй гүйцэтгээд эдгээр зүйлийг шинэ гэрээслэлд нь оруулах зөвшөөрөл Вериндер ахайгаас авлаа. Ингэсний учир бол одоо нэгэнт анхны эхийг гутаасан, үнэндээ юмны учир зүйг зохицуулдаг миний мэргэжлийн ухамсрын үүднээс баахан харамсалтай санагдсан зарим зайлшгүй будлиан, нуршсан зүйлээс зайлсхийх гэсэндээ тэр байв.

Шинэ гэрээслэлийг баталсан тухай гэрчээр оролцож, тус хүргэсэн мисс Клак дээр нэгэнт өгүүлсэн билээ. Рэчел Вериндерийн мөнгөн өвтэй бхолбогдсон зүйлсийг анхны гэрээслэлээс үг гээлгүй хуулж оруулсан юм. Зөвхөн асрамжлагч томилох асуудалд миний зөвлөсний дараа би гэрээслэлийг батлуулах гэж нотариусдаа өгснийг ёсоор болгожээ.

Түүнэс гурван долоо хоногийн дараа шиг санана, нэг жигтэй хэрэг гарсан анхны сургийг би авсан юм. Нөгөө нотариус найзынхаа ажлаар орсонд, намайг арай л их хөөрцөглөн хүлээж авахыг нь ажиглалаа.

-Танд дуулгах нэг сонинтой. Иргэний асуудал эрхэлсэн хуульчдын нийгэмлэг дээр өнөөдөр юу сонссон гэж бодно? Вериндер ахайн гэрээслэлийг аль хэдийн хүн асууж, үзэж танилцсан байна! Гэж хэлэв.

Үнэхээр сонин мэдээ байлаа! Үгүйсгэж няцаахаар юм гэрээслэлд огт байхгүй. Тэр гэрээслэл хэний сонирхлыг татаж болохыг би бодоод олсонгүй. (Энд тайлбарлахад, иргэний хэрэг эрхлэх хуульчдын нийгэмлэгт хадгалуулахаар өгсөн бүхий л гэрээслэлийг ямар ч хүн хямдхан үнэ төлөөд үзэхийг хуулиар зөвшөөрсөн байдаг.

-Хэн үзээнийг нь мэдсэн үү? Гэж би асуулаа.

-Мэдсэн. Албан хаагч бүр итгэлтэй хэлсэн шүү. Скипп ба Смолли пүүсийн мистер Смолли үзсэн байна. Шинэ гэрээслэлийг бүртгэлд хуулж хараахан амжаагүй байсан учир анхны эхийг өгөхөөс өөр аргагүй болжээ. Мистер Смолли гэрээслэлийг маш хянуур уншиж, өврийн дэвтэртээ баахан тэмдэглэл хийжээ. Яах гэсэн юм бол, та юу гэжбодож байна?

Би толгой сэгсэрч,

-Мэдэхгүй юм даа, гэхдээ өнөөдрийн дотор заавал мэднэ гэж хэлчихээд ажил руугаа алхлаа.

Миний талийгаач түншийн гэрээслэлийг өөр пүүс тэгж жигтэй сонирхож байгаа юм бол би хүч гаргаж учрыг нь тайлах ёстой болно, Скипп, Смолли нарт би нөлөөтэй учраас надад нэлээд хялбар байсан юм. Миний конторт алба хаадаг ерөнхий эрхийн хуульч (онцын чадалтай, эрхэм сайн хүн дээ!) маань мистер Смоллийн дүү бөгөөд янз бүрийн шалтгаанас уламжлан, гардан шийдээд зохисгүй гэж миний үзсэн аа рсаар хэргүүдийг Скипп, Смоли нар эл хэдэн жилийн нүүр үзэж байв. Ийнхүү мэргэжлийн талаар тэтгэж, тэр пүүсэд дориун тус болдог билээ. Одоо хэрэг гарвал үүнийгээ санууля гэж бодож байв.

Ажил дээрээ очмогц нөгөө хүндээ учир явдлыг яриад Скипп, Смолли нарын амрыг эрээд, тэдэнд Вериндер ахай агсны гэрээслэлийг үзэж танилцах ямар шаардлага гарсныг мэдэх хүсэлтэй байгаагаа уламжлуулахаар ахынх нь ажил руу явуулсан юм.

Үүнийг сонсоод мистер Смолли дүүтэйгээ хамт миний ажил дээр алгуурлалгүй ирлээ. Нэг түншийнхээ зааврын дагуу ажилласнаа хүлээгээд илүү юм хэлбэл мэргэжлийн ёс зүйг зөрчихөд хүрнэ гэж учирлав.

Бид хоёр ширүүн маргалдав. Мэдээжээр түүний зөв, миний буруу байлаа. Үнэнийг хэлэхэд, би уурлаж хардаж, илүү юм мэдэх гэж зүтгэж байв. Тэр байтугай, өөртөө найдан итгэмжилсэн нууцтай зүйрлэж үзэхээс дургүйлхэж, бүрэн чөлөөтэй ажиллах боломж олгохыг шаардаж байв. Тэгээд бүр ч долоон дор авирлаж давуу талаа ашигласан юм.

-Эрхэм ээ, та тэр түншийнхээ эсвэл миний ажил төрлөөс салах болж дээ. Одоо шийдэгтүн! Гэж би мистер Смоллид тулгав.

Тэр бол огт уучилшгүй, зоргоороо авирласан хэрэг байсныг би үгүйсгэхгүй. Би зоргоор туйлагчдын нэгэн адил санаснаараа зүтгэж байлаа. Мистер Смолли өчүүхэн ч тээнэгэлзэлгүй шийдэж, хүлцэнгүй инээмсэглээд,

-Эблвайт Годфри хэмээн түншийнхээ нэрийг хэлсэн юм.

Уг хариу хангалттай байв. Надад өөр юм мэдэх шаардлага байсангүй.

Нэгэнт энэ зүйлд хүрсэн болохоор Вериндер хатагтайн гэрээслэлийн агуулгыг уншигч танд танилцуулах нь зүйтэй юм.

Товчхон хэлбэл, гэрээслэл нь Рэчел Вериндерийн зөвхөн насан туршийн амьжиргааг нь хангаснаас биш, эд хөрөнгөө нааш цааш болгох эрх олгоогүй билээ. Эхийнх нь гойд ухаан, миний их туршлага, түүнийг хожим хойно нүнжиггүй хомхой сувьдаг хүний гарт хохирч болзошгүй аюулаас сэрэмжлэн хамгаалсан юм. Рэчел ч, нөхөр нь ч (хэрэв хадамд гарвал) эдлэн газар болон мөнгөн хөрөнгөө дураараа ашиглах эрхгүй. Тэд Лондон, Иоркширийн байшинд сууж, бас арвин орлого авна. Тэгээд л гүйцэх нь тэр.

Би олж мэдсэн зүйлээ тунгааж бодоод цаашид хэрхэхээ мэдэлгүй мухардаж орхилоо.

Мисс Вериндерийг гэрлэх ёслол хийхээр зөвшөөрснийг нь сонсоод, мэл гайхаж, ихэд харамсан өдрөөс хойш нэг долоо хоног ч өнгөрөөгүй байлаа. Би мисс Рэчелийг үнэн сэтгэлээсээ бахдаж, хайрладаг учраас Годфри Эблвайттай гэрлэхийг тийнхүү хөнгөн хуумгай зөвшөөрснийг нь мэдээд, өгүүлшгүй их гуниг төрж билээ. Бал бурам шиг үгтэй хуурамч этгээд гэж миний үргэлж боддог тэр хүн одоо адгийн чанараа нотолж, мөн л зоосны нүхээр харж гэрлэх гэсэн нь эргэлзээгүй байв! "Тэгээд юү гэж? Ердийн л үзэгдэл шүү дээ" гэж та хэлж магад. Тийм ээ, хүндэт эрхэм минь. Гэвч таны дүүд ийм юм тохиолдсон бол та жишимгүй тайван байж чадна гэж үү?

Годфри Эблвайт, хуульчаасаа гэрээслэлийн агуулгыг мэдээд гэрлэх санаагаа орхиж болзошгүй гэсэн бодол надад хамгийн түрүүнд зүй ёсоор төрсөн юм. Энэ бол миний бие огт үл төсөөлөх түүний хөрөнгө мөнгөний байдлаас шууд хамарна. Хэрэв тартагтаа тулчихаагүй бол мисс Рэчелийн зөвхөн орлогод дулдуйдан гэрлэсэн ч түүнд ашигтай болно. Нөгөө талаар, Годфри Эблвайт тодорхой

хугацааны дотор үлэмж хэмжээний мөнгө олох шаардлагатай бол Вериндер ахайн хүсэл яг хэрэгжиж, охиноо луйварчны савраас аврах юм.

Хоёр дахь таамаглал зөв болбол эхээсээ хагацаж уй гашууд унаа дудаагүй байхад нь юу юугүй үнэн учрыг тайлж, урмыг нь хугалах хэрэг алга. Эхний таамаглал зөв байгаад би нүдэн балай өнгөрвөл Рэчелийг нэг насны зовлонд унагаах гэрлэлтийг нь дэмжсэн хэрэг болно.

Миссис Эблвайт мисс Вериндер хоёрын буусан Лондонгийн зочид буудалд очоод аливаа эргэлзээ арилсан юм. Тэд маргаааш нь Брайтон орохоор завдаж буйгаа, мөн Годфри Эблвайт хамт явах гэтэл гэнэт нэг саад учирлаа гэж ярив. Тэгмэгц би оронд нь явъя гэв. Рэчел Вериндерийн тухай санаандаа бодож, тээнгэлзэж байсан бол одоо нүүр учирмагц ямар ч атугай үнэнийг ний нуугүй хэлье гэж эрс шийдсэн юм. Брайтонд очсоны маргаааш нь салхинд хамт гарахдаа бидэнд ярилцах боломж таарсан билээ.

-Таны гэрлэх тухай сэдвээр ярьж болох уу? гэж би асуусанд,

-Өөр ярьчхаар сонин юм олдохгүй байгаа бол тэгье л дээ гэж хайш яйш хариулав.

-Та хайр сэтгэлдээ хөтлөгдөн гэрлэх гэж байгаа юмуу гэдгийг зүрхлэн асуучихвал мисс Рэчел та, танай гэрийн өвгөн анд, үнэнч зарцыг өршөөх үү?

-Мистер Брафф, би амьдралын эрхийг дагаж, амгалан тайван суух газар горилж л цөхрөнгөө барсандаа гэрлэж гэж байгаа юм.

Мөн сүрхий үг ээ! Энэ үгийн цаана янаг сэтгэлийн явдал нуугдаж байх шиг санагдав. Гэвч надад ярих зүйл байсан тул сэдвээсээ хазайсангүй билээ.

-Годфри Эблвайт арай ийм бодолтой байгаа нь юу л бол доо? Тэр хүн танд ядахдаа сэтгэлтэй биз дээ?

-Сэтгэлтэй ч гэсэн, би түүнд итгэх ёстой байх. Надад сайнгүй бол миний үнэн үгийг сонссон хэрнээ надтай гэрлэнэ гэж үү дээ?

Хөөрхий амьтан. Хувиа хичээж, эд хөрөнгөнд нь шунаж гэрлэх гэж байгаа эрийн авилгач хомхой санааг даанч тааварласангүй ажээ. Өөртөө авсан даалгавар санаснаас яггүй хэцүү бололтой.

-Миний хоцрогдсон үзлээр бол нэг л хачин...

-Юу хачин байна?

-Ирээдүйн нөхрийнхөө чин үнэнч сэтгэлд тээнгэлзсэн юм шиг өнгөтэй ярих чинь хачин сонсогдлоо. Танд эргэлзэх үндэс байгаа юм уу?

Үүнийг асуухдаа, уг яриаг цаанаа бодолтой, зоиуд үүсгэснийг сануулсан өнгө аяс гарсныг Рэчел бишрэм хэрсүү ухаанаараа доор нь ойлгожээ. Зогсож, гараа татаж аваад намайг сонжин ажигласнаа,

-Мистер Брафф, та надад Годфри Эблвайтын тухай нэг юм хэлэх гээ юү? Ярь л даа гэв.

Би Рэчелийг арван хуруу шигээ мэддэг учраас огтхон ч түдгэлзэлгүй бүгдийг ярилаа.

Намайг дахин сугадаад аажуухан алхав. Миний цааш өгүүлэхийг сонсох тусмаа намайг улам чанга сугадан, царай нь улам их цонхийвч нэг ч үг дуугарсангүй. Намайг яриагаа дуусгасан хойно ч дуугүй л байв. Миний явааг ч, ер орчны бүх зүйлийг умартаад, бодолдоо гүнээ дарагдан тэргүүнээ гудайсхийн алхана.

Би бодлыг нь сатааруулах гэж оролдсон ч үгүй. Зангий нь андахгүй болохоор иймэрхүү үед тайвширтал нь хүлээх хэрэгтэй гэж санасан юм.

Сонирхлыг нь татсан юм сонсохоороо элдэв шалдвыг асууж, шалгаачихаад, түргэхэн харайлган одож, сайн найз нартаа аманцарлан чалчдаг нь охид, хүүхнүүдийн ердийн зан билээ. Харин Вериндер Рэчел юуны өмнө, дотроо бодож тунгаадаг зантай ажээ. Энэхүү толгой даасан чанар бол эр хүний хувьд асар том эрхэм чанар мөн. Эмэгтэй хүний хувьд бол, ёс суртахууны ноцтой дутагдал гэж үздэг учраас түүнийг олон нийт ташаа тайлбарладаг юм. Би ч бас Рэчелээс бусад бүсгүйг тэгж л бодох буйзаа. Түүний бие даасан байдал нь миний бодлоор нэг сайн чанар юм. Нэг талаар, би Рэчелийг чин сэтгэлээсээ хайрлаж, бахархдаг учраас тэр. Нөгөө талаар гэвэл, түүний зан авирыг үл андах тул Саран чулуу алдагдсан хэрэгт холбогдсоныг нь би өөрийн үзэмжээр тайлбарлаж байсан учраас тэр бөлгөө. Очир алмазын хэрэгт тэр зан нь хэчнээн аягүй харагдавч, илрээгүй хулгайд ямар нэг хэмжээгээр холбогдсоныг нь мэдэхэд хачирхаж гайхах нь зайлшгүй хэдий боловч, Рэчелийг зохисгүй юм гэж яасан ч үйлдэхгүй гэдэгт би итгэж байлаа. Яагаад гэвэл, эхлээд бодож тунгаалгүйгээр нэг ч элхэхгүй гэдгийг нь би мэднэ.

Бид бараг нэг бээр явсны дараа Рэчел сая гүн бодлоосоо ангижрав. Гэнэт намайг урьдын жаргалтай үеийнх шигээ сулхан боловч мишээн харлаа. Тийм сайхан мишээл бүсгүй хүний царайд тодорч байхыг бие ер үзээгүй.

-Та надад маш их тус хүргэсэн. Одоо би таны ачийг бүр ч гүн санаж явна. Та Лондонд буцаж очоод миний гэрлэх тухай сонсвол миний өмнөөс няцааж байгаарай.

-Та гэрлэхээ болихоор шийдээ юү? гэж лавлахад

-Та тийм юм ярьчихаад миний шийдвэрт эргэлзлээ гэж үү? Хэмээн Рэчел бардмаар хариулав.

-Хонгор Рэчел минь, та цэл залуу хүн. Одоогийн байдлаасаа гарах нь танд санаснаас төвөгтэй байж болзошгүй. Зөвлөж, ярилцчихаар дотны эмэгтэй найз бий юу?

-Байхгүй.

Үүнийг сонсоод би үнэхээр их харууссан билээ. Тийм залуухан, ганцаархнаа мөртлөө бүх бэрхшээлийг үүрч гарахаас буцахгүй байдаг! Тиймэрхүү үед би эвгүйцэж, барьц алдаж магадгүй боловч Рэчелд туслахсан гэдэг хүсэлдээ дийлдэн толгойд орж ирсэн саналаа хэллээ. Энэ насандаа мөн ч олон хүнд зөвлөгөө өгч, тун ч ээдрээтэй хэргийг нучрыг олж байсансан. Гэтэл одоо гэрлэх амнаасаа хэрхэн буцвал зохихыг залуу бүсгүйд зөвлөх хэрэг анх удаа гарав. Саналаа товчхон өгүүлбэл: Годфри Элбвайтад (мэдээжээр, ганцаарчлан уулзаад) сувьдаг хомхой санаа агуулж гэрлэх гэсэн нь илэрсэн, нэгэнт цаад зорилгыг нь мэдсэн учраас түүний эхнэр болох аргагүй гэдгээ хэлнэ. Тэгээд нэг бол саналы нь зөвшөөрч, Рэчелийг дуугүй байлгах, эсвэл зөрж, санаснаараа зүтгэвэл Рэчел үнэн учрыг нийтэд зарлах болно, энэ хоёр замын нэгийг сонгогтун гэж сануулна. Биеэ өмөөрч, баримтыг няцаах гэж оролдвол надтай уулзуулах хэрэгтэй гэлээ.

Мисс Вериндер миний яриаг дуустал нь анхааралтай сонсов. Дара нь зөвлөгөө өгсөнд их л ялдамхан талархсан боловч энэ зөвлөгөөг дагах нөхцөлгүй гэдгээ бас хэлсэн юм.

-Учрыг асууж болох уу? гэж би шалгаав.

Рэчел тээнэгэлзсэнээ, миний өөдөөс асуулт тавьж,

-Годфри Элбвайтын зан авирыг та юу гэж бодож байна? Гэв.

-Би юу?

-Та юу гэж хэлэх вэ?

-Адгийн мэхчний авир гэнэ дээ.

-Мистер Брафф! Би тэр хүнд итгэж байсан, тэр хүнтэй гэрлэнэ гэж амласан. Тэгчихээд одоо түүнийг адгийн хүн, мэхчих хүн гэж хэрхэн нэрлэж олны нүдэнд шившгий нь тарьж хэрхэн чадах билээ?

Би түүнийг ирээдүйнхээ нөхрийг гэж бодсоноороо нэрээ гутаасан юм. Хэрэв таны зөвлөснөөр харьцана гэвэл, түүний өмнө доромж байдлаа хүлээнэ гэсэн үг. Би тэгж чадахгүй! Ичиж зовохыг Годфри Элбвайт юман чинээ тоохгүй байж магадгүй. Гэтэл би яавч тэсэхгүй!

Энд Рэчелийн бас нэг гайхамшигт чанар илрэв. Аливаа өөдгүй явдлыг үнэн голоосоо жигшдэг тул өөргийгөө ч умартах, найз нөхдийнхөө нүдэнд нэр төрөө гутааж болзошгүй боольшойтой байдалд орохоос ч сийхгүй байжээ. Би өгсөн зөвлөгөөнийхөө зохистой эсэхэд баахан эргэлзэж байлаа. Харин одоо Рэчелийн амнаас ийм үг сонссоны дараа дахиад сайн ятгаж, үгэндээ оруулъя гэж эргэлтгүй шийдсэн юм.

Гэтэл толгой сэгсэрч, нөгөө тайлбараа давтав.

-Намайг эхнэрээ болооч гэж гуйхдаа нэлээд дотно байсан. Би нэлээд хүндэтгэсэн учраас л зөвшөөрсөн. Гэтэл одоо адгийн шаар гэж хэлж чадахгүй!

-Гэхдээ хонгор Рэчел минь, тодорхой шалтгаан заалгүйгээр гэрлэхээ болилоо гэж хэлэх боломж танд бас л байхгүй шүү дээ гэж хэлж чадахгүй!

-Гэхдээ хонгор Рэчел минь, тодорхой шалтгаан заалгүйгээр гэрлэхээ болилоо гэж хэлэх боломжт анд бас л байхгүй шүү дээ гэж би эсэргүүцлээ.

-Эргэцүүлж үзээд, хоёулаа гэрлэхээ болибол хэн хэнд маань өлзийтэй юм гэж бодлоо гээ.

-Ердөө л тэр үү?

-Ердөө л тэр.

-Тэр хүний зүгээс юу гэхийг бодож үзэв үү?

-Юу дуртайгаа л хэлнэ биз.

Түүний эелдэг мөртлөө эрс шийдэмгий зан нь гайхахгүй байхын аргагүй. Түүнчлэн буруу замаар будаа тээх гээд байдаг нь гайхалтайн учир ямаршуу байдалд орчихоод байгаагаа сайтар бодож үзээч гэж гуйж гувшлаа. Түүний учирлан тайлбарласан шалтгааныг хүмүүс буруугаар ойлгож магадгүй гэдгийг ч сануулаад,

-Сэтгэл зүрхэндээ хөтлөгдөн олон түмний санаа бодлыг сөрөн зогсож та чадахгүй шүү дээ гэв.

-Чадна. Чадсан ч юм гэж Рэчел хариуллаа.

-Юу гэсэн үг вэ?

-Мистер Брафф, та Саран чулууны хэргийг мартжээ. Тэгэхэд би өөрийн гэсэн учир шалтгаанаа дурдсаар олон түмний санаа бодлыг сөрж чадсан шүү дээ.

Тийм хариу сонсоод би нэг хэсэг чимээгүй болов. Дөнгөж сая цухуйлгасан тэр хачин үгийг сонсоод, Саран чулуу алга болсон үед ямар учраас тийм зан авиртай байсныг нь мэдэхээр зорьсон

юм. Би арай залуу байсан бол тайлбарлаж дөнгөх байсан буй заа. Харин одоо бол барахгүй гэдэг нь мэдээж.

Харихын нь өмнө би дахиад нэг ятгаад үзлээ. Гэвч гуйвалтгүй хэвээр ажээ. Тэр өдөр Рэчелээс салж явахдаа Рэчелийн тухай жигтэйхэн зөрчилтэй бодол толгойд эргэлдэж байв. Рэчел гөжиж, буруугаар зүтгэж байлаа. Сонирхолтой, бахархмаар, туйлын өрөвдөлтэй ажээ. Хэлэх сонин гарвал надад нэн даруй бичнэ гэсэн амыг нь аваад сэтгэл онцгой зовж шаналсаар Лондонд буцаж ирлээ.

Миний эргэж ирсэн орой, Рэчелээс амалсан захиаг нь хараахан аваагүй байтал мистер Эблвайт гэнэт морилон ирж, яг тэр өдөр Годфри татгалзсан хариу авч түүнийг нь зөвшөөрчээ гэж мэдэгдсэн юм.

Миний бодлоор бол Годфри Эблвайтын дуулгавартай зөвшөөрсний цаад учир алган дээр мэт илт болов. Түүнд их хэмжээний мөнгө тодорхой хугацаанд хэрэгтэй байжээ. Бусад юунд ч хэрэг болж чадах Рэчелийн орлого энэ удаа л огтхон ч хэрэг болж чадахгүй байж. Иймээс ч Рэчел түүний зүгээс ямар ч эсэргүүцэлтэй тулгаралгүй салжээ. Үүнийг хоосон таамаглал гэж хэлэх юм бол насан туршаа эдлэх баялгийг авчрах хүнтэй ямар учраас гэрлэхээ болио вэ гэж би хариуд нь асууна.

Хэрэг явдал тийнхүү азтайгаар эргэсэнд баярласан боловч Эблвайт өвгөнтэй ярилцаад төдөлгүй хөөрсөн сэтгэл унтарсан юм.

Эблвайт мисс Вериндерийн этгээд авирласны урыг асуух гэж над дээр ирсэн юмсанж. Би ч олигтой хариу өгөөгүй гэдгээ хэлэх юун. Саяхан хүүтэйгээ уулзаж, эгдүүцэж хилэгнэсний дээр тийм бүтэлгүй хариу сонсоод бүр тэсвэр алджээ. Түүний нүүр царай, үг ярианаас үзэхэд маргааш Брайтонд очиход нь мисс Вериндер түүнээс ямар ч өршөөл горьдолтгүй болох нь илэрхий.

Цаашид хэрхвэл зохихыг эргэцүүлж тунгаасаар тэр шөнийг тух муутай өнгөрөөв. Тэгээд хэрхэн шийдсэнийг, мөн мистер Эблвайтын тухайд миний бие эндүүрээгүй болохыг, шаардлагатай газар нь нөгөө буянт бүсгүй Клак нэгэнт сүрхий сайн дүрслэн өгүүлсэн билээ. Нэмж хэлэх ганц зүйл гэвэл, хөөрхий мисс Вериндер Хэмпстедэд, манай гэрт очоод юу юунаас чухал хэрэгтэй амар амгалан, тайтгарлыг олж авсан юм. Манайд овоо удаан айлчилж соёрхсон бөгөөд эхнэр, охид маань дотно хайртай болцгоожээ. Гэрээслэл биелүүлэгч нар шинэ асрамжлагч томилж, манай зочин, манай гэрийнхэн анд нөхдийн журмаар салцгаасныг би үнэхээр бахархан, баяртайяа дурснам.

## II бүлэг

Одоо миний бие Саран чулууны талаар олж мэдсэн зүйлээ буюу нарийвчлан тодруулбал, тэрхүү очир алмазыг хулгайлан авахын тулд нөгөө гурван энэтхэг юу сэдэж төлөвлөсөн тухай өгүүлэх хэрэгтэй байна. Хэлэх зүйл хэдий бага ч гэсэн (би сануулсан байх аа) хожмын хэрэг явдалд гайхалтай хамаарах учраас ихээхэн чухал юм.

Мисс Вериндер манайхаас яваад долоо ч юмуу, арав хонож байтал манай нэг албан хаагч миний ажлын өрөөнд нэрийн хуудас барьсаар орж ирээд, нэг эрхэм надтай уулзахаар доор хүлээж байна гэж мэдэгдсэн юм.

Нэрийн хуудсыг авч үзвэл гадаадын хүний нэр байсан бөгөөд одоо мартжээ. Харин хуудасны доод буланд англиар “Септимус Люкер явуулав” гэж бичсэн байсныг би маш тод санаж байна.

Мистер Люкер мэтийн этгээд бөх зүрх гарган над руу хүн явуулж увайгүй авирласанд нь бүр гайхаш тасран, нүдэнэдэ итгэж ядан нэг хэсэг дуугүй суув. Манай ажилтан миний гайхсаныг мэдээд доор хүлээж буй харийн хүнийг ажиглаж, төрсөн сэтгэгдлээ хуваалцах нь зүйтэй гэж үзжээ.

-Эрхэм ээ, гойд содон төрхтэй эр байна. Хүрэн бор царайтай болохоор манай конторынхон энэтхэг ч юмуу, ер нь тэр хавийн хүн бололтой гэлцсэн.

Ажилтныхаа таамаглалыг, нэрийн хуудсан дээр хийсэн тэмдэглэлтэй харьцуулж үзээд мистер Люкерийн тийнхүү зуучилсан, мөн тэр үл таних хүн миний ажил дээр ирсэн нь Саран чулууны хэрэгт холбогдолтой байж ч юуны магад гэж бодлоо. Тэгээд ажилтнаа гайхуулан байж, доор хүлээж байгаа хүнтэй даруйхан уулзъя гэж шийдлээ.

Миний мэргэжилд огт хавьтахгүй сониуч зан гаргаж, ажил төрлөө хохироосноо цагаатгахын үүднээс, энэтхэгийн очир алмазын хэрэгт миний адил тийм нягт холбогдсон хүн наад зах нь Англид лав үгүй гэдгийг эдгээр мөрийг уншиж буй хүн б%үхэнд сануулахыг зөвшөөрнө үү. Хурандаа Хэрнкастель өшөө авагчдын гараас амь насаа хэрхэн аврахаар төлөвлөж буйгаа надад итгэмжлэн ярьсан билээ. Амьд сэрүүн байгаагаа мэдээлж надад тогтмол захиа бичиж байв. Саран чулууг мисс Вериндерт үлдээсэн гэрээслэлийг нь би боловсруулж өгсөн. Тэр очир алмаз тэднийд үнэт олбор болох учраас түүнийг үүргийнхээ дагуу Рэчел Вериндерт гардуулж өгөгтүн гэж би хурандаагийн гэрээслэл биелүүлэгчийг ятгасан юм. Эцэст нь, Фрэнклин Блэйкийн эргэж хургасан занг дийлж, очир

алмазыг мисс Вериндерийн гэрт хүргүүлэх болсон. Тэгэхээр миний бие Саран чулуутай холбогдсон бүхнийг сонирхох эрхтэйг хэн ч үгүйсгэхгүй буй заа.

Тэр нууцлаг түншийнхээ барааг хармагц, нөгөө гурван энэтхэгийн нэг, лав дарга нь иржээ гэдэгт дотроо бүрэн итгэсэн билээ. Европ маягаар тун нямбай хувцаслажээ. Гэвч түүний дорно зүгийн гарлыг илтгэсэн бор царай, уян налархай бие бялдар, ялдам ганган хөдөлгөөн аливаа гярхай хүний нүднээ шууд тусах ажээ.

Би түүнийг урьж суулгаад хэрэг зоригий нь асуулаа.

Тэр хүн юуны түрүүнд тав тух алдуулж зүрхэлсэндээ сонгомол англи хэлээр уучла лэрээд, хоргойдз ороосон боодолтой жижигхэн юм гаргав. Хоргой боодлоо болон давхар ороосон торгомсог эдийг задлаад эрдэнийн чулуугаар гар таталгүй, чамин гоёмсог чимсэн хар майлс модоор хийсэн бяцхан хайрцаг гарган миний ширээн дээр тавилаа.

-Эрхэм ээ, миний зорьж ирсэн хэрэг бол надад мөнгө зээлүүлэх боломжтой эсэхийг танаас асуух гэсэн юм. Тэгээд үүнийг танд барьцаанд үлдээе.

Би нэрийн хуудсыг нь зааж,

-Таныг мистер Люкер нааш нь явуулсан уу? гэж асуулаа.

Энэтхэг эр мэхэсхийв.

-Мистер Люкер яагаад танд мөнгө зээлүүлээгүй учрыг асууж болох уу?

-Хүнд зээлүүлэх бэлэн мөнгө байхгүй гэсэн, эрхэм ээ.

-Тэгээд нааш нь явуулсан юм уу?

Нөгөө энэтхэг нэрийн хуудас руу заагаад,

-Энд тэгж бичсэн байгаа гэв.

Товч, тодорхой хариу ажээ! Хэрэв Саран чулуу надад байсан бол дорно зүгийн энэ эрхэм намайг огт түдгэлзэлгүй цааш харуулчих байсанд би бат итгэж байв. Энэ бяцхан аягүй байдлыг эс тооцон өгүүлбэл, тэр энэтхэг хүн үнэхээр өөгүй үлгэр жишээч түнш байсныг хэлэх ёстой. Тэр хүн миний амь насыг юман чинээ тоохгүй байж магадгүй боловч миний цагийг хайрлаж байлаа. Гэтэл нэг ч англи хүн тэгдэггүй билээ.

-Та өөртөө төвөг удаж энд ирсэн нь харамсалтай. Мистер Люкер андуурч, таныг цааш нь явуулжээ. Миний мэргэжлийн бусад хүмүүсийн нэгэн адил надад ч бас мөнгө зээлээр өгөх ажлыг даалгадаг юм. Гэхдээ би танихгүй хүнд, таны өгч байгаа шиг ийм барьцааны хариуд мөнгө зээлүүлдэггүй.

Энэтхэг эр, намайг зарчмаасаа ухраач гэж бусад улс шиг гуйж гувших гэсэн ч үгүй, харин мэхэсхийгээд хар цагаан үг дуугаралгүй нөгөө хайрцага буцааж давхар ороолоо. Тэгээд өндийлөө. Намайг хариулж байх яг тэр мөчид тэрхүү шагшим сайхан алуурчин явахаар бослоо!

-Явахын өмнө танаас ганц юм асууя. Харийн хүнд хариу өгч тус болно уу?

Би хариуд нь мэхэсхийв. Салахдаа ганцхан юм асууна гэнэ! Гэтэл надаас дунджаар тавин юм асууж шалгаацгаадаг билээ.

-Эрхэм ээ, та надад мөнгө зээлдүүлээ гэж бодъё л доо. Тэгвэл ямар хугацаанд би эргүүлж төлөх ёстой вэ?

-Энэ оронд тогтсон ерөнхий заншлаар бол та хүсвэл зээлсэн мөнгөө яг жилийн дараа эргүүлж өгөх эрхтэй.

Энэтхэг эр сүүлчийн удаа доор мэхийн ёслоод өрөөнөөс гэнэт, сэмхэн гарч одлоо.

Тэгэхдээ нүд ирмэх зуур, чимээ аниргүй муур шиг хөнгөн шалмаг гарсан нь миний айдсыг бага зэрэг төрүүлснийг нуух юун. Юм бодож дөнгөхүйц сэхээ ормогцоо, тэрхүү учир битүүлэг зочныхоо цаад зорилгыг тодорхой ухаарсан билээ. Ярилцах үедээ тэр хүн туйлын хянуур байсан тул нүүр царай нь ч, дуу хоолой нь ч юуг ч үл илтгэнэ. Гэлээ ч гэсэн багийнх нь цаагуур зэрвэс боловч шагайх боломж надад олдсон юм. Эхлээд миний яриаг ер сонирхсон шинжгүй сонсож байлаа. Гэтэл зээлээр авсан мөнгөө хүмүүс хэдий хугацааны дараа төлж эхлэх эрхтэй тухай дурсах үед л ярианы турш анх удаа миний нүүрийг эгцлэн ширтсэн юм. Үүнээс үүдэн миний хийсэн дүгнэлт гэвэл, энэтхэг эр сүүлчийн асуултаа жич зорилгоор тавьсан ба миний хариуг сонсох тустай учир байжээ. Саяны яриаг сайтар тунгааж бодох тусам, энэтхэг эр хамгийн сүүлд асуусан зүйлээ сонирхохын тулд л хайрцаг авчирч, мөнгө зээлдүүлээч гэж шалтаг зохиосноос зайлахгүй гэдэг таамаглал улам үнэмшилтэй санагдсан юм.

Эл таамаглалынхаа үнэн зөвд эргэлзэхнийг больж, дараа нь урагш бас нэг алхаж, энэтхэг эргийн ирсэн шалтгаанг олох гэж оролдов. Тэгтэл нөгөө мистер Септимус Люкерийн захиаг авчирч өглөө. Ой гутам зусар зулгүй үгээр уучлал эрээд, хэрэв биеэр уулзаж соёрхвол бүгдийг ханатал тайлбарлая гэжээ.

Миний бие дахин мэргэжилдээ огт падгүй сониуч зан гаргаж, ажил төрлөө хохироов. Маргааш нь Люкер гуайтай ажил дээрээ уулзахаар болзов.

Люкер гуай, нөгөө энэтхэг эр хоёр бол өдөр, шөнө шиг зөрөөтэй ажээ. Люкер гуай, энэ хуудсанд дэлгэрэнгүй дүрслэн бичихийн ч хэрэггүй бүдүүлэг, заваан, бялдууч этгээд юм. Надад ярьсан зүйлийнх нь гол агуулгыг сийрүүлбэл:

-Нөгөө ганган энэтхэг над дээр ирэхийнхээ өмнөх өдөр мистер Люкертэй уулзжээ. Европ хувцастай байсан ч гэсэн урьд гэрийнх нь ойр хавиар эргэлдэн яршиг удаж шүүхэд мэдүүлэхээс өөр аргагүй байдалд хүргэж байсан гурван энэтхэгийн ахлагчийг даруй таньсан гэнэ. Эл хачирхмаар зүйлийг илрүүлээд тэр энэтхэг хүн бол нүдийг нь боож, аманд нь алчуур чихэж, банкны баримтыг нь дээрэмдсэн гурвын нэг мөн гэсэн дүгнэлтэд (зэгсэн үнэмшилтэй гэдгийг зөвшөөрч байна) хүрчээ. Үүний эцэст мистер Люкер айсандаа алмайр хөшөөд одоо ч хоногийн тоо гйүцжээ гэдэгт хатуу итгэсэн байна. Гэтэл нөгөө энэтхэг ер зүс үзээгүй хүний шинжтэй байв. Нөгөө бяцхан хайрцгаа гаргаж надад хандсан яг тэр хүсэлтээ өгүүлжээ. Түүнээс бушуухан салахын түүс болхдоо бэлэн мөнгө алга гэж хэлжээ. Нөгөө энэтхэг эр, мөнгө зээлдүүлж чадах найдвартай, сайн хүн зааж өгөхийг хүсэхэд нь, иймэрхүү хэрэгт голдуу нэр хүнд бүхий хуульч нар тус болдог гэжээ. Тийм хүний нэрийг хэлж өгөхийг хүсэхэд нь айж самгардсандаа, хамгийн түрүүнд санаанд нь орохоор намайг нэрлэсэн юмсанж.

-Би бүр усан хулгана болтлоо хөлөрчихсөн шүү, эрхэм ээ. Юу ярьж байгаагаа ч мэдэхгүй байсан. Брафф гуай, эрхэм ээ, сүнсээ хальтал айсныг минь харж үзээд та намайг буруушаахгүй болов уу гэж тэр унхиагүй этгээд үгээ төгсгөв.

Би түүнийг зэгсэн эелдгээр уучиллаа. Түүнээс салах хамгийн хялбар арга тэр байсан юм. Мистер Люкер гарахаар завдахад нь би түр саатуулж, нөгөө энэтхэг эр тэднийхээс явахын өмнө анхаарууштай юм хэлсэн эсэхийг лавлав.

Тэгжээ! Тэр энэтхэг салахынхаа өмнө надаас асуусан яг тэр зүйлээ асуусан бөгөөд мэдээжээр миний өгсөн шиг хариу авчээ.

Энэ юү гэсэн үг вэ? Люкерийн тайлбар уг асуудлыг шийдвэрлэхэд ямар ч тусыг үзүүлсэнгүй. Би ч оюун ухаанаа дайчлаад тэрхүү бэрх асуудлыг дийлсэнгүй. Тэр өдөр би айлд уригдсан байв. Хувцсаа солихоор шатаар сэтгэл гонсгор өгсөж явахдаа тухайн тохиолдолд өрөөндөө очих зам миний хувьд нууцыг тайлах зам болсон гэдгийг өчүүхэн ч төсөөлхгүй явсансан.

### III бүлэг

Тэр зоогонд мистер Мэртвэт хүндэт гийчнээр уригджээ. Тэр жуулчныг хорвоогоор тэнээд Англид ирэхэд нь зүсэн зүйлийн адал явдалтай учран, аюул ослоос эсэн мэнд мултран гарсан хүний хувьд олон түмэн ихэд шохоорхох бөлгөө. Одоо мөн л гавъяат үйлс хүлээсэн талбар луу тэгэхдээ хүний хөл тавиагүй зэлүүд нутагт очихоор завдаж буйгаа сонирхуулав. Эл баатрын аюул ослыг үл тоомсорлон, амь насаа дахин өрөхөөс буцахгүй гойд чанар нь хүмүүсийн унтарч эхэлсэн шохоорхлыг сэргээжээ. Түүнийг энэ удаад амь гарна гэхэд магадлалын онолоор даанч эргэлзээтэй ажээ. Алдар цуутантай цуг хоолож, мөдхөн амь үрэгдсэн тухай нь сонсож тун болзошгүй гэдгээ мэдрэн суух явдал бидэнд тэр болгон тохиолдохгүй билээ.

Хоолны өрөөнд дан эрчүүд үлдсэн хойно би мистер Мэртвэгийн хажууд суусан байв. Бүсгүйчүүдийг гармагц зочдын биеэ барьсан байдал дорхноо арилж, жинхэнэ англи хүний зангаар улс төрийн сэдвээр ярилцаж эхэлснийг хэлэх юун.

Манай үндэстний дийлэнх олны ухаангүй дурладаг энэ сэдвийн тухайд гэвэл, надаас өөр этгээд зантай англи хүн ер байхгүй буй заа. Улс төрийн яриа миний хувьд, ёс шиг хамгийн уйтгартай, хамгийн ашиггүй санагддаг юм. Эхний хундага хоосорсны дараа Мэртвэт гуайг ажиглаваас надтай нэг бодолтой мэт харагдав. Гэрийн эзнийг чадах ядахаараа хүндэтгэж, туйлаас хичээвч “зөөлөн бөхөд” дийлдэх шахан сууна. Саран чулууны талаар яриа өдөж, нойрыг нь сэргээжү гэдэг санаа толгойд зурсхийн орсон бөгөөд хэрэв энэ бүтвэл жирийн байдлаар миний албан тасалгаанд үргэлжлүүлсэн энэтхэгүүдийн хуйвалдааныг хэрхэн үзэж буйг нь мэдье гэсэн билээ.

-Мистер Мэртвэт би эндүүрээгүй бол та талийгаач Вериндер хатагтайг таньдаг байсан байх аа? Мөн Сара нчулуу алга болсноор төгссөн явдлыг сонирхож байсан байх аа? Гэж би үгээ хэлэв.

Алдарт жуулчин тэр даруй сэргэж миний хэн болохыг асуулаа.

Би Хэрнкастлийнхантай ямраар холбоотой байдгаа хэлэхийн хамт хурандаа Хэрнкастль болон түүний алмазын хэрэгт жигтэй үүрэг гүйцэтгэсэнээ марталгүй дурсав.

Мэртвэт гуай бусад зочдын зүг ар нуруугаа харуулаад Грэйс Инний эгэл нэгэн хуульч Брафф намайг анхааран соёрхсон юм.

-Тэр энэтхэгүүдийн талаар сүүлийн үед юм дуулдаа юу? Гэж асуусанд,

-Өчигдөр миний албан тасалгаанд тэдний нэг ирсэн гэж үзэх үндэс байна гэж би хариулав. Мистер Мэртвэт барагтай юм тоодог хүн биш боловч миний үгэнд мэл гайхжээ. Би өөртөө болон мистер Люкерт тохиолдсон явдлыг дээр өгүүлсэн шигээ нэгд нэгэнгүй яриад,

-Тэр энэтхэг эрийн явахдаа лавласан зүйл нэг л учиртай. Мөнгө зээлсэн хүн өрөө хэдий хугацааны дараа төлөх эрхтэй байдгийг мэдэх гэж юундаа тэгтлээ чармайсан юм бол? Гэж асуулаа.

-Мистер Брафф та учрыг нь ойлгохгүй байна гэж үү?

-Мистер Мэртвэт ээ, би мунхаг толгойноосоо ичиж байгаа ч ер ойлгохгүй нь ээ.

Алдарт жуулчин миний мохоо ухааны ёроолыг хүртэл уудлах гэж шийдэв бололтой.

-Нэг зүйл асууж болох уу? Саран чулуу хулгайлах зорилго тавьсан энэтхэгүүд одоо юу хийхээр завдаж байна вэ?

-Хэлж чадахгүй нь. Энэтхэгүүдийн санаа надад таагдашгүй оньсого л гэсэн үг.

-Мистер Брафф та ултайхан тунгааж бодоогүй учраас л энэтхэгүүдийн санаа оньсого шиг байгаа юм. Таныг хурандаа Хэрнкастлийн гэрээслэлийг зохиосон цагаас эхлэн энэтхэг хүн таны ажил дээр очсон үеийг хүртэлх бүх явдлыг хоёулаа нэг эргээд харчих уу?

Мистер Вериндерийн ашиг сонирхолд хэрэг болбол тэдний гэрийн хуульчийн хувьд эл хэргийн талаар тодорхой мэдэх нь танд ихээхэн чухал байж магадгүй юм. Үүнийг болгоон үзээд, энэтхэгүүдийн нууцыг лавтай тайлбарлах уу? Эсвэл зорилгын нууцыг зугуухан, дэс дараалалтай тайлбарлах уу, лавлаж, судалж толгойгоо зовоолгүй миний бодлыг шууд сонсмоор байна уу?

Үнэхээр догь санагдсан тул чухамхүү эхний саналыг сонгон авч зөвшөөрснөө хэлэх юун.

-Их сайн гэж мистер Мэртвэт хэлээд –Юуны өмнө тэр гурван энэтхэгийн нас сүүдрийг авч үзье. Гурвуул ойролцоо насны улс бололтой харагдсан. Тантай уулзсан нь ид гялалзаж яваа эр байсан биз? Дөч ч шүргээгүй хүн байна гэж бодсон уу? Би ч бас тэгж бодсон. За, дөч шүргээгүй гэж бодъё. Одоо Хэрнкастль Англид эргэж ирсэн үеийг түүнчлэн амь насаа хамгаалахын тулд түүни бодож олсон төлөвлөгөөнд таны гар бие оролцох болсон үеийг эргэн харцгаая. Би танаар нас сүүдрийг нь тоолуулах гээгүй байна.

Одоогийн энэ энэтхэгүүдийн нас сүүдрийг авч үзвэл, хурандаа Хэрнкастлийг Английн эрэг хүртэл мөшгин дагасан нөгөө гурван энэтхэгийн залгамжлагчид болж таарна. Тэр эх нутгаа орхин гарсан улсууд бүгдээрээ дээд зиндааны язгууртан бярманууд байсан юм мистер Брафф! Их сайн. Манай энэ энэтхэгүүд бол тэдний өмнө энд байсан улсынхаа халааг авчээ. Хэрэв халааг нь авснаас цаашгүй ахул эл хэрэг онц их сонирхол татахгүйсэн. Гэтэл энэ гурван хүн их юм хийжээ. Түрүүчийн зүтгэлтнүүд нь энэ оронд үүсгэсэн байгууллагын толгойлогч болжээ. Бүү сандар! Бидний ойлголтоор бол тэр байгууллага ёстой юу ч биш гэдэгт би эргэлзэхгүй байна. Энэ бол мөнгөтэй байж, хэрэг гарвал Лондонд нууцгай маягаар аж төрдөг сэжиг бүхий англичуудын тус дэмийг ашиглан, эцэст нь энэ том хотод есөн шидийн ажил эрхэлдэг нутгийнхныхаа, ядаж наад зах нь, шашин нэгтэй цөөн хүний талархлыг олж авах гэсэн учиртай байгуулалга юм. Үүнд аюултай юм өчүүхэн ч үгүй байгаа биз! Гэвч үүнийг анхаарвал зохино, яагаад гэвэл бид энэтхэгчүүдийн эл даруухан жижиг байгууллагыг цаашдын яриандаа дурсаж магадгүй юм. Одоо учир байдал нэгэнт тодорхой болсон тул танаас нэг зүйлийг лавлая. Чухам ямар хэрэг явдал, очир алмазыг гартаа оруулчихмаар анхны боломжийг энэтхэгчүүдэд олгосон гэж та бодож байна вэ?

Миний туршлагатай хашир гэдгийг юунд сануулсныг би ч ойлгосон билээ.

-Хурандаа Хэрнкастлийн үхэл тэдэнд анхны боломж олгожээ. Түүний нас нөгчсөнийг тэд доор нь мэдсэх байхаа даа гэж би хариуллаа.

-Мэдээжийн хэрэр. Таны хэлснээр, түүний үхэл энэтхэгчүүдэд анхны боломж олгожээ. Хурандааг нас барахаас өмнө Сара нчулуу банкны бат бэх санд хадгалаастай байлаа. Тэр үнэт чулууг зээ охиндоо үлдээсэн тухай гэрээслэлийг нь та хууль ёсны болгож, түүнийг хэвшсэн журмын дагуу баталсан. Үүний дараа энэтхэгчүүд (англи хүний зөвлөсөн ёсоор) ямар алхам хийснийг та хуульч хүний хувьд төвөггүй гадарлах биз.

-Хуульчдын нийгэмлэгээс гэрээслэлийн хуулбарын хувийг авч үзсэн байх.

-Яг зөв. Миний дээр өгүүлсэн сэжиг бүхий англичуудын нэг нь тэр гэрээслэлийн хуулбарыг тэдэнд олж өгсөн хэрэг. Саран чулууг Вериндер ахайн охинд гэрээслэн үлдээснийг, эцэг Блэйк юмуу, эсвэл түүний томилсон этгээд тэр эрдэнэсийг мисс Рэчелд гардуулж өгөх ёстой гэдгийг тэд гэрээслэлийн хуулбараас олж мэджээ. Вериндер ахай мистер Блэйк нарын зиндааны улсын талаар чухал мэдээллийг тун хялбар олж дөнгөдөг гэвэл та зөвшөөрөх биз. Харин алмазыг банкнаас авах үеэр нь үү, эсвэр Иоркширт, Вериндер ахайнд хүргэсэн хойно нь хулгайлах оролдлого хийх үү гэдгээ шийдэх л үлджээ. Хоёр дахь зам нь арай осол багатай байсан нь эргэлзээгүй.

Тэд Фризинхоллд илбэчний дүрээр очигцоосны шалтгаан гэвэл энэ юм. Лондон дахь байгууллага нь тэднийг мэдээ сэлтээр тасралтгүй хангаж байсныг яриад ч хэрэггүй. Хоёр хүн байхад л хүрэлцээтэй. Нэг этгээд нь мистер Блэйкийнхээс ямар хүн гарч, банкинд очихыг харуулдан

ажиглаж, нөгөө нь мистер Блэйк зарц нарыг шар айргаар дайлан гэрийн сониныг сонсож байснаас зайлахгүй. Ийм хялбар замаар, Фрэнклин Блэйк банк руу очихыг, түүнчлэн Вериндер ахайнд Фрэнклин Блэйк л айлчилна гэдгийг мэдсэн аж. Дараа нь хэрхсэнийг та надаас өөрцгүй сайн санаж байгаа нь дамжиггүй.

Фрэнклин Блэйк гудамжинд хүн мөшгин дагаж байхыг ажиглаад Иоркширт болзсоноосоо хэдэн цагийн түрүүнд очиж энэтхэгүүд Фризинхоллд очсоныг нь мэдэхээс өмнө өвгөн Бэттережийн эрхэм сургаалын ачаар нөгөө алмазыг Фризинхоллын банкинд хадгалуулсныг би санасан юм. Тэр болтол бүх зүйл тодорхой байна. Гэтэл тийнхүү сэргийлсэн арга хэмжээ авсныг энэтхэгүүд мэдээгүй хирнээ Вериндер ахайн сууцанд (алмаз бий гэж тэд бодох ёстойсон) нэвтрэх гэж Рэчелийн төрсөн өдрөөс өмнө яагаад, нэг удаа оролдоогүй бол?

Миний бие энэ ойлгомжгүй зүйлийг мистер Мэртвэтээс лавлахын хамт нөгөө жаал хөвгүүн, бэх сэлтийн тухай сонсоноо, түүнчлэн далдыг харах онол дээр үндэслэсэн аливаа тайлбар надад үнэмшилгүй санагдсан болохыг нэмж хэлэх нь зүйтэй гэж бодсон билээ.

-Би ч бас үнэмшихгүй гэж Мэртвэт гуай зөвшөөрөв. -Энэ тохиолдолд далдыг харна гэдэг бол ерөөсөө л энэтхэг романтик тал юм. Энэ хүмүүс харийн оронд сэтгэл санаагаа тайтгаруулж, сэргээхийн тулд зүдэргээтэй, осолтой ажил үйлээ гайхалтай, жирийн бус зүйлээр хүрээлэх гэдэг. Үүнийг англи хүн огт ойлгохгүй л дээ. Тэр жаал ховсын аргад хялбар автдагаас зайлахгүй бөгөөд түүний нөлөөгөөр ховсийн сэтгэсэн бодлыг тольдон авдаг нь лавтай. Би далдыг харах тухай онолыг судалж үзсэн, тэгэхэд үүнээс цааш гарсан юм олж тогтоож чадаагүй юмдаг. Энэтхэгүүд харин өөрөөр үзнэ. Нөгөө хөвгүүнийг тэдний нүдэнд үл харагдах зүйлийг харах увдистай гэж бодоцгоох бөлгөө. Давтан хэлэхэд, эл гайхамшигт ажлынхаа үед тэднийг нэгтгэн буй зорилгодоо хүрэх шинэ сэжүүр олсон байна. Хүний зан авирын сонин бөгөөд бидний хувьд цоо шинэ онцлогийг сонирхуулах гэсэнэдэ үүнийг дурдлаа. Эдүгээ та бид хоёрын эрхлэн буй эрэл хайгуулын үед хашир догль улс итгэхүйеэ бэрх далдыг харах, ховсдох мэт сэтгэлийн элдэв шалдав юмыг анхаарах сөхөөгүй байна. Миний бие, оновчтой арга хэрэглэн бодит үндэс шалтгаанаас дүгнэлт хийх зорилгоор энэтхэгүүдийн төлөвлөгөөг алхам алхмаар дэс дараатай судалсан м. Танд хангалттай зүйл хэлж чадав уу, би?

-Мистер Мэртвэт минь, яриа юу байх вэ! Гэхдээ түрүүхэн надаас лавлах завшаан тохиолдсон төвөгтэй асуудлын зохистой тайлбарыг л шалавхан сонсох юмсан гэж би хариуллаа. Мэртвэт инээмсэглээд,

-Үүнээс хялбар юм үгүй. Уг хэргийг та тун зөв тайлбарласан гэдгийг эхлээд хэлэхийг зөвшөөрнө үү. Энэтхэгчүүд Фрэнклин Блэйкийг алмазаа хэрхсэнийг үнэхээр мэдэхгүй байсан учраас түүнийг нагац эгчийндээ очсон хойно анхныхаа алдааг гаргасан байна.

-Анхны алдаа гэнэ ээ? Хэмээн би эргүүлж асув.

-Яг тийм! Тэр орой дэвсэг дээр Гэбриэл Бэттережтэй тааралдсан явдал тэдний алдаа болсон юм. Гэвч тэд алдаагаа доор нь ухаарчээ. Ягаад гэвэл, таны хэлснээр, төчнөөн их хугацаа байхад хэдэн долоо хоногийн турш Вериндер ахайн байшинд ер хавьтсангүй байна.

-Яагаад тэр вэ, мистер Мэртвэт. Би үүнийг мэдмээр байна! Яагаад?

-Яагаад гэвэл, нэг ч энэтхэг хүн хэрэгцээгүй үед азаа сорьдоггүй юм. Таны бичсэн, хурандаа Хэрнкастлийн гэрээслэлийн нэгэн зүйлд Саран чулууг мисс Вериндерт төрсөн өдрөөр нь гардуулах ёстой гэдгийг тэдэнд хэлээд өгсөн шүү дээ, мистер Брафф тийм биз дээ? Их догь. Ийм нөхцөлд хэрхвэл зохих вэ? Ямар нэг сэжиг авчихаад тэднийг овжин маэллаж дөнгөсөн Фрэнклин Блэйкийг байгаа үеэр алмазыг хулгайлах гэж оролдох уу, эсвэл бололцоо таарах бүрийд тэр гайхамшигтай эрдэнийг гэнэхнээр баясан хөөрч зүүх залуу бүсгүйн гарт орох цагийг хүлээх үү? Миний бодлын үнэн зөвийг батлан нотолгоо танд хэрэгтэй байж магадгүй ээ? Нөгөө гурван энэтхэгийн аяг зан үүний нотолгоо болог. Тэд хэдэн долоо хоног хүлээсний эцэст мисс Вериндерийн төрсөн өдөр тэднийд очсон бөгөөд тэвчин хичээснийхээ шанд залуу бүсгүйн палаажны энгэр дээр Сара нчуулу гялалзан байхыг харжээ! Тэр үдэш талийгаач хурандаа болон түүний очир алмазын түүхийг сонсоод миний бие Фрэнклин Блэйк хэчнээн айхавтар аюулд (Вериндер ахайнх руу ганцаархнаа буцсан бол замд нь гарцаагүй халдах байсан) эрсдэх байсанд ер эргэлзээгүй, түүнчлэн хожим мисс Вериндерт түүнээс ч долоон дор аюул учирна гэдэгт баттай итгэж байсан тул хурандаа агсны төлөвлөгөөг дагаж, уг чулууг хэдэн хэсэг хуваагаад үндсэн чанарыг нь устгагтун гэж зөвлөсөн юм. Гэтэл тэр шөнө хачин жигтэйгээр алга болсон нь миний зөвлөгөөг хэрэгцээгүй болгож энэтхэгүүдийн төлөвлөгөөг баллаж орхив. Маргааш нь тэднийг луйварчин тэнүүлчид хэмээн баривчилж, шоронд хорьсон явдал ямар нэг зүйл үйлдэхэд нь саад хийснийг та ч бас миний адил андахгүй мэдэж байгаа шүү дээ. Эхний үзэгдэл ингээд дууслаа. Цааш өгүүлэхийн өмнө миний тайлбар хашир догт хүнд хэр хангалттай санагдсан бол гэдгийг асууж болох уу?

Энэтхэг хүний зан авирыг арван хуруу шигээ мэддэгийн хүчинд түүнчлэн хурандаа Хэрнкастлийг нас нөгчсөнөөс хойш миний адил өөр хэдэн зуун гэрээслэл янзлах ажилд ухаан зарах

хэрэгцээ түүнд байгаагүйн ачаар дээрх төвөгтэй асуудлыг надад аятайхан тайлбарлаж өгснийг үгүйсгэх аргагүй!

-За, тэгэхээр хэмээн мистер Мэртвэт үргэлжлүүлэн –Энэтхэгүүдийг Фризинхоллын шоронд суулгасан тэр өдөр Саран чулууг гартаа орулах анхны боломж алдагдсан байна. Дараагийн эгзэг хэдийд гарсан бэ? Шоронд байхад нь гарсан гэж би баталж чадна. Тэгсэнээ өврийн дэвтрээ гаргаж, нээгээд өгүүллрүүн:

-Тэр үед би хэдэн найзтайгаа хамт Фризинхоллд очсон байлаа. Энэтхэгүүдийг суллахаас хоёр хоногийн өмнө, даваа гариг байсан шиг санагдана, шоронгийн харгалзаг надад нэг захиа авчирч өгсөн юм. Энэтхэгүүдийн хөлсөн сууж байсан байрны эзэгтэй Маккан гэдэг авгай тэр захиаг эзэнд нь дамжуулах санаатай шоронд очжээ. Тэр захиаг урьд өглөө нь Маккан авгайд шуудан хүргэгч өгсөн юмсанж. Дугтуй дээр Ламбет хтын шуудангийн тамга дарсан цэвэр англи хэлээр хаягласан хэдий боловч нэг л этгээд хаягласан байхыг шоронгийн эрхтнүүд анзаарсан ажээ. Захиаг задалбал гадаад хэлээр, энэтхэгийн нэг хэлээр бичсэн бололтой гэж тэд зөв таамагласан байна. Мэдээжээр захиаг орчуулуулах зорилгоор над руу иржээ. Би захианы эхийг орчуулгынхаа хамт дэвтэртээ хуулаад авчихсан юм. Май, та үз л дээ.

Надад өврийн дэвтрээ дэлгээстэй чигээр нь өгөв. Юуны өмнө хаягийг нь хуулж авсан нь ямар ч таслал тэмдэггүйгээр “Йоркширийн Фризинхоллд Макканг хэмээгч хатагтайн байранд сууж буй гурван энэтхэгт” гэж шууд цувруулан бичжээ. Дараа нь захидлын эхийг мэн доорх учир битүүлэг үг бүхий орчуулгыг хавсаргасан байна. “Бодь гөрөөс дээр залран, орчлонгийн дөрвөн зүгийг алдлан тэвэрч байдаг шөнийн эзний нэрийн өмнөөс айлтгасугай.

Ах дүү нар аа, өмнө зүг хандаж, бохир ус руу уруудан одогч хөл үймээнт гудамжинд, наашаа ирэгтүн! Ингэсний шалтгаан бол түүнийг би нүдээр харлаа”.

Захианы төгсгөлд сар өдөр ч, гарын үсэг ч тавьсангүй аж. Би мистер Мэртвэтэд эргүүлж өгөөд энэтхэгийн захидал харилцааны энэхүү хачин маяг намайг бүр мухардууллаа гэж үнэнээ хэлэн юм.

-Эхний өгүүлбэрийг би танд тайлбарлаж чадна. Харин энэтхэгчүүдийн үйлдсэн хэрэг бусад өгүүлбэргийн учрыг аяндаа хэлээд өгнө. Энэтхэгийн домогт, Сарны бурхныг дөрвөн мутартай бөгөөд бодь гөрөөс дээр залардаг гэж өгүүлсэн байдаг, бас нэг нэрийг нь шөнийн эзэн гэдэг юм. Энд дам утгаар Саран чулууг дурдсан байж тун ч болзошгүй мэт харагдана. За одоо, шоронгин захиргаа тэр захиаг гардуулсны дараа энэтхэгчүүд хэрхэнийг үзье. Тэд суллагдсан өдөртөө л төмөр замын буудалд очиж Лондон орох эхний галт тэргэнд суужээ. Энэтхэгчүүдийг сэмхэн мөрдөж тандалгүй зоргоор нь орхичихсондоо бид бүгдээрээ Фризинхоллд байхада их л харамсаж, халагласан билээ. Гэвч Вериндер ахай цагдаагийн эрүүлчийг буцааж, Сара нчулууг эрж хайх ажлыг зогсоосон учраас энэ хэргийг шийдэх талаар хэн ч, юу ч хийх нөхцөлгүй болсон юм. Энэтхэгчүүд Лондонд очиход саат тотгор гараагүй тул Лондон явжээ. Дараа нь юу болсныг мистер Брафф та сонссон биз дээ?

-Тэд Ламбетэд, Люкер гуайн байрын ойролцоо эргэлдэж, баахан залхаасан гэж би хариулав.

-Люкер шүүхэд гомдол мэдүүлсэн тухай та сониноос уншсан уу?

-Уншсан.

-Мөн хулгайд сэрдэж, нойтон хамуу шиг алахгүй зовоох энэтхэгүүдтэй эцнээ сүлбээтэй байж магадгүй хэмээн сэжиглээд, гадаадын нэг ажилтнаа халсан тухай дурсааныг нь та мартаагүй биз. Тэгэхээр мистер Брафф таныг сая мухардуулсан захиаг хэн бичсэн, мөн нөгөө халагдсан ажилтан Люкер гуайгаас дорно зүгийн чухам ямар эрдэнийг хулгайлах гэж оролдсон тухай дүгнэлт аяндаа тодорхой болно.

Эл дүгнэлтийг тайлбарлахын хэрэггүй даанч тодорхой байсан тул би мистер Мэртвэтийн үгийг зөвшөөрсөн юм. Мэртвэийн сануулан буй тэр үед Сара нчулуу Люкерийн гарт байсан гэхэд би урьд нь ч эргэлзээгүй билээ. Харин энэтхэгүүд түүний гямар аргаар олж мэдсэнийг л ойлгохгүй байсан юм. Миний бодлоор бол хамгийн бэрх энэ асуудал бусдын нэгэн адил илэрхий болов.

Миний бие хуульч хэдий боловч би нүдээ боогоор явсан ч өдий хүртэл толгой эргэм хонгил дундуур намайг удирдан замчилсан мистер Мэртвэт одоо сүүлчийн нугачаанаас нь давгүй гаргачихна гэдэгт бүрэн найдаж болохоо ухаарч эхэлсэн юм. Миний энэ тааламжтай үгийг мистер Мэртвэт их л ялдамхан хүлээж авав.

-Цааш ярихын өмнө та нэг зүйлийг надад тодруулж өгөөч. Сара нчулууг нэг этгээд Йоркширээс Лондонд авчирсан. Нэг этгээд түүний гбарьцаанд өгчээ, эс тэгвэл мистер Люкерийн гарт орохгүйсэн. Тэр этгээд хэн болох тухай мэдэгдсэн зүйл байна уу?

-Мэдэгдсэн юм хараахан байхгүй.

-Годфри Эблвайтын талаар нэг явдал бий байх аа? Түүнийг цуутай ивээгч гэж би сонссон. Энэ чинь л хангалттай баримт шүү дээ.

Би ч энэ талаар мистер Мэртвэтэй үнэхээр санал нийлж байлаа. Тэгэхийн хамт, шударга голч зантайг нь би батлан дааж чадах нэг хүн (мисс Вериндерийн нэрийг дурдаагүй гэдгээ хэлэх юун) Годфри Эблвайтыг өмгөөлж, аливаа хардлага сөрдлэгээс нэрийг нь цэвэрлэсэн тухай хэлбэл зохино гэж бодсон юм.

-Их сайн байна хэмээн мистер Мэртвэт тайван өгүүлдээд, -Энэ хэргийн учир яваандаа олдох биз гээд орхиё. Харин одоогоор нөгөө энэтхэгүүд рүүгээ эргэж орох хэрэгтэй, мистер Брафф. Тэд Лондонд очоод дахиад л бүтэлгүйтжээ. Мөнгө хүүлэгчийн ашиг орлоготой, эртний түүхтэй ажлыг дэмий эрхлээгүй мистер Люкерин ов заль, хашир зангийн гайгаар тэд очир алмаз хулгайлах хоёр дахь боломжоо алдсан гэжби бодож байна! Нөгөө ажилтнаа яаран халснаар, энэтхэгчүүд тэр хуйвалдагч этгээдийн тусламжинд түшиглэн байшинд нэвтрэн орох замыг тасалжээ. Хуйвалдагчдыг шинэ төлөвлөгөө боловсруулж амжихаас өмнө Люкеер Саран чулууг банкиндаа нэн даруй хадгалуулж, тэднийг бүр балмагдуулсан байна. Тэр арга хэмжээг нь энэтхэгчүүд хаанаас олж мэдсэн, мөн банкны баримтыг хэрхэн олзлон авсан тухай дэлгэрэнгүй ярих шаардлагагүй, шинэхэн хэрэг билээ. Харин тэд гараас нь Саран чулуу дахин мултарч, банкны шатдаггүй шүүгээнд зүгээр л “үнэт эрдэнэ” гэдэг нэрээр хадгалагдсаныг нь олж мэдэцгээснийг хэлэхэд хангалтгүй юм. Одоо тэд алмазыг хулгайлж авах гэж гурав дахь удаа хэзээ, хэрхэн оролдох вэ, мистер Брафф?

Эл асуултыг сонсмогц нөгөө энэтхэг хүн ямар зорилгоор миний ажил дээр очсоныг гадарласан юм!

-Ойлголоо! Хэмээн би дуу алдаад, -Очир алмазыг барьцаанд өгсөн гэдэгт энэтхэгүүд бидний нэгэн адил итгэж байсан учраас өр төлж эхлэх наад захын хугацааг яг таг мэдэх хэрэгтэй байж. Яагад гэвэл, чухам тэр үед л алмаз банкны хадгаламжнаас гарна шүү дээ! Гэлээ.

-Танд сэжүүрий нь цухуйлгаад орхиход л та бүх учрыг ойлгоно гэж би эс хэлэл үү. Саран чулууг барьцаанд өгснөөс яг нэг жилийн дараа энэтхэгүүд түүнийг хулгайлах гурав дахь боломжийг хайна. Люкер тэдэнд хэдий хэр хугацаатай хүлээхийг хэлсэн бөгөө дмаргашгүй нэр хүнд бүхий тан бие Люкерийн үнэн гэдгийг нотолсон байжээ. Очир алмаз мөнгө хүүлэгчийн гарт хэдийд орсон гэж та бодож байна?

-Зургадугаар сарын сүүл хавиар шиг санагдаж байна.

-Одоо дөчин найман он. Их сайн. Саран чулууг барьцаанд өгсөн үл мэдэгдэх этгээд түүний үнийг төлөөд жилийн дараа авч болох тул дөчин есөн оны зургадугаар сарын сүүлчээр алмаз тэр этгээдийн гарт орох юм. Тэр үеэр би Англиас хэдэн мянган бээрийн алсад явж байна. Гэвч та энэ хугацааг тэмдэглэж аваад, тэр үеэр Лондонд байхыг хичээвэл зүгээр байж магадгүй шүү.

-Ноцтой хэрэг гарна гэж та бодож байна уу?

-Саран чулууг өвөртлөөд банкны босго алхснаас төв Азийн улайрсан догшин сүжигтнүүдийн дунд байсан нь хавьгүй өлзийтэй гэж бодож байна. Энэтхэгүүд хоёр удаа араараа тавиулсан. Харин гурав дахь удаагаа бүтэлгүйтнэ гэж хол хэвтэнэ. Мистер Брафф би үүнд хату итгэж байгаа юм шүү.

Энэ бол уг хэргийн талаар мистер Мэртвэгийн хэлсэн төгсгөлийн үг байлаа. Кофе авчргов. Гийчид суудлаасаа босож, өрөөгөөр тарцгаан, бид хатагтай нар руу очихоор дээд давхар өөд өгслөө.

Би он, сар, өдрийг тэмдэглэж авсан бөгөөд “Мянга найман зуун дөчин есөн оны зургадугаар сар. Энэ сарын сүүлчээр, энэтхэгүүдийн талаар сураг чимээ хүлээх” гэж бичсэнээ давтан сийрүүлж, хүүрнэлээ дуусгавал давгүй болов уу.

Ингээд надад цаашдаа хэрэггүй болсон үзгээ дараачийн хүнд шилжүүлсүгэй.

## I бүлэг

Хэдэн сарын өмнө боловсруулж, банкны эзэн, хуульч хоёртоо танилцуулсан жуулчлалын төлөвлөгөөгөө миний бие мянга найман зуун дөчин найман оны хавар өөрчилсөн юм.

Ийнхүү өөрчилсний улмаас надад ирсэн захидал, гуйвуулсан мөнгийг шинэ төлөвлөгөө ёсоор айлчилна гэж бодож байсан нэг хотод суугаа Английн консулаас авахуулахаар зарцыгаа илгээх шаардлага гарав. Тэр зарц болзсон цагт товлосон газар надтай уулзах ёстой байлаа. Гэтэл түүний буруугаас биш, санамсаргүй явдлаас болж саатаж орхисон юм. Би түүний гцөлийн босгон дээр хүмүүсийнхээ хамт бүтэн долоо хоног хүлээлээ. Тэгсээр эцсийн эцэст нөгөө сураггүй болсон элч маань майхны үүдээр орж ирсэн бөгөөд мангө захиа авчирчээ.

-Яана даа, би танд муу мэдээ авчрав бололтой гээд гашуудлын хүрээ татаж, мистер Браффын хаягласан захидлыг заан өгүүлэв.

Иймэрхүү үед учрыг мэдэхгүй байхаас бэрх зүйл үгүй билээ. Тийм ч учрас гашуудлын хүрээтэй захидлыг юуны түрүүнд задлав. Тэнд эцэг маань нас барж, миний бие дээр асар их өмч

хөрөнгийг өвлөн авах болсныг мэдэгджээ. Тэр их баялаг миний мэдэлд шилжсэнээр надад их хариуцлага тохоосон юм. Мистер Брафф намайг цаг алдалгүй Англидаа нэн даруй эргэж ирэхийг гуйжээ.

Маргааш нь үүр хаяармагц би эх нутгийн зүг хөлгийн жолоо заллаа.

Намайг Англиас явах үед миний эртни анд Бэттереж гуай мини зан авирыг дүрслэн бичихдээ арай л хэтрүүлсэн мэт санагдана. Миний гадаад боловсролыг элдвээр дооглодог залуу эзэгтэйнхээ үгийг өвгөдийн зангаар үнэмшиж, шооч үеэлийн маань зүгээр л наадам тохуу хийж байсан, зөвхөн манай цайлган Бэттереж гуайн санаанд л биеллээ олсон франц, герман, итали, зан миний ааш авирт үнэхээр илэрдэг хэмээн итгэсэн байна. Гэвч үүнийг эс тооцвол чин үнэнийг бичсэн гэдгийг хэлэх хэрэгтэй. Юү гэвэл, миний бие Рэчелийн харьцаанд үнэхээр эмзэглэн шаналж, цаглашгүй гашуудан зовсон сэтгэлээ эс дийлж Англи орныг орхин одсон билээ.

Энд тэндхийн газар орноор хэрэн тэнэж, алс хол явбал түүнийг мартагнах болов уу гэж горьдсон юм. Иймэрхүү тохиолдолд, өөр газар очих, хагацан холдох нь ачтай нөлөө үзүүлдгийг үгүйсгэвэл том эндүүрэл болно гэдэгт би эргэлзэхгүй байна. Нутаг сэлгэн, холдон салж явахад бодол санаа, сэтгэлийг нөмрөн эзэмдсэн уй гунигаас сатааруулан хөндийрүүлдэг юм. Би Рэчелийг ер мартаагүй хэдий боловч газрын хол, замын уртад гуниг дүүрэн гашуун дурсамж балран бүдгэрсээр, Рэчел бид хоёр үнэндээ улам улам холдон хөндийрсөөр байлаа.

Харин нөгөө талаас гэвэл, надад тийм сүрхий сайн тус болсон эмний хүч харих заэмд зугуухан суларч ирэв. Рэчелийн сууж буй нутагт дзөхөх тусам, түүнтэй уулзах боломж ойртох тусам миний сэтгэлийг эзэмдэн захирсан түүний урьдын хүч давшгүй их болж байлаа. Англиас гарч явах үедээ би нэрийг нь ч дурсаж зүрхлэхгүй байсан бол Англид ирээд мистер Браффтай уулзмагцаа хамгийн түрүүнд Рэчелийг сураглав.

Миний эзгүйд болсон бүх явдлыг надад танилцуулсан нь мэдээжийн хэрэг билээ. Өөрөөр хэлбэл, Бэттереж гуайн хүүрнэлийн үргэлжлэлд дүрсэлсэн бүхнийг, ганц зүйлээс бусдыг нь надад ярьсан юм. Рэчел Годфри Эблвайт нар гэрлэхээ больсон шалтгааныг мистер Брафф тэр үед надад хэлэх эрхгүй гэж үзжээ. Тэрхүү эмзэг сэдвийн талаар би түүнээс элдвийг хоргоож завдсаныг нь сонсоод хардаж, урам хугарчихаад байсан миний бие, түүнийг эргэцүүлж тунгаасны эцэст хөнгөн хуумгай хөдөлснөө ухаарч, хэлсэн амнаасаа буцсаныг нь мэдэнгүүтээ л сэтгэл уужирч, тайвширсан юм.

Өнгөрсөн хэрэг явдлын тухай ханатал сонсоод одоогийн байдлын талаар (гэхдээ дандаа Рэчелийн тухай шүү!) асууж лавлалаа. Мистер Браффыхаас яваад хэний асрамжинд очсон бэ? Одоо хаана сууж байна? Одоо талийгаач Жон Вериндерийн бэлбэсэн дүү авгай Мэрридьюгийн сууж байгаа гэнэ. Талийгаач Вериндер нагацын гэрээслэл гүйцэтгэгч нар Рэчелийг асрамжиндаа авахыг тэр авгайгаас гуйсанд зөвшөөрсөн ажээ. Тэр хоёр Портланд дахь Мэрридью хатагтайн байранд маш эвсэг хаваржиж байгаа ажээ.

Үүнийг тодруулж аваад, хагас цагийн дараа миний бие Портландыг зорьсон бөгөөд мистер Брафф үнэнээ хэлж зүрхлээгүй юм!

Үүд тайлж өгсөн зарц, мисс Вериндер гэртээ бий эсэхийг сайн мэдэхгүй байв. Эл асуудлыг шалавхан нэг тийш болгохын тулд би нэрийн хуудсаа өгөөд явуулав. Зарц буцаж ирээд, мисс Вериндер гадагшаа гарчээ хэмээн хэнэггүй гөлийсөн царайгаар мэдэгдэв.

Өөр хүнийг бол надтай уулзахаас зориуд зайлсхийж байна гэж сэрдэхсэн. Гэтэл Рэчелийг тийнхүү сөрдөх аргагүй билээ. Тэгээд оройн зургаан цагт дахиад ирнэ гээд дамжуулчихаарай гэж захиад явлаа.

Зургаан цагт мисс Вериндерийг эзгүй байна гэж дахиад хэлэв. Надад юм хэл гэв үү? Юу ч хэлээгүй. Мисс Вериндер миний нэрийн хуудсыг авсан уу? Зарц надаас уучлал эрээд, мисс Вериндер нэрийн хуудас авсан гэлээ.

Учир даанч тодорхой ажээ. Рэчел надтай уулзах дургүй байгаа ажээ.

Би бол, ийм хачин харьцааны ядаж шалтгааныг нь мэдэх гэж оролдолгүйгээр эвлэрчих хүн биш билээ. Мэрридью хатагтайгаас намайг хүлээж аавх бололцоотой цагийг товлохыг хүсэж, нэрийн хуудсаа өгч зарцыг явуулав. Мэрридью хатагтай цааргалалгүй намагй тэр даруй хүлээж авлаа. Намайг подхийсэн, тохилогхон зочнч өрөөнд оруулж, жижиг биетэй, хижээл насны, нүдэнд дулаахан хатагтайтай уулзуулав. Их сайхан зантай хүн байлаа. Намайг машинд өрөвдөж бас нэлээд гайхаж байлаа. Чингэвч Рэчелийн зан аашийг тайлбарлан тус болж ч чадахгүй бөгөөд хүний сэтгэлийн нууцад хамаарах асуудал учраас Рэчелийг шахаж шаардаж ч чадахгүй гэлээ. Үүнийгээ гуйвшгүй, тэвчээртэйгээр хэд хэдэн удаа ялдамхан давтлаа. Мэрридью хатагтайтай уулзаад ийм л олзтой буцсан юм даа.

Одоо Рэчелд захиа бичхээс өөр азм үлдсэнгүй. Маргааш нь захиагаа өгч явуулахдаа хариуг заавал авчир гэж зарцдаа хатуу сануулав.

Хариу ирсэн ба үнэндээ ганцхан өгүүлбэр байлаа. Үүнд “Мистер Фрэнклин Блэйктай захидлаар харилцахаас мисс Вериндер татгалзаж байна” гэжээ.

Рэчелд хэдий хайртай боловч ингэж доромжлуулаад зэвүү хүрчихэв. Намайг сэтгэлээ барьж, сэхээ авч амжаагүй байтал мистер Брафф ажил төрөл ярилцахаар ирлээ. Би ч хамаг ажи лтөрлөө нэн даруй хойшлуулчихаад тохиолдсон явдлыг илэн далангүй ярьсан юм. Гэтэл Брафф, Мэрридио хатагтайн нэгэн адил олигтой тайлбар өгч бас чадсангүй. Ямар нэг этгээд намайг Рэчелд гүтгэн муучилсан юм болов уу гэж асуув. Тэгж гүтгэж муучилсан үг дууддаагүй гэж мистер Брафф хариулав. Брафф гуайнд сууж байх үедээ намайг дурсан ярьсан удаа бий юу? Нэг ч удаа яриагүй гэнэ. Намайг удтал эзгүй байхад амьд, үхсэн алин болохыг ер нь сонирхож байсан уу? Тиймэрхүү юм огт асуугаагүй гэнэ. Намайг урьд Иоркшир дахь эдлэнгээс мордох өдөр талийгаач Вериндер нагацын надад бичсэн захиаг дэвтрийнхээ завсраас гаргаж, “Алдагдсан алмазыг эрж хайх ажилд таны үзүүлсэн тусламж эдүгээ сэтгэлийн бэрх хямралд орсон Рэчелийн хувьд одоо хүртэл уучилшгүй доромжлол болж байх шиг санагдана. Үүнийг гадарлаагүйн улмаас та хичээл зүтгэлээрээ нууцыг нь гэнэгүй илчлэхэд хүрч, сэтгэлийн тавыг нь улам алдагдуулжээ” гэсэн хоёр өгүүлбэрийг мистер Браффын анхааралд толилуулав.

-Рэчел одоо ч гэсэн урьдын адил надад уурласан хэвээр байж болох уу? гэж би асуулаа.

Мистер Браффын царайд үнэн голоосоо харамссан шинж тодрон, -Та заавал хариу шаардаж байгаа бол үнэндээ, Рэчелийн авирыг өөрөөр тайлбарлах аргагүй гэв.

Би хонх цохиж, зарцыгаа дуудаад аян замын юм бэлтгэж, галт тэрэгний хуваарь авчир гэж тушаав. Мистер Брафф намайг яах гээ вэ хэмээн гайхан асуухад нь,

-Дараагийн галт тэргээр Иоркшир явъя гэлээ.

-Ямар учиртайг асууж болох уу?

-Алмазыг нь эрж олох ажилд ёстой л бодож санасан юмгүй зүтгэсэн маань жил орчмын өмнө Рэчелийн хувьд уучилшгүй доромжлол болж, одоо ч хэвээр байгаа ажээ. Би ийм байдалтай эвлэрч чадахгүй! Яагаад эхдээ юу ч хэлэлгүй нуусан, яагаад надад дайсагнаад байгаагийн учир шалтгааныг тайлж мэдье. Цаг хугацаа, хөдөлмөр зүтгэл, хөрөнгө мөнгө тус болдог л юм бол би Саран чулууг авсан хулгайчийг олохдоо л олно!

Эххэмсэг өвгөн намайг ухаалаг байж, ултай хөдөл хэмээн ятгаж, товчоор хэлбэл, миний өмнө хүлэсэн үүргийнхээ дагуу хориглох гэж оролдлоо. Гэвч тэр үед юу ч гээд тусгүй, би гуйвалтгүйгээр санаа шулуудсан байлаа.

-Би мөрдлөгийг орхисон газраасаа үргэлжлүүлнэ. Алхам, алхмаар судалж, эцсийг нь үзнэ. Мөрдлөгийг орхисноос хойших үед холбогдох мэдээ бармитын хэлхээсэнд дутах юм бий л байх. Тэр дутууг Габриэл Бэттереж нөхөж өгнө. Би одоо Габриэл Бэттереж рүү явлаа!

Тэр оройдоо, нар шингэхийн алдад миний бие танил дотно дэвсэг дээр дахин хөл тавьж, хөдөөгийн намуун тайван эртний байшингийн барааг дахин нэг харж билээ. Хүнгүй цэцэрлэгт хамгийн түрүүнд цэцэрлэгчтэй уулзав. Дөнгөж цагийн өмнө Бэттереж гуай арын хашаанд нөгөө л буландаа нарлан сууж байсан гэнэ. Би тэр газрыг андахгүй тул өөрөө олж уулзъя гэлээ.

Миний бие танил зам, харгуйгаар явсаар нээлттэй явган хаалгаар шагайлаа.

Өмнө минь үүрд өнгөрөн одсон жаргалант цагийн хонгор өвгөн анд минь, нөгөө л буландаа, хуучин сүрэл сандал дээрээ мөн л гаансаа зууж, “Робинзон Крузогоо” өвөр дээрээ тавиад налайн суух агаад хөлд нь хоёр нөхөр нь буюу ноход үүрэглэн хэвтэнэ! Шингэн нарны сүүлчийн туяа араас тусаж байв. Ноход миний сүүдрийг харав уу, эсвэл сүрхий үнэрч чанараараа ойртсоныг мэдэв үү, ямар боловч архирсаар босон харайлаа. Манай өвгөн давхийснээ ганц хашгиргч тэднийг хориод, явган хаалган дээр зогсож буй хүнийг таньж ядан муудсан нүдээ хүчлэн гараараа саравчлан байж харав.

Миний нүдийг нулимс бүрхээд авсан учир үг дуугарахын тулд нэг хоёр минут азнахаас өөр аргагүй болж билээ.

## II бүлэг

Эцэст нь би,

-Бэттереж гуай! Гэж дуудаад –“Робинзон Крузо” чинь өнөө орой таныг Фрэнклин Блэйктай уулзана гэж хэлсэн юм биш биз? Хэмээн өвөр дээр нь байсан хэзээний танил номыг заан асуулаа.

-Бурхан өршөө! Мистер Фрэнклин минь! “Робинзон Крузо” яг л тэгж хэлсэн шүү! гэж өвгөн дуу алдав.

Би өвгөнийг босоход нь дэмнэн тусалаа. Босож зогсчихоод ном бид хоёрын аль нь илүү ихээр гайхшийг нь төрүүлснийг шийдэж ядах мэт ээлжлэн харж хэсэг зогсов. Эцсийн эцэст ном дийлжээ.

Тэрхүү гайхамшигт номоо хоёр гардан бариад дүрслэхийн аргагүй янзаар ширтэх нь тэндээс “Робинзон Крузо” биеэрээ гарч ирээд бидэнтэй уулзана хэмээн горьдох мэт ажээ.

Тэгээд үг дуугарах сөхөөтэй болмогцоо,

-Мистер Фрэнклин ээ! Нөгөө мөр энэ байна! Таныг ирэхээс өмнө би энэ мөрийг уншиж байсан маань, одоо таныг харж байгаа шиг үнэн юм шүү, эрхэм ээ! Зуун тавин зургадугаар хуудсан дээр “Би аянганд ниргүүлсэн мэт, эсвэл хий үзэгдэл харсан мэт алмайран зогсов” гэжээ. Энэ бол Фрэнклин Блэйк санаандгүй байтал чинь ирэх вий” гэсэнтэй утга нь нэг биш байдаг юм бол, англи хэл ямар ч утга алга гээд Бэттереж гуай номоо тасхийтэл хааж, сая нэг гараа чөлөөлөн, сунгасаар байсан гарыг минь атгах боломжтой болов.

Намайг одоо л асуултаар булна (тэгэх ч үндэстэй билээ) байхдаа гэж санатал тэгсэнгүй. Гэрийн нэг хүн ямар боловч айлчлан ирсэнд (ямар байдлаар гэдэг нь хамаагүй!) зарц өвгөний сэтгэлийг гагцхүү зочлон хүндлэх хүсэл л эзэмджээ.

-Мистер Фрэнклин морилогтун! Хэмээн хаалга нээн хуучны ёсоор мэхийн хэлээд –Таны ямар хэргээр ирснийг хожим асуумз юуны өмнө эхлээд танд тавтай байр бэлтгэе. Таныг явснаас хойш олон юм харамсаар өөрчлөгдсөн дөө. Байшинг хаасан, зарц, шивэгчингүүд ч явцгаасан. Гэхдээ дажгүй ээ! Би танд хоол хийж өгнө, цэцэрлэгчийн эхнэр ор дэрийг тань засаж өгнө. Манай алдарт Латурын сархадаас зооринд ганц нэг лонх үлдсэн бол та ууж л таарна даа эрхэм ээ, морилон орно уу, орж хайрлагтун! Гэж хөөрхий өвгөн эзгүйрсэн байшингийн дүнсгэр байдлыг эрэлхэгээр сөрж, өнгөрөн одсо нцагийн элэгсэг, зочломтгой ёсоор өгүүллээ.

Түүний урмыг хугалах даанч өрөвдмөөр байв. Гэвч энэ байшин бол одоо Рэчелийн байшин билээ. Лондонд бидний хооронд болсон явдлын дараа би энэ байшинд хооллож, унтаж чадах уу даа? Биеэ хүндэтгэх хамгийн энгийн бошдол тэдний босгыг алхахыг хориглож байсан юм. Тэр ч үнэхээр зөв байлаа.

Би Бэттереж гуайг сугадан цэцэрлэгт дагуулан оров. Би түүнд бүгдийн ний нуугүй ярихаас өөр зам байсангүй. Рэчел, бид хоёрыг адилхан хайрладаг өвгөн, байдал тийнхүү хувирсныг сонсоод хачин их гонсойж, гайхшаа барав. Тэгээд ил шулуун зангаараа, миний мэдэхээс хорвоо дээрх хамгийн сайн гүн ухааныхаа буюу Бэттережийн сургуулийн гүн ухааны үүднээс бодол саналаа илтгэсэн юм.

-Мисс Рэчелд дутагдал бий. Би түүнийг нь үгүйсгэхгүй. Заримдаа өөрийнхөө санаснаар болгох дуртай байдаг. Одоо таныг давах гэсэн юм байж. Тэнгэр минь, Фрэнклин та өдий хүртэл бүсгүй хүнийг мэддэггүй юмуу? Талийгаач Бэттереж авгайн тухай ярихыг минь та сонссон биз дэ?

Талийгаач Бэттереж авгайг эмэгтэй хүний сул дорой тал, дур зоргоороо зан авирын хөдөлшгүй жишээ болгон ярихыг нь би олонтаа сонссон бөгөө додоо ч бас талийгаачийг тийм утгаар дурслаа.

-Их сайн мистер Фрэнклин. Одоо миний үгийг сонсож бай. Эмэгтэй хүн болгон санаснаараа зүтгэн давж буух өөрийн гэсэн арга барилтай байдаг. Талийгаач Бэттереж авгай хүссэн зүйлийг нь биелүлэхгүй л бол ёстой бууж гардагсан. Тийм явдлын дараа намайг ажлаа тараад харихад бүдүүлэг харьцсан учраас миний хроол ундыг бэлтгэх чадал даанч хүрсэнгүй гэж гал тогооны өрөөнөөс хаширдагсан. Нэг хэсэгтээ би, та мисс Рэчелийн аашийг тэсэн өнгөрөөж байсан шиг л тэсээд байлаа. Гэвч эцэстээ миний тэсвэр барагддаг юм байна. Би гал тогоо руу очиж, Бэттереж авгайг тэвэрч аваад, гэхдээ ялдамхнаар шүү дээ, зочид хүлээн авдаг хамгийн гоё өрөөндөө оруулаад “Хонгор минь, энэ л чамд яг тохирох газар шү” гэхихээд гал тогоо руу буцсан юм. Хаалгыг нь түгжчихээд, сюртукээ тайлж, ханцуйгаа шамлан хоолоо бэлтгэх ажилд орлоо. Хоол болохоор нь өөрөө аягалж, тухтайхан идсэн дээ. Дараа нь гансаа нэрж, грог найруулан амтархан тамшаалж уусан биэлэ. Тэгээд ширээгээ цэвэрлэж, хувин сав, халбага, хутга, сэрээ бүгдийг угааж, шал шүүрдэв. Хамаг юм гял цал, цэвэр цэмцгэр болсны дараа үүд онгойлгож, Бэттереж авгайг оруулаад, “Хонгор минь, би хоолоо идчихлээ. Тогооны өрөөгөө үүнээс илүү сайхан байлгая гэж чи минь лав бодохгүй биз ээ” гэв. Түүнээс хойш, тэр бүсгүй амьд сэрүүн цагтаа надаар нэг ч удаа хоол хийлгээгүй юм даа! Эндээс ямар сургамж авах вэ гэвэл, та мисс Рэчелийн муухай аашлахад нь Лондонд эвлэрсэн, харин Иоркширт бүү эвлэр! Байшинд буцаж орогтун.

Юу ч гэх вэ дээ! Энэ удаад, нотлох үнэмшүүлэх чадвар нь ч талаар өнгөрнө гэдгийг сайн санаат өвгөн анддаа хэлэхээс өөр арга байсангүй.

-Сайхан орой байна шүү. Би Фризинхолл руу алхъя. Тэнд зочи дбуудалд байр авна, та маргааш өглөө очиж надтай хамт цай уухыг гуйя. Ярих юм байна гэж би хэллээ.

Бэттереж гуай сүрхий буурьтайгаар толгой сэгсрээд,

-Надад үнэхээр харамсалтай байна. Мисс Рэчел та хоёрыг учраа ололцож, дахиад эвлэрсэн тухай сонсодно гэж горьдож байсан юмсан гээд түр бодлогоширсноо, -Та санаснаараа зүтгээд байгаа

бол заавал өнөө орой Фризинхолл руу явах шаардлагагүй, арав ойрхон газар байр олдоно. Хотерстоны эдлэн эндээс хоёрхон бээрийн газар байдаг юм. Та ч үүнээс татгалзахгүй биз дээ хэмээн өвгөн жоготой инээмсэглээд, -Хотертстонд мисс Рэчелийн эзэмшил дээр биш, өөрийнхөө газар дээр суудаг юм шүү гэж нэмж хэллээ.

Бэттереж гуайг дурсахад л би тэр газрыг санасан юм. Тэр эдлэнгийн байшин Иоркширийн тэр хавийн хамгийн үзэсгэлэнт горхины нөмөр бүхий хөвөөнд байдаг агаад эдлэнгийн эзэн, ерөнхийдөө зураач, загасчин, жуулчдыг хөлслөн суулгадаг унтлагын ба зочны өрөөтэй билээ. Энд байх үед түүнээс аятайхан байр үзээд ч олж чадсангүй.

-Өрөө нь сул юм болов уу? гэж би асуухад,

-Эрхэм ээ, Хотернстоун авгай өрөө хөлслөх хүн мэдэж яваарай гэж өчигдөрхөн надад захисан юм гэлээ.

-Бэттереж гуай, би дуртайяа явъя.

Бид хоёр хашаа руу гарав. Би тэнд аяны цүнхээ орхисон байсан юм. Бэттереж гуай тулууур модоо чемоданы бариулд хийж, дамнан мөрлөөд, сүрлэн сандал дээрээ зүүрмэглэн байснаа гэнэт ирснийг минь харж мэл гайхаж цл хөхөрсөн шигээ дахиад л учиргүй гайхсан байдал царайд нь тодорлоо. Байшингийн зүг учраа олохгүй янзтай харснаа, эргэж намайг бүр ч алмайран ширтэв.

-Би хорвоогийн тоосыг бишгүй л олон жил хөдөлгөлөө. Гэвч ийм юм үзнэ гэж даанч бодсонгүй явжээ. Энэ байшин байна. Фрэнклин Блэйк энд зогсож байгаа атлаа нүүр буруулан явж, хөлсний байранд буух гэж байдаг! Хэмээн хөгшин зарц нарын хамгийн дотно эрхэм сайн энэ хүн өгүүллээ.

Толгойгоо сэжин, амандаа бувтнасаар түрүүлж алхав. Тэгснээ хойшоо харж,

-Фрэнклин та жаал хөвгүүн байхдаа надаас зээлж авсан зургаа, долоон пенсээ төлнө гэж шидийг үзүүлэх л дутаа шив дээ гэв.

Түүний энэ хошигнол бид хоёрын сэтгэлийг зассан юм. Бид байшингаас холдож, манаачийн швгорын хажуугаар гарлаа. Чөлөөтэй газар дээр хөл тавимагц зочлон хүндэтгэх үүрэг (Бэттереж гуайн ёс суртахууны зарчим ёсоор) арилж, сониуч зан нь дийлж эхэлжээ. Бэттереж гуай намайг хойноосоо ирэхийг хүлээзнэн зогсож надтай зэрэгцээд,

-Мистер Фрэнклин, зугаалж баймаар сайхан орой байна шүү хэмээн дөнгөж уулзсан мэт хэлээд, -Таныг Фризинхоллын зочид буудал руу явлаа гэж бодъё л доо эрхэм ээ гэв.

-За тэгээд?

-Тэгвэл би маргааш өглөө тантай цуг цай уух байсан.

-Фризинхоллын зочид буудлын оронд Хорнстоуны эдлэнд очиж, надтай хамт цай уугаарай.

-Фрэнклин танд их гялайлаа. Гэхдээ би цай уух тухай яриагүй юм. Надад хэлэх юм бий гэсэн байх аа? Хэрэв нууц биш юм бол та яагаад ийнхүү гэнэт ирэх болсныг мэдэхсэн гэхээс би бүр тэсэж ядаж байна хэмээн Бэттереж гуай тойруу замаар явснаа орхиж, шулуухан хэлж орхив.

-Би урьд юунаас болж ирлээ?

-Саран чулуунаас. Гэвч одоо яагаад ирэв, эрхэм ээ?

-Бас л Саран чулуунаас болж ирлээ, Бэттереж гуай минь.

Өвгөн зогтусан чихэндээ үл итгэх мэт үдшийн бор гэгээнд намайг гайхан ширтлээ.

-Эрхэм ээ, та тоглож байгаа бол би хөгшрөөд жаахан мангар болжээ. Таныг ойлгосонгүй гэхэд нь,

-Би тоглоогүй. Би Англиас явахдаа орхисон мөрдлөгөө үргэлжлүүлэхээр ирсэн юм. Хэний ч хийж чадаагүй зүйлийг гүйцээх, өөрөөр хэлбэл алмаз хулгайлсан этгээдийг олох зорилготой ирсэн юм гэж би хариу өчив.

-Фрэнклин, та тэр алмазыг орхи, мартаж үз! Энэтхэгийн тэр гайтай чулуу хавьтсан хүн бүхнийг баллаж байсан юм. Цэцэглэж яваа ид залуу насандаа Саран чулуугаар оролдож хайран хүч, мөнгө хөрөнгөө үрэх хэрэггүй, эрхэм ээ. Түрүүч Кафф хүртэл будилж орхисон хэргийг та гүйцээж дөнгөнө гэж (уучлаарай) яаж санаа вэ? Гээд хуруугаа гозгонуулан их л ширүүн дүртэйгээр зангаад, -Түрүүч Кафф, Английн хамгийн алдартай эрүүлч шүү! гэж давтан хэлэв.

-Өвгөн найз минь, би нэгэнт шийдсэн. Түрүүч Кафф ч намайг ятгэж дийлэхгүй. Дашрамд хэлэхэд, эрт орой хэзээ боловч би түүнтэй зөвлөж ярих л болно. Сүүлийн үед та түүнээс сураг сонссон уу?

-Түрүүч Кафф танд туслахгүй дээ.

-Яагаад?

-Таныг явсны дараа цагдаагийн байгууллагад өөрчлөлт гарсан шүү дээ. Алдарт Кафф халагдаж, Доркинд багавтар байртай болсон. Одоо сарнай тарих ажил хоолойгоор нь татаад байгаа. Өөрөө надад тэгж бичсэн юм л даа. Эхлээд нохойн хошуу суулгалгүй, цагаан сарнай дангаар нь тарьсан гэнэ. Тэгээд Бэгби цэцэрлэгч Доркинд очиж ялагдлаа хүлээсэн шүү.

-За тэр ч нэг их сүйдтэй юм биш ээ. Би түүрүүч Каффын тусламжгүйгээр гүйцэтгэх ёстой болж дээ. Харин ажилаа эхлэхийн тулд танд бүгдийг итгэмжлэн ярих хэрэгтэй юм гэж би хэллээ.

Би баахан тоомжиргүй ярьчихав бололтой. Ямар боловч миний энэ хариу Бэттереж гуайг гомдоочих шиг болов.

Та надаас өөр арай дор хүнд ч итгэж болно шүү дээ, Фрэнклин хэмээн ууртайгаар бувтналаа.

Дууны өнгө, нэлээд уймарсан байдлаас нь нэг зүйл сонсож мэдсэн түүнийгээ хэлж зүрхлэхгүй байгааг би гадарласан юм. Тэгээд,

-Түүрүүч Каффын анхаарлаас мултарсан баримт сэлт олж цуглуулахад минь таныг тусална гэж бодож байна. Та үүнийг дөнгөнө л дөө. Харин та өөр тус үзүүлж чадахгүй гэж үү? Хэмээн лавласанд,

-Та надаас өөр юу хүсээ вэ? Гэж Бэттереж гуай туйлын хүлцэнгүй номхон царайгаар асуув.

-Таны түүрүүнд хэлснээс үзвэл арай ихийг сонсоно гэж бодлоо.

-Хоосон сайрхал, мистер Фрэнклин минь. Зарим хүн ойворгон төрчихөөд нүд анитлаа л хэвээр байдаг шүү дээ. Би чинь тийм хүний нэг дээ гэж өвгөн зөрүүдлэн хариулав.

Түүнийг ятгаж, үгэндээ оруулах ганцхан арга байсан нь юу гэвэл, Рэчел бид хоёрыг хайрладаг сэтгэлийг нь ашиглахаар шийдсэн юм.

-Бэттереж гуай, та Рэчел бид хоёрыг хайрладаг сэтгэлийг нь ашиглахаар шийдсэн юм.

-Та үүнд эргэлзэж байгаа бол би энэ насандаа танай гэр бүлд муу үйлчилж байж дээ, эрхэм ээ.

-Намайг Англиас явахын өмнө Рэчел надтай ямаршуу харьцаж байсныг та санаж байна уу?

-Өчигдрийн юм шиг л тодхон байна! Талийгаач ахайтан маань танд өөрөө тэр тухай бичээ биз дээ. Та тэр захиаг нь надад үзүүлж соёрхсон шүү дээ. Эрдэнийн чулууг нь эрж олох ажилд таныг оролцлоо гэж мисс Рэчел жигтэйхэн зэвүүцэж байна гэсэн. Түүний учрыг ахайтан маань ч, би ч ер хэн нь ч тааварлаж чадаагүй.

-Яг үнэн, Бэттереж гуай. Би өчнөөн удаан жуулчилж яваад ирлээ. Гэтэл Рэчел намайг одоо хүртэл жигшсэн хэвээр юм байна. Ноднин бол нөгөө очир алмазаас л болж надад зэвүүцэж байсныг нь би мэдсэн, энэ жил ч бас л очир алмазаас болсныг нь би мэдэж байна. Би Рэчелтай ярилцах санаатай оролдсон боловч надтай уулзсангүй. Захиа бичиж үзлээ, хариу өгсөнгүй. Түүнийг юү гэж ойлгох вэ? Бурхан тэнгэрийг бодож хэлээд өгөөч. Саран чулуу алдагдсан нууцыг илчлэх нь Рэчелийн надад үлдээсэн учрыг олох цорын ганц боломж юм!

Миний үг байдлыг огт өөрөөр үзэхэд хүргэжээ. Би түүнд нэгийг бодогдуулж дөнгөснийг асуусан зүйл нь илтгэсэн юм.

-Та Рэчелд дургүйлхээгүй биз дээ, Фрэнклин?

-Лондонгоос гарахдаа жаахан уурласан л даа, харин одоо уур арилсан. Би Рэчелтэй учраа ололцох гэснээс өөр юмгүй.

-Та нэг юм илчиллээ гэж бодъё. Тэгвэл мисс Рэчелийн ааш авирын талаар ямар нэг зүйл мэдэгдэнэ гэж та айхгүй байна уу?

Энэ үгнийх нь цаана залуу эзэгтэйдээ хязгааргүй ихээр итгэдэг итгэл агуулагдаж байгааг би ойлгосон юм.

-Би түүнд танаас өөрцгүй итгэдэг. Уг хэргийг бүрэн гүйцэд илчиллээ ч гэсэн Рэчелийн нэр хүндэд хал ба болох юм өчүүхэн ч гарахгүй гэж би хариуллаа.

Үүнийг сонсоод Бэттереж гуайн эргэлзээ ор мөргүй замхарсан билээ.

-Фрэнклин танд тусалж байна гэж зэмлэвэл би харин огт гэмгүй гэж бодож байна л гэнэ дээ хэмээн өвгөн дуу алдсанаа, -Та толгой даагаад явж чадах л юм бол би таныг нээлт хийх замд хөтөлж оруулъя. Та манай хөөрхий шивэгчин Розанна Спирманыг санаж байна уу? гэв.

-Саналгүй яах вэ!

-Саран чулууны хэрэгтэй холбогдсон нэг юм хэлэх нь гээд та сэжиглээд байсан байх аа?

-Хачин авирыг нь өөрөөр тайлбарлах аргагүй байсан шүү дээ.

-Та энэ талаар аливаа эргэлзээгээ орхиж болно шүү, Фрэнклин.

Одоо миний мэл гайхаж, цэл хөхрөх ээлж иржээ. Харанхуйд Бэттереж гуайн нүүрий нь ажиглах санаатай дэмий л оролдов. Гайхаж алмайрсан миний бие баахан тэвчээр алдан учрыг шалгааж гарлаа.

-Эрхэм ээ, бүү яар! Би Розанна Спирман танд захиа үлдээсэн гэж л хэлэх гэсэн юм хэмээн Бэттереж гуай намайг зогсоов.

-Хаана байна?

-Коббс Холлд талийгаачийн найзад бий. Та энд байхдаа хазгар Люси гэдэг алмууртай бүсгүйг дуулсан биз дээ?

-Загасчны охин уу?

-Яг мөн эрхэм ээ.

-Захиаг яагаад надад явуулаагүй юм бэ?

-Эрхэм минь, хазгар Люси бол гэжүүн зантай хүн дээ. Танаас өөр хэний ч гарт өгөхгүй. Харин намайг захиа бичиж амжихаас өмнө та Англиас явчихсан байсан.

-Одоохон буцъя Бэттереж гуай. Тэр захиаг даруйхан олж авъя.

-Одоо оройтсон эрхэм ээ. Загасчид лаа, дэнлүүгээ их хэмнэдэг, тэгээд ч Коббс Холлынхон эрт унтдаг юм.

-Баларсан юм! Тэнд хагас цагийн дотор л оччихно шүү дээ.

-Та очиж болно, эрхэм ээ. Харин очсон хойноо түгжээтэй хаалга л мөргөх вий гээд доор анивалзах гэрлийн зүг заах үес горхины ус шоржигнон урсах чимээ чих дэлслээ.

-Тэр эдлэн харагдаж байна! Өнөө шөнө тухтай нойрсоод маргааш өглөө над дээр очиж соёрхоно уу?

-Надтай хамт загасчныд очих уу?

-Очно, эрхэм ээ.

-Өглөө эрт үү?

-Таны л тааллаар больё.

Бид хоёр эдлэн орох харгуйгаар уруудлаа.

### III бүлэг

Хотерстоуны эдлэнд өнгөрөөсөн шөнийг бүүр түүрхэн төсөөлнө.

Намайг элэгсэг хүлээн авсан, дорно зүгийн бүхэл бүтэн тосгоныг цатгачихаар элбэг дэлбэг хоол унд, өвөг дээдсээс уламжилж ирсэн ой гутам өдөн хөнжил гудсыг эс тооцвол хэлэх өөгүй, цэвэр цэмцгэр унтлагын өрөө, түүнчлэн шөнөжин нойр хулжиж зовсноос нэг бяцхан лаа өчнөөн төчнөөн лаа асааснаа эцсийн эцэст нар сая мандаж, босох цаг болсонд сэтгэл жигтэйхэн уужирсныг л санаж байна.

Миний бие нөгөө захиаг шалавхан олж авахын тулд Бэттереж гуайнхаар дайрч Коббс Холл руу эртхэн явъя гэж тохиролцсон маань захиаг олж авахаар тэсэж ядан байгаа миний хувьд аль болох эрт явна гэсэн үг байлаа. Цай өгөхийг ч хүлээхгүй, талхны булан шүүрч аваад, сайн санаат Бэттереж гуайг арай босоогүй болов уу гэж эмээсээр очсонд миний нэгэн адил хөөрч догдлоод, хэдийн хувцаслачихсан, тулуураа барин намайг хүлээж байхыг харж, сэтгэл амарч билээ.

-Сайн байна уу, Бэттереж гуай?

-Их л муу байна эрхэм ээ.

-Ямар харамсалтай юм бэ? Юу болоо вэ?

-Өөрийнхөө зохиосон шинэ өвчинд шаналаад байна, Фрэнклин минь. Би таныг айлгах гэсэн юм биш гэхэд өнөө өглөө танд ч тэр өвчин халдсан бололтой.

-Чөтгөр алгад!

-Ходоод чинь эвгүйрхэн халуу шатраж, зулайгаар чинь хачин муухай хатгуулаагүй байнаг уу, эрхэм ээ? Арай үгүй юү? Тэгвэл Коббс Холлд очоод л өвдөж эхэлнэ дээ. Энэ өвчнийг мөрдөх дон гэж би нэрлэсэн. Түүрүүч Каффтай хамт байхдаа л өвчилсөн юм даа.

-Өө, за за! Розанна Спирманы захидлыг задалмагц л эдгэрэх биз. Явъя, очиж явъя.

Хэдийгээр эрт байсан ч гэсэн загасчны эхнэр гал тогооныхоо өрөөнд байлаа. Бэттереж гуай намайг танилцуулсанд сайхан зант Ёолланд авгай тун ёс төртэй угтсан бөгөөд хожим сонсвол зөвхөн хүндтэй айлчинд тийнхүү ханддаг юмсанж. Ширээн дээрээ нэг лонх голландын хуурай дарс, хоёр цэвэр ганс тавиад, “Эрхэм ээ, Лондонгоор ямар сонинтой байна даа?” хэмээн яриа эхлэв.

Энэхүү ерөнхий асуултанд юу гэж хариулахаа бодожбайтал өрөөний харанхуй буланд нэгэн хий үзэгдэл шиг юм намайг чиглэн айсуу үзэгдэв. Гайхмаар сайхан үстэй, эцэнхий ядарч туйлдсан хүүхэн алмуур тулан хазганасаар ширээ рүү дөхөх агаад би л сонирхлыг нь учиргүй их татаж, жигшлийг нь төрүүлж, илбэдчихэв үү гэлтэй намайг цоо ширтэнэ.

-Бэттереж гуай, энэ хүний нэрийг дахиад хэлээд өгөөч гэж надаас нүд салгалгүй ширтсээр асуув.

-Энэ эрхмийн нэрийг Фрэнклин Блэйк гэдэг юм хэмээн Бэттереж гуай “эрхэм” гэдэг үгийг зориуд онцлон цохож хариуллаа.

Нөгөө хүүхэн цааш эргэж, өрөөнөөс гэнэт гараад явчихав. Зан сайт Ёолланд авгай охиныхоо хачин авирласны төлөө уучлал гуйж, түүнийг нь Бэттереж гуай надад ялдамхан англи үгээр дамжуулж байх шиг л ярьж байна. Яагаад гэвэл, би тэр үед холдон одох бүсгүйн алмуурын шал

товших чимээг чих тавин хамаг анхаарлаа хандуулчихаад байлаа. Модон шатаар товор товор өгсөж дээд давхарт өрөөндөө товор товор алхангаа, шатаар тор, тор уруудан төдөлгүй онгорхой үүдний цаана дахин хий үзэгдэл аятай сүүдийн үзэгдэх намайг даллан дуудсан бөгөөд энэ удаа азхидал барьсан байв!

Миний бие, уучлал эрсэн бөгөөд үг урсгах Ёолланд авгайг үлдээгээд хазганан түргэн түргэн алхах сони нбүсгүйг даган налуу эргээр уруудлаа. Тийн явсаар тосгоны хүмүүсийн нүдэнд өртөхөөргүй газар, хэдэн завины араар орсны дараа бүсгүй зогсож, миний өөдөөс сая эгцлэн хараад,

-Наашаа зогс, би таны царайг хармаар байна гэж хэлэв.

Түүний бодол царайнаас нь андашгүй ажээ. Намайг яс махнаасаа жигшин зэвүүцэж байлаа. Сайрхсан ч юм биш, үнэндээ нэг ч эмэгтэй урьд өмнө намайг иймэрхүү янзтай ширтэж байсан удаагүй, би ер нь иймэрхүү байдлыг нэг ч эмэгтэй хүн дээр ажиглаагүй билээ. Хүн тийм эрээ цээргүй сонжин ширтэхийг нэг их удаан тэвчихгүй нь лав. Би хазгар Люсигийн анхаарлыг миний нүүрийг бодвол арай бага жигшил төрүүлэх зүйлд хандуулахыг оролдож,

-Надад өгөх захиа танд байгаа юм уу. Энэ барьж байгаа захиа мөн үү? Хэмээн яриа өдөв. Гэтэл,

-Дахиад хэлээдэх гэснээс өөр хариу дуугарсангүй. Би ч дуулгавартай хүүхэд хичээлээ бататгаж байгаа мэтээр үгээ давтлаа.

-Үгүй ээ, энэ хүний царайнаас юу олж харсныг нь би лав ойлгохгүй юм байна. Дуу хоолйнх нь юунд болсон юм бол доо? Хэмээн бүсгүй өөртэйгөө ярих авч догшин харцаа надаас үл салгана. Тэгснээ гэнэт нүд буруулж, толгойгоо гилжилгэн алмуураа түшээд,

-Хөөрхий муу найз минь! Ай зайлуул, энэ ертөнцөөс халин одсон хонгор минь дээ! Гэхэд хоолойд нь уян зөөлөн аялга анх удаа сонсдож билээ. Дараа нь толгойгоо огцом өргөж, над руу дахин харснаа

-Хоол унд хоолойгоор чинь давах юм уу? гэж асуув.

Би төв буурьтай дүр үзүүлэхийг чадлаараа хичээж,

-Давгүй ээ гэв.

-Нойронд сайна уу?

-Сайн.

-Ямар нэг хөөрхий зарц бүсгүйг харахаараа та гэмшдэг үү?

-Үгүй, хаанаас даа. Ер юу болж гэмших билээ?

Хазгар Люси нөгөө захиаг бараг л миний улаан нүүр өөд чулуудаад,

-Май! Хэмээн хилэнтэй хашгирч, -Би урьд таныг ер үзээгүй. Бүхнийг чадагч бурхан минь, энэ хүний барааг хойшид ч миний нүдэнд бүү харуулаач! Гэв.

Тэгж хэлчихээд чадах хэрээрээ хурдлан хазганасаар одлоо. Түүнийг солиотой юм байна гэсэн бодол л төрсөн бөгөөд хэн ч тэгж бодох байсан нь эргэлзээгүй. Тийм гарцаагүй дүгнэлтэд хүрчихээд арай сонин зүйлийг буюу Розанна Спирманы захиаг үзвэл, "Мистер Фрэнклин Блэйкт, Люси Ёолланд зөвхөн гарт нь (өөр хэнд ч итгэмжлэн өгч болохгүй) дамжуулна" гэж хаяглажээ.

Би захианы лацыг ховхлов. Дугтуйнд захиа, захиан дотор нэг хуудас цаас байлаа. Захиаг уншваас, "Эрхэм ээ, та манай эзэгэйт Вериндер ахайнд айлчлах үеэр миний гаргасан зан оёгийн учры гмэдэх хүсэлтэй байгаа бол энэ захидалд хавсаргасан санамжинд бичсэн зүйлийг гүйцэтгэгтүн. Таны дуулгавартай зарц Розанна Спирман" гэжээ.

Дараа нь захианд хавсаргасан нөгөө цаасыг үзэв. Тэр бичгийг нэг ч үг гээлгүй сийрүүлбэ:

"Санамж: Далайн түрлэг эхлэхээс өмнө Нуранги элсэнд очиж, өмнөд цохионы дээрх цамхаг, Коббс Холлоос дээхэн байдаг гаалийн хорооны тугийн иш хоёр давхцаж харагдах хүртэл өмнөд хавцал дээгүүр явагтун. Цамхаг, тугийн ишний давхацсан шугамыг тэмдэглэхийн тулд саваа мод ч юмуу, ямар нэг шулуун зүйл хясаан дээр тавина. Тэгэхдээ савааны нэг үзүүр, цохионы Нуранги элс рүү тонойсон талын ирмэгт байхаар тавьж, цамхаг руу заасан үзүүрийн чигээс эхлэн савааны дагуу замгийг тэмтэрвэр цохионы ирмэгээс торгож, Нуранги элс рүү унжуулсан хэсэгт хүрнэ. Дараа нь гинжийг татаж гарга".

Сүүлчийн мөрийг уншиж дуусав уу, үгүй юу Бэттереж гуайн дуу ард гарлаа. Мөрдөх дон гэгч өвчнийг зохиогч маань тэрхүү тэсвэрлэшгүй бэрх өвчиндөө бүрмөсөн дийлджээ.

-Мистер Фрэнклин, би цаашид тэсэхгүй нь! Захианд нь юу байна вэ? Бурхан тэнгэрийг бодож хэлээд өгөөч, эрхэм ээ, захианд юу гэж вэ?

Би түүнд захидал, санамж хоёрыг өглөө. Захиаг онц сонирхохгүй боловч нөгөө санамжийг уншаад учиргүй их догдлон хөөрчээ.

-Түрүүч Кафф хэлээд байсан юм шүү! Юм нуусан газраа бичиж тэмдэглэсэн байж таарна гэж түрүүч Кафф бүр анхнаасаа хэлсэн. Тэр нь энэ байна. Бурхан минь, өршөөж хайрла! Агуу Каффаас эхлээд хүн бүхнийг мухардуулсан нууц энэ байна. Зөвхөн таны өмнө нээгдэхэд бэлэн хүлээж байна

гэхэд болно хэмээн өвгөн дуу алдаад, -Одоо татлага болж байгаа нь илэрхий. Харин түрлэг хэзээ эхлэх бол? Гэснээ дээш өлийн, загасны тор сэлбэн биднээс холгшйхэн суусан залууг олж хармагц, - Тамми Брайт аа! Гэж хоолой мэдэн хашгирсанд,

-Юу гээ вэ? Хэмээн Тамми хариу хашгирав.

-Түрлэг хэдийд эхлэх вэ?

-Цагийн дараа.

Бэттереж бид хоёул цагаа харлаа.

Хоёулаа эргээр тойрч яваад Нуранги элсэнд хүрч болох цаг элбэг байна. Яах вэ, эрхэм ээ? Гэж Бэттереж гуай асуулаа.

-Явъя!

Нуранги элс орох замдаа түрүүч Кафф мөрдлөг явуулж байсан үеийн Розанна Спирмантай холбогдол бүхий явдлуудыг сэргээн сануулж өгөөч гэж би Бэттереж гуайгаас хүссэн юм. Төдөлгүй өвгөн андынхаа тусламжаар тэр үеийн нөхцөл байдлыг нэг бүрчлэн тодорхой санах. Розаннаг бие нь муу, өрөөндөө хэвтэж байгаа гэж гэрт байсан бүх хүн бодож байтал Фризинхолл руу хулгайгаар яваад ирсэн, өрөөгөө дотроос нь түгжихээд өглөө болтол лаа барьж, шөнөжихнгөө нэг юм нууж хийсэн, Ёолланд авгайтай төмөр лааз, нохойн хоёр гинжний сэжиг бүхий наймаа хийсэн, тэгээд Нуранги элсэнд ямар нэг зүйл нуусан гэж түрүүч Кафф таамаглаж байсан боловч чухам юу нуусныг нь огтхон ч төсөөлөхгүй байсан зэрэг Сара нчулууг олох санаатай явуулсан бүтэлгүй мөрдлөгийн бүх явц, үр дүн биднийг нүүдэг элсэнд хүрч, өмнө цохио хэмээгч хясааны доод ирмэг дээр гарах үест надад дахиад тов тодорхой болсон юм.

Миний бие Бэттереж гуайн тусламжтайгаар цамхаг, гаалийн өртөөний туг давхцан үзэгдэх газрыг тун удалгүй оллоо. Дараа нь нөгөө санамжинд дурдсан зааврыг дагаж, миний таягийг хадны овгор товгор гадарга дээр зохих чигт боломжийн хэрээр тохируулан тавиад цагаа дахин харцгаав.

Түрлэг эхлэхэд нэг мөч гаруй хугацаа үлджээ. Тэр болтол нойтон, гулсамхай хадан дээр байснаас эрэг дээр гарцгаая гэж би хэлсэн юм. Хуурай элсэнд хүрээд суухаар завдтал Бэттереж гуай намайг орхиод явах гэхэд нь би жигтэйхэн гайхаж,

-Та явж яах нь вэ? Гэж асуулаа.

-Та захиагаа дахиад нэг харчих, тэгэхээр ойлгоно, эрхэм ээ. Миний бие захиаг дахин нэг хармагц л эл хэргийг зөвхөн ганцаараа гүйцэтгэх ёстой гэдгийг даруй санасан юм.

-Ийм үед таныг орхих хэцүү л байна. Гэвч хөөрхий тэр охин аймшигтайгаар нас эцэслэсэн болохоор түүний сүүлчийн хүслийг биелүүлье дээ гэж Бэттереж гуай хэлээд -Түүнээс гадна, та нууцыг мэдчихээд түүнээ хадгалах хэрэгтэй гэсэн үг захианд байгаагүй. Би гацууран ойд очоод хүлээж байя. Та нэг их удахгүйг хичээгээрэй, эрхэм ээ. Иймэрхүү байдал мөрдөх дон гэгч тэсэхүйеэ бэрх өвчин юм шүү дээ хэмээн учиртай гэгч нь нэмж өгүүллээ.

Тийнхүү сануулаад намайг орхин одов.

Хугацаа хэдий богино байвч хүлээсэн үед цаг явж өгөхгүй тамалгаатай удаан өнгөрдөг билээ. Иймэрхүү үед тамхи сэтгэлийг зүйрлэшгүй сайхнаар тайтгаруулан амраадаг юм. Би ороомол навчин тамхи асаан налуу эрэг дээр суув.

Орчны юмс нарны тунгалаг ариун гэрэлд гоо үзэсгэлэн бүрдэн үзэгдэнэ. Агаар даанч цэнгэг тул жирийн амьдралд жаргал цэнгэлийн өнгө оруулах аж. Тэнгисийн өнчин булан хүртэл өглөөг цовоолог угтах агаад Нуранги элсний нүцгэн чийглэг гадаргуу алтлаг өнгөөр гялалзан, хамаг аюул ослыг хуурмаг хүрэн мандлынхаа хоромхон зуурын инээмсэглэлийн цаана нуух бөлгөө. Миний бие Англид эргэж ирснээр ийм сайхан өдрийг үзсэнгүй.

Асаасан тамхиа бараагүй байтал далайн түрлэг эхлэв. Элсний мандал аяндаа овойж эхэлснээ тэр чигтээ жихүүдэс хүрэн доргин чичирхийлэх нь хөлгүүд гүнд нь орогногч савдаг амилан хөдөлж, тонрочон тийчигнэх лугаа адил үзэгдэнэ.

Санамжинд зааснаар бол цамхгийн талын үзүүрээс эхлэн таягны дагууд замаг дундуур тэмтрэх ёстой билээ.

Би таягны тэхий дундыг хүртэл тийнхүү тэмтэрсэн боловч хадны овгор товгороос өөр юу ч гарт өртсөнгүй. Гэвч дахиад ганц, хоёр ямх тэмтэрвэл тэвчээр гаргасныхаа шанг хүртлээ. Долоовор хуруу хүрэх газар нарийхан завсар гинж тааралдав. Цааш явуулан гинжний дагуу тэмтэрье гэвэл Розанна Спирман нууц газраа сонгож авснаас хойш ургаж, зузаарснаас үл зайлах замаг, хигдэрт гар орооцолдон саад болов.

Тэрхүү замаг, хигдэрийг гаргаж хаях буюу түүнийг нэвтэлж гараа шургуулна гэж санахын ч аргагүй ажээ. Таягны Нуранги элсний зүг хандсан үзүүрийн газрыг тэмдэглээд, нөгөө гинжийг өөрийнхөөрөө олохоор шийдлээ. Би гинжний яг элс рүү орсон газраас хад чулуу доогуур эрж хайх бодолтой байв. Таягаа авч өмнө цохионы ирмэг дээр сөхрөн суулаа. Тийн суухад миний нүүр Нуранги элсний мандлаас хэдхэн тохой дээр байв. Нүдний өмнөхөн оволзон бургилах элс ой гутам

зэвүүн тул хэрдхийн айдас төрөв. Мөдхөн талийгаач бүсгүй миний эрэлд туслахаар амиа бүрэлгэсэн газраасаа босож ирэх вий гэсэн аюумшигт бодол төрж, элсний зузаан мандал доороос юу юугүй өндийн гарч, нууц газрыг зааж өгөх вий гэхээс миний сэтгэлийг өгүүлэшгүй их айдас эзэмдэн, нарны дулаан элч төөнөн байвч бие хүйт даан дагжиж билээ. Таягны үзүүрээр элс хатгах анхны эгшинд өөрийн эрхгүй нүдээ аньсныг нуух юун.

Төдий л удалгүй, таягаа хоёр гуравхан ямх гүн дүртэл мухар сүсгийн элдэв айдас хүйдэс даруй замхарч, сэтгэл догдлон хөөрсөндөө хамаг бие чичрэн Сохор таамгаар ганц хатгаад л яг онож хатгажээ! Таяг гинжинд хүрэв.

Зүүн гараараа замаг, хигдэрийн үндэс ишнээс бат чанга зуурч, хясааны ирмэг тэгнэн харуулдан хэвтээд баруун гараа урагш түрсэн хадны доогуур явуулсаар нөгөө гинжийг олж барилаа.

Гинжийг алга урвуулах адил хялбар татаж гаргасан бөгөөд үзүүрт нь төмөр лааз бэхэлсэн харагдав.

Усанд удсан гинж зэвэрч, нөгөө лаазыг бэхэлсэн цагирагнаас салгах нөхцөлгүй болсон тул тэрхүү лаазыг өвдөг завсраа хавчуулж байгаад хамаг тэнхээгээрээ угзарч, тагийг нь онгойлгов. Дотор нь нэг цайвар эд байх агаад тэмтэрвэл бөс даавуу ажээ. Бөс даавууг гаргасанд бас нэг захидал унав. Хаягийг нь үзвэл миний нэр байх тул халаасандаа хийгээд нөгөө даавууг авч харлаа. Хайрцагт багтаах гэж маш чанга ороосон байх бөгөөд хэдий их удаан байсан боловч далайн ус нэвчиж муудсан шинж огт байсангүй.

Би тэр даавууг задлан эргийн хуурай элсэн дээр дэлгэв. Тэр бол эрэгтэй хүний унтлагын хувцас байлаа. Дэлгэхэд энгэрт нь түмэн үрчлээ, нугалаанаас өөр гойд юм байсангүй. Харин эргүүлтэл хойд хормойд нь Рэчелийн өрөөний хаалганы будаг наалдсан байхыг харав! Миний харц тэр толбо дээр гөлрөн тогтож, ухаан бодол тэртээ өнгөрснийг даруй нэхэн санав. Түрүүч Кафф хаалганы будаг халтартсаныг харан няцаашгүй дүгнэлт хийж хэлсэн үг бүр нь одоо миний хажууд зогсоод ярьж буй мэтээр санаанд тов тодхон буулаа. Энэ байшингаас “будаг хүрч балиартсан хувцас эрж ол. Хэний хувцас болохыг тодруул. Шөнө дундаас өглөөний гурван цагийн хооронд тэр этгээд энэ өрөөнд ямар санаатай орныг нь мэд. Тэр этгээд үнэмшилтэй хариу өгч чадахгүй бол алмаз хулгайлсан хүнийг холоос эрээд хэрэггүй биз ээ”

Эдгээр үгс тархинд эргэлдэн, нэгэн хэмээр нэн зүдэргээтэй давтагдана. Намайг дуудах чимээнээр үнэн хэрэг дээрээ хэдхэн хором болсон ч өчнөөн олон цаг үргэлжилсэн мэт санагдсан алмай байдлаасаа сая л ангижирлаа. Толгой өндийлгөж харвал эцэстээ тэсвэр алдсан Бэттереж гуай элсэн манхан дундуур сүлжин эргийн зүг айсуу үзэгдэв.

Өвгөний барааг хармагц би сэхээ орон эхэлсэн ажлаа дуусгалгүй орхисноо санасан юм. Унтлагын хувцас дээр толбо оллоо. Хувцасны эзэн хэн юм бол?

Эхлээд хайрцагнаас олсон захиаг уншью гэж бодлоо.

Гэвч халааснаасаа захиа авахыг завдсанаа арай хялбар дөт арга буйг санав. Унтлагын хувцас эзнийгээ хэлээд өгнө шүү дээ. Хувцсан дээр эзнийх нь нэр заавал байж таарна.

Би хувцсыг газраас авч тэмдэг эрэв.

Тэмдгийг олоод уншвал... миний нэр байх нь тэр. Нүдэнд дасал болсон үсгүүд шөнийн хувцас минийх байсныг өгүүлнэ. Би харц буруулав. Тунгалаг наран гийж, тохойн ус гялалзана. Бэттереж өвгөн улам улам ойртоно. Би нөгөө үсгүүдийг дахин нэг харлаа. Яах аргагүй миний нэр байна. Нүдний өмнө миний нэр жирийтэл бичээстэй үзэгдэнэ.

“Цаг хугацаа, хүч хөдөлмөр, хөрөнгө мангө тус болдог л юм бол би Саран чулууг хулгайлсан этгээдийг заавал олно” гэж ам алдаад Лондонгоос гарсан билээ. Нуранги элс амьтай бүхнээс чандлан нуусан нууцад би нэвтэрлээ.

Миний бие Саран чулууг хулгайлжээ гэдгийг будгийн толбо маргаогүй нотлон харууллаа.

## IV бүлэг

Тэр үед ямаршуу байдалд орсноо одоо хэлж эс чадна.

Цочиж мэгдсэндээ бодож, сэтгэх чадвараа бүрэн алдчих шиг болсон. Бэттереж гуайг хажууд ирэхэд чухам юу хийж буйгаа ч ухаарахгүй байсан маань лавтай. Өвгөний хэлснээр бол, надаас учрыг асуухад, би тачигнатал хөхөрч шөнийн хувцсыг гарт нь атгуулаад, учрыг өөрөө тайлагтун гэсэн гэнэ. Эрэг дээр бид юу ярилцсанаа би төсөөлөх ч үгүй байна. Одоо бодоход гацуурын ой юуны түрүүнд санаанд оров. Бэттереж гуай бид хоёр байшин руу буцаж алхсан бөгөөд нэг нэг аяга грог уучихвал нөхцөл байдлыг зохих ёсоор харах сөхөөтэй болно гэж хэлсэн билээ.

Үйл явдал гацуурын ойгоос Бэттереж гуайн зочны бяцхан өрөөнд шилжив. Би Рэчелийн байшингийн босгыг алхахгүй гэж шийдсэнээ ч мартжээ. Сүүдэр тусч, сэрүү татсан нам гүм өрөөнд ороход сэтгэл сэргэн баярламаар аж. Өвгөн андынхаа шүд хага ташим худгийн усаар найруулж бэлдсэн грог ууса нмаань тэр өдөр цаг нөхцөөх жирийн бус нэг арга болж билээ.

Өөр үед архи дарсны зүйл ухаан санааг мохоож орхих байлаа. Харин одоо сэтгэл санааг чангалав. Бэттереж гуайн хэлснээр, байдлыг зохих ёсоор үзэх сөхөөтэй болж эхэллээ. Бэттереж гуай ч бас өөрцгүй.

Өөрийнхөө байдлыг ийм маягаар дүрслэн өгүүлж байгаа минь нэмж хачирлалгүй хэлэхэд, тун ч жигтэй санагдана буй заа. Миний бие юутай ч зүйрлэшгүй тийм нөхцөлд орчихоод хамгийн түрүүнд хэрхэх ёстой байв? Хүн амьтнаас зайлж дөлөх үү? Байж боломжгүй атлаа няцашгүй баримтын учрыг олох гэж ухаан зарах уу? Лондон руу анхны галт тэргээр нэн даруй буцаж, нэр хүнд бүхий хүмүүстэй уулзаж зөвлөн, мөрдлөг сурвалжлагын ажлыг шуурхай эхлүүлэх байв уу? Үгүй ээ. Миний бие босгыг нь дахиж алхан нэр төрөө гутаахгүй гэсэн байшиндаа толгой хоргодохоор ороод, өглөөний арван цагт өвгөн зарцын хамт хүйтэн устай хольсон архи шимэн сууж байлаа. Минийх шиг ийм аймшигт байдалд орсон хүн ийм зан авир гаргадаг гэж үү? Өвгөн Бэттереж гуайн дотносог царай намайг үгээр илэрхийлэхийн аргагүй тайтгаруулан, бие тамирдан, сэтгэл цөхрөн мордсон тэр үед Бэттереж гуайн бэлдсэн грогноос өөр юу ч тус болоогүй гэдгийг л хэлэх байна. Би гагцхүү үүгээр цагаатгаж чадах агаад, хэрэв эдгээр мөрийг уншиж буй эрэгтэй, эмэгтэй хэн боловч насан туршдаа ямарваа байдалд орлоо ч гэсэн нэр төр, тогтвортой зангаа гуйвалтгүй чанд сахиж чадах юм бол бахдан шагстрихаас өөр юм надад үгүй.

-За мистер Фрэнклин ямар боловч нэг зүйл магадтай байна гээд Бэттереж гуай унтлагын цамцыг ширээн дээр шидэж, үгийг нь сонсох амьд амьтанд хэлж буй мэтээр хуруугаараа чичин –Энэ худалч этгээд залж байна гэв.

Ийм сэтгэл амраасан үг намайг тайтгаруулсангүй.

-Очир алмаз алдагдсан хэрэгт би таны нэгэн адил гэм буруугүй боловч миний эсрэг баримт байна шүү дээ! Унтлагын цамц дээрх будагны толбо, миний нэр хоёр хөдөлшгүй баримт байна гэж би хэллээ.

Бэттереж гуай миний шилэн аягыг ширээн дээрээс авч, гарт бариулаад,

-Баримт ий? Хэмээн давтан асууснаа, -Та грогноос дахиад нэг балгачих, тэгвэл баримтанд итгээд байгаа хулчгар зангаа дийлнэ! Нэг л будлиантай хэрэг байна, эрхэм ээ! Хэмээн дуугаа намсгаж, -Энэ оньсогыг би ингэж л таарах байна! Нэг л будлиантай хэрэг байна, та бид хоёр учрыг нь тайлах ёстой. Тэр хайрцаганд өөр юм байсан уу? гэлээ.

Би халаасандаа хийсэн захиаг даруй санаж, гаргаж ирээд задлав. Шигүү бичсэн олон хуудас захиа байлаа. Би тэвчээр алдан гарын үсгийг нь яаран үзвэл “Розанна Спирман” гэжээ.

Энэ нэрийг уншмагц санаанд нэг зүйл зурсхийн орж гэнэтийн шинэ таамаглал төрөн

-Байз Розанна Спирманыг манай нагац засан хүмүүжүүлэх газраас авсан билүү? Розанна Спирман урьд хулгайч байсан байх аа? Хэмээн би дуу алдан асуулаа.

-Яг үнэн.Одоо энэ ямар хэрэг болсныг хэлж өгнө үү.

-Одоо юу? Ер нь тэр бүсгүй очир алмазыг хулгайлсан ч юмуу, бид яаж мэдэх вэ дээ? Миний унтлагын цамцыг зориуд будаг болгосон ч байж магадгүй, хэн мэдэх вэ дээ...

Бэттереж гуай миний гар дээр гараа тавьж цааш яриулсангүй.

-Фрэнклин, та биеэ цагаатгаж чадах нь огт эргэлзээгүй. Гэвч ийм аргаар цагаатгахгүй байх гэж найдна. Эрхэм ээ, эхлээд захианд юу бичсэнийг хар л даа. Талийгаачийг хүндэтгэж, захиаг нь үзэгтүн.

Бэттереж гуайн тийнхүү төв өгүүлэх дуунд нөхөрсгөөр зэмлэх өнгө сонсдов.

Захиаг нь та өөрөө шүүж үзээрэй, би танд дурдаад өгье гэж хэлээд доорх мөрийг уншиж эхлэв.

“Эрхэм ээ, би танд үнэнээ хэлэх ёстой. Заримдаа тоймгүй уй гашуу дүүрсэн үнэнийг хэдхэн үгээр илэрхийлж болдог билээ. Би ч бас гуравхан үгээр үнэн учраа хэлж чадна: Би танд хайртай”.

Захиа миний гараас алдран унав. Бэттереж гуайг ширтэн, “Тэнгэр минь, юү гэсэн үг вэ!” хэмээн би дуу алдлаа.

Бэттереж гуай хариу хэлэхээс эвгүйцсэн бололтой

-Өнөө өглөө та хазгар Люситай цуг хоёулханаа байсан шүү дээ. Танд Розанна Спирманы талаар юу ч хэлээгүй гэж үү?

-Розанна Спирманы нэрийг ч цухуйлгаагүй.

-Мистер Фрэнклин, та захиагаа цааш нь унш л даа. Ний нуугүй хэлэхэд, таны амссан зовлонг харсаар байж урмыг чинь хугалах зүрх надад алга. Талийгаачийн захиа учрыг хэлэг, эрхэм ээ. Грогносоор балга. Сэтгэлээ барьж, тайван байхын тулд грогноосоо уу!

Би захиаг цааш нь уншлаа.

“Намайг амьд сэрүүнд та үүнийг унших байсан бол ингэж бичих нь надад туйлын ичгэвтэр байхсан. Гэвч та миний захиаг авах үед би нэгэнт хорвоогоос одсон байх болно. Энэ л намайг зоригжуулсан юм. Намайг танд сануулах булш ч үлдэхгүй. Би үнэнийг бичихээр шийдлээ. Яагаад гэвэл, бичиж дуусмагц л Нуранги элс намайг нууж далдлахаар хүлээж байгаа билээ. Түүнээс гадна та миний нууц газраас будгийн толбо бүхий унтлагын цамцаа олох бөгөөд түүнийг би ямар аргаар ав нуусан, амьд сэрүүндээ энэ тухай танд яагаад үг цухуйлгаагүй учрыг мэдэхийг хүсэх буй заа. Ийм хачин зүйл үйлдсэний цорын ганц шалтгаан бол би танд хайртай байлаа.

Манай эзэгтэйд ирсэн өдрөөс чинь өмнөх үеийн туулсан амьдралаа болон өөрийнхөө тухай элдвийг нуршиж таныг чилээхгүй. Вериндер ахай намайг засан хүмүүжүүлэхээс авсан юм. Тэнд би шоронгоос очсон байлаа. Би хулгай хийсэн учраас шоронд орсон байв. Намайг бага балчир байхад эх минь гудамжаар хэрж тэнүүчилдэг байсан болохоор би хулгайч болсон юм. Миний эцэг гэгч нэг эрхэм эхийг минь хаясан учраас гудамжинд орогнох болсон билээ. Ийм ерийн түүхийг дэлгэрэнгүй нурших хэрэггүй биз. Иймэрхүү зүйлийг сонинд зэгсэн элбэг бичсэн байдаг. Вериндер ахай надад их л сайн. Бэттереж гуай ч бас их сайн байлаа. Би энэ насандаа тэр хоёр болон засан хүмүүжүүлэх газрын дарга авгай гурваас өөр сайн хүнтэй ер тохиолдсонгшгүй. Та манай ахайтныд айлчилж ирээгүй байсан бол би нэг их аз жаргалтай биш ч гэсэн хэвийн л амьдрах байлаа. Би таныг зэмлээгүй шүү, эрхэм ээ. Энэ бол миний буруу, бүхэлдээ миний буруу.

Та Бэттереж гуайг эрж элсэн манхны дундаас гарч ирсэн тэр өглөөг санаж байна уу? Тэгэхэд та шидэт үлгэрийн хөвгүүн шиг, хүсэл мөрөөдлийн янаг залуу мэт харагдсан билээ. Танаас өөр тийм бахдам сайхан хүнийг энэ насандаа ч үзсэнгүй билээ. Таныг хармагц миний дотор нэг л цоо шинэ аз жаргал бялхах шиг болсон. Чадвал та бүү шоолж дооглоорой. Ай хөөрхий, энэ бүхэн миний хувьд хэчнээн чухал гэдгийг танд ойлгуулж чаддаг ч болоосой!

Би хариад ажлын хайрцаг дээрээ таны нэрийг өөрийнхөө нэртэй зэрэгцүүлэн бичиж, доогуур нь холбон зурсан. Тэгтэл нэг чөтгөр, үгүй ээ, сайн санаат сахиулсан тэнгэр (ингэж хэлбэл зохино) “Очиж толинд харагтун!” гэж шивнэлээ. Толь надад юу харуулсныг дурсаад ч яах вэ. Би тэр сануулгыг анхаарах сөхөөгүй даан ч тэнэг загнажээ. Би тантай нэг зэрэг зиндаанд хатагтай шиг таны урьд өмнө үзсэн бүсгүйчүүдийг дагуулахгүй гоо үзэсгэлэнэтэй юм шиг танд улам улам тэмүүлсээр байв. Таны нүдэнд өртөх гэж би хичээн байлаа. Ай тэнгэр минь, хэчнээн их мэрийдэг байв аа. Та намайг ганц нүдээрч тооц харахгүй байсанд би гутран гашуудаж, шөнөжин уйлан усан нүдэлдэг байсныг минь та гадарласан бол намайг өрөвдөж надад амьдрах хүч тэнхээ олгохын тулд хааяа нэг харц тогтоон соёрхох байсан буй заа.

Гэвч миний бие мисс Рэчелийг хэрхэн үзэн яддагийг мэдвэл таны харц төдий л аятай байхгүй болов уу. Таныг мисс Рэчелд сэтгэлтэй болсноо ухаарахаас чинь өмнө би гадарласан бололтой. Мисс Рэчел таныг энэ гэртээ зүүж яваг гэж сарнай бэлэглэдэг байсан. Ай, байсан юм шүү. Тэр үед мисс Рэчелийн өгсөн сарнайг хаячихаад устай шилэнд өөрийнхөө гараар тасалсан сарнайг сэмхэн хийж л сэтгэлээ амраадаг байлаа би.

Мисс Рэчел таны бодож байгаачлан үнэхээр царайлаг бол би энэ бүхнийг давгүй тэсэхсэн. Үгүй ээ, бүр ч зэвүүцэх минь лавтай. Та мисс Рэчелийг элдэв гоёл чимэглэлгүй нь шивэгчний жирийн нэг хувцатайгаар төсөөлөөд үз л дээ. Би ийм маягаар бичээд мар ашигтай болохыг мэдэхгүй л байна. Мисс Рэчелийн биеийн галбир муухай, дэндүү эцэнхий гэдгийг хэн ч няцааж чадахгүй. Гэвч эрчүүдийн сэтгэлд юу таалагддагийг хэн мэдэх билээ? Бас залуу авхай нар, шивэгчин хүн бол ажлаасаа хөөгдчихөөр, зан авиртай байж болдог. Энэ ч надад падгүй л дээ. Би иймэрхүү маягаар бичих юм бол та миний захиаг гүйцэд уншихгүй биз ээ. Гэвч мисс Рэчелийг царайлаг хөөрхөн гэлцэхийг сонсоход, өмсөж зүүсэн хийгээд эршүүд бардам зан нь түүнд өнгө оруулдагийг мэдэж байгаа хүнд их л гомдолтой юм даа.

Эрхэм ээ, тэвчээр гарган цааш уншиж соёрхоно уу. Би одоо таны сонирхлыг татах нь лавтай үе буюу очир алмаз алдагсдан үеийг өгүүлье.

Гэвч юунд өмнө хэлэх нэг зүйл байна. Би хулгай хийж амь зуудаг үедээ тэгтлээ зовж гачигддаггүй байлаа. Харин засан хүмүүжүүлэх газарт намайг гутамшигт үйлээ ухамсарч, засарч хүмүүжихийг сургаж эхэлсэн үед л өдөр хоног барагдахгүй, зүдэргээтэй сунжирдаг болсон юм. Ирээдүйн тухай элдвийг боддог боллоо. Шударга жураөмт хүмүүс, хүний сайн нь ч гэсэн намайг дотроо зэмлэж байдгийг би мэддэг байв. Хаана ч явсан, юу ч хийсэн, хэнтэй ч уулзсан би зүрх шимшрэн үргэлж ганцаарддаг байлаа. Шинэ газар ирээд хамт ажилладаг зарц шивэгчин нартайгаар ам хэлээ ололцож, эвтэй байх нь миний үүрэг гэдгийг би мэднэ. Гэвч би тэдэнтэй үерхэж, дотносож нэг л чадсангүй. Тэд миний яма рбайсныг гадарласан бололтой, эсвэл надад тэгж санагдсан юм. Би засаръя гэж урамшин хичээхдээ огт харамсадаггүй байсан ч гэсэн үнэндээ даанч залхмаар бэрх амьдрал байж билээ. Гэтэл та энэ амьдралыг зүсэн гийгүүлсэн нарны туяа мэтээр эхлээд гарч ирсэн

боловч хожим миний горьдлого бас л талаар өнгөрсөн юм. Би танд дурлаж, ихээхэн мунхаг загнасан байтал та намайг нэг нүдээр ч харсангүй. Энэ бол маш их зовлон, үнэхээр их зовлон юм шүү.

Одоо би хэлэх гэсэн зүйлдээ орё. Гашуун үй гунигт автсан тэр өдрүүдэлд миний гадагш гарах ээлжийн чөлөө болоход би дурладаг газраа буюу Нуранги элсний эрэг дээр хоёр гурван удаа очсон юм. “Би энд л төгсөнө байх. Тэсвэр барагдахаараа энд л эцэс болно байх даа” гэж би өөртөө хэлдэгсэн. Таныг энд ирэхээс өмнө тэр газар намайг илбэдчихсэн юм шиг татдаг байсныг та ойлгоно бизээ. Нуранги элсэнд надад нэг л юм тохиолдоно эгж би дандаа муу ёрлодог байлаа. Одоо миний өгүүлэн буй үеэс өмнө тэр элсийг харахдаа амь насаа бүрэлгэх зэвсэг минь болох юм гэж огтхон ч төсөөлөөгүйсэн. Харин сүүлдээ энд зовлон гамшгаасаа нүд ирмэх зуур салж, намайг үүрд агуулж чадах газар байна гэж би бодох болсон юм.

Таны барааг анх удаа харсан тэр нэг өглөөнөөс эхлэн, очир алмаз алга болж, гэр оронд үймж сандарсан өглөөг хүртэл өөрийнхөө ямаршуу янзтай байсныг өгүүлэхэд ийм л байна. Хэнийг хамгийн түрүүнд сэрдэх бол гэлцэн холхилдох шивэгчин авгай хүүхнүүдийн элдэв тэнэг ярианаас би бүр залхаж гүйцсэн ба мөн сайхь чулууг эрж олох гэсэн тан хүчин чармайлт миний бие холхон явахыг хичээдэг цагдаагийн газар хүн илгээсэн зэрэг чинь Фризинхоллоос цагдаагийн эрүүлч ирсэн өдрийн шувтарга хүртэл миний уурыг (тэр үед би олигтой юу ч мэдээгүй байсан л даа) хүргэж байлаа.

Мистер Сигрев юуны түрүүнд шивэгчин нарын унтлагын өрөөнд харуул тавьж ажлаа эхэлснийг та мартаагүй бизээ. Тэгэхэд нь авгай хүүхнүүд галзууртлаа уурсаж, ямар учраас тийнхүү доромжлоснг нь мэдье гэлцэж дээш гүйлдсэн. Би ч бас тэдэнтэй хамт явлаа. Эс тэгвэл мистер Сигрев намайг олон таван үггүй сэжиглэх байсан юм. Бид мистер Сигревийг мисс Рэчелийн өрөөнд байхад нь олж уулзсан. Тэгтэл үүдний будаг халтартсаныг заагаад, энд ийм олноороо шавааралдах хэрэг огт үгүй, та нарын нэг нь хормойгоороо үүнийг шүргэчихжээ гэж хэлээд биднийг өрөөнөөс гаргасан юм.

Би мисс Рэчелийн өрөөнөөс гараад шатны талбайд зогсон хормойгоо будаг болгочихоогүй байгаа хэмээн үзэж байтал Пенилоп Бэттереж (миний нөхөрсөг байдаг ганц эмэгтэй) хажуугаар өнгөрөхдөө юу хийж байгааг минь ажиглажээ.

-Розанна зовох юмгүй ээ. Мисс Рэчелийн өрөөний хаалганы будаг хатаад хэдэн цаг болж байгаа юм. Мистер Сигрев манай өрөөнд харуул манаа тавиагүйсэн бол ч би түүнд энэ тухай хэлэх л байлаа. Та яасныг мэдэхгүй, харин би энэ насандаа ингэж доромжлуулж үзсэнгүй! Гэж Пенилоп хэлж билээ.

Пенилоп бол түргэн ууртай бүсгүй байв. Би түүнийг аргадаж тайтгаруулаад, хаалганы будаг хатаад хэдэн цаг болсон мэтээр хэлснийг нь лавла насуулаа.

-Та яаж мэдээ вэ?

-Би өчигдөр өглөөжин мисс Рэчел мистер Фрэнклин хоёрыг хаалган дээр зураг зурж дуусан дуустал будгийг нь найруулж х амт байсан юм. Орой зочдод үзүүлэхэд будаг хатсан байх болов уу гэж Рэчел авхай асуухад, мистер Фрэнклин толгой сэгсрээд арван хоёр цагаас наашгүй гэсэн. Тэд цайны цагаас зөндөө хойно, гурван цагийн алдад дууссан. Тэгэхээр, Розанна бодоод үз л дээ. Миний бодоход, будаг өглөөний гурван цагт хатчихсан байх ёстой байжээ.

-Хатагтай нарын нэг өчигдөр орой хаалганы зураг очиж үзсэн юм болов уу? Уг нь мисс Рэчел хаалганд хүрүүзэй гэж тэдэнд анхааруулж байсан шиг санагдах юм гэж би асуулаа.

-Хатагтай нараас хаалганд хүрсэн хүн байхгүй. Би мисс Рэчелийг хэвтүүлээд шөнө арван хоёр цагт гарсан. Тэгэхэд хаалганы зурэг зүв зүгээр байсан юм гэж Пенилоп хариулав.

-Пенилоп, та үүнийгээ мистер Сигревд хэлэх хэрэгтэй юм биш үү?

-Би мистер Сигревд тус болох нэг ч үг хэлэхгүй! Гэхээд Пенилоп би дхоёр тус тусын ажил руу явсан юм.

Эрхэм ээ, би таны орыг хурааж, өрөөг чинь эмхэлц цэгцлэх ажилтай байв. Тэр бол миний хувьд хамгийн аз жаргалтай өдрийн цаг байдагсан. Таны шөнөжин тэргүүнээ тавьсан дэрийг би үндсдэг байлаа. Хожим таны өрөөг хэн ч цэвэрлэлээ гэсэн юм хүмийг чинь тэгж сайхан цэгцэхгүй биз ээ. Таны шөнөжин тэргүүнээ тавьсан дэрийг би үндсдэг байлаа. Хожим таны өрөөг хэн ч цэвэрлэлээ гэсэн юм хүмийг чинь тэгж сайхан цэгцлэхгүй биз ээ. Таны аяны цүнхэндээ авч явдаг аар саар зүйл дээр өчүүхэн тоос шороо байлгадаггүйсэн. Гэвч та намайг анхаардаггүйтэйгээ адил үүнийг ч бас ажигладаггүй байсан. Уучлаарай, бүр хадуурч орхилоо. Яаравчилж, цааш үргэлжлүүлье.

За, би тэр өглөө таны өрөөг цэвэрлэхээр явлаа л даа. Унтлагын цамцаа тайлаад орон дээрээ шидчихсэн байлаа. Би түүнийг авч эвхэж эхэлтэл мисс Рэчелийн өрөөний халганы будаг хүрсэн харагдав!

Эхлээд би цочиж балмагдсандаа таны унтлагын цамцыг барьсан чигээрээ гүйн гарч арын шатраар харайлгасаар цамцыг сайтар үзэхэд хүн амьтан саад болох вий хэмээн өрөөндөө орж түгжсэн билээ.

Жаахан сэхээ авмагцаа Пенилоптой ярилцсанаа эргэн санаж, “Урьд шөнийн арван хоёроос гурва нцагийн хооронд мисс Рэчелийн зочны өрөөнд орсон байх нь ээ” гэж өөртөө хэлсэн юм.

Тэр будгийг олж хараад анх ямар бодол төрснийг танд илэн далангүй хэлээд хэрэггүй биз. Тэгвэл та уурлаж, миний захиаг уншилгүй ураад хаячихаж магадгүй.

Харин таны зөвшөөрлөөр ганц зүйл хэлэхэд хангалттайн юу гэвэл, би бүгдийг эргэцүүлж үзээд, доор дурдах шалтгааны улмаас миний сэжиглэл огт үндэсгүй юм гэж шийдсэн билээ. Хэрэв та мисс Рэчелийн зочны өрөөнд тийм орой болсон хойно орсон бол мисс Рэчел заавал мэдэх ёстой бөгөөд та хаалганы будаг хатаагүйг мартахаар ухаан алдчихсан явлаа гэхэд Рэчел танд сануулах байсан нь лавтай. Ягаад гэвэл мисс Рэчел нэр төрд нь харшлах одоо миний нүдний өмнө байгаа энэхүү эвгүй баримтыг авч явахыг танд хэрхэвч зөвшөөрөхгүй л дээ! Тэр үед би анхын сэжиглэл маань буруу эсэхэд үнэндээ л эргэлзэж байсан юм. Би мисс Рэчелийг үзэн ядаг гэж үнэнээ хэлснийг минь та лав мартаагүй биз. Тэгээд чадвал энэ бүхэнд үзэн ядах сэтгэлийн өчүүхэн хэсэг байсан гээд төсөөлөөд үзээрэй. Эцсийн эцэст, би хожим яаж ашиглавал зохихыг харзная, хүлээзнэе гэж шийдсэн юм. Тэр үед, үүнийг бүү мартаарай, таныг очир алмаз хулгайлсан гэдэг бодол миний толгойд даанч ороогүй юм шүү”.

Энэ хэсэгт хүрээд би дахин завсарлав.

Тэр золгүй бүсгүйн сэтгэлээ илчилсэн мөрүүдийг уншихдаа би эвгүйцэн гайхаж, мөн нуулгүй хэлэхэд үнэн голоосоо гашуудсан билээ. Захианаас нь ганц ч мөр уншаагүй байхдаа ясыг нь өндөлзүүлсэн бодолгүй юм ярьсандаа амаа барьж үнэхээр харамссан билээ. Гэтэл дээр дурдсан сүүлчийн мөрд хүрэх тусам Розанна Спирманд улам их эгдүүцэн цухалдаж байснаа хүлээ.

-Май, бусды нь өөрөө унш. Намайг мэдэх хэрэгтэй гэж үзвэл тэр хэсгийг нь хэлчихээрэй гэж захиаг ширээн дээгүүр Бэттереж гуайд сарвайлаа.

-Мистер Фрэнклин таныг ойлгож байна. Таны хувьд энэ бол зүй ёсны юм. Тэнгэр биднийг ивээг гэснээ Бэттереж гуай дуугаа намсган, -Талийгаачийн хувьд ч бас зүй ёсны юм шүү дээ гэж нэмж хэлэв.

Одоо миний гарт буй захианы эхийг нааш сийрүүле:

“Таны унтлагын цамцыг өөртөө үлдээж, хожим миний хайр юмуу хорсол (алин болохыг би сайн мэдэхгүй) түүнийг хэрхэхийг үзэхээр шийдсэн бөгөөд хүнд сэжиг авахуулалгүйгээр нуух хэрэгтэй болсон юм.

Бямба гаригт угаагч авгай бүртгэлийн дэвтэртэйгээ ирэхээс өмнө яг адилхан унтлагын цамц хийх ганц арга байлаа.

Энэ ажлыг дараагийн өдөр буюу баасан гариг хүртэл хойшлуулбал элдэв юм тохиолдуузай хэмээн эмээсэн учраас тэр өдөртөө (пүрэв гаригт) шинэ цамц оёж дуусгахаар сэтгэл шулуудсан юм. Хэрэв би олигтойхон жүжиглэж чадвал хэдэн цагийн чөлөө олж дөнгөх байв. Таны унтлагын цамцыг авдранда хийж цоожлоод, цэвэрлээг хийж дуусгахын (Пенилопоос гуйвал миний өмнөөс гүйцээчих л байсан юм) тулд төдийгүй, ор дэвсгэртээ юмуу, өрөөний тавилгад будаг хүрсн эсэхийг үзэхийн тулд таны өрөөнд буцаж очлоо.

Би будгийг нэгд нэгэнгүй сайтар нарийн шалгасны эцэст таны халаатны дотор будгийн бяцхан толбо байсныг олов. Тэр бол таны үргэлж өмсдөг даавуун халаат биш, харин таны бас авчирсан үслэг бөсөн халаат байлаа. Та дан унтлагын хувцастайгаа хойш урагш холхисоор даарч, гартаа тааралдсан дулаан юм авч нөмөрсөн бололтой. Ямар ч атугай халаатны дотор будагны толбо байсан юм. Түүнийг хусч, хялбархан арилгав. Үүний дараа таны эсрэг цорын ганц баримт үлдсэн бөгөөд тэр нь миний авдранд цоожтой байлаа.

Таны өрөөг дөнгөж цэвэрлэж дуусмагц мистер Сигревт байцаагдахаар бусад зарц шивэгчин нарын хамт очлоо. Дараа нь бидний авдар, савыг нэгжив. Сүүлд нь таны унтлагын хувцас дээр наалдсан будгийг олж үзсэний хойно миний хувьд тун жирийн бус нэг явдал тохиолдсон юм. Пенилопыг ахлах байцаагч Сигрев дахин дуудаж байцаасны дараа тэр явдал болсон юм. Пенилоп галзууртлаа уурлачихсан хүрч ирэв. Учир нь мистер Сигрев тун доромжилсон байдлаар харьцсан юмсан. Пенилопыг хулгайд сэрдэж буйгаа эргэлзэх аргагүй шууд цухуйлгасан гэнэ. Үүнийг сонсоод бид бүгдээрээ гайхаж, “Яагаад?” хэмээн ам амандаа асууцгаав.

-Яагаад гэвэл, очир алмаз мисс Рэчелийн зочны өрөөнд байсан бөгөөд тэндээс би хамгий нсүүлд гарсан юм гэж Пенилоп хариулав.

Пенилопыг ам ангаймагц л зочны өрөөнд түүнээс хойш өөр нэг хүн орсон гэдгийг би даруй санасан билээ. Тэр хүн бол та байлаа. Миний толгой эргэж, ухаан санаа бүр самуурч орхив. Тэгэхээр цамцанд таны цамцанд хүрсэн будгийн учир түрүүнд бодож байснаас шал өөр юм биш үү гэсэн бодол зурсхийн орж ирлээ. “Өрөөнд хамгийн сүүлд орсон хүнийг хулгайд сэрдэж байгаа юм бол тэр нь Пенилоп биш, мистер Фрэнклин Блэйк байж таарах нь ээ!”.

Танаас өөр эрхмийг тэгж хулгайд сэрдэх битгий хэл, тиймэрхүү юм бодохоосоо ч би ичих байлаа.

Гэвч та надтай адилхан болтлоо урууджээ, тэгээд таны унтлагын цамц миний гарт орсноор таныг илрэх аюул, шившгээс аварчээ гэдэг нэг бодол, эрхэм минь, таны талархлыг хүлээх боломж олгох мэт санагдаж билээ. Таныг талархана гэж таамаглаж байснаа сүүлдээ мухар сохроор итгэж эхэлсэн билээ. Та бид бүхнийг төөрөлдүүлэхийн тулд л цагдаагийн газраас хүн авчрахаар тэглээ их мэрийжээ, мисс Речелийн очир алмазыг та авснаас зайлахгүй нь гэж даруй ухаарсан юм.

Энэхүү шинээр олж мэдсэн зүйл миний толгойг бүрмөсөн эргүүлсэн байх. Би таны барааг харж, очир алмазын талаар ганц хоёр үг цухуйлгахыг тэсгэлгүй хүсэж, намайг хараасай, надтай ярилцаасай гэсэн хүсэлд автан үс гэзгээ самнаж, царай зүсээ чадах хэрээрээ янзлаад таны юм бичээд сууж байсан номын сан руу зоригтой алхсан юм.

Та нэг бэлзгээ шатан дээр унагасан байсан нь надад хүсэвч олдшгүй шалтаг болсон юм. Гэтэл, ай зайлуул гэж! Таны сууж байсан өрөөний босгыг алхмагц л хамаг бие хүйт даагаад явчихсан билээ! Эрхэм ээ, та дурлаж үзсэн бол үүнийг ойлгох буй заа. Намайг та хүйтнээр ширтэн, бэлзэн олсонд даанч хайхрамжгүй талархсан тул өөрийн эрхгүй өвдөг чичрэн таны хөлд сөхөрч унамаар болж билээ. Надад талархчихаад та гэнэт санах мэт бичиж байсан зүйл рүүгээ эргэсэн. Тийнхүү басамжлуулсандаа гомдож хорссон миний бие бас ч гэж ярих сөхөөтэйгөө байсан юм. “Энэ очир алмазын хэрэг мөн сонин оо!” гэж хэлэхэд та миний зүг дахин харж, “Тийм ээ” гэсэн. Та эелдэг ялдам хариулсныг би үгүйсгэхгүй, гэхдээ хөндий, аймшигтай хөндий харьцаж байсан. Нөгөө алмазыг та биедээ нуусан гэдэгт би урьдын туршлагадаа үндэслэн итгэж байсан тул таны хүйтэн хөндий байдал эцэстээ намайг түлхэж, танд битүү сануулахаар зориг шулуудсан юм. “Эрхэм ээ, тэр алмаз хэзээ ч олдохгүй, тийм ээ? Авсан хүнийг нь ч олохгүй, би батална” гэж хэлээд “Би мэдэж байна!” гэх маягаар тан руу толгой дохиж инээмсэглэсэн. Энэ удаад та намайг нэлээд сонирхсон шинжтэй харсан. Та бид хоёр дахиад хэдхэн үг солиод л үнэнээ хэлэлцэх байсныг би ойлгож билээ. Тэгтэл яг тэр мөчид Бэттереж гуай ирж, хамаг юм баллачихав. Би түүний хөлийн чимээг андахгүй, бас өдрийн цагаар номын санд орохоор барахгүй тантай хамтбайгаа нь дүрэм журам зөрчсөн хэрэг болохыг би мэдэж байв. Хөөгдөхөөсөө өмнө гарч амжих төдий л зай үлджээ. Миний уур хүрч, урам хугарсан горьдлогт тасраагүй юм. Та бид хоёрын хооронд нэгэнт ам хагарсныг та ойлгоо биз. Хожим, Бэттереж гуайг байхгүй үеэр эвийг нь олж ярилцъя гэж бодлоо.

Намайг зарц нарын тэнхимд эргэж очиход үдийн хоолны хонх дуугарч байв. Аль хэдийн үд болчихож! Гэтэл унтлагын шинэ хувцас хийх даавуу аваагүй л байдаг! Даавуу олж авах ганцхан л арга байсан юм. Хооллох үеэш би өвдсөн царай гаргаж, оройн цайны цаг хүртэл чөлөөтэй болж, тэр хугацаанд юу ч хийсэн дур байлаа.

Намайг өрөөндөө өвчтэй хэвтэж байгаа гэдэгт зарц шивэгчин нар бүгд үнэмшсэн тэр үед би юу хийснээ, мөн тэр оройн цайн дээр дахиад бие муудлаа гээд хэвтэхээр явсан хэрнээ шөнө хэрхэн өнгөрөөснөө танд хэлээд хэрэггүй биз ээ. Эрүүлч Кафф илүү л юм илрүүлчихээгүй бол харин үүнийг сайн мэдсэн юм. Хэрхэн мэдсэнийг нь би тааварлаж ч чадна. Фризинхоллын бөс барааны мухлагт ороход намайг хэдийгээр гивлүүрээ сөхөөгүй байсан боловч таньсан юм. Дааваа авсан мухлагт миний өмнө толь байсан бөгөөд нэг н аймаачин миний мөрийг заагаад, нэг нөхөртөө юм шивнэх нь толинд үзэгдсэн билээ. Мөн шөнө өрөөгөө түгжээд унтлагын хувцас нууцгайхан оёж суутал намайг сэрдэж байсан шивэгчин авгай, хүүхнүүдийн амьсгаадах нь үүдний цаанаас сонсогдсон юм.

Энэ бүхэн тэр үед надад ер падгүй байв. Одоо ч бас огт хамаагүй. Баасан гаригийн өглөө, түрүүч Каффыг ирэхээс хэдэн цагийн өмнө таны унтлагын цамцыг шинээр бэлэн болгов. Түүнийг оёж шидэн, угааж индүүдээд угаалгачин хүүхний адил эвхээд таны авдарт бусад цамцны хамт тавьсан юм. Дотуур хувцас хунар шалгалаа ч гэсэн тэр шинэ өмд цамц намайг илчилж чадахгүй байв. Учир нь юү гэвэл таны дотуур хувцас шинэ байлаа. Та гадаадаас ирэхдээ бүгдийг сольсон бололтой.

Дараа нь түрүүч Кафф ирээд хаалганы будаг балиартсаны учрыг хэрхэн үзэж буйгаа мэдэгдсэн нь туйлын их гайхлыг төрүүлсэн юм.

Дээр нэгэнт үнэнээ хэлсэнчлэн, би таныг өөр хэрэгт буруутгаагүй байгаасай гэсэндээ л хулгайд сэрдсэн билээ. Гэтэл одоо эрүүлч огт өөр замаар минийхтэй адилхан дүгнэлтэнд (унтлагын цамцны тухайд) хүрчээ! Гэвч таныг буруутгах цорын ганц эд мөрийн баримт болсон хувцас миний гарт байлаа! Үүнийг нэг ч амьд амьтан, та ч хүртэл мэдэхгүй билээ! Хожим та намайг жигшин дурсах болно гэж бодоход ямар санагдсаныг танд хэлэхээс ч айнама”.

Энд хүрээд Бэттереж гуай захианаас нүд салган дээг харав.

Мистер Фрэнклин одоо хүртэл юуны ч сэжүүр гарсангүй шив дээ. Эрхэм ээ, намайг дуудаж өгөх зуур та ямар нэг дүгнэлт хийв үү? Гээд өвгөн яст мэлхийн ясан хүрээ бүхий нүсэр шилээ авч, Розанна Спирманы наминчлалыг жаахан түлхэв.

Бэттереж гуай, хэлээд зайхиагаа дуусгачихъя. Сүүл рүүгээ учир нь олдож магадгүй. Дараа нь би танд ганц хоёр үг хэлэмз.

Зүйтэй, одоо нүдээ жаал амраагаад цааш нь уншъя. Тэр хооронд, би таныг шавдуулах гээгүй л джж гэхдээ дургүйцэхгүй бол та энэ аюумшигт будлианаас гарах зам олсон эсэхийг товчхон ё болов хэлж өгөөч.

Лондон руу буцаж мистер Браффтай зөвлөх зам байна. Надад туласж чадахгүй гэвэл. . .

Тэгнэ гэж үү?

Бас түрүүч Кафф Доркины аглаг амьдралаа орхихоос дургүйцвэл...

Дургүйцнэ дээ, мистер Фрэнклин минь!

...Тэгвэл ч миний хамаг арга тасрах нь тэр дээ, Бэттереж гуай. Мистер Брафф эрүүлч хоёроос өөр надад бэчүүрхэн төдий ч тус болох хүн ер үггүй гэж би хэллээ. Намайг үгээ хэлж гүйцтэл хаалга тогшив. Бэттереж гуай тийнхүү яриа тасалдуулсанд баахан гайхахын зэрэгтээ дурамжхан байгаа харагдав.

Хэн ч байсан орж дээ. Ор, ор хэмээн уцаарлан хашгирав.

Хаалга онгойж, миний бие урьд хожимд үзээгүй гайхмаар сонин хүн орж ирлээ. Бие бялдар, хөдөлгөөнийг нь харвал, залуухан эр атал царай зүсийг нь харвал Бэттререж гайн дэргэд хавьгүй хөгшин ажээ. Цыган шиг бараан урай, хонхойсон эцэнхий хацар, ёрдойсон төвгөр шанаатай, дорно дахитны эртний ард түмний дунд элбэг тохиолддог, өрнө зүгийн шинэхэн овог аймгийн дотор тун ховор тааралддаг гоёмсог хэлбэр бүхий хамартай эр байв. өндөр, том духтай, түмэн үрчлээс болсон нүүртэй аж. Энэхүү хачин царай дээр гуниг тодорсон бодлогшронгуй, зөөлөн харцтай хүнхэр бор нүд нь бүр ч хачин бөгөөд тэр сонин нүд таныг ширтэн, хүсэл зоргоороо таны (наад зах нь эмайг л тэгсэн юм) хамаг анхаарлыг татах бөлгөө. үүн дээр нэмж хэлэхэд, байгаль эхийн адтай хүслээр тэр хүний өтгөн үс туйлын гайхалтай, сонин маягаар өнгөө өлджээ. Зулайн үс нь төрөлхийн тас хар өнгөтэй атал хоср талаар нь шууд дун цагаан үс залгажээ. үс нь алаг цоог сааралтан зугуухан цайсан бол тэгтэл эрс тэс өнгө ялгарахгүйсэн. Хар, цагаан үс жигд зааглагдаагүй, зарим газраа нэг рүүгээ түрж орсон байна. Би тэр хүнийг сониуч зангаа огт барьж чадалгүй ширтэж байснаа хэлэхэд ичмээр. Түнийг өөрийн эрхгүй тийнхүү бүдүүлгээр алмайран ширтэж буйд минь уучлал эрэх мэт надаас тэгж уучлал гуйх хэрэгцээ огт байхгүй байхад зөөлөн бор нүдээрээ миний өөдөөс элэгсэг харах ажээ.

өршөөгөөрэй, би Бэттереж гуайг ажилтай байсныг мэдсэнгүй л дээ гэж хэлээд халааснаасаа цаас гаргаж Бэттереж гуайд өгөөд –Ирэх долоо хоногийн нэрс гэхихээд намайг дахин нэг харц тогтоон ажиглаад орж ирсэн шигээ чимээгүйхэн гарч одов.

Энэ юун хүн бэ? Гэж би асуулаа.

Мистер Кандийн туслагч. Дашрамд хэлэхэд манай палдгар доктор нөгөө төрсөн өдрийн үдэшлэгээс харих замдаа өвдчихөөд одоо хүртэл олигтой эдгэрээгүй байгаа гэдгийг дуулаад мистер Фрэнклин та лав харамсах биз. Бие нь эрүүл саруул боловч халуурч дэмийрээд ухаан алдаж, ер сайжрахгүй байгаа юм. Тэгэхээр хамаг ажил нь туслагчийн нуруун дээр буусан даа. Хүн бараг үзүүлэхээ болиод ядуус л очдог болсон. Тэдэнд шилж сонгох бэл байх биш. Тэд ямар ч атугай, тарлан үстэй, цыган шиг царайтай хүнд үзүүлэхээс өөр аргагүй болжээ эс тэгвэл, өөр эмч олдохгүй шүү дээ.

Бэттереж гуай, та энэ хүнд нэг их сайнгүй юм аа?

Хэн ч сайн биш, эрхэм ээ.

цагаад тийм нэр хүндгүй байдаг юм бэ?

Нэгдүгээрт, гадаад төрх нь хүний дургүй хүргэдэг юм. Хоёрдугаарт, мистер Канди их л эргэлзээтэй хүнийг авч туслагчаараа ажиллуулсан юм. Түүнийг чухам ямар хүн гэдгийг хэн ч мэдэхгүй, энд ер найз нөхөргүй, зожиг суудаг. Тэгэхээр ийм хүнд хүмүүс сайн байна гэж үү?

Мэдээж хэрэг, огч үгүй! Танд тэр цаасыг яах гэж өгснийг мэдэж болох уу?

Жаахан дарс уулгах шаардлагатай байгаа энэ хавийн өвчтэй улсын нэрсийн жагсаалт ядуу өвчтөнгүүдэд сайн дарс тогтмол өгдөг байсан, мисс Рэчел бас энэ хэргийг нь үргэлжлүүлэхийг хүссэн юм. Цаг өөр болж дээ, болж! Канди гуай өөрөө ирж манай эзэгтэйд нэрсийн жагсаалт өгдөг байж билээ. Одоо харин мистер Кандийн туслагч ирж, надад өгдөг болжээ. Эрхэм ээ, та зөвшөөрвөл нөгөө захиагаа цааш нь уншъя гэж Бэттереж гуай хэлээд Розанна Спирманы наминчлалыг ойртуулав.

Уншихад сонирхолгүй боловч өнгөрснийг дурсаж, гунигт автахаас ангижруулах юм даа гээд нүдний шилээ зүүж царайгаа барайлган толгой сэгсэрч, мистер Фрэнклин минь бид ертөнцөд мэндлээд гаргадаг авирт зөв тал байгаа юм. Бидний хэн маань ч ертөнцөд мэндлэхдээ их бага хэмжээгээр дургүйцэн эсэргүүцдэг. Энэ ч үнэхээр бидний зөв юм даа гэлээ.

Мистер Кандийн туслагч надад даанч гүн сэтгэгдэл төрүүлсэн учраас би түүнийг толгойноосоо тэр даруй үлдэн хөөж чадсангүй. Бэттереж гуайн гүн ухааны мэргэн үгийг назааралгүй өнгөрөөж нөгөө тарлан үст эрийн тухай сэдэвт эргэн орж.

Тэр хүнийг хэн гэдэг юм бэ? Гэж асуув.

Тийм муухай нэр хайгаад ч олдохгүй биз. Эзра Женнингс гэдэг юм хэмээн Бэттереж гуай уцаарлав.

## V бүлэг

Мистер кандийн туслагчийн нэрийг хэлчихээд ашиггүй юманд хангалттай цаг дэмий хүрлээ гэж Бэттереж гуай бодов бололтой, Розанна Спирманы захиаг цааш нь уншиж эхлэв.

Би уншиж дуусахыг нь хүлээж цонхны наана суув. Эзра Женнингсийн надад төрүүлсэн сэтгэгдэл яваандаа арилж эхлэв. ер миний адил байдалд орсон хүнд аливаа хүн тэгтэл нөлөөлнө гэдэг огт утгагүй мэт санагдах бус уу! Миний санаа бодол хэвийн янзандаа орлоо. Би ямар бүтэлгүй явдалд орооцолдсоноо дахин нэг шийдмэгхэн эргэцүүлж үзэхийг өөртөө шаардав. Цаашид хэрхэхээр төлөвлөснөө дахин нэг тунгааж үзлээ.

Тэр өдөртөө Лондонд буцаж очих, мистер Браффт бүхий л хэрэг байдлыг танилцуулах, мөн эцсийн бөгөөд хамгийн чухал асуудал бол ямар ч аргаар, яаж ч хохирсон хамаагүй, Рэчелтэй биечлэн уулзах зөвшөөрөл олохоор төлөвлөсөн бөгөөд тэр үед миний бие чадлын хэрээр л зохиосон төлөвлөгөө минь тэр байв. Галт тэрэг хөдлөхөд цаг гаруйхан хугацаа үлджээ. Алмаз алдагдсан байшингаас мордохын өмнө Розанна Спирманы захианы уншаагүй хэсгээс Бэттереж гуай надад хэрэг болох зүйл олно гэдэг найдлага ч бага үлджээ. Ингээд л захиаг уншиж дуусахыг нь хүлээхээр шийдэв.

Захианы үргэлжлэлийг сийрүүлбэл:

“Мистер Фрэнклин, таны амьдралын бүх л хэтийн төлөв миний гарт орсныг мэдээд намайг баахан ялан дийлсэн сэтгэл эзэмдэж байсан ч гэсэн та уурлах хэрэггүй. Гэвч дахиад л сэтгэл зовж, айж эхэлсэн юм. Түүрүүч Кафф алмаз алдагдсан хэргийг хэрхэн үзэж буйг харвал бидний цагаан хэрэгсэл, хувцас хунарыг шалгах төлөвтөйд эргэлзэх аргагүй байв. Түүний хараанаас мултрах газар миний өрөөнд ч , ер бүхэл байшинд байхгүй мэт санагдав. Таны унтлагын цамцыг түрүүчид олдохооргүйгээр хэрхэн нуух билээ? үнэт цагаас ганц ч хором алдалгүй хэрхэн амжуулах вэ? Энэ бол шийдэхэд нэлээд төвөгтэй асуудал байв. Би учраа олохгүй тэвдсэнээ, эцэстээ эг арга сэдсэн маань лав таны инээдийг хүргэх буй заа. Би хувцсаа тайлж, таны унтлагын цамцыг өмсөн хэсэг зууртаа жаргалыг амссан билээ.

Дараа нь зарц нарын өрөөнд ороод би таны цамцыг цагаа олж өмссөнөө ойлгосон юм, юу гэвэл түрүүч Кафф угаалгын дэвтэр үзэхийг хүсчээ.

Би дэвтрийг олж, хатагтайн зочны өрөөнд, эрүүлч Каффт аваачиж өгөв. Эрүүлч бид хоёр урьд нэг биш удаа учирч явсан юм. Эрүүлч Кафф намайг танина гэдгийг би лавтай мэдэж байсан бөгөөд харин үнэт чулуу ладагдсан айлд зарцдагдаж буйг минь үзээд надад яаж хандахыг нь төсөөлөх ч үгүй байлаа. Ийм учраас уулзаж, адгийн мууг даруйхан мэдвэл сэтгэл хөнгөрөх байлаа.

Угаалгын дэвтрийг өгөхөд эрүүлч намайг огт танихгүй хүн мэтээр хараад онцгой их эшлдгээр талархав. Аль алиныг нь би муу ёр гэж бодлоо. Намайг гарсны дараа миний тухай юу хэлэхийг ч, намайг сэжиглэж хэдийд баривчлан авч нэгжихийг ч мэдэхгүй байлаа. Тэр үед та мистер Годфри Эблвайтыг төмөр замын буудал дээр гаргаж өгчихөөд ирэх цаг ойртсон байв. Би тантай ярилцах бас нэг, эцсийн ч байж болзошгүй оролдлого хийсүгэй хэмээн таны зугаалах дуртай бут сөөгөнд очоод хүлээв. Гэтэл та ирсэнгүй, гай болоход Бэттереж гуай, түрүүч Кафф хоёр миний нуугдсан газрын хажуугаар өнгөрөхдөө эрүүлч намайг харчихав.

Тэгэхээр дахиад л гай зовлон учраагүй дээр ажлын байр руугаа буцаж очихоос өөр зам надад үлдсэнгүй. Намайг яг зам гартал та төмөр змаас эргэж ирсэн юм. Та бут руу шууд алхсанаа намайг хараад, эрхэм ээ та намайг харсан гэдэгт би баттай итгэж байна. Тахал туссан хүн үзсэн мэтээр цааг эргэн байшин руу яюсан билээ.

Би байшинд зарц нарын ордог арын хаалгаар орлоо. Тэр үеэр угаалгын газар нэг ч хүнгүй байсан бөгөөд би ганцаараа тэнд үлдэв. Нуранги элс надад юу бодогдуулдаг тухай би танд дээр нэгэнт өгүүлсэн билээ. Одоо тэр бодол дхиадл сэргэв. Хэрэг явдал иймэрхүү янзтай үргэлжлэх юм бол, Фрэнклин Блэйкийн тоомсоргүй харьцааг тэвчих, эсвэл нуранги элсэнд үсэрч ороод энэ бүхнийг цэглэх хоёрын чухам аль нь бэрх болохыг би мэдэхгүй байлаа.

Тэр үед миний бие ямаршуу янзтай байсныг асуугаад ч ашиггүй. Би хэчнээн чармайгаад өөрөө ч ойлгож чадахгүй байна.

Та надаас тийнхүү хэрцгийгээр нүүр буруулахад би яагаад зогсоосонгүй вэ? цагаад би, “мистер Фрэнклин ээ! Танд хэлэх юм байна. Танд хамаатайучраас та соносох ёстой, соносох ууй гэж хашгирсангүй вэ? Та бол миний эрхэнд, таны хувь заяа миний гарт гэгчээр байсан юм. Түүгээр ч зогсохгүй таныг өөртөө итгүүлж чаддаг юм бол таны ирээдүйд ашиг болох юм надад байлаа. Тань шиг эрхэм, тийм үнэ цэнэтэй алмазыг зөвхөн наргиан болгон хулгайлсан гэж санаагүй минь мэдээж хэрэг. үгүй. Таны үрэлгэн зан, өр ширийн тухай мисс Рэчелийн ярьсныг Пенилоп, Бэттереж гуайн өгүүлэхийг би сонссон юм. Та алмазыг дарах буюу барьцаанд өгч хэрэгцээтэй мөнгөө олж авах санаатай байсан чинь надад илэрхий байв. Тэр эрдэнийн чулуунд элдвийг асууж шалгаалгүй их үнэ урьдчилан өгч чадах Лондонд суудаг нэг хүнийг би танд хэлж өгч чадах байсан л даа.

Би тантай юунд харилцсангүй вэ! Юунд ярилцсангүй вэ!

Таны унтлагын цамцыг өөр бас бус төвөг, бэрхшээл тарилгүйгээр аргалаад нууж би чадах байв ээ? Бусад эмэгтэйчүүдэд нэлээд ярвигтай л байх, гэвч миний хувьд юу шалих вэ дээ. Урьд би хулгайч байхдаа үүнэс хавьгүй осолтой аюулаас тавь, жаран удаа мултарч яусан болохоор энэ бол алга урвуулахдаа адил хялбар байлаа. Би есөн шидийн заль мэх арга булхай (та ингэж хэлнэ байх лдаа) үйлдэж сурсан бөгөөд зарим нь бүр сонинд хүртэл нийтлэгдсэн их гарын ухаалаг мэх байсан юм. Унтлагын цамц нуух үзэргийн ийм шалихгүй зүйл намайг тантай ярилцах ёстой үед миний зоригийг мохоож, зүрхийг үхүүлнэ гэж үү? Ийм юм асуудаг юутай мунхаг вэ! Ийм юм байш болзошгүй.

өөрийнхөө учир утгагүй бодлыг ийнхүү дэлгэрэнгүй өгүүлээд ямар ашиг байна? Илэрхий үнэн хангалттай тодорхой байсан бус уу? таныг би дотроо хамагзүрх сэтгэлээрээ хайрладаг байлаа. Харин тантай нүүр тулахаараа танаас айж сүрддэг байснаа үгүйсгэх аргагүй. Надад уурлах вий гэж айдагбайлаа. Та хэдийгээр алмазыг авчихсан боловч би олж мэдсэнээ цухуйлгаж зүрхэлбэл надад юу хэлэх бол гэхээс айж байлаа. Таныг номын санд байхад би овоо зүрхлэн яриа өдсөн билээ. Тэгэхэд та надаас нүүх буруулалгүй, халдварт тахлаар өвдсөн хүнээс дайжих мэт зугтаж зайлаагүй. Би танд уурлаж, дургүйцэх сэтгэлийг дэврээх замаар биеэ зоригжуулах гэж оролдлоо. Гэтэл уй гуниг, зовуур бухимдлаас өөр юу ч болсонгүй. “Чи бол царай муутай, далиу мөртэй бүсгүй, зөвхөн шивэгчин байэ надтай ярилцах гэж оролддог чинь ямар учиртай юм бэ?” гэж та хэлээгүй ч гэсэн таны байдал үргэлж үүнийг өгүүдэг байлаа! Ер иймэрхүү солиорлыг тайлбарлах хэрэг байна уу? үгүй ээ, наминчилж үнэнээ хэлэхээс өөр яах ч аргагүй.

Есөн шидийн дэмий юм сараачсандаа дахин уучлал гуйя. Дахиад ингэнэ гэж иайсны хэрэггүй. Үүгээр цэглэе.

Намайг угаалгын өрөөнд ганцаархнаа сууж байтал Пенилоп орж ирлээ. Миний сэтгэлийн нууцыг хэдийн гадарлачихаад намайг ухааруулах санаатай эвтэйхэн оролддог байсан юм.

“Өө! Чамайг энд яагаад ганцаархнаа энэлж суугааг би мэдэж байна. Мистер Фрэнклин айлчлалаа дуусгавал чамд их л сайн болохсон доо. Удалгүй явна байх шүү гэж Пенилоп хэлэв.

Би таныг хэзээ нэгэн цагт эндээс явна гэж огтхон ч боддоггүй байжээ. Би Пшцилопт хариу өгчих тэнхэлгүй, өөдөөс нь дуугүй л ширтлээ.

Пенилоп үргэлжлүүлэн:

Би дөнгөж сая мисс Рэчел дээрээс ирлээ. Олон зангаас нь болж би ч зэгсэн зовж байна даа. Гэрт нь цагдаа байхад тэсэж сууж чадашгүй гэнэ. өнөө орой хатагтай ярилцаад маргааш Эблвайт нагац эгчийндээ очихоор шийдсэн. Тэгвэл ч мистер Фрэнклин бас явах шалтгаан олох нь лавтай, үнэн шүү!

үүнийг сонсоод би үг хэлэх сөхөөтэй болж,

Мистер Фрэнклин хамт явна гэсэн үг үү? Гэж асуулаа.

Мисс Рэчел зөвшөөрвөл ч хачин дуртай явах байлгүй. Гэвч зөвшөөрөхгүй л дээ. Мистер Фрэнклинд бас муухайн загнаж байгаа юм. Мисс Рэчелд туслах санаатай чадлаараа зүтгэж байхад нь л нүүр өгөхийг больсон, хөөрхий амьтан! Үгүй, үгүй! Тэд өнөөдөр л эвлэрэхгүй юм бол маргааш мисс Рэчел нэг тийшээ, мистер Фрэнклин нөгөө тийшээ явах бий, хараарай мистер Фрэнклин чухам хаачихыг бүү мэд. Гэвч мисс Рэчелийг явчихвал энд үлдэнэ гэж ярихгүй дээ, Розанна минь.

Таныг явна гэдгийг дуулаад гутарч гонсойсон сэтгэлээ би нууж дөнгөсөн билээ. үнэнийг хэлэхэд мисс Рэчел та хоёр үнэхээр ноцтой зөрөлдсөн юм болов уу гэсэн өчүүхэн найдлага надад төрсөн юм.

Тэд яагаад хэрэлдсэнийг та мэдэх үү?

Бүгд л мисс Рэчелээс болж байгаа юм. Мисс Рэчелийн муухай аашилснаас өөр юу ч үгүй гэдгийг би сайн мэдэж байна. Розанна, чиний урмыг хугалахад надад эвгүй байгаа боловч, мистер

Фрэнклин мисс Рэчелтэй хэрэлдэнэ гэж сэтгэлээ зовоох хэрэггүй мистер Фрэнклин мисс Рэчелд дэндүү хайртай болохоор хэрэлдэж чадахгүй л дээ!

Пенилоп эдгээр чихэнд чимэггүй үгээ дөнгөж хэлж дуустал Бэттереж гуай биднийг дуудуулсан байв. гэр дотор ажилладаг бүх зарц, шивэгчнийг танимд цуглуулж байгаа юмсанж. Дараа нь биднийг Бэттереж гуайн өрөөнд нэг нэгээр нь оруулан түрүүч Кафф байцаасан юм.

Ахайн шивэгчин, гэрийн ахлах зарц авгайн дараа миний ээлж болов. Эрүүлч Кафф хэдийгээр байцаалтаа тун овжин хаацайлж чадсан боловч тэр хоёр авгай (миний заналт дайснууд даа) пүрэв гаригийн өглөө, орой хоёр миний өрөөний үүдний гаднаас намайг танджээ гэдгийг би ойлгосон юм. Тэр түрүүчид хагас хугас үнэнийг илрүүлэхэд тус болох зүйл мэдэгдсэн ажээ эрүүлч намайг унтлагын шинэ цамц нууцаар оёсныг мэдсэн боловч будаг хүрсэн цамцыг минийх байсан хэмээн эндүүрчээ. Гүйцэд сайн ухаараагүй авч би түүний үгнээс бас нэг зүйлийг мэдэж авсан юм. Алмаз алга болсон хэрэгт намайг сэрдсэн нь мэдээж. Тэгсэн атлаа эрлэнийн чулууг чухам толгой дааж авсан хүн гэж үзэхгүй байлаа. үүнийгээ надад зориуд ойлгуулах шиг болсон. Намайг өөр нэг хүний захирамжаар л ажилласан гэж бодсон бололтой. Тэр өөр хүн нь хэн байж болохыг би тэгэхэд ч, тааварлаагүй, одоо ч чадахгүй.

Энэ учир битүүлэг нөхцөлийн зэрэгцээ түрүүч кафф хамаг үнэнийг мэдэх яагаа чгүй юм байна гэдэг ганц зүйл л мадаггүй тодорхой байлаа. Таны унтлагын цамц илрээгүй цагт л та эсэн мэнд яваа аж.

Одоо намайг эзэмдсэн уй гашуу, шаналгааг танд ойлгуулна гэж горьдолтгүй л дээ. Таны унтлагын цамцыг цаашид өмсөж, аз сорих ямар ч бололцоогүй болов. Намайг сэрдсэн тул Фризинхоллын цагдаагийн хэсэг рүү юү юүгүй авч яваад нэгжиж болзошгүй байлаа. Түрүүч Кафф намайг чөлөөтэй орхиж байгаа дээр нь унтлагын цамцыг устгах уу, эсвэл найдвартай газар байшингаас хохон нуух уу гэдгээ нэн даруй шийдэх ёстой болов.

Хэрэв та намайг хумсын чинээ ч гэсэн хайрлаж байсан бол би тэр цамцыг устгах байсан биз гэж бодном. Гэвч таныг илрэхээс аварсан гэдгээ баталж өгөх цорын ганц зүйлийг устгаж болно гэж үү? Хаанаас даа! Хэрэв та бид хоёр учраа ололцлоо гэж бодоход та намайг хардаж, мэлзлээ гэхэд унтлагын цамц шинээр оёснсс үзүүлэлгүйгээр би таныг өөртөө хэрхэн үнэмшүүлж чадах билээ? Таныг гэмт хэрэгт түлхэн, мөнгөний гачигдлын улмаас үйлдсэн хулгайд над мэтийн золгүй бүсгүйг хамсаатнаа болгон, нууцаа хуваалцахаас та түдгэлзэж мэдэх учраас таны итгэлийг олох гэж оролдсон, мөн оролдожбайгаа минь буруу гэж үү? Эрхэм ээ, та надтай хачин хүйтэн хөндий харьцаж байснаа санагтун. Тэгвэл надад аз жаргал хайрлах таны итгэл, талархлыг олж авах цорын ганц нотолгоог устгахыг хүсээгүйг минь та төдий л гайхахгүй буй заа.

Эцэст нь би таны унтлагын цамцыг нууя хэмээн сэтгэл шулуудсан бөгөөд арван хуруу шигээ сайн мэддэг газрыг буюу нуранги элсийг сонгон авсан билээ.

Байцаалт дуусмагц би хамгийн түрүүнд толгойд орсон шалтаг хэлж, цэвэр агаарт гарья гэж гуйлаа. Тэгээд Коббс Холл руу Ёолланд гуайнх руу шууд явсан юм. Түүний авгай, охин хоёр миний сайн найзууд билээ. Тэдэнд таны нууцыг хэлсэн гэж бүү бодоорой, би хэнд ч итгэдэггүй. Би танд энэ захиаг бичих, мөн унтлагын цамцыг биеэсээ слгах найдвартай арга хайх л гэсэн юм. Намайг хэрэгт сэжиглэж байсан тул би энэ бүхнийг хатагтйнд амар тайван гүйцэтгэж чадахгүй байлаа.

Одоо би энэхүү урт захидлаа Люса Ёолландын өрөөнд ганцаархнаа суугаад бичиж, дуусах дөхөж байна. Дуусгачихаад таны унтлагын цамцыг эвхэж, хуйлаад цуван дотроо нууж доошоо бууна. Түүнийг хэвээр нь, хуурай хадгалчих савыг би Ёолланд авгайн гал зуухны өрөөний новшноос олно. Дараа нь нуранги элс рүү очно. Миний хөлийн мр намайг илчилнэ гэж бүү ай! Тэгээд таны унтлагын хувцсыг би л өөрөө хэлдэггүй юм бол нэг ч амьд амьтан олж чадахааргүй газар нууна.

Тэгээд дараа нь үүний дараа яах вэ?

Дараа нь мистер Фрэнклин танд өдий хүртэл хэлж зүрхлээгүй үгээ хэлэх гэж дахиад оролдох хоёр шалтгаан байгаа юм. Пенилопын бодсончлон та үнэхээр явж, би ярьж амжихгүй бол энэ боломж бүрмөсөн өнгөрөх нь тэр. Энэ бол нэг шалтгаан юм. Мөн хэрэв миний хэлсэн үгэнд та эгдүүцэж уурлах юм бол унилагын цамц таныг юунаас ч илүү зөөлрүүлж чадна хэмээн найдаж сэтгэлээ зогоож ббайна. Энэ бол хоёр дахь шалтгаан юм. Хэрэв энэ хоёр шалтгаан өдий хүртэл намайг тамлан зовоож байсан таны хүйтэн цэвдэг харьцааг тэсэн зогсох хүчийг надад олгож чадахгүй бол миний хамаг чармайлт дуусаж, амьдрал минь төгсөх болно.

Тийм ээ. Хэрэв би одоо гарах боломжийг ашиглаж чадахгүй бол та надтай мөн л ширүүн догшин харьцаж, урьдын адил сэтгэл минь шаналж эмзэглэх юм бол өрөөл бусдад аз жаргал заяасан атлаа надаас харамласан энэ хорвоогоос хагацна. Таны ялдам зангаас өөр юу ч сэтгэл үл баясгахаа өнгөрсөн амьдралаас хагацна. Эрхэм ээ, хэрэв үнэхээр ингэж дуусгавал та өөрийгөө бүү зэмлээрэй. Гэвч намайг өчүүхэн боловч өрөвдөхийг бодоорой! Таны төлөө юу хийснээ өөрөө өгүүлж чадахгүй гэхнээ танд заавал мэдэгдэх талаар би санаа тавина. Тэр цагт та мисс Рэчелтэй ярьдаг шигээ

ялдамхан өнгөөр миний тухай аятайхан үг дуугарах болов уу? Тэгвэл, сүнс гэж үнэхээр байдагсан бол миний сүнс таны хэлэх элэгсэг үгийг сонсоод баярлах буйзаа хэмээн би итгэнэм.

Захиагаа дуусгая даа. Би одоо уйлж хайлан байна. Хэрэв дэмий л асгарсан нүд бүрхэх нулимсаа зоргоор нь тавтбал нууц газар хүрэх замыг хэрхэн олж гарах билээ?

Түүнээс газна, яагаад юмыг заавал муу талаас нь харна вэ? Эцсийн бүлэгт энэ бүхэн сайнаар төгсөнө гэдэгт яагаад итгэж болдоггүй юм бэ? Таныг өнөө орой биш гэхэд маргааш өглөө сайхан зантай байхад уулзаж болно шүү дээ. Миний муухай царай уй гунигаас болоод дээрдэхгүй нь мэдээж. Би энэ урт захиаг өчнөөн олон цаасан дээр шал дэмий эрээчиж байгаа ч юм билүү, хэн мэдэх вэ дээ? Болгоомжлохын үүднээс (бас нэг шалтгааны энд дурсахаа больё) энэ захиагаа унтлагын цамцны хамт нуух болно. Энэ захиаг танд бичихэд юутай бэрх байв аа! Ай, та бид хоёр эцэстээ бие биеэ ойлгох юм бол би үүнийг хэчнээн дуртай урж хаяхсан!

Эрхэм таныг чин сэтгэлээсээ хайрладаг, таны хүлцэнгүй зарц

Розанна Спирман”

Бэттереж гуай захиаг чимээгүйхэн уншиж дуусгаад дугтуйд нь болгоомжтой буцаан хийж, толгой гудайлган газар ширтэн бодлогошрон суулаа.

Бэттереж гуай захианы сүүл рүү надад тус болчихоор юм гарав уу? гэж би сонирхлоо.

өвгөн алгуурхан дээш харж, сүүрс алдаад,

Мистер Фрэнклин танд тус болох юу ч гарсангүй. Та одоогийн ажил хэргээ дуусгахаас нааш энэ захиаг дугтуйнаас нь гаргах хэрэггүй гэж зөвлөмөөр байна. Хэдийд ч уншсан та их л гутрах юм байна даа. Одоо битгий уншаарай гэж хариулсан юм.

Би захиаг авч халаасандаа хийв. Бэттереж гуайн хүүрнэлийн арван зургаа, арван долдугаар бүлгийг эргэн сөхвөл, миний сэтгэлийн хүч нэгэнт хэрцгий сорилтыг амсаж ббайсан тэр үед биедээ тийнхүү яршиг удахгүй гэсэн шалтгаан надад үнэхээр байсныг та үзэх болно. Хөөрхий золгүй бүсгүй надтай ярилцах гэж хоёр удаа, эцсийн оролдлогоо хийжээ. Тэгээд гай болоход хоёуланд нь би түүнийг өөрөөсөө огт гэнэгүй (“тэнгэр мэднэ!”) түлхжээ. Баасан гаригийн орой Бэттереж гуайн өгүүлсэнчлэн намайг бильярдын өрөөнд ганцаараа байхад РОзанна Спирман орж ирсэн юм. Түүний шинж төрх, үг яриа нь алмаз алга болсонд гэмтэй гэдгээ наманчлах нь уу гэж надад санагдсан билээ. Ер над шиг байдалд орсон ямар ч эр тэгж санах буй заа. Би тэр бүсгүйн тусын тулд л юу болсныг огт сонирхоогүй дүр зориуд үзүүлсэн юм. Мөн түүний тусын тулд л өөдөөс нь харахын оронд бильярдын бөмбөгийг харсан юм. Гэтэл ямар үр дүнд хүрэв? Түүний зүрхийг эмзэглүүлэн шархдуулаад хөөж явуулжээ.! Пенилопоос миний явах цаг хаяанд ирснийг мэдсэн байж таарах бямбаа гаригт бас бүтэлгүйтжээ. Надтай бутат зөрөг дээр уулзах санаатай оролдоход нь би Бэттереж гуай, түрүүч Кафф хоёртой цуг байжээ. Трүүч цаанаа нэгийг бодож, Розанна Спирманыг сонирхдог эсэхийг надаас зориуд чанга дуугаар асуухад нь би мөн л хөөрхий бүсгүйн тусын тулд, цагдаагийн даргын бодлыг эрс няцаахаар шийдээд “Розанна Спирманыг огтхон ч сонирхдоггүй” гэж түүнд сонсдож таарахаар чанга дуугаар мэдэгдсэн юм. Надад аминчлан ярих гэж дахин оролдсоны хэрэггүй гэдгийг л сануулах гэж хэлсэн миний энэ үгийг сонсоод бүёсгүй нуугдаж байсан газраасаа холджээ. Харин одоо мэдэхнээ биеэ хороохор одсон байжээ. үүнээс хойш юу болсныг сордог элсэнд хэрдхийн зүйл илрүүлэхээс өмнөх явдлыг би дээр нэгэнт өгүүлсэн билээ. өнгөрсөн явдлыг одоо бүгдийг гээлгүй дурсав. Энд зориуд дуугүй орхисон бүгдийг аяндаа хэлээд өгнө гээд Розанна Спирманы золгүй (одоо ч эргэн санахад зүрх шимширдэг юм) явдлыг орхиж болох юм. Нуранги элс дээр амь асаа бүрэлгэсэн явдлаас эхлэн, мөн тэр явдал миний одоогийн байдал, ирээдүйн төлөвт хэчнээн аймшигтай, хачин нөлөөлснийг, эл хүүрнэлд гарч буй амьд хүмүүсийн ашиг сонирхол, харанхуйгаас гэрэлд гарах урт бөгөөд зүдэргээтэй зам тавихад минь тус болсон үйл явдлуудыг хүртэлх хэсгийг дуугүй өнгөрч болох юм.

## VI бүлэг

Төмөр замын буудал руу би явган алхсан ба Габриэл Бэттереж надад хань болсныг хэлэх юун. Тэр оройдоо мистер Браффт амжиж үзүүлье хэмээн захиаг халаасандаа, унтлагын цамцыг аяны цүнхэндээ хийв.

Бид байшингаас дуу шуугүй гарлаа. Бэттереж өвгөн миний хажууд ийнхүү амаа таглуулсан мэт хэлэх үггүй явж байхыг нь би түүнийг мэддэг болсоор анх удаа л харав. Харин надад хэлэх юм байсан учраас цэцэрлэгийн хаалгаар гармагцаа яриа өдөж,

Лондон явахын өмнө танаас хоёр зүйл асууя. Надад хамаарах бөгөөд та яггүй гайхах биз ээ гэв.

Хөөрхий талийгаачийн захиаг миний толгойноос зайлуулж л чадах юм бол мистер Фрэнзлин минь ямар ч хамаа байх вэ. Алив, намайг шалавхан гайхуулаад орхиоч,

Бэттереж гуай, эхний асуулт ийм байна. Рэчелийн төрсөн өдрийн баярын орой би согтсон уу,

Та юу? Хэмээн өвгөн дуу алдаад, -та зөвхөн үдийн хоолон дээрээ уугаад дараа нь нэг ч балга амсдаггүй. Энэ чинь л их ноцтой дутагдал шүү! гэв.

Гэвч төрсөн өдөр онцгой үйл явдал шүү дээ.

Тэр орой би зуршлаа зөрчсөн эрхэм ээ. цаж зөрчсөнийг би одоо хэлье. Та хачин зовууртай харагдсан болохоор таныг жаахан сэргээх гэж хэдэн дусал шарзтай ус уулгах гэсэн юм.

Би устай шарз ерөөсөө уудаггүй. Тэгэхээр магадгүй...

Азнаарай мистер Фрэнклин. Таны уудаггүйг би бас мэднэ. Манай тавин жил дарсан хуучин шарзнаас шилэн аяганы дундуур хийгээд, тэр сайхан ундаагаа (ичмээр шившгийн вм!) бүтэн аяга хүйтэн устай найруулсан билээ. Түүнийг уугаад нас гүйцсэн эр битгий хэл хүүхэд ч согтохгүй!

Иймэрхүү хэрэгт Бэттереж гуайн ой ухаанд найдаж бүрэн болохыг би мэдэж байна. Тиймээс би согтож мансуурсан гэх үндэсгүй ажээ. Би хоёр дахь асуудалдаа оров.

Бэттереж гуай намайг гадаадад явуулахаас өмнө, бага байх үеийг маань та сайн мэднэ шүү дээ. Би шөнө нойрондоо элдэв хачин зан гаргадаг байсныг санаж байна уу, та шулуухан хэлээрэй. Зүүдэндээ явж байсныг та ер нь харсан уу?

Бэттереж гуай зогтусан намайг хэсэг ширтсэнээ, толгой сэжээд цаашаа алхав.

Мистер Фрэнклин би одоо л таны санааг ойлголоо! Та өөрөө мэдэлгүй унтлагын цамцаа хэрхэн будаг болгосны учрыг олох гэж оролдож байнаа даа. Бүтэхгүй, эрхэм ээ. Та үнэнээс хэдэн бээр хол байна. Зүүдэндээ явдаг уу гэнэ ээ? Та насандаа ч тэгж байгаагүй! Хэмээн Бэттереж гуай хариу өгүүллээ.

Бэттерейн зөв гэдгийг би дахиад ойлгов. Нутагтаа ч, харийн газарт ч би зожиг ганцаараа сууж байгаагүй. Хэрэв би зүүдэндэ унтаагаараа явдаг байсан бол хэдэн зуун танил маань ажиглаж мэдээд миний тусын тулд эл муу зуршлаас ангижруулах талаар надад сануулж санаа тавихсан.

Энэ бүхнийг зөвшөөрсөн хэдий боловч, тэр үед миний орсон аюумшигт байдлbn учрыг тайлахад дөхөм болох хоёр тайлбараас би үхэн хатан зууралдаж байсан бөгөөд энэ ч уучлуштай, зүй ёсны хэрэг билээ. өгсөн хариунд нь сэтгэл дундуур байгааг минт ажиглаад Бэттереж гуай Саран чулууны хэргийн сүүлчийн явдлыг сануулж, миний горьдлогыг дор нь бүрмөсөн хийсгэж орхисон юм.

Эрхэм ээ, өөр маягаар нэг үзье. Таны саналыг зөв гэж бодоод үнэнийг илрүүлэхэд хэрхэн тус болохыг нь харъя л даа. Унтлагын цамцыг ганц нотолгоо гэвэл (би үүнд огт итгэхгүй байна), та цамцаа өөрөө мэдэлгүй будаг болгосноор үл барам очир алмазыг ч бас өөрийн ухаангүй авчээ. Зөв үү?

цг зөв. Цааш нь ярь даа.

Маш сайн, эрхэм ээ. Та тэр эрдэнийн чулууг согтуудаа, эсвэл зүүдэндээ унтаагаараа яваад авсан гэж бодъё. Энэ бол төрсөн өдөр тэмдэглэсэн шөнө болсныг хэлээд өгч байна. Гэтэл түүнээс хойно болсон явдлыг үүгээр хэрхэн тайлбарлах вэ? Алмазыг Лодндонд хожим аваачсан байсан. Тэгээд мистер Люкерт барьцаанд өгчээ. Энэ хоёр зүйлийг та бас л өөрийн ухаангүй явж үйлдсэн гэж үү? Хөнгөн сүүх тэргэнд суугаад мордоход чинь би гаргаж өгсөн тэр бямба гаригийн үдэш та согтуу ббайсан гэж үү? Та галт тэрэгнээс бууж, мистер Люкерийн рүү унтаагаараа явсан гэж үү? Мистер Фрэнзлин намайг уучлаарай, үнэндээ хэрэг явдал таныг бүр хямруулж орхисон учраас та олигтой тунгааж бодох ч сөхөөгүй болжээ. Та мистер Браффтай хэдийчинээ түргэн уулзаж зөвлөвөл, энэ мухардлаас төдийчинээ хурдан гарна даа.

Бид хоёр галт тэрэг хөдлөхөөс ганц, хоёрхон минутын өмнө буудал дээр очлоо.

Хэрэгцээ гарвал захиа бичиг хэмээн би Бэттереж гуайд Лондонгийн хаягаа яарч тэвдэн өгөнгөө шинэ сонин зүйл гарвал мэдэгдэнэ хэмээн ам өгсөн юм. Тэгчихээд Бэттереж гуайтай салах ёс гүйцэтгэж байхдаа ном, сонины мухлагийн зүг санаандгүй хартал мистер Кандийн хачин туслагч, мухлагийн эзэнтэй ярилцан зогсож байлаа! Бидний харц ч тулгарав. Эзра Женнингс малгайгаа сөхөхөд нь би хариу мэндэлсэн бөгөөд галт тэрэг ч хөдөлж, би ч оров. Надад огт падгүй зүйл бодоход сэтгэлд хөнгөн байсан биз ээ. цмар ч атугай, би тийм чухал хэргээр мистер Браффыг зохин хөдлөхдөө юуны түрүүнд тарлан халимаг бүхий сонин хүнтэй ганц өдрийн дотор хоёр удаа учирдаг байна шүү хэмээн гайхан (ихээхэн утгагүй хэрэг гэдгийг би үгүйсгэхгүй) бодож билээ!

Лондонд дэндүү оройтож хүрсэн тул мистер Браффтай ажил дээр нь уулзана гэж саналтгүй болов. Тиймээс би Хэмпстэд дэх байр руу нь шууд явж, өвгөн хуульчийг хайрт хав нохойгоо өвөр дээрээ хэвтүүлчихсэн, нэг лонх дарс тэврээд хоолныхоо өрөөнд ганцаархнаа зүүрмэглэн сууж байхад нь очиж үймүүлсэн юм.

Миний сонссон түүх мистер Браффт яаж нөлөөлснийг дүрсэлье гэвэл, ярианы төгсгөлд хэрхэснийг дурдсан нь дээр болно. Ажлынхаа тасалгаанд гал түлж, өтгөн цай авчирч өгөхийг тушаагаад, юу ч болсон өйднийг саатуулж огт болохгүй гэж эхнэр, охиддоо дамжуулав. Ийнхүү бэлтгэсний дараа хамгийн түрүүнд унтлагын цамцыг шалгаж үзээд, Розанна Спирманы захидлыг уншиж эхлэв.

Уншиж дуусаад, ажлын тасалгаандаа хоёул тусгаарлан түгжиж суусаар анх удаа ам нээж, Фрэнклин Блэйк энэ бол бүх талаар тун ноцтой хэрэг байна. Энэ хэрэг бол Рэчелд танаас дутуугүй ойр хамаатай мэт санагдав. Рэчелийн жигтэй зан авир одоо нууц биш боллоо. Таныг очир алмаз хулгайлсан гэж итгээд байгаа юм байна хэмээн өвгөн эрхэм хэлэв.

Энэхүү эгдүүтэй дүгнэлтийг зайлуулах гэж байгаараа тэмцсэн боловч толгойноос гарч өгөхгүй байлаа. үнэнийг хэлэхэд би чухамхүү мистер Браффын дөнгөж сая өгүүлсэн шалтгааны үндэслэж Рэчелтэй аминчлан уулзах гэсэн билээ.

Хуульч, цааш үргэлжлүүлсэн нь,

Одоо юуны түрүүнд Рэчелтэй уулзах хэрэгтэй. Рэчелийн занг андахгүй болохоор өдий хүртэл дуугай байсных нь учрыг ойлгоход хялбар юм. Харин ийм явдал тохиолдсон хойно цаашид дуугүй байлгаж болохгүй. цмар шалтгааны улмаас заавал таныг алмаз хулгайлсан гэж итгэснийг нь ятгах буюу шахаж шаардаж байгаад хэлүүлэх хэрэгтэй. Бид рэчелийн зөрүүд занг нугалж ам ангайлгаж чадах л юм бол одоо ийм сүрхий ноцтой санагдах энэ бүх хэрэг шальгүй юм болон хувирах найдлага байна.

Энэ я миний ухвд их л сайхан санал байна. үнэнийг хэлэхэд би нэг юм мэдмээр байна .. гэж намайг эхэлтэл, мистер Брафф яриа таслан,

Энэ саналыг юунд үндэслэснийг мэдмээр байна уу? Одоохон хэлье. Юуны өмнө, би эл хэргийг хуульч хүний нүдээр харж байгааг ойлгогтун. Миний хувьд гэрч баримт гол нь юм. Маш сайн. Энэ баримт нь анхнаасаа нэг чухал зүйл дээр үндэслээгүй байна даа гэв.

цмар зүйл дээр?

Одоохондоо та сонсоно. Тэр унтлагын цамцан дээрх тэмдэг цамц таных болохыг гэрчилж байгааг би зөвшөөрнө. Цамцны хормойд Рэчелийн өрөөний хаалганы будаг хүрчээ гэдгийг ч би зөвшөөрнө. Гэтэл алмаз алдагдсан шөнө, тэр цэмцыг та өмссөн гэх нотолгоо хаана байна?

Надад бас л иймэрхүү санаа төрж байсан учраас энэ бодол их л үнэмшилтэй санагдав.

Мистер Брафф Спирманы наминчлалыг авч цааш агүүллүүн:

үүний хувьд гэвэл, танд эвгүй сэтгэгдэл төрүүлсэн захидал гэдгийг би ойлгож байна. Та үүнийг цэвэр бодит талаас нь задлан дүгнэж төвдөөгүйн учрыг би ойлгож байна. Харин би бол тан шиг байдалд ороогүй хүн. Мэргэжлийнхээ туршлага дээр үндэслэн энэхүү браимт бичгийг бусад баримт бичиг үзэж судлахтай нэгэн адил үзнэ. Энэ бүсгүй хулгайч байсныг үл дурсан, өөрөө нэгэнт үнэнээ хүлээсэн ёсоор үзвэл үнэхээр хэлээгүй гэж сэжиглэх үндэс надад байгаа юм. Түүнийг одоохондоо ийм хэрэг үйлдэж чадсан эсэхийг нь би шүүн үзэж, элдэв таавар хийхгүй. Миний хэлэх ганц зүйл гэвэл, хэрэв Рэчел унтлагын цамцыг л баримт нотолгоо болгон таныг сэжиглэж байгаа бол Розанна Спирман л түүнийг үзүүлж дээ гэж бараг итгэлтэй хэлж болох юм. Энэ бүсгүй Рэчелд жөтөөрхөж байсан, Рэчелийн танд өгсөн сарнайг сольдог байсан, та хоёрыг түнжин хагарах болов уу гэсэн найдварын бяцхан оч төрж байсан зэргийг нуулгүй бичжээ. Саран чулууг хэн аваа вэ гэж би асуухгүй (Розанна Спирман зорьсондоо хүрэхийн тулд тавин Саран чулуу ч хулгайлахаас сийхгүй биз), харин Саран чулуу алга болсон явдал Рэчел та хоёрын тунд насан туршдаа үл эвлэрэх яс хаях боломжийг танд дурласан тэр хулгайч бүсгүйд олгожээ. Гэдгийг л хэлэх байна. Тэр үед амиа бусниулах гэж санаагүй байсныг санагтун. Түүний зан чанар, байр суурийг харгалзан үзсэн ч саран чулуу алдагдсан завшааныг ашиглахаас ер буцахгүй хүн байжээ гэдэгт би огт үл эргэлзэнэ. Та юу хэлмээр байна даа?

Анх энэ захидлыг задлахдаа иймэрхш сэжиг надад бас төрсөн юм шүү.

цг тэгнэ дээ! Тэгдээд захиаг уншсаны дараа хөөрхий бүсгүйг өрөвдөж, сэрдэж сэжиглэх зай сэтгэлд чинь үгүй болоо биз дээ. Энэ бол нэр төртэй хэрэг, эрхэмсэг ноён минь, нэр төртэй хэрэг шүү!

Гэтэл би тэр унтлагын цамцыг өмсөж байжээ. Гэж бодъё. Тэгвэл яах вэ?

үүнийг хэрхэн нотлохыг би мэдэхгүй байна\_ хэрэв та үнэхээр тэр цамцыг өмсөж байсан гэж үзвэл таны гэм буруугүйг нотлоход их л төвөгтэй болно доо. За, одоо цааш гүнзгийрүүлэхээ больё. Харин түр хүлээнэж, Рэчел ганц унтлагын цамцнаас үндэслэн таныг сэжиглэсэн эсэхийг харъя.

Ивээлт тэнгэр минь! Рэчел намайг сэжиглэж байгаа тухай та яасан хэнэггүй ярина вэ? Ер ямар ч баримт сэлт байлаа Рэчел намайг хулгайд сэрдэх ямар эрхтэй юм бэ? Хэмээн цухалдан хашгирав

Эрхэмсэг ноён минь маш ухаалаг юм асуулаа. Баахан аягтай хэлсэн боловч анхаарууштай зүйл байна шүү. таныг мухардуулсан зүйл намайг ч бас мухаодуулж байна. Та өнгөрснөө хичээж санаад

надад нэг зүйлийг тодруулж өгөөч. Тэднийд зочилж байх үеэр чинь таны нэр төрийн ч юмуу, ер нь таны зан суртахууны талаар Рэчелийн эргэлзээг төрүүлж болзошгүй шальгүй боловч ямар нэг явдал тохиолдсон уу?

Сэтгэл хөдөлсөндөө би өөрийн эрхгүй босон харайн Мистер Браффын асуулт намайг АНглиас явснаас хойш анх удаа үнэхээр нэг зүйл тохиолдсоныг сануулсан юм. Ажил хэргийн талаар надтай уулзахаар нэгэн үл таних гадаадын хүн намайг нагацынд байхад ирсэн тухай Бэттереж гуайн хүүрнэлийн наймдугаар бүлэгт дурдсаныг сануулья. Тэр хүний зорьж ирсэн хэргийг өгүүлүгэй.

Миний бие бахь байдгаараа мөнгөөр гачигдаад байнгынх нь үйлчлүүлэгч болсон Парисын нэгэн багавтар рестораны эзнээс нэлээд хэмжээний мөнгө зээлээр авч тэнэглэсэн юм. Мөнгийг эргүүлж өгөх хугацааг товлосон боловч мянга мянган шударга хүнд олонтаа тохиолддогийн адилаар би амандаа хүрч чадаагүй юм. Тэгээд нөгөө эзэнд өр төлөх баталгаа явууллаа. Гэтэл харамсалтай нь, тиймэрхүү баримтанд би дэндүү олон удаа гарын үсгээ зурсан билээ. Нөгөө хүн миний явуулсан баталгааг тоож үзсэнгүй аж. Намайг мөнгө зээлж авсны дараа түүний ажил үйл эмх замбараа алдаж дампуурахад тулаад байжээ. Тэгтэл түүний хамаатан нэг франц өмгөөлөгч эр, надаас өр нэхэхээр Англид иржээ. Их түргэн зантай хүн бөгөөд намайг эвгүй муугаар боджээ. Бид хоёр ширүүн ширүүн үг хаялцлаа. Аз харихад, тэр үеэр нагац, Рэчел хоёр хажуугийн өрөөнд байж, бидний яриаг сонссон юм. Вериндер ахай орж ирээд ямар хэрэг гарсныг тайлбарлаж өгөхийг шаардав. Нөгөө франц эр эрхийн бичгээ үзүүлээд, миний нэр хүндэд найдсан нэгэн хөөрхий эрийн сүйрэлд намайг буруутай гэж мэдэгдэв. Нагац маань тэр даруй мөнгө өгч, миний өрийг төлөөд нөгөө хүнийг явууллаа. Намайг арван хуруу шигээ мэддэг болохоор тэр франц эрийн бодлыг зөвшөөрөөгүй л дээ. Гэвч миний хэнэггүй хайнга занг гайхан цочиж, өөрөө гар бие оролцоогүй бол тун ч шившигтэй байдалд орж магад бус уу хэмээн надад зүй ёсоор уурласан билээ. Энэ бүхнийг эх нь хэлсэн юмуу. Рэчел өөрөө сонссон юмуу, бүү мэд. Рэчел романтик бодолтой хүн учир эл хэргийг хэтрүүлсэн үзжээ. Намайг “нүнжиггүй”, “өөдгүй”, “ёс шурамгүй”, “хойшдоо яах ч юм билээ” ер товчхон хэлбэл нэг ч залуу бүсгүйн амнаас энэ насандаа сонсоогүй хатуу үгээр загнасан билээ. Бидний марган маргааш нь ч үргэлжлэв. Зөвхөн нөгөөдөр нь би Рэчелтэй эвлэрч чадсан бөгөөд энэ тухай төдөлгүй мартсан юм. Миний нэр хүнд дахин арай ноцтойгоор асуудалд орооцолдсон эгзэгтэй үед Рэчел тэр явдлыг санасан болов уу? гэхэд минь Брафф гуай тэгж таарна хэмээн тэр даруй хариулав.

Тэр явдал Рэчелийн бодолд нөлөөлсөн биз ээ хэмээн нухацтай өгүүлээд –Тийм явдал гараа ч үгүй байсан болоосой. Гэхдээ та бид хоёр, таны нэрийг хорлосон явдлыг илрүүллээ. цмар боловч нэг нууцыг тайлав. Одоогоор бид цааш нь юу ч хийхэв дээ. Энэ эрэлд хийх бидний дараачийн алхам биднийг Рэчел рүү аваачих ёстой гэв.

Тэгээд босож, тасалгаан дотуур хойш урагш бодлогошрон холхиж эхлэв.би Рэчелтэй уулзахаар шийдсэнээ хэлье гэж хоёр ч удаа завдсанаа мистер Браффын зан авир, нас сүүдрийг харгалзан үзээд ийм тохиромжгүй үед дахин балмагдуулаад хэрэггүй биз хэмээн түдгэлзэв.

Бүгдийг яаж ний нуугүй хэлүүлэх вэ гэдэгт л гол бэрхшээл байна даа. Танд бодож санасан юм байна уу?

Мистер Брафф, би Рэчелтэй өөрөө уулзаж ярилцахаар шийдлээ.

Та юу?! Хэмээн дуу алдан зог тусч намайг солиорчихов уу гэсэн маягтай ширтэв.

Бүтнэ гэж үү дээ! Гэснээ огцом хөдөлгөөнөөр толгой сэгсрээд өрөөгөө дахин нэг тойров.

Байз. Иймэрхүү жирийн бус тохиолдолд хөнгөмсөг зан заримдаа хамгийн зөв арга байдаг юм шүү.

Брафф асуудлыг тийн шинээр сэтгээд хэсэг эргэцүүлэн тунгаасны дараа миний шийдвэрийг зоригтойгоор дэмжсэн юм.

Аз сорихгүй бол юу ч хожихгүй гэж өвгөн эрхэм дүгнээд, -надад үгүй горьдлого танд байна. Тэгээд та эхлээд азаа туршаад үзэж дээ гэв.

Надад горьдлого байна гэнээ ? хэмээн би учиргүй гайхан лавлав.

Мистер Браффын царай энэ ярианы турш сая л зөөлөрч, инээмсэглэл тодорлоо.

Хэргийн учир бол нуулгүй хэлэхэд, би таныг няхуур, хэнэггүй байж чадна гэдэгт итгэхгүй байна. Гэхдээ Рэчел сэтгэлийнхээ гүнд танд сайн хэвээр гэдэгт би итгэж байна. Энэ сэжүүрээс барьж ав, тэгвэл бүсгүй хүний амнаас гарч болох хамгийн тлэн далангүй үгийг сонсоно, үнэн шүү. харин Рэчелтэй ямар аргаар уулзах билээ?

Рэчел танайд айлчилж ирдэг шүү дээ. Тэгэхээр урьдаар миний тухай юу ч дурсалгүй байж байгаад түүнийг гэртээ уривал яасан юм бэ?

Мистер Брафф “Бүдүүн зүрх ээ!” гэснээс өөр хариу хэлсэнгүй, дахин хойш урагшаа холхив.

Шулуухан хэлэхэд манай гэрийг, эхнэр, хоиндын урилгаар өгөөш тавьсан хавх болгоё гэсэн үг байх нь ээ. Хэрэв та Фрэнклин Блэйк биш, энэ хэргийн учир холбогдол үүнээс хумсын чинээхэн бага байсан бол би таны саналыг хэрхэвч зөвшөөрөхгүйсэн. Гэвч байдал нэгэнт ийм хойно, өвгөн миний

бие ийнхүү итгэл эвдсэнд Рэчел хожим талархах нь дамжиггүй. Намайг та хамсаатнаа гэж үзэгтүн. Рэчелийг энд бүтэн өдөр айлчлахыг урья. Тэгээд танд даруйхан хэл хүргэмз.

Хэзээ? Маргааш уу?

Ммаргааш хариугий нт авч амжихгүй. Нөгөөдөр л больё.

Надад яаж дуулгах вэ?

өглөөгүүр гэрээсээ гаралгүй намайг хүлээж байг, би очимз.

Хариулж баршгүй тус хүргэсэнд нь мистер Браффт чин сэтгэлээсээ баярлаж талархаад, зочломтгой зангаараа Хэмпстидэд хоноод яв хэмээн урихад нь татгалзаж Лондонгийн байр руугаа зүглэв.

Дараагийн өдрийн тухайд гэвэл, урьд хожим тохиолдоогүй их урт өдөр байсан гэхээс өөр хэлэх юм алга. Гэм буруугүй гэдгээ мэдэж байгаа хгүй боловч надад тохоод байгаа эрт, орой хэзээ нэгэн цагт учир нь олдох ёстой тэр гутамшигт гүтгэлгээс болоод би амьхандаа бүгж, найз нөхөдтэйгөө уулзахаас өөрийн эрхгүй дөлж, дургүйцэж байлаа. Буруутан этгээд гэм буруугүй мэт харагддаг гэж хэлэлцэхийг бид олонтаа гэхдээ голдуу өнгөц ажигласан хүмүүсээс ихэвчлэн сонсдог. Надад бол харин гэмгүй хүн буруутан болж харагддаг гэвэл илүү үнэмшилтэй санагдана. Би өдөржин хэнийг ч хүлээж авалгүй гэртээ суугаад шөнийн харнхуйд дулдайдаж, сая нэг гадагш гарч зүрхэлсэн билээ.

Маргааш өглөө нь цай ууж суутал мистер Брафф ирж сонин дуулгав. Надад нэг том түлхүүр өгөөд, энэ насандаа анх удаа л хийсэн хэргээсээ ичиж зовж байн гэлээ.

Рэчел ирэх үү?

өнөөдөр өдрийн цайнаар ирээд өдөржингөө манайхантай цуг байна.

Таны эхнэр, охид бидний нууцыг мэдэж байгаа юу?

өөр арга алга даа. Гэхдээ эмэгтэйчүүд гэдэг чинь, та ажигласан ч байж магадгүй, тууштай улс биш шүү дээ. Энэ хэрэгт манай гэрийнхний сэтгэл зовохгүй байгаа юм. Эцэстээ Рэчел, та хоёрыг эвлэрүүлэхийг зорьж буй учраас манайхан зорилгодоо хүрэхээр бидний хэрэглэсэн арга залийн иезут нар шиг л сэтгэл төвшин харж байгаа юм.

Би тэдэнд туйлгүй баярлаж байна. Энэ юун түлхүүр вэ?

Манай арын цэцэрлэгийн хаалганы түлхүүр.

өнөөдөр гурван цагт тэнд очоорой. Цэцэрлэгт ороод ургамлын хүлэмж рүү оч. Зочны бага өрөөг өнгөрч, хөгжмийн өрөөний үүдийг онгойлго. Тэнд Рэчел байна, ганцаараа сууж байна.

Таны ачийг яаж хариулах билээ!

Би хэлээд өгье. Сүүлд юу ч болсон намайг бүү зэмлээрэй. Тийн хэлчихээд мистер Брафф гарч одов.

Шаналгаатай нэлээд олон цаг хүлээх хэрэгтэй байлаа. Цаг нөхцөөхийн эрхээр ирсэн захидлуудыг авч үзтэл Бэттереж гуайгаас захиа ирсэн байв.

Түүнийг яаран зсадлав. Онцын чухал сонин мэдээ дуулдана гэж горьдсоны хэрэггүй хэмээн захидлынхаа эхэнд сануулж, уучлал гуйсныг нь уншаад баахан гайхаж, урам ухагрсан юм. Дараачийн мөрөнд нөгөө өонин Эзра Женнингсийн сураг гарч ирэв! Бэттереж гуай төмөр замын буудлаас харьж явахад нь зогсоогоод миний хэн болохыг асуужээ. Миний нэрийг тэгж мэдээд, надтай тааралдсан тухай эзэндээ хэлсэнд мистер Канди надтай уулзаж чадсангүйдээ ихэд харамсаж буйгаа мэдэгдэх гэж Бэттереж гуайнд давхиж ирсэн байна. Надтай уулзаж, хэлэх онц чухал юм бий гэнэ. Фризинхоллын хавьд дахиад л ирэх юм бол заавал хэл дуулгаарай гэж гуйжээ. Бэттереж гуайн гүн ухааны онцлог болсон хэдэн мөрийг эс тооцвол миний сурвалжлагчийн захидлын гол алуулга иймэрхүү л байв. цагаан санаатай, үнэнч өвгөн маань, “гол нь бичмээр санагдаад л энэ захиаг бичлээ” хэмээн нуулгүй мэдэгджээ

Би захидлыг халаасандаа хийгээд, Рэчелтэй уулзах тухай бодолд автан төдөлгүй мартаж орхисон билээ.

Хэмпстидийн сүмийн хонх гурван цагийг цохиход би мистер Браффын цэцэрлэгийн хашааны хаалганы цоожинд түлхүүр хийлээ. Цэцэрлэгт хөл тавьж, хаалгыг дотроос нь хааж байхдаа юу болох бол гэхээс нэлээд айж билээ. Цэцэрлэгийн бөглүү буланд санаандгүй хүн байж намайг харчих вий хэмээн ийш тийш сэм ажиглав. Гэвч айх хэрэг байсангүйн цэцэрлэгийн жим харгуй цөм хоосон, зөний шувуунаас өөр амьд амьтан үгүй ажээ.

Би цэцэрлэгээр дамжин хүлэмжинд орж, зочны бага өрөөнд орлоо. өөдөөс харсан үүдийг татахаар бариул дээр нь гараа тавитал өрөөнөө төгөлдөр баян хуур дээр хэдэн гунигтай ая наадах сонсогдов. Намайг нагацынд айлчилж байх үед Рэчел дандаа ингэж хайнга хөгжимддөгсөн. Би зоригоо дайчлахын тулд жаахан саатах хэрэгтэй боллоо. Өнгөрсөн, одоо хоёр зэрэгцэн тодорц, хэчнээн их ялгаатай намайг гайхуулан цочоосон юм.

Хоромхон зуур зориггоо чангалж аваад өрөөний үүдийг нээлээ.

## VII бүлэг

Намайг босго алхахыг хараад Рэчел төгөлдөр хуурын араас босов.

Би үүд хаалаа. Бид өрөөний хоёр үзүүрт өөд өөдөөсөө харан дуу шуугүй зогсож байлаа. Рэчел суудлаасаа өндийхөөс өөр нэг ч хөдөлж чадсангүй мэт, бие сэтгэлийнх нь хамаг хүч чадал зөвхөн намайг ширтэх харцанд нь шингэж төвлөрсөн мэт байв.

Би тэгж дэндүү гэнэдүүлж ирсэндээ айх шиг ч боллоо. “Рэчел!” гэж ялдамхан дуудаад өөдөөс нь хэд алхав.

Миний дуу Рэчелд амь оруулж, царай нь туяарлаа. Миний өөдөөс үг дуугүй алхав. Хүсэл зориггоосоо үл хамаарах хүчний нөлөөгөөр хөдлөх мэт аажуухан ойртсоор байлаа. Хацар нь улаа, бутран, нүд нь улам л гялалзан гийнэ. Би ирсэн хэрэг зориг, миний ариун нэр төрийг гутаасан сэжиг, зайлшгүй санаж явах ёстой байсан өнгөрсөн, одоо, ирээдүйн бүхий л санаа явдлыг умартжээ. Хайрлаж явсан бүсгүй минь л улам дөхөн ойртсоор байна. Түүнээс өөр юуг ч би харахгүй байв. рэчел давхийн чичирснээ шийдэж ядан зогтусав. би цаашид тэссэнгүй, түүнийг тэврэн авч, нүүр нүдгүй үнслээ.

Рэчел ч бас бүхнийг умартсан бололтой намайг хариу үнсэх шиг болов. Гэтэл ингэж бодож амжаагүй байтал Рэчел сэхээ орсон бөгөөд ыбүх явдлыг санажээ гэдгийг би ойлгосон юм. Айж цочсон мэт орь дуу тавьж, хичээлээ ч гэсэн байрандаа тогтож чадахааргүй хүчтэй түлхэв.

Нүдэнд нь догшин хилэн бадарч, уруулд нь жигшил тодорсон үзэгдэв. өөрийг нь доромжилсон тэс хөндлөнгийн хүнийг харж байгаа мэтээр намайг толгойноос хөл хүртэл сонжин ажигласнаа,

Хулчгар амьтан! Аймхай, нүнжиггүй хулчгар! Гэв.

Ийм л үг хамгийн түрүүнд амнаас нь гарсан юм даа! Ер бүсгүй хүний амнаас эр хүнд хандан гарч болох адгийн муухай зэмлэлийг Рэчел надад хэлсэн юм.

Би таныг гомдооход үүнээс арай л аятайхан хэлдэг байсныг би санаж байна. Намайг уучларай гэж би өгүүлэв.

Сэтгэлийн уй гашуу миний дуу хооллод илэрсэн бололтой надаас харц буруулсан Рэчел миний үгийг сонсохдоо өөдөөс дурамжхан харав. Тэгээд хачин дүнсгэр, бие барьсан байдлаар, намуухан дуугаар хариу өгсөнб өгөөд урьд өмнө тийм байхыг нь би огт хараагүй билээ.

Намайг уучилж болно байх л даа. Та нэгэнт тийм хэрэг үйлдчихээд, өнөөдрийнх шиг арга замаар надтай уулзана гэдэг эр хүнд зохино гэж үү? Энэ бол хулчгар зангийнх, танд талтай байдгийг минь ашигласан өөдгүй зангийн илрэл мэт санагдана. Гэнэт балмагдсаныг далимдуулан цачаан гайхуулж, үнсдэг чинь ёстой өөдгүй зан. Гэвч энэ бол бүсгүй хүний л бодол шүү дээ. Та үүнийг зөвшөөрөхгүй гэдгийг би санах ёстой. Би биеэ захирч, амаа барьж чадсан бол дээр байжээ.

Эдгээр уучлалын үг доромжлолоос долоон дооор сонсогдов. цмар ч адгийн эр үүнийг сонсоод басамжлалыг ойлгох буй заа.

Миний нэр төр таны гарт байгаагүй бол би таныг одоохон орхиод, дахиад хэзээ ч уулзахгүй сэн. Та намайг нэг хэрэг үйлдсэн гэлээ. Би яасан юм бэ?

Та яасан гэнээ! Та үүнийг надаас асууж байгаа юм уу?

Тийм ээ, би асууж байна.

Би таны булай хэргийг нууж байсан, тэгж нуусныхаа шанг ч амслаа. Юу үлйдсэнээ надаас шалгааж доромжлохгүй байж болохгүй гэж үү? Эсвэл хүний ачийг санах сэтгэлгүй болсон юм уу та урьд боловсон сайн хүн байсан. Урьд эх минь таныг хайрладаг, би бүр ч их хайрладаг байсан. . . гээд Рэчелийн дуу тасалдав.

Сандал дээр цаашаа харж суугаад хоёр гараараа нүүрээ дарлаа.

Миний бие үг хэлэх тэнхээтэй болтлоо хэсэг хүлээзнэв. Тэр нам гүмийн дунд Рэчелийн жигшин зэвүүцсэн доромжлол юмуу эсвэл зовсон гунигийг нь хуваалцах аргагүй болгосон миний бардам шийдвэрийн чухам аль нь намайг тэгтэл шаналгасныг би сайн мэдэхгүй байв.

Та эхэлж ам нээхгүй бол би эхлэх хэрэгтэй болжээ. Би тантай нэг чухал зүйл ярилцах гэж энд ирсэн юм. Наад захын шударга ёсыг бодож та миний яриаг сонсоно уу?

Рэчел хөдөлсөн ч үгүй, дуугарсан ч үгүй. Би ч дахиж гуйсангүй, сандал руу сөөм ч ойртсонгүй. Тэгээд Нуранги элснээс олсон зүйлийг, тэр нь эцэстээ намайг юунд хүргэснийг бүгдийг Рэчелийн нэгэн адил ихэмсэг бардмаар өгүүллээ. Эл яриа дориун цаг авсан нь мэдээжийн хэрэг. Рэчел нэг ч удаа эргэж харалгүй ганц ч үг дуугаралгүй дуустал сонсов.

Би биеэ бариад л байлаа. Энэхэн үед л тэсвэр алдалгүй, биеэ захирч чадах эсэхээс миний ирээдүй тэр чигээрээ хамаарна гэдэг тодорхой байсан билээ. Мистер Браффын онолыг туршиж үзэх цаг ирэв. Тэр туршлагыг туйлаас сонирхсон миний бие Рэчелийг тойрон гарч, өөдөөс нь харж зогсов.

Би танаас нэг юм асууя. Эмзэг асуудлыг дахин хөндөхөөс аргагүй боллоо. Розанна Спирман танд миний унтлагын цамцыг үзүүлсэн үү? Тийм үү, үгүй юу?

Рэчел ухасхийн босоод надад бүр тулж ирэв. Миний царайг сонжин ширтэх нь нэгийг олж үзэх гэсэн мэт.

Та солиороо юу? Гэв.

Тэгэхэд нь би тэвчиж,

Рэчел намайг огт хайхрахгүй үргэлжлүүлсэн нь:

Миний төсөөлөхгүй байгаа далд зорилго энд байна уу? Ирээдүйдээ айж зовох зүйл байгаа, тэр нь надад ч бас хамаатай юа уу? эцэг чинь нас барж, та их баяжсан гэлцэх юм. Та миний алдагдсаналмазын үнийг төлөх гэж ирээ юу? үйлдсэн гэмээсээ ичиж зовох сэтгэл бага ч атугай байна уу? Энэ чинь таны ингэж гэмгүй царайлж, Розанна Спирманы тухай үлгэр зохиосны учрыг тайлбарлах юм уу? Энэ бүх заль мэхийн чинь цаана ичиж зовох сэтгэл байна уу?

Эцэстээ гэвчээр барагдаж, яриаг нь таслаад,

Та намайг муухай дормжиллоо! Намайг алмаз хулгайлсан гэж сэрдэж байх шив дээ. цмар учраас ингэж сэжиглэх болсныг би мэдэх эрхтэй, мэдэх ч болно! Гэж цухалдан дуу алдав.

Сэжиглэх ий? Гэж Рэчел надаас дутуугүй уурсан хашгираад, -Өөдгүй амьтан! Алмаз авч байхыг чинь би хоёр нүдээрээ харсан! Гэв.

Эдгээр үгийн даанч илэрхий утга мистер Брафф найдаж байсан бүхнийг хоромхон зуур тас цохисон намайг балмагдуулж орхисон билээ. Гэм бруугүй атлаа Рэчелийн өмнө бүлх залгисан мэт дуугүй зогсож байлаа. Би түүний нүдэнд, ер аливаа хүний нүдэнд хулгай нь баригдсан сэтгэл мэтээр үзэгдэх болж дээ.

Миний шалдаа буусныг, өөрөө дийлснийг хараад бол одоо ч гэсэн уучлах л байсан гэж ирсэн юм бэ? Тан юунд намайг доромжлох гэж ирсэн юм бэ? хэмээн лавлав.

Тэгээд хэд алхсанаа дахин зогтусч,

Тэнгэрийг бодож нэг ч гэсэн үг дуугараачдээ! Танд нинжин сэтгэлийн ул мөр үлдсэн бол намайг ингэж зовоохоо болиоч! Ганц ч болов үг дуугарч намайг энэ өрөөнөөс гараад аль! Гэж догдлон дуу алдав.

Би юу хийж буйгаа ч үл ухааран Рэчелд дөхөж очлоо. Түүний амнаас өөр үг гарахаас өмнө амжиж зогсооё гэсэн бүүр түүр бодол төрсөн байж магадгүй юм. Оечэл намайг зэмлэхдээ нүдээр үзсэн явдлыг үндэслэснийг сонсоод, биеэ гэмгүй буруугүй гэсэн итгэл маань хүртэл ганхчихсан билээ. Би Рэчелийн гараас ббарьж, буурьтай, ухаалаг ярихыг оролдсон авч,

Рэчел та урьд намайг хайрладаг байсан шүү дээ гэхээс өөр үг дуугарч чадсангүй.

Рэчел дагжин ч чичирч, нүүр буруулав. Суларч, салганасан гарыг нь би атгасаар байлаа.

Миний гарыг тавиач дээ хэмээн Рэчел доройхон эсэргүүцэв.

Миний гар хүрсэн нь анх би өрөөн орж ирээд дуугарсантай яг адил нөлөөлөв бололтой. Намайг аймхай хулчгар гэж нэрлэн, мөн хулгайч хэмээн тооцож буйгаа хэлсэн хойно нь ч гарыг нь атгаж байгаа цагт миний эрхшээлд байх нь ээ!

Би түүнийг эелдэгхэн хөтөлсөөр өрөөний нолд аваачаад хажуудаа суулган,

Рэчел ээ, би одоо хэлэх зүйлийнхээ үөрчилтэй санааг тайлбарлаж чадахгүй. Таны нэгэн адил үнэнийг л ярьж чадна. Та намайг алмаз авч байхыг нүдээрээ харжээ. Гэтэл би алмаз авснаа сая л таны амнаас сонслоо. Тэнгэрийн өмнө тангарлая! Та одоо ч надад итгэхгүй л байна уу? гэлээ.

Рэчел миний үгийг анзаараа ч үгүй юмуу, эсвэл сонсоогүй бололтой “Миний гарыг тавиач дээ” гэж дорой дуугаар давтан өгүүлснээ өөр хариу эс хэлэв.

Толгойгоороо миний мөрийг түшиж, гараа суллахыг гуйсан хэрнээ өөрийн мэдэлгүй миний гарыг атгаж байлаа.

Би давтан асуухаас түдгэлзсэн боловч бас гэвчээр барагдав. Хожим шударга хүмүүсийн дунд нүүр бардам явах боломж одоо Рэчелийг илэн далангүй яриулж чдаах эсэхээс шалтгаална гэдгийг би ойлгосон юм. Рэчел хэрэг явдлын хэлхээсээ нэг гогцоо буюу өчүүхэн зүйлийг анзааралгүй орхисон байж, түүнийг нь нарийвчлан хянаж үзвэл миний гэм буруугүйг нотолж юу магад гэсэн цорын ганц горьдлого надад үлдсэн байв. Рэчелийн гарыг атгасаар сууснаа хэлье. Би түүнтэй урьдын дотно, элэгсэг агсан үеэ сэргээмээр ялдамхан ярьсан гэдгээ хэлье.

Би нэг юм гуймаар байна. Та бид хоёр бие биедээ тавтай нойрсохыг ерөөгөөр салснаас хойш би алмазыг авах хүртэл хугацаанд чухам юу болсныг нэгд нэгэнгүй ярьж өгөөч.

Рэчел толгойгоо мөрөн дээрээс авч, гараа суллахыг оролдон,

Ай үүнийг юунд дахин сөхнө вэ? Юунд дахин дахин сөхнө вэ! Гэв.

Рэчел ээ, би учрыг нь хэлье. Та ч тэр, би ч тэр, үнэн мөнийн багаар халхавч хийсэн аюумшигт эндүүрлийн золиосболжээ. Таны төрсөн өдрийн баярын шөнө юу тохиолдсоныг цуг эргэн үзвэл хоёулаа бие биеэ ойлгож магадгүй шүү дээ.

Рэчел миний мөрийг толгойгоороо дахин түшив. Нүдэнд нь нулимс цийлэгнэн ирснээ хацрыг нь даган бөмбөрлөө.

Ай-яа! Надад ч бас ийм горьдлого байгаагүй гэж үү? Би ч бас таны одоогийнх шигээр учрыг нь олох санаатай оролдоогүй гэж үү?

Та ганцаархнаа оролдсон. Та миний тусламжтай оролдоогүй шүү дээ гэж би хариуллаа.

Эдгээр үг миний найдлагыг Рэчелд халдаав бололтой. Миний асуусанд дуулгавартайгаар үл барам хамаг оюун ухаанаа хөвчлөн байж хариулсан юм.

Хоёулаа бие биедээ тавтай нойрсохыг ерөөгөөд салсны дараа юу болсныг эхэлье. Та орондоо орсон уу, эсвэл суугаад үлдсэн үү?

Орондоо орсон.

Хэдэн цаг болж байсныг ажигласан уу? их оройтсон байсан уу?

Нэг их оройтоогүй. Раван хоёр л дөхөж байсан байх,

Та хэвтсэгц л унтсан уу?

Үгүй, тэр шөнө нойр хулжаад унтаж чадаагүй.

Та амраагүй хэрэг үү?

Би тувт таныг бодож байлаа.

Энэ хариуг сонсоод би зориг шантрахад хүрсэн юм. үгнээсээ илүү хэлсэн өнгө аяс нь миний зүрхийг бүлээд авах шиг санагдан, би зогтуссанаа сая дуугарах сөхөөтэй болж,

Та өрөөндөө гэрэлтэй байсан уу? гэж асууллаа.

Босож лаа асаахаас өмнө үгүй.

Хэвтээд хэр удсан байсан бэ?

Цаг шахам болсон байх аа. Нэг цагийн үед.

Та унтлагын өрөөнөөсөө гарсан уу? гарах гэж байсан юм. Халаад нөмрөөд зочны өрөөнөөс ном авах гэж ...

Хаалгаа онгойлгосон уу?

Онгойлгосон.

Гэхдээ зочны өрөөнд ороогүй юм уу?

үгүй, больсон.

цаагаад?

Зочны өрөөний хаалганы завчраар гэрэл тусаж, хүний алхаа ойртох сонсогдсон юм.

Та айсан уу?

Тэгэхэд айгаагүй. Хөөрхий ээж миний нойр муутай хүн байлаа л даа. Тэр үдэш миний алмазыг өөрөө хариуцаж хадгалъя гэж намайг ятгаад цөхсөнийг нь би санав. Ээж дэмий л сэтгэлээ зовоогоод байх шиг бодогдож байв. намайг хэвтсэн эсэхийг үзэж, сэрүүн байвал алмазын талаар дахин ярилцах санаатай иржээ гэж би бодсон юм.

Тэгээд та яасан бэ?

Намайг унтсан гэж бодог гээд би лаагаа үлээчихсэн. Миний хувьд ч утгагүй л юм болсон. Юу гэвэл, алмазаа өөрийн сонгосон газар л хадгалах гэж зүтгээд байлаа.

Дэнлүүгээ унтраачихад буцаж хэвтсэн үү?

Амжаагүй. Лаа дөнгөж унтраавал зочны өрөөний үүд нээгдэж, босгон дээр нь...

Хэн байсан бэ?

Та.

Хувцастайгаа юу?

үгүй.

Унтлагын цамцтай юу?

Унтлагын цамцтай, лаа барьсаар орж ирсэн.

Ганццаараа.

Миний царай харагдсан м уу?

Харагдсан.

Тод уу?

Бүр тод. Таны барьсан лаа гэрэлтүүлж байсан юм.

Нүдээ хараастай явна уу?

Тийм.

Миний харцанд шийдчихсэн юмуу, уймарсан, ер нь ямар нэг этгээд шинж байсан уу?

үгүй, тийм юм мэдэгдээгүй. Харин таны нүд ердийнхөөс илүүгээр гялалзаж байсан. Тэр өрөөнд тэгж орох ёсгүй гэдгээ ойлгож, хүнд харагдахаас айж сэрэмжилсэн мэтээр өрөөг тойруулан ажигласан.

өрөөнд орж ирэх үед миний алхаа гишгээ ямаршуу байсныг ажигласан уу?  
явдгаараа л явсан. Өрөөний голд хүрээд зогсож, эргэн тойрноо харсан.

Намайг хараад та яасан бэ?

цаж ч чадаагүй. Гайхаад хөшиж орхиссон юм. Би дуугарах ч сөхөөгүй, таныг дуудах ч чадалгүй, үүдээ ч хаах тэнхэлгүй болчихсон.

Би таныг харж болох байсан уу?

Мэдээжээр харах л байсан. Гэвч та миний зүг хялам ч хийгээгүй. Энэ тухай асуугаад ч ашиггүй. Та намайг ер нь хараагүй дээ.

Та яагаад ийм итгэлтэй байгаа юм бэ?

Харсан бол алмаз авах байсан гэжүү? Хожим нь тэгж хуурамж загнах байсан гэж үү? Би тэр шөнө унтаагүй, таныг харсан гэдгийг мэдсэн бол та одоо энд байх юм гэж үү? Энэ тухай ярь гэж надаас бүү шард! Би танд тайван хариулмаар байна. Тайван байлгаж үзээч. Өөр юм ярилцъя.

Рэчелийн зөв бүх талаар Рэчелийн түмэн зөв байлаа. Би өөр сэдэвт оров.

Би өрөөний голд зогсоод дараа нь юу хийсэн бэ?

Цаашаа эргэж, миний энэтхэг шүүгээ байдаг булан руу шууд очсон.

Шүүгээний дэргэд очсон бол би тань руу нуруугаараа хандаж зогсох ёстой. Тэгэхээр миний юу хийж байгааг та яаж харах юм бэ?

Таныг хөдлөхөөр би бас дагаж хөдөлсөн юм.

Миний юу хийхийг харах гээд үү?

Зочны өрөөнд гурван толь байдаг. Таны үйлдэж байгаа бүхэнд толинд тусаж харагдаж байсан юм.

Та юу харсан бэ?

Та лаагаа шүүгээн дээр тавьсан. Шургуулга бүрийг татаж үзсээр алмаз хийсэн шургуулгыг онгойлогоод нэг харснаа гараа хийж, алмазыг авсан.

Намайг алмаз авсан гэж та яаж мэдсэн юм бэ?

Та шургуулганд гараа хийхийг би харсан. Бас гараа авахад долоовор, эрхий хурууны чинь завсар чулуу гялалзахыг үзсэн.

Би шүүгээд дахиж гэр хүрсэн үү? Жишээлбэл, шургуулга хаах гэж?

үгүй. Алмазыг баруун гартаа бариад солгой гараараа шүүгээн дээрээс лаа авсан.

Дараа нь хавь ойроо ажигласан уу?

үгүй.

Би өрөөнөөс тэр даруй гарсан уу?

үгүй. Та огт хөдөлгөөнгүй нэлээд удаан зогсох шиг санагдсан. Таны царай хажуугаасаа толинд харагдаж байв. та бодолд дарагдан хийж байгаадаа сэтгэл дундуур юм шиг байсан.

Дараа нь яасан бэ?

Та гэнэт сэхээ авч, өрөөнөөс шууд гарсан.

Би гарахдаа үүд хаасан уу?

үгүй, үүд онгорхой орхиод гудамд хурдхан гарсан.

Дараа нь?

Дараа нь таны лааны гэрэл үзэгдэхээ больж таны хөлийн чимээ тасарч, би харанхуйд ганцаараа үлдсэн.

Тэр мөчөөс алмаз алдагдсаныг хүмүүс мэдэх хүртэлх хугацаанд ямар нэгэн хэрэг гараагүй биз?

Юу ч болоогүй.

Та яг мэдэж байна уу. та тэгэхэд дугхийгээгүй гэж үү?

Би цурамхийгээгүй, хэвтээ ч үгүй. Пенилоп өглөө ирдэг цагтаа ирэх хүртэл ямар ч хэрэг гараагүй.

Би Рэчелийн гарыг тавьж, босон өрөөн дотуур холхив. Миний асуусан бүхэнд хариуллаа. Мэдэхийг хүссэн нарийн ширийн зүйлс цөм илэрхий боллоо. Зүүдэндээ явах ч юмуу, согтуу байсан гэдэг таамаглалаа би эргэж сөхсөн ч үгүй. Аль аль нь ч үндэслэлгүй таамаглал болохыг намайг нүдээр харсан гэрч батлаад өгөв. Одоо юугаа хэлж, юу хийвэл зохих вэ? Бүхнийг уусган живүүлсэн таг харанхуйн дунд хулгай хийснийг минь баталсан аймшигт нотолгоо, барин тавин илэрхий баримт л нүдний өмнө үзэгдэнэ! Нуранги элсэнд Розанна Спирманы нууцыг тайлаад ч надад тус болчихоор зурвас гэрэл гараагүй билээ. Одоо тэр нэгэн шөнийн ой гутам явдлыг Рэчелийн амаас сонсоод ч юмны сэжүүр олсонгүй.

Энэ удаад Рэчел түрүүлж нам гүмийг эвдлээ.

За, та асууж би хариуллаа. Та энэ бүхнээс нэг юм олно гэж горилж байсан учраас надад жаахан найдлага төрүүлсэн. Одоо хэлэх юм байна уу?

Миний эрхшээлээс нэгэнт гарсан нь Рэчелийн дууны өнгөнөөс илэрхий.

Миний төрсөн өдрийг тэмдэглэсэн шөнө юу болсныг хамт эргэж хараад бие биеэ ойлголцоно гэсэн шүү дээ. Тэгээд ойлголцов уу? хэмээн Рэчел огт өрөвдсөн шинжгүй хариу шаардав.

Би хариу өчихдөө биеэ барихын оронд арчаагүй загаснаараа залруулшгүй алдаа хийсэн юм. Тэр явдлын талаар надад өдий болтол юу ч дурссангүй гэж би түүнийг их болчимгүй, шал дэмий зэмлэж гарсан билээ.

Та хэлбэл зохих үед нь надад хэлбэн бол, наад захын шударга ёсыг бодож учраа гарган тайлбарласан бол... гэж эхэлтэл Рэчел галзууртлаа уурсан хашгирч миний үгийг тас дайрав. Тэр хэдэн үгэнд ганиран хилэгнэв бололтой.

Тайлбарлах ий! Ай, энэ хорвоод ийм хүн өөр байдаг болов уу? миний элэг эмтэрч байвч, би үүнийг өршөөсөн, миний нэр төр дээсэн дөрвөн дээр санжигнаж байхад би үүнийг хамгаалж байлаа. Гэтэл одоо намай учраа гаргаж тайлбарласангүй гэж зэмлэж байна! Тэгж итгэж, хайрлаж, өдрийн бодол, шөнийн зүүд болж явсан хүн, уулзмагцаа л өөрийнх нь шившгийг уудлан “Хайрт минь, чи хулгайч!”. “Дурлаж, хүндэлж явсан чи минь шөнийн харанхуйд дулдуйдан өрөөнд сэм орж, миний алмазыг хулгайлсан шүү дээ!” гэж зэмлэсэнгүйд гайхаж байна. Би тэгж л хэлбэл зохих байж л дээ. Та бол өөдгүй, овилгүй амьтан. Одоо энэ ичшүүргүйгээр худал хэлж байгаа царайг чинь харснаас тавин алмаз алдвал надад хавьгүй дээр сэн!

Би малгайгаа авав. Рэчелийг өрөвдсөндөө (үнхээр өрөвдсөн юм шүү!) би нэг ч үг дуугаралгүй эргэн алхаж, хаалга нээв.

Үгүй! Болоогүй! Би тантай эвгүй харьцаж байснаа цагаатгах ёстой юм шиг байна. Та явалгүй сонсогтун, эсвэл зөрж зүтгээд яв л даа. Тэгвэл адгийн шаар болохоо харуулна даа гэв.

Түүнийг харахаас зүрх шимширч, дууг нь сонсохоос элэг эмтэрнэ. Би үг дуугарах ч сөхөөгүй байсан тул хүслийг нь дагаж буйгаа толгой дохин мэдэгдэв.

Намайг буцаж чимээгүйхэн суухад уурласандаа минчийсэн царай нь зугуухан шигнэрч ирлээ. Рэчел хэсэг азнаснаа биеэ барьж тайвшрав. Гэхдээ ямар ч ухаан мэдрэлгүй мэт агаад хоёр гараа чанга гэгч салаавчлан атгаж, өвөр дээрээ тавиад миний зүг хялам ч хийлгүй газар ширтэж ярьж эхэллээ.

Би танд наад захын шударга ёсыг бодож учраа гарган хэлэх ёстой хэмээн миний үгийг давтаад, -Би танд шударгаар хандахыг оролдсон эсэхийг та үзээрэй л дээ. Таныг зочны өрөөнөөс гарч явснаас хойш би цурам ч хийгээгүй, хэвтээ ч үгүй гэдгээ түрүүн хэлсэн. Юу бодож байснаа ярьж, танд төвөг удаад хэрэггүй биз, та ойлгох ч үгүй. Харин нэлээд хугацаа өнгөрсөний хойно сэхээ аваад хэрхэснээ ярья. БИ тэр даруй түгшүүр зарлаж, хүн бүрд хэлбэл зохих байсан авч тэгээгүй юм. Таныг даанч их хайрладаг учраас таны үйлдсэн хэргийг нүдээр харсан атлаа таныг хулгайч гэж л санахгүй байхын тулд ямарваа бүтэшгүй зүйлд ч итгэхэд бэлэн байлаа! Тэгээд бодож бодож, эцэстээ захиа бичихээр шийдэв гэхэд нь,

Тэр захиаг чинь аваагүй шүү дээ гэж би санууллаа.

Таны аваагүйг би мэднэ. Жаахан хүлээ яагаад аваагүйн учрыг хэлэмз. Би тэр захиандаа тодорхой юу ч бичээгүй. Хөндлөнгийн хүний гарт орлоо гэхэд таныг баллахааргүй байсан юм. Захиандаа, таныг өр ширэнд баригдсан, мөн ээж бид хоёрын ойлгосноор бол, мөнгөний хэрэгцээ гарсан үед зөв бурууг ялгадаггүй, огт ёсорхдоггүй хүн юм гэж үзэх үндэс байна гэдгийг л бичсэн бөгөөд та ч цаад учрыг нь эндүүгүй ухаарах байв. тэгээд та нөгөө хэрэг хөтлөгч франц хүний ирснийг санаж, миний битүү сануулгыг ойлгох байсан биз. Цааш нь сонирхвол, танд нэг нууц зүйл (энэ тухай ерөөсөө хоорондоо ярилцаж байгаагүй болохоор) буюу танд шаардлагатай хэмжээний мөнгө чадлын хэрээр зээлдүүлье гэж бичсэнийг та унших байв. би мөнгө олох ч байлаа! Хэмээн Рэчел дуу алдав. Царай нь дахин улайж, өөдөөс эгцлэн ахарв. өөр арга олдохгүй бол алмазаа барьцаанд өгөөд ч гэсэн мөнгө олох байсан! Танд ийм л захидал бичсэн юм даа. Байз! Арай илүү юм хийсэн шүү. таныг ганцаараа байхад гарт чинь өгүүлэхээр Пенилоптой тохиролцсон байлаа. Би унтлагын өрөөндөө түгжиж суугаад зочны өрөөгөө өглөөжин эзгүй, онгорхой орхиё гэж бодсон юм. Энэ боломжийг ашиглан алмазыг шүүгэнд сэмхэн буцаагаад хийчихээсэй гэж үнэн голоосоо горьдож байсан билээ!

Намайг ам нээх гэтэл, Рэчел цухалдан зангаж болиулав. Зан нь тун түргэн өөрчлөгдөх агаад дахин уур хилэн нь бадарч эхэлжээ. Босож ирээд үргэлжлүүлэн,

Таны юу хэлэх гэмнийг би мэдэж байна. Та миний захиаг ер аваагүй гэх гэж байгаа биз дээ. цагаад гэдгийг би танд хэлчихье, би хаячихсан юм гэв.

цагаад?

Ихээхэн үндэстэй шалтгаан бий. Тань шиг хүнд өгснөөс урж хаясан нь дээр гэж үзсэн юм! Өглөө хамгийн түрүүнд ямар сонин дуулсан гээч? Төлөвлөгөөгөө боловсруулчихаад байтал юу сонсов? Та (чухам та шүү!!) санаачлан цагдаа дуудуулсан гэнэ. Тэр эрдэнийн чулууг олох ажилд та хүн бүхнээс илүү идвэхтэй зүтгэж, голлох үүрэг гүйцэтгэж байлаа! Тэр ч байтугай, өөрөө хулгайж, биеэсээ салгахгүй авч явсан хэрнээ алмаз алга болсон талаар надтай ярилцах гэж зүүрхэлснийг нь яана! Таныг ийм ой гутмаар бялангач, хоёр нүүртэй зальхай этгээд гэдгийг чинь барин тавин хараад би захиагаа урж хаясан. Таны урьж авчирсан цагдаа асууж шалгаан, эрж сурвалжлахад нь галзуурах дөхсөн атлаа таныг сэтгэлээсээ бүрмөсөн гаргаад хаячихаж чадаагүй юм. “Энэ хүн бусдын өмнө жигшүүртэй жүжиглэлээ. Одоо миний өмнө жүжиглэж зүрхлэх эсэхийг нь харъя” гэж би бодлоо. Таныг дэвсэг дээр ганцаар байгааг сонсоод би дэвсэг рүү очсон. Биеэ албадан таны өөдөөс харж, хүчээр тантай ярьсан билээ. Тэр үед миний хэлсэн үгийг та мартчихсан уу?

Түүний үгийг нэгд нэгэнгүй санаж байгаагаа хэлж болох л байв. гэвч тэглээ гээд ийм үед ямар ашиг гарах вэ дээ? Рэчелийн үгэнд мэл гайхаж, урам хугарснаа, түүнийг сэтгэлийн хэт хямралд оржээ гэж бодоход хүрснээ мөн алмаз алдагдсан явдал түүний хувьд тийм нууц зүйл мөн үү гэсэн эргэлзээ хүртэл төрсөн боловч үнэний сэжүүр олдоогүй гэдгийг хэрхэн учирлах билээ? Миний гэм бруугүйг нотолчихоор өчүүхэн ч баримт үгүй тул, дэвсэг дээр хэлсэн үгийг нь сонсохдоо би түүний юу бодож буйг даанч төсөөлөөгүй гэдгээ учирлаж хэрхэн чадах билээ?

Рэчел өгүүлдүүн:

Таны хувьд тэр үгийг мартсан нь дээр бол харин би санаж явах учиртай юм. Хэлэхийн өмнө сайтар бодож тунгаасан болохоор би мартаагүй юм шүү. буруугаа хүлээж, үнэнээ хэлэх боломжийг танд удаа дараа олголоо. Таны хулгай хийснийг мэдэж буйгаа шууд хэлээгүй болохоос биш би тун ойлгомжтой сануулсан шүү дээ. Гэтэл та яг одоогийнх шигээ гэмгүй царайлж гайхсан дүр үзүүлэн ширтэж билээ! Энэ хорвоогийн тоосыг хөдөлгөж яваа адгийн увайгүй этгээд гэдгийг чинь мэдэж аваад л би тэр өглөө явсан юм даа!

Рэчел ээ, та тэр үед тодорхойхон ярьсан бол огт гэмгүй хүнийг сүрхий доромжилсон гэдгээ ухаарч аваад явах байсан юм.

Рэчел дахин дүрсхийн уурсаж,

Бусад хүнд учирлан ярьсан бол таны нэр насан туршдаа хугарах байсан юм! Танд аминчлан хэлсэн бол өндөөрийн шигээ л мэлзэх байсан шүү дээ! Би танд итгэх байсан гэж бодож байна уу? тийм хэрэг үйлдчихээд дараа нь улайм цайм ичгүүргүй авирлаж байсан хүн хуурч мэхлэхээ торно гэж үү? Дахин хэлэхэд, таны хулгай хийхийг харж, айж цочсон болохоор худал хэлэхийг чинь сонсохоос айсан юм. Та эл явдлыг хэдхэн үгээр залруулчихаж болох эндүүрэл мэтээр ярьж байна! За яахав, эндүүрэл гээд өнгөрөөе л дөө. Гэтэл хэрэг явдлыг залруулж чадав уу? үгүй! уг л хуучин хэвээрээ үлдлээ. Би танд одоо итгэхгүй байна! Унтлагын цамц олсон гэдэгт ч, РОзанна Спирманы захианд ч, ер нь таны нэг ч үгэнд би үнэмшихгүй! Тэр чулууг та хулгайлахыг би нүдээрээ харсан! Цагдаа нарт тусалсан дүр үзүүлж байхыг чинь ч харлаа! Алмазыг та Лондонд аваачиж мөнгө хүүлэгчид барьцаанд өгснөөс зайлахгүй! Би арчаагүйтэж, амаа хамхиж явсны гайгаар таны үйлдсэн гутамшигт хэрэг гэмгүй хүнийг балласан шүү дээ. Та олзоо аваад эх газар руу шалавхан зугтсан! Энэ бүх бузар явдлынхаа дараа та ганц л зүйл хийж чаджээ. Та адгийн хуурамч, зусар үгтэй ирж, бас шударга бус харьцлаа гэж намайг зэмлэлээ!

Миний бие дахиад хоромхон зуур л саатсан бол хожим хэчнээн харамсавч тусгүй үг амнаас гарчихаж болзошгүй байсан юм. Би Рэчелийн хажуугаар өнгөрч, дахин үүд нээв. Уурлаж догшрон тэвчээр алдсан Рэчел миний гараас зууран дахин зам хөндөлсөв.

Рэчел ээ, намайг явуул л даа. Тэгвэл аль алинд маань дээр, намайг явуулчих! гэж би учирлалаа.

Рэчел багтартал хилэгнэсэндээ амьсгаа нь давхцан намайг хаалганд шахангаа миний нүүр өөд тун ойрхон тасалданги амьсгаадан байв.

Та яах гэж ирсэн юм бэ? хэмээн улайран шалгааж, -Яах гэж ирсэн юм бэ гэж асууж байна! Таныг илчилнэ гэж айгаа юу? Одоо та баян чинээлэг, байр сууриа олсон хүн. Английн бүсгүйчүүдээс сайныг нь шилэн авч гэрлэж чадах боллоо.Тэгээд одоо танаас өөр нэг ч хүнд цухуйлгаа ч үгүй нууцыг илчлэх вий гэж айгаа юу? Би нэг ч үг хэлж чадахгүй! Би таныг илчилж чадашгүй нь! Би танаас ч долоон дор юм! Гээд эхэр татан нулимс асгаруулав. Гэвч биеэ барих санаатай цөхрөн оролдож, надаас улам чанга зуурна.

Би одоо ч гэсэн таныг зүрх сэтгэлээсээ зайлуулчихаж чадахгүй байна! Одоо ч гэсэн шүү! тантай өөрөөр тэмцэх хүчгүй миний шившигтэй, ичмээр дорой занд та найдаж болно!

Рэчел намайг гэнэт тавьж, гараа цухалдан базалж,

Надаас өөр бүсгүй бол энэ хүнд хүрэхийг ч цээрлэх биз ээ! Ай, тэнгэр минь! Би өөрийгөө энэ хүнээс илүүгээр жигшиж байна! Хэмээн дуу алдлаа.

Би энэ аймшигт явдлыг цаашид үл, тэсвэрлэн, нүднээ өөрийн эрхгүй нулимс цийлэгнэв.

Та намайг эндүү бодож явснаа хожим ойлгоно, эсвэл миний барааг дахиад хэзээ ч харахгүй гэж хэлээд би холдлоо.

Рэчел суусан даруйдаа ухасхийн босож, (ёстой л сайхан сэтгэл шүү!) намайг өрөөнөөс гартал дагасаар, салахдаа нигүүлсэл дүүрэн үг хэлж билээ.

Фрэнклин! Би таныг уучилъя! Ай, Фрэнклин, Фрэнклин бид хоёр дахиад уулзахгүй шүү дээ! Намайг уучлаач дээ!

Би эргэж харлаа. үгээр илэрхийлж чадаагүй санааг миний царайнаас олж үзээсэй гэсэндээ эргэн харж, зөнгөөрөө болог хэмээн орхив. Хоёр нүдийг хэдийн мэлмэрсэн нулимс бүрхээд Рэчелийн дүрс хий үзэгдэл мэт сүүдэгнэнэ.

Параагийн эгшинд бүх зүйл дуусав. Би цэцэрлэгт гарч, Рэчелийн барааг дахин харсангүй, дууг нь ч дахин сонссонгүй.

## VIII бүлэг

Тэр үдэш, цаг орой болсон хойно мистер Брафф манайхаар орж ирэхэд нь би гайхаж билээ.

Хуульчийн байдалд мэдэгдэүйц өөрчлөлт гарсан байв. хэзээний өөртөө итгэсэн, эрэмгий зоримог байдал нь үгүй болжээ. Надтай дуу шуу ч үгүй гар барьсан нь анх удаагийн үзэгдэл юм.

Та Хэмпстэд рүү буцах нь уу? хэмээн би яаж дуугүй байх вэ гэсэндээ асуулаа.

Хэмпстедээс дөнгөж сая ирлээ. Фрэнклин, та одоо бүх үнэнийг мэдэж авлаа. Харин ямаршуу үнээр гэдгийг нь урьдаас мэдсэнсэн бол би таныг юу ч мэдэхгүй хэвээр нь үлдээх байсан гэдгээ шууд хэлье.

Та Рэчелтэй уулзаа юэ?

Портленд талбайд хүргэж өгчихөөд би өөрөө нааш ирлээ. Ганцааранг явуулах аргагүй байв. миний байшинд, миний зөвшөөрөлтэйгөөр та түүнтэй уулзсан болохоор тэр гайтай яриа Рэчелд хэчнээн хүнд нөлөөлсний гэмийг танд тохоох үндэс алга даа. Дахин ийм гай тарихгүйг л хичээе. Нас залуу, цус шингэн болохоор тэсэж, яваандаа тайвширна байх лдаа. Тайвширч уужрахад нь та саад хийхгүй байвал сайнсан. Намайг зөвшөөрөхөөс наана та түүнтэй уулзах гэж оролдохгүй гэдэгт би итгэж болох уу?

Рэчел тэгж зовж, би өөрөө ч ингэж зовсон байж хаанаас тэгэх билээ.

Та амлах уу?

Амлаж байна.

Мистер Браффын дотор амрав боллолтой. Малгайгаа авч тавиад сандлаа минийхэд дөхүүлэн сууж.

За, энэ талаар хоёул тохирлоо! Одоо ирээдүйн тухай, таны ирээдүйн тухай ярилцъя. Уг хэрэг явдал онцгой маягтай болоод буйн шалтгаан товчхондоо доор үнэнийг ний нуугүй хэлсэн байх гэж бил итгэж байна. Нөгөө талаар Рэчел өөрийн нүдээр харснаар үл барам хэдийд, ямар нөхцөл байдалд болсныг ч худал гэхийн аргагүйгээр тоочоод таныг буруутан болгон зэмлэж байгаа явдалд мисс Рэчелийг буруутгах юм бидэнд алга, гэхдээ ямар нэгэн аймшигтай эндүүрэл, будлиан гарсан нь лавтай гэдгийг бид мэдэж байна гэхэд нь би үгийг нь тасалж,

Би Рэчелийг зэмлэхгүй, харин тухайн үед нь надад шууд хэлж, илэн далангүй, ярилцаагүйд нь л харамсах юм гэлээ.

Рэчел өөр хүн бишид нь та бас харамсаж болох байсан. өөр хүн байлаа ч гэсэн тантай суухаар сэтгэл зүрхээ зориулсан аилваа журамт бүсгүй танд хулгайн хэрэг улайм цайм тулгах нь юу л бол. цмар ч болтугай Рэчелд ийм чанар байсангүй. Түүнээс гадна хэрэв тэр үед ний нуугүй хэлчихсэн бол таны мэлзэж мэтгэхэд одоогийнх шигээ бас л үнэмшихгүйсэн гэж өнөө орой хот руу явах замдаа хэлж байдаг шүү. Ингэж байгаад нь та одоо ямар хариу өгч чадах вэ? цмар ч хариу өгөх аргагүй байна шүү дээ. Болиоч дээ, Фрэнклин минь, больсон нь дээр! Энэ хэргийн талаар миний бодож байсан бүгд буруу байж, би хүлээж байна, гэвч одоогийн байдлаас үзвэл миний зөвлөгөө хэрэг болж мэдэх юм шүү, Шулуухан хэлэхэд, бид цагаа дэмий үрж урьд чухам яалаа хэмээн эргэж хургаад ийм аймаар будлиантай юмны орооцолдоог эхнээс нь гаргах гэх юм бол тархиа ашиггүй зовоох болно. Иймд ноднин Вериндер ахайнд болсон тэр хэргийг шийдтэйхэн орхиод өнгөрсөн юмнаас олж чадахгүй зүйлээ ирээдүйгээс олж чадах эсэхээ үзье гэж мистер Брафф өгүүлэв.

Нэнэ бүх хэрэг надад холбогдохын хувьд ерөнхийдөө нэгэнт өнгөрсөн зүйл гэдгийг та мартжээ дээ? Гэсэнд

Надад нэг хариу хэлээдэх дээ, Саран чулуу л энэ бүх гай зовлонгийн үндэс болж байна уу, эсвэл үгүй юу? Гэж мистер Брафф мэтгэв.

цриангүй тийм.

За, тийм байж. Саран чулууг Лондонд аваачаад ясан гэж бодож байгаа билээ?

Мистер Люкерт барьцаа болгож өгсөн.

Барьцаанд өгсөн хүн нь та биш гэдгийг би мэдэж байна. Хэн өгснийг та мэдэх үү?

Мэдэхгүй.

Саран чулуу одоо хаана байгаа гэж бодож байна?

Мистер Люкерийн банкинд хадгалаастай байгаа.

цг зөв. Одоо бодоод үз. Зургадугаар сар аль хэдийн гараад байна. Энэ сарын шувтаргаар (чухам хэдний өдрийг яг таг хэлж чадахгүй) тэр эрдэнийн чулууг бидний бодож байгаачлан бинкинд хадгалуусаар бүтэн жилийн нүүр үзэх болж байна. Тэгэхээр барьцаанд хадгалуулсан хүн нь чулуугаа авахаар бэлдчихээд байгаа наад захын нэг боломж гарч ирж байгаа нь энэ. Тэр хүн юмаа авахад хүрвэл Люкер тогтоосон болзлын дагуу банкнаас тэр алмазыг өөрийн биеэр очиж авах ёстой. Нөхцөл байдал ийм учраас энэ сарын сүүлчээс эхлэн банкинд хяналт тавьж, Люкер ямар хүнд Саран чулууг өгөх нь вэ гэдгийг мэдэх хэрэгтэй байна. Одоо та учрыг ойлгож байна уу?

Миний бие үүнийг ямар ч атугай шинэ санаа юм гэж ялимгүй дурамжхан боловч арга буюу хүлээн зөвшөөрлөө.

Мистер Мэртвэйг бас яг ингэж бодож байгаа юм шүү. бид хоёр ярилцаагүйсэн бол ч миний толгойд ийм санаа ер орохгүй байсан байх. Мистер Мэртвэйгийн таамаглал зөв бол энэтхэгүүд бас банкийг ахруулдана байх, тэгэхээр энэ сарын сүүлчээр нэг сүрхий юм болж мэднэ. Юу болох нь та бид хоёрт хамаагүй, харин алмазыг барьцаанд өгсөн тэр үл мэдэгдэх этгээдийг л олоход нэмэр болох юм. Тэр хүн бол чухам таныг одоо ийм байдалд оруулсан (чухам яаж гэдгийг мэдэмхийрч хэлээд ч яахав) гэмт этгээд мөн гэдгийг та лавтай үнэмших бөгөөд тэр хүн л таныг Рэчелийн өмнө цагаатгах учиртай юм.

Таны энэ санаа бол эл бэрх зүйлийг шийдэхэд зоригтой, ухаалаг, цоо шинэ арга болохыг би үгүйсгэж чадахгүй гэхдээ...

Гэхдээ зөвшөөрөхгүй юм байна гэж байгаа хэрэг үү?

Тийм ээ, Таныхаар бол бид хүлээх ёстой болж байна, үүнийг чинь зөвшөөрөхгүй.

Тийм шүү. миний багцаалж буйгаар бол хоёр долоо хоног орчим хүлээх хэрэгтэй их удаан санагдаж байна уу?

Мистер Брафф минь, над шиг болчихоод байгаа хүнд бүх насаараа хүлээнэ гэсэн үг. Даруйхан энрээ цэвэрлэх талаар даруйхан, бага ч болтугай юм хийхээс нааш амьд явах тэвчимгүй болоод байна.

Аргагүйдээ, рагагүй би ойлгож байна. Харин та юу хийхээ бодчихоод байгаа юу?

Эрүүлч Каффаас зөвлөгөө авъя гэж бодож байна.

Цагдаагийн албанаас чөлөөнд гарсан шүү дээ. Түрүүч танд тус болно гэж горьдоод дэмий дээ.

Хаана байгааг нь би мэдэж байгаа болохоор гомдлын мөрт гуйгаад үзвэ.

Мистер Брафф бодолхийлснээ,

Тэг л дээ. Энэ хэрэг эрүүлч Каффын гардаж явуулсан мөрдлөгийн үеийнхээс онцгой өөрчлөгдсөн болохоор таныг хэлэхээр хөөцөлдөөд үзье гэж сонирхож магадгүй. Хэлээд үз, юу болсныг надад дуулгаарай. Ингэхэд гэснээ босож өгүүлрүүн: -Хэрэв та энэ сарын эцэс хүртэл хэргийн учрыг илрүүлж эс дөнгөвөл би өөрийн зүгээс банкийг харуулах ажил хийх үү, яах вэ? гэв.

Тэгэлгүй яах вэ. үүнийг хөөцөлдөх чухал үүргээс таныг чөлөөлөөгүй цагт та хөөцөлдөнө шүү.

Мистер Брафф инээмсэглээд малгайгаа өмсөнгөө.

Алмазыг барьцаанд өгсөн хүнийг олох эсэхээс үнэн эсэх шалтгаална гэж намайг хэлж байна гээд түрүүч Каффт дамжуулаарай. Бас эрүүлч энэ талаар ямар бодолтой байгааг надад сонсгоорой гэв.

Бид хоёр ийнхүү салав.

Маргааш нь миний бие Дорьин хэмээх жижиг хот орохоор өглөө эрт явлаа. Түрүүч албанаас огцроод тэнд суух болсон гэж Бэттереж надад хэлсэн юм.

Зочид буудлаар нь ороод эрүүлчийн зуслангийн байрыг хэрхэн олж очихыг заалгав. Тийшээ хөдөөгийн хөл хөдөлгөөнгүй замаар явж хүрэх ба холоос зайдуухан хоёр тал, араараа бөх бат тоосгон ханатай, урд талдаа ум хумгүй босгосон боллолтой өндөр шургууг хашаа бүхий цэцэрлэгийн дунд эвтэйхэн бүгсэн байртай ажээ. Дээд талдаа хээ хуартай явган хаалга нь цоожтой байв. Хонхыг нь дараад сараалж завсраар шагайсанд алдарт Каффын дуртай цэцгүүд энд тандгүй харагдав. Цэцэрлэг дотор байтугай хаалга үүд, цонхны нь хавиар цэцэгс үзэсгэлэнтэйеэ алаглана. Хулгайдчын

аянга болсон алдар цуут эрүүлч Кафф эдүгээ гэмт хэрэг, их хотын элдэв нууц явдлаас холдон насныхаа намрыг дуртай сарнай цэцгийнхээ дунд ийнхүү амар жимэр өнгөрөөж буй юмсанж!

Нэгэн намбатай хижээл авгай үүд онгойлгож өгсөн боловч түрүүч Каффтай уулзаж туслуулах горьдлого маань тасрав. Дөнгөж өчигдөр Ирланд руу явчихсан байлаа.

Ажлаар яваа юу? Гэж намайг асуухад авгай инээмсэглэж,

Эрхэм ээ, түүний ажил одоо зөвхөн сарнай цэцэг л болсон шүү дээ. Ирландын нэг том түшмэлийн цэцэрлэгч шинэ төрлийн сарнай ургуулсан гэж дуулаад сураглахаар явсан даа гэв.

Хэзээ ирэх бол, та мэдэх үү?

Төдийд гэж хэлэхэд тун хэцүү. Тэр шинэ зүйл нь дэмий санагдвал дорхноо буцаад ирнэ гэсэн. Танд хэлэх юм байгаа бол би дамжуулъя, эрхэм ээ.

Би нэрийнхээ хуудсан дээр “Саран чулууны талаар хэлэх юм байна. Та ирсэн гэдгээ надад даруй мэдэгдэнэ үү” гэж харандаагаар бичээд орхилоо. Ингээд л тухайн шаардлагаар Лондон руу шууд буцахаас өөр арга байсангүй.

Өгүүлэн буй үед миний сэтгэл санаа их бухимдуу байсан тул түрүүч Каффын очоод уулзаж чадалгүй буцсандаа улам их цухалдаж зүгээр сууж чадахгүй болчихсон билээ. Тэгээд Доркингоос буцаж ирсэн өдрөө миний бие уг хэрэг явдлыг ийнхүү харанхуй шөнө шиг байлгахыг больж заавал гэгээн өдөр гаргаж ирсэн мэт болгохын тулд ямар ч бэрхшээл тохиолдсон хамаагүй, маргааш өглөөнөөс л эхлэн бүхий хүч чадал оюун ухаанаа дайчилъя хэмээн шийдсэн юм.

Чухам юу хийе гэж би шийдэв?

Уг асуудлыг тийнхүү эргэцүүлэн бодож байхад сүрхий ухаалаг Бэттереж гуай миний хажууд байгаад дотроо юу бодож буйг минь тааварласан бол тухайн тохиолдолд герман боловсрол чинь аргагүй л давамгайлж байна даа гэж гарцаагүй хэлэх байсан буй заа. Ер нь тоглоом ч үгүй хэлэхэд, ашиггүй есөн шидийн юм болж бясалгасаар хаашаа гарах зүгээ ч мэдэхгүй хонгилд ороод мухардах шиг болсон маань герман боловсролын үр байж магадгүй л юм. бараг шөнөжин тамхи баагиулан суухдаа түрүү түрүүчийнхээсээ илүү адармаатай элдэв онол зохиосоор унтах гээд хэвтээл сэрүүндээ бодсон зүйлс зүүдэнд ороод болдоггүй. өглөө босоход толгойд бодит-хийсвэр, хийсвэр-бодит бөөн бодол эх толгойгүй хутгалдчихсан байлаа. Миний бие амьдралынхаа бас нэг өдрийг угтахдаа ер нь аливаа зүйл (нөгөө алмазыг оролцуулан) оршин буй эсэхийг (гагцхүү гүн ухааны үүднээ) авч үзэх эрхтэй хүн эсэхээ нотлохын шинэ буюу дараачийн алхам хийхээр сэтгэл шулуудсан юм.

Хэрэв өөрийнхөө зохиосон эх захгүй будлианаас мултрах гэж оролдсон бол тэр манан буданд дунд хэчнээн хугацаагаар төөрөлдөх байсныг хэлэх баримжаа надад үнэндээ алга. Аз болоход хэрэг явдал аяндаа эргэж миний аминд орсон юм. Тэр өглөө би урьд Рэчелтэй уулзаж ярилцахдаа өмсөж байсан цуваа өмссөн юм. Нэг юм эрж халаасаа тэмтэрч байтал үнгэгдэж эхэлсэн жаахан цаас гарч ирснийг үзвэл Бэттереж гуайн захидлыг хийгээд мартсан байжээ.

Үнэнч сайн хуучин андаа хариу бичихгүй бол гомдох буй заа гэж бодоод ширээнээ сууж захиаг нь дахин уншив.

Нэг их чухал биш захидалд хариу өгнө гэдэг тэр бүр хялбар ажил биш билээ. Бэттереж гуайн захидал тиймэрхүү захидалд багтах байв. мистер Кандийн туслагч буюу өөрөөр хэлбэл, Эзра Женнингс надтай уулзлаа гэж эзэндээ хэлэхэд, намайг Фризинхолл хавиар очвол надтай уулзаж нэг юм дуулгах юмсан гэж эзэн нь хэлсэн гэнэ. Цаас дэмий гарздахгүй гэж бичсэн зүйлийн хариуд юу бичих ёстой билээ? Би хааш яаш суугаад уг нь Бэттереж гуайд хариу бичихээр зэхсэн хуудсан дээр мистер Кандийн хачин туслагчтай төстэй дүрс сараачиж байтал тэр давилуухан Эзра Женнингс миний замд дахин хөндөлсөж байх шиг гэнэт санагдав! Алаг үстэй дор хаяад арван хоёр дүрс (үс нь тухайн бүрт гайхмаар адилхан болж байв) гаргаснаа хогийн сагс руу чулуудчихаад тэр даруй Бэттереж гуайд хариу бичив. Энэ бол ёстой л эгэл захиа байсан боловч надад нэг талаар сайн нөлөө үзүүлсэн билээ. Жирийн англи хэлээр цөөн өгүүлбэр бичсэн маань урьд өдөр нь тархи толгойд дүүрэн чихээстэй байсан хамаг хог новшийг хуу цэвэрлэв.

Тайлагдашгүй оньсого шиг болсон өөрийнхөө байдлыг тайлбарлах санаатай дахин оролдохоо тохиолдох бэрхшээлийг бодит байдалд тулгуурлан угтъя гэж шийдлээ. Тэр нэгэн дурсгалт үдэш болсон явдлыг огт санахгүй байгаа учраас түүнээс нэлээд урьдын явдлыг энхэн санаж улмаар тэр өглөөгүүр юу юу болсныг дурсан таавар шиг болчихоод буй байдалдаа таарах түлхүүр олохыг хичээсэн юм.

Рэчел бид хоёр хаалга будаж дуусах үед ямар нэг юм болсон билүү? Дараа нь Фризинхолл явахад яалаа? Сүүд нь Годфри Элбвайт болон дүү нартай нь цуг буцаж ирэхэд яалаа? Саран чулууг Рэчелд гардуулан өгөх үед яасан билээ? Мөн зочид бүгд ирээд хоолны ширээнд сууцгаасан хойно яалаа? Энэ мэтээр тодорхой санаж байвч сүүл рүүгээ юм ч толгойд орохоо больчихоод байлаа. Зоог ббарьсан үеэс эхлэн юу юу болсныг ер санахгүй, тэр ч бүү хэл надтай хамт хэчнээн гийчин сууж байсныг хүртэл хэлж чадахгүй байлаа.

Нэгэнт энэ талаар огт юу ч санахгүй байгаа тул зоог найрын үед чухам юу юу болсныг магадлан үзэх нь зүйтэй гэж болсон билээ. Миний адил байдалд эргэлзэнэ. Ер нь хүн өөрийн ашиг тусын тулд аливаа зүйлийг довруулахын үүднээс өөрийгөө шалгаж үзэхэд хүрвэл үл мэдэх зүйлийг үнэндээ тун хартайгаар үздэг. Зоогонд байсан хүмүүсийн нэр усыг мэдээд авбал тэдний дурсамжийг сонсож тэмдэглээд өөрийн санахгүй байгаа зүйлийг нөхөж, хожим зочид тарсны дараа болсон явдлуудтай зүйрлэн үзэж, шалгая гэж бодлоо.

Мөрдөн шалгах урлагийн талаар миний бясалгасан аргууд дотроос хамгийн сүүлчийн бөгөөд цоо шинэ энэ арга аяндаа ажил хэрэгт маань тус болох авч Бэттереж гуай сонсвол тухайн үед миний толгой сэргэлэн гайлж байсныг гэх буйзаа. Юу ч гэж бодлоо гэсэн миний бие уг хэргийн үндсийг хөөх замаа оллоо. Эхнээсээ л зөв хөтлөх баримжаатай болохыг би хүссэн юм. Бас нэг өдрийг дэмий өнгөрөөхөөс өмнө тийм нэг баримжааг нөгөө төрсөн өдрийн найранд оролцсон нэг хүн гаргаж өгөв!

Үдээс өмнө Лондогоос явах галт тэрэгнээс ам мөлтөс хожигдсон байлаа. Дараачийн явах галт тэргийг гурван цаг орчим хүлээхээс өөр арга байсангүй. Тийн хүлээх зуур хийж амжуулах шаардлагатай чухал ажил юу байдагсан билээ?

Хамаг бодол санаа нөгөө л төрсөн өдрийн зоог тийш тэмүүлэх ажээ. Хэдийгээр кочдын тоо, тэр байтугай олных нь нэрийг мартсан боловч ихэнх нь Фризинхолл, түүний хавиас ирсэн гэдгийг дорхноо саналаа. Гэвч ихэнх гэдэг бол бүгдээр гэсэн үг биш. Зарим нь тэр нутгийн хүн биш байсан. Би ч тэр цөөнхийн тоонд орно. Бас мистер Мэртвэйт мөн Годфри Эблвайт гурав дахь мистер Брафф үгүй ээ, ажил төрөл болсонгүй гээд ирж чадаагүй шүү дээ. Лондонд суудаг эмэгтэйчүүд ирсэн билүү? Мисс Клакаас өөр хүнийг санахгүй байх шив. Цмар боловч эндээс гарахын өмнө гурван хүнтэй уулзаж авах нт чухал юм байна. Уулзах гэсэн хүмүүсийнхээ хаягийг мэдэхгүй учир мистер Браффыг тус болох магад гэж бодоод ажил руу нь тэр даруй явлаа.

Мистер Брафф туйлын их ажилтай байсан тул нада нэгээс илүү минут зарцуулж чадсангүй атлаа тэр ганц минутандаа миний сэдсэн бүх асуудлыг урам хугармаар өөрчлөх нь тэр.

Нэгдүгээрт, оньсого таавар мэт байгаа зүйлийн учрыг олоход тараах түлхүүр болно гэж бодсон миний шинэ аргыг ултай авч хэлэлцье гэхэд нялх хүүхдийн бодол шиг дэндүү гэнэн юм гэв. Хоёр, гурав, дөрөвдүгээрт ч өөрцгүй мистер Мэртвэйт одоо хуучин адал явдлынхаа замд дахин орохоор явсан байв. Мистер Клак баахан мөнгөний алдагдалтай болж мөнгө бага үрэх гэсэндээ Францад суух болжээ. Годфри Эблвайтыг Лондонгоос эрж олно гэдэг дурын хэрэг биш гэнэ. Клуб дээр нь очвол хаягийг нь хэлж өгөх болов уу? эсвэл одоо мистер Брафф намайг замдаа сайн яваарай гээд ажилдаа орлоо гэхэд надад мөчөөрхөх юм байна уу?

Лондонд эрэн сурвалжлах ажлын маань хүрээ Годфрийн хаягийг зааж өгөөд миний чихэнд урьд орсдоогүй, нэлээд чухал хоёр ч явдал түүнд тохиолдсоныг дуулгав.

Годфри, Рэчелтэй суух гээд бүтэлгүйтсэндээ зориг огтхон ч мохсонгүй, харин ч төдхөн асар их өвлөх хөрөнгөтэй гэж олны шагшин ярилцдаг өөр нэг залуу авхайг гуйсан гэнэ. Нааштай хариу авсан болохоор нэгэнт гэрлэх нь мадаггүйд тооцогджээ. Гэтэл хэрэг бас гэнэт бишдэж, гэрлэх ажил нь бүтэхээ больсон гэнэ. Учир нь юу байсныг шивэр авир ярилцахдаа зарим болзол дээр ирээдүйн хадам эцэг, хүргэн хоёр хэл амаа ололцоогүй гэлцэнэ.

Годфри тийнхүү хоёр дахь удаагаа шившгээ тарьж, бүтэлгүйтээд байтал гутах өдөр байхад баярлах өдөр бас байдаг гэсэн мэтээр урьд өөрт нь сүйд болдог агсан олон хүүхнүүдийн нэг түүнийг бахдан биширдэг байснаа дурсан санаж гэнэ. Тэр баян хөгшин авгай (“Хувцас хасах эхчүүдийн нийгэмлэгт” ихээхэн нэр хүндтэйгээс гадна мисс Клакийн дотны найз учир түүнд гашуудлынхаа бөгжнөөс бусад юмбг бүгдийг өгнө гэсэнг) гайхам гоолиг, их гавъяатай Годфрид таван мянган фунт өв болгон өгч гэнэ. Годфри тэр их мөнгийг аваад бага сага хөрөнгө дээрээ нэмсэн, өмч нь буяны ажил төрлөөс түр холдон амсхийх шаардлагаар “эх газар очиж марвал эрүүл мэндэд нь тустай” гэж зөвлөсөн ажээ. Түүнтэй уулзъя гэж байгаа бол цаг алдалгүй очих хэрэгтэй болжээ.

Тэгээд би тэдний рүү даруйхан явлаа.

Түрүүч Каффтай ганц өдөр хожуу очиж ам мөлтөс зөрсөн шигээ Годфритэй уулзахаас бас л өдрөөр хожигдсон байлаа. Урьд өдрийн өглөө нь Лондонгоос Дувр орох галт тэргээр гарсан байв. Тэндээсээ Остендыг дайрч, Брюссель орно байх гэж зарч нь хэлэв. чухам хэдийд буцаж ирэх нь тодорхойгүй боловч гадаадад наад зах нь гурван сар болох ажээ.

Би байрандаа урамгүйхэн буцаж ирэв. Төрсөн өдрийн баярт оролцсон гурван гийчин (гурвуул хамгийн ухаалаг) хамгийн чухал шаардлагатай үед уулзах аргагүй хол ббайдаг байна. Одоо Бэттереж гуай болон Вериндер ахайн найз нөхөдтэй л уулзах ганц горьдлого үлдэв. Тэднийг Рэчелийн хөдөөгийн байрны ойр хавиас олж магадгүй юм.

Ингээд би эрэн сурвалжлах ажлын төв болох ёстой Фризинхолл хотыг шууд зүглэв. Дэндүү оройтож очсон тул Бэттереж гуайтай уулзаж чадсангүй. Маргааш өглөө нь захиа бичиж, зочид буудалд аль болох түргэн ирж уулзаач гэв.

Нэгд, цаг алдахгүйн тулд: хоёрт, Бэттереж гуайд амрыг бодож захиагаа хөлсний тэргээр явууллаа. цмар нэгэн саад тотгор тохиолдохгүй л бол би Бэттереж өвгөнтэй тийнхүү хоёр хүрэхгүй цагийн дараа уулзах боломжтой болсон юм. Тэр зуур би эрэн сурвалжлах ажлаа үргэлжлүүлж төрсөн өдрийн найрт оролцсон гийчдийн дотроос танил бөгөөд уулзахад ойр дөт нэгтэй нь уулзаж асуухаар шийдлээ. Тийм хүмүүс гэвэл миний садан Эблвайтынхан, мөн мистер Канди байв. Доктор надтай уулзахын мөн болж байснаас гадна, зэргэлдээ гудамжинд суудаг байсан учраас би эхлээд түүнтэй уулзахаар явав.

Тэр эмч их л хүндээр өвдсөн гэж Бэттереж гуай надад ярьж байсан болохоор царайд нь өвчний ул мөр үлдсэн байх гэж бодсон авч тэгтлээ хувирсан юм гэж даанч бодоогүй тул орж ирээд гар барихад нь ихэд гайхсан билээ. Нүдний нь жалх арилж, үс нь цал бууралгаж, нүүр нь үрчийн, нуруу нь бөгтийсөн байв. урьдын марзан, цовоолог, хэл ам нь гүйцэлдэхгүй алиа, гэмгүй шалиг зантай байсан палдгар эмч маань огт өөр болж гагцхүү эв дүйгүй дэгжирхэн гангалах санаа нь л үлдсэн байлаа. Хүний хувьд нэгэнт өнгөрсөн атал ингэтэл хачин хувирсны нь тавлан тохуурхах гэсэн юм шиг өмссөн хувтцас, зүүсэн эрдэнэс нь уртдын адил их л дэмжин гял цал бууна.

Мистер Блэйк, та миний санаанаас гардаггүй юм, ингэж нэг дахин уулзсандаа сэтгэлийн угаас баярлаж байна. Танд тус болж чадах юм байвал би байдгаараа зүтгэнэ шүү, эрхэм ээ байдгаараа зүтгэнэ! Эмч энэ хэдэн ердийн үгийг дэмий их яарч, сүржигнэн хэлэхдээ миний хүүхэд ммэт гэнэн бодлоор бол намайг Иоркширт ямар зорилгоор ирсэн юм бол гэж тэсэж ядан сонирхож буйгаа нууж чадахгүй байлаа.

Би энэгнт тодорхой зорилготой яваа болохоор, эрэн сурвалжлах ажилд голдуу танихгүй шахам хүмүүсийг ёдах ядахаар надад туслах хэрэгтэй юм гэж үнэмшүүлэхийн өмнө хувийн зүгээс тайлбарлах хэрэг зайлшгүй гарна гэдгийг мэдэж байсан л даа. Фризинхоллд ирсэн учраа юу гэж хэлэхээ урьдаас төлөвлөчихсөн тул одоо энэ завшааныг ашиглаж миний тайлбар мистер Кандид хэр нөлөөлж чадахыг нь харахаар шийдэв.

Би Иоркширт саявтар ирээд явсан боловч одоо дахин нэг сонин ажилтай ирлээ. Мистер Канди минь талийгаач Вериндер ахайн бүх найз нөхдийн сонирхож байгаа нэг хэргээр ядна даа. Бараг жилийн өмнө энэтхэг алмаз хачин жигтэйгээр алга болсныг та санаж багйаа биз дээ? Сүүлийн үед гарсан хэрэг явдлуудаас тэр эрдэнийн чулуу олдож болмоор байгаа тул энэ гэр бүлийн хүнийхувьд миний бие түүнийг илрүүлэх сонирхолтой байгаа юм. Тэр үеийн гэрч баримтыг бүгдийг дахин цуглуулах, чадвал шинийг нэмж олох тун ярвигтай сүрхий ажил байгаа юм. Мисс Вериндерт төрсөн дөрийнх нь орой чухам юу юу болсныг нэхэн санах гэсэн хүслийг надад төрүүлсэн уг хэрэгт хэд хэдэн онцлог шинж байгаа юм. Тэгээд ч миний бие тэр орой тэднийд байлцсан талийгаач эхийнх нь найз нөхдөд хандаж дурсамжаараа надад тус хүргэнэ үү гэж гуйхаар шийдлээ... гэж би ярилаа.

Ингэж ярьчихаад өөдөөс нь хартал миний үгийг тоосон шинж Канди гуайн царайд огт үгүйг би даруй ммэдэв.

Палдгар доктор миний ярианд залхсан янзтай хумсаа мэрнэ. Нулимс цийлэгнэсэн жалхгүй нүдээр намайг тун ёозгүй ширтэх нь харахаас сэтгэл зовмоор. Юу бодож байгааг нь тааварлахуйяа бэрх. Эхний хоёр, гурван үгээс хойш миний яриаг огт анхаарч чагнаагүй нь тодорхой байлаа. өөр бодолд дарагдаж мэлийчихсэн түүнийг бодлыг сарниулахын тулд ярианыхаа сэдвийг өөрчлөх ёстой болжээ.

Тэгээд шууд өөр юм ярьж эхлэв.

Фризинхоллд ирсэн хэрэг маань гэвэл ийм л байна! Одоо таны ярих ээлж боллоо гэж би хөгжилтэйгөөр хэлээд, -Та Габриэл Бэттережээр, надад нэг юм хэлнэ гэсэн байв уу... гэтэл доктор хумсаа мэрэхийг больж, царай нь гийн,

Тэгсэн! Тэгсэн! цг үнэн! Танд нэг юм хэлье гэсэн юм! Хэмээн дуу алдав.

Бэттереж гуай тэр дор нь надад захидлаар мэдэгдсэн. Энэ хавиар ирвэл уулзаж, нэг юм хэлэхсэн гэж байна гэсэн. За мистер Канди би ирчихээд байна шүү дээ!

Та ирчихээд байна! Гэж доктор цууриа шиг давтаад-Бэттережийн бичсэн яриангүй зөв. Үнэхээр танд нэг юм хэлэх гэсэн юм. Тэгээд хэлүүлсэн юм л даа. Бэттереж гайхмаар сайн хүн байна. цасан мартдаггүй юм бэ! Тийм настай хүн байж, ухаан нь хэвээр байна шүү! гэв.

Тэгснээ гэнэт дуугүй болоод дахиад л хумсаа хэмэлж гарав. Халуун хумхаа ой тойнд нь балаг тарьсан юм гэж Бэттережийн өгүүлснийг санаад яриагаа үргэлжлүүлэхийн тулд үг өдөж,

Та бид хоёр уулзалгүй их удаж шүү ! Хөөрхий талийгаач нагац маань Рэчелийн төрсөн өдрөөр эцсийн удаа биднийг дайлахад л уулзсан шүү дээ гэлээ.

Тийм шүү! хэмээн мистер канди дуу алдаж –төрсөн өдрийн нарийн дээр! Гээд гэнт огло харайн босож миний өөдөөс ширтэв.

Толиогүй болсон царай нь гээнт барайн улайж, хэзээ ч мэдэгдэхгүй нууж явах ёстой байсан сул талаа илчилчихлээ гэж сандрах мэт шалавхан буцаж суув.

Ой ухаан нь аргагүй л муудсныг өөрөө мэдэж буй бөгөөд найз нөхдөөсөө нуух санаатай оролдох нь улам ч өрөвдмөөр ажээ.

Би саяхан болтол түүнийг өрөвдөхөөс цаашгүй байсан бол түүний хэлсэн үг хэчнээн цөөн ч гэсэн миний сонирхлыг нэн хүчтэй татсан юм. Нэгэнт өнгөрсөн тэр төрсөн дөрийн зоогийг миний бие найдвар төрөхийн хамт горь тасран хачин сэтгэгдэлтэйгээр эргэн санах бөлгөө. Мистер Кандийн надад хэлэх гээд байгаа учхал юм нь тэр л зоогтой гарцаагүй холбоотой аж!

Би түүний сэтгэлийг тайвшруулан тус болохыг оролдов. Гэхдээ сэтгэлийн угаас сонирхон буй юм маань зорьсондоо түргэн хүрэх юмсан гэж шавдуулж байлаа.

Тэр сайхан найрын ширээнд сууж байснаас хош бараг бүтэн жил өнгөрөх гэж байна даа. Та дэвтэртээ тэмдэглэл хийгээ юу, өрөөр хэлбэл надад хэлэх гэсэн юмаа тэмдэглэсэн байсан юм уу? гэж би асуулаа.

Мистер Канди миний санааг ойлгосноор үл барам бүр доромжиллоо гэж үзсэн нь андашгүй болов.

Мистер Блэйк надад тэмдэглэл ч хэрэггүй. Би насандаа хараахан дарагдчихаагүй, ой ухаан маань ч тэнгэрийн авралаар наддаа болоод л байгаа юм шүү! гэж нэлээд зэвүүн хэлэв.

Миний хэлсэн үгэнд гомдсоны нь мэдээгүй царайлснаа энд дурдах хэрэггүй биз ээ.

Миний ой той бас л тийм гэдгийг хэлмээр байна. Жилийн өмнө болсон ямар ч юмыг олигтой сайн санахад хэцүү дээ. Жишээ нь, Вериндер ахайнд болсон нөгөө зоогийн тухайд... гэмэгц мистер Кандийн царай дахин гийж, малилзаад ирэв.

өө тийм! Вериндер ахайнд болсон зоог уудаа! Хэмээн жигтэйхэн дуу алдаад, -Тэр тухай би танд нэг юм хэлэх гэсэн юм гэв.

Тэгснээ дахиад л харахаас урам хугарам өрөвдөлтэй, гайхсан, арчаагүй\_ хачин хоосон харцаар өөдөөс мэлийтэл ширтэв. Мартсан зүйлээ нэхэн санах гэж хэчнээн хүчлэвч талаар болж буй нь илт байлаа. “нээрэн сайхан найр болж билээ” хэмээн хэлэх гэснээ толгой дохин инээмсэглэв. Ой ухаан нь хэвээрээ байна гэж надад үнэмшүүлж чадлаа гэж хөөрхий минь, бодов бололтой.

Мартснаа санаасай гэж би хэчнээн хүсэвч түүний байдал даанч сэтгэл зовмоор байх тул орон нутгийн чанартай аар саар юм ярилцаж эхлэв.

Иймэрхүү юмыг овоо торохгүй ярих ажээ. Хотынхны дунд сар оорчмын өмнө шивэр авир сонсдож байсан хов жил,\_ хэрүүл маргааныг андахгүй мэт байв. бараг урьдынх шигээ түгдрэхгүй ярьж хөөрч байвч заримдаа таг болоод юу хэлэх гэснээ мартаж өөдөөс мэлийн ширтэж, биеэ барьснаа цааш үргэлжлүүлнэ. Би зовлонгоо хүлцэнгүй тэсвэрлэж байтал (хөдөөгийн суурингийн хов живийг дув дуугүй, хүлцэнгүй сонсох нь ертөнцийн юм бүхэнд сэтгэл зовч явдаг хүний зовлонг бодвол юу ч биш биз дээ?) задгай зуухан дээр байсан цагийн хонх миний айлчлал хагас цаг гаруй хэтэрснийг дохиолов. Хохирч дууссанд тооцох эрх бүхий болсон миний бие явахаар босов. Гар барих зуур мистер Канди өнөөх төрсөн өдрийн зоогийн талаар нэхэн санах гээд үзэв.

Дахин уулзсандаа үнэхээр баярлаж байна. Мистер Блэйк би тантай ярилцъя гэж бодоод явсан юм. Вериндер ахайнд болсон зоогийн тухайд шүү дээ, мэдэв үү? Их сайхан найр болсон, үнэхээр сайхан болсон, тийм ээ?

Хэлсэн үгээ тийнхүү давтахдаа түрүүчийнх шиг ойтой нь самуураад надад сэжиг төрүүлснээ арилгах санаа агуулав. Боллолтой гөлийсөн харц нь царайг нь дахиад л биш болголоо. Уг нь намайг гадагш гаргаж өгөх санаатай байснаа өрөөндөө үлдэв.

Энэ хүн надад үнэхээрийн чухал нэг зүйл хэлэх байснаа санаж яагаад ч дөнгөсөнгүй дээ хэмээн урамгүйхэн бодож, эмчийн шатаар аажуухан уруудаж явлаа. Эмч хэлэх гэж байсан юмаа санагч гэж чармайвч доройтсон ухаан нь даанч тус болсонгүй.

Шатны эцсийн гишгүүрт хөл тавьж, гадагш гарахаар өрөөний буланг тойртол доод давхрын нэг өрөөний үүд аяархан нээгдэж, нэг хүн эелдэг зөөн дуугаар,

Эрхэм ээ, мистер Кандийн байдал их өөрчлөгдсөн байгаа биз? Гэхэд нь эргэн харвал Эзра Женнингстэй улаан нүүр тулав.

## IX бүлэг

Эмчийн царайлаг шивэгчин гадагш гарах хаалга нээгээд намайг хүлээн зогсоно. өглөөний нарны тунгалаг туяа үүдний өрөөг гэрэлтүүлэх агаад мистер Кандийн туслагч руу эргэн харахад нарны туяа нүүрэн дээр нь яг туссан байв.

Эзра Женнингсийн нүүр царай үнэхээр барагтайхан гэж нийтээр хэлэлцдэг юм гэж Бэттереж гуайн хэлснийг мэтгэх үндэс алга ажээ. Цыганархуу зүс, ёрдойсон нүд, хачин этгээд өнгөтэй үс,

хөгшин ч юм шиг залуу ч юм шиг харагдуулдаг эрс харшлах нүүр царай бие цогцос энэ бүгд нь танихгүй хүнд их бага боловч давхийн цочмоор эвгүй сэтгэгдэл заавал төрүүлэх ажээ. Надад ч гэсэн тиймэрхүү сэтгэл төрсөн сөртлөө яах аргагүй аятайхан санагдах тал Эзра Женнинигст байгааг ор тас үгүйсгэж болохгүй билээ. Тавьсан асуултынх нь хариуд үнэхээр Канди гуай харамсмаар их өөрчлөгдсөн байна гээд гарах ёстойг мэдэж байсан хэрнээ Эзра Женнингсийг сонирхон хадагдсан мэт зогтуссан маань эзнийхээ талаар надтай аминчлан ярилцахыг эрэлхийлэн байсан түүнд энэ бололцоог нь олгожээ.

Бүр малгайгаа барьсныг нь ажиглаад,

Мистер Женнингс, та бид хоёрын явах зам таарч байгаа юм биш биз? Би нагац эгч Эблвайт хатагтайнд очих гэж байна гэлээ.

Эзра Женнингс нэг өвчтөн үзнэ, явах зүг таарах юм байна гэв.

Тэгээд бид хоёр хамт гарав. Намайг баяртай гэж хэлэх үед эелдэг аашлан, мишилзан байсан царайлаг шивэгчин бүсгүй, Эзра Женнингс хэдийд буцаж ирэх тухайгаа мэдэгдэхэд нь уруулаа жимийн, өөдөөс нь харахын оронд зориуд өөр тийш харж байхыг би ажиглав. Хөөрхий энэ доожоогүй эр тэр айлд ад болдог бололтой. Гадаа гарсан хойноо, энэ хүн хаана ч явсан хүмүүс дургүй байдаг юм гэж Бэттереж гуайн хэлсэн үг санагдав. “Юү гээч амьдрал вэ!” хэмээн би довжоо уруудан явахдаа бодож билээ.

Эзра Женнингс, мистер Кандийн бие өвчтэй байгаа тухай өөрөө нэгэнт хэлсэн болохоор миний үгийг сонсох гэж “Одоо таны ээлж” гэсэн шиг зориуд дуугүй байв. эмчийн эрүүл мэндийн талаар үг хэлэх үндэс надад бий тул эхлэн ам нээх хариуцлагыг бэлхэнээ зөвшөөрч,

Тэгж өөрчлөгдсөнийг үзэхэд мистер Кандийн өвчин миний бодож байснаас хавьгүй ноцтой юм уу даа? Гэв.

Харин ч хөл дээрээ боссон нь гайхалтай хэрэг шүү.

Ой той нь ер нь өнөөдрийнх шиг байдаг хэрэг үү? Надтай нэг юмны тухай ярилцах гэж оролдлоо.

өвчин тусахаасаа өмнөх юмны тухай юу? Гэж Женнингс миний тээнэгэлзэхийг мэдээд асуулаа.

Тийм.

Урьдын явдлуудыг бүр санахаа болиод байгаа юм. Хөөрхий минь, зах сэжүүр төдий л зүйл үлдэж үү гэмээр даанч харамсалтай. Төлөвлөж байсан зүйлээ юмуу хэлж хийх гэсэн юмаа бүүр түүр санах аядавч юү төлөвлөж, бодож байсан эсвэл юү хийж, юү хийх гэж байснаа санахаа бүр болвсон. Ийм болсноо мэдээд ихэд гутарч, хүнээс нуух санаатай хачин их зовдог болсныг нь та ажиглаа биз дээ. өнгөрснийг таг мартан эдгэрвэл баярлахсан даа гээд гунигтайяа инээмсэглэсэнээ, -Хэрэв бид таг мартчихаж чаддагсан бол бүгдээрээ баярлана даа! Гэж нэмж өгүүлэв.

цавч мартаггүй явдал хүн бүхний амьдралд байдаг шүү дээ гэж би хэлэв.

Ихэнх хүнд нээрэн байдаг байх шүү, мистер Блэйк. Бүх хүнд гэвэл арай юу л бол. Саяхан тантай ярилцахдаа мистер Кандийн хэчнээн чармайгаад санаагүй тэр зүйл танд чухал хэрэгтэй байж болох уу?

Ийм үг аяндаа гаргаж ирснээрээ ёстой л загатнасан газар маажив гэгч болох нь тэр. Би энэ хачин хүнийг шохоорхохдоо юуны өмнө надтай ний нуугүй ярилцаасай гэж бодсон юм. Гэхдээ даруу төлөв, аятайхан эсэхийг нь лавтай мэдэж авахаас нааш эзнийх нь талаарх бодлоо хэлэхгүй юм шүү гэж бодсон билээ. Гэтэл амнаас нь гарч буй цөөн хэдэн үгнээс нь үзсэн ч тохитой томоотой хүн бололтой. Угаасаа гүндүүгүй хүн бол гану Англид төдийгүй ерөөс соёл иргэншилтэй ертөнцөд сайн хүний шинж гэж тооцогддог билээ. Дөнгөж сая асуусан зүйл нь ямар зорилго агуулсан ч бай, хамаагүй би огт түдгэлзэлгүй хариу хэлэхэд буруутах газаргүй байлаа.

Мистер Кандийн санахгүй байгаа зүйл надад үнэхээр чухал гэж би бодож байна. Нэхэн санах чадварыг нь сэргээх арга мэдэж байвал хэлж өгөөч гэж би танаас гуймаар л байна.

Эзра Женнингсийн мөрөөдөлт бор нүдэнд сониуч шинж гялсхийн тодорч, намайг ширтэв.

Мистер Кандийн ой ухаан яагаад ч нэмэргүй болсон. Бие нь илаарь болсон цагаас хойш би бишгүй олон удаа оролдсон. Энэ талаар лавтай хэлж чадах байна.

Ийм үг сонсоод миний урам хугарахад үүнийгээ ч нуусангүй.

Та арай горьдлоготой хариу сонсох найдлага төрүүлж байх шив дээ гэж намайг хэлсэнд Женнингс инээмсэглээд,

Мистер Блэйк энэ ч эцсийн хариу биш байж мэднэ шүү дээ. Мистер Кандийн мартсан дурсамжийг өөрөөс нь хоргоолгүй нэхэн хөөцөлдөж болох юу магад гэв.

Тийм үү? Хэрэв яаж ямар арга байна гэж асуувал дэндүү цаашилсан хэрэг болох боловуу%

Хаанаас даа. Таны асуултанд хариу гэхэд ганц бэрхшээл бол хэрхэн тайлбарлахад л байгаа юм. Би мистер Кандийн өвчний тухай дахин нэг ярьж, тэгэхдээ мэргэжлийн хүмүүсийн ярилцдаг хэдэн нарийн ширийн юм хэлж таныг чилээвэл таны тэвчээр хүрэх болов уу?

Тэгээч дээ! тэр нарийн ширийн юмыг шалавхан сонсох юмсан.

Намайг тэгтгэх сонирхсонд Эзра Женнингс гайхсан гэхээсээ таламжтай байсан гэвэл үнэнд дөхнө байх. Женнингс дахин инээмсэглэв. Энэ үед бид хоёр хотын хамгийн захын байшин өнгөрөөд явж байлаа. Эзра Женнингс зогтусан замын хажуугаас цэцэг таслан авч “Мөн сайхан цэцэг ээ!” гээд надад харуулснаа,

Англид энэ цэцэгийн сайхныг мэддэг хүн даанч цөөхөн байдаг юм! Гэв.

Та Англид бүх насаараа байгаагүй юм уу?

үгүй. Би бол манай нэг колони оронд төрж бойжсон хүн. Эцэг англи, харин эх маань ... мистер Блэйк та бид хоёр надаас болж ярьж байсан сэдвээсээ баахан хадуурчихлаа. Замын хажуугийн хашааны ёроолын энэ цэцэгтэй би их холбоотой хүн дээ. За, энэ ч яахав. Бид хоёр уг нь мистер Кандийн тухай ярилцаж байсан, одоо тэр утхайгаа ярилцъя.

өөрийнхөө тухай санамсаргүй ам алдсан хэдэн үг, хүний азжаргал бол өнгөрснийг таг мартаж байж л бүрдэнэ гэсэн амьдралыг хэрхэн үздэгээ илэрхийлсэн үхээнц үзлийг нь харьцуулаад наад зах нь хоёр зүйл яв цав үнэн болохыг би мэдлээ. Хүн хүнээс илүү зовлон амсчээ, мөн жинхэнэ англи хүн биш, эрлийз юм байж.

Мистер Кандийн өвчин анх юунаас үүдсэнийг мэднэ байх аа? Бериндер ахайнд болсон будаалгын шөнө ширүүн бороотой байсан. Манай эзэн харихдаа тэдний задгай сүүхэнд сууж яваад бороонд нэвч цохиулсан юм. Гэртээ орж ирэхэд нь хүнд өвчтөнийг үзүүлэхээр хүн ирээд хүлээж байж, Гай нь ирэхэд мистер Канди яарч, нойтон хувцсаа ч солилгүй гарчээ. яДахдаа би тэр шөнө Фризинхоллын хавьд нэлээд хол бас нэг өвчтөнийд саатсан юм л даа. өглөө нь буцаж ирэхэд мистер Кандийн дэлбэгч их сандарч тэвдчихсэн намайг хүлээж байсан бөгөөд эмчийн өрөөнд оруулав. Энэ үед нэгэнт өвчин нүүрлэж даамжирсан байлаа.

Халуун хумхаархуу л юм туссан гэж хэлсэн юмдаг гэж намайг хэлэхэд Эзра Женнингс,

Үүнээс өөрөөр нарийн хэлж чадах юм надад алга. Бүр эхнээсээ аваад адгаа хүртэл өвчин нь онцлог хэлбэртэй ббайгаагүй юм. Тэр даруй хот руу хүн явуулж, мистер Кандийн таньдаг хоёр доктороос санал зөвлөгөө авахад тун ноцтой өвчин туссан байна гэж надтай санал нийлсэн боловч эмчлэх аргын талаар тас зөрсөн юм. өвчтөнийхөө судсыг бариад бид өөр дүгнэлт хийж байв. нөгөө хоёр эмч, судасны цохилт хурдан байгаа учраас юуны өмнө халууныг дарах хэрэгтэй гээд байдаг. Гэтэл би, судасны цохилт түргэн байна, гэхдээ чул цохиж байгаа учир зүрх нь муу байна гэсэн үг учраас зүрхийг нь сайжруулах эм заавал хэрэглэх ёстой гэсэн юм. Хоёр эмч мистер Кандид будаа, жимсний ундаа, арвайн шөл гэх мэт л юм өгөх хэрэгтэй гэхэд нь би шарз юмуу, хатуу дарс, аммиак юмуу хининогье гэсэн юм. Сүрхий олон юмаар зөрсөн байгаа биз! Энэ хавьдаа алдар цуутай хоёр эмчийн үгээс эмчийн туслагч, танихгүй шахам нэг хүн зөрсөн хэрэг юм л даа. Эхний хэдэн өдөр аль ч талаараа надаасаа дээгүүр хүмүүсийн үгээр явахаас өөр арга байсангүй, өвчтэй хүн маань ч улам дордоод л байлаа. Тэгээд би судасных нь цохилтыг дахин зааж, хэн ч үзсэн тодорхой байна, хурдан цохидог нь хэвээр атлаа улам тамиргүй болж байна шүү дээ гэсэнд нөгөө хоёр эмч уурлаж,

женнингс гуай, нэг бол бид эмчилдгээрээ эмчилье, эсвэл та эмчил. За, юу гэж бодож байна? Гэв.

Эрхмүүд минь, надад таван минут хэртэй, бодох хугацаа өг, тэгвэл тэртэй тэргүй тодорхой асуудалд тодорхой хариу гарна гэлээ.

Таван минут өнгөрөхөд би ч хариугаа өгөхөд бэлэн болов. “Та хоёр сэргээж идэвхжүүлэх эмчилгээ хийхээс эрс татгалзсаар л байгаа юм уу?” гэж намайг асуухад нөгөө хоёр татгалзааж буйгаа нуршуу үгээр тайлбарлав. “Эрхмүүд минь, би өөрийнхөө аргыг одоохон хэрэглэлээ”. “Тэг, тэг. Женнингс гуай, өөрөө л мэд, бид энэ ажлыг орхилоо” гэв. Би зоориноос шил шампан дарс авчруулаад элбэг хагас аягыг өвчтөндөө өөрийн биеэр уулгалаа. Хоёр эмч ч малгайгаа дуугүй өмсөөд гарч одов.

Та өөртөө сүрхий хэцүү үүрэг хүлээсэн байна даа. Би л бол ингэхгүй байх гэлээ.

Мистер Блэйк минь, хэрэв та миний оронд байсан бол насан туршдаа ачийг нь санаж явах ёстой нөхцөлд мистер Канди намайг авч ажиллуулсан хүн гэдгийг эрхбиш санах ёстой. Хэрэв та миний оронд байсан бол энэ хорвоод өөртөө дэм болсон цорын ганц хүнийг харсаар байгаад үхүүлэхгүйн тулд юу ч хийхээс буцахгүй байхсан. Би өөрийгөө ямаршуу аймшигт байдалд оруулснаа мэдээгүй гэж таа бүү бодоорой. Ганцаардаж, өөртөө аймаар хүнд хариуцлага хүлээснээ хэнээс ч илүү ухаарч байсан цаг мөч надад зөндөө бий. Хэрэв би аз жаргалтай, амьдрал маань өлзийтэй байсан бол ийм сүрхий үүргийг дааж давахгүй даруулах байсан юм. Гэтэл надад эргэн санаж, бахархах жаргалтай амьдрал байсангүй. Үргэлж сэтгэл санааны зоюуртай учир битүүдээ зовох юм байхгүй болохоор эцсээ хүртэл үзээд алдсан юм. өвчтөний маань бие овоо гайгүй үед би ингэж үд дунд

амсхийж явна шүү дээ. Амь нас нь хутганы ир дээр байгаа бусад үед бол дэргэдээс нь салдаггүй юм. Нар шингэхийн алдад дэмийрч эхэлнэ. Ер нь халуун хумхаа туссан хүн заавал ингэдэг л дээ. Бараг шөнөжин дэмийрээд шөнийн хоёроос өглөөний таван цаг хүртэл хамгийн их тарчлахад хэчнээн чийрэг хүн ч тамир тэнхээгээ бүр барна. чухам энэ үед л үхэл олон хүнийг авдаг юм даа. Энэ үед л орон дээр байгаа хүнийг үхлийн гарт өгөхгүй гэж би үхэлтэй үзэлцсэн юм. Би эмчилгээнийхээ аргаас огтхон ч ухарч буцаагүй. Дарс нэмэргүй болохоор шарз хэрэглэв. Тэр мэтийн сэргээх зүйл нэмэр болохгүй болохоор тунгий нт хоёр дахин нэмэв. Ингэсний дараа өвчтөн маань нэг хэсэг яах нь мэдэгдэхгүй байдалтай байснаа (дахиад л ийм юм битгий болоосой гэж тэнгэрт залбирах юм) зүрхний цохилт ялимгүй ч гэсэн намдаж, бас цохилт нь дорвитой чадалтай болж зүгширсэн өдөр ирлээ шүү. Тэгэхэд нь л би аминд нь орсноо мэдэж, бие сулраад явчихлаа. Хөөрхий сайн нөхрийнхөө чөргөр гарыг тавиад уйлж билээ. Баярласандаа тэр шүү дээ, мистер Блэйк минь өөр юу байх вэ! Бие судлалын ухаанд зарим эр хүн эм хүн шиг байдаг гэсэн үнэн юм, би тийм амьтан юм л даа!

Нулимс асгаснаа ингэж шинжлэх ухааны хөдөлшгүй үндэстэй тайлбарлахдаа мөн л тайван хэвээрээ үнэн санаанаасаа хэлэв. црж буй өнгө маягаас нь ажихад миний сонирхлыг биедээ нэг их тгчих вий хэмээн дэндүү эмзэглэн хичээсэн мэт байлаа.

Цааш өгүүллүүн:

Ийм жижиг сажиг юм тоочин намайг залхаах хэрэг юу байна гэж та асууж болох юм. Гэхдээ мистер Блэйк минь чухам ингэж байж л танд хэлэх гэсэн дараачийнхаа юманд орохоос өөр арга алга. Одоо та, мистер Кандид өвчин тусах үед миний ямаршуу байдалтай байсныг яг таг мэдэж авлаа, тэгэхээр би сэтгэлийнхээ дарамтыг бага ч гэсэн хөнгөлөхийн эрхээр ямар нэг зүйл хийх шаардлагатай байсныг та амархан ойлгох болно. Би сүүлийн хэдэн жилд чөлөө цагаараа мэргэшил нэгт нөхдөдөө зориулж уураг тархи, мэдрэлийн системийн нарийн төвөгтэй асуудлын талаар нэг ном бичиж эхэлсэн юм. Номоо бичиж хэзээ ч дуусахгүй байх тэгээд ч ер хэвлэгдэхгүй нь лавтай. Гэвч ганцаардахын цагт надад олон удаа хань болсноор барахгүй мистер Кандийг сахиад сэтгэл шаналан хийх юмгүй үед цаг нөгцөөхөд тус болсон юм. Мистер Кандийг дэмийрдэг байсан гэж би танд хэлсэн байх аа?

чухам хэдийд дэмийрдгийг нь ч хэлсэн байх аа?

Хэлсэн.

Дэмийрч эхлэх үед нь би номынхоо яг ийм асуудал хөндсөн бүлэгт хүрээд байсан юм. Энэ сэдвийн талаар онолоо ярьж таныг чилээхгүй, гагцхүү одоо таныг сонирхож буй зүйлийг л ярья. Дэмийрэх үед ярих чадвараа алддаг нь уялдаатай сэтгэх чадвараа алдсаныг нотолдог гэдэг ер юу л бол гэж би эмчийн ажил хийдэг болсоор олонтаа эргэлздэг байсан юм. Хөөрхий Кандийн өвчин намайг энэ эргэлзээгээ сорих болосжтой болгов. Бихурдан бичлэгийг эзэмшсэн бөгөөд өвчтөнийхөө “дэгс догос яриаг” үг алдалгүй бичээд вч амждаг юм. Миний юу гэх гээд байгааг мистер Блэйк та одоо ойлгож байна уу?

Би тун сайн ойлгосон болохоор цааш юу ярихыг нь амьсгал даран хүлээж байв.

Тэгээд босон суунгаа хурдан бичлэгээр тэмдэглэж авсан юмаа жирийн бичигт буулгана, ярьж байгаад тасалдсан газар нь ганц үг ч байсан том зай үлдээн мистер Кандийн амнаас гарсан уялдаа холбоогүй үгсийг тэр чигээр нь буулгалаа. Тэгээд үзэхээр хүүхдийн толгой эргүүлэх бодлого шиг юм болно доо. Хаанаасаа эхэлсэн нь мэдэгдэхгүй, ёстой л холион бантан шиг юм байна. Гэвч аргыг нь зөв олбол дэс дараа, хэлбэр загварыг нь олчихож болдог юм. Ингэхдээ би үгүүдийн хоорондох онгорхой зайнуудыг энд тэнд хэлсэн үгээр утгы нь тааварлан бөглөх аргаар дахин давтан элдэв янзаар үзсээр байгаад урд нь байх ёстой юмыг хойно нь оруулалгүй, хойно нь байх ёстой юмыг урд нь оруулалгүй оролдсоор зохих байдалд нь болгочихно. Ингэж байсны ачаар сэтгэл дэнслүүлсэн их сул цагийг хий дэмий өнгөрөөгөөгүйгээр барахгүй өөрийнхөө онолын баталгаанд дөхөөд ирэх шитг санагдсан. Арай тодруулж хэлбэл, тасархай өгүүлбэрүүдийг нь эвлүүлээд үзэхэд өвчтөний маань сэтгэх дээд чадвар их бага боловч нэлээд уялдаатайгаар үргэлжлэн байдаг бөгөөд харин түүнийгээ үгээр илэрхийлэх доод чадвар нь бараг бүрмөсөн будилчихдаг юм байна гэдгийг мэдэж авсан юм гэж Эзра Женнингс хүүрнэв.

Ганц юм асууя! Дэмийрч байхдаа миний нэрийг дурссан удаа бий юу? Хэмээн би ихэд шамдан асуулаа.

Мистер Блэйк та одоо сонсох болно дөнгөж сая миний хэлсэн таамаглалын баталгаа болсон бичмэл зүйлсийн дотор буюу өөрөөр хэлбэл миний таамаглалыг сориход хэрэг болох бичээстэй туршилтуудын дотор таны нэр гарсан хэсэг газар бий. Та хоёрт холбогдолтой ямар нэг юмны тухай нэг шөнөжин мистер бодол болон завгүй байсан юмдаг. Би ч амнаас гарсан алдаг оног үг бүрийг нь нэг хуудсан дээр бичээд авсан. Тэгээд тасархай үгүүдийг нь холбох аргаар өөр нэг хуудсан дээр утга учрыг нь мөн цэгцлээд авсан л даа. Нийлбэр нь (энгийн тоо шиг) учир утга төгөлдөр мэдэгдэл

болсныг дурдвал, нэгдүгээрт, урьд нэгэнт бодитой үйлдсэн зүйлийн тухай, хоёрдугаарт, мистер Кандид өвчин тусаад саатуулчихаагүйсэн бол өөрөө ирээдүйд хийе гэж бодож байсан ямар нэг зүйлийн тухай байлаа. Өнөө өглөө таныг уулзахад нэг юм нэхэн санах гээд даанч чадаагүй нь энэ мөн байсан уу, үгүй юү гэдэг л байлаа.

- Эргэлзэх юм алга, мөн байж таарна! Одоохон буцаж очоод тэр бүгдийг чинь үзье.

- Тун боломжгүй юм.

- Яагаад?

- Та өөрийгөө миний оронд тавиад үз л дээ. Хэлэх нь зүйтэй гэж өөрөө лавтай мэдээгүй хэрнээ өвдөж зовж, арчаагүй болсон найз нөхрийнхөө амнаас өөрийн ухаангүй үед нь гарсан үгийг та өөр хүнд хэлэх үү? Гэж Эзра Женнингс дургүйцэв.

Ингэж хэлэхэд нь сөргөх аргагүй санагдсан хэдий боловч миний бие мэтгээд үзэхээр оролдлоо. Тэгээд,

- Иймэрхүү эгзэгтэй үед бол би хэлсэн үгий нь өөр хүнд дуулгаснаараа нөхөртөө балаг тарих эсэхийг бодож байж л хэрхэхээ шийднэ дээ гэв.

- Би ч энэ талаас нь аль хэдийн бодсон. Мистер Кандийн нууц байлгая гэсэн зүйлс тэмдэглэлд байхгүй л дээ, би устгачихдаг байсан юм. Нөхрийнхөө орны хажууд сахиж суунгаа туршин бичсэн гар бичмэлийн минь дотор хэрэв ухаан нь ордог юмаа гэхэд бусдаас нуучих юмсан гэхээр юм байхгүй. Таны хувьд гэвэл мистер Кандийн танд одоо хэлэх гээд байгаа зүйл бий байх гэж би лавтай бодож байна...

- Гэхдээ л та эргэлзэж байгаа юм уу?

- Гэхдээ л би эргэлзэж байгаа юм. Би ямар нөхцөлд тэр мэдээ сэлтийг олж авсныг та бодоод үз л дээ! Тэр бичгийг танд үзүүлээ гээд гэм болохгүй ч гэсэн, танас учрыг нь сайн дуулахгүй бол үнэндээ би танд өгч зүрхлэхгүй санагдаад байна. Цаадах чинь даанч өрөвдмөөр өвчтэй байсан хүн шүү! Тун ч арчаагаа алдан миний эрхэнд байса хүн! Та уучлаарай, түүний санахгүй байгаа зүйлийг сонирхож байгаагийнхаа учрыг зах зухаас нь ч болтугай надад хэлбэл яана? Эсвэл тэр мартсан зүйл нь юу байж болохыг хэлээс гэвэл миний зүгээс арай дэндсэн болохгүй биз?

Эзра Женнингсийн яриа, байдлыг үзвэл аргагүй л илэн далангүй хариулмар байсан авч энэ маань алмазны хулгайд сэрдэгдсэнээ шившигтэйгээр илчилнэ гэсэн үг юм. Энэ хүн надад анхнаасаа л аятайхан санагдаж, одоо бүр их таашааж байвч би тийм олхиогүй гутамшигт байдалд орчихоод буйгаа хэлчихэж зүрхэлсэнгүй. Тэгээд танихгүй хүмүүс сонирхож асуувал хэлнэ гэж бэлтгэсэн хариугаа өчив.

Энэ удаад миний үгийг сонссон хүн маань хайхрамжгүй хандах бүү хэл, харин ч намайг ярьж дуусан дуустал тун гэвчээртэй, тэр ч байтугай сэтгэл түгшин сонсож билээ.

- Мистер Блейк би таныг хий дэмий горьдоогоод урмыг тань хугалах нь, одоо яана даа. Мистер Канди өвдсөн цагаасаа одоо хүртэл алмаз иэрдэнийн тухай нэг ч үг цухуйлгаагүй шүү. Таны нэрийг дурдаж байсан зүйлд мисс Вериндерийн эрдэнэ алдагдсан буюу олдсон талаар холбоотой юм огт байгаагүй гэдгийг би танд лавтай батлан хэлэх байна.

Тийн өгүүлж байхад нь бид хоёр, салаа замын уулзвар дээр ирэв. Нэг зам нь мистер Эблвайтын байшин тийш, нөгөө нь хоёр гурван бээрийн тэртээ харагдах тал газрын тосгон тийш чиглэсэ ажээ. Эзра Женнингс тосгон орох зам дээр зогсоод,

- Би эн эзамаар явна. Танд өчүүхэн ч тус болж чадахгүйдээ би чин үнэнээсээ харамсаж байна, мистер Блейк минь гэлээ.

Үнэн голоосоо өгүүлж буй нь дууны нь өнгөнөөс андашгүй байв. Ноомой бүр нүдээрээ намайг өрөвдсөн шинжтэй хяламхийн харснаа мэхэсхийн ёслоод өөр юу ч хэлэхгүй тосгоны зүг одлоо.

Надаас улам холдсоор буй түүний хойноос ажиглан хэсэг зуур зогсохдоо миний эрж сурвалжлан буй зүглийн учрыг тайлах түлхүүрийг аван надаас улам улам холдож байна даа гэдэгт хатуу итгэж байв. Женнингс жаахан явснаа эргэж харлаа. Намайг түүнээс салсан газраа зогсож байхыг үзээд дахин ярилцах гэсэн юм болов уу гэж бодов бололтой. Би өөрийнхөө байдлыг миний амьдралд чухал эргэлт гаргаж болзошгүй боломжийг гагцхүү нэр төрөө хичээх нэрэлхүү зангаа дийлээгүйн улмаас алдаж буйгаа эргэцүүлэн бодож амжсангүй! Би Эзра Женнингсийг дуудчихсан хойноо л сая юу хэлэх гэснээ бодож билээ. Над шиг ийм хөнгөмсөг тэвдүү хүн энэ хорвоод ховор буй заа. Түүнийг дуудчихаад “Одоо өөр арга алга. Үнэнээ л хэлье дээ!” гэж бодлоо.

Эзра Женнингс шууд буцаад алхахад нь би зам даган тосож очоод,

- Мистер Женнингс би танд ний нуугүй ярьсангүй. Би Саран чулуу хайж олох гэсэндээ мистер Кандийн санаж чадахгүй байгаа зүйлийг сонирхсон юм биш. Иоркширт хувийн өөр чухал хэргээр ирсэн юм. Танд ний нуугүй хэлээгүй маань нэг учиртай юм л даа. Өөрийнхөө үнэн байдлыг өрөөл хүнд ойлгуулахад тун хэцүү байгааг онож хэлэх ч бэрх байна гэсэнд Эзра Женнингс намайг анх удаа л сандарсан янзтай харав.

- Мистер Блейк минь, таны хувийн амьдралд оролцох эрх надад байх ч үгүй, оролцохыг хүсээ ч үгүй юмса. Би таныг даанч санаандгүй тун эвгүй байдалд оруулжээ. Намайг өршөөгөөрэй.
- Мистер Кандийн өвчтэй байх үедээ хэлж байсан үгийг ийм тийм болзолтойгоор хэлнэ гэх эрх танд бүрэн бий шүү дээ. Таны баримталж буй шударга чанарыг би ойлгож, хүндэтгэж байна. Хэрэв би танд итгэхгүй юм бол яаж таныг өөртөө итгүүлнэ гэж горьдох билээ? Кандийн надад хэлэх гээд байсныг б миний бие ингэтэл сонирхож буйн учрыг та мэдэх ёстой, мэдэх ч болно. Хэрэв горьдлого маань талаар болж, та миний эрлийн үнэн шалтгааныг мэдэвч надад тус болж чадахгүй гэж үзэх аваас миний нууцыг хадгална байх гэдэгт би итгэнэ. Яагаад ч итгэж болмоор санагдана.

- За, байз мистер Блейк таныг цааш ярихаас өмнө нэг хоёр юм хэлэх хэрэгтэй байна.

Тийн өгүүлэхэд нь гайхан харвал сэтгэл нь гэнэт аймшигтай их догдлон түгшсэн бололтой. Цыганархуу гялалзан, дуу нь намсаж танигдахааргүй шийдмэг болсон байв. энэ хүний дотор хадгалаастай байсан хүч чадал нь (сайн буюу муугаар алин болохыг хэлэхд тэр үед хэцүү байлаа) огт санаандгүй байтал мини өмнө цахилгаан гялбах адил дүрсхийн илрэх нь энэ.

- Та надад итгэхийн өмнө би мистер Кандийнд анх ямаршуу нөхцөл байдлын дунд очсоныг та мэдвэл зохино, заавал мэдэж авах хэрэгтэй. Би нэг их нуршиж сунжруулахгүй. Ноёнтон минь, би бол үүх түүхээ (ингэж л хэлэх үү дээ) хэнд ч тоочих болдолгүй хүн байгаа юм. Миний түүх надтай л хамт үхнэ. Би мистер Кандид ярьсанаа л танд илүү, дутуу үггүй ярихыг сонсож соёрхооч гэж л гуйх байна. Та миний яриаг сонссон хойноо ч санаагаа өөрчлөлхгүй бол миний анхаарлыг жолоодож, юү хийлгэхээ хэлээрэй. Жаахан алхах уу даа?

Харваас гансрал гунигаа нууж ядан яваа энэ хүнд юү ч гэлтэй билээ, хариуд нь дуугаралгүй дохиод цааш хамт алхлаа.

Тийнхүү хэдэн зуун алхам явсны дараа хонин арцат хөндийг замаас тусгаарладаг чулуун хананы нэг нурсан хэсэгт хүрээд Эзра Женнингс зогсов.

- Жаахан амарвал яасан юм бэ? Миний бие урьдынхтай адилгүй болжээ. Намайг сүрхий шаналгадаг зүйл ч байгаа юм.

Би ч мэдээжийн хэрэг зөвшөөрлөө. Женнингс нөгөө нуранхайгаар цааш гараад замын хажуугийн бут сондуул, давжаа модны дундах жанжуу гүйстэй алга дарам аятайхан газар намайг дагуулан очив. Тэндээс хонин арцат хөндий тийш харвал бараантан цэлийх уужим сүрлэг үргэлжлэх ажээ. Хагасхан цагийн дотор үүл бүрхэж амжаад тэнгэр бүүдийн тэртээ алсын юмс сүүдийнэ. Байгаль эн хамуухан эелдэг, өнгө жигд, дүр гоолиг авч мишээн угтсан нь үгүй.

Бид хоёр хэсэ дуу шуугүй суув. Эзра Женнингс малгайгаа авч хажуудаа тавиад бууралтаж эхэлсэн үс, духаа ихэд ядарсан янзтай илээд барьж явсан хээрийн цэцгээ гэнэт шидчихий нь ажвал тэр цэцэгнээс уламжлан санагдсан дурсамж одоо түүнийг зовоов уу гэмээр байлаа. Тэгснээ гэнэт,

- Мистер Блщйк та муу хүнтэй цуг явж байна шүү дээ. Бодохоос аймшигтай ял зэмллэлийн хар үүл намайг олон жил бүрхсэн юм. Танд адгийн өлзий бус юмаа шуудхан хэлэхэд амьдрал нь бүрэн сүйрч, нэр төр нь эргэлтгүй хугарсан хү тантай хамт байна гэв.

Би үгий нь таслан юм хэлэх гэтэл,

- Байз, байз! Хэмээн хашгирснаа, - Уучларай та түр азна. Намайг өрөвдсөн үг хэлчихээд хожим амаа барих хэрэг гарвал дэмий. Би олон жил ял зэмлэл хүлээж явсан хүн гэдгээ цухуйлгасан,. Надад нүүрлэсэн гай байдаг юм. Чухам ямар ял зэм надад тохсоныг би өөрөө мэддэггүй. Тэгээд гэм буруугүйгээ ч нотолж чаддаггүй, яагаад ч чаддаггүй юм. Харин буруугүй гэдгээ христос мөргөлтний ёсоор тангараглая. Нэр төрөөрөө тангараглаад бол нэмэргүй л дээ гэснээ хэсэг дуугүй болов.

Би өөдөөс нь харсанд газар ширтэн байх агаад хамаг бие сэтгэл нь урьдын зовлонт явдлуудыг дурсан тарчилж, ярихыг чармайж буй бололтой.

- Төрөл садан маань хуншгүй загнаж, миний бие өршөөлгүй дайсагналын золиос болсон тухй яривал их юм бий. Гэвч үйл лайг нь нэгэнт амсаж, шударг бус хэргийг засаж залруулах хөг нь өнгөрсөн хойно би, ноёнтон минь, эсэн бусын юм өгүүлж таны сэтгэлийг чилээж, зовоохгүйг бодож байна. Энэ оронд хоолондоо дөнгөж хүрч эхлээд байтал түрүү цухуйлгасан муухай гүтгэлэг намайг насан туршид бүрмөсөн балласан юм. Олж авсан мэргэжлээрээ амжилт олох аливаа горьдлого тасраад, хүний анхаарал татахгүй шиг амьдрахыг л мөрөөдөхөд хүрсэн юм. Хайр сэтгэлээ өгсөн бүсгүйгээсээ хагацлаа. Миний бузарлагдсан нэрийг хуваалцаж яв гэлтэй нь биш! Английн нэг лас бөглүү газар эмчийн туслагчийн ажилтай болоод амар жимэр сууж, хэнд ч анзаарагдалгүйгээр мөрөө хөөж болмоор санагдаж байлаа. гэтэл тэгсэнгүй, Муу үг модон улаатай гэж хүрэхгүй газаргүй, цаг үргэлж шалтаг мундахгүй өсөж дэврэн энд тэндгүй хэсүүчлэн тархдаг юм байна. Ял зэмээс зугтаасан боловч араас гээг даран хөөгөөд байлаа. Үүнийг нэг хүнээс дуулмагц сай ажиллаж байсан, ажилд авахад болно гэсэн тодорхойлолт аваад ажласаа сайн

дураараа гарч амжлаа. Тэгээд өөр нэг зэлүүд газар ажилтай болж амжлаа. Нэг их удаагүй байтал нэр төрийг минь бузарласан нөгөө гүтгэлэг намайг бас л гүйцээд очдог байна. Тэр удаа би урьтаж мэдсэнгүй. Эзэн маань “Женнингс, таныг өөлж, муучлах юм надад байхгүй, гэхдээ та нэг бол биеэ цагаатгах эсвэл манайхаас зайлах хэрэгтэй байна” гэв. Надад зайлахаас өөр зам байсангүй. Түүнээс хойш хичнээн зовж зүдэрснээ тоочих юун. Одоо би дөнгөж дөчтэй хүн. Миний царайг харахад олон жил тарчилсан маань андашгүй. Яв явсаар энэ хязгаар нутагт ирж, мистер Кандитай учирсан юм. Туслагч хайж байсан юмсанж. Миний ажлын чадвар зүтгэлийн талаар сүүлчийн эзнээс маань лавлаарай гэж би хэлсэн юм. Харин нэр төрлийнхөө асуудлын талаар саяын танд ярьснаа, бүр ч илүү тодорхой ярьж өгөөд надад хичнээн итгэлээ ч гэсэн бэрхшээл үүсэж магадгүйг сануулаад “Би энд ч тэр, ер хаана ч тэр хуурамч нэр зээлдэж гэмт хүн шиг гилбэлзэж явахад яснаасаа дургүй. Хаана ч очлоо гэсэн араас мөшгиж явдаг муу ёсры хар үүл Фризинхоллд ч намайг гүйцээд ирэхгүй гэх нотолгоо үгүй” гэсэнд “Би юмыг дутуу орхидог хүн биш. Би танд итгэж ч байна, таныг өрөвдөж ч байна. хэрэв та осолтой гэж айхгүй бол иб ч бас айхгүй” гэж билээ. Тэнгэр өршөөх болтугай! Энэ хүн л надад толгой хоргодох орон, амь зуух ажил өгч, сэтгэл санааг минь амраасан юм. Ингэсэндээ хожим хойно юу ч болж байсан гэмшихгүй нь лавтай. үүнд би итгээд хэдэн сар болж байна.

- Нөгөө гүтгэлэг тэгээд дарагдсан уу? гэж би асуулаа.
- Яг л хэвээрээ байгаа. Харин энд намайг дэндүү хожуу гүйцэж ирнэ байх даа.
- Эндээс явах гэж байгаа юм уу?
- Үгүй ээ, мистер Блейк минь, би үхчихсэн байх болно. Эдгэршгүй өвчинд шаналаад арван жил боллоо. Амьд явах нэг учир шалтгаан байгаагүйсэн бол би аль хэдийн энэ тарчилгаатай өвчнөөр үхчих л байлаа. Танаас нуугаад яахав. Дахиад бараагий нь харахгүй ч гэсэн элэг зүрхний хайтай нэг хүнийг амь зуулгатай болгохыг л би хүсдэг юм. Эцэг эхээс өвлөсөн жаахан мөнгө тэр эмэгтэйг гачигдаж дутахы зовлонгүй аж төрөхд нь хүрэхгүй л дээ. Тэр мөнгийг бодсон хэмжээндээ хүргэнэ гэсэндээ л энэ өвчнийг чадах бүхий л арга ухаанаар аргалан амьд яваа хүн юм шүү дээ, би. Надад хар тамхи л их тус болсон доо. Хүч төгөлдөр, өлзийтэй эн эмийн ачаар би үхлийн ялыг олон жил хойшлуулж чадлаа. Харин хар тамхины өлзийтэй сайхан чанарт ч хязгаар байдаг юм байна. Өвчнөө даамжрах тусам хар тамхийг хэрээс хэтрүүлж, буруу хэрэглэх болов. Ингэсний гор одоо л гарч байх шиг байна. Мэдрэлийн эрхтнүүд биш болж, шөнө хар дарах боллоо. Одоо ч шороо хөдөлгөх хоногийн тоо цөөрчээ. Яахав дээ үхэх цэг ирэг, амьд явж ажил хийсэн минь талаар өнгөрсөнгүй. Жаахан мөнгө хураах гэснээ бараг гүйцээлээ. Багцаалж байгаа хугацаанаас наана гол тасрах боллоо ч гэсэн гүйцээчих юм бий. Би яах гэж танд энэ бүхнийг ярихав даа, бүү мэд. Лав л танаар өрөвдүүлэх гэж горьлоогүй юм шүү. Үхэх цаг ойртсоноо сайн мэдээд ийм юм ярьж байна гэдгийг та мэдвэл надад илүү итгэнэ байх гэж бодсон байж магадгүй юм. Та надад аятайхан санагдсаныг нуугаад хэрэггүй биз. Хөөрхий найзынхаа ой ухаан муудсаныг тантай бүр сайн танил болохыг хичээхдээ ашиглав. Юү хэлэх гээд байгааг нь та нэгэнт их сонирхож байгаа бол намайг туслах болов уу гэж бодох завшаан гарч магадгүй гэж санаса юм. Танд ингэж наалдаад байгааг минь уучлах үндэс байхгүй юм гэж үү? Эрхбиш бага сага юм бий биз. Над шиг ийм амьдрал туулсан хүн, хүний хувь тавиланг бодохдоо улам их гачлантай байдаг юм. Танд залуу нас, эрүүл бие, эд хөрөнгө, нийгэмд эзэлсэн байр суурь байан, сайхан ирээдүй хүлээж байна. та болон тан шиг хүмүүс хүний амьдралын нар мэт гэгээн талыг харуулж, намайг ертөнцөөс хагацан одохын өмнө амьдралтай эвлэрүүлж байна. бидний энэ яриа ямраар ч төгслөө гэсэн ингэж ярилцан соёрхсоныг тань би мартажгүй. Одоо, эрхэм ээ, юү хэлэх гэснээ хэлэх эсэхийг таны таалал мэдэг дээ.

үүнд өчих хариу ганц л байлаа. Би агшин зуур ч тээнэгэлзэлгүйгээр хамаг үнэнийг эдгээр хуудсан дээр бичсэнчлэн илэн далангүй өгүүллээ.

Женнингс амьсгаа даран сонсож байснаа ярианы хамгийн гол хэсэгт хүрэхэд минь огло харайн босож, өөдөөс ширтлээ.

- Би тэр өрөөнд нь яах аргагүй орж, алмазыг ч бас яах аргагүй авч шүү. Энэ хоёр хөдөлшгүй баримтын хариуд, би үүнийг хийх нь, хийжээ, гэхдээ хийлээ гэхэд өөрөө огт мэдэхгүй байсан гэж л хэлж чадна...хэмээн намайг өгүүлтэл, Эзра Женнингс сэтгэл хөдлөн миний гарас шүүрэн барьж,
- Байз! Та надад хэлэх гэснээсээ илүү юм бодууллаа. Танд хар тамхи хэрэглэж байсан удаа бий юү? гэв.
- Насандаа амсаж үзээгүй.
- Ноднин тэр үеэр таны мэдрэл хямарсан юм биш биз? Жигтэйхэн уур унтуутай, тайван бус байса юм биш биз?
- Тэгсэн.

- Нойрондоо муу байсан уу?
- Хачин муу. Огт цурамхийгээгүй шөнө олон байсан.
- Төрсөн өдрийн баярын шөнө өөр байсан биш биз? Бодоод үз л дээ. Тэр шөнө та сайн нойрсоогүй юу?
- Сайн санаж байна! Бөх гэгч нь унтсан шүү.

Эзра Женнингс миний гараас гэнэт шүүрэн барьсан шигээ одоо гэнэт тавиад өөдөөс ширтэхэд сүүлчийн эргэлзээ нь арилсан шинж нүдэнд нь ил байлаа.

- энэ бол та бид хёёрын хоёулангийн амьдралд тэмдэглэлт өдөр болов хэмээн Женнингс нухацтай хэлээд, -мистер Блэйк, одоо би нэг зүйлийг буюу өнөө өглөө мистер Кандийн хэлэх гээд байсан зүйлийг лавтай мэдлээ. Энэ тухай миний тэмдэглэлд бичээстэй байгаа. Хүлээзнэ! Өөр ч юм бий. Та өрөөнд орж, алмаз авахдаа өөрийн ухаангүй байсныг би нотолж чадна гэж хатуу итгэж байна. Таны гэм буруугийн нотолгоо миний гарт байгаа нь дамжиггүй боллоо! Надад бодох цаг, танаас лавлах зав өгөөч.

- Тэнгэр минь! Юү гэсэн үг вэ, тайлбарлаад өгөөч!

Бид хоёр сэтгэл хөдөлсөн яриандаа автаад хэд алхсан нь олоо хүртэл хүний нүднээс халхалж байсан давжаа моддоос гарчихсан байжээ. Эзра Женнингс надад тайлбарлан ярьж амжагүй байтал дардан замын тэртээгээс Эзра Женнингсийг эрж байсан бололтой нэг хүн их л тэвдсэн янзтай дуудав.

- За одоохон очлоо, одоохон гэж хариуд нь хашгираад над руу эргэж, - Тэр тосгон яаралтай очих хэрэгтэй юм. Уг нь хагас цагийн өмнө оччихсон байх ёстой юм л даа. Одоохон явалгүй горьгүй. Хоёр цаг болоод та мистер Кандийнд очоорой, би хүлээж байя гэв.
- Би тэр болтол яаж хүлээх билээ! Салахын өмнө ганц хоёр үгээр ч болов тайлбарлаад санаа амраагаад өгөөч дээ! Хэмээн би тэсэж ядан дуу алдав.
- Мистер Блэйк минь, энэ бол яаран сандран тайлбарлах аргагүй сүрхий ноцтой хэрэг юм шүү. Би таны тэсвэрийг зориуд сорих гэсэн юм биш. Одоо таны санааг амрая гээд хэдэн үг хэлчихвэл та тэсвэ бүр ч их алдах болно. Эрхэм ээ, хоёр цагийн дара фризинхоллд уулзъя!

Нөгөө хүн дардан зам дээрээс дахин дуудсанд Женнингс намайг орхин яаран одов.

## Х БҮЛЭГ

Тийнхүү арга буюу хүлээх болсон зовлонтой хугацаа, миний оронд өөр хүн байсан бол яаж нөлөөлөх байсныг таамаглан хэлж би үнэндээ чадахгүй. Миний тэвчээрийн сорилт болсон тэр хоёр цагийн нөлөө тодорхой байв. Үүнийг өгүүлбэл, бие цогцсын хувьд Нэг газраа тогтоож сууж чадахгүй болж санаа сэтгэлийн хувьд гэвэл, Экра Женнингсийн ярихыг бүгдийг сонсох хүртлээ хүнтэй үг солилцох чадалгүй болчихоод байлаа.

Ийм байдалтай болчихоод Эблвайт хатагтайнд буцаж очих нь бүү хэл Габриэл Бэттережтэй нүүр учрахаас төвөгшөөн дөлөв.

Фризинхоллд эргэж очоод гэнэт ажил гарлаа, гэвч үдээс хойш гурван цагийн алдад ирнэ байх гэсэн зурвас Бэттереж гуайд бичиж орхив. Мөн хоол, цайгаа цагт нь захиалаарай, намайг иртэл юу хийж байхаа өөрөө мэдээрэй гэв. Бэттереж гуай Фризинхоллд нэлээд хэдэн найзтайг нь би мэдэх бөгөөд намайг буудалдаа буцаж ирэх зуур цаг нөгцөөж ядах юм түүнд үгүй билээ.

Ингээд би хотоос шалавхан гарч, Фризинхоллыг тойрсон хонин арцат талаар баахан бидэрч, цагийн зүү сая нэг хугацаа болсныг заамагц мистер Кандийн руу алхлаа.

Эзра Женнингс хэдийн харьчихаад хоосон шахам өмгөрхөн өрөөндөө намайг хүлээж байв. өрөө нь эмийн сан руу ордог шилэн хаалгатай юм. Аймшигт өвчнүүдийн уршгий харуулсан дотор зарсхиймээр өнгөт диаграммууд үлбэгэр шар ханаар нь нэг ярайжээ. Номын шүүгээнд нь өнгө алдсан хавтастай анагаахын ном дүүрэн агаад шүүгээн дээр цээж баримал тавьдаг газар нь хүний гавлын яс залжээ. Нэл бэх асгаж халтартуулсан том гэгчийн нарса ширээ байна. гал тогоо болон хөдөө зусланд тааралддаг шиг хэдэн сандал харагдана. Өрөөний голд урагдаж навсарсан хивсэрхүү юм дэвсчээ. Тосгуур, хананд эв хавгүй суулгасан ус дамжуулах хоолой бүхий цорго буй нь хагалгаа хийх ажиллагаатай холбоотой болов уу гэж бодогдмоор, аймаар ажээ. Цонхныхоо гадаа тавьсан ваартай хэдэн цэцэг дунд зөгий дүнгээж, цэцэрлэгт шувуу жиргэж, хажуугийн байшингийн зүгээс хөггүй төгөлдөр баян хуур гэнэ гэнэ хангинан чих дэлсэнэ. Эндээс өөр хаан ч гэсэн тиймэрхүү ерийн дуу чимээ сонсдох юм бол гадаад ертөнцийн ерийн урамтай цовоо байдлыг илтгэхсэн билээ. Гэтэл хүний гашуун зовлонгоос өөр юм халдах эрхгүй энэ өрөөний нам гүмийг тэдгээр дуу чимээ халдан дайрах мэт ажээ. Мэс заслын багажны улаан зандан хайрцаг, номын шүүгээний тавиурууд дээр буй том гэгчийн боодлыг харад Эзра Женнингсийн өрөөнд өдөр бүр сонсогддог дасал болсон танил дуу шуу гарах шиг санагдсанд бие зарсхийв.

- Мистер Блэйк таныг ийм өрөөнд хүлээн авсандаа санаа зовохгүй байна. Яагаад гэвэл өдийд та бид хоёрт хэн ч саад хийхгүй йхамгийн тохиромжтой газар энэ л байга юм. Энд би нөгөө бичиг сачгаа танд үзүүлэхээр бэлдчихээд байна. Үхэх хэрэг болж магдагү йгээд бас хоёр ном ил гаргалаа. Сандлаа ширээнд дөхүүлээд суучих, тэгээд хоёул хамтдаа үзье.

Ширээнд нь дөхөн суусанд Эзра Женнингс тэмдэглэлээ надад өгөв. Хоёр том хуудсан дээр бичсэн байлаа. Нэг дээр нь и хол хол зайтай бичсэн харагдана. Нөгөө дээр нь дээрээс доош нь улаан, хар бэхээр жирийнтэл пиг дүүрэн бичжээ. Энэ үед миний шохоорхон сониучлах маань бүр эгдүүцэл болон хувирсан учраас дотор цухалдан хоёр дахь хуудсыг хажуу тийш болгоод,

- Намайг жаахан өрөвдөж үзээч! Үүнийг уншихаас өмнө надад юу болох гээд байгааг хэлээч дээ гэв.
- Мистер Блэйк дуртайяа хэлж өгье Танас ганц хоёр юм асуувал та дургүйцэх үү?
- Дуртай юмаа асуу!

Женнингсийн царайд гунигтай инээмсэглэл тодорч, зөөлөн бор нүдэнд нь дотноор сониучлах янз илрэв. Тэгээд,

- Та өөрий мэдэхээс хар тамхи насандаа амсаж үзээгүй гэж надад хэлсэн шүү дээ.
- Тийм ээ би өөрийн мэдэхээс гэсэн.
- Яагад намайг шууд хэлчихгүй түдгэлзээд байсан учрыг та одоо шулуухан ойлгоно. Цааш нь ярья л даа. Та ер нь хар тамхи хэрэглэж байснаа мэдэхгүй байгаа. Ноднин яг энэ үеэр мэдрэл тань бишдэж, шөнө ч унтаж чадахгүй тарчилдаг байсан. Харин өнөөх төрсөн өдрийн баярын шөнө л бөх унтсан гэж байгаа. Тийм байх аа, би зөв ярьж байна уу?
- Яг зөв.
- Таны мэдрэл юунаас болж ядарсан, яагаад нойр алдах болсон шалтгааныг мэдэх үү?
- Мэдэх юм алга. Бэттереж өвгөн л миний санахад шалтгааны нь таамаглаж байсан. Энд дурдахы ч хэрэггүй байх
- Уучлаарай намайг. Иймэрхүү тохиолдолд аливаа юмыг дурдах хэрэгтэй байдаг юм даа. Таны нойр хүрэхгүй болсны шалтгааныг Бэттереж хэлсэн байж. Юунаас боллоо гэсэн бэ?
- Тамхиа хаяснаас боллоо гэсэн.
- Та тахим байнга татдаг байсан юм уу?
- Тийм.
- Гэнэт хаясан уу?
- Тэгсэн.
- Мистер Блэйк минь, Бэттереж гуай яах аргагүй зөв хэлж шүү дээ. Тамхи байнга татдаг хүн гэнэт хаяхада мэдрэлийн систем нь заавал түр боловч хямардаг, тэгдэггүй хүн тун ховор. Миний бодоход түүнээс болоод л таны нойр ухлжижи байжээ. Миний асуух бас нэг зүйл бол Канди гуайтай холбоотой юм. Төрсөн өдрийн будаалгын үеэр юм уу, дараахан нь та мистер Кандитай мэргэжлийнх нь талаар маргасан эсэхээ санаж байна уу?

Ингэж асуумагц нь төрсөн өдрий найрын үед юу юу болсон тухй бүүр түүр юм гэнэт санагдав. Мистер Канди бид хоёрын хооронд болсон тэнэг маргааныг Бэттереж хүүрнэлийнхээ аравдугаар бүлэгт их л өсгөн бичсэн байх ёстой. Би тэр марганы талар хожим нь бараг бодоогүй болохоор нарийн ширийн юм ер санагдахгүй байлаа. Найрын ширээнд сууж байхдаа анагаах ухааныг би их л ширүүнээр давшлан дайрч, мистер Кандийн уурыг хүргэснээ ло санаж, Эзра Женнингст энэ тухай хэлэв. Мөн Вериндер ахай, палдгар доктор бид хоёрын маргааныг зогсоож, бид хоёр ч сургуулийн хүүхдүүдийн хэлдгээр “төдхөн сайндаад “ тэр орой тарж явахынхаа өнм хэзээний гэмгүй сайн найз нар шиг болчихсон байснаа санаж билээ.

- би заавал мэдвэл зохих бас нэг зүйл байна. Ноднин өдийд алмазны талаар сэтгэл зовох шалтгаан танд байсан уу? гэж Эзра Жеенингс лавлав.
- Сэтгэл зовох их ултай шалтгаан байсан. Хэдэн этгээд тэр алмазыг яаж ийгээд олж авахар хөөцөлдөж байсныг би мэдэж байсан бөгөөд тэр чулууг эзэмшигч болсон мисс Вериндерийн амь насыг сэргэмжлэн хамгаалах бодолтой байлаа.
- Төрсөн өдийн найрын шөнө та унтахаасаа өмнөхөн алмазыг хадгалах талаар хүнтэй ярилцсан уу?
- Вериндер ахай охинтойгоо энэ талаар ярилцаж байсан...
- Таны дэргэд үү?
- Тийм.

Эзра Женнингс ширээн дээрээс тэмдэглэлээ авч надад өгөөд,

- Мистер Блэйк бүрхэг байсан зүйл нь миний асууж, таны хариулсны ачаар тодорсон энэ тэмдэглэлийг та одоо унших ахул өөртөө холбоотой хоёр гайхмаар зүйлийг олж үзнэ. Нэгд, хар тамхины нөлөөгөөр мисс Вериндерийн зочны өрөөнд өөрийн ухаангүй орж, алмазыг авчээ. Хоёрт,

тэр хар тамхийг мистер Канди төрсөн өдрийн найран дээр таны илэрхийлсэн үзлийг туршлага дээр няцаахын тулд танд мэдэгдэлгүй сэмхэн уулгажээ гэдгийг мэдэж авах болно гэв.

Би бү эргүүтэж гүйцээд нөгөө тэмдэглэлийг барьсаар суулаа.

- Хөөрхий мистер Кандийг өршөөж үзээрэй хэмээн туслагч нь ялдамхнаар гуйгаад –Сүрхий гайтай хэрэг хийсэн л дээ, гэвч зриудаар тэгээгүй юм шүү. Та наад тэмдэглэлээ уншаад, Канди өвдчихөөгүйсэн бол найрын маргааш өглөө л Вериндер ахайнд очиж, таныг хэрхэн дажигнасан үнэнээ хэлэх байж гэдгийг ойлгоно. Тэгсэн бол мисс Вериндер ч тэр тухай сонсож түүнээс сайтар асууж лавлах байсан биз. Тэгсэн бол бүтэн жил нууц байсан үнэн учир ганц хоногийн дотор л илрэх байж дээ гэлээ.

Би дахиад л биеэ барьж эхлэв.

- Одоо мистер Кандид гомдож зэвүүдэд ч яах вэ дээ намайг тэгж даажигнаса нь итгэл хөсөрдүүлснээс өөрцгүй юм болжээ. Яахав, уучилж болно, харин хэрхэвч мартаггүй хэмээн би уурсан хэлэв.

- Мистер Блэйк минь, эмч бүр эмчилгээний ажилдаа иймэрхүү итгэл хөсөрдүүлсэн зүйл үйлддэг юм шүү дээ. Хар тамхины хүчинд мунхгаа үл итгэх үзэл ангид зөвхөн боловсролгүй доод давхаргын дунд тархсан байдаг юм биш. Туршлагатай хашир эмч бүхэн Канди гуай таныг мэхэлсэнтэй адилаар өвчтөнүүдээ үе үе мэхлэхээс өөр аргагүй болдог юм. Тухайн нөхцөлд таныгтйинхүү даажигнасан тэнэг явдлыг би зөвтгөөгүй. Харин яагаад тэгэж болсны шалтганыг арай нарийн, арай нааштай тайлбарлаж л өгье.

- Гэвч яаж үүнийг хийгээ вэ? Хэн нададхар тамхи мэдэгдэлгүй өгсөн юм бэ? гэж би шалгаалаа.

- Үүнийг хэлж чадашгүй нь. Мистер Канди өвчтэй байх үедээ энэ талаар нэг ч үг цухуйлгаагүй. Сэжиглэчихмээр хүн таны санаанд орж магадгүй бус уу?

- Санахгүй байн.

- Иймэрхүү юманд тархиа зовоогоод ашиггүй. Танд ямар нэг аргаар хар тамхи өгчихөж л дээ. За, энэ тухай орхиод оогоор хамгийн чухал байгаа хэргийг хэлэлцье. Чадвал миний тэмдэглэлийг уншигтун. Урьд юу болсныг ой тойндоо толилогтун. Би ирээдүйд холбогдол бүхий маш зоримог, нэг жигтэй зүйлийг танд санал болгох санаатай байгаа юм.

Эзра Женнингсийн сүүлчийн хэдэн үг намайг урамшуулж, нөгөө тэмдэглэлийг өгсөн дарааллаар нь эргүүлж үзлээ. Арай бага эрээчсэн хоёр хуудас дээр нь байв. Мистер Канди дэмийрэн буй үедээ хэлсэн утга учиргүй үгс, тасархай өгүүлбэрүүдийг доор дурдсугай.

“...Фрэнклин Блэйк ...аятайхан ...давилуун аашилдгаа болбил...анагаахын ...шөнө нойр... зовдог гэнэ...хямарсан эм уух ...хэлэхд...надад ярилаа...харанхуйд...тэмтчих хоёр адил шүү дээ гэсэн...найрын ширээнд сууж байсан олон зочны ...хэлэв...харанхуйд нуруу тэмтчин хайж яваа бол эмнээс өөр юу ч...гэсэнд сохор нь сорыгоо хөтлөх...гэсэн үгийг...одоо л ойлголоо... цэцэг цэлмэг, гүг газар гээхгүй ярдаглаж...ганц шөнө сайн унтаж амраг л даа...үнэхээр...нойргүй...Вериндер ахайн манхаг...өөрт нь хар авахуулалгүй хорин таван дусал...маргааш өглөө...мистер Блэйк...уухгүй бол ердөө ч...мистер канди та эндүүрч байна...уугаагүй мөртлөө...үгэнийг гайхуулъя...хачин сайн...эрхэм ээ, хачин сайн...нэг тун хар тамхи...одоо анагаахын эмийн... юу..”

би хоёр хуудасны нэг дэхийг нь уншаад Женнингст буцааж өгөнгөө,

- Сахиж суухдаа сонссон зүйл чинь энэ юм уу? гэв.

- Үг үсэгчлэн мөн. Харин байн байн давтаж хэлсэн үгийг нь би хурдан бичигнээс буулгахдаа орхиосон. Зарим үг, өгүүлбэрээ арав, хорь дахин, өөрөө чухал гэж бодсон зүйлээ тавь гаруй удаа ч давтдаг байсан юм. Тэгж олон хэлж байсны нь ачаар би энд хэсэг бусад үгсийг холбон уялдуулж, заим утга төгөлдөр өгүүлбэр болгож чадсан юм шүү гээд хоёр дахь хуудсыг зааж, - Мистер Канди утга уялдаатай ярих чадвартай үедээ өгүүлэх яриаг нь энд яг сэргээн буулгаж чадсан гэж та битгий бодоорой. Харин хоорондоо уялдаагүй баахан өгүүлбэрийн цаана буй утга санааг нь олохыг л хичээсэн юм шүү. Та өөрөө дүгнэж үнэлээрэй л дээ гэв.

Хоёр дахь хуудсыг нь уншиж эхлэв. энэ бол түрүүчийн хуудасны учрыг тайл өгөх түлхүү гэдгийг ч ойлголоо.

Бас л Канди эмчийн дэмийрсэн үгийг хар бэхээр бичиж, тасалдсан газруудыг нь улаанаар нөхөж тавьсан байв. Би энд үр дүнг нь ганц янзаар тодотгон сийрүүлэв. Дэмийрсэн яриаг шууд буулгасан, түүний энэ тайлбар хоёр зэгсэн ойр буй тул харьцуулан тулгаж үзэхэд хялбар билээ.

- “Фрэнклин Блэйк ухаалаг, аятайхан занта йхүн юу мэгхдээ анагаах ухааны талаар ярихдаа давилуун аашилдгаа болибол таарна. Шөнө нойр нь хүрэхгүй зовдог гэнэ. Мэдрэл чинь хямарсан байна, тэгэхээр эм уух хэрэгтэй гэж намайг хэлэхэд эм уух, харанхуйд тэмтчих хоёр адил шүү дээ гэсэн. Найрын ширээнд сууж байсан тэр олон зочны дэргэдхээв нэг ингэж хэлэв. Харанхуйд нойроо тэмтчиж яваа бол эмнээс өөр юу ч тус болохгүй дээ гэсэнд, сохор нь сорыгоо хөтлөх гэсэн үгийг урьд сонссон боловч учрыг нь одоо л ойлголоо гэнэ. Цэцэг цэлмэг хэллээ, үг газар

гээхгүй ярдаглалаа ч эсэн ганц шөнө сайн унтаж амраг л даа. Үнэхээр нойргүй тарчилж яваа хүн юм. Вериндер ахай манхаг миний мэдэлд байна. Шөнө өөрт нь хар авахуулалгүй хорин таван дусал уулгаад маргааш өглөө ирье. "За, Блэйк ноён, та өнөөдөр нэг жаахан эм уугаад үзэх юм биш үү? Эм уухгүй бол ердөө ч унтаж чадахгүй шүү". "Мистер Канди та эндүүрч байна. Би урьд шөнө эм уугаагүй мөртлөө хачин сайхан унтсан шүү". Одоо үнэнээ хэлж гайхуулаатхъя! "Эрхэм ээ, хачин сайхан унтахад чинь тус болсон юм бий. Таныг унтахын өмнө нэг тун хар тамхи уулгасан юм шүү дээ. Одоо та анагаах эмийн урлагийн талаар юу хэлмээр байна?"

Би Эзра Женнингсийн гар бичмэлийг буцааж өгөхдөө учир нь олдохгүй бөөн будлиантай дэмийрсэн үгээс ийм утга төгөлдөр яриа босгож чадсан авхаалжийг нь юуны өмнө шагшин гайхаж билээ. Женнингс нөгөө л даруухан зангаараа магтаалын үг цухуйламагц миний яриаг таслаад тэмдэглэлээсээ хийсэн дүгнэлттэй нь санал нийлж буй эсэхийг асуулаа.

- Мисс Вериндерийн төрсөн өдрийн найрын шөө таны үйлдсэн бүхэн хар тамхины нөлөөгөөр болсон гэдэгт та миний адил итгэж байна уу?
- Би хар тамхины нөлөөллийг даач мэдэхгүй болохоор хэлэх юм алга. Таны бодож байгааг л зөв гэж итгэнэ.
- За зүйтэй. Бас нэг асуудал байна. Та бид хоёр ч яахав, ингэж итгэдэг л юм байж. Харин бусдад яаж итгүүлэх билээ?

Би ширээн дээр буй гар бичмэлийн хоёр хуудсыг заасанд Эзра Женнингс толгой сэгсрээд,

- Тус болохгүй ээ, мистер Блэйк минь! Энэ байдлаараа огт тус болохгүй. Хариулж боломжгүй гурвншалтгаан байгаа юм. Нэгдүгээрт, хүн төрөлхтний амьдралын туршлагад ийм нөхцөлд тэмдэглэл хөтөлсөн түүх байгаагүй болохоор яаж итгэх вэ дээ, хамгийн наад зах нь энэ шүү дээ. Хоёрдугаарт, энэ тэмдэглэл бол анагаахын урьд нь шалгагдаагүй шинэ онол юм. Тэгэхээр бас л итгүүлэхэд бэрх! Гуравдугаарт, энэ тэмдэглэл бол ганц миний хийсэн ажил. Зохиомол худал юм биш гэж мини йхэлэх үгээс өөр нотлох баримт байхгүй. Би хонин арцат хөндийд байхда танд юу ярьсныг санагтүн. Тэгээд миний үг жинтэй байж чадах эсэхийг бодоод үз л дээ. Миний тэмдэглэл олон түмний санал бодлын үүднээс үзэхэд юу ч биш дэмий зүйл боловч тан ыгэмгүйг нотлох арг азамыг зааж өгөх юм. Та бид хоёр үнэмшлээ нотолгоотой болгох ёстой. Та чнотолж чадна!

- Яаж?

Женнингс ширээн дээгүүр тэгнэн над руу тонгойж,

- Та нэг зоригтойхон юм туршиж чадах уу? гэж асуув.
- Би одоо худал сэжгээс нэрээ цэвэрлэхийн тулд юу ч хийхэд бэлэн байна!
- Тун эвгүй байдалд орсон ч хамаагүй юу?
- Ямар ч эвгүй байдалд орохоос буцахгүй.
- Та миний зөвлөгөөг үгидуугүй дагах уу? Таныг тэнэг хүмүүсийн доог тохуу болгож, санал болдлыг нь хүндэтгэх ёстой найз нөхөд чинь зэмлэж мэднэ шүү дээ гэхэд нь
- Яах ёстой юм бэ! Хэлээд өгөөч! Юу ч болсон хамаа алга, үзээд л алдъя! Хэмээн яаран мэдэгдэв.
- За, тэгвэл та нөгөө алмазыг хөдөлбөргүй гэрчлэн нотлох хүмүүсийн нүдэн дээр дахин хулгайлах ёстой болно доо.

Би огло харайн босоод юм хэлье гэтэл дуу ч гарахгүй, дэмий л өөдөөс нь гөлийн зогсов.

- Болно байх гэж би бодож байна. Та л туслах юм бол бүтнэ л дээ. Бизэ барь, суу, суугаад миний хэлэхийг сонс. Та тамхинд буцаад орсон юм шив дээ. Хэзээнээс дахин тататж эхэлсэн бэ?
- Бараг жил болж банья.
- Урьдынхаасаа их татаж байгаа юу? Бага татаж байгаа юу?
- Их
- Тамхиа дахиж хаях уу? Түүрүүнд больсон шигээ гэнэт хаяна шүү дээ!

Би Эзра Женнингсийн зорилгыг гадарлаж эхэллээ.

- би яг одоо л хаячихъя!
- Ноднингийн зургадугаар сарын явдал дахин давтагдвал, хэрэв та тэр үеийх шигээ нойр алдаж зовох юм бол та бид хоёр анхны алхмаа хийлээ гэсэн үг. Таны сэтгэл мэдрэлийн байдлыг нөгөө төрсөн өдрийн найрын шөнө байсантай адилхан болгоно. Дараа нь тэдний гэр орныг яг тэр үеийнх шиг сэргээх буюу ядахдаа төсөөтэй янзалж чадвал, бас алмазтай холбоотой элдэв төрлийн асуудлаас болж таны сэтгэл санаа дахин үймрэн зовж эхлэх юм бол бид таныг ноднин хар тамхины ханд уугаад сэтгэл санаа, бие бялдын хувьд хэрхэн хувирсантай адил байдалд дахин оруулж чадах юм. Тэгсэн цагт хар тамхи уулгавал тэр үздэш хэрэглэхэд нөлөөлсөнтэй их бага хэмжээгээр адил нөлөөлж магадгүй юм. Төлөвлөн сэдсэн зүйлээ хэдэн үгээр хэлэхэд ийм байна. Одоо харин тийм туршлага хийхэд бүтэмжтэй болно гэж яагаад бодсондоо танд тайлбарлаж өгье гээд хажуу дахь хэдэн номныхоо нэгийг нээж, жажан цаас хавчуулж тэмдэглэсэн газрыг заан,

- Хүний бие махбодын талаар лекц уншиж таныг чилээхгүй. Би өөрийнхөө зохиосон ямар нэг онолыг нотлохын тулд туршлага хийх гэсэн юм биш гэдгээ танд хэлэх нь зүйтэй гэж бодож байна. миний онолыг нийтэд баттай зарчим, нэрд гарсан эрдэмтэд нотолж байгаа юм. Хэрэв та миний хэлэх үгийг түр анхаран соёрхвол, миний онол хэчнээн хачирхмаар санагдавч шинжлэх ухааны үндэстэй гэдгийг харуулж өгөх байна. Юуны өмнө миний баримтлан буй физиологийн зарчим бол доктор Карпентерийн алдарт зарчим юм. Та уншаад үз дээ гээд номд хавчуулсан жижиг цаасыг надад өгөв. Түүн дээр бичсэнийг сийрүүлбэл:

“Ойлгох ухамсраар нэгэнт тархинаа бүртгэгдсэ (гэж хэлж болох) мэдрэцийн аливаа сэтгэгдлийг хожми нэгэн цагт сэргээн босгож болно гэхэ итгэх үндэс бишгүй байх мэт бөгөөд тийм сэтгэгдэл тархинд буйг мэдэхгүйгээр хэчнээн ч хугацаа өнгөрсөн байж болно” гэжээ.

- ойлгомжтой байгаа биз?

- Бүрэн ойлгомжтой байна.

Эзра Женнингс ширээн дээрх нээлттэй номоо над руу түлхэж, харандаагар зурсан мөрүүдтэй хуудсыг зааж,

- Таны байдал, одоо миний турших санаатай таныг ятган буй сорилттой шууд холбоотой мэт санагдах энэ зүйлийг унш даа. Английн их физиологчдын нэгийг би танд хэлж байгааг давын өмнө анхаарна биз. Энэ бол доктор Эллиотсоны бичсэн “Хүний физиологи” гэдэг юм. Докторын дурдаж буй тохиолдол бол ихэд нэрд гарсан алдар цуутай мистер Кобигийн мэдээлсэн зүйл юм.

Намайг унш гэж заасан хуудасных нь үгийг доор сийрүүлэв.

“Мистер Комби хэлэхдээ, Ирландын агуулахын нэг зөөгч согтуу үедээ юу хийснээ мартчихдаг боловч дахин архи ууж согтохдоо түрүүн согтуудаа хийснийг санадаг байж. Нэг удаа тэр хүн нэг боодолтой үнэ цэнэ бүхий юмаа алга болгочихоод архиа гарсан хойно яасан ийснээ огт санахгүй байжээ. Дараа нь бас архи ууж согтоод нөгөө боодолтой юмыг нэг байшинд орхисноо санасан байна. Боодолтой юм дээр хаяг тавиагүй байсан учраас зөөгчийн очиход тэндээ л байсан гэнэ. Үүнийг би доктор Эйблээс сонссон юм”.

- Бас л ойлгомжтой байгаа биз? Гэж Эзра Женнингс асуув.

- Үүнээс илүү ойлгомжтой юм байх уу даа!

Женнингс тэр жижиг цаасаа авч, байсан газар нь хавчуулад номоо хаав.

- Би өөрийнхөө онолыг нотлох гэж нэр төртэй эрдэмтдийн үгнээс иш татлаа. Хэрэв та сэтгэл дундуур байгаа бол энэ тавиурууд дээр байга номнуудын хуудсан дээр тэмдэглэсэн зүйлсийг уншиж болно шүү.

- Нэмж ганц ч үг харахааргүй боллоо.

- Тэгвэл одоо таны хувьд холбогдох юмны тухай ярилцъя. Харин миний хэлээд байгаа туршилтыг хийхэд бас нэг татгалзмаар тал байгааг би хэлэх ёстой. Хэрэв бид энэ жил ноднингийн нөгөө нөхцөл байдлыг яг хэвээр нь сэргээж чадах юм бол физиологийн үүднээс аваад үзэхэд бид мөн тийм үр дүнд хүрч чадна л даа. Гэвч энэ бол (үгүйсгэх арга байхгүй) ерөөс боломжгүй юм. Уг нөхцөл байдлыг ойролцоо адилавар л сэргээж чадна уу гэхээс биш яг адил болгож чадахгүй. Таны сэтгэл санааг ч тэр үеийнх шиг болгохгүй бол туршилт бүтэлгүй болно Хэрэв чадвал (амжилттай болно гэдэгт би итгэж байна) мисс Рэчелийн төрсөн өдрийн найрын үдэш үйлдсэн зүйлээ та давтан хийхэд учир ойлгодог аливаа хүн таныг тэр алмазыг шунахай сэтгэлээр хулгайлаагүй гэдэгт итгэх биз. Мистер Блэйк, би энэ асуудлыг хоёр талаас чадах чинээгээрээ тайлбарлалаа. Танд ойлгогдоогүй юм байгаа бол надад хэлээрэй, би танд тодотгоод өгье.

- Таны тайлбарласан бүхнийг сайн ойлголоо. Харин, үнэнээ хэлэхэд, надад тайлбарлалгүй орхисон нэг л юмыг ухаарахгүй байна даа.

- Юу юм бол?

- Хар тамхи надад яаж нөлөөлөхийг ойлгохгүй байна. Би яаж шатар бууж, гудмаар яваад шүүгээний шургуулга нээж, буцаад өрөөндөө очсоноо ер ойлгохгүй байна. Энэ бүхэн бол идэвхтэй ажиллагаа шүү дээ. Би, хар тамхи хүнийг эхлээд мансууруулж дараа нь унтуулдаг нөлөөтэй л гэж боддог.

- Хүн бүхэн хар тамхины тухай ингэж буруу боддог юм! Би бол яг энэ агшинд мистер Канди танд өгснөөс арав дахин их хэмжээний хар тамхины хандны нөлөөнд таны тусын тулд хамаг ухаанаа зарж байгаа юм шүү. Гэвч биедээ хийсэн сорилт дээр үндэслэн ярьж байлаа ч гэсэн миний үгэнд итгэх хэрэгтэй. би таныг яг ингэж хэлнэ гэж тааварлаж байсан юм. Тэээд ч таны болон найз нарын чинь сэтгэл жинтэй санагдах бас нэг жич гэрчтэй болж авса юм гээд ширээн дээрх хоёр номныхоо нөгөөг надад өгч,

- Энэ бол “Англи хар тамхичны үнэн үг” гэдэг их алдартай юм. Авч яваад уншаарай. Миний тэмдэглэсэн нэг газа Де Квинси “цадиггүй их хар тамхи” уусны дараа Дуурийн театрт очиж хөгжим сонсдог эсвэл бямба гаригийн орой Лондонгийн зах зээл дээр очиж ядуу хүмүүс ням

гаригт гол зогоох хоол олохын тулд юунхан хийхнээр наймаацаж байгааг ажиглан зугаацдаг гэсэн нь бий. Тэгэхээр хүн хар тамхины нөлөөгөөр идэвхтэй ажиллаганд орж, явж хөдлөх чадвар нь нэмэгддэг байна гэв.

- Та надад хариу хэлэх нь ч хэллээ гэхдээ хар тамхи надад ямраар нөлөөлөлхийг та хэлж өгөөгүй л байгаа шүү дээ гэж намайг хэлэхэд Эзра Женнингс,
- Би танд цөөн үгээр хариулахыг бодъё. Хар тамхины нөлө ихэнх тохиолдолд хоёр янз байдаг. Эхлээд сэргээн дэвэргэснээ дараа нь тайвшруулдаг. Сэргээн дэврээх нөлөөлөлд таны санаанд үлдсэн хамгийн сүүлчийн хамгийн тод сэтгэгдэл буюу тухайлбал алмазын таларх сэтгэгдэл илэрсэн байна. таны сэтгэл мэдрэлийн байдал ихээхэн эмзэг байсан тэр үед нөгөө сэтгэгдэл таны тархинд улам эрчимтэй болж ухаан бодол, хүсэл зоригийг чинь захирчээ. Энэ бол хү ердийн үүдэнд ч өөрцгүй ухаан бодол, хүсэл зоригоо захируулчихсан байдагтай яг адил юм л даа. Ийм учраас өдөр нь та өнөөх алмазыг алдаж орхиузай хэмээн дотроо зовж байсан бол хар тамхины нөлөөнд автан автсаар эргэлзээ нь итгэл болон хувираад чулууг хямтадахаар идэвхтэй хөдөлж, нөгөө өрөөнд орж, шүүгээний шургуулга татан эрдэнийн чулууг олж авсан байна. Энэ бүхнийг та хар тамхинд мансуурсны уршгаар үйлджээ. Тэгээд хар тамхины сэтгээн дэврээх нөлөө нь өнгөрч, тайвшруулах нөлөө нь давамгайлад ирэхэд таны бие аажмаар өлбийн суларч, хөшсөөр сүүлдээ гүн нойронд автжээ. Өглөө болоход хар тамхины нөлөө бүррмөсөн арилж, шөнө юү хийснээ огт мэдэхгүй, харин ч өөр ертөнцөөс залраад ирсэн юм шиг дажгүй байсан байна. Одоо миний тайлбар танд ойлгогдохоор болов уу?
- Ойлгогдохоор барах уу, цааш нь яриулмар байна. Та намайг хэрхэн орж, алмаз хэрхэн авсныг тайлбарлалаа. Гэтэл гарахда алмазыг аваад явж байсныг мисс Вериндер харсан гэж байгаа. Цааш нь би яасныг та тааж чадах уу?
- Яг энэ тухай одоо би ярих гэж байна. Бидний туршилт таны гэмгүйг нотлох хэрэгсэл болохын хамт алдагдсан алмазыг олоход тус болж юу магад гэж би бодож байна. Та мисс Вериндерийн өрөөнөөс эрдэнийн чулууг авч гараад өөрийнхөө өрөөнд л буцаж очсон байж таарна...
- Тийм үү? Тэгээд яасан юм бол?
- Та нэгэнт тар алмазыг алдчихаас айж байсан болохоор нэг газар нуух гэсэн байж таармаар, тэгэхээр унтлагынхаа өрөөнд л нэг газар нуусан байх гэж бодогдоно, өөр илүү юм хэлэхэд бэрх байна. Хэрэв үнэхээр тэгсэн бол таны явдал Ирландын нөгөө нэг зөөгчийнхтэй ижил болно. Иймд хар тамхийг дахин хэрэглэвэл түүрүүн хэрэглэсний нөлөөгөөр ламазыг нуусан газраа санаж магадгүй юм.

Одоо Эзра Женнингсийг бага сага юмаар сэнхрүүлэх ээлж надад ирлээ. Яриаг нь таслаад,

- Таны энэ хэлж байгаа тань, тун байж боломжгүй юм. Тэр алмаз одоо Лондонд байгаа гэсэнд ихэд гайхан өөдөөс ширтэж,
- Лондонд ы? Яахлаараа мисс Вериндерийн өрөөнөөс Лондонд хүрчихдэг байна аа? Гэв.
- Хэн ч үүнийг мэдэхгүй.
- Та түүнийг өөрийн гараар мисс Вериндерийн өрөөнөөс авч гарсан. Гэтэл таны гараас яаж мултардаг байна вэ?
- Үнэндээ мэдэх юм алга.
- Өглөө босоод тэр алмазыг үзсэн үү?
- Үгүй.
- Мисс. Вериндер буцаагаад авчихсан юм уу?
- Үгүй.
- Мистер Блэйк! Энд нэг л далд учир байна. Тэр алмаз одоо Лондонд байгааг та яаж мэдсэн юм бэ? Миний бие Англид буцаж ирээд Саран чулууны талаар анх асууж сураглахдаа мистер Браффаас яг ингэж асуусан юмдаг. Эзра Женнингст би хариу хэлэхдээ хуульчийн амнаа сгарсан үгийг давтан хэллээ. Тэр тухай уншигч авгай нар андахгүй билээ. Женнингс миний хариуд сэтгэл дундуур байгаа нь илэрхий ажээ.
- Би таныг болон, таны хуулий зөвлөгчийг хүндэтгэж байгаа хэдий боловч саяхан хэлсэн бодлоо баримтална. Энэ нь зөвхөн таамаглал л даа. Учлаарай, таны бодол ч гэсэн таамаглал шүү дээ.

Түүний бодол надад цоо шинэ зүйл байв.

Түүнийгээ хэрхэн хамгаалахы нь би сэтгэл догдлон хүлээхэд Эзра Женнингс,

- Та хар тамхины нөлөөгөөр, алдахгүй юмсан гэдэг зорилгоор амлазыг авсан бол тийм нөлөөгөөр, мөн л тийм зорилгоор өрөөндөө нэг газар нуусан байж таарна гэж би бодож байна. Харин та бол хуйвалдагч энэтхэгүүд яавч эндүүрэхгүй, алмазыг авах гэж мистер Люкерийнд очсон, тэгэхээр Люкерийн мэдэлд алмаз байх ёстой гэж бодож байна! Саран чулууг Лондонд аваачжээ гэсэн баттай баримт танд байгаа юм уу? Вериндер ахайнхаас хэн, ямар аргаар авсныг та таамаглаж ч чадахгүй байгаа шүү дээ! Эрдэнийн чулууг мистер Люкерт барьцаа болгож өгсөн тухай танд ямар

нэгэн баримт байгаа юм уу? Тэр хүн чинь Саран чулуу гэгчийн тухай ер сонсоогүй гэсэн, Бакных нь эрхлэгчийн баримт бичигт нэн үнэтэй зүйл гэснээс өөр юм дурдсангүй. Энэтхэгүүд Люкерийг худал хэлжээ гэж үзсэнийг та бас л зөвшөөрч байна. миний бодол бол боломжийн юм л гэж танаас зөрөн хэлье. Таны бодлын тухайд утга зүйн болон хууль зүйн талар өөр юү гэж хэлж болмоор байна.

Ширүүхэн хэлсэн боловч үнэн юмыг эсэргүүцэх аргагүй.

- Т намайг тээнэгэлзэхэд хүргэлээ. Таны хэлснийг мистер Браффт бичвэл та татгалзах уу?
- Хаанаас даа. Хэрэв та мистер Браффт бичвэл харин ч их баярлах болно. Тийм туршлагатай хүнтэй зөвлөвөл бидний ажилд тус дөхөм болж мэднэ. Одоохондоо, хар тамхиар сорилт хийх тухайгаа ярилцъя. Та тамхиа яг одооноос хаяна гэл үү? Хэмээн эзра Женнингс асуухад,
- Яг одоо л хаялаа гэж би хариулав.
- Энэ бол эхний алхам. Дараачийн алхам бол ноднин таны байсан тэр нөхцөл байдлыг аль болох адилхан болгож сэргээх ажил байна.

Үүнийг хэрхэн хийх вэ? Вериндер ахай нас барсан. Би хулгайд сэрдэгдэж байгаа цагт Рэчел бид хоёр эргэлтгүй салсан хэвээр байна. Годфри эблвайт Европоор тэнээд алга болсон, мини йхамгийн сүүчлийн удаа хоносон тэр айлд байсан хүмүүсийг цуглуулах боломж огт үгүй байлаа. Үүнд Эзра Женнингс зовсон шинжгүй байв. Намайг одоо нээнт өөрөөр үзэх болсон тэр хүмүүсийг цуглуулах нь нэг их чухал юм биш гэж Женнингс бодох ажээ. Нөгөө талаар, намайг тэр айлд сүүлийн удаа очихдоо байсан шиг орчинд л байлгавал бидний туршилт амжилттай болно хэмээн үзэж байсан тул,

- Хамгийн гол нь, та төрсөн өдрийн найры шөнө унтсан тэр өрөөндөө л унтах хэрэгтэй, тэр өрөөний тавилга засал яг тэр үеийнх шиг байвал зохино. Шат, гудам, мисс Вериндерийн зочны өрөөг бас л тьяны хамгийн сүүлчийн удаа үзсэнтэй адилхан янзлах хэрэгтэй. Тэр байшингийн доторх тавилга хэрэгслийг ийш тийш зөөсөн байвал одоо буцааж байранд нь тавих л туйлын чухал шүү мистер Блэйк минь. Ингэхийг мисс Вериндер зөвшөөрөөгүй цагт тамхиа хаясны чинь ач гавъяа гарахгүй шүү.
- Хэн зөвшөөрөл гуйвал дээр вэ? гэж би асуув.
- Та өөрөө гуйвал яасан юм бэ?
- Хэрхэвч болохгүй. Алдагдсан алмазын мөр дээрээс бид хоёрын хооронд болсон явдлын дараа би уулзаж ч, захидал бичиж ч чадахгүй.

Эзра Женнингс түр бодолхийлснээ,

- Танаас нэг нарийн юм асуух уу? гэв.

Би тогой дохилоо.

- Таны амнаас гарсан хэдэн үгнээс үзвэл таныг урьд мисс Вериндерт згээргүй байжээ гэж бодсон маань зөв үү, буруу юу?
- Яг зөв.
- Мисс Вериндер бас тийм байсан уу?
- Тийм байсан.
- Таны гэмгүйг нотлохын тулд мисс Вериндер үнэн голоосоо чармайх болов уу?
- Би эргэлзэхгүй байна.
- Тэгвэл зөвшөөрдөг юм бол би мисс Вериндерт бичье л дээ.
- Надад тавьсан саналынхаа тухай хэлэх гэж үү,
- Өнөөдөр та бид хоёрын ярилцсан бүхний тухай хэлье.

Би тийнхүү тусалъя гэснийг нь дуртайяа зөвшөөрснөө хэлээд илүү биз ээ.

Женнингс бугуйн цагаа харснаа,

- Захиа бичээд өнөөдрийн шуудангаар явуулчихаж амжих юм байна. Зочид буудалдаа очоод ороомол навчин тамхиа далдын далд хийхээ мартуузай! Би маргааш өглөө очиж, таны хэрхэн нойрссоныг мэдье гэв.

Би босож, явахынхаа өмнө түүнд туйлын их баярласнаа илэрхийлэх гэсэнд Женнингс миний гарыг эелдгээр атгаж,

- Арцат хөндийд миний ярьсныг санагтун. Мистер Блэйк минь, би танд энэ өчүүхэн тусыг хүргэж чадвал миний хувьд, бүрхэг урт өдрийн үдэш нарны туяа сүүлчийн удаа гялсхийн туссантай чанар нэг санагдах болно гэв.

Бид хоёр тийнхүү салав. Тэр өдөр зургадугаар сарын арван таван байсан юм. Түүнээс хойших арван өдрийн үйл явдлыг (өдөр бүр нь миний идэвхгүй оролцоотой сорилт лугаа их бага аль нэг хэмжээгээр холбогдсон билээ) канди эмчийн туслагч тэмдэглэлийнхээ дэвтэрт үг үсэгчлэн тодорхой хөтлөн тэмдэглэжээ. Эзра Женнингс тэмдэглэлдээ юу ч нуусангүй, юу ч мартсангүй. Хар тамхиар хэрхэн туршилт хийсэн, туршилт хэрхэн төгссөнийг Эзра Женнингс өөрөө танд толилуулав.

1849 оны зургадугаар сарын 1:... Өвчтөн үзэх, бас миний бие өвдөж байснаас бага зэрэг саатсан боловч би мисс Вериндерт бичих захидлаа бичиж дуусгаад өнөөдрийн шуудангаар цаг алдалгүй явууллаа. Захидлаа аль болох товчхон бичихийг бодсон боловч чадсангүй. Гэвч хэрхэн шийдэхээ дураараа болоорой, мөн бидний хийж буй туршлагад Фрэнклин Блэйк буюу намайг бодох үүднээс бус гагцхүү өөрийн хүслээр туслаарай гэсэн санаагаа тодорхой илэрхийлж чадсан гэж бодож байна.

зургадугаар сарын 16. Шөнөжин хар дарж зүүдлээд нар дээр хөөрсөн хойно бослоо, өчигдрийн хэрэглэсэн хар тамхины гайгаар янз бүрийн аймаар юм зүүдлэв. Заримдаа үхэж үрэгдсэн анд нөхөд, атаат дайснуудынхаа сүнстэй хамт огторгуйд эргэлзэн нисэж ч байх шиг, заримдаа дахин хэзээ ч барааг нь үл харах нэгэн хайрт хүний царай түнэл харанхуйн дунд миний орны хавьд сүүмэлзэн байснаа гэрэлтэн тоорч өөдөөс харан инээвхийлнэ. өглөө эрт алгуур хөдөлдөг архөг өвчин эхэлж, өнөөх ёрын зүүд, хий үзэгдлийг сарниан алга болгох тул сэтгэл амрах ч шиг, өвчин маань тэвчиж болох мэт санагдана.

Шөнө муу унтсанаас өглөө оройтож босоод Фрэнклин Блэйк дээр хожимдож очлоо. Намайг ороход буйдан дээрээ хэвтээд шар аххи, соодтой усаар даруулж уугад, шагшуур тачигнуулж байв.

- би ч сайхан эхэлж байн шүү, үүнээс илүү яах вэ дээ. Шөнөжин тарчилж, тавгүй хонолоо. Өнөө өглөө хоол идэх дур хүрсэнгүй. Ноднин тамхи хаясны дараа яг л ийм байж билээ. Хар тамхи дахин хүртэх бэлтгэл маань түргэхэн дуусвал аятай сан гэхэд нь би,
- Аль болох л түргэлнэ дээ. Гэхдээ бид таны эрүүл мэндийг онцгой анхарах ёстой. Таны тамирыг брагдуулчихвал бүр баларсан юм болно. Та хоол сайн иддэг болох хэрэгтэй, өөрөөр хэлбэл өглөө цэвэр агарт мориор буюу явгаар зугаалах хэрэгтэй гэж би хэлэв.
- Морь олж өгцгөөдөг юм бол мориор л явъя. Ингэхэд өчигдөр би мистер Браффт бичсэн, та мисс Вериндерт бичсэн үү?
- Бичсэн. Өчигдөр оройн шуудангаар явуулчихсан.
- Их сайн. Хоёул маргааш бие биендээ ярих сонинтой болох юм байна Жаахан хүлээгээрэй! Нэг юм хэье. Та өчигдөр, хар тамхин ыталаар бидний хийж байгаа туршлагыг миний заримнөхөд нэг их сайшаахгүй гэж бодож байх шиг байсан. Таны зөв байжээ. Би, Габриэл Бэттереж өвгөнийг найз нөхдийнхөө нэг гэж үздэг юм. Өчигдөр надтай уулзаад жигтэйхэн зэмлэж байсан нь даанч хөгийн. "М"стер фрэнклин минь, та энэ насандаа гайхмаар олон тэнэг юм хийсэн шүү, гэхдээ энэ чинь бусдаасаа хэтэрсэн тэнэг хэрэг байна!" Бэттереж гуай ингэж л бодож байгаа юм даа! Та уулзаж ярилцвал энэ мухар сохор бодлы нь харгалзан үзнэ биз дээ?

Би мистер Бэйктэй хэдхэн үг сольсон боловч бие хөнгөрч, сэтгэл сэргээд тэднийхээс гарч, өвчтөнүүдээ үзэхээр явсан билээ.

Миний сэтгэлийг татах энэ хүний увдисын нууц нь юу вэ? Бусад хүн намайг хайр найргүй зэвүүцэн үл итгэж байхад энэ хүнд надай танилцахдаа илэн далангүй чин сэтгэл гаргасан ийм эрс тэ сөөр байдалтай байсанднь болов уу? Аль эсвэл олон жилийн турш ганцаардаж, хяхагдаж явсаар сүүлдээ бүр мээрч, хүлцэхээ болих цаг ойртох тусам улам улам хүчтэй болж байсан хүсэл эрмэлзэлд минь буюу хүмүүс намайг өчүүхэн төдий боловч өрөвддөг болоосой хэмээх хүсэлд минь нааштай хандах тал түүнд үнэхээр байсан юм болов уу? Ийм асуудал тавиад ч ямар нэмэр байх вэ дээ! Мистер Блэйк надад амьдралыг шинээр үзэх сонирхол төрүүлэв. Чухам ямар сонирхол төрүүлснийг мэдэх гэж оролдохын ч хэрэггүй, ингээд л орхиё.

Зургадугаар сан 1\_. Өнөөгөлөө цайны өмнө мистер Канди Английн өмнөд нутагт суудаг нэг найзындаа очихоор хоёр долоо хоногийн хугацаагаар явна гэж мэдэгдэв. Хөөрхий минь, өвдөхөөсөө өмнөх шигээ хашир туршлагатай хэвээр буй мэтээр надад өвчтөнүүдийнхээ талаар тусгайлан олон заава зөвлөгөө өгөв. Одоо ч туршлага гэхээр юмгүй болсон билээ! Бусад эмч түүнийг тоохоо болсон, тэгэхээр намайг ажиллуулах хүн байхгүй.

Яг тэр үеэр эзгүй байх нь ч аз болж мэдэх юм. Би мистер Блэйктэй хийх туршилтынхаа тухай түүнд дуулгахгүй бол гомдох байлаа. Тэгээд ятгаж итгүүлсэн бол ямар ч эвгүй болох байсныг хэлэхүйеэ бэрх санагдана. Явсан нь дээр байжээ. Яриангүй, дээр байжээ.

Мистер Кандийг явсан хойно мисс Вериндерийн хариу шуудангаар ирлээ.

Хачин сайхан захидал байв! Уншаад л тун сайн хүн юм даа гэж бодлоо. Бидний хийх туршилтыг сонирхож буйгаа нуух гэж оролдсонгүй. миний захИдлаас мистер Блэйкийг гэмгүй хүн гэдэгт өчүүхэн төдий ч эргэлзэхгүй үнэмшсэнээ маш эвтэйхэн бичжээ. Тэр ч бүү хэл, хөөрхий минь, нууцын учрыг цаг тухайд нь тааварлан мэдсэнгүй хэмээн биеэ огт үндэсгүй зэмлэсэн байлаа! Хүнийг санандгүй гомдоосон нүглээ чин сэтгэлээсээ наманчлах гэсэнээ гадна өөр нэг шалтгаан бий бололтой. Хоёул хөндий байгаа ч гэсэн мистер Блэйкийг хайрласан хэвээр буй нь ил ажээ. Танихгүй хүнд

захидал бичихдээ нийтэд тогтсон журмыг баримтлах учиртай хэр нь цаадхыга хайрлавал зохих хүн гэдгийг нэлээд хэдэн газар цайлган сэтгэлээр аргагүй л цухуйлгасан байв.

Эл сайхан захидлыг нь уншаад энэ хоёр залууг эвлэрүүлж, дахин ойртуулахад зууч болох хү хорвоод надаас өөр байхгүй гэж үү? Хэмээн бодлоо. Амьдралын маань аз жаргал уланд гишгэгдэж, амраг минь бусдад булаагдсан билээ. Гэтэл би бусдын аз жаргалыг тэтгэж, хайр сэтгэлийг нь сэргээх тавилантай хүн байлаа гэж үү? Аяа, өршөөлт Үхэл та, намайг тэврэн аваад “Одоо л нирваан бологтүн!” хэмээн шивнэн тушаахаасаа өмнө үүнийг үзүүлж соёрхооч!

Мисс вериндер захидалдаа хоёр юм гуйсан байв. нэгд гэвэл, эн эзахидлыг фрэнклин блэйкт битгий үзүүлээрэй, харин мисс, Вериндер байшингаа бидний мэдэлд дуртайяа өгье гэсэн байна л гэж хэлээрэй, өөр илүү дутуу юм ярьсны хэрэггүй шүү гэсэн байв. энэ гуйсан зүйлийг нь биелүүлэхэд зовлон байсангүй. Харин хоёр дахь нь тун ч адармаатай санагдлаа.

Мисс Вериндер өгөх бүх зааврыг нь ёсоор гүйцэтгэхийг Бэттереж гуайд бичээд зогсоонгүй, зочды өрөөг хуучин янзаар нь янзлах ажлыг та биеэр ажиглан хянаж байгаач гэж надаас гуйсан байв. тэгээд надаас хариугаа амвагцаа Йоркширт ирж хар тамхины талаар хийх хоёр дахь удаагийн сорилын шөнө биеэр байлцан гэрч болохыг л хүсэж байна гэжээ.

Эн бас л цаанаа нэг шалтгаан байсны нь би тааж ядах юм байсангүй.

Мистер фрэнклинд хэлэхийг хориглосон зүйлээ бусдын нүүрэн дээр нэр төрөө цагаатгах сорилтонд орохынх нь урьд өөрөө хэлье гэж их хүссэн бололтой (би тэгж л ухаарав) Гэмгүй нь нотлогдсон ч, нотлогдоогүй ч нэрийг нь түргэхэн цагаатгах гэсэн авхйн ийм сайхан санаг би ойлгон бахархаж байна. Санаатай биш болвч яах ч аргагүй гомдоосон нүглээ, хөөрхий охин наманчлах гэж буй нь энэ ажээ. Даанч ингэж болохгүй нь харамсалтай. Уулзахын цагт хоёул урьдын дотно явснаа санаж, шинэ найдвар төрж, сэтгэл зүрх нь хөдлөн ялангуяа мистер блэйкт их нөлөөлөх учир бидний хийх туршлагад балаг тарих нь дамжиггүй. Тэгтэл одоо гэхэд л мистер Блэйкийн ноднин жилийнхтэй яг адил буюу төсөөтэй байдалтай болгоно гэхэд тун хэцүү байдаг. Сэтгэл санаа, сонирхол, эрмэлзэл нь шинэ шинэ зүйлээс болон өөрчлөгдвөл бидний туршлага ч өнгөрнө л дөө.

Үүнийг би мэдэж байвч бас мисс Вериндерийн урмыг хугалах зүрх үл хүрнэ. Чингэхээр, миний бие Фрэнклин Блэйкт үзүүлэх тусламжда хор болохооргүй юм сэдэж олсон хойноо л мисс Вериндерт зөвшөөрсөн хариу хэлэх нь зүйтэй гэж бодож байлаа.

Хоёр цаг. Би өчвтөнүүдээ үзчихээд дөнгөж сөя буцаж ирэв. Мэдээжээр, замда зочид буудлаар дайрав.

Мистер Блэйк өнгөрсөн шөнө урьдын адил байдалтай хоножээ. Хэдэн удаа сэрснээс өөр гойд юм болоогүй. Гэхдээ өчигдөр үдийн хоолны дараа унтсан болохоор өнөөдөр бие хөнгөн байна гэв. Мориор гадуур яв гэж миний зөвлөсний ачаар үдийн хоолноос хойш нойр авсан нь эргэлзээгүй. Цэвэр агаарт энэ маягаар гаргаж тамир тэнхээг нь сэргээх дасгалыг арга буюу хязгаарлахаас өөр замгүй болов. Яагаад гэвэл биеийг нь нэг чих чийрэг ч биш, нэг их дорой чибш, дунд зэргийн байдалтай байлгах ёстой. Энэ бол далайчдын үгээр хэлэхэд сэлүүрдлэгий нь яг тааруулна гэсэн хэрэг юм.

Мистер Браффаас сураг хараахан алга гээд мисс Вериндерээс хариу авсан эсэхийг маань их л сонирхон шохоорхож байа.

Хариуд нь би хэлбэл зохих ёстой зүйлээсээ илүү юм хэлсэнгүй. Ирсэн захидлы нь үзүүлэхгүй байгаа учраа тайлбарлах гэж үг зохиох хэрэгцээ огт байсангүй. Үзүүлж болохгүй учрыг чинь сайн ойлгож байна л даа гэж, зайлуул, их л гоморхон өгүүлээд,

- цаадах чинь хүнийг хүндлэх, шударгаар үзэх ёсыг дагаж л зөвшөөрч л дээ. Гэхдээ миний тухай өөрийн бодлоо хэвээр хадгалсаар, туршлагын үр дүнг хүлээж байгаа биз гэхэд нь “Урьд мисс Вериндер таныг буруу ойлгож байсан шиг одоо та түүнийг буруу ойлгож байх шив дээ” гэж арай л хэлчихсэнгүй. Гэнэт баярлуулж, шууд уучлах гэсэн бүсгүйн нууцы урьдаас задлаад яахав хэмээн сэтгээд би ам хамхив.

Би тэднийд удсангүй. Өчигдөр шөнийн туршлагын дараа миний бие хар тамхи хэрэглэхээ дахин болиход хүрэв. Тийм учраас тамалгаатай өвчин арггүй л дахин хөдөлсөн юм. Өвдөж эхэлмэгц мистер Блэйкийг зовоож, сандраахгүйн тулд шалавхан гарч одов. Энэ удаа ужигласангүй, нэг мөч хэртэй л үргэлжлээд өнгөрсөн болохоор би ажлаа цааш явуулах тэнхээтэй болов.

Таван цг- Би мисс Вериндерт хариу захидал бичлээ.

Хэрэв энэ авхай зөвшөөрдөг юм бол миний төлөвлөсөн зүйл хоёулангийнх нь эрх ашгигт тохирч байгаа юм. Туршлага эхлэхий өнмө мистер Блэйк тэр хоёрын уулзахыг зөвшөөрөхгүй гэдээ би хамгийн түрүүнд учирлан мэдэгдээд, Вериндер авхайг бидний туршлага хийх орой л гэртээ нууцаар ирэх нь зүйтэй гэлээ. Лондоны үдийн галт тэргээр гарч, оройн есөн цагийн өмнө ирвэл тохиромжтой болно. Тэр үед нь миний бие мистер Блэйкийг унтлагын өрөөнд нь оруулчихна, тэгсэн цагт мисс Вериндер туршлага эхлэхээс өмнө өрөө тасалгаагаараа орох боломжтой болох юм. Тэгвэл хийх

туршлагын үр дүнг мисс Вериндер бидний хамт ажиглахад татгалзах юм бидэнд үгүй. Маргааш өглөө нь мисс Вериндер өөрөө хүсвэл надад бичсэн захидлаа мистер Блэйкт үзүүлэхэд гэмтэй гэмгүйг нь сорин туршихаас өмнө мисс Вериндер өөрийг нь нэгэнт цагаатгасан байжээ гэдэгт итгүүлж санааг нь амраах учиртай юм.

Би тэр авхайд ийм утгатай захиа бичлээ. Өнөөдрийн хувьд миний хийж чадах зүйл ердөө л энэ байлаа. Маргааш би Бэттереж гуайтай уулзаж, байшингийнх нь доторхийг хэрхэн янзлах тухай чухал заавар өгөх ёстой.

Зургадугаар сарын 1,. Фрэнклин Блэйк дээр бас л хожмидож очлоо. Өглөө эрт өнөө айтхар өвддөг маань улам даамжирч, дараа нь хэдэн цагийн турш тамир алдрв. Хар дарж зүүдлэн зововч хар тамхийг хойшд зуу дахин хэрэглэх юм байна гэдгээ ёрлож байна. Ганц биеэ бодохул аймаар хар дарж гарчилж байснаас өвдөж зовж байсан маань дээр санагдна. Тэгтэл бие өвдөхөөр тэнхээ барагдах юм. Биеэ гаргуунд нь хаячихвал мистер Блэйкт хамгийн их хэрэг болох үед арчаагаа алдчих гээд байдаг.

Өнөөдөр зочид буудалд очиход бараг нэг цаг болж байв. миний бие тааруухан байсан хэдий боловч тэнд габриэл Бэттереж ирсний ачаар ихээхэ зугаатай байж билээ. Намайг орж очиход өрөөнд нь сууж байв. Өвчтөнөөсөө ердийн лавладаг хэдэн зүйл асууж байх зуур өвгөн цонх руу очоод гадагш юм харж зогсов. Мистер Блэйк урьд шөнө бас л нойр муу хоносо болохоор улам ч их тамирдаж ядарсан харагдана. Мистер Браффаас сурагтай эсэхийг асуувал өглөө захидал ирсэн гэв. Өөрийн найзг, түнш нь миний зөвлөснөөр хийх гэж буй зүйлийг туйлын их буруушааж, огт бүтэшгүй горьдлого төрүүлэхээс цаашгүй дэмий зүйл гэжээ. Түүнээс гадна ховс, мэрэг төлөг мэт ов мэх л баймаар огт үл ойлгогдох ажил байна. Вериндер авхайн гэр орныг түйвээсэн одоо өөрийг нь түйвээж дуусах вий. Энэ тухай нэгэн алдартай эмчид (нэрийг нь дурдсангүй) ярьсанд алдартай эмч нь инээмсэглэн толгой сэгсэрсэн мөртлөө юү ч хэлсэнгүй гэнэ. Ийм учраас мистер Брафф бидний төлөвлөн буй зүйлийг эсэргүүцэж байгаа юмсанж.

Би дараа нь очир алмазын тухай сонирхов. Хуульч маань лмазыг Лондонд байгаа нотолгоо олж уу? Олох бүү хэл, ер нь уг асуудлыг хэлэлцэхийг хүссэнгүй. Саран чулууг мистер Люкерт барьцаанд өгсөн итгэж байгаа ажээ. Юдоо эзгүй буй алдарта найз Мэртвэйт нь ч (энэтхэг хүний зан байдлыг сайн мэддэгийг нь хэн ч үгүйсгэж чадахгүй) үүнд итгэсэн байв. Иймэрхүү нөхцөл байдлын улмаас, мөн толгой дээш татах завгүй байгаа учраас нотолгоо баримтын тухай аливаа маргаан хийхээс татгалзах ёстой болжээ. Цагийн аяс аяндаа харуулаад өгнө, тэгэхээр мистер Брафф дуртайяа азнах ажээ. Мистер Блэйк захидлыг уншиж өгөлгүй зөвхөн агуулгыг нь ярьсан авч надад итгэхгүй байгаад л хэргийн учир буй нь даанч тодорхой байв. Ингэнэ гэдгийг нэгэнт тгааварлаж байсан болохоор гайхсан ч үгүй, гонсойсон ч үгүй. Найз чинь эсэргүүцэж байгаа болохоор эргэлзэж байна уу гэж би мистер Блэйкээс асуухад, санаа бодол нь өчүүхэн төдий ч нөлөөлөхгүй байна хэмээн их л зоримог хариу өчив. Ийм үг сонсоод би Браффын саналыг анзаарахгүйгээр шийдэх эрхтэй болж анхаарахаа бүр болив.

Бид хоёрын яриа түр завсарлахад Габриэл БэБэттереж цонхноос холдон дөхөж ирээд,

- Одоо надтай хэдэн үг сольж соёрхохсон болов уу, эрхэм ээ? Гэж надаас асуухад нь,

- Би таны үгийг сонсоход бэлэн байна гэж хариулав.

Баттереж гуай сандал авч ширээний ард суулаа. Тэгээд хуучин маягийн ширэн хавтастай том өврийн дэвтэр, түүндээ таарсан бүдүүн харандаа гаргаж ирэв. Нүднийхээ шилийг зүүж, өврийн дэвтрээ нээгээд цэвэр хуудас гаргаснаа намайг сүрхий ширтэн.

- би талийгаач хатагтайнхаа албанд тавь шахам жил зүтгэсэн хүн. Өвгөн ноён эцгийн нь сэрүүн тунгалаг цагт зарц явлаа. Одоо би дал хол гараад ная шахаж явна, чухам хэдтэйгээ мэдэхгүй! Намайг хэнээс ч дутахгүйгээр хал үзэж хашир сусан хүн гэлцдэг. Тэгээд энэ маань юугаар төгсөх гэж байна даа? Эзра Женнингс минь, энэ чинь докторын туслагчийг ид шидтэн болгож, өвгөн намайг ид шидтэнд туслалцуулан, хуруу шилтэй хар тамхины хандаар Фрэнклин Блэйкт туршлага хийснээр л дуусах гэж байна шүү дээ, ай бүү үзэгд! Гэв.

Мистер Блэйк инээд алдав. Би юм хэлэх гэтэл Бэттереж гуай хэлэх юмаа хэлж дуусаагүй байна хэмээн дохиж нэг гараа өргөснөө

- Мистер Женнингс минь, дуугарсны хэрэггүй! Танаас ганц ч үг сонсохыг хүсээгүй байна эрхэм ээ. Тэнгэрийн авралаар, би чинь өөрийн гэсэн зарчимтай хүн. Беламаас1 ирдэгтэй адил зарлиг ирлээ ч гэсэн би баримталдаг зарчмаасаа ухрахгүй. Харин эзэн, эзэгтэй нарынхаа буулгасан зарлигийг би дагах л болно. Би бас өөрийн гэсэн бодолтой байж болно. Миний бодол мистер Брафф, агуу их мистер Браффын санаатай таарч байгааг та санаж үзээрэй! Гэж Бэттереж гуай дуугаа өндөрсгөн толгойгоо намбатайхан дохисноо, - За энэ ч яахав, би бодлоосоо ухаръя. Залуу эзэгтэй маань. "Гүйцэтгэ!" гэвэл би "За, гүйцэтгэе" л гэнэ шүү дээ. Би өврийн дэвтэр харандаа хоёроо гаргачихаад байна. Харандаагаа л санаандаа хүртэл олигтой үзүүрлэж чадсангүй, гэхдээ христос мөргөлтнүүд

солиорч гэм харандааны үзүүр хурц байна уу, мохо байна уу гэж хэн хөөцөлдөх вэ дээ. Мистер Женнингс минь, надад өгөх тушаалуудаа хэлээд бай, би бичээд авъя, эрхэм ээ. Заавраас нь хумсын чинээ ч хожимдохгүй, урьтахгүй гэж шийдсэн. Би бо сохроор гүйцэтгэдэг хүн юм шүү дээ хэмээн биеэ тийнхүү тодорхойлсондоо хязгааргүй уужрах мэт давтан хэлэв.

- Та бид хоёр санал зөрсөнд би их харамсаж...гэтэл Бэттереж гуай миний үгийг таслан,
- Энэ хэрэгт намайг бүү орооцолдуул! Энэ бол санал нийлэх, эсэх тухай асуудал биш, харин захирагдах эсэх тухай асуудал. Эрхэм минь захирамжаа л гарга. Алив та захирамжаа хэлэгтүн! Гэв.

Мистер Блэйк надад хэлсэн дээр нь ашигла гэсэн дохио өгөв. Тэгээд би “захирамжаа” аль болох тодорхой бөгөөд нухацтай өгүүллээ.

- Энэ байшингийн зарим өрөө тасалгааг ноднин жилийн өдийд байсан янзаар засах хэрэгтэй байна. Бэттереж гуай мохоо харандаагаа нэг долоож норгосноо,
- аль, аль өрөөг засах вэ, мистер Женнингс нэрлээд байгаарай гэж додигор хэлэв.
- Нэгд, голын шат руу ордог дотоод өрөө,
- Нэгд, дотоод өрөө гэж Бэттереж гуай бичсэнээ- Ноднин жилийнх нь байдлаар засах боломж байхгүй. Эрхэм инь гэв.

1 Бедлам 1402 онд Лондон хотноо байгуулсан сэтгэл мэдрэлийн эмнэлэг

- Яагаад?
- Яагаад гэвэл ноднин тэр өрөөнд сар шувууны чихмэл байсан юм. Мистер Женнингс. Гэрийн эздийг явахад бусад юмны хамт гаргасан. Чихмэлийг гаргах гэж байгаад эвдчихсэн юмдаг.
- Тэгвэл чихмэлээс бусды нь тавь даа.

Бэттереж гуай үүнийг анхааралдаа авч - “Дотоод өрөөг ноднин байсан байдлаар засах. Гагцхүү эвдэрхий чихмэлээс бусдыг нь” гэж бичээд –Цааш нь хэл дээ мистер Женнингс гэв.

- Шатны хивсийг урьдын байдлаар дэвсэх.
- “Шатны хивсийг урьдын байдлаар дэвсэх гэж бичсэнээ” –Эрхэм минь, ингэж даанч болохгүй нь харамсалтай гэв.
- Яагаад болдоггүй юм бэ?
- Яагаад гэвэл, мистер Женнингс минь, тэр хивсийг дэвсэж байсан хүн үхчихсэн шүү дээ. Хивсийг яг тэр хүн шиг өнцөг булан бүхэнд нь тааруулж чаддаг хүн Англи орон даяар эрэвч олдохгүй.
- За яахав, удаа нь орох хүн Англи даяар олохыг хичээе л дээ.

Бэттереж гуайн тэмдэглэж дуусахаар нь би захирамжаа үргэлжлүүлэн өгөв.

- Мисс Вериндерийн зочны өрөө, түүнчлэн зочны өрөөнөөс анхны тавцан хүртэлх гудам, бас хоёр дахь тавцангаас унтлагын өрөөнүүд хүртэлх гудам, мөн ноднин зургадугаар сард Фрэнклин Блэйкийн сууж байса унтлагын өрөөг яг ноднингийнх нь байдлаар янзлах.

Бэттереж гуайн мохоо харандаа миний хэлснийг үг бүрчлэн тэмдэглэж байлаа.

- Эрхэм ээ, цааш нь. Миний харандааны үзүүр бас нэлээд юм бичиж дөнгөхөөр байна шүү гэж Бэттереж гуай ёжтой ихэмсэг байдлаар өгүүлэв.

Өөр өгөх захирамж надад алга гэсэнд Бэттереж гуай,

- Тэгвэл эрхэм минь, би санаанд орсон ганц хеёр зүйл тэмдэглээтэхье гээд дэвтрийнхээ хуудсыг эргүүлж цэвэр хуудас гаргаад бичиж барагддаггүй харандааныхаа үзүүрийг бас нэг долоогоод
- Би гараа угааж болох уу, үгүй юү гэдгийг мэдмээр байна1 гэхэд нь
- Бололгүй яахав. Би зарц дуудаадахья гэж мистер Блэйк хэллээ. Гэтэл өрөөнд надаас өөр хүн байхгүй мэтээр Бэттереж гуай огт хэнэггүй үргэлжлүүлэн:-...зарим нэг хариуцлагаас зайлсхийхийн тул мисс Вериндерийн зочны өрөөнөөс эхэлье. Ноднин хивсий нь авахад, мистер Женнингс минь, гайхмаар олон сүүлбэр зүү гарсан шүү дээ. Тэр бүгдийг бас тавих уу? гэв.
- Өө, хэрэггүй.

Бэттереж гуай доор нь тэмдэглэж авлаа.

- Нэгдүгээр давхрын гудмын тухайд гэвэл, тэнд байса гоёл чимэглэлийн зүйлүүдийг зайлуулахдаа тус гэрийн эд аж ахуйн дансанд алдас болмоор үгээр “Амрагийн сахиус” гэж бичсэн байдаг тарган шалдан хүүхдийн баримлыг бид бас зайлуулсан. Тэгэхэд махлаг мөрөн дээрээ хоёр жигүүртэй байсан юм. Түр нүд салгах хооронд нэг нь алдагдсан юмдаг. Тэр жигүүрийг нь би хариуцах уу? гэхэд нь, би дахин буулт хийсэнд өвгөн бас л тэмдэглэв.
- Нөгөө гудмын тухайд гэвэл, ноднин тэнд өрөө тасалгааны хаалгануудаас өөр юм юу ч байгаагүй (хэлрэв хэрэгтэй бол би тангараглахад ч бэлэн байна) үнэнээ хэлэхэд, энэ байшингийн тэр хэсэгт л сэтгэл зовох юмгүй байдаг юм. Харин мистер Фрэнклиний өрөөний хувьд гэвэл (урьдын байсан янзаар засны гэх юм бол) эмх цэгцтэй байлгая гэж хэчнээн оролдсон ч хэзээний л энд ч өмд,

тэнд ч алчуур, газар сайгүй франц роман хөглөрсөн, үргэлжийн новширсон байлгах ажлыг хэн хариуцах вэ гэдгийг мэдмээр байна. Мистер Фрэнклиний өрөөг эмх замбараагүй байлгах ажлыг тэр хүн, бид хоёрын аль нь хариуцах вэ гэж байгаа юм шүү дээ гэв.

үүнийг тун тааламжтайяа биеэр хариуцъя гэж мистер Блэйк өчсө боловч Бэттереж гуай миний заавар, сайшаалыг сонсохоос нааш эл асуудлыг өөр хэний ч үгээр шийдэхгүй зөрүүдлэн зүтгэнэ. Би мистер Блэйкийн хэлснийг дэмжсэнд Бэттереж гуай бичиж авлаа.

1 Английн “To wash hands” гэдэг гар угаах гэсэн хэллэгийн нэр утга нь (хариуцлагаас) ...зайлах” гэсэн санааг илэрхийлнэ (ред)

Бэттереж гуай босож,

- Мистер Женнингс, та маргаашнаас очоорой, би туслах хүмүүсийнхээ хамт таны тушаасан ажлыг хийж байх болно. Хэмхэрсэн чихмэлийн талаар бас сахиусны жигүүрийн талаар та намайг өршөөж, мөн хивснээс гарсан олон сүлбээр зүүний тухайд, түүнчлэн Фрэнклин ноёны өрөөний новширхуу байдлыг хариуцахаас намайг хэлтрүүлж өгсөнд туйлын их талархаж буйгаа танд илэрхийлэхийг соёрхоно уу. Зарц хүний хувьд, би танд маш их баярлаж байна. Харин эр хүний хувьд, би таныг элдвийн хачин бодлоор тархи толгойгоо дүүргэсэн хүн юм хэмээн таны хийхээр сэдсэн туршлагыг хүнийг хуурч мэхлэх урхи гэж үзээд эсэргүүцэж буйгаа илэрхийлж байна. Гэвч ингэж бодоод зарцынхаа үүргийг эс гүйцэтгэнэ. Таны толгойд ямар ч хачин бодол байсан би таны үгийг дагана, эрхэм минь. Байшинд гал гардаг юмаа гэхэд та хонх цохиж, гал сөнөөгчдийг дуудах тушаал өгөхөөс нааш би тэднийг дуудвал уу, намайг хараал идэг! Хэмээгээд мэхэхийн ёсолж гарч одов.

- Найдаж болох хүн гэж та бодож байна уу? гэж намайг асуухад мистер Блэйк.

- Яриангүй. Очоод үзэхэд бүгдийг ёсоор хийсэн, ганц ч юм мартаагүй гүйцэтгэсэн байна даа гэв.

Зургадугаар сарын 19. Бидний төлөвлөсөн туршлага бас нэг эсэргүүцэлтэй тулгарав. Энэ удаад нэгэн хатагтай эсэргүүцдэг юм байна.

Өнөө өглөөний шуудангаар надад хоёр захиа ирлээ. Нэг нь мисс Вериндер миний тавьсан саналыг нэн халуунаар хүлээн авч буйгаа мэдэгдсэн захидал, нөгөө нь энэ залуу авхайг асрамжиндаа авсан Мерридю хатагтайнх байв.

Мерридю хатагтай миний мэндийг хүндэтгэн эрээд, мисс Вериндер та хоёрын захидлаар хэлэлцэн буй зүйлийн шинжлэх ухааны утга учрыг ойлгохгүй байна, харин нийгэмд холбогдох учир зүйн талаар нь бол өөрийн санал бодлыг хэлж болно байх гэжээ. Мисс Вериндерийг дөнгөж арван ес хүрч явааг намайг мэдэхгүй хэмээн боджээ. Ийм насны залуу авхайг дан эрчүүд дүүрэн байшинд (харж хаацайлах эмэгтэй хүнгүйгээр) анагаахын туршлага хийхэд оролцуулна гэдэг нь эрхэмлэн сахих ёс журамд нийцэхгүй тул зөвшөөрч чадахгүй нь ээ. Уг ажлыг нэгэнт шийдчихсэн аваас миний бие өөрийн тав тухыг сүрхий алдуулавч Йоркширт мисс Вериндер ганц таны үгнээс гажихгүй байгааг харгалзан та уг төлөвлөсөн зүйлээ дахин хянаж өөрчлөхийг бодно уу. Мисс Вериндер заавал очих шаардлагагүй байж магад бус уу. Та иймэрхүү ганц л үг хэлчихвэл та бид хоёр тун эвгүй хариуцлагаас мултарна шүү дээ гэжээ.

Энэ эелдэг, ёсорхог үгийг жирийн хар үгээр орчуулбал, миний ухаарч байгаагаар бол, Мерридю хатагтай олны хэл амнаас үхтлээ айж буй ажээ. Гэтэл тийм санаа бодлыг даанч тоомсорлон үздэггүй хүнд хандсан нь харамсалтай юм даа. Би Вериндерийн урмыг хугалж, гонсойлгох ч үгүй, бие биенээсээ салаад өчнөөн удсан хоёр залуугийн уулзаж учрх цагийг хойш татах ч үгүй. Энэ эгэл хар үгийг эелдэг ёсорхог үг болгон хөрвүүлбэл, Женнингс миний бие Мерридю хатагтайн мэндийг хүндэтгэн эрээд нэгэнт шийдэж төлөвлөсөн ажилд цаашид элдвээр оролцохыг зөв гэж үзэхгүй байгаадаа харамсаж байна гэсэн үг юм.

Мистер Блэйкийн бие өнөө гөлөө урьдахаасаа өөрчлөгдөөгүй гэнэ. Бэттереж гуай дээр очиж, төвөг удахыг өнөөдөртөө больцгооё гэж бид хоёр шийдлээ. Шалгах цаг маргаашдаа бишгүй их гарна.

Зургадугаар сарын 20. – Блэйк ноён шөнө олигто йунтаж чадалгүй зовдог нь эхэлж байгаа ажээ. өрөө тасалгааг аль болох түргэн янзалбал одоо тун хэрэгтэй байнасанж.

Өнөө өглөө мистер Блэйк байшин руу очих замдаа түрүүч Каффаас (Лондонгоор дамжиж ирсэн) авсан захидлынхаа талаар надтай нэлээд шид муутай, үймэрсэн янзтай ярилаа.

Мистер Кафф Ирландаас бичжээ. Доркингийн ойролцоох байранд нь мистер Блэйкийн орхисон нэрийн хуудастай зурвасыг (гэрийнх нь зарц авгай дамжуулжээ) авлаа гэдгээ мэдэгдээд Англид долоо хоногийн дараа ч юм уу, наана нь очно гэжээ. Одоохондоо мистер Блэйк Саран чулууны талаар (зурвастаа тэгж бичсэн байж) чухам ямар учиртай ярилцах гэсэн юм бол, мэдэхсэн гэжээ. Ноднин жил очир алмазын хэргээр явуулсан мөрдлөгийн үеэр ноцтой алдаа гаргасан гэж мистер Блэйк гарцаагүй итгүүлэх аваас миний бие (талилгаач Вериндер ахайн өгөөмөр шан харамжийг

бодож) залуу эрхмийн мэдэлд очих үүрэгтэй гэж үзэж байна. Эс итгүүлбэл цэцэг навч нь дэлгэрсэн хөдөөгийн энэ амгалан нутгаасаа гармааргүй байгааг болгоон соёрхоно уу гэсэн байв

Би тэр захидлыг уншаад, ноднин мөрдөн байцаах ажил зогссоноос хойш тохиолдсон бүх явдлыг тоочин бичиж, түрүүч Каффт мэдэгдэн, тодорхой баримтуудаас дүгнэлт хийх бололцоо түүнд олгох хэрэгтэй гэж мистер Блэйкт шууд зөвлөв.

Бас тунгаан бодвоос түрүүч Кафф бидний хийх туршлагаас өмнө Лондонд ирчихвэл туршлагын үед байлцаач гэж урих нь зүйтэй мэт санагдав. Хамгийн наад зах нь сайн гэрч болохоос гадна, тэр алмазыг мистер Блэйкийн өрөөнд нуусан болов уу гэдэг миний таамаглал бүруутвал хойшид миний бие нэгэнт оролцож чадахгүй ажил үйлд тэр хүний зөвлөгөө нэн чухал юм. Энэ саналыг сонсоод мистер Блэйк сэтгэл шулуудав бололтой, миний зөвлөснийг дагана гэж надад ам өгөв.

Биднийг байшингийн довжоон дээр хүрч очиход алх сүхний дуу хадах нь өрөө тасалгаануудыг хуучин байдлаар нь засаж янзлах ажил ид оволзож буйг илтгэнэ.

Энэ ажлын үеэр загасчны улаан малгай тацууямбуун хормогч зүүсэн Бэттереж гуай бид хоёрыг үүдний өрөөнд угтан уулзав. Намайг хармагцаа дэвтэр, харандаагаа гаргаж ирээд миний амнаас унах үг бүрийг заавал тэмдэглэж авна гэв. Хаашаа ч харсан ажил яг л Блкэй ноёны хэлснээр хурдан шуурхай, өө сэвгүй хийгдэж байна. Харин дотоод өрөө болон мисс Вериндерийн өрөөнд хийх юм бас л их үлджээ. Энэ долоо хоногийн шувтаргаар янзалж дуусгана гэхэд эргэлзээтэй мэт байлаа.

Хийж гүйцэтгэсэн ажилд нь баяр хүргээд (Бэттереж гуай намайг ам нээх бүрд үг гээлгүй тэмдэглэж авах атлаа мистер Блэйкийг юу ч гэж хэлсэн өчүүхэн төдий ч анхаарахгүй ажээ) бид нэг хоёр хоногийн дараа ирж шалгана гэв.

Тэгээд бид арын хаалгаар гарахаар завдан доод давхрын гудмаар явж байтал Бэттереж гуай намайг өөрийнхөө өрөөний яг үүдэнд зогсоож,

- Тнд аминчлан ганц хоёр үг хэлж болох уу? хэмээн их л нууцлан шивнэв.

Би ч мэдээжээр зөвшөөрлөө. Намайг Бэттереж гуайн өрөө рүү ороход мистер Блэйк цэцэрлэгт хүлээхээр гарав. Нөгөө сар шувууны чихмэл, Сахиусны жигүүрийн дараа бас баахан буулт хийлгэх шаардлага тавих нь л дээ гэж бодлоо. Гэтэл гайхмаар юм бол Бэттереж гуай миний бугалга дээр гараа цаанаа нэг их учиртай мэт тавьснаа,

- Мистер Женнингс та “Робинзон Крузог” сонсоод яаж гайхахыг нь харья байз! Хэмээн надад биш, өөртөө хэлэв.

Тэгээд өрөөний булангийн шүүгээг онгойлгож нэг навсарсан халтар ном гаргаад хуудсыг нь эргүүлж эхлэхэд тамхины нэгшсэн үнэр хамар цоргив. Хайсан хуудсаа олов бололтой, намайг дуудлаа. Ингэхдээ бас л итгэмлэн нууцалсан мэтээр шивнэнэ.

- эрхэм минь, тэр хар тамхи, мистер Блэйктэй хийх таны илбэ жилбийн талаар ярья. Энэ байшинд ажилчид байх үеэр би зарцын үүргийг хүн гэсэн сэтгэлээсээ илүү эрхэмлэх юм, харин ажилчид явсан хойно би бол хүн шүү ээ гэсэн сэтгэл зарцын үүргээсээ давчих юм. Ийм л байсан даа. Мистер Женнингс урьд шөнө таны хийхээр завдан буй анагаах ухаан ыажил муугаар төгсөх юм банья гэж бодогдоод тун болсонгүй. Хэрэв би тэр далдын зарлигийг дагасан бол өрөө тасалгаанд орж тавьсан тавилаг хогшлыг өөрийн биэр дахин зайлуулаад, өглөө ажилчдыг ирэхээр хөөгөөд явуулчих байлаа шү гэв.

- Дээд давхарт таны хилгэсэн ажлыг үзвэл та тэр далдын зарлигт автсангүй гэдгийг мэдээд баярлаж байна.

- Автсангүй биш, тэмцжээ гэвэл таарна. Эрхэм ээ, миний бие дотоод сэтгэлийн зарлигтаа татагдан нэг тийш хэлтийхэд тэмдэглэлийн дэвтэртээ бичиж авсан зарлиг өөр тийш нь татаад, шулуухан хэлэхэд хүйтэн хөлсөө асгартал тэмцэж байлаа шүү дээ. Тэгж сэтгэл зовон хямарч, бие сулран тамирдаж байхдаа би ямар эмчилгээний арга хэрэгвэл? Эрхэм минь, сүүлийн гуч гаруй жил аминд орсон энэ номоо л хэрэглэсэн шүү! гээд номоо падхийтэл алгадахад нэгшсэн тамхины үнэр улам ч их ханхлав.

- Би энэ нээгээд байгаа хуудаснаас юу олов? Зуун далан наймдугаар хуудсанд, аймшигтай юм бичсэн байна. сонс л доо: “Энэ болон энэ мэтийн Бодлыг миний бие сүүл сүүлдээ журам болгосон буюу аливаа нэг зүйлийг хийх эсэх, энэ замаар явах уу, тэр замаар явах уу гэдгийг сэтгэлийн далдын Дохио буюу Зааврыг даган шийдэж, Далдын Зарлигаас ер гаждаггүй болсон билээ” гэжээ. Мистер Женнингс, би далдын зарлигийг үл тоомсорлон явсан яг тэр үед миний нүдэнд хамгийн түрүүнд энэ үгүүд л яах аргагүй өртсөн юм шүү. Үүнд этгээд юм байхгүй байгаа биз дээ, эрхэм ээ?

- Санамсаргүй тохиолдлоос өөр юу ч алга.

- Та тэр хийх гэж байгаа анагаах ухааны ажлынхаа талаар өчүүхэн ч эргэлзэхгүй байна уу?

- Өчүүхэн ч үгүй.

Бэттереж гуай намайг дуу шуугүй, жигтэйхэн сүрхий ширтэж, номоо нямбайлан хаагаад хоолны шүүгээнд нэн болгоомжтой буцааж хийгээд, эргэж, намайг дахин няхуур ажиглав. Тэгснээ,

- Эрхэм ээ, “Робинзон Крузог” багадаа л нэг уншаад дахиж сөхөөгүй хүнийг уучлах тал олон бий гэж нухацтай өгүүлээд – Баяртай гэв.

Бэттереж гуай өрөөнийхөө үүдийг онгойлгон доор мэхийн ёслоод цэцэрлэгт гарах замыг өөрөө олог хэмээн намайг орхих нь тэр. Мистер Блэйктэй байшин руу буцаж явахад нь тааралдав.

- Юу болсныг надад ярилтгүй. Бэттереж гуай эцсийн мэхээ хэрэглэж үзээ биз. Бодвол “Робинзон Курзогоос” бас нэг мэргэн зөн олсон байлгүй. Та түүний нандингадаг хоосон бодлыг нь дооглов уу? Үгүй юу? Та “Робинзон Крузод” итгэдэггүйгээ мэдэгдээ биз дээ? Женнингс гуай, та ч Бэттереж гуайд адгийн доогуур үнэлэгдэх нь тэр дээ! Хойшид хэлэх гэснээ л хэлж, дуртайгаа л хий. Одоо цаадах чинь танд дахиад ганц үгээ ч гарздахгүй, харж л байгаарай.

Зургадугаар сан 21. - Өнөөдөр би өдрийн тэмдэглэлээ товчхон хөтлөх болно.

Мистер Блэйк урьд шөнө хэзээ хэзээнийхээс доор байжээ. Би түүнд арга буюу эм бичиж өгөв. Аз болоход түүн шиг сэтгэл хөдлөмтгий хүмүүст эмийн нөлөө түргэн тусдаг ажээ. Тэгээгүй бол туршлага явуулахын цагт түүний бие бүр дийлэх янзгүй болох нь гэж би айх байлаа.

Миний хувьд гэвэл, сүүлийн хоёр өдөр бага зэрэг өвдөж байснаа өнөө өглөө гэнэт ширүүссэ тул би арга буюу хар тамхи дахин хэрэглэхэд хүрснээ хэлэхээс өөр үг алга. Одоо тэмдэглэлийн дэвтрээ хааж тавиад хар тамхины ханднаас бүхэл тун таван зуун дуслыг ууя.

Зургадугаар сан 22. – Бидний найдлага өнөө өглөө нэлээд нааштай мэт. Мистер Блэйкийн сэтгэл, мэдрэлийн тарчилгаа ихээхэн намдаж, урьд шөнө овоо дугхийжээ. Би энэ шөнийг хар тамхины ачаар нам дэлсүүлсэн хүн шиг л өнгөрөөлөө. Өнөө өглөө би нойроос сэрсэн гэхийн оронд ухаан орсон гэвэл илүү оновчтой болох биз ээ.

өрөө тасалгааг засаж янзлах ажил юу болж байгааг үзэхээр бид байшинд очлоо. Маргааш бямба гаригт жин тан болчихсон байх ёстой. Мистер Блэйкийн хэлсэнчлэн Бэттереж гуай дахиж эр эсэргүүцсэнгүй, харин тувт туйлын эелдэг бөгөөд хэлгүй мэт дуугаа хураан явлаа.

Миний анагаах ухааны ажлыг (Бэттереж гуайн нэрлэснээр) даваа гариг хүртэл зайлшгүй хойшлуулах болов. Маргааш үдэш ажилчдыг орой болтол явуулахгүй гэнэ. Дараа өдөр нь буюу ням гаригт тус чөлөөт орны нэг байгууллагын тогтоосон цагийн хатуу харгис хуваарь ёсоор Лондонгоос галт тэрэг ирэх боломжгүй байдаг. Ингэхлээр мистер Блэйкийг дав гариг хүртэл сайтар арчлан ажиглаж, болбол өнөөдрийнх шиг хэвээр байлгахыг хичээхээс өөр аргагүйд хүрэв.

Мөн үүни йхамт браффыг гэр чоблж өгөөч хэмээн гуйсан захидал бичихийг мистер Блэйкт байдгаараа ятгасаар байлаа. Тэр хуульч бидний эсрэг хатуу зогсож байгаа учраас түүнийг ирүүлэхийг би зориуд шамдсан юм. Түүнд л итгүүлж дөнгөвөл бид ямар ч маргаангүй дийлэх болно.

Мистер Блэйк, түрүүч Каффт захидал бичиж, би ч бас мисс Вериндерт зурвас илгээв. Энэ хоёр хүн, бас тус гэр бүлд үнэхээр чухал хүн болсон Бэттереж өвгөнийг гэрч болгоход бидний зорьсон ажилд чамлалтгүй бөгөөд Мерридю хатагтай олны хэл аманд өртөж, нэрээ бузарлана гээд байгаа бол түүнгүйгээр хэрэг бүтнэ.

Зургадугаар сарын 23. – Хар тамхи хэрэглэсний гол урьд шөнө дахин гарав. Одоо ямар ч атугай дава гариг өнгөртөл тэсэх л хэрэгтэй болжээ.

Мистер Блэйкийн бие өнөөдөр бас л тааруухан байна. Өнөө өглөөний хоёр цагт янжууртай шургуулгаа онгойлгоод тун их хүчээр биеэ барьж, буцааж түгжсэн гэнэ. Тэгээд бухимдсандаа түлхүүрээ цонхоор шидчихжээ. Тэр нь хоосон төмөр торхны ёроолд байхыг манаач олоод өглөө оруулж өгчээ. Тавилан ийм байдаг аж! Би түлхүүрийг нь мягмар хүртэл хадгалахаар авав.

Зургадугаар сарын 24. – Мистэр Блэйк бид хоёр задгай тэргэнд сууж гадуур баахан зугаалав. Зуны өдрийн сайханд хоёул сэтгэл тэнийн явлаа. Дараа нь зочид буудалд хамт хооллов. Өнөө гөлөө уулзахад би нь суларч, сэтгэл нь үймэрсэн байсан хүн маань хоолны дараа хоёр цагийн турш буйдан дээр бөх гэгч унтсанд нь миний дотор ихэд уужрав. Одоо бас нэг шөнө тарчилдаг байлаа ч гэсэн уршгаас нь айлтгүй боллоо.

Зургадугаар сан 25. Даваа гариг- Туршлагын өдөр! Оройн таван цаг. Бид дөнгөж хүрч ирээд байна.

Эн тэргүүний гол чухал асуудал бол мистер Блэйкийн эрүүл мэндийн асуудал байлаа.

Миний ажигласнаар бол, өнөө орой хар тамхи өгөхөд түүний биеийн байдал ноднингийнхтой яг л адилхан болох юм шиг байна. Үдээс хойш уур унтуутай, бухимдуу байна. Царай нь амархан хувьсч, гар нь салгалах маягтай. Гэнэтийн дуу чимээнээр буюу хүн, юм нүдэнд нь гэнэт өртөхөд давхийн цочих ажээ.

Энэ бол нойр алдсаны уршиг мө бөгөөд тийнхүү нойр алдсан нь олон жилийн турш хэтэрхий татаж дасчихаад байсан тамхиа гэнэт хаяснаас шалтгаалж буй хэрэг юм. Ноднин нөлөөлсөн

шалтгаанууд хэвээр үзэгдэж байна, уршиг нь ч өөрцгүй адилхан илрэх бололтой. Туршлага дуустал энэ янзаараа байх болов уу? энэ шөнө л мэдэгдэнэ.

Намайг энэ хэдэн мөрийг бичиж суухад мистер Блэйк ноднин зургадугаар сард эднийд айлчилж байса үеийнх шигээ доод танхимд бильярдын янз бүрээр цохих дасгал хийн биеэ зугаацуулж байна. Миний бие тэмдэглэлийн дэвтрээ авч ирсэний учир бол нэг талаас, өглөө болтол дэмий хоосон цаг нөгцөөхөд хүрнэ гэж бодсоных, нөгө өталаас зайлшгүй тэмдэглэж авууштай хэрэг гарч магадгүй гэж горьдсоных билээ.

Юм орхиогүй байгаа? Өчигдрийн тэмдэглэлээ гүйлгэн харвал би өглөөний шуудан ирснийг бичихээ мартжээ. Дэвтрээ хааж, Блэйк ноён дээр очихоосоо өмнө үүнийг нөхөж бичье.

Өчигдөр би мисс Вериндерээс товчхон зурвас авсан юм. Миний зөвлөснөөр үдийн галт тэргэр гарахаар завдаж буй гэнэ. Мерридюю хатагтай заавал хамт явах гэж зүтгэсэн гээд энэ хичээж хатагтай уг нь сайхан зантай хүн боловч базаахгүй аашилж байгаа нь харамсалтай, гэвч нас сүүдэр, сурсан занг нь харгалзан уучилбал зүйтэй гэсэн сааа цухалзуулжээ. Би Мерридюю хатагтайтай Бэттереж гуай надтай харьцдаг шиг л харьцъя гэж шийдлээ. Бэттереж гуай өнөөдөр цайныхаа хар костюмыг өмсөж, цардсан цагаан зангиа зүүгээд биднийг баяр ёслолын байдалтай угтан авав. Намайг харах бүрдээ “Робизон Крузог” багадаа л нэг уншсанаас хойш ер уншаагүйг минь санаж, хүндэтгэн өрөвдөх бөлгөө.

Түүнчлэн мистер Блэйк өчигдөр мистер Браффаас хариу авсан билээ. Бидний урилгыг хүлээж авсан боловч тайлбар тавьжээ. Үүнд, түүний хэлснээр одоо тавих гэж буй жүжигт Вериндер авхайг оролцуулахаар завдаж байгаа бол дэргэд нь нэлээд саруул ухаантай эрхмийг байлгах хэрэгтэй гээд тийм хүн олдохгүй бол би хажууд нь байлцъя гэжээ. Тэгэхээр хөөрхий мисс Вериндер хоёр "х"руултай" "олох нь ээ. үүни улмаас улс амьтны санаа бодол хангалуун болно гэж бодохоос баярламаар байна!

Түрүүч Каффаас сураггүй л байлаа. Ирландад байгаа нь эргэлзээгүй. Өнөө орой ирэх болов уу гэж горьдолтгүй ажээ.

Мистер Блэйк намайг дуудуулсныг хэлэхээр Бэттереж гуай сая орж ирсэн тул би үзгээ түр тавих хэрэгтэй боллоо.

Долоон цаг. – Бид, хуучин янзаар нь зассан өрөө тасалгаа, шатыг дахин нэг эргэж үзлээ. Өнгөрсөн жил мистер Блэйкийн явах дуртай байсан бтат зөргөөр бид сайхан зугаалав. Би ийм аргаар мистер Блэйкийн санаанд урьдын байсан газар, нөхцөлийнх нь тухай аль болох тод сэтгэгдэл төрүүлнэ гэж найдсан юм.

Ноднин төрсөн өдрийн баярын зоог барьсан яг тэр цагт бид одоо оройн хоол идэх гэж байна. энэ тухяд миний зорилго бол гагцхүү анагаах ухаантай холбоотой билээ. Хар тамхины хандыг ноднингийнх шиг адил нөхцөлд хэрэглэх ёстой юм.

Оройн хоолноос хойш хэсэг азнаж байгаад би өнөөх алмазын тухай, түүнийг энэтхэгчүүд хулгайлах гэсэн тухай сэдвийг санаандгүй мэтээр сөхөн ярилцана. Тийнхүү хамаг бодлыг нь эл сэдвээ дүүргэчихсэв хар тамхи өгөхөөс өмнө өөрийн зүгээс чадах бүхнийг хийж амжуулах минь тэр.

XX XX XX

Наймаг цаг хагас. Миний бие хамгаас чухал нэг үүргээ буюу энэ айлын эмийн сангаас ноднин мистер Кандийн хэрэглэсэн хар тамхины хандыг олох ажлаа биелүүлэх боломж дөнгөж сая л гарав.

Арваад минутын өмнө, Бэттереж гуайг завтай байхад нь юу хийх санаатай буйгаа хэлсэнд хар, цагаан үггүй дэвтрээ тэмдэглэнэ ч гэсэнгүй эмийн сан хадгалдаг зоорь руу намайг дагуулан (алхам бүрдээ надад найр тавин) оров. Шилэн бөглөөгөөр нямбайлан таглаад дээрээс нь бас сарьсны өөдсөөр баглан боосон шилэн сав харагдана. Миний тааварлаж байсанчлан хар тамхины ердийн ханд дүүрэн байлаа. Аргагүйдвэл өөрийнхөө ууж байсан хоёр бэлдмэлийн нэгийг хэрэглэе гэж бодож байснаа уг шилтэй ханд дүүрэн буйг үзээд түүнийг хэрэглэхээр шийдлээ.

Чухам хэдэн дусал хэрэглэхийг шийдэхэд бэрхшээлтэй байв. Би эргэцүүлэн үзсэний эцэст тунгий нь нэмүүхэн өгье гэж бодлоо.

Тэмдэглэлээ үзэхэд Канди гуай хорин тавхан дуслыг өгчээ. Энэ бол мистер Блэйк мэтийн эмзэг мэдрэмхий хүнд өгөхөд ч тэгтэл нөлөөлөхөөргүй дэндүү бага хэмжээний тун байлаа. Мистер Канди сайн болох дуртай хүн бөгөөд тэр орой цайллагын дараа эмээ хэмсэн болохоор өгөхөөр завдаж байснаасаа хэтрүүлчихсэн байж тун магадгүй юм гэж би бодож байна. Ямар ч атугай би тунг дөчин дусал болгон нэмж өгөөд азаа үздэг хэрэг. Ингэхэд, мистер блэйк хар тамхины ханд уухаа одоо нэгэнт мэдэж байгаа хойно өөрийн эрхгүй түүний нөлөөг эсэргүүцэн давах гэж оролдох юм. Миний энэ бодол зөв бол энэ удаад ихээхэн тун өгөх нь ноднин бага тун хэрэглэсний дараа гарсан үр дүнг давтан харуулахад зайлшгүй шаардлагатай болж байгаа юм.

Арван цаг. – Гэрчийн этгээдүүд буюу зочид маань (алинаар нь хэлбэл оновчтой юм бэ дээ?) энд ирээд цаг болж байна.

Есөн цагаас өмнөхөн би мистер Блэйкийг өрөөндөө надтай хамт ороод засаж янзлахдаа мартсан юм байгаа эсэхийг нэг үзээдэхээч гэж ятгалаа. Блэйк ноёны өрөөний хажууд мистер Браффт унтах өрөө гаргаж тэр хуульчийг хүрч ирснийг надад үүд тогшиж мэдэгдэх талаар Бэттереж гуайтай тохиролцов. Их танхимын цаг есөн цагийн дохио цохисноос таван минутын дараа үүд тогших чимээ сонсогдмогц би тэр даруй гарвал мистер Брафф гудамд уулзлаа.

Миний гадаад төрх нөгөө л байдгаараа олиггүй харагджээ. Брафф гуайн харцанд надад үл итгэсэн байдал илт тодорлоо. Анх уулзаж буй танихгүй хүмүүст эвгүй үзэгддэгээ нэгэнт мэддэг учраас би, түүнийг Блэйк ноёны өрөөнд орохоос өмнө хэлэх гэснээ хоромхон төдий ч тээнэгэлзэлгүй хэлэв.

- Та Мерридю хатагтай, мисс Веридер хоёртой цуг ирсэн биз дээ? Гэхэд мистер Брафф
- Тэгсэн хэмээн тун ч тоомжиргүй хариулав.
- Туршлага дуусахаас наана энд мисс Вериндерийг (Мерридю хатагтайг ч өөрцгүй) ирээд байгааг мистер Блэйкт мэдэгдэхгүй байя гэснийг минь мисс Вериндер танд хэлсэн биз?

Мистер Брафф тогтож ядан

- Эрхэм минь, би амаа татаж байх ёстойгоо мэднэ! Ер нь хүний тэнэг балай явдлын талаар дуугүй байж сурчихсан хүн болохоо би эл тохиолдолд амаа олигтойхон татахад бүр ч бэлэн байна. Одоо таны сэтгэл амрав уу? гэв.
- Би мэхэхийн ёслоод, өрөөнд нь оруулах үүргийг Бэттереж гуайд даатган орхисонд Бэттереж гуай миний өөдөөс хяламхийн харах нь “мистер Женнингс минь, та Брафф гэдэг хэцүүхэн амьтантайгаа учирч дээ” гэж өгүүлэх мэт.
- Дараа нь хоёр хатагтайтай уулзах хэрэгтэй байв. Мисс Вериндерийн өрөөг зориг шатаар бууж явахдаа сэтгэл минь (нуух юу байх вэ) бага зэрэг догдолж байв.

Цэвэрлэгчийн эхнэр (энэ авгай тэр хоёр хатагтайг тав тухай байлгах үүрэг хүлээсэн юм) надтай доод давхры гудамд тааралдав. Энэ сайхан сэтгэлт авгай үнхэлцгээ хагартал айсан учраас надад хэтэрхий их хүндэтгэл үзүүлж буй бололтой. Намайг үг хэлэх бүр бүлтэлзэн чичирч, өвдөг нь нугаран навтасхийнэ. Мисс Вериндер хаана байгааг асуусанд дахиад л нүд нь бүлтэлзэн, бие нь чичрээд өвдөг нь сулран сөхөрдгийн даваан дээр Вериндер өрөөнийхөө үүдийг гэнэт онгойлгон гарч ирснээ уг ёслол хүндэтгэлийг доор нь таслав.

- Та мистер Женнингс үү? Гэж асуугаад намайг хариу дуугарч амжаагүй байтал надтай ярилцах гэж гудамд яаран гарч ирлээ. Бид хоёр туурганы дэнлүүний гэрэлд уулзав. Вериндер авхай намайг хармагцаа зогтусан тээнэгэлзсэнээ төдхөн сэхээ авч, царай нь ялимгүй улайснаа сэтгэл татам шулуун зангаар гараа сунгаж,
- Би таныг танихгүй хүн мэтээр үзэж чадахгүй, мистер Женнингс. Таны захидлыг аваад би хэчнээн их баярласныг та яаж мэдэх вэ дээ! Гээд миний үрчгэр муухай царайг биширч талархсан байдалтай ширтэхэд нь найз нөхөд маань ерөөс ингэж байсан удаагүй учир и ямар хариу өчихөө мэдэхгүй балмагдлаа. Түүний тийм сайхан зан, гоо үзэсгэлэнтэй гэнэт тулгарсан болохоор барьц алдлаа л даа. Олон жил зовж шаналсан ч, тэнгэрийн өршөөлөөр, зүрх минь чулуу шиг болоогүй юм байж. Энэ бүсгүйн өмнө би арван хэдтэй хөвгүүн шиг л зүрх алдан хулчийж орхив.

Мисс Вериндер, гагцхүү мистер Блэйкийг л их сонирхож буйгаа нуусан ч үгүй.

- Одоо хаана байга авэ? Юу хийж байгаа бол? Намайг ярьж байна уу? Санаа сэтгэлээр д давгүй юу? Ноднингоос хойш энэ байшинд гарсан өөрчлөлтийг үзээд ямаршуу янзтай байна вэ? Та хар тамхины хандыг хэдийд уулгах гэж байна? Дусааж байхыг чинь харж болох уу? Их сонин санагдах юм. Миний сэтгэл дэндүү их хөдөлчихөөд, танд хэлмээр юм өчнөөн төчнөөн байлаа ч гэсэн чухам юунаас эхлэхээ мэдэхгүй байна шүү. Ингэж их сонирхоод байгааг та гайхаж байна уу?
- Үгүй, Би бүгдийг ойлгож байх шиг байна.

Мисс Вериндер огт ичиж зовсон шинжгүй, яг л төрсөн ахтайгаа буюу эцэгтэйгээ ярьж байгаа юм шиг байлаа.

- Та намайг өгүүлшгүй айхтар зовлонгоос ангижрууллаа. Та наад шинэ амьдрал хүртээлээ. Танаас би юугаа ч нуухгүй, Фрэнклинд би хайртай юм гэж энгүүн өгүүлээд, - Эхнээсээ аваад эцсээ хүртэл шүү. Түүнийг буруутган бодох байхдаа ч, хамгийн муу муухай үгээр зэмлэж байхдаа ч хайртай л байсан юм. Энэ маань уучлал болж чадах болов уу? Үүнээс өөр уучлал болмоор юм даанч алга. Маргааш наммайг энд байгааг мэдээд ячих бол, та юу гэж бодож байна...гэснээ дуугүй болж өөдөөс сүрхий шаардангуй храв.
- Маргааш та сая надад хэлснээ л түүнд хэлэх болно доо.
- Мисс Вериндерийн нар нь гарах шиг болон над руу нэг алхам дөхөөд миний бие цэцрлэгээс түүж товчны нүхэнд тогтоосон цэцгийн дэлбээг оролдоход гар нь үл ялиг салгалах бөлгөө.
- Та сүүлийн үед түүнтэй байнга уулзаж байсан. Та үнэхээр ингэж бодож байна уу?

- Үнэхээр бодож байна. Маргааш юу болохыг лавтай мэдэж байна. Харин өнөө шөнийн болох гэж байгаад ийм итгэлтэй байх юмсан.

Бид хоёрыг ийн ярилцаж байтал Бэттереж тосгууртай цай барьсаар ирсэн тул яриа тасалдлаа. Бэттереж гуай зочны өрөө рүү орох үедээ бас нэг учиртйхан харах нь “Хүүе хө! Ямааны мах халуун дээрээ гэдэг юм. Хэцүүхэн амьтан чинь энэ дээр байна мистер Женнингс минь, хэцүүхэн амьтан чинь энэ дээр байна!” гэх шиг.

Бид хойноос нь дагаж орлоо. Тун сйхан хувцасласан жижигхэн биетэй хижээл хатагтай нэг буланд чамин гоё хатгамал хийж хамаг анхаарлаа төвлөрүүлэн сууж байснаа миний цыган царай, алаг үсийг хармагц гар дахь юмаа унагаад тэрүүхэндээ дуу алдав.

- Мерридю хатагтай, энэ бол мистер Женнингс гэж мисс Вериндер хэлэхэд настай авгай мистер Вериндер руу харж, надад зориулан,

- Мистер Женнингс уучлаарай. Галт тэргээр явахад би заавал ядарч, сэтгэл тавгүй болдог юм. Тэгээд сэтгэлээ тайвшруулах санаатай аар саар юм оролддог л доо. Ийм чухал явдал болж байхад хатгамал хийгээд суудаг маань зохимжгүй ч юм уу. Ингэдэг маань мистер Женнингсийн анагаах ухаанд саадтай бол би дуртайяа хойш тавих байна гэлээ.

Би, нөгөө чихмэл, Сахиус өрөөсөн жигүүртэй байхад дажгүй гэсэн шигээ, хатгамал хийх нь ямар ч гэмгүй гэж шалавхан хэллээ. Мерридю хатагтай миний царай руу харах гэж гайгүй сайн оролдов. Гэвч чадсангүй. Мисс Вериндер рүү дахин эргэн харж,

- мистер Женнингс соёрхвол би нэг юм гуймаар байна. Өнөө шөнө та шинжлэх ухааны туршлага хийхээр завдаж байна. Би сургуульд сурдаг жаахан охин байхдаа шинжлэх ухааны туршлагуудыг үздэг байв. Тийм туршлага заавал дэлбэрэлтээр төгсгдөгсөн. Энэ удаа дэлбэрэлт чухам хэдийд болохыг надад мэдэгдвэл би Женнингс гуайд их баярлах байна. Намайг өрондоо орж, унтахаас өмнө болбол бүр сайнсан гэв.

Энэ удаа бид төлөвлөгөөндөө дэлбэрэлт гаргах зүйл оруулаагүй гэж би Мерридю хатагтайд үнэмшүүлэх санаатай оролдов.

- Мистер Женнингс, миний тусын тулд л намайг хуурч байгаад нь би их талархаж байна, гэхдээ би илэн далангүй яриаг эрхэмлэдэг хүн. Дэлбэрэлт болно гэдгийг би нэгэнт сайн ухаарсан, гэхдээ намайг орондоо орж унтахаас өмнө л болоосой гэж хүсэж байна.

Тэгтэл хаалга нээгдсэнд Мерридю хатагтай дахин тэргүүхэндээ дуу алдав. Дэлбэрэлт эхэлсэ хэрэг үү? Үгүй ээ, Бэттереж гуай л орж ирэв. Бэттереж гуай туйлын нууцлан итгэмжилсэн маягаар,

- Уучлаарай, мистер Женнингс, мистер Фрэнклин таныг сураглаж байна. Залуу авхайн энд ирснийг мэдэгдэхүйн тулд түүнийг хуурч бай гэсэн таны тушаалыг дагаж, би хаана байгааг тань мэдэхгүй гэсэн шүү. Ингэж худал хэлснийг минь болгоож анхаарна буйзаа. Хөгшин ямааны насгүй болсон надад, эрхэм минь аль болох цөөн худал хэлэх боломж олговол тандтөдийчинээн их талархан, үхэхийн цагт сэтгэлийн хар нүгэлгүй байхсан гэж бодох юм гэлээ.

Нэн даруй өрөөнд нь бчихгүй бол мистер Блэйк намайг эрж сурагласаар ороод ирж магадгүй учраас Бэттереж гуайн сэтгэлийн хар нүглийн талаар эргэцүүлэн бодох гэж хормын төдий ч хугацаа алдаж болохгүй байв. Мисс Вериндер миний хойноос гудамд гарч ирээд,

- Цаадуул чинь таныг зовооё гэж сэм хуйвалдсан юм уу даа. Эн эер юу гэсэн үг вэ? гэв.

- Мисс Вериндер минь, аливаа шинэ юмыг эсэргүүцдэг нийгмийн нэг гэм байдаг, тийм л нэг шалихгүй явдал юм даа.

- Мерридю хатагтайг яах вэ?

- Дэлбэрэлт өглөөний есөн цагт болно гэж хэлээрэй.

- Тэгэд хэвтүүлчих юм уу?

- Тийм тийм, тэгж хэлээд л хэвтүүлчих.

Мисс Вериндер зочны өрөө рүү буцаж, би ч мистер Блэйк дээр очихоор өгслөө. Түүнийг ганцаархнаа байхыг хараад гайхлаа. Ганцаар үлдсэндээ бухимдан өрөөн дотуураа холхиж байгаа бололтой.

- Мистер Брафф хаачсан бэ? гэж намайг асуухад дамждаг өрөөни йхаалга руу заалаа. Түр орж ирээд гарсан юм байж. Бидгний төлөвлөсөн туршлагыг дахин эсэргүүцсэн боловч бас л талаар өнгөрч мистер Блэйк огт тоомсорлосонгүй учир албаны бичиг цаас пэндийтэл чихсэн хар ширэн цүнхээ уудалж суугаа юм байж, “Амьдралын ноцтой асуудал тухайн тохиолдолд огт хүртээлгүй байгаа нь харамсалтай, гэсэн ч амьдралын ноцтой асуудал байдаг хэвээрээ л байна шүү дээ. Блэйк та, ажил хэрэгч хүний хэвшсэн хуучин заншлыг уучлан соёрхох юм байгаа биз. Цаг бол алт, тэгэхээр Брафф яг хэрэгтэй цагт орж ирнэ байх гэж мистер Женнингс бодож буй бололтой” хэмээн хуульч уучлал эрэн хэлээд өрөөндөө орж, хар цүнхээ бүр ч их шамдан уудалжээ.

Би Мерридю хатагтай болон хатгамлыг нь Бэттереж гуай болон түүний сэтгэлийн нүгэл гээд байсныг санав. Англи хүний зүс царайнд илэрч байдаг шигээ яг адилаар англичуудын зан чанарын угт ч гайхмаар төсөөтэй зүйлс байх ажээ.

- Та надад хэзээ хар тамхи өгөх гэж байна даа? Хэмээн мистер Блэйк нэлээд адгуу асуухад нь би,
- Жаахан хүлээх хэрэгтэй байна, тэр хүртэл би тантай цуг байя гэв.

Тэгэхэд арван цаг арай болоогүй байсан юм. Бэттереж гуай, мистер Блэйк хоёроос олон удаа асууж лавлахад мистер Кандийн өгсөн хар тамхийг арван нэгэн цагаас өмнө уугаагүй бололтой байсан тул би одоо мөн л тэр цагт нь өгье гэж шийдэв.

Бид хоёр жаахан ярилцсан боловч хоёулаа л одоо хийх гэж буй туршлгын тухай бодолд автчихад байлаа. Тэгээд ч яриа маань төдхөн авцалдахаа больж, сүүлдээ бүр дуугарахаа болив. Мистер Блэйк орны өмнөх ширээн дээр байсан хэдэн номын хуудсыг дэмий л эргүүлнэ. Би анх өрөөнд орохдоо ямар ямар ном байгааг нь зориуд харсан юм: “Манна”, “Ховч” Ричардсоны Памела”, Мэкензийн “Өөнтөгч хүн” Роскогийн “Лоренцо Медичи”, Робертсоны “Тавдугаар Карл” гэсэн сонгодог зохиол байв. Цөм сүүлийн үед бичигдсэн зохиолуудаас хмаагүй дээр л дээ. Бүгд миний бодоход, нэг лут сайн чанартай нь юугэвэл, хэний ч анхаарлыг тэгтэл их татахгүй, хэний ч ухаан бодлыг үймүүлэхгүй.

Би мистер Блэйкийг сонгодог уран зохиолын ээлтэй нөлөөнд орхиод өдрийнхөө тэмдэглэлд энэ зүйлсийг бичив. Цагаа харвал арван нэг дөхсөн байна. Одоо дэвтрээ бас хаах хэрэгтэй боллоо.

Шөнийн хоёр цаг. – Туршлага хийчихлээ. Хэрхэн шувтарсныг одоо тодорхой бичье.

Арван нэгэн цгт би хонх дарж Бэттережийг дуудчихаад Блэйк ноёныг одоо хэвтэж болно гэв. Би цонхоор харла. Салхигүй, зөөлөн бороо шиврэн буй нь ноднингийн зургадугаар сарын хорин нэгний шөнөтэй тун төсөөтэй ажээ. Би тэнгэрийн байдлыг ажиглан хэрхэхийг тааварлаж мэдэхгүй хэдий боловч цахилгаан цахиж, салхи шуурга дэгдэн хүний сэтгэл мэдрэлд шууд нөлөөлөх юм үгүйд баярлаж, урамшлаа. Бэттереж гуай цонхны дэргэд хүрч ирээд жижигхэн цаас атгуулав. Зурвасыг уншвал: “ Мерридю хатагтй, өглөөний ?есөн цагт дэлбэрэлт болно гэдэгт итгээд, одоо явж болно гэж өөрийн биеэр ирж хэлэхээс нь нааш би байшингийн энэ хэсэгт байна гэдэг ам өгсний дараа унтахаар хэвтэв. Туршлагын гол ажил миний өрөөнд болно гэдгийг огт мэдээгүй, мэдсэн бол ч шөнөжин эндээс гарахгүй л дээ! Би одоо, сэтгэл ихэд түгшин ганцаар байна. Хар тамхины ханд хэмжихийг тань үзэх юмсан. Зүгээр хажууд чинь хараад ч гэсэн тэр ажилд оролцох юмсан, та надад соёрхон зөвшөөрөвч Р.В” гэжээ.

Би, Бэттереж гуайн хойноос дагаж гарад эмийн санг мисс Вериндерийн өрөөнд оруулчих гэлээ. Үүнийг сонсоод Бэттереж гуай учиргүй гайхаж, мисс Вериндерт анагаах ухааны аргаар ямар нэг зүйл хийх нь гэж сэжиглэсэн янзтай харан: “Уучлаарай, залуу авхай, манхаг хоёры хооронд холбогдох юу байдаг билээ?” гэв.

- Зочны өрөөнд байж байгаад хараарай л даа гэж би хариулав.

Манхгаас үүдэн ажил гараад ирмэгц Бэттереж гуай намайг бусдын тусламжгүйгээр амжилттай ажиглаж чадахаа болих нь гэж бодов бололтой.

- Энэ ажилд чинь мистер Браффыг оруулъя гэвэл, та татгалзахгүй биз, эрхэм ээ.

- Хаанаас даа! Харин би одоо мистер Браффыг дагуулаад ирэх гэж банья.

Бэттереж гуай олон таван үг дэлгэлгүй, манхаг авчрахаар гарав. Би, мистер Блэйкийн өрөөнд ороод дамждаг өрөөний үүдийг тогшонд Брафф үүдээ нээв. Анагаах ухаанд огт хүртээлгүй, хууль эрхийн асуудалд хамаг ухаанаа эзэмдүүлсэн Брафф баахан бичиг цаас барьжээ.

- Танд төвөг удсанд өршөөгөөрэй. Одоо би мистер Блэйкт уулгах хар тамхины хандыг бэлтгэх гэж байгаа тул та очиж, миний юу хийхийг ажиглана уу.

Мистер Брафф хамаг анхаарлынхаа аравны есийг гартаа барьсан бичиг цаасандаа хандуулан, надад зөвхөн аравны нэгийг нь дурамжхан зориулж,

- Аа тийм үү? Өөр юу байна? гэв.

- Та одоо надтай хамт яваад, тун хэмжихийг үзэх хэрэгтэй болоод байна.

- өөр юу байна?

- Бас нэг юм байгаа шүү. Та мистер Блэйкийн өрөөн үлдэж, юу болохы нь харах Хэрэгтэй байна.

- Өө бололгүй дээ! Миний өрөө мистер Блэйкийн өрөө, аль нь ч хамаатай юу. Хаана ч байсан энэ бичиг цаасаа уншиж болохоос хойш. Таны энэ зохиож байгаа юманд чинь эрүүл саруул ухааны өчүүхэн төдий юм оруулъя гэвэл мистер Женнингс та татгалзахгүй юм байгаа биз дээ?

Намайг хариу дуугарахаас өмнө мистер Блэйк орон дотроосоо,

- Бидний туршлагыг та огт сонирхохгүй байна гэдгээ үнэхээр хэлж байгаа хэрэг үү? Мистер Брафф та ч ёстой дээрээ шүдтэй үхэр юм даа! Гэж хуульчид хэлсэнд,

- Үхэр бол маш их ашигтай амьтан шүү, мистер Блэйк минь, хэмээн хуульч хариулаад нөгөө бичиг цаасаа барьсаар надтай цуг гарлаа.

Биднийг орж очиход мисс Вериндерийн сэтгэл нь ихэд догдолж царай нь цонхийн өрөөн дотуураа холхиж байлаа. Булангийн ширээний дэргэд Бэттереж манхагтай эмээ хараад зогсож байна. Мистер

Брафф ормогцоо тааралдсан нэг сандал дээр сууж (үхрээс ч илүү ашигтай хүн болохыг хичээн) өнөөх бичиг цаасаа шагайж эхэллээ.

Мисс Вериндер намайг зайдуухан аваачаад санаа бодлыг нь бүхэлд нь эзэмдсэн зүйл буюу мистер Блэйкийн тухай шууд шалгааж гарав.

- Одоо бие нь ямар байна? Сэтгэл нь тайван уу? Уцаарлах юм уу? Та энэ туршлагыг амжилттай болно гэж бодож байна уу? Ямар хор уршиг тарихгүй гэдэгт та бүрэн итгэж байна уу?

- Бүрэн итгэж байна. За, одоо ханд хэмжихийг хар л даа.

- Одоохон! Одоо арван нэг өнгөрч байна. Үр дүн нь хэр удаж мэдэгдэх вэ?

- Хэлэхэд амргүй, цаг орчим болно байх аа.

- Энэ өрөөг ноднингийнх шиг харанхуй байлгах уу?

- Тэгэлгүй яахав.

- Би түрүүчийнх шиг унтлагын өрөөндөө хүлээж, үүдээ ялимгүй онгорхой орхионо. Ноднин жаахан онгорхой байсан. Зочны өрөөний үүдийг ажиглаж байгаад онгойж эхлэмц нь гэрлээ унтраачихна. Миний төрсөн өдөр, ноднин яг ингэсэ юмдаг. Одоо бас л яг тийм болно байх аа, тийм үү?

- Мисс Вериндер, та биеэ барьж чадна биз?

- Түүний төлөө би яахаас ч буцахгүй! Хэмээн мисс Вериндер омог бардам хариулав.

Үнэхээр итгэж болохоор байв. Царайнаас нь андашгүй харагдана. Би мистер Браффт дахин хандаж,

- Та наад бичиг цаасаа түр хойш тавина уу гэсэнд,

- Өө, тэгье, тэгье! Хэмээн онцын сонирхолтой юм уншиж байхад нь үймүүлчихсэн мэт мэлрэн ширтсээр өндийж, намайг даган манхагийн дэргэд очлоо. Тэгээд мэргэжлийнхээ бичиг цаасанд хамаг ухаан санаагаа зарцуулах боломжгүй болсон тул Бэттережийн зүг нэг харснаа ядарсан шинжтэй эвшээв.

Мисс Вериндер хажуугийн ширээн дээрээс хүйтэн устай галуун хүзүүт авч, миний хажууд ирээд,

- би усы нь хийе, заавал гар хүрэх ёстой юм шүү! гэж шивэгнэв.

Би гожгор шилтэй ханднас дөчин дуслыг хэмжин авч, шилэн аяганд хийлээ. “Гуравны нэгий нь хүртэл дүүргээрэй!” гээд би аягатайгаа мисс Вериндерт өгөөд Бэттереж гуайг манхагаа цоожил, одоо дахиж хэрэггүй гэсэнд өвгөн зарцын царайд дотор нь жигтэйхэн уужирсэн байдал илрэв. Залуу авхайд анагаах ухааны туршлага хийх нь хэмээн намайг илэрхий сэрдэж байжээ!

Мисс Вериндер, миний хэлснээр шилэн аяганд ус хийгээд Бэттереж гуай манхаг цоожлох ажилтай, Брафф гуай нөгөө бичиг цаасаа бас л шагайж эхэлсэн зай завсрыг ашиглан шилэн аяганы ирмэгийг сэмхэн үнссэнээ, - Та энэ эмээ уулгахдаа энэ талаар нь өгөөрэй! Гэж надад хэлэв.

Би алмазыг төлүүлэх болор чулууг халааснаасаа гаргаж авхайд өгөөд,

- Та үүнд ч бас гар хүр. Наадхыгаа ноднин Сран чулуу тавьсан газар тавиарай гэлээ.

Вериндер энэтхэг шүүгээ рүүгээ очоод хуурамч алмазыг ноднин төрсөн өдрийнх нь шөнө жинэхнэ алмаз байсан шургуулганд хий. үүнийг мистер Брафф мөн л үл ойшоосон байртай харж байлаа. Харин туршлага хийхээр тийнхүү зэхэж эхлэхэд Бэттереж гуай бүр тэвчээр алдсан нь надад тун таатай санагдав. Лаа барьсан гар нь салганаж,

- Авхай та зөв шургуулганд хийсэн байгаа даа, андуураагүй биз? Хэмээн ихэд санаа зовсон янзтай шивнэн асуув.

Би хар тамхины хандтай ус барьсаар өрөөнөөс гарахдаа мисс вериндерт

- Гэрлээ түргэхэн унтраахаа мартав аа гэж сануулсанд,

- Дор нь унтраагаад унтлагын өрөөндөө ганц лаа асалттай хүлээнэ гэлээ.

Тэгээд биднийг гармагц үүдээ хаав. Би Брафф, Бэттереж хоёрыг дагуулсар мистер Блэйкийн өрөө рүү буцав. Биднийг ороход мистер Блэйк орондоо тавгүй эргэж хөрвөө хар тамхины ханд уулгах нь уу, үгүй юү хэмээн эгдүүцэ оёг муутай байлаа. Би, хоёр гэрчийн этгээдийн нүүрэн дээр нөгөө хар тамхины хандыг мистер Блэйкт уулгаад дэрий нь засаж, одоо тайван хэвтээд хүлээ гэж хэлэв.

Нимгэн даавуун хөшигтэй орны толгойг хананд тулгаж тавьсан болохоор хоёр талдаа их зайтай. Нэг талынх нь хөшгийг бүхэлд нь буулгаад цаана нь мистер Брафф Бэттереж гуай хоёрыг түүнд харагдуулалгүйгээр суулгалаа. Нөгөө талын хөшгийг нь дутуу буулгаж, сандлаа орн ыхөлд ялимгү йзайдуу тавив. Ингэснээрээ тухайн нөхцөлөөс шалтгаалан би харагдаж ч болох, нуугдаж ч болох түүнтэй ярьж ч болох, ярихгүй байж ч болох боломжтой болж авав. Гэрэлтэй унтдагий нь хэдийн мэдсэн тул асаасан хоёр лааныхаа нэгийг орны толгойн жижиг ширээн дээр тавьж, лааны гэрэл нүдэнд нь шууд тусахааргүй болгоод нөгөө лаагаа мистер Браффт өгөв. Буулгасан хөшигний цаанаас лааны гэрэл бүдгэрэн үзэгдэнэ. Өрөөнд нь салхи оруулах гэж цонхыг нь жаахан онгойлгосонб айв. Гадаа бороо зүсэрч, өрөөнд нам тайван байлаа. Бэлтгэл ажлаа дуусгаад цагаа харвал арван нэгээс хорин минут өнгөрч байв. Тэгээд би орны хөлд зайдуу тавьсан сандал дээрээ суулаа.

Мистер Брафф бичиг цаасаа улам ч их анхааран уншиж буй бололтой. Гэвч одоо сайтар ажиглавал хууль зүйн нөлөө нэлээд алдран эхэлж буй шинж тэмдэг илэрч байв. Одоо бидний байдал нэгэнт онцгой их сонирхолтой учраас түүний саруул ухаанд хүртэл зугуухан нөлөөлсөөр ажээ. Бэттереж гуайн тухайд гэвэл, өнөөх ёс горим, зарчмаа хатуу баримталдаг гэсэн дэмий хоосон үгнээс цаашгүй болжээ. Намайг мистер Блэйкт илбэ жилбэ туршиж байгааг мартжээ. Энэ айлыг эх толгойгүй бужигнуулсныг минь ч мартжээ. “Робзинзон Крузог” хүүхэд байхдаа л нэг уншсан гэдгийг минь ч мартжээ.

- Эрхэм ээ, бурхны арврал, энэ чинь хэдийд нөлөөлж эхлэх юм бэ? гэж надад шивэгнэхэд нь би,  
- Шөнө дундаас наашгүй, юм ярилгүй, тайван сууж бай гэж бас шивнэн хариулав.  
Беттереж гуай нэр төрөө хадгалах гэж хичээсэн ч үгүй, надтай бүр эрээ цээргүй болов. Миний өөдөөс нүд ирэмсэн гээч!

Мистер Блэйкийг харвал хар тамхи одоо хүртэл яагаад нөлөөлдөггүй юм хэмээн цухалдан гайхаж тун тавгүй хэвтэж байв. Энэ үед нь ингэж бухимдаж, гайхаад байх тусам улам л удааширна гэж учирлаад ч тус болохгүй байсан юм. Түүний толгойноос хар тамхины бодлыг эвтэйхэн сарниулахаас өөр мэргэн арга байсангүй.

Би ийм зорилгоор яриа өдөн, энэ үдэш бидний хэлэлцэж, байсан алмазын тухай ярианд оруулахыг бодлоо. Тэгээд тэр чулууг Лондонгоос Йоркшир руу авчирсан, мөн мистер Блэйк түүнийг фризинхоллын банкнаас авахдаа аз сорьсон түүнчлэн мисс Вериндерийн төрсөн өдрийн баярын орой хаанаас ч юм бүү мэд, энэтхэг хүмүүс ирсэн зэрэг Саран чулуутай холбогдох явдлуудыг сануулах гэж оролдов. Чингэхдээ хэдэн цагийн өмнө мистер Блэйкийн ярьснаас олон зүйл ойлгоогүй дүр зориуд үзүүлэв. Ийм аргаар миний бие түүний тархи толгойг эзэмдүүлэх ёстой байсан, чухамхүү тэр зүйлсийг яриулж дөнгөсөн бөгөөд зориуд ингэж буйгаа хар авахуулаагүй нь мэдээж билээ. Яваандаа миний эндүү ташаа ойлгосныг засах гэж шамдаж эхэлсэн болохоор ганц юм бодож цухалдан орондоо эргэж хөрвөөхөө болив. Тархинд нь хар тамхи нөлөөлж эхлэхийг харцнаас ньхарж болохоор чухал мөчид хар тамхины тухай бодлоос ангижирсэн байлаа. Би цагаа харлаа. Хар тамхи нөлөөлөн буй анхны шинж мэдэгдэж эхлэхэд арван хоёр цаг тавхан минут дутуу байв.

Энэ үед туршлагагүй хүн бол ямар нэг өөрчлөлт гарч буйг огт ажиглахгүй буйзаа. Гэвч хором өнгөрөх бүр хар тамхины нөлөө улам хурдан тодорч байлаа. Нүд нь гялалзан, нүүрэнд нь хөлс бурзайн чийхарч, тав зургаан минут өнгөрөхийн алдад яриа нь уялдаа холбоогүй болж ирлээ. Алмазын тухай л ярих атлаа, утга санаагаа гүйцэд гаргаж чадахгүй, өгүүлбэрээ дутуу хагас орхиод эхлэв. тэгсээр өгүүлбэрийнх нь үг цөөрсөөр ганц нэг үг болж хувирснаа дуугаа хураачихав. Тэгснээ өндийж суулаа. Дараа нь алмазын тухай бодсон хэвээрээ дахин ярьж эхлэв. Гэхдээ надтай биш, ганцаараа л үглэж гарав. Ийнхүү өөрчлөгдсөнийг нь хараад туршлагын маань анхны шат амжилттай болсныг ойлголоо. Хар тамхины идэвхжүүлэх нөлөө мистер Блэйкт үйлчилж эхэллээ. Одоо цаг арван хоёроос хори гурван минут өнгөрч байна. Дахиад хагас цаг өнгөрөөд орноосоо босож өрөөнөөс гарч явах эсэх нь мэдэгдэнэ.

Түүнийг амьсгаа даран сонирхон ажиглаж байтал туршлагын анхны үр дүн миний бодолтой тун ойролцоо болсон бөгөөд мөн миний багцаалсан хугацаанд эхэлсэнд учиргүй их баярлчихаад энэ шөнө нойроо хасан хань болж буй хоёр түншээ таг мартчихсан байснаа сая л нэ санаж, харвал мистер Браффын авч яваа бичиг цаасаар төлөөлөн байсан хууль эрх шалан дээр ундуй сундуй хэвтэж байна. Мистер Брафф өөрөө орны хөшигний завсраар ухаангүй сонирхон шагайж байхад Бэттереж гуай нийгмийн зэрэг дэвийн ялгааг умартаад мистер Браффын мөрөн дээгүүр өлийн харж байв.

Өөрсдийг нь харж буйг мэдмэгцээ, дүрсгүйтэж байгаад багшдаа баригдсан жаал шиг хамт тэр хоёрт гутлаа чимээгүй тайл гэсэн дохио өглөө. Хэрэв мистер Блэйкийн арас дагахад хүрвэл чимээ анир гаргахгүй байх нь нэн чухал билээ.

Хэдэн минут өнгөрлөө, юу ч болсонгүй. Тэгтэл мистер Блэйк хөнжил даавуугаа гэнэт хуу татан хаяж, нэг хөлөө орноосоо буулган азнаснаа,

- Банкнаас авдаггүй л байж, тэндээ байсан бол баттай шүү дээ эж ганцаараа үглэв.

Миний зүрх булгилж, чамархайн судас хүчтэй цохилон. Алмазыг хадгалж хамгаалах тухай бодол дахиад л ухаан бодлыг нь эзэмджээ! Энэ бол бидний туршлагын бүхий л амжилтын гол нуруу юм. Гэнэт ийм бүтэмжтэй болж эхэлсэнд тэртээ тэргүй дэндсэлсэн сэтгэл жигтэйхэн хөдөлж орхив. Тиймээс түр харц буруулахас өөр аргагүй болов. Эс тэгвэл би биеэ барьж чадахгүйд хүрэх байлаа. Дахин чив чимээгүй болж ирэв.

Одоо харж болно гэж бодоод харвал мистер Блэйк орноосоо босож хажууд нь зогссон байв. Хүүхэн хараа нь нарийсч, толгойгоо аяархан сэгсрэхэд нүд нь лааны гэрэлт гялалзана. Юм бодож, эргэлзэн тээнэглэжээ байснаа дахин ганцаараа ярьж эхлэв.

- Энэтхэгүүд байшинд ороод нуугдчихсан байхыг хэн мэдэх юм бэ гэснээ дуугүй болж, өрөөний нөгөө булан руу ажуухан алхав. Тэгснээ эргэж түлдгэлзэн байснаа орон дээрээ буцаж ирээд, -

Ядаж цоожгүй шүү. энэтхэг шүүгээнд хийсэн. Шүүгээний нь шургуулга ч цоожгүй шүү дээ гээд ороо сандайлаад- Авчихаж болно гэснээ сандран босож, - Энэтхэгүүд байшинд орж ирээд нуугдаж байхыг хэн мэдэх юм бэ? хэмээ дахин үглээд чимээгүй болов.

Би орных нь хөшигний араар орж, завсраар нь ажиглахад мистер Блэйк өрөөгөө гөлийсөн нүдээр хэсүүлэн харж байв. Амсгаа даран хүлээлээ. Дахиад л саатах шиг болсон нь хар тамхины нөлөө юү, эсвэл тархины ажиллагаа тасалдав уу, бүү мэд. Одоо энэ хүн юү хийхээс л хамаг юм шалтгаалах байв.

Буцаад хэвтчихлээ!

Аймшигтай эргэлзээ толгойд харван орж ирлээ. Хар тамхины мансууруулах нөлөө эхэлчихсэн гэж үү? Миний хурмитлуулсан туршлаганд ийм юм ер тохиолдоогүйсэн. Гэвч хар тамхины хувьд туршлага гэгч юү билээ? Хар тамхи яг адилхан байдлаар нөлөөлдөг хоёр хүн байхгүй буйзаа. Нөлөөг нь өөр маягаар тусган авах бие бялдрын онцлог түүнд байгаа юм биш байгаа? Бид амжилт олохын даваан дээр балрах юм гэж үү?

- Үгүй юм байна! Мистер Блэйк огло харайн босоод,

- Ийм юм толгойд эргэлдээд байхад ямар үлийгээ хийж унтах вэ? гэв.

Орны толгойн ширээн дээр буй гэрлийг ширтэв. Дараа нь нөгөө лаг ввлаа.

Би ч хөшигний ард асаалттай байсан лаг үлээж унтраагаад мистер Брафф Бэттереж гуай хоёрын дэргэд хүрч гурвуул орны тэртээх буланд очлоо. Би тэр хоёрын амь нас үүнээс л шалтгаална гэсэн мэтээр чимээгүй байгаарай гэж дохилоо.

Бид гурав хөшигний араар орж нуугдаад хүлээв. Юу ч харагдахгүй, юу ч сонсогдохгүй л байлаа.

Бидний нөгөө талд түүний барин зогсож байсан гэрэл нэнэт хөдлөв. Тэгтэл ч мистер Блэйк лагаа барьсаар бидний хажуугаар чимээгүй, хурдан явж өнгөрөөд унтлаганы өрөөний үүдийг нээж гарав.

Бид гурав араас нь гудмаар дагасаар шатаар бууж, хоёр дахь гудам хүрэхэд ер эргэж харалгүй шулуухан явсаар зочны өрөөний хлгыг нээж, онгорхой хэвээр нь орхиод орчихов.

Тэр хаалга (бусад хаалга нь ч өөрцгүй) хуучин маягий том нугастай юм. Хаалга, энэ хоёрын хооронд том завср гарчээ. Би тэр хоёрыг мистер Блэйкт харагдчихгүйн тулд энэ завсраар хар гэж дохиод өөрөө хажуу талд нь зогслоо. Миний зүүн гар талд хананы хөндий байсан бөгөөд хэрэв мистер Блэйк гудам руу шагайх юм бол би тийшээ ороод нуугдчих байлаа.

Мистер Блэйк лагаа барин явсаар өрөөний голд очоод тэр хавиа ажиглан харах боловч ер эргэж харсангүй.

Мисс Вериндерийн унтлагын өрөөний үүд хагас онгорхой харагдана. Гэрлээ унтраажээ. Биеэ сайтар барьж чадсан нь андашгүй. Зуны цав цагаан дашинз нь харанхуйд цайрахаас өөр юм үзэгдсэнгүй. Тэнд хүн байгааг урьд нь мэдээгүй бол тэнд амьд амьтан бий гэж хэн ч бодохооргүй ажээ. Залуу авхай тас харанхуйд ганц ч үг дуугаралгүйг өчүүхэн төдий ч хөдлөхгүй зогсоно.

Нэг цагаас арван минут өнгөрч байв. Шөнийн нам гүмд зөөлөн бороо шиврэх, модны навчис зөөлөн салхин ыаясаар сэргижнэх л сонсодно.

Мистер Блэйк ганц хоёр хормын төдий өрөөний голд тээнэлзсэн янзатай саатсанаа энэтхэг шүүгээ байгаа цонхны дэргэдэх булан руу зүглэв.

Лагаа шүүгээн дээр тавьж, шургуулгуудыг нь татаж үзсээр хуурамч алмаз байгаа шургуулгыг онгойлгон хэсэг харснаа алмазыг баруун гараара аваад нөгөө гараар шүүгээн дээрээс лагаа аваа.

Тийнхүү, ноднин төрсөн өдрийн баярын шөнө үйлдсэн зүйлээ яг давтав бололтой. Драа нь бас л ноднин үйлдсэн зүйлээ хийх болов уу? Өрөөнөөс гарч явах болов уу? Тэр үед буцаад явсан байх гэж минийтааварлаж байсанчлан одоо бас унтлагын өрөөрүүгээ буцаж орчихно уу? Өрөөндөө орсон хойно алмазыг хэрхсэнээ харуулах болов уу?

Хар тамхины нөлөөгөөр одоогийн хийсэн үйлдэл нь анхны удаа хар тамхины уршгаар хийсэн үйлдлээс зөрөх шиг болов. Лагаа ширээн дээр тавьчихаад өрөөний нөгөө буланг зүглэн хэд алхлав. Тэнд байгаа буйдангийн арыг зүүн гараараа түшин зогсож байснаа биеэ цэхлэн алхаж өрөөний голд буцаж очлоо. Нүдний нь цог түргэн буурч гөлийж байхыг би ажиглав.

Вериндерийн тэсвэр барагдан урагш алхсанаа гэдрэг ухрав. Брафф Бэттереж хоёр онгорхой хаалгаар над руу анх удаа харав. Итгэн хүлээж байсан зүйл маань бүтэх шинжгүй болох нь гэж тэр хоёр, миний нэгэн адил тааварласан бололтой.

Гэсэн ч мистер Блэйк нэгэнт тэндээ зогсож байгаа цагт горьдлого хараахан тасраагүй л байлаа. Бид олоо яадаг бол хэмээн тэсэн ядан хүлээж байтал асуудлыг нэг тийш болгосон явдал тохиолдов.

Блэйк барьж байсан хуурамч алмазаа хаалганы өмнө унагав. Бүгдийн нүдэнд өртөхөөр унасан боловч түүнийгээ газраас авахын оронд дэмий л ширтэн зогсох ба толгойгоо бүр унжуулав.

Тэгснээ гэнэт сэхээ авах шиг эргээд буйдан руу гуйвсар очиж суув. Босох гэж оролдоод чадалгүй лагхийн сууж, өөрийн эрхгүй жинтүү дэрлэв. Энэ үед нэгээс хорин минут өнгөрч байлаа. Би цагаа хараад халаасандаа буцааж хийх хооронд митсер Блэйк унтчихсан байв.

Ингээд бүгд гүйцэх нь энэ дээ. Хар тамхины унтуулах нөлөө түүнийг дийлж, туршлага маань ч дууслаа.

Би өрөө рүүгээ орж мистер Брафф, Бэттереж гуай хоёрыг намайг дагаад явж болно гэв. Одоо мистрер Блэйкийг цочоочих нь гэх зовлонгүй учраас бид чөлөөтэй явж, ярилцаж болох байв.

- Одоо энэ хүнийг яах вэ гэдгийг юуны өмнө шийдэх хэрэгтэй байна. Доор хаяад зургаа, долоон цаг сэрэлгүй унтах байх. Өрөөнд нь аваачна гэхэд бас зайтай юм даа. Арай залуу байсан бол ч ганцаараа аваачиж дөнгөх л юм. Гэтэл одоо эрүүл мэнд, тэнхээ тамир биш болж дээ тэгэхээр та хоёрыг л гуймаар байна санж гэж би хэллээ.

Тэр хоёрыг ам нээхээс өмнө мисс вериндер намайг аяархан дуудав. Толгойн хөнгөн алчуур, орны бүтээлэг хоёры бариад унтлагын өрөөнийхөө үүдэнд зогсож байлаа.

- Та түүнийг унтаж байх хооронд хажууд нь байх гэсэн юм уу?

- Тийм ээ. Хар тамхи ямраар нөлөөлөхийг би лавтай хэлж мэдэхгүй болохоор ганцааранг орхимооргүй байна.

Мисс Вериндер алчуур, орныхоо бүтээлэг хоёрыг надад бариулаад,

- хөөрхийг зовоогоод юу хийнэ? Буйдан дээр аятайхан хэвтүүлчих. Би үүдээ хаагаад өрөөндөө байх хэмээн шивнэв.

Энэ бол маргаангүй хамгийн хялбар, хамгийн зөв арга байв. Би энэ саналыг нь мистер Брафф Бэттереж гуай хоёрт хэлбэл хоёул тун зөв гэлцэв. Таван минутын дотор мистер Блэйкийг буйдан дээр эвтэйхэн хэвтүүлээд өнөөх алчуур, орны бүтээлэг хоёроор хучлаа. Вериндер авхай бидэнд тавтай нойрсохыг ерөөгөөд үүдээ хаав. Миний хүссэнээр бид гурвуул өрөөний голын ширээнд суулаа. Ширээн дээр асаалттай лаа, бичгийн хэрэгсэл ч байсан юм.

- Хэдүүл салахын өмнө энэ шөнө хийсэн туршлагынхаа талаар би ганц хоёр үг хэлмээр байна. Бидэнд хоёр гол зорилго байлаа. Нэг нь мистер Блэйк ноднин хар тамхинд мансуураад, өөрийн ухаангүй энэ өрөөнд орж ирээд тэр алмазыг авсан байсан гэдгийг нотлох гэсэн юм. Та хоёр сая болсон бүх явдлыг нүдээр үзлээ, одоо итгэж байгаа биз дээ? Гэж намайг асуухад тэр хоёр итгэлээ хэмээн агшин зуур ч эргэлзэлгүй хариулав.

\Би цааш үргэлжлүүлэн

- Хоёр дахь зорилго гэвэл, төрсөн өдрийн баярын шөнө мисс Вериндерийн дэргэдүүр алмазыг нь барьсаар гарсан хойноо, тэр алмазыг яасан бэ? гэдгийг мэдэх гэсэн юм. Ноднин үйлдсэн зүйлээ тэр чигээр нь үргэлжлүүлэн давтах эсэхээс туршлагын маань мжилт шалтгаалах байлаа. Гэтэл тэгж далтсангүй учраас туршлагын энэ зорилго бүтэлгүй боллоо. Ингэж төгссөнд би гонсойхгүй байна гэж хэлж чадахгүй, харин их гайхахгүй байна гэдгээ чин үнэнээсээ хэлж чадах байна. Би бүр анхнаасаа мистер Блэйкт бидний амжилт, ноднин жилийн тэр үеийн орчин тойрны болон сэтгэл санааны нөхцөл байдлыг яг хэвээр нь сэргээн бүрэлдүүлж чадах эсэхээс шалтгаална, энэ бол бараг л боломжгүй юм гэдгийг анхааруулсан. Бид тэр нөхцөл байдлыг хагас дутуу бүрэлдүүлсэн болохоор туршлага ч дулимхан амжилт оллоо шүү дээ. Бас би хар тамхины тунг арай ихдүүлсэн байж ч магадгүй. Гэвч би эхний шалтгааныг бидний бүтэл хазайж гонсойх, амжилт олж баярлахад хоёулангийн үндс болсон гэж үзэж байна гэв.

Тийн өгүүлээд би Браффийн өмнө бичгийн хэрэгсэл тавьж, хэрэв та татгалзахгүй бол энд юу үзэж харсан тухайгаа одоо бичээд гарынхаа үсгийг зурна уу гэсэнд хуульч даруй үзэг авч, зохих мэдэгдлийг энэ зэргийн юм бичиж сурсан хүний барилаар биччихээд гарынхаа үсгийг зурах зуур,

- Энэ маань орой та бид хоёрын хооронд гарсан явдлыг мартахад жаахан ч гэлээ нэмэр болохсон болов уу. Танд итгэхгүй байсныг минь уучилж үзээрэй, мистер Женнингс. Та Фрэнклин Блэйкт үнэлж баршгүй их ач хүргэлээ. Манай хуулийн үгээр хэлэхэд та зарга авлаа гэв.

Бэттереж гуай бас л уучлал гуйсан ба энэ нь түүний зан араншинг бүрэн тусгасан байв.

- Мистер Женнингс та “Робинзон Крузог” дахин уншихдаа (заавал уншаарай гэж би зөвлөх байна) Робинзон Крузо ямар нэг юмад буруутлаа гэхэд ерөөсөө мэтгэдэггүй байсныг та мэдэж авах болно. Тухайн тохиолдолд би Робинзон Крузо шиг байна гэж хэлээд гарынхаа үсгийг зурлаа.

Бид ширээний араас босоход мистер Брафф намайг зайдуухан аваачиж,

- Тэр алмазын талаар нэг үг хэлье. Таны онолоор бол Фрэнклин Блэйк Саран чулууг өрөөндөө нуусан, минийхээр бол тэр Саран чулуу Люкерийн Лондон дахь банканд байна. Та бид хоёр зөв, буруу гэж маргаад яах вэ. Харин хэнийх нь онол бодит хэрэг дээр эхэлж шалгагдах бол гэдгийг л асууя.

- Миний онолын шалгуурын тухайд гэвэл, энэ шөнө сориод бүтэлгүйтлээ шүү дээ.

- Минийх бол сорилын явцад л байна. Сүүлийн хоёр өдөр би Люкерийг сэм ажиглуулахар банкны орчимд мөрдөгч тавиад байгаа. Энэ сарыг дуустал тандана даа. Тэр алмазыг мистер Люкер банкнаас өөрийн биеэр авах нь гарцаагүй. Эрдэнийн чулууг барьцаанд өгсөн этгээд золиосоо төлж, Люкерийг шаардан авахуулна гэж би тааварлаж байгаа юм. Тэгвэл би тэр этгээийг илрүүлэх боломжтой болно. Энэ ажил бүтвэл ч бидний толгойг одоо эргүүлээд байгаа нууцыг яг л сөхнө дөө. Та юу гэж бодож байна?

Би ч тун зүйтэй гэв.

- би өглөөний галт тэргээр Лондон буцна. Очтол маш чухал зүйл мэдэцгээсэн байгаад Фрэнклин Блэйктэй нэн даруй уулзах хэрэг гарч болзошгүй юм. Сэрмэгц нь надтай цуг Лондон руу буцах хэрэгтэй гэж хэлэх гэсэн юм. Нэгэнт болж өнгөрсөн бүхий л явдлын дараа та надад өөрийн нөлөөгөөр дэмжлэг үзүүлнэ гэж найдаж болох уу?

- Бололгүй яхав!

Мистер Брафф гадтай гар бариад гарахад Бэттереж ч араас нь дагав.

Би, мистер Блэйкийг харахаар буцаж оров. Буйдан дээр дэвсгэр засан хэвтүүлснээс хойш огт хөдлөөгүй, бөх тайван нойрссоор байна.

Түүнийг харан зогсож байтал унтлагын өрөөний үүд аяархан нээгдэх чимээ сонсогдов. Мисс Вериндер зуныхаа хөөрхөн даашинзаа өмсчихөөд дахиад л босгон дээрээ гарч ирээд,

- Танаас сүүлчийн удаа ганц юм гуйя. Тантай хамт хажууд нь сууя, тэгэх үү хэмээн шивнэлээ.

Миний бие тээнэгэлзсэн нь ёс горимд таарах эсэхийг бодсон хэрэг биш, түүнийг харин нойроо авч амарвал дээр сэн гэж бодсоных юм. Тэгтэл хүрч ирээд гараас барьж,

- Нойр хулжчихлаа. Өрөөндөө тайван сууж ч чадашгүй нь. Женнингс гуай минь, хэрэв та миний оронд байгаа бол хажууд нь суугаад л хармаар санагдана шүү дээ. За, зөвшөөр л дөө! Хэмээн шалгаав.

Зөвшөөрөхөөс өөр замгүй болсныг хэлэх юун!

Мисс Вериндер сандал ойртуулж буйдангийн хөлд суугаад нар нь гарах шиг сэтгэл нь ихэд баясан мистер Блэйкийг чимээгүйхэн ширтэн байснаа нүдэнд нь нулимс дүүрэн мэлмэрч эхлэв. Нлуимсаа арчсанаа, нэхэж байсан юмаа аваад ирье хэмээв. Явж авчирсан боловч ганц ч гогцоо өлгөсөнгүй, өвөр дээрэ этавьчихаад мистер Блэйкээс нүд үл салган юм нэхэх сөхөөгүй сууна. Би залуу насаа өөрийн эрхгүй дурсав. Намайг урьд хайр шингэсэн урсгал зөөлөн нүд ширтэн байсан нь санаанд орлоо. Зүрх шимшрэн шаналахад, дотроо онгойлгох гэж тэмдэглэлийнхээ дэвтрийг шүүрэн авад энэ бүхнийг бичиж эхэллээ.

Ийнхүү бид хоёр дуу шуугүй суулаа. Нэг нь бичиж тэмдэглэх ажилдаа автан улайрч, нөгөө нь хайр сэтгэлдээ умбасан байлаа.

Блэйк хэдэн цагийн турш бөх гэгч унтсаар бөгөөд үүрийн гэгээ туяарч улам улам тодорсоор авч хөдлөх ч үгүй таг чиг бөлгөө.

Зургаан цагийн алдад миний ужиг өвчин хөдлөх шинж цухалзсанд би дээшээ гарч, өрөөнөөсөө бас нэг дэр авчирья гэсэн шалтаг заан авхайг ганцааранг орхин түр гараха хүрэв. Энэ үед өвчин маань нэг их удаан зовоосонгүй.

Намайг өрөөнд буцаж ороход мисс лериндер буйдангийн толгойд зогсоод унтсаар буй мистер Блэйкийн духанд хошуугаа хүргэж байв. Би чадах хэрээрээ хүйтэн царай гарган толгой сэгсрээд сандал руу нь заахад залуу авхай өөдөөс баясгалантайгаар инээмсэглэн царай нь гэрэлтэн гийв. Тэгснээ “миний оронд та байса бол бас л ингэнэ шүү дээ!” гэж шивнэлээ.

Яг найман цаг болж байна. Мистер Блэйк сая л нэг хөдөлж эхлэв. Мисс Вериндер буйдангийн хажууд өвдө сөхрөн цаадхыгаа нүдээ нээхэд нь шууд харагдахаар суужээ.

Энэ хоёрыг орхиод гардаг юм билээ?

Тэгьеэ!

Арван нэгэн цаг. Байшин дахиад л эзгүйрчээ. Тэд ярилцаж тохироод бүгдээрээ арван цагийн галт тэргээр Лондон руу явцгаав. Миний аз жаргал дүүрсэн богинохон зүүд дуусаж, ганцаардмал, гунигт амьдрал дахин залгав.

Надад хэлж байсан сэтгэл зүрхний сайхан үгсийг, ялангуяа мисс Вериндер, мистер Блэйк хоёрын амнаас гарсан үгсийг энд бичиж үл төвдөнө. Бичээд ч ямар хэрэг байх вэ! Харин ганцаардан гансрах үедээ, амьдралын эцсийн мөчийг давж туулахдаа эдгээр үгсийг санагалзан дурссан минь дээр буй заа. Мистер Блэйк Лондонд болсон явдлыг надад бичнэ гэсэн билээ. Мисс Вериндер энэ намар Иоркширт (эргэлзээгүй хуримаа хийх гэж) ирнэ. Би ч амралтаа аваад тэднийд айлчлах ёстой. Намайг талархал, аз жаргал дүүрэн харцаар ширтэн, миний гарыг халуун дотноор атгасан нь “Энэ бүхэн таны ач шүү дээ!” гэсэн үг байлаа.

Ай, үүнийг харахад юутай сайхан!

Хөөрхий өвчтөнүүд маань намайг хүлээж буй. Хэвшил болсон ажилдаа шалавхан оръё! Хар тамхи, өвчин хоёр ээлжлэн тамладаг аймшигт байдалд буцаж оръё!

Бурхан тэнгэрийн ивээлд сүслэн залбирнам! Би зурвасхан ч гэсэн нарны гэрэл үзлээ, би түр ч гэсэн аз жаргалтай мөчийг үзжээ

## ФРЭНКЛИН БЛЭЙКИЙН БИЧСЭН НЬ

Экра Женнингсийн өдрийн тэмдэглэл бичсэн эл хүүрнэлийг төгсгөхөд миний зүгээс цөөн хэдэн үг л хэрэгтэй юм.

Миний хувьд гэвэл, хорин зургааны өглөө сэрэхдээ, хар тамхи нөлөөлж эхэлснээс, Рэчелийн зочны өрөөнд нүдээ нээж сэрсэн хүртэлх хугацаанд би чухам юу ярьсан, хийснээ огт төсөөлөхгүй байлаа.

Сэрэд юу болсныг нэгд нэгэнгүй тоочин бичих шаардлагагүй биз ээ. Товчхон хэлэхд, Рэчел бид хоёр бие биеэ үг дуугүй бүрэн ойлгосон юм. Тийм амархан эвлэрснээ өгүүлэхээс би ч, Рэчел ч гэсэн татгалзаж байна. эрхэм минь, хатагтай минь, та нар хоёр биеэ мөрөөсөн санаж явсан залуу насаа эргэн дурсагтун. Тэгвэл женнингс гуай үүд хаагаад явахад бид хоёр хэрхэснийг ойлгоход ядах юмгшүй шүү дээ.

Харин Рэчел ухаан жолоо алдаагүй байсны ачаар бид хоёр Мерридю хатагтайд баригдалгүй аргацааж чадсан юм гэдгийг нэмж хэлэхээс дургүйцэхгүй. Хөгшин хатагтайн хувцасны сүржигнэх чимээ гудамд гармагц Рэчел өөдөөс нь угтаад гарсан юм. Мерридю хатагтай, “Юу болж байна?” гэж асуухад Рэчел, “Дэлбэрэлт болно!” гэх нь сонсдов. Мерридю хатагтай тийм үг сонсоод доргионд нь сүйд болох вий хэмээн холдох гэж гараасаа хөтлүүлэн цэцэрлэгт гарчээ. Буцаж ирэхдээ надтай үүдний өрөөнд тааралдаад шинжлэх ухаан ч намайг сургуульд сурч байсан үеийг бодвол мөн ч гайхмаар их дэвшсэн байна гэж яриу.

- Дэлбэрэлт тэр үеийнхтэй зүйрлэхийн аргагүй чимээ багатай болжээ. Мистер Женнингсийн дэлбэрэлт цэцэрлэгт дуулахтай үгүйтэй л байсан шүү! Байшинд орж ирэхэд үнэр танар ч гэх юм алга! Би анагаах ухааны мэргэжилтэй найзаас чинь уучлалт гуйх ёстой болж байна. Энэ ажлыг тун сайхан явууллаа гэдгийг түүнд хэлэх нь зүйтэй юм!

Ийнхүү Эзра Женнингс эхлээд мистер Брафф, Бэттереж гуай хоёрыг буулгаж аваад одоо Мерридю хатагтайг бас дийлэх нь энэ. Гэсэн ч хорвоод энэ зэргийн юмыг үл ойлгох явдал мундах биш дээ

Цай уух зуур мистер Брафф намайг өглөөний галт тэргээр Лондон руу заавал авч явах болсны шалтгааныг нуулгүй хэлэв. Банкинд тавьсан хяналт, түүни йүр дүнг Рэчел тэсгэлгүй их сонирхож байгаа учраас бидний ажиллагааны талаар доор доор нь сосож байхын тулд Мерридю хатагтай эс татгалзвал бидэнтэй хамт хот руу буцна хэмээн даруй шийдсэн юм.

Үнэхээр дэг журамтай туршсан дэлбэрэлтийн дараа Мерридю хатагтай үгнээс зөрөхгүй, наалинхай зантай болжээ. Бид дөрвүүл өглөөний галт тэргээр буцах болсноо Бэттереж гуайд мэгэгдлээ. Бэттереж гуай хамт явъя хэмээн шалгааж гарна даа гэж би бодож байтал Рэчел үнэнч өвгөн зарцдаа сонирхлы нь татсан ажил даалган үлдээх мэргэн арга сэджээ. Өрөө тасалгааг сэргээн янзлах ажлыг дуусгах даалгавар өгсөн агаад Бэттереж гуай тэрхүү үүрэгтээ даанч их анхаарсан байлаа. Өөр үед сэн бол түүнд “мөрдөх дон” нь сэргэх байсан буй заа.

Бид Лондон руу явахдаа Эзра Женнингсээс ийм хурдан салах болсондоо ихэд харамсаж билээ. Түүнийг хамт явъя гэж ятгах аргагүй байв. харин би захидал бичнэ гэж амлахад, Рэчел Иоркширт буцаж ирсний дараа заавал ирж уулзаарай гэж шалгаав. Хэдэн сарын дараа үнэхээр уулзах хувь бий хэмээн итгэвч галт тэрэг хөдлөхөд хосгүй сайн, дотно хайртай анд маань тавцан дээр ганцаараа торойтол хоцрохыг хараад сэтгэл өвдөн, зүрх шимшрэгч билээ.

Лондонд ирмэгц хар өнгийн хуучин хүрэм, өмд өмссөн тун хачин нүдтэй жаал хүү, мистер Браффыг тосон уулзав. Нүд нь дэндүү бүлтгэр аягандаа яаж тогтож байдаг юм бол гэмээр эргэлзэнэ. Мистер Брафф тэр жаалын үгийг сонссон хойноо бид Портлендын талбай хүртэл та нартай хамт явж чадахгүй боллоо гэж хоёр хатагтайгаас уучлал эрэв. Би буцаж ирээд юу үзэж харсн бүхнээ ярьж өгнө гэж Рэчелд дөнгөж хэлж байтал мистер Брафф намайг хөтлөн хлөсний тэрэг рүү яаран харайлгав. Нөгөө хачин нүдтэй жаал дэлбэгчийн хажууд сууж, тэрэг Ломбардын гудамж руу зүглэв.

Тэрэг хөдлөх үес,

- Банкны талар сурагтай юу? Гэж би Браффаас асуув.

- Люкерээс сураг байна. Цагийн өмнө Ламбэт дахь байшингаасаа хоёр хүн дагуулан хөлсний тэргээр гарчээ. Тэр хоёр нь энгийн хувцас өмссөн цагдаа нар байсныг миний хүмүүс таньжээ. Мистер Люкер, энэтхэгүүдээс айсандаа тийм сэрэмжлэх арга хэрэглэж байгаа бол хийх дүгнэлт зэгсэн тодорхой боллоо. Алмазаа банзнаас авах гэж яваа хэрэг.

- Тэгэд бид юу болохыг нь үзэх гэж банк руу явж байгаа юм уу?

- Тийм, хэрэв энэ хооронд бүх юм болоод өнгөрчихсөн байла гэхэд чухам яасныг нь сонсох гэж байгаа юм. Та дэлбэгчийн хажууд сууж байгаа миний энэ жаалыг ажиглав уу?

- Нүдийг нь л гайхлаа.

Мистер Брафф инээж,

- Хөөрхий манай ажлынхан Гусбери (морин хад) гэдэг юм. Миний зарлага юм л даа. Тэр нэр хоч өгсөн ажилтнууд маань энэ жаал шиг найдвартай ч болоосой доо! Гусбери бол хачин нүдтэй ч гэсэн Лондонгийн хамгийн овжин сэргэлэн жаалын нэг юм шүү, мистер Блэйк минь гэлээ.

Биднийг Ломбардын гудамжин дахь банкны үүдэнд ирэхэд таван цагт хорин минут дутуу байлаа. Гуёери хаалга нээж өгөхдөө эзнийхээ өөдөөс сүрхий царайчилсан байдалтай харна.

- Чи бас ормоор байна уу? хэмээн мистер Брафф эелдгээр асуугаад- Орвол ор л доо, харин өөр заавар өгөөгүй байхд надаас холдож болохгүй гэснээ- Тун ч овсгоотой жаал даа. Өөр хүүхдэд хорин үгээр ойлгуулах зүйлийг Гусберид хоёрхон үг хэлэхэд л ойлгоно хэмээн надад шивнэв.

Банкинд орж очиход урт лангууных нь араар мөнгөний нярвууд ярайн суусан гадаад танхимд хүн пиг дүүрэн байлаа. Таван цагт банк хаахаас өмнө мөнгө авах нэг нь авч, тушаах нэг нь тушааж амжих хэмээн ээлжээ хүлээн зогсоцгооно.

Мистер Браффыг ормогц олны дотроос хоёр эр хүрч ирэхэд хуульч

- за яав? Гэлээ.

- Хагас цагийн өмнө бидний хажуугаар өнгөрч, дотогшоо орсон, эрхэм ээ.

- Гарч ирээгүй л байгаа хэрэг үү?

- Үгүй, эрхэм ээ.

Брафф над руу эргэн

- Хүлээзнэе дээ гэв.

Би хавийн улс дундаас нөгөө гурван энэтхэгийг олж харах санаатай хайлаа. Тэд энд байгаа шинж огт үгүй мэт. Нэгэн бараан царайтай усан цэргийн хүрэм, дугуй малгайтай өндөр хүн харагдах нь далайчин гэмээр. Нөгөө гурвын нэг нь зүсээ хувилгачихаад байгаа юм болов уу? Арай ч дээ! Тэр хүн гурван энэтхэгийн аль алинаас нь өндөр ажээ. Өтгөн хар сахлыг нь эс оролцуулаад ч түүний царай тэр энэтхэгүүдийн аль алиныхаас наад зах нь хоёр дахин өргөн байж таарна.

- Тэд тагнуулаа энд тавьсан байх ёстой доо гэж Брафф хэлснээ нөгөө бараан царайт далайчныг олж хараад, - Тэр нь энэ хүн ч байж мэднэ гэв.

Өөр үг хэлж амжаагүй байтал нь морин хад шиг нүдтэй зарлага хүү хормойноос нь сэм татсанд мистер Брафф өөдөөс нь харвал: - Чш! Мистер Люкер тэр явж байна! гэлээ.

Мөнгө хүүлэгч, банкны отор этгээдээс энгийн хувцастай хоёр цагдаа дагуулсаар гараад ирэв.

- Нүд салгалгүй ажиглаарай. Алмазаа хүнд өгөх бол энд л өгөн байх шүү хэмээн мистер Брафф шивнэлээ.

Мистер Люкер бидний хэнийг ч анзаарсангүй, үүдний зүг олны дундуур шахалдах газара шахалдсаар алгуурхан зүтгэнэ. Бараан саарал өнгийн аятайхан костюмтай лагс намхан биетэй нэгэн эрийн хажуугаар гарахдаа гар нь учиртайхан хөдлөхийг би тодорхой харав. Тэр хүн ялимгүй давхийснээ хойноос нь харсаар хоцров. Ноён Люкер олны дундуур яаралгүй алхсаар үүдэнд хүрэхэд дагаж явсан хоёр цагдаа хоёр талд нь гарлаа. Тэд гурвын араас мистер Браффын нэг хүн дагах бөгөөд тэд тэгсгээд бараа тасарсан юм.

Би, хуульч өөд харснаа бараан саарал хувцастай хүн рүү учиртайхан харахад Брафф

- Тийм ээ! Би ч харсан! Гэж шивнэв.

Хоёр дахь хүнээ олох гэж ийш тийш харахад тэр нь үзэгдсэнгүй. Эргэж хартал зарлага жаал Гусбери нь ч арилаад өгчээ.

- Яасан золиг шиг юм болж байна вэ? Хоёул бидэнд хамгийн хэрэгтэй үедээ алга болчихдог нь юу вэ! хэмээн мистер Брафф уурсан дуу алдав.

Цг энэ үед саарал костюмтай хүний ээлж болж лангууны дэргэд очоод чекээр төлж тасалбар аваад гарах гэж байна.

- Одоо яадаг юм билээ? Энэ хүний хойноос тагнуул шиг мөрдөх болтлоо шалдаа буух хэрэг үү? гэж мистер Брафф асуухад нь би,

- Би бол мөрдөнө! Би энэ хүнийг алдахгүй дагана! Түмэн фондээр мөрийцсэн ч бэлэн! Гэлээ.

- Тэгвэл, би таны барааг хэлдгээс чинь хоёр дахин их мөнгөөр мөрийцсэн ч алдахгүй шүү. Миний мэтийн ийм ажилтай хүнд сайхан л хэрэг байна. Бурхан тэнгэрийг бодож энэ тухай хүн амьтанд бүү дурсаарай. Хүн мэдчихвэл би балрах нь тэр хэмээн надтай цуг нөгөө хүнийг даган банкнаас гарах зуураа бувтнаж билээ.

Саарал костюмтай хүн баруун тийш явах омнибусанд суухад нь бид хоёр ч хойноос нь орлоо. Мистер Браффт залуу халуун насных нь юм бас үлдсэн бололтой. Омнибусанд ороод суухдаа царай нь улайсан болохоор би ингэж хэлж байгаа юм л даа.

Саарал костюмтай хүн омнибусыг зогсоогоод Оскфорд гудамжинд буухад нь бид хоёр ч дагаад буув. Нөгөө хүн эмийн санд орчихов. Мистер Брафф хэрдхийн цочиж,

- Манай эмийн сан байх чинь, та бид хоёр буруудсан бололтой, яана даа! Гэв.

Бид хоёр тэр эмийн санд орж, мистер Брафф эзэнтэй нь хэдэн үг аминчлан шивнэлдээд буцаж ирэхдээ царай нь барайж урам нь хугарсан харагдав.

- Та бид хоёрт л их сайн юм болж дээ, сэтгэлд ч амар! Гэж мистер Брафф намайг хөтлөн гарах зуураа хэлэв.

- Юун сайн юм боллоо гэж?

- Мистер Блэйк минь! Та бид хоёр мөрдөн хйах ажилд авъяасаа сорьсон сайн дурын тагнуулчдын дотроос адгийн мууд орох юм байна. Саарал костюмтай хүн маань энэ эмийн санд гучин жил ажиллаж буй хүн гэнэ. Эзэн нь банканд мөнгө тушаалгахаар явуулсан юм гэнэ. Саран чулууг мэдэх талаараа бол өлгийтэй хүүхдээс ч дээрдэхгүй юм байж.

- Одоо яах вэ гэсэнд Брафф

- Миний албаны газар очъё. Гусбери миний нөгөө нэг хүн хоёр эрхбиш хүнээ олж дагасан биз.

Ямар ч атугай арай гярхай биз гэж найдъя даа! Хэмээв.

Грейс-Иин талбайд Браффын албан газар очиход хоёр дахь хүн нь бид хоёроос өмнө ирчихээд хориод минут хүлээж байна гэв.

- За хө ямар мэдээ байна? гэж мистер Брафф асуусанд,

- Эрхэм ээ, өршөөгөөрэй, би андуурч буруудсан байна.

Люкер, цайвар пальтотой хижээлдүү хүнд нэг юм өгөх шиг болсон юм л даа. Тэгсэн чинь, эрхэм ээ тэр хижээл эр бол Истчин дэх төмөр эдлэлийн худалдаачин, их тохитой томоотой эрхэм байжээ хэмээн өчлөө.

- Гусбери хаана байна? гэж Брафф илүү дутуу үггүй асуусанд нөгөө хүн нүдээ бүлтийлгэн,

- Мэдэхгүй, эрхэм ээ. Банкнаас гарснаас хойш бараагий нь ер хараагүй гэлээ.

Мистер Брафф тэр хүнээ явуулаад надад,

- Гусбери нэг бол тэр чигээрээ оргоод явчихаж, эсвэл өөрөө дур мэдэн нэг хүний хойноос хөөцөлдөж яваа, энэ хоёрын л нэг. Тэр жаалыг ганц хоёр цагийн дараа эргээд ирж магадгүй гэж горьдоод энд үдийн хоол идвэл яасан юм? Зооринд сайхан дарс бий, гуанзнаас махан шанз авчруулаад идчихье гэв.

Мистер Браффы конторт хоолочихоод ширээний бүтээлгийг нь хурааж амжаагүй байтал хуульчтай нэг хүн уулзах гэж ирээд байна гэж мэдэгдлээ. Гусбери юм болов уу? Биш байв. Люкерийг банкнаас гарахад нь дагах ёстой байсан хүн л иржээ.

Тэр хүний мэдээнд сонирхол татахаар юм огт үгүй байлаа. Мистер Люкер гэртээ хариад бие хамгаалагч нараа явуулжээ. Гэрээсээ дахиад цухуйсан ч үгүй. Үдшийн бүрий эхлэхэд цонхныхоо самбарыг хааж, үүд хаалгаа түгжжээ. Байшингийн урд гудамж, арын нарийн гудамжийг сайтар харуулдсан байна. Нөгөө энэтхэгүүд бараа туруугүй, ер тэр хавьд дэмий холхих хүн хар огт харагдсангүй ажээ. Тэр эрүүлч эдгээрийг мэдээлээд өөр даалгавар өгөх эсэхийг мэдэж авахаар хүзээзнэсэнд мистер Брафф түүнийг өнөө шөнөдөө амар гээд явууллаа.

- Мистер Люкшр, Саран чулууг гэртээ авч харьсан гэж та бодож байна уу? гэж би асуухад Брафф,

- Үгүй ээ, өөрө авч явахгүй. Тэр чулууг гэртээ дахин аваачиж хадгалсан бол хоёр цагдаагаа хэрхэвч явуулж зүрхлэхгүй хүн гэлээ.

Бид хоёр нөгөө жаалыг ирэх болов уу хэмээн дахин хагас цаг хүлээсэн боловч хүлээсний гарз боллоо. Мистер Брафф Хэмпстэд рүү, би Портланд талбай руу, Рэчел дээр очих цаг болов. Би тэр орой арав хагас гэхэд байрандаа ирнэ гэж нэрийнхээ хуудсан дээр бичээд жаал хүүг ирвэл өгчихөөрэй гээд конторын манаачид орхив.

Зарим хүн болзож товлосон цагаа хатуу баримталдаг байхад зарим нь ёс шиг хожимддог. Би бол эдний тоонд орох хүн. Үүний дээр тэр үдэш Портланды талбайд очиж хориод алхам урт өрөөний нэг үзүүрт нь Мерридюю хатагтай сууж байхад би, Рэчелийн хамт нэг буйдан дээр сууж байсан гэвэл арван цаг хагаст харих байсан атлаа арван хоёр хагаст сая гэртээ очсон гэхэд гайхах хүн үгүй бизээ. Байвал тэр хүн даанч нүнжиггүй хүн байж таарна! Тийм хүнтэй хэзээ ч учрахгүй буй заа хэмээн үнэн голоосоо итгэж байна!

Намайг гэртээ ороход зарц нэг цаас өгч байна. Хуульч хүнийнх баймаар нямбай бичгээр:

“Эрхэм ээ, таныг соёрхвол би явж унтмаар байна. Өглөө ес, арван цагийн хооронд буцаж ирье” гэжээ.

Хэрхсэнийг лавлавал маш содон нүдтэй нэг жаал хүү гарч ирээд, миний нэрийн хуудас, зурвасыг үзүүлж, намайг хүлээн бүтэн цаг унтаж сэрэнгээ надад хэдэн үг бичиж үлдээхдээ “шөнө унтаж нойроо авахгүй бол би хэнд ч хэрэггүй хүн болно” гэж зарцад тун хэвлүүхэн додигор тайлбарлаад гэртээ харихаар явсан байлаа.

Өглөө нь би есөн цагт босоод гийчнээ хүлээж авахад бэлэн болоод байлаа. Есөн цаг хагаст хаалганы цаана хөлийн чимээ гарахад нь ... “Ор, ор. Гусбери!” гэсэнд “Баярлалаа, эрхэм ээ” гэсэ нухацтай номой дуу сонсдов. Үүд нээгдэв. Би босож очвол түрүүч Каффтай улаан халз тулгарах нь тэр!

- Мистер Блэйк минь, Таныг хотод байж магадгүй гэж бодоод Иоркшир руу бичихээсээ өмнө үүгээр ороод гаръя гэж бодлоо л доо.

Түрүүч Кафф мөн л уруу царайтай, эцэнхий туранхай хэвээр ажээ. “Хүнийг харад өөрөөс нь ч илүү их олоод мэдчихдэг” (Бэттереж гуайн хүүрнэлд гарсан шүү дээ) нүд нь тэр сүрхий шинжээ алдаагүй байна. Гэвч хувцас хүнийг өөрчилж нэгэнт чаддаг болохоор түрүүч Кафф танигдахааргүй хувирсан байна. Толгой дээрээ өргөн хүрээтэй цагаан бүрх тавьж, анчны хөнгөн хүрэм, цагаан өмд, хар хүрэн өнгийн түрүү өмсжээ. Царс модон бүдүүн тулуур барьжээ. Бүх насаараа хөдө өнутагт суусан хүн гэж харагдахыг бүхий л талаар хичээсэн мэт. Түүний бие тийнхүү их өөрчлөгдсөнд нь баяр хүргэвэл тоглоом тохуу хэмээн хэрэгсээгүй атлаа Лондоны чимээ шуугиан, муухай үнэр танарыг гайхан жигшинэ. Үг яриа нь хүртэл хөдөөний аялгуутай болсон байлаа.

өглөөний хоол, цай идэж уу гэхэд хөдөөний гэнэн хонгор эр маань ихэд гайхаж, би өглөө зургаа хагаст хооллодог, тахиа шувуутай зэрэг унтдаг! Гэв.

- би дөнгөж урд шөнө Ирландаас ирлээ. Ноднин миний орхисон нөгөө алмазын хэргийн талаар юу юу болсныг бичсэн таны захидлыг унтахаасаа өмнө уншсан. Тэр хэргийг би ерөөсөө ойлгоогүй байж гэдгээ л одоо хэлэх байна. Тэр үеийн тиймэрхүү нөхцөл байдалд хэн ч гэсэн уг хэргийн учрыг үнэнээр нь олж барахгүй байсан бизээ. Гэсэн ч үүгээр бодит байдал өөрчлөгдөхгүй. Би ч холион бантан болгож орхисноо мэдлээ л дээ. Мөрдөн байцаах ажил эрхэлсээр анхны удаа холион бантан хугтасан гэж байгаа юм биш шүү. Мистер Блейк минь! Ном зохиолд л мөрдөх байцаах газрын эрүүлчид алдаа хийдэггүй юм даа хэмээн түрүүч энд ирсэн жинхэнэ зорилгынхоо тухай тойруу замаар хэнэггүй тайван янзаараа ярилаа.

- Та яг л алдаагаа залруулж, нэр төрөө сэргээх бололцоотой цагаан олж ирсэн байна гэж намайг хэлэхэд эрүүлч татгалзан,

- Уучлаарай, мистер Блэйк би огцорсон хүн болохоор ооо нэр төрөө сэргээх талаар санаа зовох хэрэг огт алга. Нэр төр гэгчийг Тэнгэрийн ивээлээр үзээд өнгөрсөн хүн! Би, талийгаач Вериндер ахайн өгөөмөр сайхан сэтгэл гаргаж байсныг бодоод энд ирлээ шүү, эрхэм ээ! Гагцхүү энэ л шалтгаанаас үүдэн миний бие (хэрэв та хүсээд надад итгэж байгаа бол) хуучин ажлаа сэргээж болох байна. Би танаас ганц ч зоос авна гэхгүй. Энэ ажлыг гагцхүү нэр төрийн хэрэг болгоно. За одоо та надад бичсэн захидлаас хойш юу юу болсо тухай ярьж өг л дөө гэв.

Би түүнд хар тамхиар хийсэн туршлага, дараа нь Ломбард гудамжин дахь банканд болсон явдлын тухай ярьж өглөө. Тэр туршлагын тухай сонсоод мистер Кафф тун их гайхав. Урьд өмнө тийм юм ерөөсөө дуулаагүй байж. Ялангуяа миний бие Рэчелийн төрсөн өдрийн баярын шөнө зочны өрөөнөөс нь гараад алмазыг хэрхсэн тухай Эзра Женнингсийн таамаглалыг ихэд сонирхлоо.

- Мистер Женнингс таныг Саран чулууг нуусан гэж бодож байгаа бол би тэгж бодохгүй байна. Харин тэр чулууг та өрөөндөө заавал аваачсан байх ёстой гэдэг талаар бид хоёрын санал нийлж байна гэж түрүүч Кафф хэлэв.

- Тийм үү? Тэгээд яасан бол? Гэж би асуулаа.

- Яасныг та санах юм огт алга уу, эрхэм ээ?

- Огт үгүй.

- Мистер Брафф ч бас адилхан уу?

- Надаас дээрдэх юмгүй.

Эрүүлч Кафф босож миний бичгийн ширээ рүү очоод эргэж ирэхдээ битүүмжилсэн дугуйтай бичиг авчрав. Дээр нь “нууц” гэж тавиад, миний хаягийг бичиж, өнцөгт нь түрүүч гарын үсгээ зурсан байв.

- Ноднин би буруу хүн сэжиглэж байсан, энэ жил ч бас тэгж байж магадгүй юм. Дугтуйг задлаха түр азнана уу, мистер Блэйк үнэнийг лавтай мэдтэл хүлээсэн нь дээр байх. Тэгээд гэмтэн этгээдийн нэрийг миний энэ дугтуйтай бичигт тавьсан нэртэй зэрэгцүүлээд үзээрэй.

Би, тэр захидлыг халаасандаа хийчихээд, банкны хавьд бидний зохион байгуулсан ажлыг юу гэж бодож байгааг нь асуулаа.

- сүрхий ухаан сийлжээ. Эрхэм ээ. Тун зөв юм хийсэн байна. Харин мистер Люкерээс гадна өөр бас нэг хүнийг ажиглах ёстой байж дээ,

- Надад сая өгсөн захидалдаа нэрий нь дурдсан гэсэн тэр хүнийг үү?
- Тийм, мистер блэйк минь, наана чинь бичсэн байгаа. Одоо яах ч арга алга. Цагий нь болоход мистер Брафф та хоёрт нэг санал тавина даа, эрхэм ээ. Одоохондоо хүлээж л байя. Эхлээд өнөө жаал маань хэрэг болох мэдээтэй ирэх эсэхийг нь үзье дээ.

Арван цаг хариугүй дөхөж байсан боловч жаал хүү алга л байлаа. Түрүүч Кафф өөр юм ярьж эхлэв. хуучин найз Бэттереж, хэзээний дайсан цэцэрлэгчийг сураглав. Дахиад нэг минут болсон бол хамгаас дуртай сарнай цэцгийнхээ тухай яриа дэлгэх байсан нь эргэлзээгүй. Гэтэл манай зарц, нөгөө жаал хүү ирчихээд доор хүлээж байна гэж мэдэгдэв.

Гусберийг өрөөнд оруулсанд танихгүй хүний бараа хармагц үл итгэсэн байртай хяламхийснээ босгон дээр зогсчихлоо. Би, жаал хүү дуудаад,

- чи энэ эрхмийн дэргэд ярьж болно. Нада туслах гэж ирээд байгаа юм. Юу юу болсныг бүгдийг нь мэдэж байгаа гээд, - Түрүүч Кафф аа, энэ бол мистер Браффын албаны зарлага жаал байгаа юм гэв.

Манай энэ соёл иргэншлийн үед алдар цуу гэгч (чухам ямар нь падгүй) аливаа бүхнийг хөдөлгөн чаддаг хөшүүрэг билээ. Агуу их Каффын алдар цуу өчүүхэ Гусберийн чихийг ч хэдийнээ дэлссэн байжээ. Тэрхүү алдарт нэрийг дуулмагц Гусберийн хэтэрхий бүлтгэр нүд жигтэйхэн эргэлдэж эхэлсэн тул хоёр нүд нь аяганаасаа бүлт үсрэн хивсэн дээр уначих вий дээ гэж би өөрийн эрхгүй бодов.

- За, хүү минь нааш ир, бидэнд юу хэлэх гэж ирснийг чинь сонсьё гэж түрүүч Кафф хэлэв. Лондонгийн хуульч бүрийн албан байранд дуулдсан асар олон дуулиантай хэрэг явдлын гол баата болсон агуу их хүн ийнхүү анхаарч буйд жаал хүүгийн нар нь гарсан шиг байв. Гусбери, түрүүч Каффын өмнө очиж, нуруугаа үүрэн зогсох нь шалгалт өгөх гэж буй бандь мэт харагдана.
- Нэр чинь хэн бэ? гэж шалгалтынхаа анхны асуултыг тавихад жаал хүү,
- Октовиус Гай. Албан газрынхан намайг нүдээр минь морин хад Гусбери гэж дууддаг гэв.
- Октовиус Гай буюу морин хад гэнэ ээ. чи өчигдөр банкнаас гараад хаашаа алга болсон бэ? Хаагуур явав? Гэж түрүүч их л нухацтай асуув.
- Эрхэм ээ би нэг хүнийг мөрдсөн юм.
- Юун хүн бэ?
- Далайчин шиг хувцасласан, өтгөн хар сахалтай, өндөр хүнийг, эрхэм ээ.
- Тэр хүнийг чинь би санаж байна! тэр лав энэтхэгчүүдийн хөлсний туршуул байх гэж мистер Брафф бид хоёр бодож байсан юм гэж би хажуунаас нь хэллээ.

Түрүүч Кафф мистер Брафф бид хоёрын юу гэж бодсоныг нэг их тоосон янзгүйгээр Гусберийг цааш нь шалгаав.

- Тийм үү? Яагаад тэр далайчныг дагасан юм бэ?
- Эрхэм ээ, мистер Люкер банкнаас гарахдаа ямар нэгэн хүнд юм өгөх эсэхийг ажиглаарай гэж мистер Брафф хэлсэн юм. Мистер Люкер гарч явахдаа тэр хар сахалтай далайчинд нэг юм өгөхийг нь би харсан.
- Юу харснаа мистер Браффт яагаад хэлээгүй юм бэ?
- Далайчин их яарау гарсан болохоор би хэнд ч, юу ч хэлж амжаагүй.
- Тэгэд чи хойноос нь гүйсэн хэрэг үү, аан?
- Тэгсэн эрхэм ээ.

Түрүүч Кафф хүүгийн толгойг илбээд- Гусбери чиний энэ бяцхан гавал дотор бага зэрэг юм байна. тэгэхдээ ус биш шүү. Чи их сайн хүү байна гэв.

Жаал хүү баярлан урамшандаа царай нь улайна.

Түрүүч Кафф цааш нь асуултаа үргэлжлүүлэв.

- За тэгээд гэж далайчин гадаа гараад яав даа?
- Хөлсний тэрэг дуудсан эрхэм ээ.
- Чи тэгэхээр нь яасан бэ?
- Хойноос нь зогсож байгаад араас нь гүйгээд байсан.

Түрүүч Кафф цааш нь юм асууж амжаагүй байтал мистер Браффын албан газраас нэг ажилтан нь ирлээ гэж мэдэгдсэнд би түрүүч Кафф, жаал хүү хоёрын чухал яриаг тасалдуулахгүйн тулд нөгөө ирсэн хүнийг өөр өрөөнд хүлээж авлаа.

Эзнээсээ урагшгүй мэдээ хүргэж ирсэн байв. Өнгөрсөн хоёр өдрийн турш сэтгэл, зүрхийг ихэд хөдөлгөсөн чухаг хэрэг явдал Браффын биед муугаар нөлөөлж өнөө өглөө босоход тулай өвчин нь хөдөлсөн байсан учир гэртээ Хэмпстидэд байгаа гэнэ. Тэгээд ажил явдал нэнэ эгзэгтэй рүүгээ ороод байгаа үед намайг туршлагатай хүний зөвлөгөө, туслалцаагүй орхиод хүрсэндээ санаа нь их зовж буй ажээ. Нөгөө ажилтан нь миний мэдэлд ажиллах тушаалтай байсан болохоор надад мистер Браффаас дутахааргүй тус болоход бэлэн ажээ.

Миний бие өвгөний сэтгэлийг тайвшруулахын тулд, түрүүч Кафф айлчлан ирээд байгаа тухай тэр даруй бичсэний дээр, яг энэхэн үед Гусберийг асуун магадалж байгаа, ер нь энэ өдрийн сүүлчээр чухм юу болсныг танд биеэр буюу захидлаар мэдэгдэнэ гэлээ. Бичсэн зурвасаа Хэмпстид рүү нөгөө ажилтнаар нь өгч явуулаад түрүүн байсан өрөөнд эргэж орвол түрүүч Кафф хонх дарах гэж задгай галын зуухны эргэд очоод байв.

- Уучлаарай, мистер Блэйк би тантай уулзах хэрэг гарад зарц дуудаж танд хэлүүлэхээр завдаж байлаа гээд Гусберийн толгойг илбэж- Ёстой сайн жаал юм даа яг л зөв хүнээ дагасан байна. Паанч эрхэм минь, өчигдөр орой та таван цаг хагаст гэртээ ирээгүйгээс болж тун чухал цагийг алдаж дээ. Одоо бол нэн даруйхан хөлсний тэрэг дуудах хэрэгтэй байна гэв.

Таван минутын дараа түрүүч Кафф бид хоёр (Гусберийг дэлбэгчид газарч болгон хажууд нь суулгаад) зүүн тийш Ситийн зүг явж байлаа.

Түрүүч Кафф, сүүх тэрэгний урд талын цонх руу зааж,

- энэ жаал миний эрхэлж байсан мэргэшлийн талаар мөд их зүйл бүтээнэ дээ. Энэ олон жил ажиллахдаа би ийм саруул ухаантай, сэргэлэн жаал хүүтэй учирсангүй. Таны эзгүйд надад ярьсан зүйлийнх нь гол утгыг нь та сонс л доо. Хөлсний тэрэгний араас гүйсэн гэж ярихад нь та байсан байхаа? Гэхэд нь би,

- Байсан гэв.

- За тэгвэл, эрхэм ээ, тэр хөлсний тэрэг нь Ломбардын гудамжнаас Тоуэрийн усан онгоцны зогсоол чиглэн явжээ. Хар сахалт далайчин тэрэгнээс бууж, Роттердамын уурын хөлгийн жижүүртэй ярилцжээ. Тэр хөлөг нь маргааш өглөө нь явах юмсанж. Сахалт, одоо хөлгөндөө орж суугаад өнөө шөнийг өрөөндөө өнгөрөөе гэсэнд жижүүр нь зөвшөөрсөнгүй. Тэр шөнө бүх өрөө тасалгаа, ор дэвсгэрийг цөмийг цэвэрлэх ёстой байсан учраас өглөө болтол ганц ч хүн оруулахгүй гэхээр нь далайчин эргэж, зогсоолоос явсан байна. Тэр үед замын нөгөө талд механикч мэт хувцасласан нэг эр нөгөө далайчныг харуулдан буй бололтой хөлхөж байхыг жаал хүү анх удаа ажиглажээ. Далайчин буурчийн газрын гадаа очиж түр саатсанаа дотогш ороход жаал хүү хэрхэх учраа олж ядасхийн тэр хавьд байсан хэдэн хүүхдийн дунд орж буурчийн газрын цонхон дээр тавьсан идэш уушны зүйлсээр нүд хужирлах зуураа нөгөө механикч мэт хүнийг ажвал гудамжны нөгөө талд бас л хүлээж харуулдан зогсох нь харагджээ. Минут орчмын дараа хөлсний нэг тэрэг аажуухан явсаар механикчийн ойр зогсчээ. Тэргэнд сууж явсан нэг хүн механикчтай ярих гэж цонхоо нь өлийж байхыг жаал хүү тодорхой харсан байв. Тэр хүнийг энэтхэг шиг бараан царайтай байсан гэж манай жаал, намайг тэр талаар юу ч дурсаагүй байха хэлсэн шүү.

Мистер Брафф бид хоёр бас нэг алдаа хийсэн нь илэрхий боллоо. Хоёр сахалт далайчин бол энэтхэгчүүдийн хөлсний тагнуул ч биш, харин Саран чулууг авсан хүн байж таарах гэж үү?

- Тэгсгээд нөгөө хөлсний тэрэг гудамж уруудан явжээ. Механикч ч гудамж хөндлөн гараад буурчийн газар орсон байна. Жаал маань гадаа нь зогсоод л байж, өлсөж ядарсан нь тэсэхийн аргагүй болохоор өөрөө ч дотогш оржээ. Халаасандаа байсан нэг шиллингээр подхийтэл хооллосо гэнэ, цусан чунз, могой гурвэлэн бялуу идэж, нэг шил гаатай пиво уужээ. Ийм насан дээр ходоод шингээхгүй гэхийн зовлон байх биш дээ!

- Буурчийн газар ороод юу харсан гэнэ?

- Далайчин нэг ширээнд сонин уншаад, механикч өөр нэг ширээнд бас сонин уншаад сууж байж. Харанхуй болсон хойно далайчин босож, гадагш гарчээ. Гудамж руу орохдоо ийш тийш сэжиглэн хараад, жаал хүүг жаахан хүүхэд гээд дэргэдүүр нь тоолгүй өнгөрчээ. Механикч гарч ирээгүй л байж. Далайчин эргэн тойрноо харсхийн чухам хаачихаа лавтай мэдэхгүй байгаа мэт явна. Тэгтэл ч механикч замынхаа цаад талд дахин үзэгджээ. Далайчин цааш алхсаар Доод ТЕМкийн гудамж руу ордог эргийн Догол хүрч тэндхийн “Азын Хүрд” гэдэг зочид буудлын үүдэнд очоод гадна байдлыг ажсаар дотогш ороход нь Гусбери ч оржээ. Зуушны газрынх нь хавьд бужигнах улсын ихэнх нь тохитой хүмүүс харагдана. “Азын Хүрд” гэдэг чинь мистер Блэйк минь, ер нь догь буудал нэн ялангуяа гахайн махан бялуу, хар пиво нь их алдартай юм шүү дээ. Сэдвээсээ хадуурахад нь би баахан эгдүүцсэн ба үүнийг ажиглаад түрүүч Кафф цаашид гагцхүү Гусберийн ярьсныг хүүрнэх болов.

Далайчныг унтах ор олдох болов уу гэж асуусанд буудлын эзэн “Олдохгүй, бүгд хүнтэй!” гэхэд зуушны газрын худалдагч бүсгүй хажуунаас нь “Аравдугаар өрөө хүнгүй байгаа шүү дээ” гэж залруулжээ. Тэгээд аравдугаар өрөөг үзүүлэхээ зарц илгээв. Зуушны лангуун дэргэд нөгөө механикч байхыг Гусбери түрүүхэн нь олж харсан байж. Зарц буцаж ирээд илтгэхийн өмнө механикч алга болсон байв. далайчинг өрөөнд нь оруулахаар явцгаахад Гусбери хэрхэхээ мэдэхгүй болоод ямар ч гэсэн цааш юу болохыг хүлээзнэх ухаан сийлжээ. Тэгтэл ч нэг юм ч болж гэнэ. БУУдлын эзнийг дуудацгаажээ. Хүмүүс уурсан хэрэлдэх дуу дээд давхраас гарч гэнэ. Буудлын эзэн нэг хүнийг заамдсаар бууж ирсэн нь нөгөө механикч байх юм гэнэ. Хөлчүү согтуу хүний бүхий л шинж

төрхтэй байгааг нь үзээд Гусбери мэл гайхаж, цэл хөхөрчээ. Буудлын эзэн түүнийг үүдээр түлхэн гаргаад, дахиж шагайвал цагдаа дуудна шүү хэмээн сүрдүүлжээ. Тэдний хэрүүл маргаанаас ажигч тэр хүн аравдугаар өрөөг эзэлчихээд энэ өрөөг авсан хэмээ согтуу хүний зангаар агсагнан зүтгэсэн аж. Гусбери, тэр хүн эв эрүүл байснаа гэнэт тийм их согтуу болсонд нь мэл гайхсан учраас гараад явахад нь хойноос тэсгэлгүй дагажээ. Нөгөө хүн зочид буудлын бараа харагдах газарт арчаагүй согтуу мэт гуйвж дайван салгалж байснаа гудамж тойрмогц тэнцвэрээ олж архи амсаа ч үгү йэв эрүүл болон хувирчээ. Гусбери бүр самуурч гүйцээд “Азын Хүрд” зочид буудалд буцаж очжээ. Дахиад юу болох нь вэ гэж хүлээгээд юу ч болсонгүй. Далайчны талаар юу ч мэдэгдэж, сонсогдсонгүй. Тэрсгээд Гусбери албан газартаа эргэж очихоор шийдээд гадагш гартал нөгөө механикч гудамжны нөгөө талд ирчихсэн байсан гэнэ шүү! Зочид буудлын дээд давхрын гэрэл ассан ганц өрөөний цонхыг хараад дотор нь онгойв боллолтой цаашаа шууд явсан гэнэ. Жаал хүү маань ч Грейс –инд эргэж ирээд таны нэрийн хуудас, зурвасыг авч танайд очсон боловч та эзгүй байжээ. Уг хэрэг явдал одоо иймэрхүү л болоод байгаа юм байна даа мистер Блэйк минь.

- Түрүүч ээ, та үүнийг юу гэж бодож байна даа?
- Эрхэм ээ, тун ч адармаатай болоод байх шиг санагдана. Жаалын харсан бүхнээс үзвэл энэ хэрэгт энэтхэгчүүд оролцсон байна, үүнийг юуны өмнө мэдэх хэрэгтэй юм.
- Тийм байж. Мистер Люкер алмазыг тэр далайчинд өгсөн байж таарлаа, гэтэл мистер Брафф түүний албаны хүн бид гурав тэгж андуурдаг маань хачирхалтай.
- Огт хачин бишээ, мистер Блэйк. Тэр хүн тийм амь өрсөн юм хийгээд байгаагаас үзвэл мистер Люкер түүнтэй урьдаар тохиролцчихоод зориуд чулуу хөөлгөж л дээ.
- Зочид буудалд болсон явдлын учрыг та ойлгосон уу? Механикч шиг хувцасласан хүн бол энэтхэгчүүдийн хөлсний хүн байжээ. Харин яах гэж гэнэт согтсон дү үзүүлж, дөвчигнөсний учрыг би, Гусберийн адил ойлгохгүй л байна.
- Эрхэм минь би бол ямар учиртайг тааварлаж чадмаар байна шүү. Сайтар тунгаан үзвэл тэр хүн энэтхэгчүүдээс хатуухан заавар авсан нь илт байна. Өөрснөө банканд юм уу, зочид буудалд ороход дэндүү содон байх учраас юм бүхнээ хөлснийхөө этгээдэд итгэмжлэхээс өөр аргагүй байжээ. За, зүйтэй! Нөгөө далайчны хоноглох болсон мөн бид эндүүрээгйү бол, тэр шөнө алмаз байх ёстой өрөөний дугаарыг зуушны лангууны хавьд чангаар хэлэхэд нь энэтхэгчүүдийн хөлсний этгээд чих дэлсжээ. Ийм нөхцөлд энэтхэгчүүд тэр өрөөний байдлыг сонирхож, хаана байдаг, гаднаас нь орж болох эсэх зэргийг мэдэх гэж улайрах нь мэдээж. Тийм даалгавар авсан хүн яах ёстой вэ? Яг л нөгөө механикч шиг аашилна даа! Далайчныг оруулахаас өмнө тэр өрөөг амжижи үзэхээр шатаар дээш гүйж гарсан байна. Ажиглаж байснаа баригдаад, амархан мултрах санаатай согтуу хүний дүр гаргажээ. Урчыг нь би нгэж л тайлах байна. Зочид буудлаас хөөгдөж гарсан хойно хөлсөлсөн эздийнхээ хүлээж байсан газар очиж юу болсныг илтгэсэн биз. Цаадуул нь, түүнийг далайчин тэндээ л латай хонох эсэхийг мэдээд ир хэмээн буцааж явуулсан нь эргэлзээгүй. Жаал хүүг харьснаас хойш “Азын Хүрдэд” юу болсныг бид урьд шөнө л мэдэх ёстой байсан юм. Гэтэл одоо өглөөний арван нэгэн цаг болж байдаг. Бид бүтэмжтэй болосой гэж найдаад чадах бүхнээ олж мэдэхийг хичээе гэж түрүүч ярилаа. Нэг мөчийн дара бид эргийн Доголд хүрээд зогсоход Гусбери бидэнд сүүхний хаалга нээж өгөв.
- Зүгээр үү? Гэж түрүүч асуухад Гусбери
- Зүгээр гэв.
- “Азын Хүрдэд” орцгооход энд ямар нэг базаахгүй явдал болсон шинж дадлагагүй миний нүднээ ч илт туслаа.

Архи дарсны лангууны ард юу хийхээ огт эс ухааран мэгдсэн зарц хүүхнээс өөр хүн тэнд байсангүй. Өглөө уух юмаа хүлээн тэсэж ядах ганц хоёр хүн зоосоороо лангууг тогшино. Мухлагийн худалдагч бүсгүй дотроос үймэрч балмгдсан гарч ирэв. Түрүүч Кафф, буудлын эзнийг бургаласанд дээд давхарт, хүнтэй уулзах зав чөлөөгүй байгаа гэж ширүүхэн хариулав.

- Эрхэм ээ надтай хамт яваарай гээд мөн жаал хүүг дагаад яв хэмээн дохиж, шатаар ажиг ч үгүй өгслөө.

Мухлагийн худалдагч хүүхэн танихгүй ‘улс хэлсээр байтал дайраад орчихлоо шүү гэж эзэндээ хашгирав. Эзэн нь юу гэгч болоод байна хэмээн ихэд эгдүүцэн уруудаж яваад бидэнтэй шатны тавцан дээр тааралдаж,

- та нар юун улс вэ? Яах гээд байгаа юм? Гэсэнд түрүүч тайвнаар,
  - Та тогтож хайрла. Би танд юуны өмнө хэн болохоо хэлье. Би бол түрүүч Кафф гэдэг хүн гэв.
- Алдар цуутай нэрийн хүч тэр даруй мэдэгдэв. Ууртай байсан эзэн зочны өрөөний үүдийг нээж түрүүчээс уучлалт эрэн,

- Эрхэм минь үнэндээ би уур уцаартай, муухай ааштай байна л даа. Өнөө өглөө манайд баахан байзаахгүй юм боллоо. Иймэрхүү ажил төрөлтэй хүнд бизэ барих аргагүй юм бишгүйдээ нэг гарах юм байна шүү дээ, түрүүч Кафф минь хэмээн учирлахад нь, Кафф,
- Тэгэлгүй дээ, таны долоон зөв. Та зөвшөөрвөл танай энд ирсэн учраа одоохон хэлье. Энэ эрхэм бид хоёрын сонирхоод байгаа хэдхэн зүйлийг танаас лавламаар байна гэв.
- Юун тухай юм бол доо, эрхэм ээ?
- Урьд шөнө энд унтсан, далайчи шиг хувцасласан, бараан царайтай хүний талаар,
- Ай бурхан тэнгэр минь! Тэр хүнээс чинь л болоод манай энэ өглөөжин хөл болж байна. Та эсвэл энэ эрхэм, тэр хүний талаар юм мэдэж байх нь уу?
- Түүнийг харахаас нааш лавтай хэлэх юм алга гэж эрүүлч хариуллаа.
- Харах ий? Гэж буудлын эзэн лавлаад- Өнөө өглөө долоон цагас хойш тэр хүний барааг харах гэж ө бүр ядчихаад байгаа юм шүү дээ. Уг нь өглөө долоон цагт сэрээгээрэй гэж захисан юм. Хэлсэн цагт нь дуудсанд хариу байдаггүй гэнэ, үүд нь түгжээтэй тул учрыг мэдэх арга байсангүй. Найман цагт, бас есөн цагт дахиад дуудсан. Нэмэр болсонгүй! үүд нь цоожтой чимээ анирч үгүй байжээ! Би өнөө өглөө гадуур ажилтай явж байгаад дөнгөж мөчийн өмнө ирээд байна. тэр өрөөний хаалгыг баахан нүдлээ. Ямар ч тус алга. Мужаан авчруулах гээд зарлага явуулсан. Та хэдэн минут хүлээвэл бид үүдийг нь өонгойлгоод чухам юу болсныг үзэж болох юм даа гэв.
- Тэр хүн урьд шөнө согтуу байсан уу? гэж түрүүч Кафф асуув
- Эв эрүүл байсан. Архи уусан хүнийгб и буудалдаа хонуулдаггүй.
- Өрөөнийхөө хөлсийг урьдчилаад төлсөн үү?
- Үгүй.
- Үүднээс өөр газраар гарч явах боломж бий юу?
- дээврийн өрөө л дөө., Таазанд нь байшингийн дээвэр рүү гарчихаар нээлхий бий. Харин энүүхэн хаяанд, одоо засварт ороод байга анэг хоосон байшин бий. Тэр хар луйварчин хөлс төлөлгүй явчихсан гэж түрүүч та бодож байгаа юм уу?
- Өглөө эрт, хөл хөдөлгөөнгүй цагаар далайчин хүн чдавгүй гараад явчихна л даа. Авирч сурсан хүн байшингийн орой дээр гарсан ч толгой нь эргэнэ гэж байхгүй.

Тийн ярьж байтал мужаан ирснийг мэдэгдэв. Бид бүгдээр өгсөж, хамгийн дээд давхарт гарлаа. Түрүүч улам ч ихб уурьтай, жижгтэйхэн бодлогоширсон харагдав. Түүнчлэн түрүүхэн дагаад яв гэсэн атлаа одоо жаал хүүг биднийг эргээд иртэл эндэ эхүлээ бай гэсэн нь бас хачин санагдаж, би баахан гайхсан билээ.

Мужааны алх, цүүц хэдхэн минутын дотор үүдний урчыг олсон боловч цаанаас нь эд тавилга овоолж хаасан байв. Бидүүдий нь нөгөө овоолсон юмтай нь хамт түлхэн орж дөнглөө. Буудлын эзэн түрүүлэн, арас нь түрүүч, дараа нь би орлоо. Бусад нь биний араас орж ирэв.

Бүгдээр ор руу хараад хэрдхийн цочив. Нөгөө хүн гарч яваагүй, харин хувцастайгаа орон дээр хэвтэх бөгөөд нүүрэн дээр нь цагаан жинтүү байлаа.

Буудлын эзэн жинтүүг зааж,

- Энэ чинь ямар учиртай юм болж байна вэ? гэсэнд түрүүч хариу дугаралгүй орны дэргэд очиж, жинтүүг зайлуулав.

Тэр хүний бараан царай ямар ч хөдөлгөөнгүй, гөлийж үс сахал нь тун ялимгүй сэгсийсэн агаад, цоггүй нүд нь тааз өөд мэлтийтэл ширтжээ. Цагаанаар эргэж гөлийсөн нүдийг харахаас айдас төрж би харц буруулан онгорхой цонх тийш очив. Харин бусад хүн түрүүч Каффын хамт орны дэргэд зогсоор байлаа.

- Ухаан алдчихсан юм болов уу? гэж буудлын эзэн дуугарах сонсдов.

- Үхчихсэн байна. Эмч рүү хүн явуул. Цагдаа дууд гэж түрүүч хэлж байна.

Хоёуланг дуудуулахаар зарлага гүйлгэлээ.

Түрүүч Кафф ямар нэгэн хачирхам зүйлд автан \орноос холдохгүй байгаа мэт санагдана. Бусад нь ч өөрцгүй, сониуч занд автаад эрүүлч одоо хэрхэх бол хэмээн хүлээж буй мэт ажээ.

Би дахиад л цонх руу эргэж харлаа. цг энэ үед миний хормойноос хүн аяархан татаж,

- Хараач эрхэм ээ! Гэж намуухан шивнэх сонсдов.

Гусберий бидний араас ороод ирсэн юмсанж. Бүлтгэр нүд нь айсандаа биш, хөөрч дэвэрсэндээ аймаар эргэлзэж байлаа. Шинэ зүйлолж харсан байжээ. “Энэ, хараач эрхэм ээ!” гэж дахин хэлээд өрөөний буланд буй нэг ширээ рүү намайг дагуулан очлоо.

Ширээн дээр онгорхой жижиг модон хайрцаг хоосон байв. Нэг талд нь эрдэнэсийн зүйл боож байсан жаахан хөвөн, нөгөө талд нь цагаан цаасны тасархай үзэгдэхэд ажвал дээрээ тамгатай бас уншиж болохоор товч бичигтэй байв. Бичгийн үгийг сийрүүлбэл: “Ламбетын Мидлсексийн талбайд оршин суудаг Септимус Люкерээс мистер Буш, Лойсот, Бут нарт хадгалуулахаар өгсөн энэхүү

тамга бүхий дугтуйд хийсэн бөгөөд дотроо асар их үнэ бүхий зүйл агуулсан эл жижиг модон хайрцгийг мистер Буш нар гагцхүү мистер Люкерийн гарт өгөх ёстой юм” гэжээ.

Энэ зурвас хамгийн наад зах нь, нэг зүйлийн талаар аливаа эргэлзээг тас цохисныг өгүүлбэл: Энэ далайчин өчигөр банкнаас гарч явахдаа Саран чулууг биедээ авч явсан байна.

Миний хормойноос Гусбери дахин угзарч, хайрцгийг заан их л урамтайгаар,

- Дээрэмдсэн байна! гэж шивнэв.

- Чамайг доор хүлээж бай гэсэн шүү, одоохон эндээс хлд гэж би зандрав.

Гусбери орон дээр хэвтээ хүнийг зааж, улам ч бахтайгаар,

- Алуулсан байна шүү дээ! Гэлээ.

Ийм аймшигтай юм хараад ид бах болгон хөөрч буй нь нэг л ой гутам зэвүүн санагдсан тул би хоёр мөрнөөс нь шүүрэн авч өрөөнөөс түлхэн гаргалаа.

Босго алхтал Кафф намайг сураглах сонсдов. Өрөөнд буцаад ороход Кафф орны дэргэд цуг очъё хэмээн тулгав.

- мистер Блэйк! Энэ хүний царайг ха даа. Будсан юм байна. Нотолгоо нь энэ байа! Гээд тэр үхсэн хүний арьс, үс, хоёрын хооронд ялимгүй зурайх цагаан судлыг хуруугаараа дагууд нь зааж,

- Доор нь юу байгааг үзье гэснээ хар үснээс нь гэгэнт зуурч авав.

Надад түүнийг харах зүрх хүрсэнгүй тул дахин холдов.

өрөөний нөгөө талд нэг сандал дээр гарч зогсоод түрүүч Каффын юу хийж буйг олж харах хэмээн томчуулын мөрөн дээгүүр амьсгаа даран ихэд шохоорхон өлийж байх эцдэггүй Гусбери хамгийн түрүүнд нүднээ тусав. Намайг юу ч харж чадахгүй ганц хүн гэж өрөвдсөн мэт,

- Хиймэл үсийг нь хуу татаж байна гэж шивнэв.

Хэсэг чимээгүй байтал ор тойрон зогссон хүмүүс гайхалдан дуу алдахад Гусбери,

- Сахлыг нь хуу татлаа! Хэмээн хашгирав.

Дахин чимээ тасарч, түрүүч Кафф нэг юм хэлэхэд буудлын эзэн угаагуур рүү очиж, түмпэнтэй ус, алчуур авчрав.

Гусбери хөөрцөглөн сандал дээрээ дэвхцэж,

- Эрхэм ээ, та наашаа энд хүрээд ирээч, одоо нүүрий нь угах гэж байна! гэв.

Тэгтэл эрүүлч Кафф хүмүүсийн дундуур гэнэт зүсэн гарч, миний хажууд хачин их айж цочсон царайтай хүрч ирээд,

- ор руу оч, эрхэм ээ! Гэснээ намайг ойртон нэг ажигласнаа -Үгүй ээ, эхлээд та, өглөө миний өгсөн захидлыг задал гэхэд нь би ч задаллаа.

- Мистер Блэйк наана чинь миний бичсэн хүний нэрийг унш даа.

Бичсэн нэрийг нь уншвал Годфри Эблвайт гэж байв.

- За, одоо та орон дээр байгаа хүнийг очиж хар даа.

Би Каффтай цуг очоод, орон дээр байгаа хүнийг хартал Годфри Эблвайт дүрээрээ байв!

## I

Доркинг, Серрей 1849 оны додугаар сарын 30. Эрхэм хүндэт ноён Фрэнклин Блэйкт. Миний бие танд өгөх ёстой байсан мэдээллийг оройтуулсандаа уучлалт гуйж байна. Уг нь гүйцээж бүрдүлчихье гэтэл энд тэндгүй саад тотгор тохиолдож, тэр бүхнийг даван туулахад нэлээд цаг хугацаа, тэвчээр хэрэгтэй болсон юм.

Тавьсан зорилгоо одоо би нэгэнт биелүүлсэн гэж найдаж байна. Талийгаач мистер Годфри Эблвайтын талаар та надтай хамгийн сүүлд уулзахдаа асууя гэж бодсон зүйлсийн бүгдэд биш гэхнээ ихэнхэд нь эдгээр хуудас хару өгч чадах буй заа.

Нэгэнт илэрсэн баримт сэлтийг үндэслэн үзвэл (миний бодлоор бол таны үеэл хэрхэн алагдсан талаар зохих дүгнэлт хийж болох юм гэдгийг энд юуны өмнө өгүүе гэж бодож байна.

Ингэсний дар атаны хамт талийгаач Вериндер ахайн хөдөөгийн байшинд айлчлан очихынхоо өмнөхөн мөн тэднийд байсан үедээ болон хожим нь мистер Годфри Эблвайт ямаршуу байсан тухай олж мэдсэн зүйлээ танд бүрэн мэдээллэх болно.

## II

Ингээд юуны өмнө таны үеэл хэрхэн алагдсан тухай дурдъя.

Түүнийг унтаж байхад, эсвэл яг сэрэх үед дэрээр бүтээж алсан алуурчид бол нөгөө гурван энэтхэг байсан, тийнхүү гэмт хэрэг үйлдсэн нь Саран чулуу хэмээгч очир алмазыг авах зорилготой байсанд эргэлзэх үндэс үгүй болх нь нотлогдсон мэт надад санагдана.

Эл дүгнэлтийг хийхэд үндэслэсэн баримт сэлтийн заримыг зочид буудлын өрөөг нягтлан үзэж, заримыг нь урьдчилан явуулсан мөрдөн байцаалтаас олсон юм.

Өрөөний үүдийг эвдэж ороход нас барсан эрхмийн нүүрэн дээр жинтүү тавиастай байв. Түүнийг нягтлан үзсэн эмч, тэр хүний амьсгаа боогдож үхжээ, өөрөөр хэлбэл, хэлмэгдэгчийн ам хамрыг нэг буюу хэдэн хүн дэрэр битүүлэн дарж, амьсгалын замыг боогдуулсан нь үхлийн шалтгаан байна гэжээ.

Одоо гэмт хэрэг үүссэн шалтгааны тухай өгүүлье.

Тэр өрөөний ширээн дээр таг нь нээлттэй жижиг хоосон хайрцаг байсан бөгөөд урж хаясан тамгатай цаасны хагас нь хэвээр үлдсэн байв. Мистер Люкер, тэр хайрцаг, тамга, бичгийг мөн байна гээд хайрцганд Саран чулуу гэгч алмаз үнэхээр байсан хэмээн хүлээснээр үл барам тэр хайрцагтай юмыг тийнхүү битүүмжилсэн хэвээр нь өнгөрсөн зургадугаар сарын хорин нэгний орой зүсс хувигасан мистер Эблвайтад өгсөн гэдгээ мэдэгдэв. Үүнээс үзэхэд, Саран чулууг хулгайлах гэсэн нь уг гэмт хэргийн шалтган лавтай мөн байжээ.

Одоо гэмт хэргийг чухам яаж үйлдсэнийг харъя.

Уг өрөөг (өндөр нь зөвхөн долоон тохой) шалган үзэхэд байшингийн дээвэр дээр гарах таазны нээлхий нь онгорхой байв. Зориулалт бүхий (орон доор байдаг байсан) богино шатыг тэнд түшүүлэн тавьжээ. Энэ нь тэр өрөөнд орсон нэг буюу хэд хэдэн хүн хялбархан буцаж гарах гэсэн хэрэг байж.

Уг нээлхийний дотор талын түгжээний хавьд хачин их хурц иртэй багажаар дөрвөлжин нүх гаргасан байв. Ингэснээр орох хүн оньсыг нь гаднаас мултлаад халга онгойлгож, долоон тохой өндөртэй өрөөнд (эсвэл хам хүнээрээ дэмнүүлэн чимээ гаргалгүй) орж чадахаар ажээ. Тэнд нэгэнт нүх гаргасныг үзвээс нэг буюу хэдэн хүн тийм л аргаар орж ирсэн нь тодорхой болж байн. Буудлын газрын байшингийн орой дээр тэр хүн (буюу тэд) ямар аргаар гарсан тухайд гэвэл, хажуугийн намхан байшин нь засвартай, эзгүй байсан бөгөөд ажилчид дээвэр дээр нь гарахдаа хэрэглэдэг урт шатыг түшүүлэн орхисон байсныг, түүнчлэн хорин долооны өглөө нөгөө ажилчид иртэл бусдад ашиглуулахгүй хэмээн шатандаа барьж боосон хөндөл мод нь газар хэвтэж байсныг анхаарвал зохино. Тэр шатаар дээш гарч байшингийн орой дээгүүр явж, буцаж буухдаа хүнд харагдахгүй боломж бас байсан гэдэг нь Эргийн Ирмэгийн хавийг цагт хоёр удаа эргэдэг шөнийн эргүүлийн цагдаагийн өгсөн мэдүүлгээс харагдав. Мөн оршин суугчдын мэдүүлгээс үзэхэд ч Эргийн Ирмэг бол хөл хөдөлгөөн багатай, бөглүү гудамжны нэг ажээ. Ингэхлээр ердийн болгоомжтой, ухаалаг хүн буюу хүмүүс тэр шатаар дээш гарч, эргээд буухдаа хүнд үзэгдэхгүй амжих боломжтой юм гэдгийг эндээс бас дүгнэж болох байна. Нэгэнт орой дээр нь гарсан бол дээврийн нүхээр орж гарахад гаднаас хүнд харагдахгүй байж болохыг туршлагаар нотлов.

Эцэст нь уг гэмт хэргийг үйлдсэн хүн буюу хүмүүсийн тухай өгүүлье.

1. энэтхэгүүд тэр алмазыг эзэмших сонирхолтой байсан.
2. Механикчийн дүрээр хувцасласан хүнтэй хөлсний тэрэгний цонхоор ярьж байхыг Октавиус Гай харсан нөгөө энэтхэг шиг зүстэй хүн бол хуйвлдагч гурван энэтхэгийн нэг байсан байж тун болзошгүй
3. Тэрхүү механикч мэт хувцасласан этгээд хорин зургааны оройн турш мистер Годфри Эблвайтыг харуулдан байсан ба түүнийг орохоос өмнө унтах өрөөнд нь орчихоод байсныг бодохул тэр өрөөг шинжлэн нягталж байсан нь магадтай байна,
4. Унтлагын өрөөнөөс олдсон алтан сааны тасархайг зохих мэргэжлийн хүмүүс шинжлээд түүнийг Англид үйлдвэрлэдэггүй, харин энэтхэг газрын зүйл байна гэлээ
5. Хорин долооны өглөө дээр дурдсан гурван энэтхэгтэй төсөө үбхий гурван хүн Доод ТЕМзийн гудамжинд харагдсан ба тэндээсээ Тоуэрийн Зогсоолд очиж, улмаар Роттердам орох нэгэн хөлөгт суугаад Лондонгоос гарч одсон байна.

Ийнхүү хүний амины хэргийг энэтхэгүүд үйлджээ гэдгийг хууль эрхийн бодитой баримтууд нотолж байна.

Механикч мэт хувцасласан зүсээ хувилгасан хүн эл гэмт хэрэгт хамсан орсон эсэхийг нотлон хэлэх аргагүй. Тэр этгээдганцаара хүн алсан гэх ямар ч боломж алга байна. Өөрөөсөө том, хүч тэнхээтэй Годфри Эблвайтыг ямар ч тэмцэлгүйгээр, дуу чимээ гаргалгүй амыг нь барин хороож ганцаараа хараахан дийлэхгүй буй заа. Зэргэлдээх өрөөнд нь унтаж байсан зарц бүсгүйд мөн доод өрөөнд нь унтаж байсан эзэнд юу ч дуулдаагүй гэнэ. Энэ гэмт хэргийг үйлдэхэд нэгээс илүү хон оролцсоны бүх баримт сэлт харуулж байга бөгөөд дахин давтан хэлэхэд, түүнийг энэтхэгүүд үйлдсэн гэдэг дүгнэлтийг нотлов.

Урьдчилан явуулсан мөрдөн байцаалтаар энэ бол үл мэдэгдэх нэг буюу хэсэг хүмүүсээс хүний амийг сантайгаар бүрэлгэсэнгэмт хэрэг болохыг тогтоосон гэдгийг л нэмж хэлэх ёстой. Мистер Годфри Эблвайтын гэр, бүлийнхэн зохих хөлсийг амласн ба гэмтэн этгээдүүдийг олоын тулд бүхий л арга хэргэлэжээ. Механикч шиг хувцасласан хүн ор мөргүй алга болжээ. Энэтхэгүүдийг мөшгин

мөрдсөн боловч тэднийг баривчлах найдлага ямаршуу байгаа тухай нэ мэдэгдлийнхээ эцэст хэдэн үг бичих болно.

Одоо миний бие, мистер гобфри Эблвайтын амь алдсан туахй холбогдол бүхий зүйлсийг бүгдийг биччихээд талийгаач Вериндер ахайнд мистер Годфри Эблавайт та хоёр уулзахас өмнө, уулзсан үед, бас хожим нь мистер Годфри Эблвайт хэрхэж байсан тухай шууд залган өгүүлсүгэй.

### III

Мистер Годфри Эблвайтын амьдрал, миний барьж авсан энэ сэдэвт хоёр талтай байсан гэдгийг эхлээд хэлчихье.

Олон нийтэд харагддаг тал нь түүний баг халхавч юм. Тэтгэмжийн хурал цуглаан дээр урн илтгэчихдэг, эмэгтэйчүүд голлосон тэтгэмжийн байгууллагуудад ориох байгуулах авьяасаа харуулчихдаг эрхэм байжээ. Олны хараанаас нууж явдаг тал нь гэвэл, жаргал цэнгэл хөөцөлддөг огт өөр чанартай эрхэм байжээ. Хотын дүүрэгт хүний нэрээр авсан орд харштай, түүндээ өөрийн нэр үл холбогдсон хатагтай байлгадаг юмсанж.

Харшийг нь нэгжиж үзэхэд хэд хэдэн сайхан зураг хөрөг, баримал, уран гоё хийцтэй тавилга хэрэгслийг зохимжийг нь тааруулан сонгож авсан байна. Лондонгоос эрээд ч олодохгүй ховор нандин цэцгийн хүлэмжтэй. Хатагтайн хөрөнгийг шалган үзвэл, нандин цэцэг шигээ хосгүй ховор эрдэнэсийн зүйл эдлэх бөгөөд унадаг, эдэлдэг морь тэргийг нь харвал Гойд-Паркт магтаал сайшаалыг олсон, морь андаггүй хүмүүс гайхан шагшихаар сайн үүдрийн, сайхан адгуус байх ажээ.

Энэ бүхнийг ч бас ердийн зүйлгэж болох юм. Харш, хатагтай хоёр нь ч гэсэн Лондонд нийтлэг үзэгдэл атал энд тэр тухай дурдсандаа би уучлал гуйя. Ердийн бус бөгөөд миний хувд ог сонсоогүй зүйл гэвэл тэр бүх сайхан юмыг захиалж авснаар барахгүй үеийг нь төлчихсөн байлаа. Зурагхөрөг, баримал, цэцэг, эрдэнэс, морьд, сүүх тэргүүдийн үнийг сохор зоос дутаалгүй төлсөн байсныг мэдээд би мэл гайхсанаа дүрслэхийн паргагүй. Харшийн туахйд гэвэл, бэлэн үнээр доор нь аваад хатагтайнхаа нэр дээр болгожээ.

Хэрэв мистер Годфри Эблвайт алагдсанаас үүдэн түүний бүхий л хэргийг сурвалжлан шалгах хэрэгцээ гараагүй бол миний бие энэ оньсогын тааврыг олох гэж мөн ч их цаг дэмий үрэх байсан биз ээ.

Мөрдөн байцаалтаас доор дурдсан зүйлс илрэв. үүнд:

Нэг мянга найман зуун дөчин найман онд насанд хүрээгүй байсан нэгэн залуу эрхмийн хожим авах оёр түмэн фунтыг нь итгэмжлэн хадгалуулсан хоёр хүний нэг нь мистер Годфри Эблвайт байжээ. Мянга найман зуун тавин оны хоёрдугаар сард тэр залуу эрхэм насанд хүрч итгэмжлэлийн хугацаа ч дуусаж, хоёр түмэн фунтээ авах учиртай байж. Уг хугацааг дуусахаас өмнө итгэмжлэх хоёр хүн ньхагас жилд нэг удаа, зул сар ба зуны дунд сард тухай үбрд зургаан зуун фунтыг төлөх үүрэгтэй байсан бөгөөд гол итгэмжлэгч мистер Годфри Эблвайт тэрхүү орлогыг тогтмол төлсөөр иржээ. Гэтэл мянга найман зуун дөчин долоон оны сүүлч гэхэд хоёр түмэн фунтыг (өнөөх орлогыг түүнэс гаргаж байсан гэх болой) янз бүрийн үед цвруулан авсаар ганц ч зоос үлдээлгүй бүгдийг банкнаас аваад дууссан байжээ. Уг үнэт цаасыг банкнаас олгох тухай итгэмжлэгчийн бүрэн эрхийн мэдэгдэл, хэчнээнийг олгох тухай бичиг сэлтэнд итгэмжлэгч хоёр этгээд гарынхаа үсгийг тухай бүр зурсан байв. Гагцхү хоёр дахь итгэмжлэгчийн (цэргийн даргын албанаасаа тэтгэвэлт гарч хөдөө суусан) гарын үсгийг тэргүүн итгэмжлэгчнь буюу өөрөөр хэлбэл мистер Годфри Эблвайт тухай бүр төлөөлөн хуурамчаар үйлддэг байжээ.

Ийм учраас л мистер Годфри нөгөө хатагтай, харшийнхаа үнэ өртгийг бэлэн төлж, бас өчнөөн төчнөөн зүйлийг (энэ тухай дурдах болно) гуйцэлдүүлж чаддаг байжээ.

Одоо мисс Вериндерийн төрсөн өдрийн тухай, мянга найман зуун дөчин найман оны зургадугаар сарын хорин нэгний тухай эргэн дурсья.

Урьд өдөр нь мистер Годфри Эблвайт эцгийндээ очиж гурван зуун фунт зээлдүүлээч гэжээ (эцэг нь надад өөрөө тэгж хэлсэн юм шүү. Зээлэх гэсэн мөнгөнийх нь хэмжээг анхаарахтун, бас нөгөө залуу эрхэмд хагас жилд олгодог мөнгөнийх нь эхний хугацаа мөн сарын хорин дөрвөнд байсныг санагтун. Бас залуу эрхмийн бүх мөнгийн итгэмжлэгч нь дөчин долоон оны эцэс гэхэд үрээд дууссан байсныг ч анхаарах хэрэгтэй юм.

Мистер Годфрийн эцэг, хүүдээ сохор зоос зээлүүлэхгүй гэжээ.

Маргааш нь мистер Годфри, мисс Вериндэртэй сууя гэжээ. Хэрэв хүүхэн зөвшөөрөөд суучих юм бол мөнгөнийх нь одоогийн болон ирээдүйн шаардлагад сэтгэл зовохгүй боломж буй болно гэж бодож л дээ. Гэтэл уг хэрэг хэрхэн эргэлээ? Мисс Вериндер түүнтэй суухаас татгалзсан шүү дээ.

Үүний улмаас авхайн төрсөн өдрийн орой мистер Годфри Эблвайт онцгой хүнд байдалд оржээ. Хорин дөрөвний өдөр гурван зуун фунт, мянга найман зуун тавин оны хоёрдугаар сард хоёр

түмэн фунт олсон байх ёстой байв. Тэгээд алины нь ч олж чадаагүй балардагийн даваан дээр байжээ.

Иймэрхүү байдалтай байтал юу болсон бэ? Канди докторыг та мэргэжлийнх нь эмзэг асуудлаар доромжилсон ба үүний хариуд хар тамхины ханд өгч таныг сайхан дөнгөсөн байна. Жижиг шилэнд найруулан бэлтгэсэн тунг мистер Годфри Эблвайтаар танд өгүүлэх болжээ. Уг ажилд оролцосон гэдгээ мистер Годфри одоо би танд танилцуулахаар завдан буй тэр нөхцөл байдалд хүлээсэн юм. Тэр хүн үдэш таны хэлсэн хатуу үгэнд дайруулсандаа шарлахаж, бүр ч их дуртай оролцжээ. Таныг унтахаасаа өмнө жаахан шарз устай уучих хэмээн Бэттережийн хамт ятгасан төдийгүй найруулсан хүйтэн архинд хар тамхины ханд сэм хольж, танд уулгасан байна.

Одоо Ламбет дахь мистер Люкерийн тухай өгүүлэхийг зөвшөөрнө үү.

Мистер Брафф бид хоёр энэ мөнгө хүүлэгчийг үнэнээ нэгд нэггүй тоочихоос өөр замгүй болтол мухардуулсан арга олсноо оршил болгон хэлсүгэй. Түүний өгсөн мэдүүлгийг бид сайтар тунгаан үзээд танд танилцуулж байна.

#### IV

Дөчин найман оны зургадугаар сарын хорин гуравны баасан гаригийн үдэш оройхон Годфри Эблвайт тэднийхээр ирсэнд мистер Люкер баахан гайхаж, Саран чулуу хэмээх алмаз гаргаж ирэхэд нь бүр ч их гайхжээ. Тийм алмаз Люкерийн мэдэхэс Европы ганц ч хүнд байдаггүй юмсанж.

Годфри Эблвайт тэрхүү гойд сайхан эрдэнийн чулууны талаар хоёр шалихгүй санал тавьса гэнэ. Нэгд, мистер Люкерийг энэ чулууг худалдаж авах юм биш үү, хоёрт, хэрэв өөрөө ввч чадахгүй гэвэл барьцааны газар өгөөд авах мөнгөнөөсөө өгнө үү гэжээ.

Мистер Люкер алмазыг сайтар нягталж шалган жигнэж, үнэ цэнийг нь дотроо эргэцүүлэн багцаалаад согог болох толбы нь харгалзан гурван түмэн фунты үнэ хүрнэ гэж үзсэний эцэст сая л ам нээж,

- Та үүнийг яаж олж авсан бэ? гэж асуув.

Ердөө л зургаахан ү) Гэсэн ч цаанаа хэчнээн их утга санаа агуулсан байв аа

Годфри Эблвайт нэг юм ярьж эхэлсэн боловч Люкер бас дахин ам нээж,

- Юу л бол доо! Хэмээн гуравхан үг дуугарчээ.

Годфри Эблвайт бас нэг юм ярьж эхлэв. Мистер Люкер түүндхариу хэлэх гэж дахин үг гарздалгүй босож, хонх даран зарцаа дуудаад энэ эрхмийг гаргаж өг гэжээ.

Хэрэг явдал ингэж шувтрах болсонд митсер Годфри уг хэргийг өөрөөр, арай үнэмшилтэйгээр ярихад хүрснийг доор өгүүлье.

Таны устай шарзанд хар тамхины ханд хольчихоод танд сайхан нойрсохын ерөөгөөд явж өрөөндөө орсон байна. Та хоёрын өрөөнүүд угтаа дамждаг хоёр өрөө байсан юмсанж. Мистер Годфри өрөөндөө ороод дамда үүдийг хаасан гэж боджээ. Унтах гэж хэвтсэн боловч мөнгөний асуудал бодогдоод нойр нь хулжиж орхисон байна. Тэгэхээр нь босож халаат, гэрийн шаахай өмсөж суугаад өөрийнхөө байдлыг бодон цаг хэртэй болсны дараа орондоо орохоор завдтал та өрөөндөө ганцаараа дүнгэр дүнгэр ярих дууддаж гэнэ. Тэгэхээр нь нь дамждаг үүдэн дээр очвол түгжээгүй байсан гэнэ.

Юу болсныг мэдэх гэж таны өрөөг шагайвал та лаа барьчихсан, тун хачин дуугаар “Энэтхэгчүүд байшинд нуугдаж байгаа ч юм бил үү, яаж мэдэх вэ дээ?” гэж үглэн өрөөнөөсөө гарчээ.

Уг нь танд хар тамхины ханд уулгахдаа гэмгүй тоглоом наадам болгож байна л хэмээн бодож байжээ. Тэгтэл хар тамхи эмчийн бодсоноос түүний бодсоноос ч огт өөрөөр нөлөөлж байхыг үзжээ. Ямар нэг золгүй явдал болж юу магад хэмээн сэрэмжил таны хэрхэхийг ажиглан сэм дагажээ.

Таныг мисс Вериндерийн зочны өрөөнд үүдий нь онгорхой орхиод ороход араас тань орж зүрхэлгүй, хаалга, энэх хоёрын завсраар хараад байжээ. Таныг шургуулга дотроос алмаз авахыг харсан төдийгүй мисс Вериндер унтлагын өрөөнийхөө онгорхой хаалгаар таныг чимээгүйхэн ажиглаж байхыг бас харчихжээ. Тийнхүү та тэр алмазыг авч буйг мисс Вериндер харсныг ч лавтай мэджээ.

Та зочны өрөөнөө шууд гаралгүй хэсэг тээнэгэлзсэн байна. Мистер Годфри үүнийг ашиглан танаас түрүүж өрөөндөө буцжээ. Таныг очихоос өмнөхөн л оржээ. Түүний таамаглаж байгаагаар бол та Годфриг дамжих хаалгаар орж байхад нь олж харсан болотой. Ямар ч атугай, та үүнийг хачин нойрмог дуугаар дууджээ.

Ирэхэд нь та нойрмог нүдээр талимааран харснаа нөгөө алмазаа өгч,

- Годфри, чи үүнийг аваачаад эцгийнхээ банканд хадгалуулчих. Тэнд байвал дажгүй, энд байгаад дэмий гэсэн байна.

Тэгээд цааш гуйвсхийн явж, халаатаа нөмөрч, өрөөийнхөө том сэнтий дээр сууснаа,

- би өөрөө банканд аваачиж өгч чадахгүй. Толгой тугалга цутгасан юм шиг дүүрээд, хоёр хөл ч мэдээгүй болсон байна гэж хэлчихээд сандлынхаа түшлэгийг налан гүн сүүрс алдсанаа нам унтжээ.

Мистер Годфри Эблвайт алмазыг аваад өрөөндөө оржээ. Яг тэр үедээ бодож шийдсэн юмгүй өглөө юу болохыг харзая гэж л бодсон хэмээн нотолжээ.

өглөө таны үг яриа, ааш төлөв урьд шөнө ярьсан, хийснээ огт санахгүй байгааг илтгэлээ. Мөн мисс Вериндер таныг өрөвдөж хайрлаад ч ярихгүй, ямар нэг юм мэдсэн шинж чухуйлгахгүй байж. Годфри Эблвайт алмазыг авчихъя гэвэл чухам л дурын хэрэг болоод байжээ. Саран чулуу түүнийг сүйрлээс аврах олз болсон тул халаасандаа хийжээ.

## V

Таны үеэл аргагүйдсэний эрхээр мистер Люкерт ярьсан юм нь энэ.

Мистер Годфри Эблвайт тиймэрхүү зүйл зохионо гэхэд дэндүү тэнэг хүн учраас түүний ярьсанд Люкер итгэсэн гэнэ. Ярьсан зүйл нь үнэн магадтай гэж мистер Люкерийн бодож буйг мистер Брафф бид хоёр ч зөвшөөрсөн юм. Мистер Люкер Саран чулууг хэрхэх байсанд дараачийн асуудал байлаа. Тэр хүн ажил төрлийнхөө үүднээс үзсэн ч аюултай бөгөөд базаахгүй энэ хэрэгт оролцоход хүртэл гагцхүү тодорхой болзлууд тавина гэжээ.

Мистер Годфри Эблвайт Саран чулууг мистер Люкерт барьцаа болгон гвөл хёор мянган фунт зээлүүлье, хэрэв нэг жилийн дараа мистер Годфри Эблвайт, мистер Люкерт гурван мянган фунт төлөх юм бол алмазаа буцааж авах эрхтэй болно, хэрэв зээлж авса мөнгөө төлөх хугацаа өнгөрвөл барьцааны зүйл буюу өөрөөр хэлбэл Саран чулуу мистер Люкерийн өмч болон шилжих бөгөөд хэрэв үэхээр ингэхэд хүрвэл мөнгө хүүлэгчи өөрийнхөө мэдэлд буй (урьд түүнтэй хийж байсан тооцоотой холбогдсон) нэлээд хэмжээний үнэт цаасыг мистер Годфрид гар таталгүй бэлэглэе гэсэн болзлууд тавьсан байж,

Мистер Годфри ийм нүнжиггүй болзлыг хүлээж аваагүйг хэлэх юун. Тэгэхлээр нь мистер Люкер алмазыг нь өгөөд гаргасан хэрэг.

Таны үеэл үүдэндочсоноо буцжээ. Тэр оройн яриа нь зөвхөн тэр хоёрын дунд үлдэнэ гэдэг баталгаа байна уу?

Мистер Люкер яаж ч чадахгүй билээ. Мистер Годфри тавьсан болзлыг нь хүлээж авсан бол өөрийнхөө хамсаатан болгож, бусдад ам алдахгүй гэдэгт нь лавтай итгэж болох байжээ. Хэрэг явдал ингэж эргэмэгц мистер Люкер амиа л бодох хэрэгтэй болжээ. Эвгүй муухай юманд асуугдахад хүрвэл надтай ажиллахаас дургүйлхсэн хүний төлөө амаа хамхиж, нэрээ гутаах юм гэж үү?

Мистер Годфри тийм хариу сонсоод урхинд орсон амьтан шиг сандарчээ. Бүр арчагаа алдаж, дэмий ийш тийш гөлрөн харвал мөнгө хүүлэгчийн задгай зуухны тавцан дээр байсан хайрцаг доторх жижиг цэвэр хуудсан дээр бичээстэй зургадугаар сарын хорин гурван гэсэн тоо нүдэнд нь өртөв. Хорин дөрөвний өдөр нөгөө залуу эрхэмд итгэмжлэгчийнх нь хувьд гурван зуун фунт төлөх ёстой байтал мистер Люкерийн тавьсан болзлыг хүлээж авахаас өөр мөнгө олох ямар ч арга байсангүй. Тийм балай гаслантай саад байгаагүйсэн бол алмазаа Амстердамд авч очоод хэдэн хэсэ хуваалган борлуулж болох л байж, гэвч хэрэг явдл нэгэнт иймд хүрсэн хойно мистер Люкерийн болзлыг хүлээж авахаас горьгүй болсноо мэджээ. Ямар ч атугай нэг жил г гэдэг овоо урт хугацаа, энэ хооронд гурван мянган фунт олчихож юу магад гэж бодсон байна.

Мистер Люкер тэр даруй бичиг баримт үйлдэж, хоёул гарын үсэг зурсан хойно мистер Годфри Эблвайтад хоёр чек өгсний нэг нь зургадугаар сарын хорин гурванд гурван зуун фунт олгох, нөгөөдөх нь долоо хоногийн дараа үндсэн мөнгийг буюу нэг мянга долоон зуун фунт олгох чек байв. Саран чулууг мистер Люкерийн банкинд яаж хадгалуулсан, өнөөх энэтхэгүүд мистер Люкер, мистер Годфри хоёрыг (банкинд авч өгөлцсөн хойно) хэрхсэнийг та нэгэнт мэдэх билээ.

Таны үеэлийн амьдралд тохиолдсон дараачийн явдал бас л мисс Вериндерт хамаарна. Сууя гэж хоёр дахь удаа гуйхад нь зөвшөөрсөн боловч төдхөн мисс Вериндерийн шаардсаны дагуу гэрлэнэ гэж тохиролцсоноо цуцалжээ. Тийнхүү зөвшөөрсөн нэг гол шалтгааныг мистер Брафф зөв таасан байна. Мисс Вериндер эхийнхээ хөрөнгийг бүх насаараа эзэмших л эрхтэй байсан болохоор түүнээс нь хоёр түмэн фунт олох бололцоогүй байж л дээ.

Гэвч гэрлэвэл барьцаанд өгсөн алмазаа буцааж авах гурван мянган фунт олж болох л байсан гэж та хэлнэ биз. Суугаад бүтэн жил ч болоогүй байж хөрөнгийнх нь орлогын тэн хагасаас илүүг үл мэдэгдэх зорилгоор урьдчилан зарахыг эхнэр нь, асрамжилсан болон итгэмжилсэн хүмүүс нь зөвшөөрч гэм л тэгж болох байсан юм. Ийм аргаар нэг бэрхшээлээс мултарлаа ч гэсэн цаана нь бас яггүй бэрхшээл үлджээ. Хотын захын харшид суудаг хатагтай нь тийнхүү ичгүүргүйгээр гэрлэх гэж буйг нь сонсчихжээ. Мистер Блэйк минь тэр бол нимгэн царайтай, ром маягийн хамартай, сэхүүн зантай, хэр баргийн юмыг зүгээр өнөгрөөхгүй сүрхий хүүхэн байж. Мистер Годфри Эблвайтыг ихэд

жигшин зэвүүцсэн байлаа. Олигтойхон тэжээгээд байвал амаа жимийгээд л явна. Чингэхгүй бол зэвүүцлээ ам хэлээрээ илэрхийлж нэмэрлэж таарах байлаа. Мисс Вериндерийн хөрөнгөнөөс тэр авгайг олигтойхон тэжээж ч чадахгүй, хоёр түмэн фунт гаргаж авах ч боломж огт үгүй ажээ. Иймд мисс Вериндертэй сууж чадахгүй, үнэхээр чадахгүй байв.

Өөр нэг хүүхэнтэй суух гэж үзээд бас л мөнгөний мөр дээрээс бүтэлгүйтсэнийг та мэднэ. Бас тэр царайлайг сайхан эрд сэтгэл татагдан биширдэг байсан олон хүүхнүүдийн нэг түүнд таван мянган фунт өв болгон үлдээж байсныг ч та мэднэ. Тэр өв болгосон мөнгөнөөс болж таны үеэл амиа алдсан билээ (үүнийг хэрэг явдал нэгэнт баталсан юм).

Таван мянган фунтээ авахаар гадаадад явахдаа Амстердамд очсон байна. Тэнд очоод нөгөө алмазаа жижиглүүлж авах бүхий л бэлтгэлээ хийжээ. Буцаж ирээд (гадаад байдлаа өөрчилсэн байж) товлосон өдрөө өнөөх Саран чулууг эгүүлэн авчээ. Зохих мөнгөний нь төлж эрдэнийн чулууг банкнас очиж авахаа (болгоомжлохын үүднээс хоёул тохиролцон) хэд хоног хойшлуулсан байж. Амстердамд эсэн мэнд очсон цагт дөчин есөн оны долдугаар сараас тавин оны хоёрдугаар сарын хооронд (тэгэхэд нөгөө залуу эрхэм нь эрийн цээнд хүрэх байв) алмазаа жижиглүүлж хэдэн хэсэг хуваалгаад ( өнгөлсөн ч, өнгөлөөгүй ч) зарахад бэлэн болгож амжих байв.

Ямар шалтгаанаас үүдэн тийнхүү амь сорих болсныг бодоод үз л дээ. Үхэх, сэхэхийнхээ нэгийг үздэг хэрэг эж бодсон нь тодорхой байна.

Өнөөх энэтхэгүүдийг баривчлах, Саран чулууг олж авах горьдлого тасраагүй байгаа гэдгийг энэ мэдээллээ дуусгахын өмнө танд сануулъя. Тэд одоо Дорнод Энэтхэгийн кампанийн хөлөг онгоцоор Бомбей орох замдаа явж буй гэсэн тун үнэмшилтэй мэдээ байна. Тэр хөлөг гэнэтийн явдал эс тохиолдвол зуур замдаа өөр газраар оролгүй шууд Бомбейд очих учраас тэндхийн эрх баригчдад захидлаар нэгэнт мэдэгдсэн болохоор хөлгийг зогсоолд орж ирэхэд нь галт онгоцоор тосож очих болно.

Эрхэм хүндэт танд ёсолсон, таны дуулгавартай зарц, Ричард Кафф (Лондон, Цагдаагийн мөрдөн бйцаах газрын түрүүч агсан)

2 Энэхүү мэдээлэл мисс Вериндерийн төрсөн өдөр болон дараагийн гурван өдөр болсон хэрэг явдалтай таарч буй эсэхийг Бэттережийн хүүрнэлийн 8-13 дугаар бүлэгтэй харьцуулан үзнэ. Үү (зох.)

## КАНДИ ЭМЧИЙН БИЧСЭН ЗАХИДЛААС

Фризинхолл, Лхагва гариг, 1849 оны есдүгээр сарын 26. Эрхэм хүндэт Фрэнклин Блэйк, таны Эзра Женнингст бичсэн захидлыг задлалгүй энэ дугтуйнд хийж буцаасныг та үзээд одоо миний хэлэх гэж буй гашуудалтай мэдээг гадарлах буй заа. Түрүүчийн лхагва гаригийн өглөө яг нарнаар миний гар дээр нас барсан юм.

Амьд явах хоногийн тоо нь тун цөөрөөд байхад танд мэдэгдээгүй маань миний буруу биш юм шүү. Танд захидал бичье гэтэл эрс дургүйцэж, “Би энэ насандаа мистер Фрэнклин Блэйкийн ачаар хэдхэн өдөр ч гэсэн жаргал үзсэн юм. Сэтгэлий нь зовоох хэрэггүй, мистер Канди минь, сэтгэлий нь бүү зовоо” гээд хориод байлаа.

Амьдралынхаа сүүлчийн зургаан цагийн өмнө түүний зовж тарчилж байхыг харахаас нүд халтирч байлаа. Өвчин нь жаал намдаж, ухаан орсон үеднь садан төрөл ямар ямар улс байдаг юм, захидал бичиж явуулъя гэж намайг шалгаахад юугаа хийх вэ? зөрүүд занг минь өршөөгөөрэй гэснээ огт гашуудаж харамссан шинжгүйгээр,

- Амьд байхдаа бүгдэд мартагдаж хаягдсан байсан шигээ үхэхдээ бас тэгье гэж хэлсэн. Бүр яг таг шийдсэн байсан л даа. Одоо ер нь түүний тухай мэдэх гээд ч нэмэргүй, намтар түүх нь тайлагдахгүй оньсого шиг үлдлээ.

Нас барахынхаа урьд өдөр өөрийнхөө бичиг баримт хаа байгааг надад хэлж тэдгээрийг нь авчирч өгсөнд жижигхэн боодолтой хуучин захидлуудыг хажуу тийш нь авч тавив. Бичиж дуусаагүй ном нь ч байлаа. Өдрийн тэмдэглэл нь олон дэвтэр болжээ. Энэ жил хөтөлсөн дэвтрийг нээж, тантай хамт байсан үед холбогдолтой хуудсуудыг ганц ганцаар нь тасдан аваад,

- Эдгээрийг мистер Фрэнклин Блэйкт өгөөрэй. Хожим хэдэн жилийн хойно энд бичигдсэн зүйлийг сонирхох цаг ирж магадгүй юм гэв. Тэгээд алга хавсран таныг, таны дотно хайрт хүмүүсийг бурхан тэнгэр өршөөн тэтгэж яваг хэмээн залбирав. Тантай уулзах юмсан гэж хэлснээ төдхөн болив. Би захидал бичье гэсэд,

- Хэрэггүй, сэтгэлий нь зовоож хэрэггүй! Сэтгэлий нь бүү зовоож үз! Гэв.

Тэгээд намайг тэр бүх бичиг цаасыг буюу өөрөөр хэлбэл боодолтой захидал бичиг, дуусагүй ном, олон дэвтэрт бичсэн өдрийн тэмдэглэл сэлтээ бүгдийг нэг доор баглаад лацдаж орхиоч гэж гуйхад нь би бүгдийг ёсоор гүйцэтгэн өөрийнхөө тамгаар лацдав.

- Энэ бүгдийг та миний авсанд өөрийн гараар хийж, хожим хойно хэний ч гар хүрэхээргүй болгоно гэж надад амла гэхэд нь би амлаж амандаа ч хүрсэн билээ.

Бас биелүүлэхэд тун хэцүү өөр нэг зүйл хүссэн юм.

- Миний булшийг мэдэгдэхгүй болгоорой. Оршуулсан газар тэмдэг болгох гэж хөшөө дурсгалын зүйл, жирийн чулууг ч бүү тавиарай. Та ингэнэ гэж чин үнэнээсээ андгайлаач. Би нэр усгүй нойрсъё, хэнд ч мэдэгдэхгүй амаръя гэж хэлэхэд нь би шийдий нь өөрчлүүлэх санаатай ятгасан боловч сэтгэл нь хачин их хямарч зовохыг нь би анхны бөгөөд сүүлчийн удаа хараад бүр сандран бууж өгсөн билээ. Одоо түүний мөнх нойрсон буй газар өвс ургасан багахан товгороос өөр юу ч байхгүй. Цаг улиран өнгөрөхөд хажуугаар нь булш бунхан бичээд ирнэ. Биднээс хойших хүмүүс нэр усгүй булш байгааг үзээд гайхах буй заа.

Нас барахаасаа зургаан цагийн өмнө тарчлах өвчингүй болсон гэж би дээр дурдсан. Жэахан зүүрмэглэхдээ зүүдэлж байх шиг байлаа. Нэг хоёр удаа инээмсэглэж зүүдэлж байх шиг байлаа. Нэг хоёр удаа инээмсэглэж “Элла” гэж байн байн хэлээд байсан. Бүсгүй хүни йнэр юм уу гэж би бодсон. Амьсгаа хураахасаа өмнөхөн толгой өндийлгөөд өгөөч, нар мандахыг цонхоор харъя гэж гуйлаа. Тамир тэнхээ нь бүр барагдаж, толгой нь миний мөрөн дээр өөрийн эрхгүй унаж байв. “Одоо л айсуй!” гэснээ “Намайг үнс!” гэв. Би духы нь үнслээ. Тэгтэл толгойгоо гэнэт өргөхөд нарны туяа магнай дээр нь тусав. Царай нь хонгор сайхан дүртэй болж гурван удаа “Амаръя” гэж хашгирав. Толгой нь миний мөрөн дээр унаж, амьдралынх нь ужиг удаан зовлон ч эцэс боллоо.

Ийнхүү Женнингс маань биднээс хагацан одов. Миний бодоход дэлхий дахин түүнийг огт мэддэггүй боловч агуу их хүн байсан юм. Хэцүү бэрх амьдралыг зориг хатуужилтай туулжээ. Түүн шиг өр нимгэн хүнтэй би ер учирч яваагүй. Ийм хүнээ алдлаа гэж бодохоос л элэг эмтэрч, өнчрөн ганцаардсан санагдана. Би өвдсөнөөсөө хойш өөрчлөгдсөн ч байж магадгүй. Заримдаа энэ жлаа хаяад зайлмаар, бас гадаадад явж халуун хүйтэн усны эмчилгээ хийлгэдэг ч юм бил үү гэж бодох боллоо.

Мисс Вериндер та хоёрыг дараагийн сард гэрлэх юм гэж энд ярилцаж байна. Танд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хөөрхий андын маань танд өгөөрэй гэсэн хуудсууд миний гарт боолт, лацтай, дээр нь таны нэрийг тавьсан, таныг хүлээсээр байгаа шүү. Шуудангаар явуулъя гэснээ гээгдчих вий гэж айгаад байх юм.

Мисс Вериндерийн амар мэндийг эрж, гүнээ хүндэтгэн сайн сайхан бүхний дээдийг хүсэн ерөөж буйг минь уламжилна уу.

Эрхэм хүндэт Фрэнклин Блэйк таныг хүндэтгэн ёсолсон, тандүнэнч Томас Канди чинь.

## ГАБРИЭЛ БЭТТЕРЕЖ БИЧСЭН НЬ

Би бол (та андахгүй санаж байгаа) эдгээр хуудсыг эхлэн бичих замд оруулж, эл түүхийг нээсэн хүн билээ. Бас эл түүхийг гүйцээн дуусгаж хэлэхээр үлдсэн хүн юм.

Харин энэтхэг алмазын тухайд сүүлчийн үгий нь хэлэх хүн юм байна гэж бүү бодоорой. Би тэр гайтай чулууг жигшдэг учраас түүний тухай мэдэхсэн гэж байгаа бол надаас өөр хүнээс л сурагласан нь дээр байх шүү. Харин би одоо хүн болгон тойрч орхиод байсан, миний бие тийм маягаар үл тоомсорлон өнгөрөөж тэвчихгүй нэгэн явдлыг өгүүлэхээр зорьсон юм. Энд дурдахаар завдан буй үнэн бодитой явдал бол мисс Рэчел, мистер Фрэнклин Блэйк хоёрын хурим юм. Тэр сонин явдал мянга найман зуун дөчин есөн оны аравдугаар сарын есний мягмар гаригт, Иоркшир дахь манай байшинд болсон юм. Энэ ёслолыг тохиолдуулан миний бие шинэ гоёлын хувцастай болсон юмдаг. Гэрлэсэн хоёр маань бал сараа Шотландад өнгөрөөхөөр явсан юм.

Хөөрхий эзэгтэй маань таалал төгссөнөөс хойш гэр бүлийн чанартай иймэрхүү найр хурим тун ховордсон болохоор миний бие тэр хуримын үеэр (өдөр нэрэнт хэлбийсэн хойно) үнэнийг хэлэхэд, баахан хэтрүүлэн балгасан билээ.

Өөрөө бас тиймэрхүү юм хийж явсан хүн бол намайг ойлгож, өрөвдөнө байх. чингэж байгаагүй хүн бол “Ямар балай өвгөн бэ! Үүнийгээ яах гэж бидэнд бурна вэ? гэх биз ээ. Чухам яагаад өгүүлэх болсноо одоо хэлсүгэй.

Тэгж уучихаад (Тэнгэр минь, та ч гэсэн бас нэг дурладаг юмтай байгаа шүү дээ. Гагцхүү та бидний дурладаг юм адилгүй байгаа л даа) хэзээний шүтдэг эмээ хэрэглэв, “Робинзон Крузо” хэмээгч эм гэдгийг та ч андахгүй. Тэрхүү хосгүй номынхоо чухам аль хэсгийг нээснээ хэлж мэдэхгүй байна. Харин өрсөн мөрүүдийн сүүлчийнх нь хаана байсныг сайн санаж байна. Гурван зуун

арван наймдугаар хуудсанд Робинзон Крузогийн гэрлэсэнтэй холбогдол бүхий явдал байсныг дурдвал:

“Тиймэрхүү зүйлс бодсоор би одоо шинэ амьдралтай золгож эхнэртэй боллоо...мистер Фрэнклин ч эхнэр аваад байгаа шүү дээ, үүнийг анхаарагтун!” – Нэг хүүхэд төрлөө...мистер Фрэнклин ч бас ингэж хэлж болох шүү дээ, үүнийг бас анхаарагтун, - (тэгэхээр эхнэр маань...) “тэгэхээр” Робинзон Крузогийн эхнэр яасан ийснийг магадлах хүсэл надад огт байсангүй. Би, хүүхдийн тухай өгүүлсэн газрыг нь харандаагаар зурж, тэр хуудсандаа тэмдэг болгон жаахан цаас хавчуулаад, -Ингээд байж байг! Фрэнклин Рэчел хоёр гэрлээд хэдэн сар болсны хойно л үзье гэж хэлээд би орхисон юм.

Нэлээд хэдэн сар өнгөрсөн (миний багцаалж байснаас бүр илүү шүү) боловч өнөөх жаахан цаас хавчуулсан хуудсаа сөхөх хэрэгцээ гарахгүй л байлаа. Мянга найман зуун тавин оны арван нэгдүгээр сар хүртэл таг чиг байтал мистер Фрэнклин миний өрөөнд их л баярласан царайтай орж ирээд

- Бэттерез гуай! Би нэг сонинтой ирлээ! Хэдэн сарын дараа манайд нэг юм болох нь байна шүү дээ гэхэд нь би,
- Эрхэм минь, таны гэр бүлийн холбогдолтой зүйл үү? Гэхэд мистер Фрэнклин
- Манай гэр бүлд шууд холбоотой гэлээ
- Таны гэргий энд хамаатай юм биш биз, эрхэм ээ?

Мистер Фрэнклин ялимгүй гайхасхийн,

- хамаатайгаар барах уу даа гэв.
- Эрхэм минь, цааш нь нэг ч үг хэлэлтгүй. Та хоёрыг тэнгэр ивээг! Би йм юм сонсоод чин сэтгэлийн угаас баярлаж байна.

Фрэнклин Блэйк аянганд ниргүүлсэн мэт мэлрэн зогтусаг,

- Та хаанаас дуулсныг мэдэж болохсон болов уу? Би өөрөө маш их нууцалж байсан энэ зүйлийг дөнгөж тавьан минутын өмнө сонслоо шүү дээ гэв.

Одоо л “Робинзон Крузогоо” үзүүлэх цаг боллоо! Миний бие мистер Фрэнклиний гэрлэсэн өдөр тэмдэглээд орхисон, хүүхдийн тухай дурдсан тэр хэсгийг уншиж өгөх завшаан гарах нь тэр! Би тэнд бичсэн шидэт үгсийг зохих ёсоор хичээнгүйлэн уншаад мистер Фрэнклиний өөдөөс ширүүн харж,

- За эрхэм минь, одоо та, Робинзон Крузод итгэж байна уу? хэмээн тухайн тохиолдолд тохирхуйц ёслол төгөлдөр байдлаар асуухад Фрэнклин бас их л биширсэн янзтай.
- Одоо л би итгэлээ гээд миний гарыг атгав. Би ч түүнийг итгүүлж чадлаа гэж бодсон.

Миний бие энэхүү онцгой явдлыг өгүүлээд энэ номын хуудсанд дахин гарахыг больё. Энд өгүүлсэн ижилгүй инээдэмтэй гэмээр зүйлийг уншаад намайг бүү шоолоорой. Миний бичсэн юуг ч уншаад чинээгээрээ хөхрөлдөж бололгүй яахав, харин Робинзон Крузогийн тухай бичсэнийг зохих хүндэтгэлтэй үзэхийг би та бүхнээс гуйя!

Нэгэнт үүнийг хэлснээс хойш өөр хэлэх юм алга даа. Эрхэм хатад, ноёд оо, өчүүхэн миний бие та бүхэнд мэхийн хүндэтгэж ёслоод өгүүлэх зүйлээ цэглэе.

## I

### (ТҮРҮҮЧ КАФФЫН ЗАРСАН ХҮНИЙ МЭДҮҮЛЭГ (1849))

Өнгөрсөн зургадугаар сарын хорин долоонд миний бие хүн амины хэрэгт сэрдэгдсэн бөгөөд энэтхэг байж магадгүй шинжтэй гурван хүнийг мөшгин мөрдөх тушаалыг түрүүч Каффаас авсан юм. Тэд, тэр өглөө Роттердам орох нэгэн хөлөгт Поуэрийн зогсоол дээрээс сууж явах харагдсан ажээ.

Би, хорин нймны, пүрэв гаригийн өглөө өөр нэг кампаний хөлөгт сууж Лондонг орхин явав. Роттердамд очоод лхагва гаригт хөдөлсөн хөлгийн даргыг олж уулзаж чадлаа. Түүний хөлөгт тийм энэтхэгүүд суусан, гэхдээ Грейвсенд хүртэл л сууж явсан гэж тэр хүн хэллээ. Тэнд хүрээд нөгөө гурвын нэг нь Калед хэдэн цагийн алдад хүрэх вэ гэж асуусан байна. Эл хөлөг Роттердам орно гэсэн хариу сонсоод тэр хүн учиргүй гайхан гурвуул буруу онгоцонд суучихаж хэмээн гайхан, гурвуул буруу онгоцонд суучихаж хэмээн халаглан сандарчээ. Тэгээд замын зардал ч одоо дүүрчээ, бид гурвыг эрэг бараадуулаад өгвөл л барав хэмээн нөгөө эр хөлгийн даргаас гуйжээ. Гадаадын улс харь газар тийнхүү мунгинаж явааг нь бодоод, бас тэднийг саатуулах ямар ч шалтгаан үгүй тул хөлгийн дарга эрэг хавьд явсан завинд дохио өгч тэр гурвыг буулган явуулжээ.

Энэтхэгүүд мөр буруулах гэж урьдаас ийм арга сэдсэн байж. Би ч цаг алдалгүй Англи руу буцав. Би Ррейвсендэд буугаад нөгөө гурав Лондон руу явсан сураг гаргалаа. Тэндээс Плимут орсныг мэдэж аваад тэнд очиж сурагласанд тэр гурав дөчин найман цагийн өмнө шууд Бомбей орох Дорнод Энэтхэгийн зампаний “Бьюли Кастл” гэдэг өлгөөр явчихсан байлаа.

Түрүүч Кафф эл мэдээг авмагц Бомбейн эрх баригчидтай хуурай газраар холбоо барьж, уг хөлгийг боомтод ормогц цагдаа нар хөлөг дээр гарч нэгжихээр болжээ. Нэгэнт ийм арга хэмжээ авснаар уг хэрэгт миний холбогдол үгүй болсон юм. Тэр цагаас хойш тэр явдлын талаар би юу ч сонсоогүй билээ.

## II АХМАДЫН МЭДҮҮЛЭГ (1849)

Өнгөрсөн зун миний удирдлагаар Бомбей орох байсан “Бьюли Кастрл” хэмээх хөлөг онгоцонд явсан (энэтхэгүүд байсан нь лавтай) гурван хүнтэй холбоо бүхий зарим зүйлсийг бичгээр мэдэгдэхийг түрүүч Кафф надаас хүссэн юм.

Тэр энэтхэгүүд манай хөлөгт Плимут хотынб уудлаас суусан. Аяллын хугацаанд тэдний зан авирын талаар ямар ч гомдол сонсдоогүй. Тэд хөлгийн хошуу хэсэгт сууж явсан юм. Би хэдхэн удаа л тэдний барааг харсан.

Аяллын шувтаргаар, энэтхэгийн эрэг ахвд явж байтал аз дутаж гурван өдөр, гурван шөнө далай дэндүү дөлгөөн байв. Одоо миний гарт хөлгийн тэмдэглэл байхгүй тул чухам ямар уртраг, өргөрөгт явснаа хэлж чадахгүй нь. Ийм учраас зөвхөн ерөнхийлөн хэлбэл, бид урсгалын хүчинд ауухай наүахи лөхсөөр салхидахин хөдлөхөд, хорин дөрвөн цагийн дараа л зогсоолд хүрсэн юм даг.

Далай урт хугацаанд дөлгөөн байхад (далайчид бүгд андахгүй) хөлгийнхний сахилга сулардаг. Манай хөлгийнхний сахилга ч энэ удаа суларсан юм. Зорчигчдын дотроос хэдэн эрхэм жижиг завь буулгаж сэлүүрдэж, усанд шумбах зэргээр орой нар хэвийж, сэрүү унсан үед зугаацан цэнгэж байлаа. Дараа нь завинуудаа хөлөг дээр гаргаж, байранд нь буцааж тавих ёстой атал хөлгийн хажууд хорхисон байжээ. Далай дөлгөөн цагт халуу шатаж, тэнгэр хэчнээн ёозгүй байсан ч дарга цэрэггүй цөм үүрэгт ажлаа гүйцэтгэхдээ дурамжхан болдог бололтой.

Гурав дахь шөнө хөлгийн тавцан дээр жижүүр хийсэн хүн ямар нэг ерийн бус зүйл үзэж, сонссонгүй. Өглөө нь хамгийн жижиг завь үгүй ! болж, нөгөө гурван энэтхэг бас алга болсныг мэдэцгээв.

Хэрэв тэд харанхуй нөмөрмөгц завь хулгайлан одсон бол (үүнд миний бие эргэлзэхгүй байв) хуурай газар тун ойртсон учраас тэдний араас нэхүүл гаргаад хэрэггүй санагдсан юм. Далай тийм дөлгөөн байхад тэд хичнээн ядарсан, муу сэлүүрддэг бйлаа ч гэсэн үүр цайхаас өмнө эрэгт хүрчихнэ л дээ.

Боомтод очсон хойноо л би тэр гурван хүн тийнхүү оргон зугтах болсон учрыг сая олж сонссон билээ. Би тэндхийн эрх баригчдад ийм л мэдүүлэг өгсөн. Тэд намайг хөлөг дээрээ сахилга сулруулсан гэж зэмлэж байв. Би тэдэнд болон өөрийн эздэд үнэхээр гэмшиж буйгаа хэлсэн. Түүнээс хойш нөгөө гурван энэтхэгийн тухай юу ч олж сонсоогүй болохоор энд нэмж бичих юм алга даа.

## III МИСТЕР МЕРТВЕТЫН МЭДҮҮЛЭГ (1850 ОН) (МИСТЕР БРАФФТ БИЧСЭН ЗАХИДЛААС)

Дөчин найман оны намар Лондонд нэг үдийн зоог дээр уулзсан хагас зэрлэг хүнийг эрхэмсэг ноён та санаж байна уу? Тэр хүний нэрийг сануулахыг зөвшөөрнө үү. Мэртвэйт гэдэг шүү дээ. Та хоёр зоогийн дараа их л удаан ярилцсан билээ. Саран чулуу гэгч энэтхэг алмаз, тэр эрдэнийг хулгайлах гэсэн хуйвалдагчдын тухай ярилцсан билээ. Тэр цагаас хойш миний бие Төв Азиар зөндөө бэдэн тэнүүлчиллээ. Тэндээсээ урьд элдэв адал явдалтай учирч байсан Энэтхэгийн хойд, баруун хойд нутагт дахин очсон юм. Хоёр долоо хоногийнө мнө Каттивар (европынхон бол бараг мэдэхгүй) хэмээх муж буюу хошш нутагт очоод байлаа.

Тэнд нада тохиолдсон нэг явдал үнэмшихүйеэ бэрх санагдаж магадгүй боловч таныхувьд сонирхолто йюм.

Каттиварын зэрлэг бүдүүлэг нутагт (тариачид нь шүдээ хүртэл өвч зэвсэлэхихэд газар хагалдагий нь дурдахад л хичнээн бүдүүлэг зэрлэг болох ынь ойлгоход хялбар) хүмүүс нь бүгд хуучны Хиндү шашин шүтэж, эртний Брама, Вишнүг ухаангүй сүсэглэн биширнэ. Нутгийн тосгодод тархан суух лалын мөргөлтэй цөөн тооны айлын хүмүүс аливаа амьтны мах амсахаас ч айна. Халдашгүй ариун амьтан хэмээдэг үхэр алсан гэж сэрдэгдсэн нэг лалын мөртөлтнийг айл хөрш хиндү нар нь огтхон ч өршөөлгүй алж устгасан явдлыг энд үйн хэрэг гэж тооцно. Каттивард хүн ардын сүсэг бишрэлийг зузаатгадаг мөргөлийн хоёр их алдартай газар байна. Нэг нь Кришна бурхны

мэндэлсэн газар Дварка нөгөө нь арван нэгдүгээр зууны үед лалын мөргөлтний байлдан дагуулагч Гизнийн Махмуд үнсэн товрог болтол эвдэн сүйтгэж байсан ариун хот Сомнатх болой.

Би энэ сүсэг бширэл ихтэй нутаг оронд хоёр дахь удаагаа очихдоо Самнатхийн сүрлэг балгасыг дахин нэг үзэхээс нааш Каттивараас явахгүй гэж санаа шийдсэн юм. Миний байсан газраас ариун хот хүртэл явгаар явахад барагцаалбал гурван өдрийн зайтай байв.

Тийнхүү замдаа ороод удаагүй явтал миний зорин буй зүгт олон хү хоёр гурваараа цувран явж байхыг хардаг юм байна.

Тийм хүмүүстэй ярилцахдаа би өөрийгөө алс нутгаас мөргөл хийхээр яваа буддийн шашинтан гэж хэлдэг байлаа. Миний өмссө хувцас хунар энэ үгийг баталж байсныг хэлэх юун. Түүний дээр миний бие тэдний хэлэрэ ус цас шиг ярьдаг, тэгээд бас туранхай гэвэл туранхай, бараан царайтай гэвэл чамлахааргүй бараан болохоор намайг европ гарлын хүн гэж зүүдлээ ч үгүй учир нэг голын биш ч гэсэн нутгийн хүн гэж итгэсэн билээ.

Нөгөөдөр нь гэхэд надтай зам нийлэх хүний тоо таяас зуу хүрч, цаад өдөр нь бүр тоймоо алдаж хэдэн мянга болоод бүгд л ариун хот Сомнатхыг зорин аажуухан алхацгаах болов.

Аяны гурав дахь өдөр миний бие хамт явсан нэг мөргөлчинд ялимгүй тус болоотохсон нь дээд язгуурын хээн хидү хүнтэй танилцах завшаан олгодог юм байна. Тэдний ярианаас сонсвол, үй олон мөргөлчин шашны нэг том баяр ёслолд оролцохоор яваа бөгөөд тэр нь Сомнатх хотын ойролцоо нэг олгод дээр болдог. Тэр баяр ёслолыг Сарны бурханд зориулсан учраас шөнө хийдэг гэнэ.

Үй олон хүний дундуур зүтгэсээр ёслолын газар арайхийн хүрэх үес сар дээр мандсан байла. Манйа хиндү найз нар тэр шүтээнд ойр очих тусгай эрх дарх бүхий байжээ. Намайг их л найрсгаар дагуулан явлаа. Ёслол хийх газар очиж харвал шүтээнийг хүний нүднээс далдлах гэж хоёр сүрлэг том модны хооронд хөшиг татжээ. Хоёр модны ёроолд хавтгай хад цухуйх нь байгалиас зориуд заяасан тавцан мэт харагдана. Тавцангийн доод биед би хиндү нөхдийнхөө хамт очиж зогслоо.

Толгойн орой дээрээс харахад байгаль хүн хослон, агуу сүрлэг бөгөөд би тийм үзэсгэлэнт байдлыг энэ насандаа үзээгүй билээ. Толгойн бэл алгуур тэлэн намссаар өвс ногоо жигдэрсэн хээр талтай нийлсэн зааг дээр нь гурван голын урсгал нийлдэг жээ. Нэг талд голын ус заримдаа ил үзэгдэн, заримдаа модонд далдран мушгиран тахиралдаж хараа цуцам алсыг зорьжээ. Нөгөө талд долгио цалгиагүй их далай шөнийн нам гүнд амгалан нойрсоно. Бүгд цагаан хувцас өмсөж, толгойн бэл даган, задгай тал хүрч тахиралдан урсах голын эрэг эмжин, багширсан түм буман хүн тийм сайхан үзэсгэлэн төгөлдөр байгалийн бас нэг чимэг болно. Тоо томшгүй олонхүнийдундаас энд тэнд улалзан асах бамбарын аранзал улаан дөл түм буман хүнийг гэрэлтүүлэх нь нэн үзэсгэлэнтэй. Бүртийх ч үүлгүй тэнгэрт дорно дүгээс мандсан тэргэл сарны мөнгөн туяа бүхнийг гийгүүлэн буй нь юутай бишрэм агсныг төсөөлөн бодохул тэрхүү ухаагийн орой дээрээс надад харагдсан үзэгдлийг гадарлах буй заа.

Чавхдаст хөгжим, цоорын гунигт аялгуу сонсогдмогц хөшиг татаж халхалсан шүтээний зүг хамаг анхаарал хандав.

Эргээд хартал хадан тавцан дээр гурван хүн зогсож буй нь нүднээ тусав. Дундах нь танил хүн байна. урьд Англид байхдаа Вериндер авхайн байшингийн өмнөх дэвсгэг дээр миний ярилцаж байсан энэтхэг эр мөн байлаа. Тэр үед хамт явсан хоёр нөхөр нь одоо ч хажууд нь байгаа нь эргэлзээгүй.

Миний гайхаж тэвдсэнийг хажууд зогсож байсан энэтхэгүүдийн нэг ажигалчихаад хадан тавцан дээр энэ гурван хүний гарч ирсний учрыг надад шивнэн тайлбарлав.

Тэр гурван бярман бол бурхны үйлст зүтгэн язгуур бүлгийнхээ хуулийг зөрчсөн гэнэ. Бурхан тэднийг мөргөл үйлдэж байж ариун үйлсийн мөрд оруулах лүндэн буулгажээ. Гурван бярман тэр шөнөдөө энэтхэгийн ариун мөргөлийн газруудыг тус тус чиглэн салж одох бөгөөд бие биесийн царайг дахин хэзээ ч харах ёсгүй юм байж. Салж одсон өдрөөсөө эхлэн амьсгаа хураах хүртлээ зогсолтгүй хэрхэн хэсүүчлэх ёстой ажээ.

Надад тийнхүү шивнэж байтал гунигт аялгуу зогслоо. Нөгөө гурван хүн шүтээнийг далдалсан хөшгийн өмнө хадан тавцан дээр сунаж мөргөөд босож өөд өөдөөсөө ширтсэнээ тэврэлдэв. Тэгээд гурвуул цувран бууж олны дунд ороход хүмүүс огт ичмээ анир гаргалгүй зам тавин өгч байлаа. Гурван зүг, нэгэн зэрэг зам гаргалаа. Бүх насаараа хэрэн тэнэх үйлтэй болсон гурван хүнд цагаан хувцастай шороон түмэн хүний дундуур гаргасан гурван зам зугуухан ариллаа. Тийнхүү тэр гурав бараа тасрав.

РШүтээнийг далдалсан хөшигний араас цовоолог хөгжим чангаар эгшиглэхэд тойрон зогссон хүмүүс хөдлөн шахцалдаж эхлэв.

Модны хооронд татсан хөшгийг буулган шүтээнийг ил гаргалаа.

Өндөр ширээн дээр бодь гөрөөс унаж, дөрвөн мутраа ертөнцийн дөрвөн зүг сунгасан Сарны бурхан тэнгэрийн шидэт гэрэлд бидний дээрээс аймшигтайяа барайн ширтэнэ. Бурхны магнай дээр

шар алмаз гялалзах нь миний бие анх Англи газар бүсгүй хүний энгэр дээр үзсэн тэр эрдэнэ зүсээрээ байлаа!

Анх үүх түүхээ эхэлсэн ариун хотынхоо барааг Саран чулуу найман зуун жилийн дараа ингэж дахин хардаг байна шүү! Энэтхэгчүүд ямар тохиолдлоор буюу ямар гэмт хэрэг үйлдэн байж тэр эрдэнийн чулуугаа олж аваад зэрлэг бүдүүлэ эх орондоо хэрхэн авчирсан түүхийг та надаас илүү мэдэх буй за. Та нар тэр чулууг нэгэнт Англид алдсан бол (энэтхэг хүнийг бага сага мэддэгийн хувьд хэлэхэд) түүний барааг дахиад харах хөг өнгөрчээ.

Он жил улиран халагдахад үйл явдал ч цагийн орчилд эргэлзэн өрнөх юм даа. Саран чулуунаас үүдэн дахин өөр ямар ямар адал явдал гарах бол? Хэн мэдэх билээ?